



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
2026 ОНЫ ХАВРЫН ЭЭЛЖИТ ЧУУЛГАН

2026 ОНЫ 06 ДУГААР САРЫН 11-НИЙ ӨДӨР, ПҮРЭВ ГАРАГ

ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ

НЭГДСЭН ХУРАЛДААН



ХУРАЛДААН ЗОХИОН БАЙГУУЛАХ ГАЗАР

Та хуралдааны тэмдэглэлийн цахим хувьтай дараах
QR кодыг уншуулан танилцах боломжтой.

НЭГДСЭН ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА
2026 оны 06 дугаар сарын 11-ний өдөр, Пүрэв гараг

Хуралдааны тэмдэглэлийн агуулга	1
Хуралдааны товч тэмдэглэл:	2-32
Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:	33-211
1. Сонгуулийн ерөнхий хорооны гишүүнийг томилох, чөлөөлөх тухай асуудал	35-38
2. Бизнесийн эрх чөлөөний тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Засгийн газар 2026.06.04-ний өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/	38-90
3. Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл /Улсын Их Хурлын гишүүн С.Одонтуяа нарын 37 гишүүн 2026.05.29-ний өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/	91-107
4. Улсын бүртгэлийн ерөнхий хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүд /Улсын Их Хурлын гишүүн П.Сайнзориг нарын 37 гишүүн 2026.05.29-ний өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/	107-129
5. Ашигт малтмалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд	129-137
Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.12-т заасны дагуу санал хураалт явуулах цаг болсон тул хуралдаан санал хураалтаар үргэлжлэв.	138-149
Ашигт малтмалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг хэлэлцэх эсэх хэлэлцүүлэг асуулт, хариултаар үргэлжлэв.	149-174
6. Газрын тосны тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Улсын Их Хурлын гишүүн Л.Соронзонболд нарын 13 гишүүн 2026.05.21-ний өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/	174-189
7. Монгол Улсын Их Хурлын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл /Улсын Их Хурлын гишүүн М.Энхцэцэг нарын 70 гишүүн 2026.05.27-ны өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/	189
8. Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл /Үндсэн хуулийн цэцийн 2026 оны 04 дүгээр дүгнэлтийг хүлээн зөвшөөрсөнтэй холбогдуулан боловсруулсан, анхны хэлэлцүүлэг/	189
9. Хүнсний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Улсын Их Хурлын гишүүн М.Мандхай нарын 10 гишүүн 2025.06.19-ний өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/	189
10. Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Улсын Их Хурлын гишүүн О.Амгаланбаатар нарын 17 гишүүн 2026.05.29-ний өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх, үргэлжилнэ/	190-201
11. “Үндэсний хиймэл дагуул хөөргөх төслийн талаар авах зарим арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл	201-204
Монгол Улсын Их Хурлын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг хэлэлцэх эсэх хэлэлцүүлэг үргэлжлэв.	204-206
Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлэг үргэлжлэв.	206-207
Хүнсний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн анхны хэлэлцүүлэг үргэлжлэв.	207-211

**Монгол Улсын Их Хурлын 2026 оны хаврын ээлжит чуулганы
06 дугаар сарын 11-ний өдөр /Пүрэв гараг/-ийн нэгдсэн
хуралдааны товч тэмдэглэл**

Улсын Их Хурлын дарга С.Бямбацогт ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 126 гишүүнээс 71 гишүүн хүрэлцэн ирж, 56.3 хувийн ирцтэйгээр хуралдаан 10 цаг 00 минутад Төрийн ордны “Их хуралдай” танхимд эхлэв.¹

Томилолттой: Б.Батцэцэг, С.Лүндэг, Н.Номтойбаяр;

Чөлөөтэй: Х.Баттулга, Э.Батшугар, Ж.Бат-Эрдэнэ, Ж.Баясгалан, Ц.Даваасүрэн, Ч.Лодойсамбуу, Э.Одбаяр, Л.Оюун-Эрдэнэ, Б.Пунсалмаа;

Эмнэлгийн чөлөөтэй: М.Бадамсүрэн, Б.Баярбаатар, Ж.Ганбаатар, С.Замира, Б.Түвшин;

Хоцорсон: С.Амарсайхан-48 минут, Ч.Анар-03 минут, Х.Баасанжаргал-04 минут, Д.Батбаяр-16 минут, Н.Батсүмбэрэл-2 цаг 21 минут, Ж.Баярмаа-12 минут, Х.Болормаа-02 минут, Э.Болормаа-37 минут, Ш.Бямбасүрэн-2 цаг 15 минут, Ж.Галбадрах-01 минут, Д.Ганбат-01 минут, Л.Гантөмөр-31 минут, Г.Дамдинням-04 минут, Т.Доржханд-08 минут, Б.Дэлгэрсайхан-1 цаг 08 минут, Б.Жавхлан-10 минут, Б.Жаргалан-09 минут, Д.Жаргалсайхан-2 цаг 39 минут, Г.Лувсанжамц-04 минут, Ц.Мөнхбат-01 минут, Т.Мөнхсайхан-10 минут, П.Мөнхтулга-3 цаг 09 минут, З.Мэндсайхан-16 минут, Б.Найдалаа-06 минут, М.Нарантуяа-Нара-03 минут, Ч.Номин-08 минут, Ц.Сандаг-Очир-02 минут, Р.Сэддорж-13 минут, Г.Тэмүүлэн-05 минут, А.Ундраа-02 минут, Ч.Ундрэм-1 цаг 28 минут, Д.Цогтбаатар-56 минут, Ж.Чинбүрэн-23 минут, Л.Энх-Амгалан-32 минут, Б.Энхбаяр-10 минут, Р.Эрдэнэбүрэн-54 минут.

Улсын Их Хурлын дарга С.Бямбацогт 06 дугаар сарын 10-нд төрсөн өдөр нь тохиосон Улсын Их Хурлын гишүүн Ч.Номинд Улсын Их Хурлын гишүүдийн нэрийн өмнөөс баяр хүргэж, эрүүл энх, аз жаргал, сайн сайхныг хүсэн ерөөв.

Өргөн мэдүүлсэн хуулийн төслийн талаар мэдээлэх

Улсын Их Хурлын дарга С.Бямбацогт Улсын Их Хурлын гишүүн О.Цогтгэрэл нарын 3 гишүүнээс 2026.06.05-ны өдөр өргөн мэдүүлсэн Эдийн засгийн эрх чөлөөний тухай хуулийн төсөл болон уг хуулийн төсөлтэй холбогдуулан боловсруулсан хуулийн төслүүдийг Эдийн засгийн байнгын хороонд;

Улсын Их Хурлын гишүүн Р.Сэддорж нарын 36 гишүүнээс 2026.06.09-ний өдөр өргөн мэдүүлсэн Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон уг хуулийн төсөлтэй холбогдуулан боловсруулсан хуулийн төслийг Хүний хөгжил, нийгмийн бодлогын байнгын хороонд тус тус хуваарилсныг танилцуулав./10:06/

Хуулийн төсөл татан авах талаар танилцуулах

Улсын Их Хурлын дарга С.Бямбацогт Улсын Их Хурлын гишүүн Н.Учрал нарын 3 гишүүнээс 2025.12.17-ны өдөр өргөн мэдүүлсэн Зөвшөөрлийн тухай хуульд

¹ Хуралдаан даргалагч ирцийг танилцуулах үед 2 гишүүн ирцэд нэмэгдсэн.

нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдээ татан авах тухай албан бичгийг Улсын Их Хуралд ирүүлснийг уншиж танилцуулав. Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.3-т заасны дагуу хууль санаачлагч хуулийн төслөө татан авсанд тооцов./10:07/

Нэг.Сонгуулийн ерөнхий хорооны гишүүнийг томилох, чөлөөлөх тухай асуудал

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Монгол Улсын Ерөнхийлөгчийн Хот, хөдөөгийн хөгжлийн бодлогын зөвлөх Т.Энхтүвшин, Монгол Улсын дээд шүүхийн Тамгын газрын дарга С.Заяадэлгэр нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хуулийн газрын дарга Ш.Хишигсүрэн, Байнгын хороодын асуудал эрхлэх газрын дарга Б.Хатантуул нар байлцав.

Монгол Улсын Ерөнхийлөгчийн саналыг Монгол Улсын Ерөнхийлөгчийн Хот, хөдөөгийн хөгжлийн бодлогын зөвлөх Т.Энхтүвшин, Монгол Улсын дээд шүүхийн саналыг Монгол Улсын дээд шүүхийн Тамгын газрын дарга С.Заяадэлгэр, Төрийн байгуулалтын байнгын хорооны саналыг Төрийн байгуулалтын байнгын хорооны дарга Б.Жавхлан нар тус тус танилцуулав.

Сонгуулийн ерөнхий хорооны гишүүнийг томилох, чөлөөлөх тухай асуудлаар Улсын Их Хурлын гишүүн, Улсын Их Хурал дахь Ардчилсан намын бүлгийн дэд дарга Х.Тэмүүжин ажлын 5 өдрийн завсарлага авах тухай мэдэгдэж, Улсын Их Хурлын дарга С.Бямбацогт ажлын 5 өдрийн завсарлага өгөв./10:23/

Хоёр.Бизнесийн эрх чөлөөний тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Засгийн газар 2026.06.04-ний өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Монгол Улсын Ерөнхий сайд Н.Учрал, Улсын Их Хурлын гишүүн, Монгол Улсын Тэргүүн Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайд Ж.Энхбаяр, Улсын Их Хурлын гишүүн, Монгол Улсын Шадар сайд Т.Доржханд, Улсын Их Хурлын гишүүн, Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайд Г.Дамдинням, Улсын Их Хурлын гишүүн, Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд Т.Аубакир, Монгол Улсын Ерөнхий сайдын зөвлөх Х.Сүрэнхорол, С.Тэнгис, Монгол Улсын Шадар сайдын зөвлөх С.Санасэр, Эдийн засаг, хөгжлийн яамны Макро эдийн засгийн бодлогын газрын дарга Б.Мөнх-Эрдэнэ, мөн яамны Хөрөнгө оруулалтын бодлогын газрын дарга Б.Төгөлдөр, мөн газрын хуулийн зөвлөх Ж.Мягмарсүрэн, Ногоон санхүүжилтийн хэлтсийн дарга С.Пүрэвсүрэн, Хөрөнгө оруулалт, худалдааны газрын дарга Б.Зандан, Улсын бүртгэлийн ерөнхий газрын Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн газрын дарга Ж.Аюуш, олон улсын арбитрч Т.Алтангэрэл нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хуулийн газрын дарга Ш.Хишигсүрэн, Байнгын хороодын асуудал эрхлэх газрын дарга Б.Хатантуул, мөн газрын Эдийн засгийн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Д.Мягмарцэрэн, зөвлөх Л.Батмөнх, референт Б.Галсанбат нар байлцав.

Төслийн үзэл баримтлалын талаарх илтгэлийг Монгол Улсын Тэргүүн Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайд Ж.Энхбаяр, хуулийн төслийг хэлэлцэх эсэх талаарх Эдийн засгийн байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Б.Мөнхсоёл нар танилцуулав.

Хууль санаачлагчийн илтгэл болон Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн О.Номинчимэг, Б.Пүрэвдорж, Ө.Шижир, Б.Уянга, О.Батнайрамдал, М.Ганхүлэг, О.Саранчулуун, А.Ариунзаяа, Ц.Баатархүү, М.Энхцэцэг, Г.Очирбат, О.Цогтгэрэл, А.Ундраа, Б.Жаргалан нарын тавьсан асуултад Монгол Улсын Ерөнхий сайд Н.Учрал, Монгол Улсын Тэргүүн Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайд Ж.Энхбаяр, Монгол Улсын Шадар сайд Т.Доржханд, Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайд Г.Дамдинням, Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд Т.Аубакир, олон улсын арбитрч Т.Алтангэрэл нар хариулж, тайлбар хийв.

Үдийн завсарлагын цаг болсон тул үдээс өмнөх хуралдаан 3 цаг 09 минут үргэлжилж, 13 цаг 09 минутад завсарлав.

Үдээс хойших хуралдаан 14 цаг 02 минутад эхлэв.

Улсын Их Хурлын гишүүн О.Саранчулуун, С.Эрдэнэболд, Д.Энхтүвшин, П.Ганзориг, Б.Мөнхсоёл нар үг хэлэв.

Улсын Их Хурлын дарга С.Бямбацогт үг хэлэв.

Улсын Их Хурлын дарга С.Бямбацогт Бизнесийн эрх чөлөөний тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжих эсэх санал хураалтыг Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.12-т заасны дагуу 17:00 цагт явуулахаар хойшлуулав./14:29/

Гурав.Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл /Улсын Их Хурлын гишүүн С.Одонтуяа нарын 37 гишүүн 2026.05.29-ний өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Хүний эрхийн Үндэсний Комиссын Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх хэлтсийн дарга Ш.Үнэнтөгс, Улсын Их Хурлын гишүүний зөвлөх Э.Дарханцэцэг нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хуулийн газрын дарга Ш.Хишигсүрэн, Байнгын хороодын асуудал эрхлэх газрын дарга Б.Хатантуул, мөн газрын Хууль зүйн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Г.Золжаргал, зөвлөх Г.Алтанцэцэг, референт Б.Баярсайхан нар байлцав.

Төслийн үзэл баримтлалын талаарх илтгэлийг Улсын Их Хурлын гишүүн С.Одонтуяа, хуулийн төслийг хэлэлцэх эсэх талаарх Хууль зүйн байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Г.Уянгахишиг нар танилцуулав.

Улсын Их Хурлын дэд дарга Б.Пүрэвдорж 14 цаг 31 минутаас хуралдааныг даргалав.

Хууль санаачлагчийн илтгэл болон Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн С.Эрдэнэболд, О.Алтангэрэл, Г.Очирбат, М.Нарантуяа-Нара нарын тавьсан асуултад хууль санаачлагч, Улсын Их Хурлын гишүүн С.Одонтуяа, Батлан хамгаалахын сайд Д.Батлут нар хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын гишүүн М.Нарантуяа-Нара, Х.Баасанжаргал, Ч.Ундрам нар үг хэлэв.

Улсын Их Хурлын дэд дарга Б.Пүрэвдорж Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжих эсэх санал хураалтыг Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.12-т заасны дагуу 17:00 цагт явуулахаар хойшлуулав./15:32/

Дөрөв.Улсын бүртгэлийн ерөнхий хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүд /Улсын Их Хурлын гишүүн П.Сайнзориг нарын 37 гишүүн 2026.05.29-ний өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Цагдаагийн ерөнхий газрын Хуулийн хэлтсийн дарга Б.Батзориг, мөн газрын Мөрдөн шалгах албаны Залилах гэмт хэрэгтэй тэмцэх газрын Мөрдөн шалгах хэлтсийн дарга Д.Сайнжаргал, Улсын бүртгэлийн ерөнхий газрын Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн газрын улсын ахлах бүртгэгч Э.Отгонтунгалаг, Ө.Өнөрлхам нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хуулийн газрын дарга Ш.Хишигсүрэн, Байнгын хороодын асуудал эрхлэх газрын дарга Б.Хатантуул, мөн газрын Хууль зүйн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Г.Золжаргал, зөвлөх Г.Алтанцэцэг нар байлцав.

Төслийн үзэл баримтлалын талаарх илтгэлийг Улсын Их Хурлын гишүүн П.Сайнзориг, хуулийн төслийг хэлэлцэх эсэх талаарх Хууль зүйн байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Д.Пүрэвдаваа нар танилцуулав.

Хууль санаачлагчийн илтгэл болон Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан Улсын Их Хурлын дарга С.Бямбацогт, Улсын Их Хурлын гишүүн С.Эрдэнэболд, О.Номинчимэг, Д.Бум-Очир, Г.Хосбаяр, Ж.Алдаржавхлан нарын тавьсан асуултад хууль санаачлагч, Улсын Их Хурлын гишүүн П.Сайнзориг, Улсын бүртгэлийн ерөнхий газрын Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн газрын улсын ахлах бүртгэгч Э.Отгонтунгалаг, Ө.Өнөрлхам нар хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын дарга С.Бямбацогт 16 цаг 19 минутаас хуралдааныг даргалав.

Улсын Их Хурлын гишүүн Ц.Туваан, С.Одонтуяа, П.Наранбаяр нар үг хэлэв.

Улсын Их Хурлын дарга С.Бямбацогт Улсын бүртгэлийн ерөнхий хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүдийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжих эсэх санал хураалтыг

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.12-т заасны дагуу түр хойшлуулав./16:55/

Тав.Ашигт малтмалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Засгийн газар 2026.05.26-ны өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайд Г.Дамдинням, Улсын Их Хурлын гишүүн, Сангийн сайд З.Мэндсайхан, Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Б.Дашпүрэв, мөн яамны Уул уурхайн бодлогын газрын дарга Г.Намчинсүрэн, Геологийн бодлогын газрын дарга Х.Санчигдорж, Ашигт малтмал, газрын тосны газрын дарга П.Баянбаатар, мөн газрын Хайгуул, ашиглалтын газрын дарга С.Ган-Очир, Кадастрын хэлтсийн дарга М.Энхтуяа, Үндэсний геологийн албаны дарга Н.Мөнхбилэг нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хуулийн газрын дарга Ш.Хишигсүрэн, Байнгын хороодын асуудал эрхлэх газрын дарга Б.Хатантуул, мөн газрын Эдийн засгийн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Д.Мягмарцэрэн, зөвлөх Л.Батмөнх, Б.Нандингэрэл, референт Т.Билэг-Өрнөх нар байлцав.

Төслийн үзэл баримтлалын талаарх илтгэлийг Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайд Г.Дамдинням, хуулийн төслийг хэлэлцэх эсэх талаарх Эдийн засгийн байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Ш.Бямбасүрэн нар танилцуулав.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.12-т заасны дагуу санал хураалт явуулах цаг болсон тул хуралдаан санал хураалтаар үргэлжлэв.

Бизнесийн эрх чөлөөний тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг хэлэлцэх эсэх хэлэлцүүлэг санал хураалтаар үргэлжлэв.

С.Бямбацогт: 1.Бизнесийн эрх чөлөөний тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн:	68
Татгалзсан:	40
Бүгд:	108

63.0 хувийн саналаар дэмжигдлээ.

Хамт өргөн мэдүүлсэн:

2.Авто замын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн:	70
Татгалзсан:	38
Бүгд:	108

64.8 хувийн саналаар дэмжигдлээ.

3.Автотээврийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 72

Татгалзсан: 36

Бүгд: 108

66.7 хувийн саналаар дэмжигдлээ.

4.Агаарын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 70

Татгалзсан: 38

Бүгд: 108

64.8 хувийн саналаар дэмжигдлээ.

5.Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 73

Татгалзсан: 35

Бүгд: 108

67.6 хувийн саналаар дэмжигдлээ.

6.Ажиллах хүчний шилжилт хөдөлгөөний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 68

Татгалзсан: 40

Бүгд: 108

63.0 хувийн саналаар дэмжигдлээ.

7.Амьтны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 70

Татгалзсан: 38

Бүгд: 108

64.8 хувийн саналаар дэмжигдлээ.

8.Арбитрын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 70

Татгалзсан: 38

Бүгд: 108

64.8 хувийн саналаар дэмжигдлээ.

9.Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 71
Татгалзсан: 37
Бүгд: 108

65.7 хувийн саналаар дэмжигдлээ.

10.Аудитын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 70
Татгалзсан: 38
Бүгд: 108

64.8 хувийн саналаар дэмжигдлээ.

11.Ашигт малтмалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 29
Татгалзсан: 79
Бүгд: 108

26.9 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

Санал хураалтад оролцсон гишүүдийн олонх хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжээгүй тул хуулийн төслийг хууль санаачлагчид нь буцаах тухай тогтоол баталсанд тооцов.

12.Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 74
Татгалзсан: 34
Бүгд: 108

68.5 хувийн саналаар дэмжигдлээ.

13.Байгаль орчныг хамгаалах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 74
Татгалзсан: 34
Бүгд: 108

68.5 хувийн саналаар дэмжигдлээ.

14.Байгалийн ургамлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 73
Татгалзсан: 35
Бүгд: 108
67.6 хувийн саналаар дэмжигдлээ.

15.Банкны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 72
Татгалзсан: 36
Бүгд: 108
66.7 хувийн саналаар дэмжигдлээ.

16.Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 70
Татгалзсан: 38
Бүгд: 108
64.8 хувийн саналаар дэмжигдлээ.

17.Барилгын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 73
Татгалзсан: 35
Бүгд: 108
67.6 хувийн саналаар дэмжигдлээ.

18.Боловсролын ерөнхий хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 72
Татгалзсан: 36
Бүгд: 108
66.7 хувийн саналаар дэмжигдлээ.

19.Гаалийн тариф, гаалийн татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 70
Татгалзсан: 38
Бүгд: 108
64.8 хувийн саналаар дэмжигдлээ.

20.Гаалийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 69
Татгалзсан: 39
Бүгд: 108
63.9 хувийн саналаар дэмжигдлээ.

21.Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 67
Татгалзсан: 41
Бүгд: 108
62.0 хувийн саналаар дэмжигдлээ.

22.Газрын тосны бүтээгдэхүүний тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 69
Татгалзсан: 39
Бүгд: 108
63.9 хувийн саналаар дэмжигдлээ.

23.Газрын тосны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 69
Татгалзсан: 39
Бүгд: 108
63.9 хувийн саналаар дэмжигдлээ.

24.Газрын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 70
Татгалзсан: 38
Бүгд: 108
64.8 хувийн саналаар дэмжигдлээ.

25.Газрын хэвлийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 66
Татгалзсан: 42
Бүгд: 108
61.1 хувийн саналаар дэмжигдлээ.

26.Гамшгаас хамгаалах тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 68
Татгалзсан: 40
Бүгд: 108
63.0 хувийн саналаар дэмжигдлээ.

27.Генетик нөөцийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 68
Татгалзсан: 40
Бүгд: 108
63.0 хувийн саналаар дэмжигдлээ.

28.Геодези, зураг зүйн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 71
Татгалзсан: 37
Бүгд: 108
65.7 хувийн саналаар дэмжигдлээ.

29.Гэрийн тэжээвэр амьтны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 69
Татгалзсан: 39
Бүгд: 108
63.9 хувийн саналаар дэмжигдлээ.

30.Гэрээт харуул хамгаалалтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 61
Татгалзсан: 47
Бүгд: 108
56.5 хувийн саналаар дэмжигдлээ.

31.Даатгалын мэргэжлийн оролцогчийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 70

Татгалзсан: 38
Бүгд: 108
64.8 хувийн саналаар дэмжигдлээ.

32.Даатгалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 70
Татгалзсан: 38
Бүгд: 108
64.8 хувийн саналаар дэмжигдлээ.

33.Дипломат албаны тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 71
Татгалзсан: 37
Бүгд: 108
65.7 хувийн саналаар дэмжигдлээ.

34.Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 68
Татгалзсан: 40
Бүгд: 108
63.0 хувийн саналаар дэмжигдлээ.

35.Зар сурталчилгааны тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 69
Татгалзсан: 39
Бүгд: 108
63.9 хувийн саналаар дэмжигдлээ.

36.Засгийн газрын тусгай сангийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 66
Татгалзсан: 42
Бүгд: 108
61.1 хувийн саналаар дэмжигдлээ.

37.Зөвшөөрлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 71
Татгалзсан: 37
Бүгд: 108
65.7 хувийн саналаар дэмжигдлээ.

38.Зөрчлийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 72
Татгалзсан: 36
Бүгд: 108
66.7 хувийн саналаар дэмжигдлээ.

39.Зээлийн мэдээллийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 73
Татгалзсан: 35
Бүгд: 108
67.6 хувийн саналаар дэмжигдлээ.

40.Кадастрын зураглал ба газрын кадастрын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 73
Татгалзсан: 35
Бүгд: 108
67.6 хувийн саналаар дэмжигдлээ.

41.Мал, амьтны эм, тэжээлийн нэмэлтийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 69
Татгалзсан: 39
Бүгд: 108
63.9 хувийн саналаар дэмжигдлээ.

42.Малын генетик нөөцийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 68
Татгалзсан: 40
Бүгд: 108
63.0 хувийн саналаар дэмжигдлээ.

43.Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын эргэлтэд хяналт тавих тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 71
Татгалзсан: 37
Бүгд: 108
65.7 хувийн саналаар дэмжигдлээ.

44.Монгол Улсын хилийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 65
Татгалзсан: 43
Бүгд: 108
60.2 хувийн саналаар дэмжигдлээ.

45.Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 68
Татгалзсан: 40
Бүгд: 108
63.0 хувийн саналаар дэмжигдлээ.

46.Нийгмийн даатгалын ерөнхий хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 66
Татгалзсан: 42
Бүгд: 108
61.1 хувийн саналаар дэмжигдлээ.

47.Нийгмийн халамжийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 65
Татгалзсан: 43
Бүгд: 108
60.2 хувийн саналаар дэмжигдлээ.

48.Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 68
Татгалзсан: 40

Бүгд: 108
63.0 хувийн саналаар дэмжигдлээ.

49.Ойн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 72
Татгалзсан: 36
Бүгд: 108
66.7 хувийн саналаар дэмжигдлээ.

50.Оюуны өмчийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 73
Татгалзсан: 35
Бүгд: 108
67.6 хувийн саналаар дэмжигдлээ.

51.Өргөн нэвтрүүлгийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 68
Татгалзсан: 40
Бүгд: 108
63.0 хувийн саналаар дэмжигдлээ.

52.Радио долгионы тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 70
Татгалзсан: 38
Бүгд: 108
64.8 хувийн саналаар дэмжигдлээ.

53.Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 72
Татгалзсан: 36
Бүгд: 108
66.7 хувийн саналаар дэмжигдлээ.

54.Согтууруулах ундааны эргэлтэд хяналт тавих, архидан согтуурахтай тэмцэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 71
Татгалзсан: 37
Бүгд: 108
65.7 хувийн саналаар дэмжигдлээ.

55.Стандартчилал, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээний итгэмжлэлийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 74
Татгалзсан: 34
Бүгд: 108
68.5 хувийн саналаар дэмжигдлээ.

56.Тамхины хяналтын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 71
Татгалзсан: 37
Бүгд: 108
65.7 хувийн саналаар дэмжигдлээ.

57.Таримал ургамлын үр, сортын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 73
Татгалзсан: 35
Бүгд: 108
67.6 хувийн саналаар дэмжигдлээ.

58.Татварын мэргэшсэн зөвлөх үйлчилгээний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 74
Татгалзсан: 34
Бүгд: 108
68.5 хувийн саналаар дэмжигдлээ.

59.Төлбөр тооцоог үндэсний мөнгөн тэмдэгтээр гүйцэтгэх тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 72
Татгалзсан: 36
Бүгд: 108
66.7 хувийн саналаар дэмжигдлээ.

60.Төмөр замын тээврийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 68
Татгалзсан: 40
Бүгд: 108
63.0 хувийн саналаар дэмжигдлээ.

61.Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 73
Татгалзсан: 35
Бүгд: 108
67.6 хувийн саналаар дэмжигдлээ.

62.Төрийн хяналт шалгалтын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 74
Татгалзсан: 34
Бүгд: 108
68.5 хувийн саналаар дэмжигдлээ.

63.Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 74
Татгалзсан: 34
Бүгд: 108
68.5 хувийн саналаар дэмжигдлээ.

64.Түгээмэл тархацтай ашигт малтмалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 67
Татгалзсан: 41
Бүгд: 108
62.0 хувийн саналаар дэмжигдлээ.

65.Тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийн эргэлтэд хяналт тавих тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 69
Татгалзсан: 39

Бүгд: 108
63.9 хувийн саналаар дэмжигдлээ.

66.Улсын бүртгэлийн ерөнхий хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 73
Татгалзсан: 35
Бүгд: 108
67.6 хувийн саналаар дэмжигдлээ.

67.Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 71
Татгалзсан: 37
Бүгд: 108
65.7 хувийн саналаар дэмжигдлээ.

68.Ургамлын эрүүл мэнд, ургамал хамгааллын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 75
Татгалзсан: 33
Бүгд: 108
69.4 хувийн саналаар дэмжигдлээ.

69.Усан замын тээврийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 74
Татгалзсан: 34
Бүгд: 108
68.5 хувийн саналаар дэмжигдлээ.

70.Усны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 76
Татгалзсан: 32
Бүгд: 108
70.4 хувийн саналаар дэмжигдлээ.

71.Уул уурхайн бүтээгдэхүүний биржийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 69
Татгалзсан: 39
Бүгд: 108
63.9 хувийн саналаар дэмжигдлээ.

72.Үйлдвэрлэл, технологийн паркийн эрх зүйн байдлын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 75
Татгалзсан: 33
Бүгд: 108
69.4 хувийн саналаар дэмжигдлээ.

73.Үнэт цаасны зах зээлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 73
Татгалзсан: 35
Бүгд: 108
67.6 хувийн саналаар дэмжигдлээ.

74.Хадгаламж, зээлийн хоршооны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 73
Татгалзсан: 35
Бүгд: 108
67.6 хувийн саналаар дэмжигдлээ.

75.Харилцаа холбооны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 70
Татгалзсан: 38
Бүгд: 108
64.8 хувийн саналаар дэмжигдлээ.

76.Химийн хорт болон аюултай бодисын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 76
Татгалзсан: 32
Бүгд: 108
70.4 хувийн саналаар дэмжигдлээ.

77.Ховордсон амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай эд зүйлийн гадаад худалдааг зохицуулах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 69
Татгалзсан: 39
Бүгд: 108
63.9 хувийн саналаар дэмжигдлээ.

78.Хог хаягдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 70
Татгалзсан: 38
Бүгд: 108
64.8 хувийн саналаар дэмжигдлээ.

79.Хот байгуулалтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 74
Татгалзсан: 34
Бүгд: 108
68.5 хувийн саналаар дэмжигдлээ.

80.Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалтын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 72
Татгалзсан: 36
Бүгд: 108
66.7 хувийн саналаар дэмжигдлээ.

81.Хөдөө аж ахуйн гаралтай бараа, түүхий эдийн биржийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 74
Татгалзсан: 34
Бүгд: 108
68.5 хувийн саналаар дэмжигдлээ.

82.Хөрөнгийн үнэлгээний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 72

Татгалзсан: 36
Бүгд: 108
66.7 хувийн саналаар дэмжигдлээ.

83.Хөрөнгө оруулалтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 74
Татгалзсан: 34
Бүгд: 108
68.5 хувийн саналаар дэмжигдлээ.

84.Хөрөнгө оруулалтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 76
Татгалзсан: 32
Бүгд: 108
70.4 хувийн саналаар дэмжигдлээ.

85.Хөрөнгө оруулалтын сангийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 75
Татгалзсан: 33
Бүгд: 108
69.4 хувийн саналаар дэмжигдлээ.

86.Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 71
Татгалзсан: 37
Бүгд: 108
65.7 хувийн саналаар дэмжигдлээ.

87.Хувийн хамгаалалтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 67
Татгалзсан: 41
Бүгд: 108
62.0 хувийн саналаар дэмжигдлээ.

88.Хувиргасан амьд организмын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 73
Татгалзсан: 35
Бүгд: 108
67.6 хувийн саналаар дэмжигдлээ.

89.Хувь хүний орлогын албан татварын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 71
Татгалзсан: 37
Бүгд: 108
65.7 хувийн саналаар дэмжигдлээ.

90.Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 72
Татгалзсан: 36
Бүгд: 108
66.7 хувийн саналаар дэмжигдлээ.

91.Хүүхэд харах үйлчилгээний тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 36
Татгалзсан: 72
Бүгд: 108
33.3 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

Санал хураалтад оролцсон гишүүдийн олонх хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжээгүй тул хуулийн төслийг хууль санаачлагчид нь буцаах тухай тогтоол баталсанд тооцов.

92.Цөмийн энергийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 73
Татгалзсан: 35
Бүгд: 108
67.6 хувийн саналаар дэмжигдлээ.

93.Чөлөөт бүсийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 72
Татгалзсан: 36
Бүгд: 108
66.7 хувийн саналаар дэмжигдлээ.

94.Шилэн дансны тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 73
Татгалзсан: 35
Бүгд: 108
67.6 хувийн саналаар дэмжигдлээ.

95.Шуудангийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 75
Татгалзсан: 33
Бүгд: 108
69.4 хувийн саналаар дэмжигдлээ.

96.Шүүх шинжилгээний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 77
Татгалзсан: 31
Бүгд: 108
71.3 хувийн саналаар дэмжигдлээ.

97.Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 79
Татгалзсан: 29
Бүгд: 108
73.1 хувийн саналаар дэмжигдлээ.

98.Эмнэлгийн тусламж, үйлчилгээний тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 76
Татгалзсан: 32
Бүгд: 108
70.4 хувийн саналаар дэмжигдлээ.

99.Эрүүл мэндийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 72
Татгалзсан: 36
Бүгд: 108
66.7 хувийн саналаар дэмжигдлээ.

100.Эрчим хүчний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 76
Татгалзсан: 32
Бүгд: 108
70.4 хувийн саналаар дэмжигдлээ.

Бизнесийн эрх чөлөөний тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжсэн тул анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Эдийн засгийн байнгын хороонд шилжүүлэв.

Уг асуудлыг 18 цаг 05 минутад хэлэлцэж дуусав.

Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг хэлэлцэх эсэх хэлэлцүүлэг санал хураалтаар үргэлжлэв.

С.Бямбацогт: Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 83
Татгалзсан: 25
Бүгд: 108
76.9 хувийн саналаар дэмжигдлээ.

Улсын Их Хурлын гишүүн С.Эрдэнэболдын “дэмжсэн” санал “эсрэг” гарсан тул санал хураалтыг дэмжсэнээр хуралдааны тэмдэглэлд тэмдэглүүлэх санал гаргаж, 77.8 хувийн саналаар дэмжигдлээ.

Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжсэн тул анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Хууль зүйн байнгын хороонд шилжүүлэв.

Уг асуудлыг 18 цаг 07 минутад хэлэлцэж дуусав.

Улсын бүртгэлийн ерөнхий хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүдийг хэлэлцэх эсэх хэлэлцүүлэг санал хураалтаар үргэлжлэв.

С.Бямбацогт: 1.Улсын бүртгэлийн ерөнхий хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 84
Татгалзсан: 24
Бүгд: 108
77.8 хувийн саналаар дэмжигдлээ.

Хамт өргөн мэдүүлсэн:

2.Барилгын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 81
Татгалзсан: 27
Бүгд: 108
75.0 хувийн саналаар дэмжигдлээ.

3.Иргэний хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 79
Татгалзсан: 29
Бүгд: 108
73.1 хувийн саналаар дэмжигдлээ.

4.Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 78
Татгалзсан: 30
Бүгд: 108
72.2 хувийн саналаар дэмжигдлээ.

5.Үл хөдлөх эд хөрөнгийн барьцааны тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 81
Татгалзсан: 27
Бүгд: 108
75.0 хувийн саналаар дэмжигдлээ.

6.Үл хөдлөх эд хөрөнгийн албан татварын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 76
Татгалзсан: 32

Бүгд: 108
70.4 хувийн саналаар дэмжигдлээ.

7.Хаягжуулалтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 79
Татгалзсан: 29
Бүгд: 108
73.1 хувийн саналаар дэмжигдлээ.

8.Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 81
Татгалзсан: 27
Бүгд: 108
75.0 хувийн саналаар дэмжигдлээ.

9.“Хууль хэрэгжүүлэх арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 80
Татгалзсан: 28
Бүгд: 108
74.1 хувийн саналаар дэмжигдлээ.

Улсын бүртгэлийн ерөнхий хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүдийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжсэн тул анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Хууль зүйн байнгын хороонд шилжүүлэв.

Уг асуудлыг 18 цаг 11 минутад хэлэлцэж дуусав.

Ашигт малтмалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг хэлэлцэх эсэх хэлэлцүүлэг асуулт, хариултаар үргэлжлэв.

Улсын Их Хурлын дэд дарга Б.Пүрэвдорж 18 цаг 19 минутаас хуралдааныг даргалав.

Хууль санаачлагчийн илтгэл болон Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Н.Алтаншагай, С.Ганбаатар, Б.Уянга, П.Ганзориг, М.Энхцэцэг, М.Нарантуяа-Нара, С.Эрдэнэболд, Д.Батбаяр, Б.Пүрэвдорж нарын тавьсан асуултад Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайд Г.Дамдинням, Сангийн сайд З.Мэндсайхан, Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамны Уул уурхайн бодлогын газрын дарга Г.Намчинсүрэн нар хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын гишүүн Д.Энхтүвшин, О.Амгаланбаатар, М.Нарантуяа-Нара нар үг хэлэв.

Улсын Их Хурлын дарга С.Бямбацогт 19 цаг 32 минутаас хуралдааныг даргалав.

Улсын Их Хурлын дарга С.Бямбацогт үг хэлэв.

Улсын Их Хурлын дарга С.Бямбацогт Ашигт малтмалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжих эсэх санал хураалтыг Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.12-т заасны дагуу 2026.06.12-ны өдрийн Баасан гарагт явуулахаар хойшлуулав./19:46/

Зургаа.Газрын тосны тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Улсын Их Хурлын гишүүн Л.Соронзонболд нарын 13 гишүүн 2026.05.21-ний өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамны Газрын тосны бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга Ч.Хишигдалай, Эдийн засаг, хөгжлийн яамны Хөрөнгө оруулалтын газрын дарга Б.Төгөлдөр, мөн яамны Макро эдийн засгийн бодлогын газрын дарга Б.Мөнх-Эрдэнэ, Сангийн яамны Төсвийн нэгтгэлийн хэлтсийн дарга В.Содномдаржаа, Ашигт малтмал, газрын тосны газрын Газрын тосны ашиглалтын хэлтсийн дарга Ш.Маргад нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хуулийн газрын дарга Ш.Хишигсүрэн, Байнгын хороодын асуудал эрхлэх газрын дарга Б.Хатантуул, мөн газрын Эдийн засгийн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Д.Мягмарцэрэн, зөвлөх Л.Батмөнх, Б.Нандингэрэл, референт Т.Билэг-Өрнөх нар байлцав.

Төслийн үзэл баримтлалын талаарх илтгэлийг Улсын Их Хурлын гишүүн Л.Соронзонболд, хуулийн төслийг хэлэлцэх эсэх талаарх Эдийн засгийн байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Ч.Анар нар танилцуулав.

Хууль санаачлагчийн илтгэл болон Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Д.Энхтүвшин, С.Ганбаатар, С.Эрдэнэбат, Ц.Туваан нарын тавьсан асуултад хууль санаачлагч, Улсын Их Хурлын гишүүн Л.Соронзонболд, Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамны Газрын тосны бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга Ч.Хишигдалай нар хариулж, тайлбар хийв.

Газрын тосны тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг хэлэлцэх эсэх асуудлаар Улсын Их Хурлын гишүүн, Улсын Их Хурал дахь Ардчилсан намын бүлгийн дэд дарга Х.Тэмүүжин 16 цагийн завсарлага авах тухай мэдэгдэж, Улсын Их Хурлын дарга С.Бямбацогт 16 цагийн завсарлага өгөв./20:36/

Долоо.Монгол Улсын Их Хурлын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл /Улсын Их Хурлын гишүүн М.Энхцэцэг нарын 70 гишүүн 2026.05.27-ны өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/

Монгол Улсын Их Хурлын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг хэлэлцэх эсэх асуудлаар Улсын Их Хурлын гишүүн, Улсын Их Хурал дахь Ардчилсан намын бүлгийн дэд дарга Х.Тэмүүжин 1 цагийн завсарлага авах тухай мэдэгдэж, Улсын Их Хурлын дарга С.Бямбацогт 1 цагийн завсарлага өгөв./20:36/

Найм.Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл /Үндсэн хуулийн цэцийн 2026 оны 04 дүгээр дүгнэлтийг хүлээн зөвшөөрсөнтэй холбогдуулан боловсруулсан, анхны хэлэлцүүлэг/

Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлэгтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Улсын Их Хурал дахь Ардчилсан намын бүлгийн дэд дарга Х.Тэмүүжин 1 цагийн завсарлага авах тухай мэдэгдэж, Улсын Их Хурлын дарга С.Бямбацогт 1 цагийн завсарлага өгөв./20:38/

Ес.Хүнсний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Улсын Их Хурлын гишүүн М.Мандхай нарын 10 гишүүн 2025.06.19-ний өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/

Хүнсний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн анхны хэлэлцүүлэгтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Улсын Их Хурал дахь Ардчилсан намын бүлгийн дэд дарга Х.Тэмүүжин 1 цагийн завсарлага авах тухай мэдэгдэж, Улсын Их Хурлын дарга С.Бямбацогт 1 цагийн завсарлага өгөв./20:39/

Арав.Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Улсын Их Хурлын гишүүн О.Амгаланбаатар нарын 17 гишүүн 2026.05.29-ний өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх, үргэлжилнэ/

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хуулийн газрын дарга Ш.Хишигсүрэн, Байнгын хороодын асуудал эрхлэх газрын дарга Б.Хатантуул, мөн газрын Төрийн байгуулалтын байнгын хорооны ажлын албаны референт Б.Баясах нар байлцав.

Улсын Их Хурлын дарга С.Бямбацогт Улсын Их Хурал дахь Монгол Ардын намын бүлгээс авсан завсарлага дууссаныг мэдэгдэв./20:40/

Төслийн үзэл баримтлалын талаарх илтгэлийг Улсын Их Хурлын гишүүн О.Амгаланбаатар, хуулийн төслийг хэлэлцэх эсэх талаарх Төрийн байгуулалтын байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Ж.Баярмаа нар танилцуулав.

Хууль санаачлагчийн илтгэл болон Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Д.Энхтүвшин, С.Зулпхар, Ц.Туваан нарын

тавьсан асуултад хууль санаачлагч, Улсын Их Хурлын гишүүн О.Амгаланбаатар, Ж.Батсуурь нар хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын гишүүн, Улсын Их Хурал дахь Ардчилсан намын бүлгийн дэд дарга Х.Тэмүүжин хэлэлцэх асуудлын дарааллын 10, 11 дүгээр асуудлыг хэлэлцэж дуусмагц хэлэлцэх асуудлын дарааллын 7, 8, 9 дүгээр асуудлаар Улсын Их Хурал дахь Ардчилсан намын бүлгээс авсан завсарлага дуусах тухай мэдэгдэв./21:05/

Улсын Их Хурлын гишүүн С.Зулпхар, Б.Хэрлэн нар үг хэлэв.

Улсын Их Хурлын дарга С.Бямбацогт Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжих эсэх санал хураалтыг Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.12-т заасны дагуу 2026.06.12-ны өдрийн Баасан гарагт явуулахаар хойшлуулав./21:20/

Арван нэг. “Үндэсний хиймэл дагуул хөөргөх төслийн талаар авах зарим арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хуулийн газрын дарга Ш.Хишигсүрэн, Байнгын хороодын асуудал эрхлэх газрын дарга Б.Хатантуул, мөн газрын Эдийн засгийн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Д.Мягмарцэрэн, зөвлөх Б.Нандингэрэл, референт Х.Шижирмөнх нар байлцав.

Инновац, цахим бодлогын хөгжлийн дэд хорооны санал, дүгнэлтийг хэлэлцсэн талаарх Эдийн засгийн байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Л.Соронзонболд танилцуулав.

Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Б.Пүрэвдоржийн тавьсан асуултад Улсын Их Хурлын гишүүн Ж.Золжаргал, Ч.Анар нар хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын гишүүн Д.Рэгдэл үг хэлэв.

Улсын Их Хурлын дарга С.Бямбацогт “Үндэсний хиймэл дагуул хөөргөх төслийн талаар авах зарим арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг батлах санал хураалтыг Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.12-т заасны дагуу 2026.06.12-ны өдрийн Баасан гарагт явуулахаар хойшлуулав./21:34/

Монгол Улсын Их Хурлын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг хэлэлцэх эсэх хэлэлцүүлэг үргэлжлэв.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хуулийн газрын дарга Ш.Хишигсүрэн, Байнгын хороодын асуудал эрхлэх газрын дарга Б.Хатантуул, мөн газрын Төрийн байгуулалтын байнгын хорооны ажлын албаны референт Б.Баясах нар байлцав.

Төслийн үзэл баримтлалын талаарх илтгэлийг Улсын Их Хурлын гишүүн М.Энхцэцэг, хуулийн төслийг хэлэлцэх эсэх талаарх Төрийн байгуулалтын байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Д.Энхтуяа нар танилцуулав.

Хууль санаачлагчийн илтгэл болон Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүд асуулт асууж, үг хэлээгүй болно.

Улсын Их Хурлын дарга С.Бямбацогт Монгол Улсын Их Хурлын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжих эсэх санал хураалтыг Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.12-т заасны дагуу 2026.06.12-ны өдрийн Баасан гарагт явуулахаар хойшлуулав./21:43/

Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлэг үргэлжлэв.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хуулийн газрын дарга Ш.Хишигсүрэн, Байнгын хороодын асуудал эрхлэх газрын дарга Б.Хатантуул, мөн газрын Төрийн байгуулалтын байнгын хорооны ажлын албаны референт Б.Баясах нар байлцав.

Төрийн байгуулалтын байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Л.Мөнхбаатар танилцуулав.

Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүд асуулт асуугаагүй болно.

Улсын Их Хурлын дарга С.Бямбацогт Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаарх санал хураалтыг Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.12-т заасны дагуу 2026.06.12-ны өдрийн Баасан гарагт явуулахаар хойшлуулав./21:45/

Хүнсний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн анхны хэлэлцүүлэг үргэлжлэв.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хуулийн газрын дарга Ш.Хишигсүрэн, Байнгын хороодын асуудал эрхлэх газрын дарга Б.Хатантуул, мөн газрын Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Ш.Ариунжаргал, зөвлөх П.Хулан, референт Ц.Рэнцэнтогтох нар байлцав.

Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Т.Мөнхсайхан танилцуулав.

Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Д.Энхтүвшингийн тавьсан асуултад хууль санаачлагч, Улсын Их Хурлын гишүүн М.Мандхай, ажлын хэсгийн ахлагч, Улсын Их Хурлын гишүүн Т.Мөнхсайхан нар хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын дарга С.Бямбацогт Хүнсний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн талаарх зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор явуулах санал хураалтыг Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.12-т заасны дагуу 2026.06.12-ны өдрийн Баасан гарагт явуулахаар хойшлуулав./22:03/

Бусад. Улсын Их Хурлын гишүүн Л.Соронзонболдын урилгаар Дорнод аймгийн Баян-Уул сумын ерөнхий боловсролын сургуулийн 1986 оны төгсөгчид, нийслэлийн ерөнхий боловсролын 105 дугаар сургуулийн 12^б, 12^в ангийн багш, сурагчид, Улсын Их Хурлын гишүүн З.Мэндсайханы урилгаар Ховд аймгийн ерөнхий боловсролын 1 дүгээр сургуулийн 1976 оны төгсөгчид, Говь-Алтай аймгийн ерөнхий боловсролын 2 дугаар сургуулийн 1976 оны төгсөгчид, Улсын Их Хурлын гишүүн Ц.Баатархүүгийн урилгаар нийслэлийн Чингэлтэй дүүргийн 7, 8, 9, 23 дугаар хорооны иргэдийн төлөөлөл, Улсын Их Хурлын гишүүн Д.Батбаярын урилгаар Төв аймгийн Баянцагаан сумын төрийн албан хаагчид, Улсын Их Хурлын гишүүн О.Амгаланбаатарын урилгаар Говь-Алтай аймгийн иргэдийн төлөөлөл, нийслэлийн ерөнхий боловсролын “Ирээдүй” сургуулийн 10^в ангийн багш, сурагчид, Улсын Их Хурлын гишүүн Ч.Ундрамын урилгаар Сэлэнгэ аймгийн Шаамар сумын Дулаанхаан тосгоны ерөнхий боловсролын сургуулийн 12^а, 12^б ангийн багш, сурагчид, Увс аймгийн Сагил сумын ерөнхий боловсролын сургуулийн 1990 оны төгсөгчид, нийслэлийн ерөнхий боловсролын 10 дугаар сургуулийн 2006 оны төгсөгчид, Улсын Их Хурлын гишүүн Б.Пунсалмаагийн урилгаар нийслэлийн Баянгол дүүргийн иргэдийн төлөөлөл, Улсын Их Хурлын гишүүн Х.Ганхуягийн урилгаар нийслэлийн Баянгол дүүргийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын албан хаагчид, Улсын Их Хурлын гишүүн Э.Батшугарын урилгаар нийслэлийн ерөнхий боловсролын 41 дүгээр сургуулийн 9^а ангийн багш, сурагчид, нийслэлийн ерөнхий боловсролын 69 дүгээр сургуулийн 1986 оны төгсөгчид, Улсын Их Хурлын гишүүн З.Мэндсайханы урилгаар нийслэлийн ерөнхий боловсролын 52 дугаар сургуулийн 7^г ангийн багш, сурагчид, Улсын Их Хурлын гишүүн Д.Үүрийнтуяагийн урилгаар Орхон аймгийн Баян-Өндөр сумын ахмадууд, Улсын Их Хурлын гишүүн Б.Түвшингийн урилгаар Завхан аймгийн Тэс сумын ерөнхий боловсролын сургуулийн 1996 оны төгсөгчид, нийслэлийн ерөнхий боловсролын 52 дугаар сургуулийн 9^б ангийн багш, сурагчид, Улсын Их Хурлын гишүүн Г.Тэмүүлэнгийн урилгаар нийслэлийн ерөнхий боловсролын “Элит” сургуулийн 10^с ангийн багш, сурагчид, Улсын Их Хурлын гишүүн О.Амгаланбаатарын урилгаар нийслэлийн ерөнхий боловсролын 19 дүгээр сургуулийн 12^в ангийн багш, сурагчид Төрийн ордон, Улсын Их Хурлын чуулганы үйл ажиллагаатай танилцав.

Чуулганы нэгдсэн хуралдаанаар 11 асуудал хэлэлцэв.

Чуулганы нэгдсэн хуралдааны зохион байгуулалтыг Улсын Их Хурлын Тамгын газрын Хуралдаан зохион байгуулах газрын дарга Г.Агар-Эрдэнэ, мөн газрын шинжээч Ш.Мөнхцоож, С.Энхзаяа, ахлах мэргэжилтэн С.Золжаргал нар хариуцан ажиллав.

Хуралдаан 11 цаг 11 минут үргэлжилж, 126 гишүүнээс 109 гишүүн хүрэлцэн ирж, 86.5 хувийн ирцтэйгээр 22 цаг 04 минутад өндөрлөв.

Тэмдэглэлтэй танилцсан:

ЕРӨНХИЙ НАРИЙН
БИЧГИЙН ДАРГА

Л.ӨЛЗИЙСАЙХАН

Тэмдэглэл хөтөлсөн:

ХУРАЛДААН ЗОХИОН БАЙГУУЛАХ
ГАЗРЫН ШИНЖЭЭЧ

Д.УЯНГА

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

2026 оны 06 дугаар сарын 11-ний өдөр,
Пүрэв гараг
Төрийн ордон “Их хуралдай” танхим
10 цаг 00 минут.

НЭГДСЭН ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ

С.Бямбацогт: Улсын Их Хурлынхаа эрхэм гишүүдийн өглөөний амгаланг айлтгая. 2026 оны 6 дугаар сарын 11-ний өдрийн чуулганы хуралдааны ирцийг танилцуулъя. Ирвэл зохих 126 гишүүнээс 71 гишүүн буюу 56.3 хувийн ирцтэйгээр ирц бүрдсэн байна. Чуулганы нэгдсэн хуралдаан нээснийг мэдэгдье.

Гишүүддээ мэдээлэл хүргэе. Долоо хоногийн тов, дараалалд тусгагдсан хэлэлцэх асуудлын тухай Төрийн болон орон нутгийн өмчит компанийн бүтээмж, ил тод байдал, засаглалыг сайжруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүдийг Засгийн газар /ЗГ/ 2025 оны 1 дүгээр сарын 8-ны өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлгийг хийх ёстой байсан. Сая 6 дугаар сарын 9-ний өдөр Эдийн засгийн байнгын хорооны хуралдааны явцад Улсын Их Хурал /УИХ/-ын гишүүн Батнайрамдалын гаргасан горимын санал дэмжигдэж, хойшлуулсан тул нэгдсэн хуралдааны хэлэлцэх асуудлаас хассан. 2-т Үндэсний их баяр наадмын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг Сайнзориг нарын гишүүд өргөн мэдүүлсэн, ТББХ-ны 2026 оны 6 дугаар сарын 10-ны өдрийн хуралдааны явцад хуулийн төслийг хэлэлцэхийг хойшлуулсан тул нэгдсэн хуралдааны хэлэлцэх асуудлаас хасагдсан.

Төрсөн өдөр нь тохиож буй, 6 сарын 10-ны өдөр УИХ-ын гишүүн Чинбатын Номин төрсөн байна. УИХ-ын гишүүн Чинбатын Номинд төрсөн өдрийн мэнд хүргэж, Монгол Төрийн эрхэм түшээ, ард түмний элч болсон танд болон таны гэр бүлд УИХ-ын нийт гишүүдийнхээ нэрийн өмнөөс эрүүл энх, аз жаргал, сайн сайхан бүхнийг хүсэн ерөөе.

Өнөөдрийн чуулганы хуралдааны ирцэд эртэч гишүүдээ танилцуулъя. Бөхчулууны Пүрэвдорж, Буланы Бейсен, Наранцэцэгийн Алтаншагай, Лутаагийн Энхнасан, Сүхбаатарын Эрдэнэболд нарын гишүүд 09:00 цагт хүрэлцэн ирсэн байна.

Өнөөдрийн чуулганы нэгдсэн хуралдаанаар дараах 12 асуудлыг хэлэлцэнэ. 1-д СЕХ-ны гишүүнийг томилох, чөлөөлөх асуудлыг хэлэлцэнэ. 2-т Бизнесийн эрх чөлөөний тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг хэлэлцэх эсэх хэлэлцүүлгийг явуулна, ЗГ 2026 оны 6 дугаар сарын 4-ний өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх. 3-д Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комисс /ХЭҮК/-ын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг хэлэлцэх эсэх хэлэлцүүлэг явуулна, УИХ-ын гишүүн Одонтуяа нарын 37 гишүүн өргөн мэдүүлсэн. 4-т Улсын бүртгэлийн ерөнхий хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслийн хэлэлцэх эсэх хэлэлцүүлэг явуулна, Их Хурлын гишүүн Сайнзориг нарын 37 гишүүн өргөн мэдүүлсэн.

5-д Ашигт малтмалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг хэлэлцэх эсэх хэлэлцүүлэг явуулна, 3Г 5 дугаар сарын 26-ны өдөр өргөн мэдүүлсэн. 6-д Газрын тосны тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг хэлэлцэх эсэх хэлэлцүүлэг явуулна, УИХ-ын гишүүн Соронзонболд нарын 13 гишүүн өргөн мэдүүлсэн. 7-д УИХ-ын хянан шалгалтын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг хэлэлцэх эсэх хэлэлцүүлэг явуулна, УИХ-ын гишүүн Алдаржавхлан өргөн мэдүүлсэн. 8-д УИХ-ын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг хэлэлцэх эсэх хэлэлцүүлгээ явуулна, УИХ-ын гишүүн Энхцэцэг нарын гишүүд өргөн мэдүүлсэн. 9-д Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг явуулна, Үндсэн хуулийн цэц /ҮХЦ/-ийн дүгнэлттэй холбогдуулж боловсруулсан. 10-д Хүнсний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн анхны хэлэлцүүлгийг явуулна, Их Хурлын гишүүн Мандхай нарын 10 гишүүн өргөн мэдүүлсэн. 11-д Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн хэлэлцэх эсэх хэлэлцүүлгийг явуулна, УИХ-ын гишүүн Амгаланбаатар нарын 17 гишүүн өргөн мэдүүлсэн. 12-д Үндэсний хиймэл дагуул хөөргөх төслийн талаар авах зарим арга хэмжээний тухай УИХ-ын тогтоолын төслийг хэлэлцэнэ. Ийм 12 асуудлыг өнөөдөр хэлэлцэх нь байна.

Монгол УИХ-ын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 29.1-д УИХ-ын дарга хууль санаачлагчаас УИХ-д өргөн мэдүүлсэн төслийг хэлэлцүүлэгт бэлтгэх Байнгын хороог, хэрэв тухайн төсөл хэд хэдэн Байнгын хорооны эрхлэх асуудлын хүрээнд хамаарахаар байвал зөвлөлтэй зөвшилцөн холбогдох болон бусад Байнгын хороог тогтоож нэгдсэн хуралдаанд мэдээлнэ гэж заасан. Үүний дагуу өргөн мэдүүлсэн хуулиудыг хуваарилсан талаар танилцуулъя.

Эдийн засгийн эрх чөлөөний тухай хуулийн төсөл болон уг хуулийн төсөлтэй холбогдуулан боловсруулсан хуулийн төслүүдийг УИХ-ын гишүүн Одонгийн Цогтгэрэл нарын 3 гишүүн 2026 оны 6 дугаар сарын 5-ны өдөр өргөн мэдүүлснийг Эдийн засгийн байнгын хороонд;

Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон уг хуулийн төсөлтэй холбогдуулан боловсруулсан хуулийн төслийг УИХ-ын гишүүн Ренчинбямбын Сэддорж нарын 36 гишүүн 2026 оны 6 дугаар сарын 9-ний өдөр өргөн мэдүүлснийг Хүний хөгжил, нийгмийн бодлогын байнгын хороонд тус тус хуваарилсан.

Монгол УИХ-ын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 32.1-д хууль санаачлагч хэлэлцүүлгийн аль ч шатанд санаачилсан хуулийн төслөө татан авч болно. 32.3-д хуулийн төслөө татан авах тохиолдолд тухайн төсөл хэлэлцүүлгийн аль ч шатанд байгаагаас үл хамааран хууль санаачлагч хуулийн төслөө татан авах тухай албан бичгийг УИХ-д ирүүлэх бөгөөд УИХ-ын дарга нэгдсэн хуралдаанд энэ тухай танилцуулснаар хууль санаачлагч хуулийн төслөө татан авсанд тооцно гэж тус тус заасан. Үүний дагуу хууль санаачлагчаас хуулийн төслөө татан авах тухай албан бичгийг УИХ-д ирүүлснийг уншиж танилцуулъя.

УИХ-ын дарга Сандагийн Бямбацогт танаа. Хуулийн төсөл татан авах тухай. УИХ-ын гишүүн Учрал, Заяабал, Ганхуяг нарын гишүүдээс 2025 оны 12 дугаар сарын 17-ны өдөр өргөн мэдүүлсэн Зөвшөөрлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг УИХ-ын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.2 дахь хэсэгт заасны дагуу татан авах саналаа үүгээр уламжилж байна. УИХ-ын гишүүн Ням-Осорын Учрал, УИХ-ын гишүүн Батжаргалын Заяабал, Хассуурийн Ганхуяг гэсэн бичиг ирүүлсэн байна. Хэлэлцэх асуудалдаа орёё.

Нэг.Сонгуулийн ерөнхий хорооны гишүүнийг томилох, чөлөөлөх тухай асуудал

СЕХ-ны гишүүнийг томилох, чөлөөлөх тухай асуудлыг хэлэлцэнэ. Монгол Улсын Ерөнхийлөгчийн саналыг Монгол Улсын Ерөнхийлөгчийн Хот, хөдөөгийн хөгжлийн бодлогын зөвлөх Төмөртөгоогийн Энхтүвшин танилцуулна. Таныг индэрт урьж байна. Ажлын хэсгийг оруулъя.

Т.Энхтүвшин: УИХ-ын дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Ерөнхийлөгчийн төв байгууллагын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.2 дахь хэсэгт заасны дагуу Дашживаагийн Ариунболдыг СЕХ-ны гишүүнээр санал болгосныг танилцуулж байна.

Дашживаагийн Ариунболд нь 1973 онд төрсөн, 53 настай. 1981-ээс 1989 онд 10 жилийн 1 дүгээр сургууль, 1989-өөс 1991 онд 10 жилийн 5 дугаар сургууль, 1991 оноос 1996 онд Цагдаагийн дээд сургуулийг хуульч мэргэжлээр төгссөн байна. 2002 онд цагдаагийн магистрыг хууль зүйн магистр зэрэгтэйгээр, 2006 онд АНУ-ын Хуурай замын командлалын цэргийн цагдаагийн сургуулийг цэргийн цагдаагийн мэргэжлээр, 2012 онд АНУ-ын Тэнгисийн цэргийн дипломын дараах сургуулийг аюулгүй байдлын магистраар, АНУ-ын Тэнгисийн явган цэргийн командлалын штабын коллежийг оператив команд штабын мэргэжлээр, 2016 онд АНУ-ын Үндэсний батлан хамгаалах их сургуулийн Дуайт Эйзенховерийн нэрэмжит Үндэсний аюулгүй байдал, нөөцийн стратегийн сургуулийг Үндэсний нөөцийн стратегийн магистр зэрэгтэйгээр тус тус төгссөн байна. Хуульч мэргэжилтэй, хууль зүйн ухааны магистр, аюулгүй байдлын судлалын магистр, Үндэсний нөөцийн стратегийн магистр зэрэгтэй, дээд боловсролтой, англи хэл, орос хэлний мэдлэгтэй. Хошууч генерал цолтой.

Ариунболд нь 1996-аас 2002 онд Хан-Уул дүүргийн цагдаагийн хэлтэст мөрдөн байцаагч, эрүүгийн төлөөлөгч, эрүүгийн ахлах төлөөлөгчөөр, 2002-оос 2003 онд Зэвсэгт хүчний 310 дугаар ангийн Энхийг сахиулах ажиллагааны үндэсний сургалтын төвийн сургагч багшаар, 2003-аас 2009 онд Зэвсэгт хүчний Жанжин штаб /ЗХЖШ/-ын Энхийг дэмжих хамтын ажиллагааны газарт мэргэжилтнээр, 2009 онд ЗХЖШ-ын Ажиллагааны удирдлагын газрын Стратеги, сургалтын бодлогын хэлтэст олон улсын ажиллагааны сургалтын ахлах мэргэжилтнээр, 2009-өөс 2010 онд ЗХЖШ-ын Ажиллагааны удирдлагын газрын Энхийг дэмжих ажиллагааны хэлтэст ахлах мэргэжилтнээр, 2012 оноос 2015 онд БХЯ-ны Гадаад хамтын ажиллагааны газрын даргаар, 2016-аас 2018 онд УИХ-ын Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны Ажлын албаны зөвлөхөөр, 2018 оноос 2021 онд Зэвсэгт хүчний Хяналт-шинжилгээ, үнэлгээний газрын хэлтсийн даргаар, Газрын даргын орлогчоор, газрын даргаар, 2021 оноос Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын

зөвлөл /ҮАБЗ/-ийн Ажлын албаны даргаар томилогдон ажиллаж байна. Төрийн албанд 34 жил ажиллаж байгаа.

Иймд Дашживаагийн Ариунболдыг Монгол Улсын СЕХ-ны гишүүнээр томилох асуудлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг хүсэж байна.

С.Бямбацогт: Баярлалаа. Улсын дээд шүүхийн саналыг Улсын дээд шүүхийн Тамгын газрын дарга Содномцэрэнгийн Заяадэлгэр танилцуулна.

С.Заяадэлгэр: УИХ-ын дарга, эрхэм гишүүд ээ, та бүхний энэ өдрийн амгаланг айлтгая.

Монгол Улсын Дээд шүүхээс СЕХ-ны гишүүнд нэр дэвшүүлсэн Доржсүрэнгийн Мөнхзоригийн танилцуулгыг хийж байна. Сонгуулийн төв байгууллагын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.2-т СЕХ-ны гишүүний 2-ыг Улсын дээд шүүх төрийн жинхэнэ албан хаагчдаас санал болгосноор томилно гэж заасан. Дээрх зохицуулалтын хүрээнд 2026 оны 5 дугаар сарын 18-ны өдрийн Монгол Улсын Дээд шүүхийн нийт шүүгчийн хуралдаанаар уг асуудлыг хэлэлцэж, Монгол Улсын СЕХ-ны гишүүнд нэр дэвшигчийг санал болгох тухай 41 дүгээр тогтоолоор нийт шүүгчийн олонхын санал авсан нэр дэвшигч Доржсүрэнгийн Мөнхзоригийн холбогдох материалыг УИХ-д хүргүүлсэн.

Нэр дэвшигч Доржсүрэнгийн Мөнхзориг нь 1980 онд төрсөн, компьютерын техник хангамж, эрх зүйч мэргэжилтэй, улсад 20 жил, төрийн албанд 20 дахь жилдээ ажиллаж байна. Д.Мөнхзориг нь 1998-аас 2003 онд ШУТИС-ийн харьяа Компьютерын техник, менежментийн сургуулийг эрх зүйч, компьютерын техник хангамж мэргэжлээр, 2011-ээс 2015 онд Түшээ дээд сургуулийг эрх зүйч мэргэжлээр, 2014-өөс 2016 онд Удирдлагын академийг төрийн захиргааны менежментээр, 2019-өөс 2021 онд Түшээ дээд сургуулийг эрх зүйн магистраар тус тус суралцаж төгссөн.

2003-аас 2007 онд Монгол Улсын Дээд шүүхийн Тамгын газарт шинжээч, референт, 2010-аас 2019 онд ШЕЗ-ийн Ажлын албанд референт, хэлтсийн дарга, 2019-өөс 2022 онд Төв аймгийн шүүхийн Тамгын газарт ахлах мэргэжилтэн, Тамгын газрын дарга, 2022 оноос Шүүхийн сахилгын хорооны Ажлын албаны даргаар ажиллаж байна. Д.Мөнхзориг нь Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2025 оны 21 дүгээр зарлигаар төрийн захиргааны тэргүүн түшмэлийн дөрөвдүгээр зэрэг дэвтэй төрийн жинхэнэ албан хаагч юм. Анхаарал тавьсанд баярлалаа. Монгол Улсын Дээд шүүхээс СЕХ-ны гишүүнд санал болгосон нэр дэвшигчийг танилцуулсан Улсын дээд шүүхийн Тамгын газрын дарга С.Заяадэлгэр.

С.Бямбацогт: Баярлалаа. Төрийн байгуулалтын байнгын хороо /ТББХ/-ны саналыг УИХ-ын гишүүн, ТББХ-ны дарга Болдын Жавхлан танилцуулна.

Б.Жавхлан: Сонгуулийн төв байгууллагын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.2 дахь хэсэгт заасны дагуу УИХ-ын ТББХ-ноос Жамсранжав овогтой Болдыг Монгол Улсын СЕХ-ны гишүүнээр томилуулахаар нэрийг нь дэвшүүлж байна.

Нэр дэвшигч Жамсранжав овогтой Болд нь 1976 онд Хэнтий аймгийн Хэрлэн суманд төрсөн, 50 настай, эхнэр, хүүхдүүдийн хамт амьдардаг. 1997 онд

Цагдаагийн дээд сургууль, 2007 онд Удирдлагын академи, 2009 онд Билиг дээд сургуульд хууль зүйн магистр зэрэг, 2023 онд Дотоод хэргийн их сургуульд хууль зүйн доктор зэрэг хамгаалсан, ЦЕГ-ын даргаар ажиллаж байна. Улсад 30 жил ажиллаж байгаа бөгөөд 1996-аас 2001 онд Хэнтий аймгийн Цагдаагийн газарт мөрдөн байцаагч, 2001-ээс 2006 онд БЗД-ийн Цагдаагийн газарт ахлах мөрдөн байцаагч, 2006-аас 2010 онд Мөрдөн байцаах газрын Эдийн засгийн гэмт хэрэг мөрдөх хэлтэст ахлах мөрдөн байцаагч, 2010-аас 2011 онд Мөрдөн байцаах газрын Онц хүнд гэмт хэрэг мөрдөх хэлтэст ахлах мөрдөн байцаагч, 2011-ээс 2014 онд Мөрдөн байцаах албаны Зохион байгуулалттай гэмт хэрэг мөрдөх хэлтэст чиглэлийн ахлах мөрдөн байцаагч, тасгийн дарга, 2014-өөс 2015 онд Зохион байгуулалттай гэмт хэрэгтэй тэмцэх газрын Хар тамхи, мансууруулах бодистой холбоотой хэрэгтэй тэмцэх хэлтэст Мөрдөн байцаах тасгийн дарга, 2015-аас 2017 онд ЭЦГ-ын Хар тамхитай тэмцэх хэлтсийн Мөрдөн байцаах тасгийн дарга, 2017-оос 2019 онд Хэнтий аймаг дахь Цагдаагийн газрын дарга, 2019-өөс 2020 онд ЦЕГ-ын дэд дарга, 2020-оос 2023 онд ЦЕГ-ын дарга, Дотоодын цэргийн командлагч, 2025 оны 10 дугаар сараас ЦЕГ-ын дарга, Дотоодын цэргийн командлагчаар тус тус ажиллаж байна.

Жамсранжав овогтой Болд нь Цэргийн хүндэт медаль, цэргийн гавьяаны одон, Цэргийн гавьяаны улаан тугийн одонгоор тус тус шагнагдсан байна. Хошууч генерал цолтой. Хэлэлцэн шийдвэрлэж өгнө үү.

С.Бямбацогт: Дараагийн нэр дэвшигчийг танилцуулъя.

Б.Жавхлан: Сонгуулийн төв байгууллагын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.2 дахь хэсэгт заасны дагуу УИХ-ын ТББХ-ноос Довдонгийн Даваанямыг Монгол Улсын СЕХ-ны гишүүнээр томилуулахаар нэрийг дэвшүүлж байна. Нэр дэвшигч Довдонгийн Давааням нь 1976 онд Улаанбаатар хотод төрсөн, 50 настай, эхнэр, хүүхдийн хамт амьдардаг, УБЕГ-ын даргаар ажилладаг. 1999 онд Цагдаагийн дээд сургууль төгссөн, 2012 онд Дотоод хэргийн их сургуульд хууль зүйн ухааны магистрын зэрэг хамгаалсан. 2000 оноос 2001 онд УМБГ-т мөрдөн байцаагч, 2009-өөс 2018 онд Гадаадын иргэн, харьяатын асуудал эрхлэх газрын зүүн бүс дэх газарт мэргэжилтэн, ахлах мэргэжилтэн, газрын дарга, 2018-аас 2023 онд Гадаадын иргэн, харьяатын асуудал эрхлэх газарт Захиргаа, удирдлагын газрын дарга, 2024 онд ХЗДХЯ-ны ТЗУГ-ын дарга, 2024-өөс 2025 онд УБЕГ-ын Тамгын газрын дарга, 2025 оны 11 дүгээр сараас УБЕГ-ын даргаар тус тус томилогдон ажиллаж байна.

Довдонгийн Давааням нь Ардын хувьсгалын 90 жилийн ойн медаль, ХЗДХЯ-ны жуух бичиг, Хууль зүйн тэргүүний ажилтан, Төрийн албаны тэргүүний ажилтан, Цэргийн гавьяаны одонгоор тус тус шагнагдсан байна. Хэлэлцэн шийдвэрлэж өгнө үү.

С.Бямбацогт: Уучлаарай, зочин танилцуулъя. УИХ-ын гишүүн Лхагвасүрэнгийн Соронзонболдын урилгаар Дорнод аймгийн Баян-Уул сумын ЕБС-ийн 1986 оны төгсөгчид УИХ-ын үйл ажиллагаа, Төрийн ордонтой танилцаж байна. 40 жилийнхээ ойг тэмдэглэж байгаа төгсөгчдөдөө нийт УИХ-ынхаа нийт гишүүдийн нэрийн өмнөөс эрүүл энх, аз жаргал, сайн сайхан бүхнийг хүсэн ерөөе. Манай Их Хурлын гишүүн Отгонбаяр, Соронзонболд, Ганхүлэг, Энхбаяр 40 жилийн ойгоо хамт тэмдэглэж байгаа юм байна. Баяр хүргэе.

ТББХ-ны санал, дүгнэлтийг УИХ-ын гишүүн, ТББХ-ны дарга Болдын Жавхлан танилцуулна. Ардчилсан намын бүлэг Тэмүүжин дарга.

Х.Тэмүүжин: Хэлэлцэж байгаа асуудлаас АН-ын бүлэг 5 өдрийн завсарлага хүсэх хүсэлт гаргаж байна. СЕХ-той холбоотой, томилгоотой холбоотой асуудлаар АН-ын бүлэг бүлгийнхээ хувьд дахиад ярилцах хэрэгцээ, шаардлага байна. Ер нь өнгөрсөн сонгуулиудын үйл явцыг хараад олон нийтийн дунд энэ сонгууль яг ардчилсан Үндсэн хуульд заасан зарчмаараа явж байна уу, үгүй юү, сонгууль хэлбэрийн төдий болсон байдлаар зөвхөн сонгууль явагдлаа гэдэг нэр хэмээгээд, ардаа эрх мэдэл, ард түмний дуу хоолой, үзэл санаанаас гадуур шийдэгдээд байна уу, үгүй юү гэх мэтчилэн олон асуудал яригдаж байгаа. Энэ яригдаж байгаа шүүмжүүдийн нэг гол эзэн СЕХ байгаа.

Тийм учраас СЕХ-той холбоотой асуудлыг няхуур ярих ёстой, ирэх 2027, 2028 оны сонгуулийг илүү нээлттэй, ил тод, ардчилсан зарчмаар нь явуулахын тулд СЕХ-нд томилогдож байгаа хүмүүсийн зан чанар болон ажиллах шударга байдал их чухал. Тэгээд энэ асуудлаар АН дахиад ярилцах шаардлага байгаа учраас хэлэлцэж байгаа асуудлаар 5 хоногийн завсарлага авч байна.

С.Бямбацогт: СЕХ 9 гишүүнтэй, 9 гишүүний 2 нь орон тооны, 7 нь орон тооны бус ажилладаг. Энэ 9 гишүүн нь бүгдээрээ төрийн жинхэнэ албан хаагч байх ёстой. Ингээд бүрэн эрхийн хугацаа нь дууссан 4 нэр дэвшигч орж ирж байгаа. Нэг нь Ерөнхийлөгчөөс санал болгодог хуультай, хуулийнхаа дагуу, Дээд шүүхээс санал болгодог, санал болгодог хуулийнхаа дагуу, УИХ-ын ТББХ-ноос 2 нэр дэвшигч санал болгодог энэ санал болгодог хуулийнхаа дагуу энэ нэр дэвшигчид орж ирж байгаа, Одоо дахиад бүрэн эрхийн хугацаа дууссан 2 нэр дэвшигчийн асуудлыг ойрын үед шийднэ. Ингээд үндсэндээ СЕХ-ны бүтцэд нэлээн томоохон өөрчлөлт орно гэдгийг хэлье.

Нухацтай ярилцах шаардлагатай гэж үзэж байгаа юм байна, нэр дэвшигчийн сонсголууд хийгдсэн. Энэ сонсголуудаар энэ 4 нэр дэвшигч орчихсон байгаа. Дараагийн 2 нэр дэвшигчийн сонсгол хигдэнэ. Тийм болохоор гишүүд нөгөө сонсгол хийгдэж байх үед нэлээн сайн ярьж байвал их зүгээр байгаа шүү гэдгийг сануулж хэлье. АН-ын бүлэгт 5 хоногийн завсарлага өглөө.

Хоёр.Бизнесийн эрх чөлөөний тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Засгийн газар 2026.06.04-ний өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/

Дараагийн асуудалдаа оръё. Бизнесийн эрх чөлөөний тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг хэлэлцэх эсэх хэлэлцүүлгийг явуулъя. Хууль санаачлагчийн илтгэлийг Монгол Улсын ЗГ-ын гишүүн, Монгол Улсын Тэргүүн Шадар сайд бөгөөд Эдийн засгийн хөгжлийн сайд Жадамбын Энхбаяр танилцуулна. Энхбаяр сайдыг дуудаарай.

Ж.Энхбаяр: УИХ-ын дарга, эрхэм гишүүд ээ, та бүгдийн энэ өдрийн амгаланг айлтгая.

Монгол Улсын Үндсэн хуулиар Монгол Улс дэлхийн эдийн засгийн хөгжлийн түгээмэл хандлага, өөрийн орны өвөрмөц онцлогт нийцсэн олон хэвшил бүхий эдийн засагтай байна гэж, Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалд эдийн

засгийн олон тулгуурт оновчтой бүтэц бүхий хөрөнгө оруулалтын тэнцвэртэй бодлого явуулах, эдийн засгийн өөрийгөө тэтгэх чадавхыг бүрдүүлж, эдийн засгийн бие даасан байдал, хэвийн үйл ажиллагааг хангах үндэсний орлогыг бүрдүүлэх бодлого баримтална гэж тусгасан.

Монгол Улсын ЗГ-аас бизнесийн орчин, хөрөнгө оруулалтын тухай хууль, эрх зүйн орчныг сайжруулах хүрээнд Бизнесийн эрх чөлөөний тухай хуулийн төсөл, түүнийг дагаж Хөрөнгө оруулалтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай болон Зөвшөөрлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт, бусад холбогдох хуулийн төслийг боловсруулан өргөн бариад байна. Эдгээр хуулийн төсөл нь бизнес, хөрөнгө оруулалтын орчныг сайжруулах, ААН, бизнес эрхлэгчдийн үйл ажиллагаа явуулахад хүндрэл болж буй саад бэрхшээлийг арилгах, таатай, тогтвортой орчныг бүрдүүлэх, ажил олгогч, баялаг бүтээгчдээ дэмжихэд чиглэсэн болно.

Та бүхэнд Бизнесийн эрх чөлөөний тухай хуулийн төслийг танилцуулъя. Эхэлье. Монгол Улс өнөөдөр хөрөнгө оруулагчдад ээлтэй байдлын хувьд нэлээн хангалтгүй ийм үзүүлэлттэй байна. Эдийн засгийн эрх чөлөөний индексээр 2025 оны байдлаар 184 улсаас 74 дүгээр байрт эрэмбэлэгдэж байгаа хэдий ч эрх зүй болон бодлогын орчин сайжруулах олон асуудлууд хуримтлагдсан байна. Үүнээс хөрөнгө оруулагчдад ээлтэй байдлын үзүүлэлтээр Монгол Улс нэлээн хойгуур 109 дүгээр байранд эрэмбэлэгдэж байгаа, энэ хөрөнгө оруулалтын орчинд гарч байгаа гомдол, маргааныг шийдвэрлэх тогтолцоог сайжруулах шаардлагатай байгааг харуулж байгаа ийм үзүүлэлт болж байна.

Одоогийн хүчин төгөлдөр үйлчилж буй Хөрөнгө оруулалтын тухай хууль 2013 онд батлагдсан байна. Уг хуулиар хөрөнгө оруулалтын хэлбэр, татварын болон татварын бус дэмжлэг, татварын орчныг тогтворжуулах болон ЗГ-тай гэрээ байгуулах зэргийг зохицуулсан ийм суурь хууль байдаг. Хөрөнгө оруулагчид хууль, эрх зүйн орчны тогтвортой байдал, ил тод, урьдчилан таамаглах боломжтой нөхцөл, хөрөнгө оруулалтын баталгаанд үндэслэн шийдвэр гаргаж, хөрөнгө оруулалтаа оруулдаг. Иймд бид өнөөгийн мөрдөж байгаа хуулийн суурийг хадгалаад, цаашаа сайжруулах, нэмэх зүйлүүдээ нэмээд, энэ хуулиа нэмэлт, өөрчлөлт болгон өргөн барьж байна.

Хөрөнгө оруулалтын тухай хуульд батлагдсанаас хойш 13 жилийн хугацаанд 17 удаа нэмэлт, өөрчлөлт хэдийгээр орсон боловч үндсэндээ өөрчлөлт нь бусад хуулийг дагалдаж орсон өөрчлөлтүүд бөгөөд хуулиар зохицуулж буй зарим харилцааг тодруулах, хууль хоорондын уялдааг сайжруулах, хуулийн хэрэгжилтийг хангах хэрэгцээ, шаардлагууд үүссэн байна. Өнгөрсөн хугацаанд хөрөнгө оруулагчийн гомдлыг үр дүнтэй шийдвэрлэх тогтолцоо бүрдэж чадаагүйгээс нийт хөрөнгө оруулалтын маргаан олон улсын арбитрт олноор очдог болсон байна. Эдийн засгийн хөгжлийн яаманд 2022 оноос хойш нийт 145 гомдол хөрөнгө оруулагчдаас ирлээ. Хөрөнгө оруулагчдын гомдлыг шийдвэрлэх талаар арга хэмжээ авч, гомдлыг шийдвэрлүүлэх үүргийг холбогдох байгууллагад өгч, ЗГ-ын 3 удаагийн тогтоол гарган ажиллаж байгаа хэдий ч хууль, эрх зүйн орчинд томоохон өөрчлөлт хэрэгтэй нь улам тодорхой болж байна.

Дэлхийн банкнаас 2023 онд гарсан Дэлхийн хөрөнгө оруулалтын өрсөлдөх чадварын тайланд дурдсанаар Монгол Улс нь хууль бусаар хөрөнгө хураан авах, валютыг хөрвүүлэх, шилжүүлэхэд хязгаар тавих асуудлаар эрсдэлтэй орны тоонд багтсан байна. Энэ нь олон улсын судалгаагаар гэрээгээ зохицсон нөхцөлд 3

хөрөнгө оруулагч тутмын нэг нь хөрөнгө оруулалтаа эргүүлэн татах, хөрөнгө хуваах, хураах асуудлын тохиолдол болгонд оруулсан хөрөнгө оруулалтынхаа 50 хувийг хөрөнгө оруулалт цуцалж байгаа ийм тооцоо гарч байна.

Нийт гомдлыг үндсэн 5 төрөлд нь ангилж үзсэн. 1 дүгээрт, төрийн байгууллагуудын үйл ажиллагаа, орон нутгийн иргэд, орон нутгийн ТББ-тай холбоотой 81 гомдол, энэ маш их нэмэгдэж байгаа гомдол. 2 дугаарт, иргэний эрх зүйн гэрээний харилцаанд үүссэн маргаан бүхий 22 гомдол. 3 дугаарт, мөрдөн шалгах ажиллагаатай холбоотой 17 гомдол. 4 дүгээрт, татварын маргаантай холбоотой 13 гомдол. 5 дугаарт, шүүхийн шийдвэр гүйцэтгэлтэй холбоотой 12 гомдол. Хэдийгээр шүүхээр асуудал ороод шийдвэрлэгдсэн хэдий ч шүүхийн шийдвэр гүйцэтгэл дээр 5-аас 8 жилийн хугацаанд шийдвэрлэгдээгүй олон асуудлууд хуримтлагдсан байна.

Монгол Улс маань 41 хуулийн хүрээнд 49 заалтаар гадаадын хөрөнгө оруулалттай ААН-ийн үйл ажиллагаа явуулж, хөрөнгө оруулалт хийхийг шууд болон шууд бусаар хориглож хязгаарлачихсан ийм эрх зүйн орчныг бүрдүүлсэн байна. Тухайлбал банк, санхүү, соёл, урлаг, үйлдвэрлэл, харилцаа холбоо, мэргэжлийн үйлчилгээ, ойн аж ахуй зэрэг салбаруудын тодорхой чиглэлээрх гадаадын хөрөнгө оруулалтыг хориглож, хязгаарласан байгаа бол хөдөө аж ахуйн /ХАА/, эрчим хүч, барилга, боловсрол, аялал жуулчлал, эрүүл мэнд, төмөр зам, уул уурхайн салбаруудын зарим үйл ажиллагааг бодлогын түвшинд шууд буюу шууд бусаар хязгаарласан байна. Ингэж хөрөнгө оруулалтыг гадаад, дотоодоор ялгах нь зах зээлийн зарчмаар өрсөлдөх бололцоог хязгаарлаж, Монгол Улсын өрсөлдөх чадварыг унагааж байгаа нэг том үзүүлэлт болж байна.

Гадаадын хөрөнгө оруулалтын орох урсгал 2025 онд 3.8 тэрбум доллар болж, өмнөх оноос 8 хувиар буурч байгаа ийм үзүүлэлт гарч байна. Нийт гадаад шууд хөрөнгө оруулалтын 40 гаруй хувийг зөвхөн Оюу толгой /ОТ/ компани, төсөл эзэлж байна. Хэдийгээр сүүлийн 3 жилд орох урсгал харьцангуй тогтвортой байгаа ч хөрөнгө оруулалтаа буцаан татах валютын гарах урсгалууд нэмэгдэж эхэллээ. Тухайлбал, 2025 онд 1.2 тэрбум долларын эргэн төлөлтийн гарах урсгал хийгдсэн байна. Уул уурхайн салбарт гадаадын хөрөнгө оруулалтыг хязгаарласан хууль, тогтоол, шийдвэрүүдийн нөлөөгөөр, төрийн бус байгууллагуудын хэт даварсан үйл ажиллагаатай холбоотойгоор хөрөнгө оруулалтууд тасралтгүй буурч байна. Мөн гадаадын хөрөнгө оруулалтад улс төр, бодлогын тогтворгүй байдал, өмчийн эрхийн сул баталгаа, авлига, хүнд суртал, шүүхийн удаашрал, давхардсан хяналт, зарим иргэний нийгмийн байгууллагуудын эсэргүүцэл, ажиллах хүчний төлбөр, квот зэрэг олон хүчин зүйлс сөргөөр нөлөөлж байна.

Гадаадын хөрөнгө оруулалттай компаниуд Монгол Улсын татвар, нийгмийн даатгалын орлогод чухал хувь нэмэр үзүүлж байгаа гэдгийг энд гаргаж байна. Гишүүд ээ, анхааралтай байгаарай. Нийт Монголд үйл ажиллагаа явуулж байгаа 4800 гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгж /ААН/ байна. Эдгээр ААН Монгол Улсын аж ахуйн нэгжийн орлогын албан татвар /ААНОАТ-ын 24 хувийг бүрдүүлж байгаа юм. Нийт цалингийн сангийн 15 хувийг бүрдүүлж байна. Нийт нийгмийн даатгалын шимтгэл /НДШ/-ийн шимтгэл төлөлтийн дүнгийн 18 хувийг гадаадын хөрөнгө оруулалттай ААН-үүд бүрдүүлж байна.

Дараагийн танилцуулга Бизнесийн эрх чөлөөний тухай хуулийн төслийн талаар танилцуулъя. Бизнесийн эрх чөлөөний тухай хууль нь эдийн засаг, нийгмийн

нөхцөл байдал нь адил төстэй орнуудад бизнес, эрх чөлөөг хамгаалж, хэт их хяналт, баримт бичгийн шаардлагыг багасгаж, төр, бизнес эрхлэгчдийн хамтын ажиллагааг хуульчилж өгч байна. Ижил төстэй Казахстан, Гүрж, Вьетнам, Киргиз, Эстони гэх улсуудад бизнес, эдийн засгийн эрх чөлөөг хангасан бие даасан хууль, эрх зүйн орчнууд мөрдөж байна. Уг хуулийн төслийг 2 хуудас бүхий бизнес эрх чөлөөний тунхгийг баталгаажуулсан малгай хууль байдлаар боловсрууллаа. Ингэхдээ 1 дүгээрт бизнесийн эрх чөлөөг хангах зарчмыг баталгаажуулах, 2 дугаарт төрийн оролцоог багасгаж бизнес эрхлэгчдийн дарамтыг бууруулах, 3 дугаарт төрийн байгууллагуудын үйл ажиллагаанд хориглох зүйлсийг жагсааж, бизнес эрхлэгчдийн хууль ёсны эрх ашгийг хамгаалсан ийм зохицуулалтуудыг хийлээ.

Бизнесийн эрх чөлөөний тухай хуулийг дагалдуулан Хөрөнгө оруулалтын тухай хууль, Зөвшөөрлийн тухай хууль болон бусад 97 хуулийн нэмэлт, өөрчлөлтийг оруулахаар бэлтгэлээ.

Хөрөнгө оруулалтын тухай 6 гол өөрчлөлтийг танилцуулъя. 1 дүгээрт хөрөнгө оруулагчийн гомдол шийдвэрлэх тогтолцоог бүрдүүлж, маргааныг олон улсын арбитраар шийдвэрлүүлэх эрхийг баталгаажуулж байгаа, 2 дугаарт хөрөнгийн зах зээлд шинэ хөрөнгө оруулалт татах татварын таатай орчныг бүрдүүлж байгаа, 3 дугаарт төрийн байгууллагуудын чиг үүргийг тодорхой болгож, хяналт шалгалтын давхардлыг бууруулж байгаа, 4 дүгээрт тогтворжуулах гэрчилгээний шалгуурыг хялбарчилж хугацааг нэмэгдүүлж байгаа, 5 дугаарт гадаадын хөрөнгө оруулалтын зарим хязгаарлалтыг цуцалж байгаа, 6 дугаарт хөрөнгө оруулалтын баталгаа, суурь зарчмыг олон улсын жишгийн дагуу хуульд тусгаж байгаа.

Нэг бүрчлэнгээ алгасаад, Зөвшөөрөл мэдэгдлийн тухай хуулийн нэмэлт, өөрчлөлтөөр бизнесийн үйл ажиллагаа дахь төрийн дарамтыг арилгах бодлогыг оруулж байгаа юм. Манай улсад бизнес шинээр эрхлэх, үйл ажиллагаа өргөжүүлэх зэрэг бүхий л үе шатанд зөвшөөрөл гэж нэрлэгдээгүй боловч бизнесийн үйл ажиллагаанд шаардагддаг, төрийн байгууллагаас олгодог баримт бичгүүдийг Төрийн бүтээмжийн хорооноос судалж үзэхэд Монгол Улсын хуулиудад бүртгэл 264, дүгнэлт 232, гэрчилгээ 132, магадлан итгэмжлэл 30, сертификат 40 зэрэг зөвшөөрөлтэй ижил төстэй зохицуулалтууд үйлчилж байна. Цаашид зөвшөөрөл шинээр бий болгоход зохицуулалтын үр нөлөөний үнэлгээ хийж, хяналт тавьдаг болох зохицуулалтыг хуульд орууллаа.

Зөвшөөрөл, мэдэгдлийн тухай хуулийн нэмэлт, өөрчлөлтөөр бизнесийн үйл ажиллагаан дахь төрийн дарамтыг буулгах байдлаар зохицуулалтуудыг орууллаа. 1 дүгээрт 1 удаагийн шинжтэй, эрсдэлийн түвшин багатай аж ахуйн үйл ажиллагааг мэдэгдлээр шууд эрхэлдэг болно. 2 дугаарт зөвшөөрлөөр эрхлэх үйл ажиллагааг зорилго, нөхцөл, онцлог, эрсдэлээс хамааруулан.../үг тасрав/

С.Бямбацогт: Индрийн микрофон өгье.

Ж.Энхбаяр: Нийт 251 тусгай зөвшөөрлөөс 233-ыг нь цахим хэлбэрээр авах боломжтой болгож байгаа. Явцын хяналт шалгалтаар үйл ажиллагаа нь хэвийн тохиолдолд зөвшөөрлийн хугацааг шууд сунгадаг болгож байгаа. Төрөөс олгож байгаа 120 зөвшөөрлийг мэргэжлийн нэгдсэн холбоодод шилжүүлэх бололцоотойгоор хуулийг өргөн барьж байна.

Гэрээ, бүртгэл, гэрчилгээ, лавлагаа зэрэг зүс нэрийг нь өөрчилсөн зөвшөөрлийг хөөцөлдөхгүй, и бизнес системд хаана юу хийхээ мэдэгдээд, хүлээлгүй шууд бизнес, хөрөнгө оруулалтын үйл ажиллагаагаа эхэлж болохоор зохицуулж байгаа. Мэдэгдээд шууд эхэлсэн иргэнд төр очиж үйлчилнэ. Төр 30 хоногийн дотор хаяг байршилд нь очиж, төрийн үйлчилгээг үзүүлэн, галын дүгнэлт гаргаж, хогийн гэрээ зэргийг хийх болно.

Бизнесийн эрх чөлөөний тухай анхдагч хууль батлагдсанаар Монгол Улсын хөгжлийн бодлогод туссан зорилтууд хангагдаж, хөрөнгө оруулалт нэмэгдэж, Монгол Улсын гадаад валютын нөөц өсөж, улмаар бизнес эрхлэлт, ажлын байрыг нэмэгдүүлэх замаар эдийн засгийн өсөлтийг нэмэгдүүлж, Монгол Улсын өрсөлдөх чадварыг сайжруулна гэж үзэж байна.

Бизнесийн эрх чөлөөний тухай анхдагч хуулийн төслийн хүрээнд Хөрөнгө оруулалтын тухай хуулийн нэмэлт, өөрчлөлт, Зөвшөөрөл, мэдэгдлийн тухай хуулийн нэмэлт, өөрчлөлт болон бусад дагалдах хуулиуд нийлсэн 99 хуулийн төслийг чуулганы хуралдаанаар хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг хүсье. Анхаарал тавьсанд баярлалаа.

С.Бямбацогт: Энхбаяр сайдад баярлалаа. Зочин танилцуулъя. Нийслэлийн ерөнхий боловсролын 105 дугаар сургуулийн Ариунтунгалаг багштай 12-ын Б ангийн сурагчид УИХ-ын үйл ажиллагаа, Төрийн ордонтой танилцаж байна. Төрийн ордонтой танилцаж байгаа сурагч багачууддаа удахгүй болох элсэлтийн ерөнхий шалгалтаа амжилттай өгч, хүссэн мэргэжлээрээ хүссэн сургуульдаа орохыг нийт гишүүдийнхээ нэрийн өмнөөс хүсэн ерөөе. Төслүүдийн талаарх Эдийн засгийн байнгын хорооны санал, дүгнэлтийг УИХ-ын гишүүн Баатаржавын Мөнхсоёл танилцуулна. Таныг индэрт урьж байна.

Б.Мөнхсоёл: УИХ-ын дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын 3Г-аас 2026 оны 6-р сарын 4-ний өдөр УИХ-д өргөн мэдүүлсэн Бизнесийн эрх чөлөөний тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэх эсэх асуудлыг Эдийн засгийн байнгын хороо 2026 оны 6-р сарын 9-ний өдрийн хуралдаанаар хэлэлцлээ.

Хууль санаачлагч иргэн, хуулийн этгээдийн бизнесийн үйл ажиллагаа эрхлэх эрх, бизнесийн орчин дахь төрийн оролцооны хязгаарыг тогтоох, шударга өрсөлдөөнийг дэмжих, хууль тогтоомж, акт батлах замаар бизнесийн үйл ажиллагаанд хүндрэл, дарамт үзүүлдэг тогтолцоог өөрчлөх, хууль зөрчигчид хүлээлгэх хариуцлагын зохицуулалтыг тусган, тус анхдагч хуулийн төслийг боловсруулсан байна.

Хуулийн төслийг дагалдуулан хөрөнгө оруулалт татах, дахин хөрөнгө оруулалтыг идэвхжүүлэх, хөрөнгө оруулагчийн хууль ёсны баталгааг хангах зорилгоор Хөрөнгө оруулалтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл, бизнесийн үйл ажиллагаа эрхлэхэд олгох зөвшөөрлийн тоо хэмжээ, шалгуурыг бууруулах, зарим төрлийн үйл ажиллагааг мэдэгдэл хүргүүлснээр эрхлэх боломжийг бий болгох зорилгоор Зөвшөөрлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулж, эдгээртэй нийцүүлэн бусад хуулийн төслүүдийг боловсруулжээ.

Хуулийн төслүүд батлагдсанаар иргэн, хуулийн этгээд, холбогдох төрийн байгууллагад нэмэлт зардал гаргахгүй, улсын төсвөөр ачаалал үүсэхгүй гэж тооцсон байна. Хуулийн төслийг dparliament.mn цахим хуудаст байршуулж иргэд, олон нийтийн саналыг авч байгаа болно.

Байнгын хорооны хуралдаанаар хуулийн төслийг хэлэлцэх үед УИХ-ын гишүүн Л.Соронзонболд Зөвшөөрлийн зөвлөлөөр батлагдаагүй орхигдсон, давхардсан болон яамдын сонирхлын зөрчилтэй зөвшөөрлүүдийг хэрхэн цэгцэлж байгаа талаар, мөн гадаад зах зээлээс эх үүсвэр татсан банкнаас бусад хувийн компаниудын хүүгийн орлогын татвар энэ өөрчлөлтөд хамрагдаж буурах эсэх талаар, УИХ-ын гишүүн О.Батнайрамдал бизнесийн эрх чөлөөний хуулийн төслийн 4.2-т заасан үндэслэлгүй мэдээллийг хэн, ямар тодорхой шалгуурын дагуу тогтоох, энэ нь үг хэлэх болон хэвлэлийн эрх чөлөөг хязгаарлах эрсдэл үүсгэх эсэх, мөн ашигт малтмалын лицензийн сонгон шалгаруулалтад 2 дугаар байрт орсон оролцогчийг шууд эрхжүүлэх зохицуулалтыг дахин хуульчилж буй үндэслэл болон үүнээс үүдэж болзошгүй гажуудлаас хэрхэн сэргийлэх, түүнчлэн Хөрөнгө оруулалтын тухай хуулийн төслийн хүрээнд тогтворжуулалтын хугацааг 20 жил болгон нэмэгдүүлсэн өөрчлөлт нь уул уурхайн салбарт хамаарах эсэх талаар, УИХ-ын гишүүн О.Номинчимэг хуулийн төсөл дэх бизнес эрхлэгчийн нэр хүндэд халдсан үндэслэлгүй мэдээллийг тооцох шалгуур, шийдвэрлэх субъект, хариуцлагын тогтолцоог хэрхэн тодорхойлсон, мөн Хөрөнгө оруулалтын тухай хуулийн өөрчлөлтөөр олон улсын хөрөнгө оруулалтын эрх зүйн зарчмуудыг дотоодын хуульд шууд тусгаснаар гадаад, дотоод хөрөнгө оруулагчдын тэнцвэр, үндэсний үйлдвэрлэл, жижиг, дунд үйлдвэр /ЖДҮ/-лэлийг дэмжих бодлогод ямар нөлөө үзүүлэхээр тооцсон, түүнчлэн үндэсний таатай нөхцөл гэх ойлголтыг зөвхөн тодорхойлолтод оруулсан атлаа бодит зохицуулалтад тусгаагүй нь ямар бодлогын үндэслэлтэй болох талаар,

УИХ-ын гишүүн Б.Жаргалан Бизнесийн эрх чөлөөний тухай хууль болон дагалдах багц хуулиудыг яаралтай горимоор, нүсэр байдлаар нэгтгэн өргөн барьсан нь бодлогын уялдаа, зохицуулалтын чанарт сөргөөр нөлөөлөх эсэх, зөвшөөрлийн тогтолцоог шинэчлэх нэрийн доор нэршил, бүтэцтэй холбоотой механик өөрчлөлтүүд хийх бодит шаардлага байгаа эсэх, мөн Хөрөнгө оруулалтын тухай болон Ашигт малтмалын тухай хуулиудад тусгагдаж буй зохицуулалтууд нь нэг талаас бизнесийн эрх чөлөөг тэлэх, нөгөө талаас шинэ зөвшөөрөл нэмэх зэргээр хоорондоо зөрчилдөж буй бодлогын уялдааны талаар, УИХ-ын гишүүн П.Сайнзориг хуулийн төсөлтэй хамт өргөн барьсан дагалдах хуулийн төслүүд нь арбитрын нууцлал, нийтийн мэдээлэл, улсын бүртгэлийн суурь зарчим зэрэг салбарын үндсэн концепцыг алдагдуулж болзошгүй байгаа бөгөөд эдгээр өөрчлөлтүүдийг ямар судалгаа, бодлогын баримт бичиг, олон улсын жишиг, үзэл баримтлалд үндэслэн боловсруулсан талаар, мөн уг эрсдэлүүдээс урьдчилан сэргийлэх зохицуулалтыг хэрхэн тусгасан талаар, УИХ-ын гишүүн М.Мандхай зөвшөөрлийн тогтолцоог сулруулснаар бизнес эрхлэгчдэд төвлөрөх эрсдэл үүсэж болзошгүй санхүүгийн хохирлыг даатгалын тогтолцоогоор хамгаалах механизмыг хуулийн төсөлд хэрхэн тусгасан талаар, УИХ-ын гишүүн Р.Сэддорж Уул уурхайн бүтээгдэхүүний биржийн тухай хууль болон худалдан авах ажиллагааны одоогийн зохицуулалтаас шалтгаалан дотоодын тээврийн ААН-үүд хүнд байдалд орж, металлургийн үйлдвэрүүд түүхий эдийн хомсдолд орж байгааг хэрхэн шийдвэрлэх, энэ чиглэлд хуульд өөрчлөлт оруулах боломжийн талаар тус тус асуулт асууж, хариулт авсан болно.

Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүд хуулийн төсөлтэй холбогдуулан асуулт асууж, хариулт авч дууссаны дараа УИХ-ын гишүүн О.Батнайрамдал хуулийн төслийг зарчмын хувьд дэмжиж байгаа боловч дагалдах хуулийн төслийн өөрчлөлтүүдэд анхаарах асуудлууд байгаа талаар, тухайлбал ашигт малтмалын лицензийн зохицуулалт болон онооны босгыг хуульд тусгасан нь өмнөх сөрөг туршлагыг давтах эрсдэлтэй талаар, мөн Хөрөнгө оруулалтын тухай хуулийн төслийн хүрээнд тогтворжуулалтын хугацааг нэмэгдүүлж байгаа нь олон улсын жишигтэй нийцэж буй эсэхэд эргэлзээтэй тул ажлын хэсгийн шатанд нухацтай хэлэлцэх шаардлагатай талаар, УИХ-ын гишүүн Б.Мөнхсоёл хуулийн төслийн үзэл баримтлалын хүрээнд дэмжиж байгаа бөгөөд өнөөгийн эдийн засгийн нөхцөлд гадаад, дотоодын хөрөнгө оруулалтыг татах эрх зүйн орчныг сайжруулах нь зайлшгүй шаардлагатай талаар, ялангуяа тогтворжуулалтын зохицуулалт нь хөрөнгө оруулагчдын эрсдэлийг бууруулж, өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэх чухал механизм бөгөөд хуулийн төслүүдийн нарийвчилсан зохицуулалтыг ажлын хэсгийн шатанд сайжруулах талаар, УИХ-ын гишүүн О.Номинчимэг хуулийн төслийг зарчмын хувьд дэмжиж байгаа бөгөөд өмнө нь боловсруулсан Зөвшөөрлийн тухай хуулийн төслийг тусад нь хурдан хэлэлцэх боломжтой, мөн Хөрөнгө оруулалтын тухай, Арбитрын тухай хуулийн төсөл зэрэг зарим хуулиудыг салгаж, олон улсын эрх зүйн зарчимтай уялдуулан гүн гүнзгий судалж боловсруулах шаардлагатай талаар,

УИХ-ын гишүүн П.Сайнзориг хуулийн төслийг зарчмын хувьд дэмжиж байгаа боловч хамт дагалдуулан өргөн барьсан хууль, эрх зүйн өөрчлөлтүүд нь салбар тус бүрийн суурь зарчим, концепцтой зөрчилдөж болзошгүй талаар, тухайлбал арбитрын маргааны нууцлалын үндсэн зарчмыг алдагдуулах, согтууруулах ундааны зохицуулалтыг хэт сулруулах, Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн зорилго, агуулгыг өөрчилж, бизнесийн бүртгэлийн шинжтэй болгох, мөн улсын бүртгэлийн суурь бүртгэлийн тогтолцоог эвдэж, баталгаажсан мэдээллээс бус төрөлжсөн мэдээллээс хамааралтай болгох зэрэг өөрчлөлтүүд нь төрийн мэдээллийн үнэн зөв байдал, хууль тогтоомжийн уялдаа, салбар хоорондын зохицуулалтын чанарт эрсдэл үүсгэж болзошгүй талаар, УИХ-ын гишүүн М.Мандхай зөвшөөрлийн тогтолцоог сулруулах бодлогын хүрээнд бизнесийн үйл ажиллагаанд төрийн хяналтын давтамж багасаж, болзошгүй эрсдэл, хохирлыг бизнес эрхлэгч өөрөө бүрэн хариуцах нөхцөл бүрдэж байна гэж үзэж байгаа бөгөөд байгаль орчин, хүнсний аюулгүй байдал, хөдөлмөрийн эрүүл ахуй зэрэг нийтийн эрх ашигтай холбоотой салбарт санамсаргүй эрсдэл үүссэн тохиолдолд бизнесийн үйл ажиллагааг зогсоох, түдгэлзүүлэх шийдвэр гарснаар их хэмжээний санхүүгийн хохирол үүсэх бодит эрсдэлтэй талаар, ийм нөхцөлд эрсдэлийг бууруулах, бизнесийн тогтвортой байдлыг хадгалах зорилгоор даатгалын тогтолцоонд суурилсан хамгаалалтын механизмыг хуульд тусгах шаардлагатай талаар тус тус санал хэлсэн болно.

Байнгын хорооны хуралдаанаар Монгол УИХ-ын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.11 дэх хэсэгт заасныг баримтлан Бизнесийн эрх чөлөөний тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төсөл тус бүрийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжих эсэх талаар санал хураалт явуулахад хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжиж, чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх нь зүйтэй гэж үзсэн болно.

УИХ-ын эрхэм гишүүд ээ, Бизнесийн эрх чөлөөний тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн: 1-д Авто замын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах

тухай, 2-т Автотээврийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, 3-д Агаарын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, 4-т ААНОАТ-ын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, 5-д Ажиллах хүчний шилжилт хөдөлгөөний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, 6-д Амьтны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, 7-д Арбитрын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, 8-д Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, 9-д Аудитын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, 10-д Ашигт малтмалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай,

11-д Байгаль орчныг хамгаалах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, 12-д Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, 13-д Байгалийн ургамлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, 14-д Банкны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, 15-д Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, 16-д Барилгын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, 17-д Боловсролын ерөнхий хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, 18-д Гаалийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, 19-д Гаалийн тариф, гаалийн татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, 20-д Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, 21-д Газрын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, 22-т Газрын тосны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, 23-д Газрын тосны бүтээгдэхүүний тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, 24-т Газрын хэвлийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, 25-д Гамшгаас хамгаалах тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, 26-д Генетик нөөцийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, 27-д Геодези, зураг зүйн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, 28-д Гэрийн тэжээвэр амьтны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, 29-д Гэрээт харуул хамгаалалтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, 30-д Даатгалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай,

31-д Даатгалын мэргэжлийн оролцогчийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, 32-д Дипломат албаны тухай хуульд нэмэлт оруулах тухай, 33-д Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, 34-д Зар сурталчилгааны тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, 35-д Засгийн газрын тусгай сангийн тухай хуульд нэмэлт оруулах тухай, 36-д Зөвшөөрлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, 37-д Зөрчлийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, 38-д Зээлийн мэдээллийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, 39.../үг тасрав/

С.Бямбацогт: Индрийн микрофон өгье.

Б.Мөнхсоёл: Нийт 99 хууль байгаа. 35.3Г тусгай сан хэлсэн. 36-д Зөвшөөрлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, 37-д Зөрчлийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, 38-д Зээлийн мэдээллийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, 39-д Кадастрын зураглал ба газрын кадастрын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, 40-д Малын генетик нөөцийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, 41-д Мал, амьтны тэжээл, тэжээлийн нэмэлтийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, 42-д Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын эргэлтэд хяналт тавих тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, 43-д Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, 44-т Монгол Улсын хилийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, 45-д Нийгмийн даатгалын ерөнхий хуульд өөрчлөлт оруулах тухай, 46-д Нийгмийн халамжийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, 47-д Нийтийн

мэдээллийн ил тод байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, 48-д Ойн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, 49-д Оюуны өмчийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, 50-д Өргөн нэвтрүүлгийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, 51-д Радио долгионы тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, 52-д Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, 53-д Согтууруулах ундааны эргэлтэд хяналт тавих, архидан согтуурахтай тэмцэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, 54-д Стандартчилал, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээний итгэмжлэлийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, 55-д Тамхины хяналтын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, 56-д Таримал ургамлын үр, сортын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, 57-д Татварын мэргэшсэн зөвлөх үйлчилгээний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, 58-д Төлбөр тооцоог үндэсний мөнгөн тэмдэгтээр гүйцэтгэх тухай хуульд нэмэлт оруулах тухай, 59-д Төмөр замын тээврийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, 60-д Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай,

61-д Төрийн хяналт шалгалтын тухай хуульд нэмэлт оруулах тухай, 62-д Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, 63-д Түгээмэл тархацтай ашигт малтмалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, 64-д Тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийн эргэлтэд хяналт тавих тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, 65-д Улсын бүртгэлийн ерөнхий хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, 66-д Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, 67-д Усан замын тээврийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, 68-д Усны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, 69-д Ургамлын эрүүл мэнд, ургамал хамгааллын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, 70-д Уул уурхайн бүтээгдэхүүний биржийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, 71-д Үнэт цаасны зах зээлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, 72-д Үйлдвэрлэл, технологийн паркийн эрх зүйн байдлын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, 73-д Хадгаламж, зээлийн хоршооны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, 74-д Харилцаа холбооны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, 75-д Химийн хорт болон аюултай бодисын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, 76-д Хог хаягдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, 77-д Ховордсон амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай эд зүйлийн гадаад худалдааг зохицуулах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, 78-д Хот байгуулалтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, 79-д Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалтын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, 80-д Хөдөө аж ахуйн гаралтай бараа, түүхий эдийн биржийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай,

81-д Хөрөнгө оруулалтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, 82-д Хөрөнгө оруулалтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хууль, 83-д Хөрөнгийн үнэлгээний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, 84-д Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, 85-д Хөрөнгө оруулалтын сангийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, 86-д Хувийн хамгаалалтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, 87-д Хувиргасан амьд организмын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, 88-д ХХОАТ-ын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, 89-д Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, 90-д Хүүхэд харах үйлчилгээний тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, 91-д Цөмийн энергийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, 92-д Чөлөөт бүсийн

тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, 93-д Шилэн дансны тухай хуульд нэмэлт оруулах тухай, 94-д Шуудангийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, 95-д Шүүх шинжилгээний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, 96-д Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, 97-д Эмнэлгийн тусламж, үйлчилгээний тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, 98-д Эрүүл мэндийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, 99-д Эрчим хүчний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүдийг хэлэлцэх эсэх хэлэлцүүлгийг явуулсан талаар Эдийн засгийн байнгын хорооны санал, дүгнэлтийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг хүсье. Анхаарал тавьсанд баярлалаа.

С.Бямбацогт: Мөнхсоёл гишүүнд баярлалаа. Зочин танилцуулъя. УИХ-ын гишүүн Загджавын Мэндсайханы урилгаар Ховд аймгийн ерөнхий боловсролын 1 дүгээр сургуулийн 1976 оны төгсөгчид УИХ-ын үйл ажиллагаа, Төрийн ордонтой танилцаж байна. Төгсөлтийнхөө 50 жилийн ойг тэмдэглэж байгаа иргэддээ УИХ-ынхаа нийт гишүүдийн нэрийн өмнөөс эрүүл энх, аз жаргал, сайн сайхан бүхнийг хүсэн ерөөе. Манай Мэндсайхан гишүүний ээж, сайдын ээж Урнаа эгч тэнд байж байна. Баяр хүргэе бүгдэд нь.

Ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг танилцуулъя. Монгол Улсын Ерөнхий сайд Ням-Осорын Учрал, Жадамбын Энхбаяр Тэргүүн шадар сайд бөгөөд Эдийн засгийн хөгжлийн сайд, Тогмидын Доржханд Шадар сайд, Хаш-Эрдэнийн Сүрэнхорол Ерөнхий сайдын зөвлөх, Сүхээгийн Тэнгис Засаглал, цахим бодлого, хариуцсан Ерөнхий сайдын зөвлөх, Содномдоржийн Сансар Шадар сайдын зөвлөх, Билэгтийн Зандан Хөрөнгө оруулалт, худалдааны газрын дарга, Батхишигийн Мөнх-Эрдэнэ Эдийн засаг, хөгжлийн яамны Макро эдийн засгийн бодлогын газрын дарга, Батжаргалын Төгөлдөр Эдийн засгийн хөгжлийн яамны Хөрөнгө оруулалтын бодлогын газрын дарга, Саруулын Пүрэвсүрэн Эдийн засаг, хөгжлийн яамны Хөрөнгө оруулалтын бодлогын газрын Ногоон хөгжлийн хэлтсийн дарга, Жамбалдоржийн Мягмарсүрэн, Эдийн засаг, хөгжлийн яамны Хөрөнгө оруулалтын бодлогын газрын хуулийн зөвлөх, Жамбалын Аюуш УБЕГ-ын Хуулийн этгээдийн бүртгэлийн газрын дарга ийм ажлын хэсэг хүрэлцэн ирсэн байна.

УИХ-ын тухай хуулийн 21.24-т нэгдсэн хуралдаанд мэдээлэл хийж байгаа ЗГ-ын гишүүн, ажлын хэсгийн бүрэлдэхүүнд орсон холбогдох албан тушаалтан үнэн зөв, бүрэн гүйцэт мэдээлэл өгөх үүрэгтэй. Нэгдсэн хуралдаанд мэдээлэл хийх, асуултад хариулах, тайлбар өгөх албан тушаалтан өөрийн танилцуулсан мэдээллийн үнэн зөвийг хариуцах бөгөөд мэдээллийг санаатайгаар нуун дарагдуулах, худал мэдээлэл өгөх, танилцуулах, УИХ-д худал мэдээлэл ирүүлэхийг хориглоно. Чуулганы хуралдаанд хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр хүрэлцэн ирээгүй, тайлбар өгөхөөс татгалзан, хуралдаанд оролцсон этгээдийн хуралдааны дэг зөрчсөн бол парламентыг үл хүндэтгэсэн үйлдэлд тооцож, Төрийн албаны тухай хууль болон холбогдох бусад хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ гэж заасан байдгийг ажлын хэсгийн бүрэлдэхүүнд сануулъя.

УИХ-ын гишүүд Байнгын хорооны санал, дүгнэлт, хууль санаачлагчийн илтгэл болон хуулийн төслийн үзэл баримтлалтай холбогдуулан намын бүлэгт болон бүлэгт харьяалагдаагүй гишүүдээс урьдчилан ирүүлсэн нэрсийн дагуу асуулт асууна. Одсүрэнгийн Номинчимэг гишүүн асуултаа асууя.

О.Номинчимэг: Өглөөний мэнд хүргэе. Бизнесийн эрх чөлөөний тухай хуультай холбоотой Эдийн засгийн байнгын хороон дээр нэлээн асуултууд,

тодруулах зүйл байсан. Тэгээд би яг чуулган дээр 3 юм хэлж, 1 асуулт асууя гэж бодож байна.

1 дүгээрт энэ Хөрөнгө оруулалтын тухай хууль, үүнтэй дагалдаад Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн хууль болон Арбитрын тухай хуульд өөрчлөлт орж байгаа. Тэгээд энэ дээр Байнгын хороон дээр хэлсэн, олон улсын нийтийн эрх зүй, олон улсын хөрөнгө оруулалтын эрх зүйн ойлголтуудыг дотоодын хууль тогтоомжтой холиод, хөрөнгө оруулалт гэдэг адилхан нэр томьёо дотор бүгдийг нь чихээд ингээд холион бантан шиг юм болоод байна. Энийгээ ялгаж салгах хэрэгтэй, маш том үр дагавартай. Арбитрын тухай хуульд орж байгаа өөрчлөлт чинь ч гэсэн орох ёсгүй өөрчлөлт. Хөрөнгө оруулалтын тухай хууль дээр маргаан таслах энэ асуудлыг дэмжиж байгаа боловч энэ хөрөнгө оруулалт гэдэг нэрийг яг аль утгаар нь ойлгох юм бэ? Бидний энэ энгийн бодоод байдаг зүгээр хөрөнгө оруулалт, бизнесийн үйл ажиллагаа гэж ойлгох юм уу, эсвэл энэ чинь олон улсын арбитр дээр очихоор олон улсын нийтийн эрх зүйн дагуу ойлгодог тэр эрх зүйн хэм хэмжээ, стандартаар бүгдийг нь тайлбарлаад явдаг хөрөнгө оруулалт болох уу гэдэг дээр ерөөсөө тодорхойгүй холион бантан байгаа учраас энийг маш нухацтай бид харж, засаж явуулах ёстой шүү гэдгийг дахиж хэлмээр байна.

2 дугаарт Энхбаяр сайдын танилцуулгад гарч байгаа ер нь гадаадын хөрөнгө оруулагч /ГХО/-аас байдаг юм уу, бизнес эрхлэгчдээс гарч байгаа гол гомдлуудын нэг бол шүүх дээр байна, шүүхийн маргаан шийдвэрлэх асуудал дээр гарсан шүүхийн шийдвэрүүд нь биелэхгүй байгаа гомдлууд байна гэж байгаа. Тэгэхээр яг энэ бизнесийн эрх зүйн орчныг бизнес эрхлэгчдэд, хөрөнгө оруулагчдад эрсдэлээ үнэлэх экзит план /exit plan/ буюу хөрөнгө оруулалтаа татах энэ асуудлууд нь хамгийн тодорхой ийм орчныг бүрдүүлэхийн тулд яалт ч үгүй энэ шүүхийн процесс болон шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн хуулиуд маш чухал байгаа. Тэгэхээр ЗГ энэ шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн хууль нэлээн бэлэн болсон гэж ойлгож байгаа, тэрийгээ, энэ суурь асуудлуудаа шийдэх асуудлуудыг оруулж ирмээр байгаа юм, ийм дагасан жижиг хуулиудаас гадна суурь хүлээгдэж байгаа реформууд байгаа, тэрийг Иргэний хэргийн шүүхийн процессын хууль болон Шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн тухай хуулийг эртхэн оруулж ирж байж, энэ сайн дохио болно шүү гэдгийг хэлмээр байна.

3-д Энхбаяр сайдын танилцуулга дээр байсан. Ер нь яах вэ энэ хуультай ингээд төрийн тэр зөвшөөрөл эд нарыг багасгая, энэ тэр гэдгээс гадна бизнес эрхлэгчдээс ирдэг хамгийн гол энэ эрх чөлөөнд халдаад байгаа нэг юм бол ерөөсөө хууль, шүүхийн байгууллага, цагдаа, татвараар айлгаж далайлгаж байгаад, дарамталж байгаад янз бүрийн байдлаар давуу эрх гаргадаг, эсвэл өрсөлдөөнийг нь хаадаг ийм асуудлууд гардаг гээд. Тэгэхээр яг энэ чиглэлийн, энэ бизнесийн эрх чөлөөг хангахтай холбоотой асуудал дээр судалгаа хийгдсэн үү? Ер нь хэдэн ААН дээр татварын шалгалтыг хууль бусаар хийсэн ч гэдэг юм уу, эсвэл компанийн захирлуудыг энэ татвараас зайлсхийсэн гэдэг асуудлаар шалгасан ч гэдэг юм уу, мөнгө угаах гэдэг асуудлаар шалгасан цагдаа дээр хэд шалгагдаад, тэр нь прокурор луу хэд очоод, хэр удаад, тэгээд тэрнээсээ хэд нь шүүх рүү очоод, шүүх дээр хэд нь шийдэгдээд тэрнийх нь дагуу ийм гомдлууд гарч байна гэсэн тоон статистик байгаа юу?

Бид ийм нөгөө зөөлөн аргаар буюу зохицуулалтын өөрчлөлт хийхээс гадна хамгийн гол ингээд хүчтэй тэр дарамталж байгаа нэг хэрэгсэл цагдаа, шүүх болон янз бүрийн гэмт хэрэг, татвараас зайлсхийх, эдийн засгийн гэмт хэрэгт

буруутгагдаад дарамтлах ийм асуудлууд байгаад байгаа юм. Шүүхийн шат руугаа очихгүй ч гэсэн цагдаа, прокурор дээр ингээд цацдаг. Тэгэхээр энэ чиглэлийн юмыг та бүхэн энэ бизнесийн эрх чөлөөг хангах асуудал дээр авч үзэв үү, судлав уу? Тооцоо, дата судалгаа ер нь энэ дээр байна уу гэдэг асуултыг асуумаар байна.

С.Бямбацогт: Хэн хариулах вэ? Энхбаяр сайд, Шадар сайд хариулъя.

Ж.Энхбаяр: Арбитрын асуудал дээр ажлын хэсэг бэлдэж байгаарай. Сүүлд Ерөнхий сайдаас үүрэг өгөгдөөд Эдийн засаг, хөгжлийн яаман дээр Хөрөнгө оруулагчдын эрх ашиг хамгаалах ийм санал хүсэлтийг хүлээж авах төвийг байгуулж ажиллуул гэдэг үүрэг авсан, 6 сар гаруй ажилласан. Бүхий л Монгол Улсад хөрөнгө оруулалт хийсэн ААН-үүдийг салбар бүрээр, улс бүрээр нь уулзаж ярилцлага хийж, энэ хуулийнхаа төслөө танилцуулж, ААН-үүдийн гомдлыг хүлээж авсан. Нийт Эдийн засаг, хөгжлийн яаманд 145 гомдол хөрөнгө оруулагчдаас ирсэн. Төрийн байгууллагын шийдвэр, үйл ажиллагаатай холбоотой 81 гомдол, иргэний эрх зүйн гэрээний харилцаатай холбоотой 22 гомдол, мөрдөн шалгах ажиллагаатай холбоотой 17 гомдол, татварын маргаантай асуудалтай холбоотой 13 гомдол, шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаатай холбоотой 12 гомдол ирсэн байна.

Ер нь ингээд ирсэн гомдлуудтай холбоотой, ер нь эрх зүйн орчинтой холбоотой 6 сарын хугацаанд ажлын хэсэг ажиллаж дүгнэлт хийж, олон нийтийн хэлэлцүүлгийг зохион байгуулсан. 1 дүгээрт ер нь бизнесийнхээ эрх чөлөөг баталгаажуулах хэрэгтэй юм байна, суурь хуультай болох ёстой юм байна. Хуулиар хориглоогүй бизнесийн үйл ажиллагааг чөлөөтэй эрхлэхийг баталгаажуулж өгөх ёстой юм байна. Төрийн оролцоог эрс багасгах ёстой юм байна. Бизнес эрхлэгчид тулгарч байгаа бүхий л шатны төрийн байгууллага, орон нутгаас үзүүлж байгаа дарамтыг бууруулах ёстой юм байна. Төр бизнестэй өрсөлдөхгүй байх ёстой юм байна. Ялангуяа бизнесийн нэр хүнд, өмчийн эрхийг, өмчийн халдашгүй байдлыг хангахгүй бол энэ хөрөнгө оруулалтын орчин, бизнес орчин их муудсан байна гэдэг ийм дүгнэлтэд хүрсэн.

Ийм учир энэ Хөрөнгө оруулалтын хууль болон Зөвшөөрлийн хуультай холбоотой 97 хуульд нэмэлт, өөрчлөлт оруулахаар Их Хуралд өргөн барилаа. Таны гаргаж байгаа саналтай холбоотойгоор Ардчилсан нам /АН/ Эдийн засгийн эрх чөлөөний тухай хуулийг өргөн барьсан, энэ 2 хуулийг нэгтгээд Их Хурлаас ажлын хэсэг хамтарч байгуулаад, ингээд хамтраад улам боловсронгуй болгоод гаргах бололцоотой гэж үзэж байгаа. Тэгэхээр ажлын хэсэг хэлэлцүүлгийн явцад улам сайжраад, улам боловсронгуй болоод явахад нээлттэй байна. Ажлын хэсэг Арбитрын хуультай холбоотой, маргаантай холбоотой.

С.Бямбацогт: Зочин танилцуулъя. Говь-Алтай аймгийн Лодойдамбын нэрэмжит ерөнхий боловсролын 2 дугаар сургуулийн 1976 оны төгсөгчид УИХ-ын үйл ажиллагаа, Төрийн ордонтой танилцаж байна. Төрийн ордонтой танилцаж байгаа, 50 жилийнхээ төгсөлтийн ойг тэмдэглэж байгаа иргэддээ УИХ-ынхаа нийт гишүүдийн нэрийн өмнөөс эрүүл энх, аз жаргал, сайн сайхан бүхнийг хүсэн ерөөе. Бөхчулууны Пүрэвдорж асуултаа асууя. Хариулах юм уу, ажлын хэсэг хариулъя, 4 дүгээр микрофон, индрийн 4.

Т.Алтангэрэл: Алтангэрэл гэж хүн байна, ажлын хэсгийн гишүүн, олон улсын арбитрч, "Оюуны инновац" ТББ-ын удирдах зөвлөлийн дарга, хууль зүйн ухааны доктор байна. Арбитрын чиглэлээр асуулт тавьсан Номинчимэг гишүүнд хариу өгье.

Тэгэхээр Хөрөнгө оруулалтын тухай хууль болон Арбитрын тухай хуулиар бодлогын хувьд ямар өөрчлөлт орж байна вэ гэхээр, одоогийн энэ мөрдөж байгаа, хүчин төгөлдөр байгаа Хөрөнгө оруулалтын тухай хуульд арбитрын хэлэлцээр их хязгаарлагдмал хүрээнд байгаа. Өөрөөр хэлбэл зөвхөн хөрөнгө оруулалтын гэрээ байгуулсан талууд арбитрын хэлэлцээрт буюу арбитрын харьяаллаар маргаанаа шийдүүлэх ийм боломжтой байгаа. Тэгэхээр энэ нь өөрөө зөвхөн цөөн тооны хөрөнгө оруулалтын гэрээ байгуулсан.../минут дуусав/

С.Бямбацогт: Тодруулж асууя, Номинчимэг гишүүн.

О.Номинчимэг: Тийм, энэ арбитрын асуудлыг мэдэж байгаа, би өөрөө олон улсын арбитрч байсан, би өөрөө энэ хөрөнгө оруулалтын маргаанууд дээр ажиллаж байсан, Монгол Улсын эрх ашгийг хамгаалахын төлөө явж байсан. Энэ үг, үсэг чинь олон улс дээр очоод яаж тайлбарлагдах вэ гэдэг дээр л би санаа зовоод байгаа байхгүй юу, холигдчихсон байна гэдэгт. Тэгэхээр тэр бол бид засах ёстой, ажлын хэсэг гарах юм байна гэж ойлголоо. Миний гол асуулт, яг энэ эдийн засгийн эрх чөлөөнд халдаад байдаг энэ хууль, хүчний байгууллагын оролцоо, мөрдөн шалгах байдаг юм уу, цагдаа, прокурор дээр эдийн засгийн гэмт хэргээр далайлгаж, эсвэл татварын шалгалтаар далайлгаж ингэж дарамталдаг асуудлын талаар та бүхэн судалгаа хийв үү, тоо баримт байна уу? Энэний чиглэлээр бид юу шинэчлэх шаардлагатай байна гэж үзэж байна вэ. Бид бизнесээс асуухаар ер нь тэгээд л нэг юм хийлээ, нэг шалгалт оруулдаг, тэрнийхээ дагуу бөөн дууддаг, баахан янаглаж тэр цагдаа, прокурор дээрээ байлгадаг, олон жил болгодог, ингэж байж байгаад нэг юм хийдэг гэсэн л ийм л асуудал байдаг шүү дээ. Тэгэхээр энэ чиглэлийнх нь шинэчлэлийг бид хамт бодож хийхийн тулд.../минут дуусав/

С.Бямбацогт: Нэмэлт асуулт, хариулт 1 минутад багтах ёстой, минутдаа багтаагаад гүйцэд хариулахыг хичээгээрэй. Энхбаяр сайд Шадар сайд хариулъя.

Ж.Энхбаяр: Нэг ийм зүйл төрийн байгууллагууд хавтгай болсон нэг зүйл байна. Зөвшөөрлийг нь хязгаарлаад ирэхээр бүртгэл гээд гаргадаг, заавал бүртгүүлнэ гээд 267 шаардлага байна. Тэр байгууллагаас дүгнэлт авах ёстой гээд 232 дүгнэлтийн шаардлага байна. Энийгээ заавал гэрчилгээжүүлнэ гэхээр тэр нь 132 салбар салбарт, ингээд тэрийг нь шийдээд ирэхээр нь энүүгээр магадлан итгэмжлэлд орсон байх ёстой гээд тэр нь 30, энэ сертификаттай байх ёстой 9 гээд ийм олон зөвшөөрөл гэж зохицуулаагүй боловч зөвшөөрлөөсөө давсан ийм бизнесийн орчинд сөрөг нөлөөлж байгаа босгууд их байгаа юм. Хүнд суртал, дэгээ гохнууд их байна, энэ болгоныг нь л арилгая гэж байгаа юм. Энэ болгоныг чинь бариад нөгөө хууль, шүүхийн байгууллага дээр, хүчний байгууллага дээр асуудал гараад байгаа нь энэ. Та энийг зөрчсөн байна шүү дээ, энэ сертификат чинь дутуу байна, хугацаа нь дууссан байна, ийм гэрчилгээ чинь.../минут дуусав/

С.Бямбацогт: Тодруулъя Номинчимэг гишүүн.

О.Номинчимэг: Энхбаяр сайдаа, наадах чинь бол ер нь төрийн дунд шатныхан байдаг юм уу, өөр хүмүүс ингэж нэг шантаажилж байгаад авлига авах ч юм уу, мөнгө авах ч юм уу эсвэл удаашруулчихаад байгаа ингэдэг л нэг хэлбэр болчихоод байгаа юм, зөвшөөрөлтэй холбоотой. Тэгэхээр энийг хөнгөлөх дээр бол санал нэгдэж байгаа. Зүгээр миний яриад байгаа юм нь нөгөө эрх чөлөөг боомилох нэг арга бол, эсвэл тэр өмчийн эрхэд халдаж байгаа нэг арга хэлбэр, хамгийн ноцтой нь тэр гэмт хэрэг, хууль хүчний байгууллагаар далайлах байхгүй юу.

Тэгэхээр тэрэнтэй холбоотой юмыг бид тоо судалгааг болбол уг нь хамт авч байгаад юун дээрээ байгаад байна, ямар хуулийн цоорхой байгаад байна уу, эсвэл юундаа байгаад байна гэдэгт нэг дүн шинжилгээ хийгээд хийвэл нэг ийм бизнесийнхээ эрх чөлөө, бизнес эрхлэгчийнхээ эрх чөлөөг хамгаалах нэг алхам болох юм болов уу. Яагаад гэвэл энэ чиглэлээр их гомдол гардаг учраас гэж байгаа юм. Тэгэхээр одоохондоо тийм тооцоо судалгаа байхгүй байгаа юм байна гэж харлаа. УИХ ч гэсэн цаашдаа энэ чиглэлээр бизнесийн эрх чөлөөг дэмжье гэвэл энэ чиглэл рүү анхаарах нь зүйтэй байх л гэсэн саналтай байна. Үг хэлье.

С.Бямбацогт: Энхбаяр сайд.

Ж.Энхбаяр: Энэ асуудал яг энэ хэлэлцүүлгийн явцад олон гарсан, тантай санал нэг байгаа. Бизнес эрхэлж явж байгаад эрүүгийн гэмт хэрэгтэн болж байгаа тохиолдлууд олон байна. Нөгөө хохирлын хэмжээ 500 мянгаас дээш бол их хэмжээний асуудал, 500 саяас хүндрээд ингээд явчихдаг. Тэгэхээр энэ 2-ыг нэлээн ялгаж, энэ хөрөнгө оруулалтын дагнасан маргаан тасалдаг, дагнасан, энэ хуулийн системийг бид тусад нь салгаж өгөхгүй бол энэ эрүүгийн асуудал руу шууд халтирч ордог энэ байдал олон тохиолдол энэ гомдол дотор нэлээн байгаа. Тэгээд энэ хуулиар бид эрүүгийн мөрдөн шалгахтай холбоотой асуудлыг хөндөөгүй. Энийг тусад нь бодлого болгож оруулж ирэх ёстой юм байна. Эрүүгийн хэрэг байцаан шийтгэх хуульд том өөрчлөлт хийх нь зайлшгүй. Энэ суурь зарчмаа бид батлаад гаргаад авсны дараа бусад хөрөнгө оруулалтын орчинд саад болж байгаа энэ бусад хуулиудаа боловсронгуй болгох ийм зайлшгүй шаардлага байгаа. Тэрний нэг хэсэг нь таны яриад байгаа энэ бизнес эрхэлж байгаад эрүүгийн гэмт хэрэгтэн болж.../минут дуусав/

С.Бямбацогт: Бөхчулууны Пүрэвдорж гишүүн асуултаа асууя.

Б.Пүрэвдорж: Эдийн засгийн эрх чөлөөний шалгуурыг 2 үндсэн зарчмаар хангадаг. Нэгдүгээрх нь бизнес эрхлэх боломж, хоёрдугаарх нь шударгаар хөдөлмөр эрхлэх боломжоор дүгнэдэг. Тэгэхээр Монголчууд өнөөдөр дэврүүн сэтгэлээрээ нийтдээ 280 мянган ААН-ийг бүртгүүлж, бизнес эрхлэхийг оролдсон. Гэвч өнөөдөр 118 мянган ААН үйл ажиллагаа идэвхтэй явуулж байна, 163 мянган ААН үүд хаалгаа хаагаад энэ бизнес эрхлэх боломжоосоо татгалзаж байна. Тэгээд энэ 118 мянган ААН дотроо 30 мянга нь Х тайлан өгч байгаа шүү дээ. Тэгэхээр энэ юунаас болж байна вэ гэвэл шударгаар хөдөлмөрлөх боломжийг нь хааж байна гэсэн үг.

Яг түрүүний хэлсэнчлэн 2022 онд 1000 зөвшөөрөл олгодог байсныг нь Зөвшөөрлийн тухай хуулиар 381 зөвшөөрөл болгосон. Гэвч энэ хооронд яасан бэ гэхээр нөгөө авлига авдаг, хээл хахууль авдаг, ажилд чөдөр тушаа болдог нөхдүүд 667 нэмэлт бичиг баримтыг бий болгосон байгаа. Үүнд 264 бүртгэл, 232 дүгнэлт, 132 гэрчилгээ, 30 магадлан итгэмжлэл, 9 сертификат, сая 40 гэж хэлнэ лээ. Тэгээд ийм нэмэлт бичиг баримтуудыг гаргаад нөгөө авлига авдаг юм, ажил хийхэд садаа болдог юм нь хэвээрээ байгаад байгаа юм.

Энд нөлөөлж байгаа бас нэг шударгаар бизнес эрхлэхэд нөлөөлж байгаа нэг хүчин зүйл бол төрийн өмчийн оролцоо нийт эдийн засаг дахь. Төр өөрөө дүрэм журам тогтооно, тэгсэн мөртөө төр дүрэм журмынхаа хажуугаар өөрөө ороод бизнест оролцоод явчихна. Тэгэнгүүт төрийн оролцоо ямар өөдтэй байх вэ дээ, баахан өр ширтэй гарна, тэр өр ширтэй гарсныг нь эргэн төлдөг ийм л тогтолцоотой

болчхоод байгаа юм. Яг өнөөдрийн байдлаар 101 төрийн өмчит ААН байгаа, тэр нь нийтдээ 60 гаруй их наяд төгрөгийн өөрийн хөрөнгөтэй, 26 их наяд төгрөгийн орлоготой, тэгээд 23 их наяд төгрөгийн өр төлбөртэй байж байгаа. Тэгээд энэ төрийн өмчийн их оролцоо нь нийт эдийн засгийн чинь 70 хувь болоод явчхаж байгаа, дээрээс нь дахиад 5 мянган ААН энэ төсвийг дагаж явдаг, 5 мянган ААН байж байна. Энэ бүхэн чинь энэ төрийн оролцоо хэтэрхий данхайснаас болоод энэ бизнес хийх боломж Монголд байхгүй болчхоод байгаа юм.

Дараагийн нэг хамгийн том шалтгаан бол, дарамт бол татварын дарамт байгаа. Өнгөрсөн хугацаанд 9 төрлийн татвар шинээр болон хувийг нь нэмэгдүүлсэн, зуу зуун төлбөр, хураамжийг энэ аймаг, сум, нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар гаргаж, төлбөр, хураамжуудыг нь нэмж байгаа. Үүний үр дүнд ерөөсөө ААН-үүд эргэлтийн хөрөнгөгүй болчхоод байгаа юм. Өнөөдрийн байдлаар 6.1 их наяд төгрөгийн татварын өртэй байна. Тэрний 1.4-хөн хувийг буюу 85 тэрбум төгрөгийн өр нь 10 саяас доош өртэй 72 мянган ААН байгаа шүү дээ 85 тэрбум. Тэгээд энэ ААН-үүдийн хаалгыг нь барьдаг, дансыг нь хаадаг ийм дарамт маш их байгаад байгаа юм. Тийм учраас энэ бизнесийн эрх чөлөөний хуулиар энэ хүнд суртал, ялангуяа та нарын өнгөрсөн хугацаанд, энэ 10 жилийн туршид төр засгийг барьж байхдаа гаргасан тэр алдаа, завхралыг засна гэж найдаж байна. Гэвч харамсалтай нь яг өнгөрсөн хугацаанд энэ социализмын маягийн эдийн засгаасаа салах ийм.../минут дуусав/

С.Бямбацогт: Ерөнхий сайд хариулъя.

Н.Учрал: Энэ ЗГ чөлөөлье гэдэг бодлогыг хэрэгжүүлж байна. Энэ хүрээнд бид Зөвшөөрлийн тухай хуульд заасан 371 зөвшөөрлөөс бусад 146 төрлийн үйл ажиллагаа эрхлэхийг 100 хувь зөвшөөрсөн буюу заавал ямар нэгэн эрх олголт, магадлан итгэмжлэл, лиценз, сертификат, бүртгэл гэдэг зөвшөөрөл гэдэг нэргүй мөртөө зөвшөөрөл шиг хориглолт болж байгаа энэ хязгаарлалтуудыг авч хаясан. Ингээд license.mn олон жил холбогдож чадахгүй байсныг нь одоо үр дүнд хүргээд, та бүхэн хүсвэл e-business.mn, license.mn рүү ороод 146 төрлийн бүх төрлийн үйл ажиллагааг нийслэл, дүүрэгт хүсэлт илгээх, хариу авах шаардлагагүйгээр мэдэгдээд эхэлж байгаа. Ингэснээр өнгөрсөн хугацаанд license.mn, e-business хоёр дээр бараг зөвшөөрөлгүй, тэр зөвшөөрөл, эрх олголт, гэрчилгээ гэдэг элдэв зүйл нэхэхгүйгээр үйл ажиллагаа эхэлсэн компани, ААН-үүдийн тоо 100 гарчихсан байна. Компани байгуулагдсан байна, үйл ажиллагаагаа эрхлээд эхэлчихсэн байна. Үүнд иргэд, компани, ААН-үүд таатай хүлээж авч байна.

Зөвшөөрлийн тухай хуульд заасан 371-ээс бусад төрлийн бүх үйл ажиллагааг бид чөлөөтэй эрхлэхийг зөвшөөрнө. Дээрээс нь хувийн хэвшил дээр API сервисийг нээж байгаа, нэг ёсондоо би цахим шилжилтийн 2 дахь үеийг эхлүүлж байна. Эхлүүлсэн ажлаа бүрэн дуусгах хууль бол энэ Бизнесийн эрх чөлөөний тухай хууль гэж үзээд байгаа юм. Яагаад гэхээр компани онлайнаар байгуулаад үйл ажиллагаагаа эхлээд элдэв бичиг баримт шаардахгүйгээр эхлэх, 5 жилийн зөвшөөрөлтэй компани эрсдэлийн үнэлгээнд сууриалаад шууд автоматаар 10 жилээр сунгах энэ асуудлыг бүгдийг нь хуульд тусгаж өгсөн. Тусгай зөвшөөрөлтэйгээр эрхлэх нийт 32 төрлийн үйл ажиллагааг энэ хуулиар бүгдийг нь энгийн зөвшөөрөлд шилжүүлнэ, 22 хоногийн дотор энгийн зөвшөөрлийг хүсээд хариу өгөхгүй бол шууд эхэлнэ, 30 гаруй тусгай болон энгийн зөвшөөрлийг хүчингүй болгоно, зөвшөөрөл олгоход 20-оос 30 төрлийн шаардлага тогтоож байгааг 8

болгоно гэдэг ийм шийдлүүдийг тусгаж өгсөн. Бараг 30 гаруй энгийн зөвшөөрлийг цуцална.

Тэгэхээр одоо хүнд суртал бодитойгоор буурна. Дээрээс нь тусгай зөвшөөрөл өгсөн бол 5 жил өгчхөөд, дахиж авахын тулд шинээр өгч байгаа юм шиг бичиг баримт шаардахаа болино. Эрсдэлийн үнэлгээг хийгээд л автоматаар сунгана л гэж байгаа юм. Тэгэхээр бодитой үр дүн гарна. Энэ хуулийг батлаад өгвөл 7 дугаар сарын 1-ний өмнө бүх тусгай зөвшөөрлүүдийг эрсдэлийн үнэлгээнд сууриалаад шууд сунгалтуудыг нь хийнэ. Зөвшөөрөлгүй үйл ажиллагаа явуулах бүх төрлийн үйл ажиллагааг чөлөөтэйгөөр нээнэ. Ингээд төрийн хүнд суртлыг бууруулах ажил бодитой хэрэгжиж байгаа шүү гэдгийг хэлье.

С.Бямбацогт: Батын Батбаатар гишүүн асуултаа асууя, алга байна. Одонгийн Цогтгэрэл гишүүн асуултаа асууя, алга байна. Зочин танилцуулъя. УИХ-ын гишүүн Цэндийн Баатархүүгийн урилгаар Чингэлтэй дүүргийн 7, 8, 9, 23 дугаар хорооны иргэд УИХ-ын үйл ажиллагаа, Төрийн ордонтой танилцаж байна. Төрийн ордонтой танилцаж байгаа иргэддээ УИХ-ынхаа нийт гишүүдийн нэрийн өмнөөс эрүүл энх, аз жаргал, сайн сайхан бүхнийг хүсэн ерөөе. Манай Баатархүү гишүүн энд байж байна, сайн гишүүн шүү. Өлзийхүүгийн Шижир гишүүн асуултаа асууя.

Ө.Шижир: Өглөөний мэнд. Манай энэ ЗГ-ын сайд нар гэнэт өнөөдөр өглөө сэрсэн юм шиг л ингэсэн байна, тэгсэн байна, ийм болчихсон, тийм болчихсон, ингээд энийг буруу хийчихсэн байна, одоо засна гээд л ингэх юм. Үгүй ээ, та нар сүүлийн 10 жилд сайд бүгдээрээ хийсэн шүү дээ. УИХ-ын гишүүн гэдэг бол та нарын хувьд хамгийн бага албан тушаал байхгүй юу даа. Ингээд сайд нар нь УИХ-ын чуулганы хуралдаанд тааллаараа оролцдог болчихсон Ерөнхийлөгч шиг, хэдэн сайд байна, тоол доо. Ерөнхий сайдаа, ЗГ-ын сайд УИХ-д тааллаараа ордоггүй юм, заавал байх ёстой юм. Бүгд ингээд тааллаараа ордог болчихсон, энэ сайд нартай хариуцлага тооцдоггүй юм уу нэг?

Өнөөдөр төр ДНБ-ий 74 хувийг үйлдвэрлэж байгаа, энэ юу вэ гэхээр ЗГ улам данхайгаад, төр нь данхайгаад, чөлөөт эдийн засаг байхгүй болоод хувийн хэвшлийн орон зай байхгүй болж байна гэсэн үг. Энэ тоо ирэх жил 77 хувь руу орно. Тэгээд төр чинь улам ингээд л данхайгаад л байна. Боловсруулах салбар болон үйлдвэрлэлийн салбарын чинь эдийн засгийн уналт нь уначихсан, бид хэдхэн зэс, нүүрс, алт зарснаараа эдийн засгийн өсөлт ингээд яриад байгаа юм. Яг бодитоор хамгийн их ажлын байр шингээдэг, хамгийн их ажиллах хүчийг шингээдэг, хамгийн их татвар төлдөг ЖДҮ-ийн тэр 90 мянган ААН чинь хасагдаад байна шүү дээ. Тэгээд үүн дээр ямар бодлого байгаа юм бэ?

Тэгээд нөгөө талаасаа ингээд бизнесийн эрх чөлөө ярина, их гоё, гоё ярина. Нөгөө талаасаа үйлдэл нь хоолойг нь боогоод байдаг. ЗГ-аас өргөн барьсан Төрийн болон орон нутгийн өмчит компани үүсгэн байгуулах үндэслэл гээд заалт байгаа шүү дээ. Нийтийн зориулалттай дэд бүтэц дээр, нийтийн үйлчилгээний салбарт үйл ажиллагаа явуулна. Тодорхой салбарт зүй ёсны монополын үйл ажиллагаа явуулна. Үндэсний эдийн засгийн ашиг сонирхол хангах зорилгоор стратегийн ач холбогдол бүхий зайлшгүй үйл ажиллагаа явуулна гээд. Дэлхий дахины нөхцөл байдал өөрчлөгдвөл та нар стратегийн нөхцөл байдлыг юу гэж ойлгох юм бэ? Энэ чинь өөрчлөгдөнө шүү дээ, ийм хуульчилж болдог юм уу нэг?

Төр улам данхайгаад байна. Би өмнөх долоо хоногт Ерөнхий сайдаас асуугаад хариулаагүй юм. 100 ААН, төрийн өмчит 100 ААН, орон нутгийн 429 ААН байгаагийн чинь 32-ыг нь ЗГХЭГ авчихсан, 28-ыг нь ЭХЯ авчихсан, Сангийн яам дээр 6, ЗТЯ дээр 5, үгүй ээ тэгвэл Төрийн өмчийн хороогоор яах гээд байгаа юм та нар татан буулгачхаач. Сайд нар энэний төлөө л алалцаж байгаа шүү дээ, ТӨК-уудаар хэн хэнийгээ томилох вэ, хэн хэнийгээ явуулах вэ гэдэг л ийм юм явж байгаа шүү дээ. Энэ талдаа гоё юм ярина, нөгөө талдаа та нар яг эсрэг үйлдэл хийж байна шүү дээ, яг бодитойгоор. Нийслэл хэдэн ТӨК-тай байгааг бүү мэд.

Нөгөө талаасаа өнгөрсөн долоо хоногт төр данхайгаад байна гэсэн, Ерөнхий сайд жишээ нь 22 сайдтай, 13 зөвлөхтэй. Жишээ нь Эдийн засгийн сайд Энхбаяр, эдийн засгийн зөвлөх нь хэн юм бэ, мэдэхгүй, тэр 2-ын санал зөрөлдвөл яах вэ. Угтаа ЗГ-ын 22 сайд чинь Ерөнхий сайдын тухайн салбарын зөвлөх байхгүй юу даа, зөвлөх нь юм. Тухайн салбарын зөвлөх, Хүнс, хөдөө аж ахуйн сайд бол хүнс, ХАА-н салбарынх нь зөвлөх нь юм. Эдийн засгийн сайд бол тухайн салбарынх нь зөвлөх нь юм. Батлан хамгаалахын сайд бол тухайн салбарын зөвлөх нь юм. Яагаад давхардуулж ийм бүтэц бий болгоод байгаа юм бэ? Зөвхөн ЗГ-ыг тойроход 70, 80 дарга байна шүү дээ. Яаж ажлаа явуулдгийг бүү мэд. Жишээ нь нэг салбарын зөвлөх нь нөгөө салбарынхаа сайдтай санал зөрөлдвөл яадаг юм бэ? Төрд ийм бүтэц хэрэггүй шүү дээ. Ерөнхий сайд 22 сайд дээр нэмэх нь 13 зөвлөхөөр яах гээд байгаа юм бэ? Төрийн данхайсан бүтэц гэж энэ шүү дээ. Тэгээд л бид яг ингээд алт, зэс, нүүрс зарсан орлогоороо төрийн бүтцээ данхайлгасаар байгаад эдийн засгийн орон.../минут дуусав/

С.Бямбацогт: Ерөнхий сайд хариулъя.

Н.Учрал: Асуулт асуугаагүй юм уу? Би тэгвэл үг хэлчихье. УИХ-ын гишүүний хувиар үгээ хэлчихье. Тэгвэл та асуулт шиг үг хэлсэн байна. Эдийн засаг дахь харьцаа, ТӨК, төсөв 2 бол эдийн засаг дахь харьцаа 61 хувь байгаа. 61 хувь байгаа. Тэгвэл хариулахгүй байж болно.

С.Бямбацогт: Асуулт асуух дэгтэй, асуулт асуух дэг дээр асуултаа асуух ёстой. Тэгээд асуулт асуух дэг дээр үг хэлнэ гэсэн дэг байхгүй, энийгээ та хуулиа ялгаж хараарай. Тэгээд асуулт асуух үед үг хэлчихлээ гээд ингээд байх юм. Дэгийнхээ дагуу л явцгаая, хуулиа сайн судал Очирбат гишүүнээ та бас.

УИХ-ын гишүүн Далайн Батбаярын урилгаар Төв аймгийн Баянцагаан сумын төрийн албан хаагчид УИХ-ын үйл ажиллагаа, Төрийн ордонтой танилцаж байна. Төрийн ордонтой танилцаж байгаа эрхэм иргэддээ УИХ-ынхаа нийт гишүүдийн нэрийн өмнөөс аз жаргал, эрүүл энх, сайн сайхан бүхнийг хүсэн ерөөе. Манай Далайн Батбаяр гишүүн энд та бүхэнтэйгээ мэндлээд, зургийг чинь аваад сууж байна шүү, тойргийнхон байна. Болдын Уянга гишүүн асуултаа асууя. Асуулт асуух дэг дээр асуултаа л асууна. Хэлэлцэж байгаа асуудалтай холбогдуулж асуулт асуудаг, хэлэлцэж байгаа асуудалтай холбогдуулж үг хэлдэг ийм дэгтэй шүү, гишүүдээ. Тийм болохоор бүгдээрээ л дэгээ сахицгаая.

Б.Уянга: Бизнесийн эрх чөлөөний тухай хуулийн төслийг дэмжиж байгаа. Өнөөдөр их чухал анхдагч хуулийг бүгдээрээ ярилцаж байна. Дагаад их олон хуульд нэмэлт, өөрчлөлт орохоор орж ирсэн байна. Тэгэхээр яг ажлын хэсгээс тодруулаад, нэг хэд хэдэн хуулийн зорилт дээр яг жишээ болоод энэ хууль дээр нь ийм, ийм өөрчлөлтүүд орох юм гэсэн хариултыг авъя.

Хуулийн зорилго, ерөнхий бүтэц, зохицуулах харилцаа, хамрах хүрээний 4-т Зах зээлийн өрсөлдөөн, хувийн хэвшлийн санаачилгыг дэмжиж, төр, хувийн хэвшлийн хамтын ажиллагааг өргөжүүлнэ гэж байна. 5-д Бизнес эрхлэхэд таатай орчныг бүрдүүлж, авлига, хүнд суртал, албан тушаалтны үйл ажиллагаанаас хамааралтай байдлыг багасгана гэж байгаа. Яг энэ 2 зорилтын хүрээнд, яг нэг хуулийг нь дагаад бараг 90 хэдэн хууль орж ирсэн байгаа учраас яг аль нэг хууль дээр нь жишээ аваад, жишээ нь хувийн хэвшлийн санаачилгыг яг энэ хууль дээр ингэж дэмжиж байгаа юм, бизнес эрхлэхэд таатай орчныг бүрдүүлэх хүрээнд яг энэ хууль дээр хүнд суртлыг ингэж багасгаж байгаа юм гэдэг дээр жишээ аваад хариулаад өгөөрэй.

Хоёрдугаарх нь болохоор дагаж нэмэлт, өөрчлөлт орох гэж байгаа Ашигт малтмалын тухай хуультай холбоотой асууя. Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамныхнаас байгаа байх гэж бодож байна. 20.5.8-д ашигт малтмалын тусгай зөвшөөрлийг сонгон шалгаруулалтаар олгож байгаа, сонгон шалгаруулалтаар олгодог журмын нэлээдгүй олон заалтыг хуульд тусгаж оруулж ирж байх шиг байна. Энэ зөвл байх, журам өөрчлөгдөөд байхгүй, тодорхой болгож байна гэсэн үг. Гэхдээ энэ 20.5.8-д бичсэн байгаа сонгон шалгаруулалтад орлоо, эхний ялсан оролцогч нь ямар нэгэн байдлаар бүтэлгүйтлээ. Тэгвэл 2-т жагсаж байгаа оролцогчид тусгай зөвшөөрлийг олгохдоо нийлбэр оноо гэдэг зүйлийг нь харъя, тэр нь 1-д орсон оролцогчоос 8 хувиас хэтрэхгүй байна гэсэн ийм өгүүлбэр бичигдсэн байгаа. Яагаад заавал 8 гэж, 8-аас хэтэрчихвэл яг яах юм бэ гэсэн процессын хариултыг авъя. Тэгээд энэ хуульд оруулах байсан юм биш үү?

С.Бямбацогт: Ерөнхий сайд хариулъя.

Н.Учрал: ЗГ-аас өргөн мэдүүлсэн хуулиа Ерөнхий сайд хамгаалж, УИХ-ын гишүүдийн асуултад хариулах үүрэгтэй. Тийм учраас УИХ-ын гишүүдийн асуултад би өөрөө хариулж байна. Тэгэхээр эрхэм гишүүддээ би засгаас барьж байгаа аль ч хуулийнхаа талаар, аль ч сэдвээр, хэдэн цагт ч, хэдэн ямар зохицуулалт туссаныг чөлөөтэй ярихад нээлттэй шүү гэдгийг УИХ-ын гишүүдэд хэлье.

Энэ Бизнесийн эрх чөлөөний тухай хуулийг дагасан 99 хуулиар олон асуудал шийдэж байгаа. Би түрүүн зөндөө хэлсэн, тэр зөвшөөрөлтэй холбоотой асуудал. Түүнээс гадна гадаадын банк байгуулах нөхцөлийг бүрдүүлж, Банкны тухай хуульд өөрчлөлт оруулж байгаа. 20 хувийн босгыг гадаадын банк байгуулах тохиолдолд тэр заалт үйлчлэхгүй гэдэг зохицуулалтыг тусгаад Хөрөнгө оруулалтын тухай хуультай нийцүүлсэн. Мөн Мэргэжлийн нэгдсэн холбоодод 120 зөвшөөрлийг шилжүүлэх эрхийг олгож байгаа. Төр данхар байна гээд байгаа, тэр данхар төрийг бий болгоод байгаа олон хөгжлийн төв хэрэгтэй, хэрэггүй улсын төсөвт үйлдвэрийн газруудын чиг үүргийг зүгээр орхиж болохгүй. Тэгэхээр тодорхой чиг үүргүүдийг мэргэжлийн холбоо руу шилжүүлэх эрхийг энэ хуулиар нээж байгаа учраас 120 гаруй зөвшөөрөл байгаль орчин, санхүү, барилга, зам тээвэр, боловсрол, уул уурхай гээд олон салбарт шилжинэ. Ингэснээр төр зарим чиг үүргүүдээсээ татгалзана гэсэн үг 120 гаруй.

Цахим бизнес эрхлэгчийг бүтэн хуулиар зөвшөөрнө. Өнгөрсөн хугацаанд цахим засаглалын индекс 28 байр урагшилсан. 360 270 зөвшөөрөл өнөөдөр цахимаар олгодог болсон. Энэ ажлыг нээх гэж байна. 270 зөвшөөрлийг цахимаар авахад хуулиуд саад болдог. Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулиар

тухайн үед би 109 хуулийг УИХ-аар батлуулж байсан. Энэ ажлаа бүрэн дуусгаж, цахим бизнес эрхлэгчийг хуулиар бүрэн зөвшөөрч байна. Цахимаар компани байгуулах, дансаа нээх бүх боломжийг бүрдүүлж байна. Татвар, НДШ-ийн үргүй шалтгаанаар зөвшөөрөл олгохоос татгалздаг байдлыг зогсоогоод, хувийн хэвшилд ажиллах нөхцөлийг илүү бүрдүүлж байна гэдгийг хэлье.

Мөн хувийн хэвшилд төр худалдан авах сонгон шалгаруулалтыг зохион байгуулахыг хүний оролцоогүйгээр, хиймэл оюун ухаанд суурилсан тогтолцоогоор нэвтрүүлэх чиглэлээр буюу төр худалдан авах ажиллагааг зохион байгуулах гэж хүн хүчээ нэмдэг, ингээд хөндлөнгийн ашиг сонирхол ордог байдлаас бүрэн татгалзаж байна. Дээрээс нь Бизнесийн эрх чөлөөний тухай хуулийн суурь хууль дээр төрийн бизнест оролцох хязгаарыг тогтоож өгсөн учраас хэрвээ хөндлөнгөөс ямар нэгэн байдлаар оролцох юм бол Бизнесийн эрх чөлөөний тухай хууль бизнес эрхлэгч, хөрөнгө оруулагч нарт олон улсын арбитрын шүүх дээр очиход хүртэл хамгийн сайн хууль, эрх зүйн үндэслэл болно гэдгийг хэлье.

С.Бямбацогт: Энхбаяр сайд нэмж хариулъя. Дараа нь Доржханд сайдад бэлдэж байгаарай.

Ж.Энхбаяр: Төр бизнестэй өрсөлдөхгүй байх зарчмыг хуульчилж байгаа. Төр нь хувийн хэвшлийн өрсөлдөөнт зах зээлд бизнесийн үйл ажиллагаа эрхлэхийг зарчмын хувьд хориглож байгаа. Бизнес эрхлэгчийн өмчийн эрхийн хамгаалалтыг өндөрсгөж байгаа. Өмч хөрөнгийг хууль бусаар хураах, дайчлах, бизнесийн нэр хүндэд хандах, хуульд заагаагүй хяналт шалгалт хийхийг хориглож байгаа.

Нөгөө талаасаа хөрөнгө оруулагчдын гомдлыг шийдвэрлэх тогтолцоог бүрдүүлж байгаа. Тодорхойгүй олон байдалд байсан, шинэ бизнесийг дэмжих бодлого орж ирж байгаа. Хиймэл оюун ухаан, дата төвийн хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэхэд гааль, татварын бодлогоор 100 хувь хөнгөлж, чөлөөлж энэ дэмжлэг явуулна. Хөдөлмөрийн зах зээл дээр манайд эдийн засгийн өсөлтөө хангахад хөдөлмөрийн зах зээлийн дутагдал үүсэж байгаа. Энийг нөхөхийн тулд дэвшилтэт технологи, хүнс, хөнгөн үйлдвэр, аялал жуулчлал, үйлчилгээний салбарт шаардлагатай ажилтан авч ажиллуулж байгаа ажил олгогчийн гадаад ажилтны ажлын байрны төлбөр.../минут дуусав/

С.Бямбацогт: Хариултаа гүйцээгээрэй. Энхбаяр сайд.

Ж.Энхбаяр: Дэвшилтэт технологи, хүнс, хөнгөн үйлдвэр, аялал жуулчлал, үйлчилгээний салбарын гадаад ажилтны ажлын байрны төлбөрөөс чөлөөлөх асуудал орж ирж байгаа. Энэ хөрөнгийн зах зээлд хөрөнгө оруулалт татах таатай орчныг бүрдүүлж байгаа. Манай эдийн засаг маань арилжааны банк дээр тулгуурласан өрөөсгөл гэж нэлээн шүүмжлэл дагуулдаг ийм санхүүгийн бүтэц байгаа. Иймд Хөрөнгө оруулалтын сан, хөрөнгийн бирж, бусад санхүүгийн байгууллага гаднаас татсан зээл, өрийн хэрэгслийн хүүгийн орлогод ногдох татварыг 20 хувь байсныг 5 хувь болгож, энэ санхүүгийн зардлыг бууруулж байгаа. Ингэснээр иргэдэд очиж байгаа зээл, хүү, санхүүгийн үйлчилгээ өртөг багатайгаар очих ийм бололцоо бүрдэж байгаа.

Зөвшөөрлийн тогтолцоог тодорхой болгож байгаа, мэдэгдээд ажлаа эхэлдэг болж байгаа, илүү хялбар, төр өөрөө очих ёстой болж байгаа. "И-Бизнес" /e-business.mn/ платформд мэдээллээ өглөө, бизнесээ эхлүүллээ, 30 хоногийн дотор

төрийн холбогдох байгууллага очиж үйлчилгээ үзүүлнэ, галын зөвшөөрөл, хогийн гэрээ.../минут дуусав/

С.Бямбацогт: Доржханд сайд нэмж хариулъя.

Т.Доржханд: Энэ хуулийн малгай хууль нь Бизнесийн эрх чөлөөний тухай хууль, дагалдаж орж ирж байгаа 2 том хуулийн нэг нь Хөрөнгө оруулалтын тухай хууль, нөгөөдөх нь энэ Зөвшөөрөл, мэдэгдлийн тухай хууль юм. Тэгээд хөрөнгө оруулалтын орчинд нэлээд их, гаднын хөрөнгө оруулагчдад зориулсан орчин их эвтэйхэн болж байгаа гэдгийг хэлчихмээр байна. Тэгээд яаж эвтэйхэн болж байна вэ гэхээр 1 дүгээрт энэ тогтворжуулалтын орчныг хялбарчилж өгч байгаа. Өөрөөр хэлбэл Монгол Улсад урт хугацаанд үйл ажиллагаа явуулъя, их хэмжээний хөрөнгө оруулалт хийе гээд, тэгэх юм бол тэр тогтворжуулалтын гэрчилгээг нь 10, 15, 20 жилийн хугацаатай олгоно. Тэгээд Монгол Улсад 20-оос 50 тэрбумын хооронд хөрөнгө оруулалтаа хийх юм бол 10 жил, 50 тэрбумаас 100 тэрбумын хооронд хөрөнгө оруулалтаа хийх юм бол 15 жил, 100 тэрбумаас дээшээгээ бол 20 жилийн хугацаанд ингээд тогтворжуулж байгаа гэдэг нь маш сайн сигнал. 2 дугаарт татварын маш том өөрчлөлтүүд.../минут дуусав/

С.Бямбацогт: Зочин танилцуулъя. УИХ-ын гишүүн Амгаланбаатарын урилгаар Говь-Алтай аймгийн иргэд УИХ-ын үйл ажиллагаа, Төрийн ордонтой танилцаж байна. Төрийн ордонтой танилцаж байгаа Говь-Алтай аймгийнхаа иргэдэд УИХ-ынхаа нийт гишүүдийн нэрийн өмнөөс эрүүл энх, аз жаргал, сайн сайхан бүхнийг хүсэн ерөөе. Манай гишүүд хуурайлаад их сүртэй байна шүү, сүртэй, хүчтэй. Аргагүй л алтай нутгийнхан байна. Отгоншарын Батнайрамдал гишүүн асуултаа асууя.

О.Батнайрамдал: Та бүхэндээ өглөөний мэнд хүргэе. Бизнесийн эрх чөлөөний тухай хуулийг ЗГ-аас оруулж ирж байгааг зарчмын хувьд дэмжиж байгаа. Бидэнд гадаадын хөрөнгө оруулалт татах ёстой, бизнесийн орчноо сайжруулах ёстой. Гэхдээ энэ дээр дагалдан бараг зуугаад хууль орж ирж байгаа шүү дээ. Тэгэхээр хэд хэдэн асуултууд байна. Нэлээн дагалдах хуулиудыг бид нухацтай харах ёстой юм байна.

1 дүгээрт, Энхбаяр сайд байгаа юм чинь тухайлан асуумаар байна. Ер нь та энэ сүүлийн 30 жилийн хөрөнгө оруулалтын орчныг дүгнээд нэг хэлэх хэрэгтэй байна. Гэхдээ цаг үлдээнэ шүү, бусад асуултууд байгаа.

2, 3 дугаар асуултууд маш ойлгомжтой. 2 дагалдах хууль дээр асуулт асууя. Нэг нь Ашигт малтмалын тухай хуулийн нэмэлт, өөрчлөлт. Энэ дээр 7.7 дахь хэсэг байна, нэг ёсондоо бид ашигт малтмалын А, Х лиценз олгох энэ эрхээ бүхэлд нь эсхүл хэсэгчлэн ТББ болон нийтийн эрх зүйн хуулийн этгээдэд шилжүүлж гүйцэтгүүлж болно гэж оруулж ирж байгаа юм. Ер нь бид зөвшөөрөл ярих юм бол зөвшөөрөл дотроос Монгол Улсын хамгийн үнэ цэнтэй, хамгийн хөрөнгө оруулалт татах тэр зөвшөөрөл нь ашиглалтын, ер нь уул уурхайн лиценз л дээ. Ашиглалтын болон хайгуулын лиценз олголт. Тэгэхээр энэ ашиглалт болон хайгуулын лиценз олголтоо бид энэ 7.7 дахь хэсгийг өөрчлөөд, ТББ-д ингээд бүхэлд нь шилжүүлж болж байгаа юм уу? Энгийг би зөв ойлгосон уу, эсвэл яг тэр эрхээ бид ингээд шилжүүлж байгаа юм уу? Энэ дээр ингээд бусад орны яг энэ ашиглалтын болон хайгуулын лиценз олголтоо гуравдагч этгээдэд шилжүүлдэг тийм жишээ байна уу?

Хоёрдугаарх асуултыг Уянга гишүүн асуучихлаа, тэгэхээр алгасъя. Хөрөнгө оруулалтын тухай хууль байна, сая, Доржханд сайд хариулж байх шиг байна. Би яг танаас тухайлан асууя. Тогтворжуулалтаа уртасгаж байгаа юм байна. 1 дүгээрт, хөрөнгө оруулалтын хэмжээний босго 500 тэрбум хүртэл байсныг 100 тэрбум болгоод, 5 дахин бууруулчихна. Тогтворжуулалтын гэрчилгээг бид 15 жил хүртэл олгодог байсан, энийгээ 20 жил болгож байгаа юм байна. Тэгэхээр Доржханд сайдаа, та олон улсын форум эд нарт явдаг, олон улсын жишиг асууна. Олон улсын чиг хандлага нь Олон улсын валютын сан /ОУВС/-ийн болон ЭЗХАХБ-ын /OECD/ зарчмаар аваад үзэх юм бол энэ чинь эсрэгээрээ яваад байгаа байхгүй юу. Яг ямар орон тогтворжуулалтаа урт болгосноороо хөрөнгө оруулалт татсан юм бэ? Та бүр яг жишээ хэлж байгаад надад хариулна шүү.

Яагаад гэвэл олон улсын жишиг сүүлийн, энэ тогтворжуулалтын гэрчилгээ олгодог энэ сүүлийн ерээд оны үед, 1990-ээс 2000 оны үед гарч ирж байсан жишиг байхгүй юу. Гэтэл яг олон улсын жишгийг аваад үзэх юм бол Латин Америк, Африк, Азид 8-аас 12 жил байгаа юм. Тэгэхээр бид 15-аас 20 жил болгохоор хөрөнгө оруулалтын орчин сайжирна гэсэн тийм судалгаа байна уу? Бизнесийн эрх чөлөөг сайжруулна гэдгийг бид олон улсын жишиг рүүгээ ойртож байна гэж ойлгож байгаа, олон улсын жишиг рүү л бид ойртох ёстой. Тэрнээс биш бид энэ дээр цоо шинэ юм гаргаж ирэх шаардлагагүй. Тэгэхээр олон улсын жишиг нь эсрэгээрээ байгаад байхад яагаад 15-аас 20 жилийг та хөрөнгө оруулалт татах үндсэн гол зүйл гэж харж байгаа юм бэ? Жишээлбэл Хөрөнгө оруулалтын тухай хуулиараа бид тогтворжуулалт дотроо ААН-ийн орлогын албан татвар, НӨАТ, гаалийн албан татвар, ноцтой нь АМНАТ-аа оруулдаг байхгүй юу. Олон улсын таны хэлээд байгаа жишиг дээр болохоор АМНАТ-ыг тогтворжуулалт руу оруулах нь буруу гэсэн чиг хандлага гараад байна шүү дээ. Тэгэхээр та олон улсын жишээг ярьж байгаа бол энэ дээр яг жишээтэй, судалгаатай тайлбарлаж өгөөч гэж асуумаар байгаа юм?

С.Бямбацогт: Энхбаяр сайд хариулъя.

Ж.Энхбаяр: Гадаадын хөрөнгө оруулалт Монгол Улсын эдийн засагт ер нь ямар ач холбогдолтой талаар 3 тоо хэлье. Өнөөдөр Монгол Улсын 4 суурь татварын нэг ААНОАТ-ын 24 хувийг гадаадын хөрөнгө оруулалттай ААН-үүд төлсөн татвар бүрдүүлж байна. Нийт Монгол Улсын цалингийн сангийн 15 хувийг бүрдүүлж байна. Нийт НДШ төлөлтийн 18 хувийг гадаадын хөрөнгө оруулалттай 4 мянган компани бүрдүүлж байгаа. Юу болж өнгөрөв гэж зах зээлийн харилцаанд орсон өнгөрсөн хугацаанд бид асар их хүчин чармайлт гаргасан, дэлхий нийтийн итгэлийг татсан, хөрөнгө оруулсан. Ялангуяа 2017 онд Монгол Улс эдийн засгаа 17.5 хувьд хүргэж, жилдээ 5 тэрбумын хөрөнгө оруулалт татдаг дараагийн Кувейт, Катар болно гэж дэлхийгээрээ шуугьж байсан, хөрөнгө оруулалтын таатай орчинтой улс байсан.

Тэр үед Монгол Улсын татаж байсан 5 тэрбум долларыг Төв Азийн Узбекистан, Казахстан, Киргиз гээд энэ 5 орнууд нийлээд хүрдэггүй байсан. Бид ингэж үнэлэгдэж байсан. Өнгөрсөн 30 жилд бид 50 тэрбумын хөрөнгө оруулалтыг татсан байна. Тэр 50 тэрбум долларын хөрөнгө оруулалтыг. Одоо Узбекистан улс дангаараа жилдээ 50 тэрбум долларын хөрөнгө оруулалтыг татдаг болсон байна. Энэ нь ч юу вэ гэвэл бид бодлогын томоохон алдаанууд хийсэн байна л гэж үзнэ. Шулуухан хэлэхэд, 2012-оос 2016 оны үед хөрөнгө оруулалт, эдийн засаг 17 дахин унаж, валютын нөөц тэг болж, хууль, эрх зүйн өөрчлөлттэй холбоотойгоор гадаадын хөрөнгө оруулалт Монголоос гарсан. Энийг засах гэсэн 10 жилийн тасралтгүй

хөдөлмөрийн үр дүнд сүүлийн жилүүдэд хөрөнгө оруулалтын орчин сайжирч байна. Бид улам сайжруулж, боловсронгуй болгох шаардлагатай байна.

Түрүүн хэлсэн, хөрөнгө оруулалт Монголын эдийн засагт ямар их нөлөөлөл үзүүлж байгаа сайн нөлөө, шинэ ажлын байр, шинэ технологи, шинэ эдийн засаг, шинэ орлогыг бүрдүүлж байгааг бид нэг үеэ бодвол нэлээн сайн ойлгодог болсон. Иймд хөрөнгө оруулалтын орчноо сайжруулаад, Монгол Улс олон улсад нээлттэй орон болох ёстой.

Харамсалтай нь дотоодын улс төржилттэй холбоотойгоор бид бий болсон нөөцөө ашиглаж чадахгүй байна. Үндсэндээ социализмын үед бий болсон нөөцийн тодорхой хэсгийг ашиглаад өдий хүрлээ. Шинээр шинэ орд, уурхай, үйлдвэрлэлийн газрыг ашиглалтад оруулах байдал улс төржилттэй их тулж байна. Төрөл бүрийн ард түмний нэр барьсан, орон нутгийн нэр барьсан төрийн бус байгууллагуудын зохион байгуулалттай шантаажны ийм үйл ажиллагаа идэвхжиж байна. Энэ болгон чинь гадаадад Монгол Улсын нэр хүндийг сөргөөр харуулаад байгаа ийм зүйлүүд байна. Иймд энэ гадаадын хөрөнгө оруулалтыг хамгаалах, бизнес орчныг сайжруулах энэ хууль, эрх зүйн орчныг дагалдах 99 хуулийн хамт өргөн барьж байгаа юм. Үүгээр олон зүйл.../минут дуусав/

С.Бямбацогт: Доржханд сайд нэмж хариулъя.

Т.Доржханд: Батнайрамдал гишүүний асуултад хариулъя. Тэгэхээр олон улсад энэ тогтворжуулалтын асуудлыг бууруулж байгаа тийм хандлага байхгүй байгаа, байна гэх юм бол та тэрийгээ гаргаж ирж үзүүлээрэй. 2 дугаарт, та зөвхөн уул уурхайн салбараа анзаараад байх шиг байна. Тэгэхээр Монгол Улс ганцхан уул уурхайгаас биш, төрөлжүүлэх бодлогын хүрээнд эрчим хүчнийхээ салбарыг дэмжье гэсэн бодлого тухайлбал хамгийн түрүүнд тавьж байгаа, эрчим хүчний төслүүд 15-аас 25 жилийн хугацаанд PPA /Power Purchase Agreement/ хийгээд орж ирж байгаа. Тэгэхээр бид зөвхөн ингээд л уул уурхайн ашигт малтмал гэдэг юмаа тойроод яваад байх юм бол энэ зангаасаа гарахгүй байгааг та мэдэж байгаа. Дэлхий дээр ингээд нийт өнөөдрийн хөрөнгө оруулалтын одоогийн байдлаар 40-өөс дээш хувь нь зөвхөн энэ эрчим хүч, технологи руу орж ирж байгаа, уул уурхайн бүтээгдэхүүн эрсдэлтэй байдаг. Яг энэ салбар руу хөрөнгө оруулалт орж ирэхгүй байгаа, тэгээд оруулж ирэх талаар бид ажиллахаас өөр арга байхгүй.

С.Бямбацогт: Доржханд сайд нэмээд хариулчихъя. Дараа нь Дамдинням сайд.

Т.Доржханд: Тэгэхээр бид ЭЗХАХБ-ын /OECD/ зарчмыг баримтлаад тусгасан байгаа. Монгол Улс ардчилсан улс, 35 жил бид ингээд засгаа байнга сольдог, тэгээд өмнөх ажлаа баллуурдаж явсны үр дүн өнөөдрийн үр дүн. Бид Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтөө ингэж хийсэн, ЗГ-ын тогтвортой байдлыг хангах гэж хийсэн. Гэтэл засаг маань ямар байгаа билээ, та бүгд мэдэж байгаа шүү дээ, ийм орчинд чинь Монголд хэн хөрөнгө оруулалт хийх билээ дээ. Тэгвэл бидний өнөөдрийн байгаа байдал яг 1990, 2000 оны тэр загварыг ашиглаж ажиллахаас өөр арга байхгүй шүү дээ. Тогтвортой байдлыг л бид гаднын хөрөнгө оруулагчдад амлахгүй бол болохгүй. Энэний ганц нөхцөл нь тогтворжуулалтын ийм баталгаажуулалтыг хийхгүй бол орж ирэхгүй шүү дээ. Том төслүүд ч орж ирэхгүй, дэд бүтцийн төслүүд ч орж ирэхгүй. Монгол Улс асар том газар нутагтай, асар их дэд бүтцийн хэрэглээтэй. Гэтэл бид нөгөө богино хугацаанд ашиг олдог бизнесээ

ингээд хараад байдаг. Гэтэл Монгол нөгөө дэд бүтцийнхээ хөрөнгө оруулалтыг хийж чадахгүй яваад байгаа нь бизнесийнхээ хувьд асар том хүндрэл үүсгээд байгаа юм. Одоо ийшээгээ бүгдээрээ бодлогоо чиглүүлъя. Төсөв дээр.../минут дуусав/

С.Бямбацогт: Дамдинням сайд нэмж хариулъя.

Г.Дамдинням: Энэ Ашигт малтмалын тухай хуульд нэмж орж байгаа энэ өөрчлөлтийг бол энэ Батнайрамдал гишүүнтэй зарчмын хувьд санал нэг байгаад байгаа. Зөвшөөрөл, мэдэгдлийн тухай хууль дээр тэртээ тэргүй нөгөө энгийн зөвшөөрлүүдийг шилжүүлж болно гэдэг заалт нь угаасаа байдаг. Тэгээд энэ хуулийнхаа хүрээнд шийдээд явчихъя гэсэн ийм зарчмын байр суурьтай байгаа, ажлын хэсэг дээр энэ ашигт малтмалын хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрлийг ТББ руу шилжүүлэх тухай асуудлыг засаад явчих боломжтой гэж харж байгаа. Салбарын байр суурь яг тийм байгаа, тийм.

С.Бямбацогт: Батнайрамдал гишүүн тодруулъя.

О.Батнайрамдал: Доржханд сайд аа, хоёулаа наадах дээр чинь нэлээн тулах нь. Та олон улсын жишиг тогтворжуулалтыг илүү урт хугацаагаар явуулдаг гэж хэлсэн шүү. Хоёулаа тэгэхээр судалгаа, та яг наад судалгаагаа гаргаад ир, би яг бууж байгаа судалгааг нь гаргаж ирүүлъя. Тэгээд хоёулаа судалгаатай ярих хэрэгтэй. Яагаад гэвэл энэ чинь аягүй ноцтой зүйл шүү дээ. Өнөөдөр ОТ дээр бид тогтворжуулаад яасан, АМНАТ-аа тогтворжуулаад үнийн өсөлт гарч байхад үнийн өсөлтөөс чинь нэг ч төгрөг орж ирэхгүй. Олон улсын жишиг чинь энэ чинь эсрэг яваад байгаа байхгүй юу. Тогтворжуулалтын яг гэрчилгээг хэвлэж тараадаг орон бараг байхгүй шүү. Тэгэхээр яг олон улсын жишгээ хоёулаа тэгээд яг судалгаатай 1 дүгээрт ярих хэрэгтэй.

2 дугаарт АМНАТ дээрээ, АМНАТ биш ээ, А, Х лиценз олгох энэ процесс чинь буцаад Үндсэн хуулийн 6.2 дээр газрын доорх баялгийг захиран зарцуулах эрх олгож байгаа энэ процесс төр дээрээ байхгүй бол ТББ-д шилжүүлж болохгүй шүү дээ.

С.Бямбацогт: Доржханд сайд хариулъя.

Т.Доржханд: Гадаадын хөрөнгө оруулалт гэхээр л ОТ руу оруулчихдаг байдлыг болимоор байгаа юм шүү. Шулуухан хэлэхэд. Би энэ Батнайрамдал гишүүний зүгээр байр суурийг хүндэтгэж байна, гэхдээ зөвхөн уул уурхай руу битгий оруул. Өнөөдөр хамгийн эхний асуудал эрчим хүч байгаа, эрчим хүчний хөрөнгө оруулалтууд бүгдээрээ урт хугацаанд хийгддэг юм, 25-аас 30 жил хийгддэг юм, эд чинь тогтвортой байдал шаарддаг юм, РРА хийдэг юм. Энэ байгаа Узбекистан, Казахстан эдгээр улсууд бүгдээрээ тийм тогтвортой байдалтай, урт хугацааны гэрээтэй явдаг юм. Тэгээд өнөөдөр бид өөрсдийгөө нэг хөгжчихсөн орнуудтай битгий харьцуулаарай, олон улсын судалгаагаа гаргаж ирээд ярихад асуудал байхгүй. Тэгээд хөгжиж байгаа орны, Монгол Улсын өнөөдрийн түвшнийг үнэлж байгаад бид энэ шийдвэрийг гаргаж байгаа шүү. Тэгэхээр хөрөнгө оруулалт үнэн, сүүлийн 25 жил зөвхөн уул уурхай дээр ирдэг байсан, одоо ирэхгүй байгаа ийм орчинд яаж ирэх билээ дээ. Тэгвэл технологийн шинэчлэлтэй холбоотойгоор эрчим хүч дээр ирж байгаа, дата төв дээр ирж байгаа, ногоон эрчим хүч дээр ирж байгаа мөнгө нь байгаа, эд нарыг чинь оруулж ирэхэд.../минут дуусав/

С.Бямбацогт: Дамдинням сайд хариулъя.

Г.Дамдинням: Батнайрамдал гишүүн салбар ойлгодог хүний хувьд яг зарчмын зөв байр суурь илэрхийлээд байгаа. Ерөнхий сайд ч гэсэн энийг энгийн зөвшөөрлийн хүрээнд эрх шилжүүлнэ гэж явж байсан. Тэгээд энэ хуулийн томъёолол дээр, энэ төсөл дээр ингээд орчихсон байгааг ажлын хэсэг дээрээ засаад явах боломжтой л гэж хараад байгаа. Манайхан тийм санал өгөөд байгаа, энэ ашигт малтмалын хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрлийг ТББ-д өгч болохгүй.

С.Бямбацогт: Батнайрамдал гишүүн.

О.Батнайрамдал: Тэгэхээр Доржханд сайд аа, хуучин Хөрөнгө оруулалтын тухай хууль дээр уул уурхайн, уул уурхайн бус гээд бид ингээд 2 хуваачихсан тогтворжуулалтын хугацаанууд байсан байхгүй юу. Тэр уул нь зөв байхгүй юу. Яагаад гэвэл уул уурхай чинь шаардаж байгаа хөрөнгө оруулалт нь хамаагүй том, уул уурхайн бус хөрөнгө оруулалтууд нь өөр байхгүй юу. Тэгэхээр энэ 2 байсныг аваачаад нэгтгээд босгыг нь 5 дахин бууруулаад, хугацааг нь уртасгачихсан байгаа юм л даа. Тэгэхээр энэ хөрөнгө оруулалт дахь хөрөнгө оруулалтыг илүү татах хөшүүргээсээ илүүтэйгээр улс төрийн тогтворгүй байдал гэх мэтчилэн олон зүйлүүд дээр илүү чухал юм гэдэг ЭЗХАХБ-ын /OECD/ дүгнэлт байгаад байгаа байхгүй юу. Би энэ дээр дүгнэлт хараад л яриад байна л даа. Тийм учраас энийг нухацтай харах ёстой юм л даа. Тэгээд бид дараа дараагийн хөрөнгө оруулалтын гэрээнүүд хийгдэнэ, тэгэхээр тэр дээр яг юуг нь тогтворжуулах юм, юунд тогтворжуулахгүй юм, яг л олон улсын зарчмаа л бид барих ёстой. Ганцхан ОТ яриад байна гэж байна, энэ чинь жишээ шүү дээ. Эндээс бид алдаанаасаа суралцъя гэвэл бид ОТ ярихгүй тэгээд өөр юу ярих юм, өөр ямар хөрөнгө оруулалт яримаар байгаа юм бэ.

С.Бямбацогт: Доржханд сайд хариулъя.

Т.Доржханд: Би энэ Батнайрамдал сайдыг баруунд төгссөн, гаднын хөрөнгө оруулалт, том төслүүдээ яаж явуулахыг хамгийн сайн мэдэж байгаа хүн гэж бодоод байгаа юм. Тийм болохоор байр сууриа нэгтгээд явах нь зүйтэй байх. ОТ маш сайн төсөл, алдаа гарсан уу гэвэл үнэн, алдаагаа засаад л явах ёстой. 18 жил бид ОТ-г ярилаа шүү дээ. Гэтэл ОТ чинь түүх болоод үлдчихсэн, Монголд ингээд зэс рүү, эрчим хүчний материал руу хөрөнгө оруулалт хийе гээд байхад бид ингээд хаалгаа түгжээд үгүй гэж болохгүй байхгүй юу даа. Өнөөдөр бид ОТ-гоос чинь хэд дахин илүү хөрөнгө оруулалтыг эрчим хүч дээр татах гээд хэлцлээ хийгээд байна шүү дээ. Private equity fund-уудтай бүгд л хөрөнгө оруулалтын банкнууд орж ирээд хийе гээд байдаг. Тэгэнгүүт л ингээд л "ОТ-г хар даа, энэ болохгүй байхгүй юу" гээд ийм байдлаар явах юм бол хөрөнгө оруулалт орж ирэхгүй. Эрчим хүч, ногоон эрчим хүч, технологид чинь дэлхийн бүх хөрөнгө оруулалт яваад байна. Тэгвэл тийшээгээ бид угтаж, бодлогоо явуулж, хуулийнхаа орчныг өөрчлөөд.../минут дуусав/

С.Бямбацогт: Мөнгөнцогийн Ганхүлэг гишүүн асуултаа асууя.

М.Ганхүлэг: Бизнесийн эрх чөлөөний тухай хуулийг агуулгын хувьд дэмжинэ. Оруулж ирсэн төсөлтэй холбоотой 2 асуулт, дагалдах хуультай холбоотой 2 асуулт асууя. 3.1.8 дээр хуульд зааснаас бусад тохиолдолд үнэ тогтоох үйл ажиллагаанд төр аливаа хэлбэрээр оролцохгүй гэсэн ийм агуулга орж ирсэн байна. Асуудлаа яг нэг мөр болгоё. Цаашдаа махны үнэ, гурилын үнэ, өргөн хэрэглээний барааны үнэд энэ хууль батлагдсанаараа төр оролцохгүй гэдэг энэ зарчим руугаа нэг талдаа гарч

байна уу? Үнэтэй холбоотой асуудал дээр энэ хууль батлагдсанаараа үндсэндээ чөлөөт зах зээлийнх нь зарчмаар явуулна гэдэг ийм ойлголтыг нэг мөр болгоё гэсэн энэ асуултад? 1 сарын өмнө бид үнэ тогтоосонгүй гээд Нийслэлийнхээ дарга дээр хариуцлага тооцсон шиг санагдаж байна. Тэгэхээр энэ нөхцөл байдал энэ хууль батлагдсанаараа цаашдаа давтагдахгүй гэж ойлгож болох уу? Энэ бизнесийн салбарынхны хувьд үйл ажиллагаагаа тооцоход их чухал зүйлүүд байгаа. Тэгээд энэ дээр тодорхой хариулт авъя.

3.1.4 дээр бизнес эрхлэгчийг өмчийн хэлбэр, хөрөнгө оруулалтын эх үүсвэр, байршил, хэмжээ, салбар хэлбэрээр яг ялгаварлан гадуурхахгүй хандана гэдэг ийм агуулга байгаа. Экспортын ч бай, импортын ч бай бүх төрлийн чиг баримжаатай ААН-үүдийг бид нэг түвшинд авч үзнэ гэж ойлгож болох уу? Монгол Улс үйлдвэрлэгч орон болох, бүтээж байгаа, боловсруулж байгаа энэхүү ААН-үүддээ давуу байдал олгохгүйгээр ижил түвшинд харах уу? Экспортын чиг баримжаатай хөгжих энэ үндсэн бодлого, үүний цаана яаж агуулагдаж байгаа вэ гэдгийг би асууя. Ялангуяа энэ хуулийн гол зорилтыг эдийн засгийн төрөлжилт гэж харж байгаа. Экспорт руу чиглэсэн үйлдвэрлэл, ААН-үүд бизнес эрхлэхэд илүү таатай орчин бүрдүүлэх энэ агуулга руугаа явна гэж харж байгаа. Тэгэхээр үүнтэй холбоотой агуулгыг дэлгэрүүлж тайлбарлаж өгөөч?

Дагалдах хууль дээр 99 дагалдах хууль орж ирж байна, Хөдөө аж ахуйн биржийн тухай хууль орж ирж байна. Ер нь бусад хуулиудыг харахаар хөнгөлөлт, чөлөөлөлтүүдийг нэлээн хассан ийм агуулгууд орж ирж байгаа бол Хөдөө аж ахуйн бирж дээр нэмэлтээр биржийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл хүсэгч хуулийн этгээдэд 15 бичиг баримт бүрдүүлэх агуулга орж ирж байгаа юм. Бүгдийг нь үндсэндээ тусгаад, тэгэхээр энэ нь нөгөө хуулийн гол зорилготойгоо хэр авцалдаж байгаа вэ? Биржийн арилжааны зуучлагч, брокерын үйл ажиллагаа явуулахад мөн 15 төрлийн бичиг баримт нэмж шаардана гэсэн ийм агуулга гэж ойлгогдохоор харагдаж байгаа. Яагаад гэвэл Хөдөө аж ахуйн гаралтай түүхий эдийн биржийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах ийм агуулга дээр ингээд нэмэлтээр орж ирж байгаа юм. Тэгэхээр энэ өмнөх байдлаасаа яаж өөрчлөгдөж байгаа вэ гэдэг дээр тодруулъя?

Нэг чухал агуулга орж ирсэнд талархалтай байна, Ажиллах хүчний шилжилт хөдөлгөөний тухай хуулийг дагалдах хуульд орж иржээ. Ингээд үүнтэй холбоотойгоор энэхүү үндсэндээ хуулийн хүрээнд Хөдөө аж ахуйн чиглэлийн гадаад ажиллах хүчнийг ажиллахад илүү таатай болгоно гэдэг ийм агуулга орж ирж байна. Энийг дэлгэрүүлж тайлбарлая. Энэ салбар, ялангуяа хөнгөн үйлдвэрийн салбар, Хөдөө аж ахуйн салбарт ажиллах хүчний хомсдолд нэлээн орчихсон байгаа. Тэгэхээр үүнтэй холбоотой олон саналуудыг иргэд, ААН-үүдээс гаргадаг. Тэгэхээр энэ гадаад ажиллах хүчнийг Хөдөө аж ахуйн салбарт ажиллахад яг яаж үндсэндээ бид дэмжлэг болох вэ гэдгийг дэлгэрүүлж нэг ойлголт өгөөч.

С.Бямбацогт: Энхбаяр сайд хариулъя.

Ж.Энхбаяр: Хөдөө аж ахуйн биржтэй холбоотой олон асуудлыг яамны журмаар зохицуулж байсан. Энэ харилцааг хуулиар зохицуулж ил болгож байгаа. Биржтэй холбоотой, энэ биржийн арилжаанд ордог брокерууд нь заавал үндэсний хөрөнгө оруулалт давамгайлсан компани байна гэдгийг гадаадын хөрөнгө оруулалттай байж болохоор ингэж чөлөөлж оруулж байгаа. Одоогийн хуулийн 12-т зааснаар биржийн арилжааны зуучлагч, брокер нь үндэсний хөрөнгө оруулалт

давамгайлсан хуулийн этгээд байх гэдгийг Монгол Улсад бүртгэлтэй гэж хуульд нь ингэж зааж өөрчилсөн. Ингээд зөвшөөрлүүдийг нь хуулийн өөрчлөлттэй холбоотойгоор нийцүүлэлт хийгээд, цаашид олон журам гаргах, зөвшөөрөл гаргах асуудлыг нь хуулиар ил тод, хатуу хуульчлан зааж байгаа нь энэ их хэрэгтэй болж байгаа зүйл.

Тэр махны асуудалтай холбоотой нийлүүлэлтийн асуудал онцгой чухал. Нийлүүлэлтэд Хүнсний тухай хуулиар аймаг, нийслэлийн Засаг дарга тухайн орон нутгийнхаа энэ мах бэлтгэлийн нөөцийн бодлогыг хариуцаад, нийлүүлэлтийг хангах учиртай. Энэ нийлүүлэлт дээр өнгөрсөн хугацаанд алдаа гарсан, нийлүүлэлт тасарсан. Энэнтэй холбоотойгоор зохиомол өндөр үнийн өсөлт үүссэнтэй холбоотойгоор зохицуулалтын арга хэмжээг авч хэрэгжүүлсэн. Гол зарчим нь цаашид төр хувийн хэвшлийн хийж байгаа аливаа бизнестэй өрсөлдөхгүй, энэ төрийн оролцоог хатуу хязгаарлаж байгаа, ийм зохицуулалтууд оруулж байгаа. Ер нь цаашдаа зах зээлийнхээ зарчим руугаа нэлээн явна.

Гэхдээ стратегийн хүнс гэж нэг хэдэн төрлийн зүйл байгаа шүү. Стратегийн бодлогын хүрээнд заавал байх ёстой, төрийн оролцоо тодорхой хэмжээнд шаарддаг цөөн нэр төрлийн хүнс байгаа, тэр хүрээнд энэ нь өөрөө онц байдлын, онцгой байдлын, дайны байдлын, ингээд бусад энэ гамшгийн үеийн хуулиуд, онц байдлын үеийн хуулиудаар зохицуулсан онцгой тийм харилцаанууд байгаа. Энэнээс бусад зүйл рүү төр оролцохыг хатуу хязгаарлаж байгаа.

Хөдөлмөр эрхлэлттэй холбоотой, ажиллах хүчний шилжилт хөдөлгөөнтэй холбоотой асуулт байсан. Бид хөдөлмөрийн зах зээл маань эдийн засгийн өсөлтийг хангахын тулд хөдөлмөрийн ажиллах хүчний оролцоо заавал ингээд тооцоо хамт яваад байгаа. 26 онд бид ер нь нийтдээ 82 мянган ажлын байрны дутагдалтай яваад байгаа, салбарууд үйлдвэрлэлийн потенциал, хүчин чадалдаа тулгахад бүрэн ажиллахад ажиллах хүч дутагдалтай байна. 28 онд энэ 100-аас 135 мянга хүртэл дутаж орж ирнэ, 2035 он гэхэд 200 мянгад хүргэх ийм тооцоо гарч байгаа. Эдийн засаг тэлэхийн хэмжээгээр нөгөө хүн амын өсөлт маань дагаж хүчтэй өсөхгүй тийм бололцоо байхгүй. Эдийн засгийн өсөлт хамаагүй хурдтай явж байгаа тул бид ажиллах хүчний энэ бодлоготой холбоотой энэ хууль, эрх зүйн орчныг оруулж ирж байгаа, энэ дээр голлох.../минут дуусав/

С.Бямбацогт: Ганхүлэг гишүүн тодруулж асууя.

М.Ганхүлэг: Одоо яах вэ болохоор бид нийлүүлэлт гэж тайлбарлаж болохгүй л дээ. Үндсэндээ үнэ, махны үнэ өссөн учраас л огцруулсан шүү дээ. Тэгээд тэр махны үнэ өсөж байгаа асуудал дээр нийлүүлэлт дээр алдаа гарсан гэдэг ийм яах вэ агуулгаар нь холбож байх шиг байна. Уул нь нэг талдаа болгочихмоор байгаа юм, бизнес эрхлэгч тодорхой байдлыг хүсээд байгаа. Тэгээд үнийн асуудал дээр төр ер нь оролцох юм уу, оролцохгүй юм уу гэдэг дээр ингээд үзэмжээр ханддаг, энэ байдлыг уул нь энэ хуулиар анхаарах юм болов уу даа гэж бодож би асуусан юм. Тэгээд хуучнаараа явах юм байна гэж ойлголоо.

Төрөлжилтийн асуудал, экспортын чиг баримжаатай, ялангуяа энэ үйлдвэрлэл, боловсруулах үйлдвэрүүдээ яг ижил түвшинд харна гэсэн ийм агуулга байгаад байгаа байхгүй юу. Тэгэхээр энүүгээрээ явах юм уу, арай давуу байдал болгож бид энэ экспортоо дэмжих чиглэлийн нөхцөл байдлуудыг үндсэндээ гаргаж явах юм уу? Энэ дээр ямар зарчмын асуудал орж ирсэн бэ? Яг ХАА-д гадаад

ажиллах хүчнийг авахад тодорхой жишээ байдаг юм уу, тодорхой кэйс дээр ерөнхийдөө хариулж өгөөч гэж байгаа юм.

С.Бямбацогт: Аубакир сайд хариулъя.

Т.Аубакир: Ганхүлэг гишүүний асуултад хариулъя. Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамнаас ажиллах хүчний шилжилт хөдөлгөөнтэй холбоотой судалгаануудыг улирал тутам хийж гаргаж байгаа. Хамгийн гол нь ажиллах хүчний эрэлт, нийлүүлэлт маань ажил олгогчдын зүгээс ур чадварын зөрөөний асуудлыг ярьдаг юм. Яг манай дотоодод байгаа боловсон хүчний хийж гүйцэтгэх боломжгүй ажиллах хүч илүүтэй эрэлт ихтэй байна гэж.

Эдийн засгийн сайдын гаргаж байгаа судалгаа, тооцоотой бид ажиллах хүчнийхээ шилжилт хөдөлгөөнийг уялдуулж явдаг. Бид ер нь энэ боловсролынхоо системд 4-өөс 5 жилийн дараа, яг өнөөдөр төгсөж байгаа хүүхдүүдэд бид 4-өөс 5 жилийн дараа хөдөлмөрийн зах зээл дээр ийм мэргэжил илүүтэй эрэлттэй байх нь байна шүү, энэ мэргэжлийг сонговол цалин пүнлүүний асуудал нь илүү байдаг юм байна шүү гэж. Яг өнөөдрийн судалгаагаар бол их, дээд сургууль төгсөгчдөөсөө илүү богино хугацааны мэргэжил эзэмшсэн ажилчдын цалин 45.../минут дуусав/

С.Бямбацогт: Зочин танилцуулъя. Нийслэлийн ерөнхий боловсролын Ирээдүй сургуулийн Ганцэцэг багштай 10-ын В ангийн сурагчид УИХ-ын үйл ажиллагаа, Төрийн ордонтой танилцаж байна. Төрийн ордонтой танилцаж байгаа сурагч хүүхдүүддээ сурлагын өндөр амжилтыг хүсье Их Хурлынхаа нийт гишүүдийн өмнөөс. Зуныхаа амралтаар сайхан амраарай. Отгоны Саранчулуун гишүүн асуултаа асууя.

О.Саранчулуун: Сайн байна уу? Нэг дэх асуулт нь бизнесийн эрх чөлөө гэж яг ямар ойлголт, ухагдахуунуудыг хэлж байна вэ? Тэгээд тэрэн дээр нь тийм шалгуур үзүүлэлтүүд, оноо энэ тэр байдаг уу, жишээлбэл бизнесийн эрх чөлөөний индекс ч гэдэг юм уу? Тэрэн дотроо ийм, ийм дэд үзүүлэлттэй, тэгээд энэ индекс гэдэг тэр утгыг бууруулахад нөлөөлж байгаа төрийн зүгээс ийм, ийм хүчин зүйлс байна, тэгээд энэ дээр нь бид энэ хуулийг өөрчилж байгаа, энэ өөрчлөлт ингэж засагдаж байгаа юм гэдэг ийм мэдээлэл байна уу гэдэг асуудал.

2-т гэвэл Барилгын тухай хуульд өөрчлөлт оруулахаар тусгасан юм байна. Саяхан бид Өргөдлийн байнгын хороон дээр маш олон хүмүүс барилгын асуудал дээр луйвардуулсан ийм хохирогчдын асуудлаар хэлэлцсэн. Тэгээд барилгын, ер нь энэ барилгын салбарт байгаа хэчнээн янзын зөвшөөрөл баримт бичиг өөрчлөгдөх, өөрчлөлт орох юм бэ? Энэ нь өөрөө барилгын хуурамч барилга ч юм уу, зөвшөөрлөө авчхаад байшин бариад хүмүүсээс мөнгө аваад байгаа энэ залилангийн асуудал дээр ямар нөлөө үзүүлэх вэ гэдэг тодруулга хэрэгтэй.

3-д Бизнесийн эрх чөлөөний хуулийн зарчим дээр харахаар Бизнесийн эрх чөлөөний хууль харьцангуй товчхон харагдаж байна л даа. Тэгээд энэ дээр нэг ийм заалт байна лээ. 3.1.5 дээр "Төрийн үйлчилгээ цахим, ил тод, түргэн шуурхай, тэгш хүртээмжтэй гэсэн бизнес эрхлэгчээс мэдээллийг нэг удаа авах нөхцөлийг бүрдүүлсэн байна" гэдэг энэ заалтад би маш талархалтай хандаж байна. Гэхдээ энэ дээр байгаа энэ тэгш хүртээмжтэй гэдэг үзүүлэлтээ 3.1.4 дээр байгаа бизнесийн өмчийн хэлбэр, хөрөнгө оруулалт гээд энэ заалт дээр байгаа. Энэ үзүүлэлтүүдээ ер нь яг яаж хэмжих вэ, энийг ер нь юугаар тодорхойлох юм бэ гэдгийг тодруулах гэсэн

юм. 3.1.6 дээр "Бизнесийн үйл ажиллагаанд эрсдэлийн үнэлгээнд суурилсан, давхардалгүй, ил тод, урьдчилан сэргийлэх, зөвлөн туслахад чиглэсэн хяналт шалгалтыг хэрэгжүүлнэ" гэнэ. Энэ нь одоо байгаа хяналт шалгалтын ямар функцээр яаж өөрчлөгдөх вэ, ямар ахиц юм уу, өөрчлөлт гарах юм бэ гэдгийг тодруулъя.

С.Бямбацогт: Энхбаяр сайд хариулъя.

Ж.Энхбаяр: Энэ өнгөрсөн хугацаанд хийгдсэн бизнес орчны судалгаан дээр хяналт шалгалттай холбоотой гомдлууд нэлээн өндөр гарсан. Зарим хөрөнгө оруулалттай компани дээр жилд 27 удаа шалгалт очсон давхардсан ийм үзүүлэлтүүд гарсан. Тэгэхээр Ерөнхий сайдаас үүрэг өгөөд энэ Төрийн хяналт шалгалтын тухай хуулийг бид боловсронгуй болгож, Төр, иргэний хяналтын хууль болгон УИХ-д өргөн барихаар бэлдэж байна. Энэ хуулиар шууд хаадаг, торгодог энэ аргачлалыг нэлээн өөрчилсөн. Эхлээд зөвлөнө, дараа нь анхааруулга өгнө, тэгээд сануулна, тэгээд дараа нь акт, торгууль тавигдана. Эцсийн хамгийн сүүлийн мөчид үйл ажиллагааг зогсоох гэсэн ийм үе шаттай.

Энэ болгон чинь хяналтын нөгөө талд нь нийт иргэдийн эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрхийн асуудал байгаа. Ингээд хүнсний аюулгүй байдал, байгаль орчинтой холбоотой ер нь сүүлийн үед нийгэмд үүсээд байгаа олон асуудал энэ хяналтын асуудал жоохон суларсантай холбоотой үүсэж байгаа гэдэг ийм дүгнэлтэд хүрсэн. Тэгэхээр энийгээ боловсронгуй болгоод иргэний хяналтыг энэ хяналтын систем дотор шигтгэж өгсөн ийм шинэ эрх зүйн орчин явна.

Эдийн засгийн эрх чөлөөний индекс гэж дэлхийн улс орнууд энүүгээрээ их өрсөлдөнө. Яг 10 жилийн өмнө гээд байгаа манай АН-ын нөхөд асуугаад байгаа юм, 10 жилийн өмнө гээд 120 дугаар байранд байсан Монгол Улс, 10 жилийн өмнө эрх чөлөөний индексээр Монгол Улс дэлхийд 120 дугаар байранд байсан, өнөөдөр 2025 оны гүйцэтгэлээр 74 дүгээр байранд орсон, 2026 оны шинэ үр дүнгээр 69 дүгээр байр хүртэл ахисан байна. Гэхдээ энэ хангалтгүй. Энэ үзүүлэлтээр бид дэлхийд эхний 50-д орж байж хөрөнгө оруулалтад таатай, бизнес явуулахад таатай орчин бүхий ийм улс орон болох ёстой, бид энэ зорилгын төлөө явж байгаа.

Тэгэхээр энэ индексээ хараад, энэ индексэд нийцсэн бүх үзүүлэлт, шалгууруудаа хангахын тулд 1 дүгээрт энэ Бизнесийн эрх чөлөөний хуулиар бизнес эрх чөлөөг хангах, үүнд баримтлах зарчмууд, төрийн бодлого, эдийн засаг, бизнест оролцох үйл ажиллагаанд хориглох зүйлүүдийг нь тодорхой болгох, хууль зөрчвөл хүлээх хариуцлагыг нь тодорхой болгох, дагаад Хөрөнгө оруулалтын тухай хуулиар дутагдаад байсан, өнгөрсөн хугацаанд судалгаагаар гарсан энэ өөрчлөлтүүдийг баталгаажуулах ажлуудыг хийсэн. Ялангуяа бизнесийн эрх чөлөөг хангах зарчим их чухал байгаа. Бизнес дэх төрийн оролцоог эрс багасгах ийм зохицуулалтууд орсон, төр бизнестэй өрсөлдөхгүй байх гэдэг зарчмын асуудлууд орж байгаа. Хамгийн гол нь бизнес эрхлэгчдийн өмчийн халдашгүй дархан байдал, бизнесийн нэр хүндийг хамгаалах асуудал, энэ болгонд л төрийн байгууллагуудыг үүрэгжүүлсэн, хязгаарласан, зохицуулсан юмнууд ингээд орно. Тэгэхээр энэ эрх зүйн өөрчлөлтийн дараа Монгол Улсын бизнес орчин нэлээн сайжрах байх гэдэгт итгэлтэй байгаа.

С.Бямбацогт: Саранчулуун гишүүн тодруулъя.

О.Саранчулуун: Тийм, эдийн засгийн эрх чөлөөний индекс дотор орж байгаа үзүүлэлтүүдээс доош нь оноог нь тэр 50 руу оруулах гээд байгаа, татаад байгаа

үзүүлэлтүүдийн хэчнээн хэсгийг нь энэ хуулийн төслөөр өөрчилж сайжруулах юм бэ гэдгийг тодруулах гээд байгаа байхгүй юу? Судалгаагаар нэг ийм ойлголт байдаг юм байна л даа, хууль эрх зүй, төрийн зохицуулалтын орчны индекс гэж байгаад байна бизнес эрхлэхэд. Тэр бол манайд бизнес эрхлэх таатай орчин бүрдээгүй байна гэдэг үнэлгээ гараад байдаг юм байна. Тэгэхээр энэ үзүүлэлт, жишээлбэл энэ хуулийн дараа хэрвээ энэ, энэ зүйлийг нь засаад, төрийн оролцоог ингээд багасгачих юм бол тэдэн хувь ахина гэдэг тооцоолол байгаа юу? Яагаад гэвэл бид чинь бизнес регистрийн өгөгдлийн сантай, судалгаатай, тоотой, 80 мянга гаруй ААН-тэй, жижиг, дунд энэ тэр гээд тоотой шүү дээ. Тэгэхээр энэ дээрээ үндэслээд ийм тооцоолол ер нь байгаа юу?

С.Бямбацогт: Энхбаяр сайд хариулъя.

Ж.Энхбаяр: Эдийн засгийн эрх чөлөөний индексийг засаглалын үр ашиг, ЗГ-ын оролцоо, зохицуулалтын үр ашигтай байдал, нээлттэй зах зээл гэсэн 4 бүлгийн хүрээнд 12 шалгуур үзүүлэлтээр ингээд тооцож байгаа. Ингээд Монгол Улсын өнгөрсөн хугацаанд, би түрүүн хэлсэн, 10 жилийн өмнө 120-д эрэмбэлэгдэж байсан Монгол Улс өнөөдөр 69-д эрэмбэлэгдэж орж ирж байгаа. Бизнесийн эрх чөлөөний тухай хууль болон хамт өргөн мэдүүлсэн хуулиуд нь нийлээд бизнес эрхлэлтэд таатай орчин бүрдүүлэх, ялангуяа мэдээллийн технологийн тусламжтайгаар үйл ажиллагааг нэлээн хялбаршуулах, сайжруулах ийм бололцоог нээж байгаа. Тэгээд дэлгэрэнгүй яг индекс, энэ 14 зүүлт, энийг хийгээд ингэж өөрчлөгдье гэсэн зүйлүүд нэлээн урт зүйл болно. Нэг минутад яагаад ч амжихгүй тул танд бид бичгээр гаргаж өгье.

С.Бямбацогт: Бичгээр гаргаж өгье гэж байна. Хариулт хангалтгүй юу, нэмж асууя.

О.Саранчулуун: Барилгын талаарх хуульд өөрчлөлт оруулж байгаа билээ. Тэр дээр түрүүний миний асуусан, одоогийн барилгын зөвшөөрөл аваад үйл ажиллагаа явуулаад олон хүмүүс залилчихсан байгаа энэ гэмт хэрэг энэ зөвшөөрлийн өөрчлөлттэй холбоотой ямар нөлөө гарах юм бэ, яаж өөрчлөлт гарах юм бэ гэдэг дээр тодруулга авъя, баярлалаа.

С.Бямбацогт: Барилга, хот байгуулалтын яам хариулах уу, хаанаас хэн хариулах вэ? Ажлын хэсэг, Энхбаяр сайд хариулах юм уу, сайд нь алга байна. Саранчулуун гишүүний асуултад хэн хариулах уу? Энхбаяр сайд хариулъя. Шадар сайд Энхбаяр.

Ж.Энхбаяр: Барилгын тухай хуульд энэ зөвшөөрлийг дагаж ингэж ийм өөрчлөлт орууллаа. 1 дүгээрт барилгын үйл ажиллагааны болон барилгын ажлын зөвшөөрөл авахад бүрдүүлэх баримт бичгийн жагсаалтыг нэгтгэн тодорхой болгож, зөвшөөрөл олгох ажиллагааны ил тод байдлыг нэмэгдүүлсэн зохицуулалтуудыг орууллаа. Барилгын зураг төсөл боловсруулах, барилгын ажил эхлэх, материал үйлдвэрлэл зэрэг ажиллагаанд хүний нөөц, тоног төхөөрөмж, санхүүгийн чадавхыг нотлох шаардлагуудыг нэлээн нарийвчилсан, энэ хүрээнд нөгөө шаардлагууд нэлээн хатуурч орж байгаа. Барилгын ажлын зөвшөөрөл олгох үед даатгал, байгаль орчны үнэлгээ, санхүүжилтийн эх үүсвэр зэрэг ийм эрсдэлийн удирдлагын шаардлагуудыг сайжруулсан. Ингээд энэ хүрээнд энэ зохицуулалтууд орж байгаа. Тэрнээс яг саяын энэ барилгатай холбоотой залилан хийгээд, дутуу гүйцэтгэлтэй

буюу зураг төсөл үзүүлээд иргэдээс санхүүгийн луйвар хийчихсэн асуудлыг энэ хуулиар зохицуулах боломж хязгаарлагдмал байна.

С.Бямбацогт: Аюушийн Ариунзаяа гишүүн. Саяын хариултууд, Саранчулуун гишүүний хариултууд бичгээр өгөх дутуу хариултуудаа гүйцээгээд өгчхөөрэй. Холбогдоод яачхаарай. Зочин танилцуулъя. УИХ-ын гишүүн Чинбатын Ундрамын урилгаар Сэлэнгэ аймгийн Шаамар сумын Дулаанхаан тосгоны ерөнхий боловсролын 9а, 12а ангийн багш, сурагчид УИХ-ын үйл ажиллагаа, Төрийн ордонтой танилцаж байна. Төрийн ордонтой танилцаж байгаа сурагч хүүхдүүддээ УИХ-ынхаа нийт гишүүдийн нэрийн өмнөөс эрүүл энх, аз жаргал, сайн сайхан бүхнийг хүсэн ерөөе. Манай Сэлэнгийн хойд бүсийн тойргийн гишүүд энд сууж байна, мэндчилгээ дэвшүүлж байна. Ариунзаяа гишүүн асуултаа асууя.

А.Ариунзаяа: Энэ Бизнесийн эрх чөлөөний тухай хуулийн төслийг яаралтай горимоор хэлэлцэх асуудлыг дэмжиж, энэ хуулийг ч гэсэн хэлэлцэх эсэхийг нь бид дэмжээд явах нь зүйтэй. Яаралтай хэлэлцэж байна гээд ажлын хэсэг байгуулахгүйгээр явж болохгүй. Энэ Эдийн засгийн байнгын хороо өөрсдөө 8 хүнээс давуулахгүйгээр ажлын хэсэг зайлшгүй байгуулж, гишүүдийн саналыг аваарай, шуурхай ажиллаарай гэж хүсмээр байна.

Зөвшөөрлийн тухай хуулийг өнөөдөр эргүүлэн татлаа. Зөвшөөрлийн тухай хуулийн явж байсан бүх агуулгууд бол энэ хуульд ороод ирчихсэн, Зөвшөөрлийн тухай хууль нь өөрөө энд дагаад ороод ирчихсэн байгаа. Бизнесийн эрх чөлөөний хуулийг дагаж орж ирсэн 99 хууль байна, энэ ямар ч алдаагүй маш сайн хууль уу гэхлээр тийм биш, бас л, дахиад л нөгөө 99 дагасан хуулиуд дээр бол жижиг алдаанууд, буруу ойлголтын улмаас үүссэн ноцтой ч алдаанууд гарсан байна гэдгийг бол зориуд хэлмээр байна. Үүнийг ажлын хэсэг дээрээ засаж батлаад явцгаая.

Ер нь бол төр, ЗГ-ыг яаралтай, шуурхай ажлаа хийх боломжийг нь бүрдүүлж өгөхгүй бол энэ хуулиуд өргөн бариад л удаад байгаа нь бол их асуудлуудыг нийгэмд хүлээлт үүсгэхээд, тэгээд ер нь энэ асуудлууд шийдэгдэхгүй байх, хэт улс төржөөд байх ийм хүндрэл байна. Ялангуяа энэ Зөвшөөрлийн тухай хуулийг хэлэлцэж байхад тухайн үедээ бид энэ салбарууд дээр үүссэн байгаа журмуудыг цуцалчихсан, хуулиас давсан журам байх ёсгүй гээд баахан журмуудыг цуцалчихсан. Тэгээд түүнийгээ салбарын хуульд нь оруулна гэсэн ийм төлөвлөгөөтэй журмуудаа цуцалчихаад, тэгээд хуулиуд нь өөрчлөгдөөгүй учраас ингээд ямар ч зохицуулалтгүй бараг жил, 2 жил явж байгаа салбарууд хүртэл байна. Үүнийг олж харсан овсгоотой бизнес эрхлэгчид бол ямар ч зохицуулалтгүй шүү дээ гээд, өмнөх журмыг ч гэдэг юм уу, өмнөх хуулийг зөрчөөд үйл ажиллагаа явуулж байгаа ч газрууд байгааг бид анхаарч, энэ хуулиудыг яаралтай батлах хэрэгтэй, ажлын хэсэг гараасай гэсэн ийм нэг хүсэлт байна.

Мөн түүнчлэн энэ гадаадын ажиллах хүчний асуудлыг 24 оны 12 сард ЗГ-аас өргөн бариад, түүнээсээ өмнө 3 гишүүн өргөн бариад, өөрсдөө хууль дээрээ байхгүй байгаа шал өөр зохицуулалтыг буруу тайлбарлаж явснаас болж энэ ажиллах хүчний хууль гацаад, эргүүлэн татагдаа ч үгүй, хэлэлцэгдээ ч үгүй ингээд үлдчихсэн байна. Энэ хуулийг яаралтай оруулж ирэх хэрэгтэй байна. Энэ гадаадын ажиллах хүч Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалаар угаасаа хязгаарлагдсан байдаг юм. Нийт хүн амын 3 хувиас хэтэрч болохгүй, нэг улсаас 1 хувь хэтэрч болохгүй гэж. Нийтдээ манай Монгол Улс 105 мянган гадаад ажиллах хүчийг авах хуулийн боломж

нь нээлттэй байгаа юм. Нэг улсаас 30 мянган хүн гадаад ажиллах хүчийг авах боломж нь хуулиараа ҮАБЗ-ийн үзэл баримтлалаараа нээлттэй байгаа.

Яг одоо бол манай улсад 8, 11 мянган хүн гадаад ажиллах хүчээр ажиллаж байна. Энэний дийлэнх нь мэдээж уул уурхайн салбарт 3 мянга орчим хүн ажиллаж байгаа. Тэгэхээр яг энэ асуудлыг цэгцэлье гэж бодож байвал тухайн ЗГ-аас өргөн барьсан байгаа 24 оны энэ Ажиллах хүчний хуулийг хамтдаа явуулж байж сая тулгамдаад байгаа асуудал буюу гадаадаас ажиллах хүч авахдаа заавал 14 хоног хөдөлмөрийн бирж дээр нээлттэй зар байршуулдаг, 50 хувь хөнгөлөх шийдвэр гарсан боловч үүнийгээ хуулиар шинэчлээгүй байгаа учраас 100 хувь түрүүлж төлчөөд, тэгээд хугацааны дараа 50 хувийг нь буцааж авдаг гэх мэтчилэн боомилсон асуудлууд их байгаа учраас үүнийг зайлшгүй шийдвэрлэх шаардлагатай байна гэж үзэж энэ үгийг хэллээ. Тэгээд хариулт хэрэггүй, ер нь дэмжиж байгаа. Гэхдээ ажлын хэсгийн хувьд үүнийгээ.../минут дуусав/

С.Бямбацогт: ЗГ-аас хариулт хэрэггүй байх. Би мэдээлэл өгчихье. Энэ Бизнесийн эрх чөлөөний тухай хуулийг ЗГ нэн яаралтай горимоор өргөн барьсан. Эдийн засгийн эрх чөлөөний тухай хуулийг Цогтгэрэл нарын гишүүд өргөн барьсан байгаа. Тэгээд ирэх долоо хоногт Эдийн засгийн эрх чөлөөний тухай хуулийн хэлэлцүүлэг хийгдэнэ. Тэгээд хуулийн төсөл санаачлагчид хоорондоо ойлголцоод, нэгтгээд явах боломжтой гэх юм бол яаралтай ажлын хэсэг байгуулна. Ингээд ажиллаад энэ хаврын чуулгандаа баталчих ийм бодлого, төлөвлөгөөтэй ажиллаж байгаа. 2-лаа Эдийн засгийн эрх чөлөөний тухай хууль, Бизнесийн эрх чөлөөний тухай хууль хоёулаа чухал хууль учраас ийм байдлаар ажиллаж байгаа шүү дээ, бид аль болох шахаж ажиллаж байгаа хурдтай, шуурхай.

Гадаад ажиллах хүчний тухай хууль гээд зарим нэг хуулиуд дээр ЗГ санаачилчхаад, санаачилсан хуулиа байлгаж байгаа ч гэж, хөрөнгө хураах тухай хууль гээд нэг хэдэн хуулиудаа ингээд байлгачихсан байгаа. Энийг Даргын зөвлөл дээр, ирэх долоо хоногийн Даргын зөвлөл дээр ЗГХЭГ-ын даргыг оролцуулаад, байр суурийг нь сонсоод, шаардлагатай бол хэлэлцье гэвэл хэлэлцээд явъя, хэлэлцэхгүй гэх юм бол хэлэлцэхгүй байх нь. Тэгэхээр Тамгын газар Даргын зөвлөлийн хуралд ЗГХЭГ-ын даргыг оролцуулаарай, түүнээс өмнө байр суурийг нь тодорхой болгуулаарай.

Зочин танилцуулъя. Нийслэлийн ерөнхий боловсролын 105 дугаар сургуулийн Энхжаргал багштай 12В ангийн сурагчид УИХ-ын үйл ажиллагаа, Төрийн ордонтой танилцаж байна. Төрийн ордонтой танилцаж байгаа сурагч хүүхдүүддээ УИХ-ынхаа нийт гишүүдийн нэрийн өмнөөс эрүүл энх, аз жаргал, сайн сайхан бүхнийг хүсэн ерөөе. Эрхэм гишүүн Цэндийн Баатархүү асуултаа асууна уу.

Ц.Баатархүү: Өдрийн мэнд. Асуулт асуугаад тодорхой хариулахгүй учраас хариулах шаардлагагүй гэдгийг Энхбаяр сайдад хэлье. Энэ зүйлийг заавал оруулаарай гэдгийг хэлье. 1 дүгээрт техникийн нөхцөлийн нэг цонх байхгүй бол төрийн байгууллага гаргасан шийдвэрээ иргэн, ААН-ээс нэхсэн хэвээрээ байна. Жишээ нь барилга барих гэж байгаа компани барилгаа бариад, барилгаа барихдаа Ус сувгийн удирдах газраас, Улаанбаатар дулааны сүлжээ ТӨХК-иас, Эрчим хүчний газраас яг ижилхэн газрын гэрээ, барилгын зураг, төрд байгаа ижилхэн мэдээллийг цаасаар нэхсээр байгаа тохиолдолд энэ хууль гарсан ч тунхаг хэвээрээ болно. Монгол Улс хуулийн тоогоороо дутахааргүй болсон, УИХ хуулийг үйлдвэрлэж

байна. Хууль нь амьдрал дээр хэрэгжихгүй байна, бид энэ хуулийн хэрэгжилт гэдэг зүйл дээрээ анхаарч энэ хуулийг батлах шаардлага байна гэж харж байна.

2-рт төрд байгаа мэдээллийг иргэнээс нэхэхгүй гээд хугацаа заагаад, 14 хоногийн дотор хариу өгөөгүй бол зөвшөөрсөнд тооцно гэдэг зүйл чинь амьдрал дээр биелдэггүй юм, заавал цаасаар нэхдэг учраас дараагийн байгууллага газрын гэрээний нотариатаар гэрчилсэн хуулбар чинь байхгүй байна гээд дараагийнхаа зөвшөөрлийг өгөхгүй. Тэгэхээр автоматаар дижитал буюу цахим систем дээр энийг гэрчилгээ үүсгэдэг, эрх үүсгэдэг цахим шийдлийн технологийг энэ хуультай хамт хийхгүй бол явахгүй гэдгийг хэлье.

3-д төрийн институтийн бүтэц буюу засаг захиргааны нэгж дээр тодорхой өөрчлөлт хийхгүй бол энэ хууль хэрэгжихгүй, хүчээр зөвшөөрлийн тоог буулгаж байгаа юм шиг болно. 22 оны Зөвшөөрлийн тухай хууль дээр 350 зөвшөөрлөөс илүү гаргахгүй гэж хуульчилсан боловч амьдрал дээр мянга гаруй дүрэм, журам бизнес эрхлэгчдийг боомилж байна. Монгол Улсад хэн танилтай нь ажлаа амжуулдаг, танилгүй нь хүлээдэг ийм тогтолцоог бид бүтээсэн байна. Тэгэхээр яах ёстой юм бэ гэхээр Иргэдийн хурал, орон нутгийн нутгийн өөрөө удирдах байгууллага журам гаргахгүй, дүрэм гаргахгүй гэдгийг хатуу хуульчлах хэрэгтэй.

2-рт, төрөөс олгож байгаа ижил төстэй зөвшөөрлийг нэг цонхоор олгодог болгох шаардлага байна. Үнэхээр энэ дэд бүтцийн зөвшөөрөл, эрчим хүч, ус суваг, дулаан, энэ барилгын зөвшөөрлийг Нийслэл Улаанбаатар хотод болон хотуудад нэг цонхоор гаргадаг, нэг цонхны үйлчилгээ хийхгүй бол 4 байгууллага дээр ээлжлэн очоод бизнес эрхлэгчид ядарч байна, хүнд суртлын хаалгыг татаж байна, авлигын эрсдэл бий болж байна, тийм учраас энэ хуулийг би дэмжиж байгаа. Гэхдээ эдгээр өөрчлөлт байхгүй бол эргээд нэг тунхаг үйлдвэрлэх гэж байна шүү гэдгийг дахин хэлье. Баярлалаа.

С.Бямбацогт: Асуулт асуух дэгтэй. Хариулах үүрэгтэй, Энхбаяр сайд хариулъя.

Ж.Энхбаяр: Баатархүү гишүүн үнэтэй санаа гаргаж байгаа, тантай санал нэг байгаа. Тэгэхээр бид энэ төрийн үйлчилгээний ил тод байдал, ялангуяа цахимжуулалт дээр онцгой анхаарч, хөгжүүлэлтийг хийж байгаа. "И-Бизнес" /e-business.mn/ платформд ерөөсөө тэнд хандаад л зөвшөөрлүүд гардаг, ер нь 90 хувь нь тэгж гарна. Тэгээд төрд өөрт байгаа мэдээллийг нэгээс илүү удаа шаардахгүй. Нэгэнт системд мэдээлэл орлоо бол тэр системийг төрийн бүх байгууллагууд тэрний дагуу бүрдүүлбэрээ хангаад явдаг, ахиж цаас нэмэхгүй гэдэг. Ингээд бид ялангуяа тэр техникийн нөхцөлтэй холбоотой асуудлууд байгаа. Ингээд олон давхар байгууллагын зөвшөөрөл, нэгдсэн бодлогын уялдааны алдагдал чинь л энэ байхгүй юу. Хот төлөвлөлт нэг гарсан бол тэрийгээ дагаад дэд бүтэц, эрчим хүч, ус суваг, цэвэрлэх бүгд гардаг, дагасан боломж нь өгдөг. Тэрнээс биш нэг нь юм өгчихдөг, нөгөөдөх нь өгдөггүй, боломжгүй байхад өгдөг гэдэг юм уу, ингээд өөр өөр.

Жишээлбэл энэ салбарууд чинь өөр, өөр яваад байна шүү дээ, эрчим хүчний эх үүсвэр нь бололцоотой болохоор өгчихдөг, нөгөө талдаа дулаан байхгүй болохоор өгдөггүй. Гэтэл тэндээс нь цэвэр, бохирын асуудал шийдэгдээгүй болохоор нөгөө ажил байдаггүй. Ийм мэтийн бидний өдөр тутмын амьдралд тулгарч байгаа асуудал шүү дээ. Энэ болгоныг л зохицуулах гээд энэ чинь 99 хуулийг өөрчилъе гэж оруулж ирж байгаа том ажил. Тэгэхээр ажлын хэсэг дээрээ бүгдээрээ,

би АН-ын нөхдөдөө хандахад, улс төржилгүй бүгдээрээ Монгол Улсынхаа хөрөнгө оруулалт, бизнес орчныг сайжруулцгаая. Энэ бизнесийн эрх чөлөө, эдийн засгийн эрх чөлөөний хуулиа нэгтгээд, 1 ажлын хэсэг гарцгаагаад бүгдээрээ хийе.

Энэ удаагийн парламентын хамтын их сайн бүтээл болох байх. Энэ Монгол Улсын хөгжил дэвшлийн төлөө бүгдээрээ хамтраад, энэний төлөө нэг сайхан ажиллаад, улсын их баяр наадмын өмнө энэ хуулиа амжилттай батлаад, ингээд бүх тойрогтоо бүх гишүүд очоод ярихад, бүх салбартаа очиж ярихад их сайхан зүйл болно. Энэ үндсэндээ өнгөрсөн 35 жилийн хугацааны Монгол Улсын хөрөнгө оруулалт, бизнесийн орчинд хийсэн 6 сар гаруйн дүн шинжилгээний үр дүн гарч ирж байгаа ажил шүү, их том ахиж байгаа, орчноо сайжруулж байгаа. Ер нь ингэхгүйгээр манай эдийн засаг цаашаа тэлэхэд хязгаарлагдмал болж байгаа. Хөрөнгө оруулалтаа сайжруулъя, орчноо сайжруулъя, шинэ зах зээлийг нээе, бизнес эрхлэгчдээ дэмжье гэдэг л ийм гол зүйл дээр санал нийлнэ. Бүгдээрээ хамтраад ажиллана гэдэгт итгэлтэй байна.

С.Бямбацогт: Мөнхчулууны Энхцэцэг гишүүн асуултаа асууя.

М.Энхцэцэг: Та бүхэнд энэ өдрийн мэндийг хүргэе. Тэгээд ЗГ-ын зүгээс Бизнесийн эрх чөлөөний тухай ийм анхдагч хуулийг боловсруулж оруулж ирж байгаа нь маш сайн байна. Энэ хуулийг үзэл баримтлалын хүрээнд дэмжиж байгаа. Тэгэхээр энэ хуулийн мэдээж эрхэм гол зорилго бол бизнесийн эрх чөлөөг хязгаарлаад байгаа хүчин зүйлүүдийг бууруулах гэж ингэж ойлгож байгаа. Тэгэхээр бид мэднэ, бизнесийн эрх чөлөөг хязгаарлаад байгаа хамгийн том зүйл бол Монгол Улсад ерөөсөө л тусгай зөвшөөрөл. Зарим салбар маань бүр тусгай зөвшөөрлийн салбар болчихсон байгаа. Тухайлбал, эрчим хүчний салбарын Эрчим хүчний тухай хуулийн 40-өөд хувь нь зөвхөн тусгай зөвшөөрлийн тухай, хамгийн гайхалтай байгаа биз. Тэгэхээр өөрөөр хэлбэл энэ салбарыг ингээд маш хүнд сурталтай, цөөхөн хэдэн хүмүүс бизнес хийдэг гэдэг энэ нийгмийн ойлголт яг эндээс ингээд харагдаж байгаа юм. Тэгэхээр шаардлагагүй зүйл дээр тусгай зөвшөөрөл шаарддаг, тусгай зөвшөөрөл нь хугацаатай байдаг. Хөөрхий нөгөө хөрөнгө оруулалтаа хийх гээд л ажлаа хийх гээд ухнатаад явж байтал нөгөө хугацаа нь дуусчихдаг, дахиад эхнээс нь тусгай зөвшөөрлөө хөөцөлддөг, тэгээд тусгай зөвшөөрөл нь асар үнэтэй. Ерөөсөө энэ салбарын хүндрэл бэрхшээл, хүнд суртлын гол үүр уурхай нь тусгай зөвшөөрөл гэж ингэж харж байгаа.

Тухайлбал, шинэ эх үүсвэр барих гэж байгаа нөхдүүдээс тусгай зөвшөөрөл ав гэж шаарддаг. Нөгөө хөрөнгө оруулалтаа ингээд хөөцөлдөөд явж байтал нөгөө тусгай зөвшөөрлийн хугацаа нь дуусчихдаг, дахиад эхнээсээ авах хэрэгтэй болдог. Хүн өөрийнхөө үйлдвэрт зориулаад зүгээр нэг сэргээгдэх эрчим хүчний эх үүсвэр барьчихъя гэхэд тусгай зөвшөөрөл ав гэдэг. Хүн өөрийнхөө мөнгөөр барих гэж байгаа шүү дээ. Өөрөөр хэлбэл эрчим хүчний салбарын хүнд суртал, цөөхөн хэдэн хүн бизнес хийдэг бухимдлыг үүсгэдэг юм бол тусгай зөвшөөрөл байгаад байгаа. Тэгэхээр энэ тусгай зөвшөөрлийг, энэ хүнд суртлыг бууруулах эрчим хүчний салбарын салбарт бизнесийн эрх чөлөөг нээх, хөрөнгө оруулалтыг татах ямар зохицуулалтыг энэ хууль дээр тусгаж орж ирсэн юм бэ гэсэн асуултыг асуумаар байна. Та бүхэн тодорхой хариулж өгөөч. Энэ хариулж байгаа байдлыг харахаар яг тодорхой хариулахгүй юм байна, ерөөсөө л нэг ийм лоозон, үзэл баримтлалыг л яриад байх юм. Яг ийм, ийм заалтууд орж ирсэн юм, Эрчим хүчний тухай хуулийн тэр 40-өөд хувь нь тусгай зөвшөөрлийн тухай байгаа, тэрийг бид 20 хувь болгох гэж байгаа, энэ, энэ заалтыг нь хүчингүй болгох гэж байгаа ч гэдэг юм уу, ийм тодорхой

хариулаач. Хэрвээ хариулж чадахгүй бол цаасаар, тэр бичгээр хариулт өгөөч. Тэгэх л юм бол өнөөдөр эрчим хүчний салбарын тулгамдсан олон асуултууд, олон асуудлууд шийдэгдэнэ, хөрөнгө оруулалтууд татагдана.

Техникийн нөхцөл хамгийн анхны асуудал шүү. Бид 20 кВт-ын нарны панелыг техникийн нөхцөлгүй болгох гэж энэ салбартай нэлээн үзэж, дарж байж нэг байхгүй болгосон. Энэ зөвхөн эхний ажил. Гэтэл хууль дээр нь 40 хувь нь тусгай зөвшөөрлийн тухай байдаг шүү дээ та бүхэн ингээд хар даа. Тэгэхээр тэр 40 хувийг хэд болгож бууруулах гэж байгаа юм бэ, энэ эрх чөлөөний хуулийн хүрээнд гэж асуулт.../минут дуусав/

С.Бямбацогт: Сайд нар тодорхой хариулмаар байна. Би 19 онд Зөвшөөрлийн тухай хуулийг санаачилж, 1300 тусгай зөвшөөрлийг 400 болгож, 3 дахин цөөлөх хуулийг 22 онд батлуулсан. Үүнээс хойш хэд болж нэмэгдсэн юм бэ, одоо энэ өргөн барьсан хуулиараа дахиж хэд болж, яаж цөөлөх гэж байгаа юм бэ энэ дээр нэг тодорхой хариулт өгчихье, тоогоор нь. Энхбаяр сайд.

Ж.Энхбаяр: Эрчим хүчний салбар яг ийм судалгаа гарсан, хамгийн их зөвшөөрөлтэй хууль. Нөгөө талаас Монгол Улсын хөгжлийн бодлогоос хамгийн их хоцрогдсон салбар, зайлшгүй иж бүрэн шинжилгээ хийгээд, иж бүрэн реформ хийх ёстой. Улс орныхоо хөгжлийг өнөөдөр эрчим хүчний үйлдвэрлэл хангаж чадахаа больсон. Тэгэхээр энэ салбарт хөрөнгө оруулалтыг татахын тулд үйл ажиллагааг сайжруулах, таатай орчныг бүрдүүлэх, салбарыг либералчлах олон асуудлууд байгаа. Энэ хүрээнд Эрчим хүчний тухай хуулийн нэг хэд хэдэн гол заалтууд орсон. Танд би яг хуулийн өөрчлөлтийг цаасан дээр буулгаж өгье. Энэ дээр нэг гол өөрчлөлт нь, төрийн бус байгууллагууд, мэргэжлийн байгууллагуудад гэрээгээр хэрэгжүүлэх бололцоог, энэ зөвшөөрлүүдийн тодорхой хэсгийг шилжүүлж байгаа. Илүү мэргэжлийн салбар дотроо өөрсдөө хяналтаа тавина гэсэн үг, салбарынхаа нэр хүндийг хамгаална, мэргэжлийн чанарыг хадгална гэсэн үг.

Зөвшөөрөл авахад бүрдүүлдэг бичиг баримтын шаардлагуудыг шинэчилсэн, нэлээн тодорхой болгосон. Эрчим хүчний үйл ажиллагааны хүчин чадал, төрөл, чанарын үзүүлэлттэй холбоотой шаардлагуудыг өөрчилсөн, сонгон шалгаруулалтаар зөвшөөрөл олгох зохицуулалтыг хүчингүй болгосон. Зөвшөөрөлтэй холбоотой нэр томьёо, зохицуулалтыг энэ Зөвшөөрлийн тухай хуулийн нэмэлт, өөрчлөлттэй нийцүүлэн иж бүрнээр нь шинэчилсэн. Цахим хэлбэрээр зөвшөөрөл олгохтой холбоотой зарим зохицуулалтуудыг хассан, хүнд суртал гох дэгээг хассан гэсэн үг. Энэ мэтчилэн ялангуяа эрчим хүчний салбарт чиглэсэн бодлогын арга хэмжээнүүд энэ хуулиар давхар зохицуулагдаж байгаа. Ажлын хэсэг нь нэгэнт Эрчим хүчний тухай хуулийг хөндөөд ороод ирсэн болохоор энэ хуулийн өргөн барьсан үзэл баримтлалын хүрээнд ажлын хэсгээс санал гаргаад, улам боловсронгуй болгох, сайжруулах ажлуудыг, Энхцэцэг гишүүнээ, хамтраад хийхэд бэлэн байна, хариуллаа.

С.Бямбацогт: Баярлалаа, Доржханд сайд нэмж хариулъя.

Т.Доржханд: Яг эрчим хүчний салбарт яг үр дүн гарахын төлөө ажилладаг цөөхөн гишүүдийн нэг нь манай Энхцэцэг гишүүн л дээ. Тэгээд Энхцэцэг гишүүний байр суурьтай би санал нэг байдаг чөлөөлөх ёстой, ногоон эрчим хүчийг дэмжих ёстой, тархмал эх үүсвэрийг дэмжих ёстой, зөвшөөрлийг бууруулах ёстой гээд. Энэ зөвшөөрөл дээр яг хуулиараа өнөөдөр 34 тусгай зөвшөөрөл байгаагаас 14-ийг нь

цуцлаад, 20 болгож байгаа шүү, Энхцэцэг гишүүнээ. Тэгэхээр 35 хувийн ийм хөнгөлөлт, чөлөөлөлт энэ хуулиар орж ирж байгаа. Тэгээд тусгайлан тэр мэдээллийг ажлын хэсгээс манайхан өгөх байх.

Танд гэж хэлэхэд нэг сайн зүйл орж ирж байгаа нь юу вэ гэхээр яг энэ сэргээгдэх эрчим хүч, дата төв, тэгээд ногоон устөрөгч гээд яг эрчим хүчний томоохон төслүүдийн бүтээн байгуулалтын тоног төхөөрөмжийг гаалийн албан татвараас 100 хувь чөлөөлөхөөр оруулж ирж байгаагаараа энэ их ач холбогдолтой. Тийм болохоор та энэ дээр.../минут дуусав/

С.Бямбацогт: Ганбатын Очирбат гишүүн асуултаа асууя.

Г.Очирбат: Гишүүддээ өдрийн мэнд хүргэе. Сүүлийн үед ЗГ-аас олон хуулийн төслүүд ар араасаа бөмбөгдөж орж ирж байна. Агуулгын хүрээнд суурь судалгаа дутуу дулимаг ийм хуулийн төслүүд орж ирж байгаа юм. Энтэй холбоотой зүгээр яах вэ, олон бараг 99 хуулийн төслийг өөрчилж байгаа нь зөвшөөрлөөс суллаад байна гээд байгаа юм. Тэгээд бүтэн сулласан юм уу гэхээр яг хуулийнхаа зүйл, заалт дээр бүтэн сулласан юм байхгүй. Би та хэдэд уншиж үзүүлбэ. Зөвшөөрөл олгох эрх бүхий этгээд Зөвшөөрөл, мэдэгдлийн тухай хуулийн 3.3 дугаар зүйлийн 1-д заасны дагуу зөвшөөрөл олгох эрхээ бүхэлд нь эсхүл хэсэгчлэн гэрээний үндсэн дээр Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.3, 1.7-д заасан хуулийн этгээдэд шилжүүлэн гүйцэтгүүлж болно гэж байгаа юм. Ингээд шилжүүлэн гэрээний дагуу гүйцэтгэнэ гэхээр яаж байна гэхээр энэ бүх мэргэжлийн холбоодыг ЗГ гартаа авах гэж байгаа юм.

Засгийн газрын тухай хуулийн 19.1, 19.2-оо манай ЗГ-ыхан өөрсдөө мэдэж байгаа байх. 19.2 дээр юу гэж заасан бэ гэхээр гэрээний дагуу ажил гүйцэтгээд төлбөр төлсөн бол Монгол Улсын зохих сайдын өмнө хариуцлага хүлээнэ гэж байгаа юм. Тэгээд ингээд буцаагаад бүгдийг нь боож авах гэж байгаа, хайрцаглаж авах гэж байгаа ийм хуулийн төсөл явж байгаа шүү. Би урьдын 2 ч хуулийн төсөл дээр энийгээ засаач гэж хэлж байсан боловч яг ингээд Засгийн газрын тухай хуулийн энэ 19.1, 19.2-оо өөрчлөхгүйгээр оруулж ирж дайрч байгаа юм. Тэгэхээр энэ хуультай холбоотой яг энэ хэчнээн ТББ-тай гэрээ хийсэн юм, хэдэн төгрөгийн мөнгө өгсөн юм, ямар үр дүн гарсан юм гэдэг нь эхний асуулт?

2 дахь нь, бид энд Их Хурлын гишүүд ингэж сууж байгаад ЗГ-аас орж ирсэн хуулийг хуу хамж баталдаг. Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн тухай хуулиараа бид энэ 2027 оны хөгжлийн төлөвлөгөө баталсан. Энийг хуулийн дагуу Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн тухай хуулийн 18.3-т 6 дугаар сарын 1-ний дотор батлах ёстой байсан. Тэгэхэд МАН-ын бүлгийн дарга нь хууль зөрчиж завсарлага аваад, Их Хурлын дарга маань 6 дугаар сарын 4-ний өдөр баталсан санагдаад байх юм, энэ асуудлыг яах вэ? Цаашаа Үндсэн хууль руу, Цэц рүү хандъя гэхээр Үндсэн хуулийн дээр хөх тэнгэр байдаг байсан бол одоо өөр дарга нар байгаа юм шиг байна лээ, тэгээд хандаж чадахгүй байгаад байна.

Дараа нь ЗГ-аас Хот, тосгоны эрх зүйн байдлын тухай хууль орж ирсэн. Үндсэн хууль зөрчсөн. Үндсэн хуультай нэг адилхан дагаж мөрдөх шилжих журмын тухай хууль байгаа. Журмын тухай хууль дээр 2020 оны эхний хагас жилд багтаан шийдвэрлэнэ гэж байгаа шүү. Дархан, Эрдэнэт гэдэг 2 хотыг хотын зэрэглэлтэй хот болгоно гэсэн, Үндсэн хуулиа зөрчиж орж ирсэн. Тэгээд бид энд ингээд хууль зөрчиж сууж байгаа. Ийм нэг давамгайлсан, далайлгасан, ард иргэдээ, сөрөг хүчнийхээ

үгийг сонсдоггүй ийм байдалтай байгаа. Тэгээд асуултдаа хариулт авчхаад тодруулъя.

С.Бямбацогт: Энхбаяр сайд хариулъя.

Ж.Энхбаяр: Эхний ээлжид Очирбат гишүүнд анхааруулъя. Үндсэн хууль зөрчсөн эсэх асуудлыг Их Хурлын гишүүн тогтоодоггүй шүү, та олон удаа хэлээд байгаа. Тогтоодог байгууллагатай, Үндсэн хуулийг хамгаалдаг ҮХЦ-тэй. Та ҮХЦ-д маргаан гаргах эрхтэй, тэр хүрээндээ энэ харилцаагаа зохицуулна шүү. Тэгэхгүй дур зоргоороо Үндсэн хууль зөрчсөн, ингэсэн гээд их зарлаад яриад үгүйсгэх нь сайн үр дагавар хүргэхгүй гэдгийг анхааруулъя.

2-рт, 3Г бүхий л салбарын зөвшөөрөл, дүрэм журмын асуудал хариуцаж байгаа, энэнээсээ л татгалзъя гэж байгаа юм, 120 чиглэлийн зөвшөөрлийг мэргэжлийн төрийн бус байгууллагуудад нь шилжүүлъя. Барилгын, нийтийн үйлчилгээ, соёлын гээд олон салбарт 120 3Г-ын олгож байгаа, яамдын олгож байгаа зөвшөөрлийг байгууллагууддаа өгөх эрхийг энүүгээр нээж байгаа юм. Энэ өөрөө бизнес дэх төрийн оролцоог багасгах, хувийн хэвшлээ дэмжих, нөгөө талд засгийг төлөөлж сайд төрийн бус байгууллагуудтай гэрээ хийнэ, бас үүрэг хариуцлагын асуудлыг хадгална. Гэрээгээр үүрэг хүлээсэн ТББ ажлаа зохион байгуулж чадахгүй бол тэрийг хүчингүй болгох, татах, зохицуулах нь төрийн үүрэг. Яагаад гэвэл тэрний цаана чинь түмэн олны эрх ашиг, иргэний эрх ашгийн асуудал яригдана шүү дээ, эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрх байгаа.

Гэхдээ ТББ харьцангуй өнгөрсөн 30-аад жилийн хугацаанд төрийн бус байгууллагууд мэргэшиж байна. Мэргэжлийн ийм төрийн бус байгууллагууд олноор бий болж байна, мэргэжлийн инженер техникийн байгууллагууд үүсэж байна, эд нартаа эрхийг нь өгье гэж байгаа юм, зөвшөөрлийг нь өгье гэж байгаа юм. Тэд нь дотроо салбараа үнэлээд, дүгнээд, шалгаад, шалгуураа хангаад одоо өгнө үү, цэцгээ өгнө үү тэр зэрэглэлийг нь тогтооно уу ингээд өөрсдөө явцгааг. Энэ болгонд бизнесийн үйл ажиллагаанаас төрийг жоохон аль болох холдохыг эхлээд бид үзээд 120 зөвшөөрлийг өгөх бололцоотой байна гэж үзэж байгаа. Нэг ийм л зохицуулалтууд хийгээд энэ хөрөнгө оруулалтын орчноо сайжруулах, бизнесийн эрх чөлөөг хангах, бизнес эрхлэх бололцоог нээх л энэ бодлогын хүрээнд явж байгаа ажил шүү дээ. Тэгэхээр асуудлыг битгий үгүйсгэл гэдэг нүдээр хараад, ингээд биш шүү дээ, яавал хамтраад ингээд хийх вэ, танд ямар гоё шинэ санал байна, санаа байна, тэрийгээ гаргаж өгч уралдуулаач. Ерөнхий ийм улс төржчихсэн, нэг ийм хоосон хийрхсэн үгүйсгэл чинь үр дүн их багатай шүү. Таны ажил хэрэгч саналыг хүлээж авахад бэлэн байна, хамтраад ажиллахад бэлэн байна шүү.

С.Бямбацогт: Хэдэн байгууллагатай гэрээ хийсэн бэ гэж байна, гүйцэд хариулаад өгөөч гэж байна. Тодруулах уу, тодруулъя, Очирбат гишүүн тодруулъя.

Г.Очирбат: Би маш тодорхой юм асуугаад байгаа юм Энхбаяр сайдаа. Та хариулт байхгүй, мэдэгдэхгүй, хэдэн байгууллагатай гэрээ хийснээ мэдэхгүй, төсвийн хэдэн төгрөгийг тийшээ оруулснаа хэлж чадахгүй байгаад байна шүү дээ, тэгээд тэрийгээ л та хэлчих л дээ, асуулт ерөөсөө тэр л байгаа шүү, 1-д.

2-т гэхэд хууль үйлчилдэг юм бол тэгш, шударгаар үйлчилъе гэж байгаа юм. Яагаад бид батлагдсан хуулиа мөрдөхгүй, 6 дугаар сарын 1-ний дотор батлах ёстой байсан хуулиараа, яагаад 4-нд баталж байгаа юм бэ? Энэ дээрээ тодруулга

авчихъя гэж байгаа юм. Үндсэн хууль дээр чинь бол ийм би яг ийм танд энэ тодруулаад, одоо энэ бичгийг би танд аваачаад өгчихье энэ цаасыг бүр хугацаатай байхгүй юу. Тэгээд энийг л би танаас асуугаад байна шүү дээ, тэгээд улс төржиж байна гээд байх юм. Би энд танаас хууль асууж байна, энэ хуулиа хэлэлцэх үү, хэлэлцэхгүй юу гэдэг дээр асуулт асууж байна. Хуулийн хүрээнд асууж байна. Тэгээд та тэр тоогоо хэлээд өгчих тэгээд, уул нь тодруулга дээр өөр юм тодруулах байсан юм ингээд хариулт нь асуултад бүрэн хариулж чадахгүй тодруулга ингээд цаг үрээд хаячих юм.

С.Бямбацогт: Энхбаяр сайд хариулъя.

Ж.Энхбаяр: Энэ чинь Монголын ард түмэн бүгд л харж байгаа шүү дээ. 6 дугаар сарын 1 чинь сая хагас, бүтэн сайн өдөр дамжаад, даваа гараг чинь 6 дугаар сарын 1 буюу бүх нийтийн амралтын өдөр л таарчихлаа шүү дээ. Тэгээд тэрийгээ дуусгаад ажлын өдөр буюу 6 дугаар сарын 2-нд ингээд л бүгд сууж байгаад л хуульд нийцүүлээд л баталлаа шүү дээ. Яагаад 6 дугаар сарын 1-нийг бүх нийтийн амралтын өдөр гээд заасан, бүх нийтийн амралтын өдөр бүх нийтээрээ л амрах зохицуулалттай. Ийм зохицуулалтууд байна шүү дээ. Ийм юмаар битгий хөөцөлд, наадах чинь дэмий байх.

2-рт бид чинь энэ шинэ хууль өргөн бариад хуулийн асуудал ярьж байна шүү дээ. 120 зөвшөөрлийг, засгаас өгөх зөвшөөрлийг төрийн бус байгууллагуудад нь шилжүүлбэ, мэргэжлийн байгууллагууд нь өгье гэж юм орж байна. Тэрнээс хэдийг өгөөд, ямар төгрөгийн гэрээ байгуулсан асуудал энд яригдахгүй. Хууль батлагдаад хэрэгжээд эхэлсний дараа дараа жил бүгдээрээ дүгнэцгээнэ. Засаг энэ 120 зөвшөөрлөөс хэдийг нь шилжүүлж чадсан байна, тэгээд бид тайлбарлана шүү дээ, ийм мэргэжлийн байгууллага хүлээж авч чадлаа, ийм зарим.../минут дуусав/

С.Бямбацогт: Очирбат гишүүн нэмж асууя.

Г.Очирбат: Энхбаяр сайдаа, хуулиа унш. 5 дугаар сарын 1-нээс өргөн бариад 6 дугаар сарын 1-нд батлагдана, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 18.3. Тэгээд 6 дугаар сарын 1 гэж юм яриад байх юм. Бид 5 дугаар сарын 30, 31-нд өмнө нь хэлэлцсэн шүү дээ, тэгээд тэрэндээ батлагдах ёстой байсан юм. Тийм тэгээд сонин юм та нээрээ зүгээр өөрөө жинхэнэ та попорч, хуулийн дагуу асуулт асуухаар хариулж чадахгүй, тэгээд Хүүхдийн баяр луу оруулаад байгаа юм уу. Нөгөө өөрийнхөө урьд нь хийж байсан тэр наадмаар баталдаг хууль шигээ, оны эцсээр баталдаг хууль шигээ, Хүүхдийн баяр дагуулж баталдаг хууль шигээ тэгж тийм юманд бодож хариулаад байгаа юм биш биз дээ та. Тэгээд хариултаа бүрэн авч чадсангүй, бичгээр өгчхөөрэй та. 3 асуулт асуусан шүү.

С.Бямбацогт: Хариултаа гүйцэд хариулах дэгтэй, дутуу байвал гүйцээгээд бичгээр өгчхөөрэй Эдийн засаг, хөгжлийн яам, ЗГ.

Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн тухай хуульд заасан улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөг бид 6 дугаар сарын 1-нд батлах хуультай, 5 дугаар сарын 1-нд өргөн бариад 6 сарын 1-нд. 6 дугаар сарын 1-нд батлах гэж байгаад баталж чадаагүй, биш, 6 сарын 1 биш, 5 дугаар сарын 29-нд батлах гээд завсарлага авсан. 6 дугаар сарын 1 амралтын өдөр байсан, 30, 31 амралтын өдөр байсан, 3 өдөр дараалсан амралт, тэгээд бид 6 дугаар сарын 2-нд баталсан. Хэрвээ энэ батлах хуулийн хугацаанд батлах нь Их Хурлын үүрэг л дээ, ЗГ-ын биш, хуулийн хугацаатай

асуудлуудыг. Тэгээд 3 амралтын өдөр дамнасан учраас 29-ндөө амжаагүй хууль маань 6 дугаар сарын 2-нд батлагдсан шүү, энийг та бүхэн зөв ойлгоорой.

Хэрвээ Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хуулийнхаа дагуу жилийнхээ төлөвлөгөөг баталж чадаагүй байсан бол төсвийн хүрээний мэдэгдлээ батлахгүй бол үндсэндээ зун ЗГ, аймаг, нийслэлүүд орон нутгийн болон улсын төсвөө боловсруулахад нэлээн эрсдэл үүсэх байсан. Тэгээд намар төсвөө өргөн барьж чадах уу, чадахгүй юү, төсвөө өргөн барьж чадахгүй бол төсвөө хуулийн хугацаанд нь батлаагүй УИХ-ын чадамжийн асуудал гээд юмнууд байдаг. Тийм болохоор аль болох энэ хуулийн хугацаатай асуудлуудыг хуулийн хугацаанд нь батлах тал дээр УИХ-ын гишүүд маань гишүүний бүрэн эрхээ хэрэгжүүлж, ард иргэдийг төлөөлөх, иргэдийн өмнөөс санал өгөх үүргээ биелүүлж ажиллах нь их зохимжтой байгаа юм. Энийгээ цаашид гишүүд бид бодох ёстой гэдгийг хэлье.

Зочин танилцуулъя. Увс аймгийн Сагил сумын ЕБС-ийн 1990 оны төгсөгчид УИХ-ын үйл ажиллагаа, Төрийн ордонтой танилцаж байна. Төрийн ордонтой танилцаж байгаа, төгсөлтийнхөө баярыг тэмдэглэж байгаа иргэддээ УИХ-ынхаа нийт гишүүдийн нэрийн өмнөөс эрүүл энх, аз жаргал, сайн сайхан бүхнийг хүсэн ерөөе. Манай Цогтгэрэл гишүүний найзууд байна уу. Одонгийн Цогтгэрэл гишүүн мэндчилгээ дэвшүүлж, үг хэлнэ, асуултаа асууна.

О.Цогтгэрэл: Төгсөлтийнхөө баярыг тэмдэглэж байгаа Сагил сумын 90 оны төгсөгчдөдөө сайн сайхныг, төгсөлтийн баяраа сайхан, дурсамж дүүрэн өнгөрөөхийг та бүхэндээ хүсэн ерөөе.

ЗГ-аас Эдийн засгийн эрх чөлөөний тухай хуулийг өргөн бариад буцааж татаж аваад, бизнесийн эрх чөлөөний гэдэг хүрээнд оруулж ирсэн байна. Тэгэхээр яг энэ үзэл баримтлалынх нь түвшинд л би тодруулж асуух гээд байна л даа. Уг нь бол эдийн засгийн эрх чөлөө гэдэг чинь олон улсаараа хэмждэг 4 бүлэг, 12 үзүүлэлт бүхий, энэ нь дотроо хуулийн засаглал, ЗГ-ын хэмжээг үүнд оруулж хэмждэг, ЗГ-ын хэмжээ их байх тусмаа эдийн засгийн эрх чөлөөг хумьж байдаг. Шилжүүлэг, төсвийн оролцоо, эдийн засгийн зохицуулалт, зах зээлийн нээлттэй байдал гээд 4 бүлэг, 12 үзүүлэлтээр эдийн засгийн эрх чөлөөг гаргадаг индекс жил бүр гарч байдаг. Энэний энэ 12-ын зөвхөн нэг нь өөрөө бизнесийн эрх чөлөө. Тэр бизнес freedom гэдэг зөвхөн нэг нь.

Гэтэл яагаад та нар Эдийн засгийн эрх чөлөө гэдэг агуулгын хүрээнд хуулийн төсөл өргөн бариад буцааж татаж аваад, тэгээд зөвхөн 12-ны 1 болгож оруулж ирээд, оруулж ирэхдээ яг үндсэн агуулгаасаа шууд хамаарах уу, үгүй юү Зөвшөөрлийн тухай хуулийг тэр хуульд оруулах нэмэлт, өөрчлөлтүүд Зөвшөөрлийн тухай хуульдаа л оруулаад асуудлыг зохицуулах байтал Бизнесийн эрх чөлөө гэдэг нэр доор өөр хуулиудыг баахан хууль тэр хуулиудад зөвшөөрлийг цуцалж байгаа, багасгаж байгаа, дарамтыг бууруулж байгааг бол дэмжиж байна. Гэхдээ яг энэ агуулгын хүрээнд яагаад ингээд ийм хэлбэр тал руу явчлав?

Яг үндсэндээ бидний хувьд эдийн засгийн эрх чөлөө гэдэг чинь яг тэр олон улсын арга, аргачлалаар нь, тэр багц бүрэлдэхүүнээр нь үзэж байж энэ чинь олон улстай харьцуулах боломж бололцоо, дахиад дээрээс нь бид асуудалд жинхэнээсээ хандах өмчийн эрхийн тухай, энэ эдийн засгийн эрх чөлөөнд өмчийн эрх хэрхэн хамгаалагдаж байна вэ, өмчийн эрхийг хэрхэн яаж Монгол Улс хуулиар хэрхэн энэ Бизнесийн эрх чөлөө, Эдийн засгийн эрх чөлөөний тухай хуулиар хэрхэн яаж

хамгаалах юм бэ, ЗГ-ын шударга байдал, ЗГ-ын тэр татаас, шилжүүлэг, төсвийн эзэлж байгаа хувь хэмжээ эдийн засгийн эрх чөлөөнд чинь ингэж нөлөөлдөг гээд харьцуулалт энэ олон зүйлүүдийг та нар бүгдийг нь орхиод, яагаад ингээд 12-ны 1 болгоод оруулчихаж байгаа юм бэ? Үндсэндээ ингээд ийм ухралт хийчихэж байгаа юм бэ? Энэ дээр нэг, энэ хуулийнхаа үзэл баримтлалын түвшинд нэг тайлбар өгөөч.

С.Бямбацогт: Энхбаяр сайд хариулъя.

Ж.Энхбаяр: Эдийн засгийн шинжлэх ухаан өөрөө хязгаарлагдмал нөөцөөр хязгааргүй хэрэгцээг хангах л ийм маш өргөн хүрээний ойлголт шүү дээ, нийгмийн бүхий л харилцааг зохицуулах болчихоод байгаа юм. Бизнесийн эрх чөлөөний гэж оруулах нь их зохистой гэж үзсэн, яг тодорхой. Өнгөрсөн 35 жилийн хугацаанд Монгол Улсын бизнесийн орчинд үнэлгээ хийгээд ер нь бид олон зүйлийг хуульд, Үндсэн хуульд заасан боловч энэ баталгаажуулах ажлууд, нэлээн тодорхой болгох, ойлгомжтой болгох зүйлүүд нэлээн орхигдчихсон байна гэж үзсэн.

Тэгэхээр энэ бизнесийн үйл ажиллагаа эрхлэх эрхийг баталгаажуулж, шударга өрсөлдөөнийг дэмжих, энэ бизнесийн тогтвортой байдал, өмчийн халдашгүй дархан байдал, бизнесийн нэр хүнд гээд төрийн эдийн засаг дахь оролцоо, бизнес дэх оролцоо гээд байна. Ер нь энэ нь илүү үр дүнтэй гэж үзсэн, Бизнесийн эрх чөлөө. Энийгээ малгай хууль болгоод, дагаад бизнесийн орчин дотор хамгийн гол юм бол хөрөнгө оруулалтын орчин их сул байна. Хөрөнгө оруулалтын орчноо сайжруулъя гээд хөрөнгө оруулалтыг нь дагасан 20 орчим хуулийн өөрчлөлтүүд. Хөрөнгө оруулалтаар ялангуяа бидний байнга ярьдаг зээл үнэтэй хүүтэй байна, санхүүгийн салбар хүнд байна гэдэгт ярьдаг энэ гадаадын банк, хөрөнгө оруулалтыг оруулах энэ тэр саад болсон хязгаарлалтыг чөлөөлсөн, хөрөнгийн зах зээлд шинэ хөрөнгө оруулалт оруулахыг, эх үүсвэр татаж авчрахыг нээсэн.

Ялангуяа шинэ бизнесийн орчныг хиймэл оюун ухаан, дата төвийн хөрөнгө оруулалтыг дэмжих, энийгээ дагасан ажлын байрны чөлөөлөлтөөс авхуулаад, аялал жуулчлал, хүнс, хөнгөн үйлдвэрлэл гээд манай ажлын байр хамгийн их бий болгож байгаа, цаашид уул уурхайгаас ангид эдийн засгийг босгохын тулд тэргүүлж байгаа энэ салбаруудаараа бид ажиллах хүчний чөлөөлөлтүүд хийгээд, татварын чөлөөлөлтийг хийгээд ингээд явж байгаа.

Хөрөнгө оруулагчид гомдол их байгаа нь тодорхой гарсан, гомдлыг багасгах хэрэгтэй байгаа. Үнэхээр бидэнд тодорхойгүй олон зүйлүүд, хууль, шүүхийн байгууллага, төрийн захиргааны байгууллага, орон нутгийн байгууллага, энэ яам, агентлагтай холбоотой энэ олон зүйлүүд тодорхойгүй, ойлгомжгүй, давхардсан, уялдаагүй зүйлүүд байсан. Тэгээд энэ болгоныг цэгцлэхийн тулд зайлшгүй зөвшөөрлийн асуудлыг хөндөж, төрөөс эдийн засагт оролцож байгаа, тэр зөвшөөрлөөр дамжин оролцож байгаа оролцоог тодорхой болгох нь зайлшгүй шаардлага байгаа юм. Тийм болохоор энэ дагаад 99 хуулийг өөрчилж байгаа юм. Салбар салбар дотор байгаа зөвшөөрлүүдийг түүсэн гэсэн үг шүү дээ, хуульчилж өгч байна. Хуулийн гадуур сайдын эрх мэдлийн хүрээнд, агентлагийн даргын эрх мэдлийн хүрээнд зохицуулж байсан олон тэр 400, 500 зөвшөөрөл нэргүй ч зөвшөөрлийн адил үйлчилж байсан захиргааны акт, хэм хэмжээг л хуульчилж ил гаргаад, заримыг нь хүчингүй болгож байгаа юм. Үүн дотроо зөвшөөрлийнхөө бүр 120 орчим зөвшөөрлийг нь төрийн бус мэргэжлийн байгууллагуудад нь шилжүүлэе л гэж байна. Энэний үр дүнд Монгол Улсын тэр.../минут дуусав/

С.Бямбацогт: Цогтгэрэл гишүүн тодруулж асууя.

О.Цогтгэрэл: Хариулт бол үнэхээр хангалтгүй байна л даа. Та хэтэрхий ерөнхий юм яриад байна, хэтэрхий ерөнхий юм. Жишээ нь ингээд бизнесийн эрх чөлөө гэж, би эдийн засгийн эрх чөлөө гэдэг чинь энэнээс чинь та нар 12 бүлгээс нэгийг нь авчихлаа. Энэнд өмчийн эрхээ хамгаалуулах гэж байгаа иргэн энд хамаарахгүй юу, хөдөлмөр хийж, эдийн засгийн харилцаанд орж байгаа тэр ажилтан нь энэнд чинь хамаарахгүй юу? Та нар асуудлыг битгий ингэж явцууруул л даа. Энэ эдийн засгийн харилцаанд оролцож байгаа тэр бүх оролцогчдыгоо хэрхэн, яаж дэмжих вэ, тэд нарт яаж эрх чөлөөг нь өгөх вэ гэдэг энэ том үзэл санааны түвшинд би уг нь ЗГ-ыг өмнө нь хандаж байна гэж ойлгосон. Тэгээд бодлого, концепцоо өөрчлөөд ингээд явчихна лээ. Тэгэхээр яг одоо үндсэндээ Монгол Улсад тулгамдаж байгаа асуудал чинь Үндсэн хуулийн дараа эдийн засгийн суурь хуулиудыг салбар бүрийн хэдэн 100 хуулиар эрэмдэглээд хаячихсан, дураараа энэ асуудалд хандаж.../минут дуусав/

С.Бямбацогт: Доржханд сайд хариулъя.

Т.Доржханд: Тэгэхээр миний хувьд 30 жил яг эдийн засгийн чиглэлээр ажиллаж байгаа, сурч байгаа. Тэгээд эдийн засгийн онол дээр эдийн засгийн асуудал өөрөө нийгмийн харилцаа байдаг. Харин бизнесийн харилцаа гэдэг тусдаа. Тэгээд бизнесийн өнөөдрийн Монголын гол зовлон бол манай Цогтгэрэл гишүүн маш сайн мэдэж байгаа, төрийн оролцоо маш их байгаа гээд. Тийм болохоор бид маш ерөнхий агуулгаар хууль бичихээ больцгооё, бодитой байцгаая, тодорхой юмаа бичье гээд. Тэгвэл тодорхой юм нь юу юм бэ гэвэл төрөө жижигрүүлэх бүх юмыг хийх, төрийн эрх мэдлийг хумья, бизнесүүдийг дэмжих бүх л юмаа хийе, тэгвэл эрх чөлөөг нь өгье гэдэг энэ 2 агуулгаар ингээд Бизнесийн эрх чөлөөний хууль орж ирж байгаа. Тэгээд үндсэн зарчим ердөө л тэр. Төр хол байя, төр янз янзын хяналт тавьдгаа больё, тэр бүх эрх мэдлийг нь бүгдийг нь хамгийн боломжит түвшинд нь хязгаарлая. Нөгөө талд нь бизнесүүдэд эрх чөлөөг нь өгөх.../минут дуусав/

С.Бямбацогт: Энхбаяр сайд нэмээд хариулъя.

Ж.Энхбаяр: Та бид 2 энэ хуулийн асуудлаар өмнө нь уулзаад санал бодлоо солилцож, олон зүйл дээр л санал нийлж байсан. Засгаас оруулж ирсэн Бизнес эрх чөлөөний тухай хуулийн төсөл, АН-аас оруулж ирсэн Эдийн засгийн эрх чөлөөний тухай хуулийн төслийг бүх заалтаар нь харьцуулалт хийсэн, ер нь 90 хувь ижил төстэй л байлаа шүү дээ. Нэг их ялгараад л, нэг их өөр болоод байгаа юм байхгүй шүү дээ. Энэ чинь бидний өнгөрсөн туулсан л түүх. Бид хамгийн давуу талтай нь юун дээр алдсанаа ойлгоод байна, юу засахаа мэдээд байна, ерөөсөө үнэт зүйлийн зөрчлийн ялгаатай байдал байхгүй. Харьцуулалт хийсэн, энийг би танд өгнө. Би бүр заавал харьцуул гээд харьцуулалт хийсэн юм билээ, ижил төстэй олон зүйлүүд байна.

Тэгээд би ийм зүйл хэлж байгаа юм, АН-ын нөхдүүд улс төржихгүй хамтраад, ажлын хэсгийг Их Хурлын дарга хамт байгуулж өгөөд ингээд Их Хурлын хамтын бүтээл, парламентын хамтын бүтээл болгоод.../минут дуусав/

С.Бямбацогт: Хариултаа гүйцээе, дуусгая.

Ж.Энхбаяр: Энэ дээр нэг улс төржихгүйгээр хамтын бүтээл болгоод улс төрийн намууд үндэсний хэмжээний зөвшлөө хийгээд, Монгол Улсынхаа эдийн засаг, бизнес орчныг нэг сайжруулаад явчихъя. АН-ын энэ дээр ажилласан Жаргалан гишүүнээс авхуулаад, та, таны хуулийн төсөл гээд олон гишүүд орсон шүү дээ, ХҮН намынхан идэвхтэй орсон, Үндэсний эвслийнхэн нь идэвхтэй оролцоцгоосон, Иргэний зориг ногоон намын гишүүд орцгоосон. Ингээд Их Хурлын дарга ажлын хэсэг байгуулж өгөөд бүгдээрээ энийгээ хийгээд, Улсын их баяр наадмын өмнө хамтраад гаргачихъя. Тэгэхгүй бол Цогтгэрэл дарга ингээд хэт үгүйсгэх, туйлшрах юмнаас аль болох зайлсхийгээрэй. Энэ Монголын нийгэм, бизнес эрхлэгчид бүгд л хүлээж байгаа ийм асуудал шүү дээ. Ялангуяа тэгээд л маргаад байвал зөндөө л юм, өмч гэж юу юм, өмчийн эрх, иргэний юм байна уу, бизнес юм байна уу, энэ чинь ялгаа байхгүй л бизнесийн л зохицуулалт шүү дээ. Иргэний хөдөлмөрийн асуудал ярина, мөн л адилхан бизнест хамаарна. Ингээд яриад байвал төгсөшгүй юм болно, тэгэхээр бүгдээрээ энийгээ яг ажлын хэсэг дээр хамтраад.../минут дуусав/

С.Бямбацогт: Зочин танилцуулъя. Нийслэлийн ерөнхий боловсролын 10 дугаар сургуулийн 2006 оны төгсөгчид УИХ-ын үйл ажиллагаа, Төрийн ордонтой танилцаж байна. Төгсөлтийнхөө 20 жилийн ойг тэмдэглэж байгаа та бүхэндээ УИХ-ынхаа нийт гишүүдийн нэрийн өмнөөс эрүүл энх, аз жаргал, сайн сайхан бүхнийг хүсэн ерөөе.

Энэ асуудлыг 1 цаг 30 минутын хугацаанд хэлэлцэх дэгтэй, одоо 2 гишүүн үг хэлэхээр, асуулт асуухаар үлдсэн байна. Энийг дуустал сунгая. Агваанлувсангийн Ундраа гишүүн асуултаа асууя.

А.Ундраа: Энэ Эдийн засгийн эрх чөлөөний тухай хуулийн 2 version гараад, тэгээд ажлын хэсэг дээрээ нийцүүлэх, тэгээд аль аль давхцал байна вэ, тэрийг нь анхаарч үзэх, ингэж нэгдмэл байдлаар оруулж ирэх талаар ажилласан, тэгээд тодорхой хэмжээнд АН-ын саналыг тусгаад, АН-ын хувилбартай нийцүүлээд ингээд оруулж ирж байгаад баяртай байна.

Асуулт, бидний хувьд ингээд төрийн өмч давамгайлсан эдийн засаг бий болчихлоо. Тэгэхээр аль болох либералчилж, илүү хувийн хэвшил давамгайлсан байдлаар хөгжиж байж улс орны эдийн засаг бол илүү хурдтай тэлнэ, төрийн оролцоо багасна гээд энэ зарчим дээр санал нэг байгаа. Салбар хоорондын харьцуулалт хэр зэрэг хийсэн бэ гэдэг дээр асуулт байна. Бидний хувьд тодорхой хэмжээнд ерээд оны эхэн үед илүү либералчилсан салбарууд нь илүү сайн хөгжсөн ийм сайн жишээнүүд хэлж болно. Хэдийгээр асуудал байгаа ч гэлээ гэсэн жишээлэхэд барилгын салбар тусгай зөвшөөрлүүдээ барилгын ассоциациар дамжуулан олгох, илүү ТББ, мэргэжлийн төрийн бус байгууллагууд руу зарим эрх мэдлээ шилжүүлэх, төрийн чиг үүргийг гүйцэтгүүлэх энэ ажлыг тодорхой хэмжээнд амжилттай хэрэгжүүлж байгаа. Тэгээд гарч байгаа асуудлуудаа цэгцлээд, ингээд илүү сайжруулаад ингээд явах бололцоо барилгын салбарт байна гэж харагдаж байгаа юм.

Харилцаа холбооны салбарт жишээлэхэд либералчлал хэдий чинээ эрт хийгдсэн тусмаа төдий чинээ өрсөлдөөн илүү бий болж, үүрэн телефоны үйлчилгээ үзүүлдэг компаниудын тоо нэмэгдсэн, үйлчилгээний цар хүрээ өргөжсөн гээд ийм сайн тал байна. Гэтэл үүнтэй харьцуулахад жишээлэхэд эрчим хүчний салбар

либералчлагдаагүй учраас өнөөдөр байгаа энэ төрийн хэт оролцоо, хэт их зохицуулалт хийснээс болж үнэ тарифын асуудлыг чөлөөлөөгүй. Энэ нь явсаар байгаад энэ салбарыг өөрийг нь тушиж, татаж унагасан энэ нөхцөл байдал бол бидний энэ өнгөрсөн 30 гаруй жилээс авах сургамж болоод байна.

Тэгэхээр яах вэ, мэдээж цаашаа өөрчлөхийн тулд энэ салбар хоорондын харьцуулалтыг хийж, илүү сайн жишээг нь авч, амжилттай хэрэгжүүлэх, болохгүй байгаа зүйлийг нь тэр дээр суралцсан бол бусад дээр нь нөгөө алдаагаа давтахгүй байх эдгээр зүйлийг хийж үзсэн гэж бодож байна. Тэгэхдээ энэ харьцуулалтыг симуляци байдлаар хийсэн үү, тэгээд энэ дээр янз бүрийн ийм сценариудыг үзэхэд хэр зэрэг хурдтай хийж байж бид жишээлэхэд эрчим хүчний хямралаас гарахаар байна вэ? Тэгээд энэ дээр ЗГ-ын бэлтгэл ажлын хүрээнд хийсэн судалгааг тодруулж асуумаар байна. Баярлалаа.

С.Бямбацогт: Энхбаяр сайд, дараа нь Доржханд сайд хариулъя.

Ж.Энхбаяр: 35 жил хангалттай хугацаа, яг төр бариад үнийн хатуу бодлого бариад байсан салбарууд хөгжлийнхөө шаардлагаас хоцорчхож байгаа юм. Үүн дотор эрчим хүчний салбар тэргүүлж байгаа юм. Салбарын нүүрс олборлолт үнийн бодлого, зохицуулалттай, нүүрс тээвэр зохицуулалттай, цахилгаан үйлдвэрлэл зохицуулалттай, цахилгаан түгээх, дамжуулах хэрэглээ зохицуулалттай, хатуу үнэ барьсан. Үр дүнд эрчим хүчний салбар хөгжлийн шаардлагаас хоцорсон. Өөрөө өөртөө хөгжлийн хөрөнгө оруулалт хийж чадахаа больсон. Үндсэндээ тэр 30, 40 жилийн өмнөх, энэ чинь барьсандаа бол 50, 60 жилийн өмнөх технологитойгоо зогсчхож байгаа юм, үлдчихэж байна гэсэн үг. Тасралтгүй хөрөнгө оруулалтыг шинэчлэх ёстой тэр бололцоогоо алдчихсан буюу шинэчлэл улам үнэтэй болж хувирч байна. Иймд нэг номерт эрчим хүчний салбарын реформ зайлшгүй, үнэ тарифын чөлөөлөлтийг хийх, энд хөрөнгө оруулалтыг татах, өрсөлдөөний бололцоог нээх нь ЗГ-ын тэргүүлэх, ер нь Монгол Улсын тэргүүлэх бодлого эрчим хүч, тог цахилгаан, дулааны асуудал.

Бусад салбарын хөгжил нь өөрөө эрчим хүчнээсээ болоод одоо хязгаарлагдаад эхэллээ. Байгаа хүчин чадлаа үндсэнд нь бүрэн ашиглаад бид дуусаж байна. Ингээд дараа нь нэг сонин жишээ төмөр зам, мөн адил тарифын хатуу зохицуулалт, байнгын алдагдал, ачаандаа үүрсэнтэй, нийгмийн зардлыг ачаан дээрээ үүрч явсантай холбоотойгоор төмөр зам маань өнөөдөр 20 дугаар зууны кино зураг авалтын павильон болж хувирсан, дундаж 1 км цагийн хурд 30 гаруй километр цагийн хурдтай л явж байна. Асар их ачаа тээвэр, боломжийн алдагдалд орж эхэлж байгаа юм. Өөрөө энэ нь хөгжлийнхөө нөлөөлөлд их өндөр гараад эхэлж байна. Зөвхөн төмөр замаар тээх ёстой экспортын ачааныхаа 30 гаруй хувийг л тээж байна шүү дээ. 70 гаруй хувийн ачаа тээвэр байгаад байдаг, бид гаргаж чаддаггүй. Ийм мэтчилэн энэ салбаруудын, эдийн засгийн суурь салбаруудыг, суурь хөгжлийн салбаруудаа бид чөлөөлөх, либералчлах, зах зээлийн харьцаанд оруулах нь зайлшгүй.

Хэрвээ эрчим хүчний салбарыг бүрэн чөлөөлж чадвал 3 жилийн дотор Монгол Улс эрчим хүчнийхээ дотоод хэрэглээг 100 хувь хангаж чадна гэсэн ийм тооцоотой, төлөвлөгөөтэй ажиллаж байгаа. Энд Их Хурлын улс төрийн дэмжлэг хэрэгтэй. Нөгөө л үнэ, "ард түмэндээ ахиад хайртай, хямдхан цахилгаантай, дулаантай, халуун устай байх ёстой" гэдэг энэ шаардлагууд өөрөө энэ хөгжил, хөрөнгө оруулалт өөрөө өөрийгөө аваад явах, өөрөө өөртөө хөрөнгө оруулалт хийх

энэ салбарын хөгжлийг боомилж байгаа асуудал байгаа. Тэгээд энэ асуудлыг оруулж ирнэ, энэ асуудал тодорхой, юу хийх нь бүрэн ТЭЗҮ, шаардлагатай хөрөнгө оруулалт бүх юм тодорхой болсон, энийг оруулна гэж бодож байна. Баярлалаа.

С.Бямбацогт: Доржханд сайд нэмж хариулъя.

Т.Доржханд: Энэ Ундраа гишүүнтэй 100 хувь санал нэг байгаа. Ер нь 2020 он хүртэл бараг л 100 хувь ганц эрчим хүчний салбар л төрөөс хамааралтай байсан шүү дээ. Яг өнөөдрийн байдлаар тоо нь эрчим хүчний төрийн оролцоо, төр үйлдвэрлэдэг нь 70 хувь, уул уурхай 40 хувь, тээвэр 30 хувьтай байна гэсэн яг ийм тоо байна. Тэгээд энэ салбарыг хувийн хэвшил рүү одоо бүр зоригтойгоор шилжүүлэе. Төсөвт мөнгө байхгүй, тэгээд гаднын зээл тусламж ийшээгээ орохоо больсон, тэгээд ганцхан боломж нь хувийн хэвшил байгаа. Тийм болохоор бид нээлттэй, ил тодоор нөгөө эрчим хүч худалдан авах гэрээг ингээд зарлаад явж байгаа шүү дээ, та мэдээлэл авсан уу, үгүй юу. Сая 5 байршил дээр 210 МВт дээр л гэхэд 140 компани оролцохоо илэрхийлж байгаа. Өөрөөр хэлбэл 35 жил ингээд дарчихсан байсан энэ төрийн өмчийн үүцийг нь өнөөдөр задлаад, 1990 онд хийж байсан тэр олон нийтэд, хувийн хэвшилд шилжүүлэх ажлыг.../минут дуусав/

С.Бямбацогт: Батбаярын Жаргалан гишүүн асуултаа асууя.

Б.Жаргалан: Өнөөдөр бид Монгол Улсын эдийн засгийн хөгжлийн үндэс суурь, суурь тогтолцоо, суурь сэтгэлгээний асуудлыг хэлэлцэж байгаа учраас арай жаахан холоос эхэлж гэж бодож байна. Монголчууд бид эрх чөлөөнд хайртай ард түмэн. Тийм ч учраас одоогоос 36 жилийн өмнө ардчилсан хувьсгалын үзэл санааг Монголын ард түмэн талархан дэмжиж хүлээж авсан. Тийм ч учраас ардчилсан хувьсгал энх тайвны замаар хийгдсэн, шилжилт хийгдсэн. Улс төрийн тогтолцоогоо, эдийн засгийн тогтолцоогоо бид өөрчилж чадсан. Тэгээд ардчилсан хувьсгалын мөрөөдөл юу байсан бэ гэхээр Монгол хүн бүрд улс төрийн эрх чөлөөг нь олгох, Монгол хүн бүр эдийн засгийн эрх чөлөөтэй байх ийм л мөрөөдөл байсан шүү дээ. Тийм ч учраас Монголчууд дэмжсэн. Тэгээд хүн бүр дор бүрнээ шударгаар хөдөлмөрлөж чадвал сайн сайхан амьдралд хүрнэ гэсэн тийм итгэл үнэмшил, тийм мөрөөдлөөр бид энэ ардчилсан хувьсгалын замналаар эхэлсэн энэ сүүлийн хэдэн жилийн өнгөрөөж байна.

Харамсалтай нь бид энэ бүхнээсээ сүүлийн хэдэн жилд маш их ухарчаад байна. Уг нь Монгол Улс Швейцар шиг хөгжинө, Азийн бар улс болно гэсэн тийм мөрөөдөл байсан нь талаар болчихоод байна шүү дээ. Тэгээд өнөөдрийн бидний ярьж байгаа зүйл ерөөсөө л энэ авлига, хээл хахууль, хулгай зэлгий. Бид ирээдүйдээ сайхан, гоё сайхан амьдарна, дор бүрнээ шинэ санал, санаачилга гаргаад гоё бизнес эрхлээд дэлхийтэй өрсөлдөнө энэ тэр гэж огт ярихаа байчихсан. Тэгээд бид ийм улс төрийн эрх чөлөөгүй, тэгээд дээр нь эдийн засгийн эрх чөлөөгүй ийм л ард түмэн болчихоод байна шүү дээ.

Тэгээд өнөөдөр УИХ дээр бид ийм сайхан хууль оруулаад ирлээ, төр ерөөсөө хувийн хэвшилтэй өрсөлдөхгүй гэдэг зарчмыг бид хуульчлах гэж байна гэж ярих нь нэг бодлын аягүй харамсалтай санагдаад байгаа юм. Тэгэхдээ тэгж ярихаас өөр аргагүй байдалд орчихлоо. Яагаад гэвэл зах зээл гэж ерөөсөө байхаа байчихлаа. МАН-ын зарим дарга нар "чөлөөт зах зээл байхгүй ээ" гэж зарлаад байсан, тэр нь одоо үнэн болчихлоо шүү дээ. Монголын эдийн засаг дотоодын нийт бүтээгдэхүүн /ДНБ/-ий 40 хувь нь төсөв, дахиад 20 гаруй хувь нь ТӨК л болчихсон. Улс төрөөс

өөр газарт ерөөсөө өрсөлдөөн байхгүй, хэн илүү том дарга болох вэ гэдэг өрсөлдөөн л явдаг боллоо. Тэгээд ийм нөхцөлд л бид энэ хуулийг авч хэлэлцэж байна. Тэгээд аргаа бараад ийм хуулийн төсөл бас АН-ын зүгээс ч гэсэндээ Эдийн засгийн эрх чөлөөний тухай хууль гээд илэрхий ардчилсан Үндсэн хуульд тодорхой заачихсан зүйлүүдээ бид хуульчлахаас өөр аргагүй байдалд хүрчхээд байна шүү дээ.

Тэгээд ийм тодорхой 2 асуулт байна. ЗГ-аас оруулж ирж байгаа Бизнесийн эрх чөлөөний тухай хуулийг дагалдуулаад 2 том хуулийн төсөл орж ирж байна гэж ойлгож байгаа, Зөвшөөрлийн тухай хууль мөн Хөрөнгө оруулалтын тухай хууль. Тэгээд энэ Зөвшөөрлийн тухай хуулийг дагалдаад бараг 90 гаруй хуульд өөрчлөлт орж байна гэж байгаа юм л даа. Өнгөрсөн хугацаанд бид харин 90 гаруй хуулиар ингээд баахан тусгай зөвшөөрлүүд бий болгоод, тэгээд ийм төрийн хүнд суртлыг нэмчихсэн байж байна шүү дээ. Тэгээд энэ Зөвшөөрлийн тухай хуулийг анх оруулж ирээд, УИХ-ын гишүүн Энхтүвшин ахлаад нэг ажлын хэсэг ажилласан, бас ийм хууль хоорондын нийцэл, алдаа дутагдал, хийдлүүд байна гэсэн зүйл яригдаад, тэгээд ЗГ буцаан татаж авсан. Ажлын хэсгээс гарсан дүгнэлтүүдтэй холбоотойгоор хэр өөрчлөлт, шинэчлэлт хийгдсэн бэ? ЗГ буцааж сая дагалдуулж оруулж ирэхдээ энэ асуудал дээр ямар арга хэмжээ авсан бэ гэсэн тодорхой асуулт байна?

Хөрөнгө оруулалтын тухай хууль ингээд шинээр дагалдаад ороод ирж байна, үүнд нөгөө тогтворжуулалтын гэрчилгээ гэдэг асуудал орж ирж байна. Уг нь бид энэ Бизнесийн эрх чөлөөний хууль, Эдийн засгийн эрх чөлөөний тухай хууль гэж батлах гээд байгаа нь цаашид төр ерөөсөө энэ эдийн засагт оролцохгүй, тэгэхээр энэ тогтворжуулалт шаардлагагүй байх нөхцөлийг бүрдүүлэх гээд.../минут дуусав/

С.Бямбацогт: Энхбаяр сайд хариулъя.

Ж.Энхбаяр: Тогтворжуулалт шаардлагатай, тогтворжуулалтын гэрээ нь хөрөнгө оруулагчийн эрх ашгийг, хөрөнгийг нь хамгаалж байгаа л зүйл шүү дээ, төрийн эрх ашиг биш байхгүй юу. Хөрөнгө оруулагч өөрөө хүсдэг, "яг энэ өнөөдрийн байгаа танай хууль, эрх зүйн орчинд би хөрөнгө оруулах гэж байна, миний хөрөнгө хамгаалалттай юу, хууль өөрчлөгдөхгүй юу" гэж. Энэ хүн чинь тэр хуулийн орчноо дүгнээд, эрсдэлээ дүгнээд хөрөнгө оруулж байна шүү дээ. Тэгэхээр яг тэр орчныг нь л баталгаажуулна. Хууль сайжирвал сайжралтыг нь аваад явна, хууль муудвал тэр хүнийг хамгаална, тэгэхээр энэ байх нь зөв байх Жаргалан гишүүн.

2 дугаарт, сүүлийн нэг Ардын намын 10 жил их болохоо байчихсан, муудсан юм шиг ингээд л нэг хаанаас тийм ойлголт аваад яриад байгаа юм, яриад л байдаг болчихоод л байгаа юм. Би сүүлийн 10 жил юу болсон бэ. 10 жилийн хугацаанд Монгол Улсын эдийн засаг 4 дахин өслөө. Нэг хүнд ноогдох дотоодын нийт бүтээгдэхүүн 2 дахин өслөө. Монгол Улс дунджаас дээш орлоготой орон боллоо, Монгол Улсын эдийн засаг 90 их наяд төгрөгт хүрэв. Би та нарт 2008-аас 2012 оныг ярьж өгье. Монгол Улсын эдийн засгийн өсөлт 17 хувьд хүрч дэлхийд тэргүүлж эхлэн, Монгол Улс дараагийн Катар, Кувейт болно. Жилдээ 5 тэрбум доллар ирдэг, манай Буянт-Ухаа дээр дэлхийн бүх топ хөрөнгө оруулалтын сангуудын удирдлагууд ирж уулздаг, Монгол Улсад хөрөнгө оруулалт буцалж байсан.

Эдийн засаг дараа нь 2012 онд улс төр яривал АН засгийн эрхэнд гарсан эдийн засгийн өсөлт 17 дахин унасан, валютын нөөц тэг болсон, ОУВС-ийн хөтөлбөрт хамрагдсан, санхүүгийн хувьд дампуурчихсан гэсэн үг шүү дээ. Ингээд

2016 онд Ардын нам хүлээж аваад 4 дахин өсгөж, нэг хүнд ногдох орлогоо 2 дахин өсгөөд, эдийн засгаа тасралтгүй, хэдийгээр ковидын хүнд үеийн хямралыг үзсэн ч гэсэн ингээд тогтворжуулаад гарч байна. Юм босгох хэцүү, унагаах амархан байдгийн л жишээ. Яагаад гэвэл тэр үеийн гэрч болоод энд сууж байсан улсууд одоо 3, 4-хөн хүн үлдсэн байна. Тэнд үүссэн эрх зүй, хөрөнгө оруулалтын муудсан орчинтой холбоотойгоор бид өнөөдөр энэ алдааг засах гээд л явж байна шүү дээ. Ингээд улс төр яривал зөндөө л юм ярина, хатуу ярьж чадна.

Би та залуучуудад уриалаад байгаа, АН-ын залуучуудад, шинэ санаа гаргаад энэ орчноо хамтраад сайжруулаач, энэ та нарын л ирээдүй шүү дээ. Засаг оруулж ирлээ, өөр юу хэрэгтэй юм бэ. Нэг л ерөнхийлсөн улс төрийн өнгө аяс зохихгүй байна шүү дээ. Гоё idea санаа гарга, энийг ингээд өөрчилье, ингээд хамтраад ажиллая гэж ярилцаач дээ. Арай өөр л өнцөг байхыг би та нараас хүсээд байдаг. Тэгээд та нар маань нэг ийм дэмий улс төрийн юм яриад байвал улс төр ярина шүү дээ, Жаргалан гишүүнээ би таны аавтай хамт энэ Их Хуралд.../минут дуусав/

С.Бямбацогт: Батбаярын Жаргалан гишүүн тодруулж асууя.

Б.Жаргалан: Энэ МАН-ын дарга нар нэг л өөр нийгэмд, нэг л өөр эдийн засагт амьдраад байх шиг байх юм. Эдийн засаг 4 дахин өссөн гээд л байгаа, сүүлийн 10 жилд ийм, тийм болсон гээд л байгаа. Тэгээд ард түмний амьдрал хэд дахин сайжирчхаад байгаа юм бэ, одоо ийм явцгүй попрол явахаа байлаа шүү дээ, Энхбаяр сайдаа. Хүмүүсийн амьдрал ахуйд бодитоор харагдаж байна шүү дээ. Сүүлийн 10 хэдэн жилд бид хэр их хэмжээний нүүрс гаргав, хэр их хэмжээний зэс гаргав, энэ чинь Монголын л байгалийн баялаг шүү дээ. Гэхдээ тэр бүх зүйлийг та бүхэн зүгээр үрэн таран хийчихлээ шүү дээ. Иргэдийн амьдрал сайжирсан юм уу, энэ агаарын бохирдол чинь буурсан юм уу, ядуурал буурсан юм уу. Тэгээд энэ чинь бид үр хүүхдүүдийнхээ ирээдүйн талаар ярьж байна шүү дээ. Тэгээд ингээд ийм явцгүй попрол урдаас яриад, биднийг загнаад байх юм. Та бүхэн л сайд, дарга нар хийлээ шүү дээ. Хэн сайд, дарга хийсэн юм бэ? Тэгээд бид хэд хийх ажлаа хийгээд, энэ Эдийн засгийн эрх чөлөөний тухай хуулиа санаачлаад ингээд.../минут дуусав/

С.Бямбацогт: Энхбаяр сайд хариулъя.

Ж.Энхбаяр: Юмыг ус, тосоор нь ялгаж сур. Өнгөрсөн хугацаанд Монголчууд бид нийтээрээ бүгд хичээж, хөдөлмөрлөлөө, улс орноо нэг өдий зэрэгт гаргаад ирлээ. Нэг хүнд ногдох орлого чинь 400 тэрбум доллар.../үг тасрав/

С.Бямбацогт: Байж байгаарай, би танилцуулна шүү.

Ж.Энхбаяр: 400 доллар хүрдэггүй байлаа шүү дээ. Өнөөдөр 7300 доллар хүрчхээд, бид дундаж хөгжилтэй орны асуудал ярьж байна шүү дээ. Улаанбаатар, Дархан, Лүнгээс илүү засмал замгүй байсан, өнөөдөр 21 аймгаа холбогцоод, 130-аад сум засмал замтай холбогдоод байна. Монгол Улсын бүх сумыг эрчим хүчинд холбоод дууслаа. Үгүй ээ, саяхан хүртэл бид өдөртөө 2-оос 3 цаг ирдэг дизелийн тогтой л амьдарч байсан ард түмэн шүү дээ. Нэгдсэн системээ угсраад дууслаа. Хүний дундаж нас 10 гаруй насаар нэмэгдлээ. Энэний цаана чинь амьдралын чанар, эдийн засгийн өсөлт, нийгмийн боловсрол, маш олон зүйлийн өсөлт гарлаа шүү дээ. Өнөөдөр малчин хүн хотноосоо дэлхий ертөнцтэйгөө холбогдож байна.

С.Бямбацогт: Одоо яах вэ. Тэгэхээр манай гишүүд эсвэл нэг талдаа хэтэрхий муу гээд, эсвэл нөгөө талдаа хэтэрхий сайн гээд нөгөө гал, ус шиг харшилдмааргүй байна. Яг болж байгаа нь, болж байгаа нь энэ байна, ингээд болгоод явъя, болохгүй байгаа нь энэ байна, болохгүй байгаа асуудлаа ингээд цэгцлээд, сайжруулаад явъя гээд харилцан ярилцаад, ойлголцоод ус, сүү мэт сүлэлдээд улс орныхоо эрх ашгийн төлөө л ажилламаар байна шүү. Хэт битгий улс төржөөрэй. Хаана хаанаа ер нь улс төржиж байгаа, хэт их улс төржихөө л больцгооё хэдүүлээ. Ойлголцох, зөвшилцөх, улс орныхоо эрх ашгийн төлөө хамтарч ажиллахыг урьдал болгоё.

Зочин танилцуулъя. УИХ-ын гишүүн Бадамдоржийн Пунсалмаагийн урилгаар Баянгол дүүргийн иргэд УИХ-ын үйл ажиллагаа, Төрийн ордонтой танилцаж байна. Төрийн ордонтой танилцаж байгаа иргэд та бүхэндээ УИХ-ынхаа нийт гишүүдийн нэрийн өмнөөс эрүүл энх, аз жаргал, сайн сайхан бүхнийг, эв нэгдлийг хүсэн ерөөе. Хөөрхий минь, хааяа нэг мэтгэлцэх юм байна, байна, зөв ойлгоорой гишүүдийг иргэдээ. Гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа.

Одоо хэлэлцэж байгаа асуудал, хуулийн төслийн үзэл баримтлал болон Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан үг хэлэх гишүүд нэрсээ өгнө үү. Сүхбаатарын Эрдэнэболд гишүүн асуултаа асууя, үгээ хэлье. Уучлаарай, үг хэлэх гишүүд 14 цаг хүртэл чуулганаа үдийн цайгаа завсарлчихъя. Тэгээд 14 цагаас орж ирээд үгээ хэлчихье, тэгэх үү? Үдийн цайны завсарлага, 14 цагаас хуралдана. Санал хураалтыг 17 цагаас нэгтгэж явуулна. Санал хураалтыг 17 цагаас. Үдийн цайны завсарлага. Индэр дээрээс үг хэлнэ шүү дээ.

*2026 оны 6 дугаар сарын 11, Пүрэв гараг,
Төрийн ордон “Их хуралдай” танхим
14 цаг 02 минут.*

ҮДЭЭС ХОЙШИХ НЭГДСЭН ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ

С.Бямбацогт: Эрдэнэболд гишүүн. Үдээс хойших чуулганы нэгдсэн хуралдаанаа эхлүүлье. Гишүүд үг хэлнэ. Аваад ирэх үү, тэгье. Отгоны Саранчулуун гишүүн үгээ хэлье. Ажлын хэсэг, ажлын хэсгийг дуудъя, оруулъя. Бизнесийн эрх чөлөөний хууль хэлэлцэж байгаа. Эдийн засгийн хөгжлийн сайд Энхбаяр, Шадар сайд Доржханд, ажлын хэсгийн бусад гишүүд. Отгоны Саранчулуун гишүүн үгээ хэлье.

О.Саранчулуун: Сайн байцгаана уу. Би та бүхэнд нэг бизнесийн эрх чөлөөний хуулийн талаар бид өнөөдөр хэлэлцэж байна. Энэ нь юу гэсэн үг вэ гэхээр халамжаас хөдөлмөрт гэдэг асуудал, хөдөлмөрөөс бизнес рүү шилжих энэ либерал эдийн засгийн агуулгыг бас бид ярьж байгаа. Би өнөөдөр та бүхэнд ийм 3 зүйлийг танилцуулахаар ярьсан, энэ нь бол шүрээр хийсэн жаазтай ийм гар хийцийн ийм зүйл байгаа. Энийг хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд хийсэн байгаа гэртээ, энэ бол ийм хөгжлийн бэрхшээлтэй хүүхдээ гэртээ хардаг ээжүүд энийг нийлж жижигхэн ийм үйлдвэр байгуулаад ингээд хийсэн байгаа. Энэ туулай мөн адилхан хөгжлийн бэрхшээлтэй нэг хүү, ээж нь энэ дээлийг нь хийгээд, нэг ээж нь энэ нүдийг нь наадаг ч юм уу ингээд хийсэн байгаа. Тэгэхээр миний гарт барьж байгаа энэ зүйлүүд бол бизнес эрхлэгч мөн.

Өнөөдөр хэлэлцэхдээ бид ингээд 70 мянган ААН-ийн тухай асуудлыг ярьсан, би тэгвэл тэр 70 мянган ААН-ийн тоонд орсон, ороогүйгээр мэдэхгүй байна. Тэгэхдээ би мянга хүрэхгүй хүний тухай асуудлыг ярих гээд байгаа юм, бизнес эрхлэгчдийн асуудлыг ярьж байгаа юм. Монгол Улсад 92 мянга гаруй хөгжлийн бэрхшээлтэй хөдөлмөрийн насны иргэд байдаг. Тэднээс бол яг үнэндээ ажил хийж байгаа буюу бизнес хийдэг хүн нь 13 хувь гэдэг ийм тоо байдаг, алдаатай янз бүрийн тоотой. Энэ яагаад ийм тоо нь бага байгаа вэ гэхээр эдгээр хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг, жишээлбэл энэ унагыг хийсэн ээжийг, энэ хамтдаа ажлын байр бий болгоод энэ хамтрал, энэ хүмүүсийг бид өнөөдөр нийгмийн хамгаалал хүртэгч гэж хараад байгаа болохоос биж бизнес эрхэлж байгаа, бие даасан үнэ цэн бүтээгч, бичил бизнес эрхлэгч гэж харахгүй байгаад л асуудал байгаа юм.

Өнөөдрийн энэ Бизнесийн эрх чөлөөний бараг зуугаад дагалдах хуультай энэ хууль дээр би 4 зүйлийг анхаарч, 4 зүйл, заалтыг оруулаач гэдэг асуудлыг хандаж хэлэхийг хүслээ. 1 дүгээрт нь, бизнес эрхлэх эрх чөлөө ба хандлагын өөрчлөлт байгаа. Намайг өнөөдөр Их Хурлын гишүүн гэж хүмүүс сонсож байгаа шиг энэ туулайг хийсэн ээжүүдийг, мөн энэ морийг хийсэн ээжүүдийг, мөн ээж, аавтайгаа нийлээд ч хамаагүй энэ шүрэн хуурлыг хийсэн тэр оюутнуудыг өнөөдөр бид нар бизнес эрхлэгч гэдэг агуулгаар нь ойлгох хэрэгтэй. Онолын хувьд бол Милтон Фридман гэж хүний тодорхойлолтоор бизнесийн эрх чөлөө гэдэг бол хувь хүн өөрийн нөөцөд түшиглэж баялаг бүтээх эрх юм гэсэн байдаг юм байна лээ.

Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс гэрээсээ ажиллах боломжтой байдаг. Тэд нар саад бэрхшээлийг даваад арай ахисан түвшинд бизнесээ хийх гэхээр өнөөдөр манайд нөхцөл байдал бүрдээгүй байгаа. Тэгэхээр 1 дүгээр асуудал нь бизнес эрхлэгч гэдэг энэ ойлголт дотроо бизнесийн эрх чөлөө гэдэг энэ агуулга дээрээ мөн тэр хэрэглээд байгаа индекс дээрээ энэ хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс болон энэ жижиг бүлгийн асуудлуудыг анхаарч оруулах хэрэгтэй байна. Нэр томьёоны болоод судалгааны хувьд. Статистикийн хорооноос гаргасан тоон мэдээллүүдээр хөгжлийн бэрхшээлтэй бизнес эрхлэгчийн мэдээллийг би олсонгүй. Тэгэхээр энэ дээр эхлээд бид хандлагаа өөрчлөх хэрэгтэй.

2 дугаарт нь, санхүүжилтийн тогтолцоог Төрийн сангаас банк руу шилжүүлэх хэрэгтэй байгаа. Өнөөдөр Хөдөлмөр эрхлэлтийн дэмжих сангийн зээл өнөөдөр хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст бизнес эрхлэхэд нь зээл олгож байгаа. Энийг бид банк санхүүгийн мэргэжлийн салбарт нь аваачиж байршуулах хэрэгтэй байгаад байна. Хөгжлийн бэрхшээлтэй хүн бизнес эрхлэхээр хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас байгаад байдаг, дээшилдэг ч үгүй. Тэр дундаа бусад ААН бизнес эрхлэхээрээ банкнаас зээл авдаг ийм тогтолцоо байгаад байна.

3 дугаарт нь, банк өөрөө эсвэл ААН өөрөө энэ бизнесийг дэмжсэнийхээ төлөө хөнгөлөлт авдаг тогтолцоог бий болгомоор байна. Бизнесийг дэмжих хөшүүрэг хэрэгтэй.

Хамгийн сүүлд нь хөгжлийн бэрхшээлтэй хүн бизнес эрхлэх энэ эко орчин хэрэгтэй байна. Төрийн худалдан авалтын асуудлыг дэмжих хэрэгтэй байгаа. Хэрвээ ингэж чадах юм бол бид жинхэнэ утгаараа бизнесийн эрх чөлөө гэдэг агуулгаа нийт хүн амынхаа ямар ч бүлгийг орхихгүйгээр дэмжсэн ийм агуулгатай болох боломжтой болох юм. Баярлалаа.

С.Бямбацогт: Баярлалаа. Сүхбаатарын Эрдэнэболд гишүүн үгээ хэлье.

С.Эрдэнэболд: Бизнесийн эрх чөлөө, бизнес хийх эрх чөлөө, баялаг бүтээх эрх чөлөө эх орондоо нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүн гаргаад ажлын байрыг бий болгох эрх чөлөө энэ бүхэн бол манай чөлөөт нийгмийн гол тулгуур зарчим. Монгол Улсад авлигатай тэмцэхэд хамгийн гол асуудал бол энэ бизнес дэх төрийн дарамт, бизнес хийх эрх чөлөөг нь барьцаалах байдлаар төр өөрөө авлигын субъект болдог байдлыг таслан зогсоох зайлшгүй шаардлагатай. Би энэ дээр 2, 3 санааг хэлье. Хуулийн төслийг үзэл баримтлалын хувьд дэмжиж байгаа ч гэсэн хуулийн төсөл дээр ороогүй нэг зүйл, цаашид нь тодотгох 2 зүйлийн тухай байр сууриа хэлмээр байна.

Нэг бизнес хийснийхээ төлөө гэмт хэрэгтэн болдог энэ нөхцөл байдлыг таслан зогсоомор байгаа юм. decriminalization буюу эрүүгүйжүүлэх энэ зохицуулалт энэ Бизнесийн эрх чөлөөний хуультай уялдаж, Эрүүгийн хуульд орох ёстой гэж үзэж байгаа. Учир нь бизнес хийж байгаа хүмүүс хамгийн эх оронч хүмүүс эрсдэл гаргадаг, өөрийнхөө мөнгийг зориулдаг, нэмээд зээл авдаг амьтны хэл ам болдог. Ингээд бизнес хийнэ.

Монгол Улсад хийсэн судалгаагаар манай улсын иргэдийн бизнесийн идэвхжилд бүр 80 хувь хүртэлх хувь байдаг. Өөрөөр хэлбэл танд хэрвээ хөнгөлөлттэй зээл өгөөд тодорхой хэмжээгээр төр яг энэ салбар дээр тогтвортой бодлогыг баримтлах юм бол та бизнес хийх үү гэсэн асуултад нийт иргэдийн ялангуяа ажиллах хүчний идэвхтэй иргэдийн дунд хийсэн судалгаагаар 80 хүртэлх хувь нь би бизнес хиймээр байна гэдэг. Япон улс, Япон ч гэдэг юм уу бусад улсуудад энэ идэвхжил 20 хэдэн хувиас дээшээ хэтэрдэггүй. Энэ юу гэж байгаа юм бэ гэхээр иргэдийн дунд бизнесийн эрх чөлөөгөө эдлэх асар өндөр эрмэлзэл байдаг. Яг энэ ажиллах хүчний насны залуучууд эх орондоо бизнес хийх гэхээр олон төрлийн дарамт шахалттай байдаг учраас хүний нутаг гүний хошуунд очиж хар бор ч болтугай ажил хийдэг, зарим нь харладаг, хууль бусаар оршин суугч гэдэг нэртэй явдаг.

Тэгэхээр энэ бол яаж байна гэхээр Монгол Улсад энэ эдийн засгийн татах хүч, бүтээгч татах хүчийг бий болгохоор Бизнесийн эрх чөлөөний тухай хуулиа маш тийм концепцын түвшинд ил тод нээлттэй байхаас гадна хүртээмжтэйгээр хүмүүсээ яаж бизнес эрхлэгч болгох вэ гэдэг дээр анхаарах зайлшгүй шаардлагатай. Тийм учраас ялангуяа ковидын үед зээл аваад бизнес хийж байгаа хүмүүс зээлээ төлж чадахгүй, сүүлдээ яасан бэ гэхээр бусдыг хууран мэхэлсэн, бусдыг залилсан байдлаар зүйл ангиар одоо шоронд олон хүн хоригдож байгаа. Тэгээд бизнес хийх гээд өр шир тавиад хариуцлага хүлээгээд, эрсдэл үүрээд явсныхаа төлөө гэмт хэрэгтэн болчихоод байгаа. Өнөөдөр Монголд ч гэсэн томоохон бизнесменүүдийг улс төрийн зорилгоор овоо хараандаа оруулаад шантаажилдаг, улс төрийн шантааж хийдэг. Зарим нь ч тодорхой хэмжээнд мэдээлэлд ойрхон байсан эрх мэдэлтэй байсныхаа хүчинд бизнесийн амжилттай яваа харагддаг байгаа. Гэтэл яг бодит байдал дээрээ энэ хоморгод нь шударгаар бизнес эрхэлж байгаа хүмүүс маш их өртөөд байдаг. Тийм учраас бизнесийн энэ эрх чөлөөний хууль дээр бизнесийн харилцааг эрүүгүйжүүлэх гэсэн энэ зүйлийг маш сайн тодорхой нэмж оруулбал өндөр ач холбогдолтой гэж үзэж байгаа.

Нөгөө талдаа ялангуяа өнөөдөр хөдөөд ажлын байр байхгүй байна. Улс төрчид улс төрийн намууд сонгуулийн үеэр гоё амлалт өгдөг, бодит байдал дээрээ ажлын байр байхгүй байна. Энэ асуудлыг бид шийдвэрлэхийн тулд тэр бүсчилсэн

хөгжил гэдэг зүйл маань таг боллоо. Энийгээ тэр ажлын байртай уялдуулж тухайн бүс нутгийн тухайн эдийн засгийн өрсөлдөх чадвартай нь уялдуулсан байдлаар энэ хуулийг бас зохицуулалт болгож гаргаж ирэх хэрэгтэй болов уу гэж бодож байна. Ингээд үзэл баримтлалын хувьд дэмжиж байна. Цаашдаа тодорхой зарчмын тодорхой саналуудыг.../минут дуусав/

С.Бямбацогт: Баярлалаа. Дашцэрэнгийн Энхтүвшин гишүүн.

Д.Энхтүвшин: Өнөөдрийн тулгамдаж байгаа асуудлуудын нэг гол нь бол улс төр үнэтэй байгаа, улс төр үнэтэй байгаа учраас дагаад төсөв том байгаа, ТӨК-уд том болохыг хүсэж байгаа. Энийг тойрч амьдардаг, энийг тойрч зардал, хөрөнгө оруулалтаа нөхдөг ийм харилцаа байгаа учраас энэ болохгүй байгаа. Тэгэхээр эдийн засаг дахь төрийн оролцоо энэ хэмжээгээр томорч байгаа. Тэгэхээр энэ өнөөдрийн хэлэлцэж байгаа хуулийн төсөл бол энэний эсрэг буюу эдийн засгийн энэ эрх чөлөөг илүү тэлж өгөх гэсэн Үндсэн хуулийн 16.4-д байгаа АН-ын бас өргөн барьсан Эдийн засгийн эрх чөлөөний тухай хуулийн үзэл баримтлал дээр байгаа энэ аж ахуй эрхлэх эрхийг илүү нээж өгөх энэ харилцаатай холбоотой асуудал байгаа. Тэгээд энэ хуулийн төслүүд, өргөн барьсан хуулийн төслүүд дээр онцолмоор хэдэн зүйл, заалтуудыг хэлмээр байна.

Өмнө аж ахуй эрхлэхийн тулд татвар, нийгмийн даатгалын өртэй байх өргүй байх ийм шаардлага тавьдаг байсныг энийг шинэ хуулийн төслөөр болиулж байна. Өөрөөр хэлбэл ААН шинээр бизнес үйл ажиллагаа эрхлэхийн тулд энэ татварын өр гэдэг бол заримдаа илүү авлагатай өглөгтэй байдаг, татварын байгууллагадаа тохирчихсон байдаг. Тэгэхээр энэ мэтчилнээр гээд ийм харилцаа байхад заавал өргүй байх гэсэн энэ шаардлага байсан, энийг больж байна. Тийм энэ бол олзуурхуштай зүйл гэж бодож байна.

Дээр нь энэ зөвшөөрөл дээр холбогдсон энэ шаардлагууд одоо хөдлөх болон үл хөдлөх хөрөнгөтэй холбоод тоног төхөөрөмжтэй холбоотой шаардлагуудыг заавал өөрийнх нь байх тухай ийм шаардлагуудыг тавьдаг байсан. Тэгээд одоо энэ шаардлагуудыг бас авч байна. Өөрөөр хэлбэл энэ зах зээл дээр бизнес эхлэх эрхлэх энэ барьер /barrier/ буюу босгыг нам болгож байгаа. Өөрөөр хэлбэл заавал хөрөнгө оруулалт ч юм уу, үл хөдлөх хөрөнгө худалдаж авахгүйгээр түрээсийн гэрээ хийгээд ч юм уу, ашиглалтын гэрээ хийгээд энэ бизнесийн үйл ажиллагаа эхлүүлэх энэ шаардлагыг нь хангах энэ бололцоо боломжуудыг нь нээж өгч байгаа юм. Энэ бол нааштай зүйл байгаа.

Дээр нь энэ хөдөлмөрийн, хүний нөөцтэй холбоотой ялангуяа энэ улирлын шинжтэй энэ нөгөө жижиг, дунд бизнесүүд, энэ хөнгөн хүнс, хүнс болон хөнгөн үйлдвэр, аялал жуулчлал, улирлын шинжтэй үйлчилгээний бизнесүүд дээр энэ гаднаас ажиллах хүчин авах төлбөрөөс чөлөөлж байгаа. Энэ бол маш дэвшилттэй. Өөрөөр хэлбэл зарим нэг ажлын байрны хувьд гаднаас, одоо энэ тогтвортой байдлаас гадна үнийн хувьд жишээлбэл хямдхан ажиллах хүчин авах бололцоо боломжууд байгаа, энийг нээж өгч байгаа бол давуу талууд байна.

Дээр нь хуульд зааснаас бусад тохиолдолд үнэ тогтоодог, эдийн засагт оролцож байгаа нэг том хэлбэр бол үнийн харилцаанд ордог төрөөс. Тэгэхээр энэ харилцааг хуулиар хязгаарлаж байгаа. Энэ бол олзуурхуштай зүйл байгаа. Тэгээд энэтэй холбоотойгоор АН-ын Цогтгэрэл дарга болон Жаргалан гишүүн нарын, Очирбат гишүүн нарын өргөн барьсан энэ хуулийн төсөл Эдийн засгийн эрх

чөлөөний тухай хууль дээр ч гэсэн яг энэ эдийн засгийн гэдэг том агуулгаар нь Үндсэн хуульд заасан энэ аж ахуй эрхлэх харилцаатай холбоотой нэлээн өргөн агуулгын хүрээнд зүйл, заалтуудыг оруулсан байгаа. Тэгээд энэ дээр ч гэсэн бас онцолмоор хэд хэдэн заалтуудаа хууль дээдлэх энэ зарчим дээр бол нийлүүлэлт хязгаарлах, үнэ тогтоох, өмчлөх эрх хамгаалах гэх мэтчилнээр ажил хэргийн нэр хүндэд халддаг байдлуудыг бас хуулиар зөвхөн тогтоож хязгаарлахаар ийм зүйл, заалтууд оруулсан байна.

Дээр нь бүтээмжийг дээшлүүлэх чиглэлээр ялангуяа энэ маргаан шийдвэрлэх процессыг сайжруулах, шүүхийн бус замаар эвлэрүүлэн зуучлах Арбитрын болон Арилжааны тухай хуулиудыг гэх мэтчилний арга хэлбэрүүд дээр энэ маргаан шийдвэрлэх процессуудыг илүү хялбар, шуурхай, шударга болгох энэ чиглэл рүү санал санаачилгууд энэ хуулийн төсөлд орсон байна. Дээр нь өрсөлдөөнтэй холбоотой, жишээлбэл банкны салбарт үйл ажиллагаа явуулдаг ААН-үүд бусад салбарт өрсөлдөхгүй байх гэсэн ийм жишээлбэл хуулийн зүйл, заалтуудыг оруулж ирсэн байна. Тэгэхээр энэ 2 хуулийн үзэл баримтлалын хувьд бол яг хувийн хэвшлийн энэ орон зай Үндсэн хуулиар олгогдсон энэ эрх аж ахуй эрхлэх энэ бололцоо боломжийг тэлж байгаа учраас нэгтгээд хэлэлцээд яваасай гэж бодож байна. Тэгээд хэрвээ нэгтгэх ажлын хэсэг байгуулагдвал ажлын хэсэгт нь орж ажиллах ийм саналтай байна. Баярлалаа.

С.Бямбацогт: Баярлалаа. Пүрэвжавын Ганзориг гишүүн үгээ хэлье.

П.Ганзориг: Энэ бизнесийн эрх чөлөөний тухай хуулийн төслийг агуулгынх нь хувьд үзэл баримтлалынх нь хувьд дэмжиж байгаа. Ялангуяа энэ уг хуулийн төслийг дагаж орж ирж байгаа Хөрөнгө оруулалтын тухай хууль, Зөвшөөрлийн тухай хууль гээд 2 чухал хуулийг томоохон өөрчлөлтүүд орж байгаа. Энэ дээр бол тухайлбал Хөрөнгө оруулалтын тухай хууль дээр хөрөнгө оруулагчдын эрхийг хамгаалах тодорхой заалтууд орсон. Нэгд энэ хөрөнгө оруулагчдын гомдол маргааныг шийдвэрлэх механизмыг нь олон улсынх нь жишиг зарчимд нийцүүлсэн. 2-т суутган татварыг бас 20 хувь байгааг 5 хувь болгож бууруулж, хөрөнгө оруулалтын сан, банк санхүүгийн байгууллагын гадаад, дотоодоос татсан эх үүсвэр зээлийн хүүгийн татварыг бас 5 хувь болгож бууруулж байгаа. Энэ маань бас цаашдаа Монгол Улсын хувьд зээлийн хүү маш өндөр байгаа энийг бууруулахад тодорхой хэмжээнд эерэг нөлөө үзүүлнэ гэж харж байна. 3-д сэргээгдэх эрчим хүч, ногоон эрчим хүч, дата төв, хиймэл оюун ухаан гээд эдгээрийн тоног төхөөрөмжийг импортын гаалийн татвараас нь чөлөөлж байгаа нь зөв чиг хандлага гэж харж байгаа.

Гэхдээ анхаарах хэд хэдэн асуудал байгааг хэлье. 1 дүгээрт, энэ хуулийг дагаж орж ирж байгаа зуугаад хуульд тодорхой заалтууд, өөрчлөлтүүд орж байгаа. Тэгээд энэ хуулийнхаа ерөнхий нэр, бизнесийн эрх чөлөө, агуулгынх нь хувьд багтаж байгаа зүйлүүдийг харах юм бол тунхгийн шинж чанартай зүйлүүд бол нэлээн их байгааг шуудхан хэлэх нь зөв байх. Тэгэхээр хуулийн төсөл нь бизнесийн эрх чөлөөг тунхаглаж байгаа хэдий ч яг эдгээрийг зөрчсөн төрийн байгууллага, эрх мэдэлтнүүдэд ямар хариуцлага хүлээлгэх вэ, төрийн байгууллагуудын буруугаас болж ААН бизнесүүдийг үндэслэлгүй хянаж, шалгаж, дарамталж, хохироосон тохиолдолд хувийн хэвшлийн хохирлыг хэрхэн барагдуулах юм зэрэг бизнес эрхлэгчийнхээ эрхийг яаж хангаж байгаа юм механизм тал нь нарийн тодорхой заагаагүй байгааг анхаарах хэрэгтэй байна.

2-т төрийн оролцоог багасгана гээд заачхаж байгаа. Тэгээд энэ тодорхой хэмжүүрүүдээр тавихгүй бол ерөнхий байдлаар хуулиар заагаагүй хориглосон зүйлүүдээс бусдаар бол төр орохгүй, чөлөөтэй бизнесээ хийж болно. Тусгай зөвшөөрөл элдэв долоон зөвшөөрлийг авахад дахин авах, давтан авах асуудлуудыг шийдвэрлэж байгаа гэж байгаа боловч энэ дээр бол асуудлууд байгаа. Жишээлбэл 2024 онд бизнесүүдийн 22 мянган дансыг хаасан засгаас гэсэн үг, татварын газар төсвөө бүрдүүлэхийн тулд. 22 мянган данс хаана гэдэг чинь дунджаар нэг ААН 10 ажилтантай гэж бодоход 220 мянган ажлын байрыг эрсдэлд оруулж байгаа. Тэгэхээр төр засаг шинээр ажлын байр бий болгох боломжийг дэмждэггүй юм гэхэд ядаж энэ ажлын байрыг тогтвортой байх, ААН дампуурчихгүй байх тал дээр онцгой анхаарах ёстой гэх мэтчилэн иймэрхүү гол асуудлуудыг анхаарахгүй бол одоогийн байдлаар, өнөөдрийн байдлаар ААН-үүд гээд тэгэхэд улсад татварын нийт хуримтлагдсан өр нь 8 их наяд хүрчихсэн 80 гаруй мянган ААН байж байгаа юм. Эдгээр асуудлуудыг цогцоор нь ингэж томоор нь авч харахгүй бол бодитой дэмжлэгүүд нь тэр болгон шууд хүрэхгүй.

Төгсгөлд нь өр нь бол ААН бизнесүүдийн гол хүсэж байгаа юм, гадаад дотоод хөрөнгө оруулагчдын гол хүсэж байгаа юм бол төр засгийн тогтвортой байдал, тодорхой байдал, эдийн засгийн ээлтэй таатай орчин хамгаас чухал байгаа. Авлигагүй эрүүл эдийн засаг. Тэгэхээр 1-д энэ макро эдийн засгийнхаа орчин буюу төсөв мөнгөний бодлогын уялдаа, үр ашиг, сахилга бат, хариуцлагын асуудлыг анхаарч, ингэж байж бизнес хийхэд таатай орчнууд бий болно. Эдийн засаг дээр хэдхэн томоохон төр дагасан бизнесүүд уул уурхай дагасан бизнесүүд төвлөрсөн жижиг, дунд бизнесүүдийн өрсөлдөх орон зай, шударга өрсөлдөөн бол хумигдмал байна.

2-т энэ төр засгийн тогтвортой байдлыг анхаарахгүй бол хөрөнгө оруулалт ч орж ирэхгүй. Жил 8 сарын хугацаанд Их Хурлынхаа 3 дахь даргатай ажиллаж байна, 3 дахь Ерөнхий сайдтайгаа ажиллаж байна. Ийм тогтворгүй төр засагт хөрөнгө оруулалтын бизнес хийнэ гэдэг бол хүнд. Ямар ч муу менежменттэй засаглалтай хувийн жижиг компани ч ТУЗ-ийн дарга, гүйцэтгэх захирлаа ингэж олон солихгүй гэдгийг бид анхаарах ёстой. Баярлалаа.

С.Бямбацогт: Баярлалаа. Зочин танилцуулъя. УИХ-ын гишүүн Хассуурийн Ганхуягийн урилгаар БГД-ийн Хөдөлмөр, халамж үйлчилгээний газрын албан хаагчид УИХ-ын үйл ажиллагаа, Төрийн ордонтой танилцаж байна. Төрийн ордонтой танилцаж байгаа төрийн албан хаагчид та бүхэндээ УИХ-ынхаа нийт гишүүдийн нэрийн өмнөөс эрүүл энх, аз жаргал, сайн сайхан бүхнийг хүсэн ерөөе. Баатаржавын Мөнхсоёл гишүүн үгээ хэлье.

Б.Мөнхсоёл: Эрхэм гишүүдийн энэ өдрийн амгаланг эрье. Эдийн засгийн байнгын хороон дээр хэлсэнчлэн би энэ бизнесийн эрх чөлөөний тухай хууль, ялангуяа энэ давхар хамт орж ирж байгаа Хөрөнгө оруулалтын тухай хууль болон Зөвшөөрөл, мэдэгдлийн тухай хуулийг маш сайн дэмжиж үг хэлсэн. Энэ одоо байгаагаа дахин илэрхийлж ингэж үг хэлж байгаа юм. Яагаад вэ гэхээр бид олон жил 2010 оноос хойш Монголын эдийн засгийн форум гэдгийг зохион байгуулж ирсэн. Маш олон зүйлүүдийг амлаж ирсэн байдаг. Начир дээрээ буюу бодит байдал дээр биеллээ олоогүй. Тийм учраас олон жил ГХО-д гадаадаас Монгол Улсад төлөөлөн суугаа Элчин сайдууд Монголд хамгийн наад зах нь 3 том асуудал байна гэж хэлдэг. 1 дүгээрт нь нээлттэй ил тод байдал дутмаг байна. 2 дугаарт нь аливаа гэрээ хэлцэл, хууль, эрх зүйн орчны биелэлт, гүйцэтгэл муу байна гэдэг. 3-д нь

мэдээж бид бүгдийн мэддэг авлига хээл хахуулийн асуудал. Энэ хамгийн наад захын 3 том асуудал, цаашлаад олон мэдээж зохицуулалтын асуудлууд яригдана.

Түүнчлэн энэ бизнесийн эрх чөлөөний хууль өмнө нь яригдаж байсан Эдийн засгийн эрх чөлөөний хуультай холбогдуулаад Херитеж сан /Heritage Foundation/, Фрейзер институт /Fraser Institute/ зэргээс гаргадаг олон улсын эрэмбүүдийг маш их ашиглаж байна. Яагаад бид энийг яриад байгаа юм бэ өнөөдөр. Энэ бол зөвхөн Монгол Улсын асуудал биш юм. Дэлхий даяар оршин байгаа олон улсуудыг зэрэгцүүлсэн, эрэмбэлсэн ийм ранкууд тайлангууд байна. Энд Монгол Улс дандаа хойгуур байранд ороод байгаа юм. Тийм учраас энэ байраа ахиулах, цаад утгаараа Монголчууд маань ажлын байртай болох, ядуурал ажилгүйдлээ шийдэх, улмаар олон улсын түвшинд өрсөлдөх чадвартай болоход энэ цогц реформын шинжтэй Бизнесийн эрх чөлөөний хуулийн энэ санаа зорилго нь маш зөв юм.

Тэгээд зах зээл дээр нэгэнт үүсэх хүлээлтийг бид маш оновчтой шийдэхийн тулд энэ 2 хууль болон холбогдож гарч ирж байгаа 99 хуулийнхаа төсөл дээр маш нухацтай ажиллах ёстой гэдгийг сануулах нь зүйтэй байх. Өнөөдөр гишүүд маш чухал санаануудыг хэлж байна. Тэрийг бид ажлын хэсгүүд, маш сайн гишүүд орж харах ёстой, дэд ажлын хэсгийн гишүүд орж нухацтай суух ёстой гэсэн ийм саналтай бас байна.

Эрх чөлөө, ялангуяа эдийн засгийн эрх чөлөөнд юуг авч үздэг вэ гэхээр тухайн улсын худалдаа наймаа, бизнес эрхлэх, хөдөлмөрийн зах зээлийн, санхүүгийн зах зээлийн зохицуулалтын асуудлууд яригддаг. Санхүүгийн зах зээлийн зохицуулалт гэхээр юу вэ гэхээр хамгийн наад зах нь эх үүсвэрүүд. Одоо жишээлбэл арилжааны банкнууд гадаадын зах зээлээс мөнгө босгодог, орж ирээд өртөг нь өндөр болдог. Тэгэхээр тэр суутган нь, суутгах тэр татварын хэмжээг 20 биш 5 хувь болгоно гэдэг чинь маш том дэмжлэг болчхож байгаа юм. Нөгөө өртгийг багасгаж өгч байгаа юм наад зах нь.

Цаашлаад нөгөө түрүүний миний хэлсэн хууль, эрх зүйн болон гэрээний хэлцлийн биелэлт муу байна гэдэг дээр. Тэгэхээр яах нь вэ маргаан гомдол маш их гардаг гэдгийг ярьж байна шүү дээ. Тэрийг шийдэх, маргаан зохицуулах, гомдлыг барагдуулах механизмуудыг дотоодын болон олон улсын түвшинд бий болгоно гэж байна. Цаашлаад мэдээж олон асуудлууд салбарын түвшинд яригдаж байна шүү дээ. Эрчим хүч, сэргээгдэх эрчим хүч гээд энэ салбаруудаа дэмжиж байгаа нь бид өнөөдөр зөвхөн уул уурхайн салбар, олборлох салбар, эрдэс баялгийн салбараас үл хамааран хөгжих ёстой гэдгийг өдөөж дэмжиж өгөх ийм зохицуулалтууд орж ирэх нь.

Цаашлаад хамгийн том яригддаг бас нэг энэ эрх чөлөөний асуулт яригддаг зүйл юу вэ гэхээр ДНБ-тэй харьцуулсан төсвийн хэмжээ байдаг. Өөрөөр хэлбэл төсвийн сахилга бат. Энэ дээр бид юуг л хэлэх гээд байна вэ гэхээр давхар бусад хуулиуд маш чухал гэдгийг үгийнхээ эцэст давхар сануулан хэлмээр байгаа юм. Энэ бол маш олон хуулийг хамарсан цогц реформ /reform/ болох учиртай. Маш нухацтай ажиллаад энэ парламентынхаа 4 жилийн.../минут дуусав/

С.Бямбацогт: Дэмжиж үг хэллээ. Мөнхсоёл гишүүнд баярлалаа. Зөвшөөрлийг тусгай зөвшөөрлийг хүнд суртлаас чөлөөлөх асуудлыг Монголын Их Хурал олон жил ярьж ирсэн. Зөвшөөрөлтэйгөөс бусад нь хориотой гэсэн үзэл хандлагаар сумын Засаг даргаас авхуулаад 3Г хүртлээ тусгай зөвшөөрөл өгдөг. Тэр

тусгай зөвшөөрөл өгөхийн тулд маш хүнд суртал гар хөлийн үсэг зуруулдаг, авлигал, шан харамж нэхдэг ийм юманд нэвт авчихсан байсан. Үүнийг өөрчлөх хуулийг 2019 онд миний бие санаачилж зөвшөөрлийг цөөлөх, зөвшөөрлийг хүнд сурталгүй болгох хуулиудыг 2019 онд санаачилж, 2022 онд батлагдсан. Харамсалтай нь энэ хууль батлагдаад хэрэгжиж байх явцад дахиад л нөгөө гарын үсгээ зурдаг улсууд гарын үсгээ санагалзаад, энэ хуулийг хэрэгжих боломжгүй болгочихсон юм байна лээ.

Тэгвэл одоо энэ зөвшөөрлийг хүнд суртлаас чөлөөлөх, зөвшөөрснөөс бусад нь чөлөөтэй байх, зөвшөөрөлтэйгөөс бусад нь, хүний амь нас, эрүүл мэнд, байгаль орчин, үндэсний аюулгүй байдалд хор хохирол учруулж болзошгүй бизнес дээр төр хянаж тусгай зөвшөөрөл өгдөг байя. Бусад тохиолдолд бизнес эрхлэгч ААН-үүд маань чөлөөтэй бизнесээ эрхэлдэг байх энэ Бизнесийн эрх чөлөөний тухай хуулийг бас өргөн мэдүүлсэн байгаа. Энэ хуулийн зорилт нь Үндсэн хуульд заасан иргэн, ААН бизнесийн үйл ажиллагаа эрхлэх эрхийг баталгаажуулах, төрөөс бизнесийн үйл ажиллагаанд үзүүлэх дарамтыг багасгах, шударга өрсөлдөөнийг дэмжих, бизнесийн орчны тогтвортой байдлыг хангахтай холбогдсон харилцааг зохицуулна гэж агуулга нь.

Бизнесийн эрх чөлөөг хангах талаар баримтлах зарчим. Төр хуулиар хориглосноос бусад бизнесийн үйл ажиллагааг чөлөөтэй эрхлэх нөхцөлийг бүрдүүлэх үүрэгтэй. Бизнесийн үйл ажиллагаанд хийх төрийн зохицуулалт нь хуульд үндэслэсэн зайлшгүй байх ёстой, дээрээс нь шударга өрсөлдөөнийг хязгаарлахгүй байх ёстой. Мөн бизнесийн үйл ажиллагаанд хийх төрийн зохицуулалтын тогтвортой урьдчилан таамаглах боломжтой байдлыг хангах. Бизнес эрхлэгчийн өмчийн хэлбэр, хөрөнгө оруулалтын эх үүсвэр, байршил, хэмжээ, салбар хэлбэрээр ялгаварлан гадуурхахгүй байх, төрийн үйлчилгээ цахим, ил тод, түргэн шуурхай, тэгш, хүртээмжтэй, бизнес эрхлэгчээс мэдээллийг нэг удаа авах нөхцөлийг бүрдүүлсэн байх гээд маш чухал ийм хөнгөлсөн энэ зарчмуудыг оруулж ирсэн байгаа.

Төрийн үйл ажиллагаа нь төрийн албан тушаалтнууд хориглох зүйлүүд дээр үндэсний аюулгүй байдал, нийтийн ашиг сонирхол, шударга өрсөлдөөнийг хамгаалахаас бусад тохиолдолд бизнесийн эрх чөлөөг хязгаарласан, хориглосон хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний акт, дүрэм, журам, норм, стандарт батлан гаргахыг хориглоно. Бизнес эрхлэгчийн нэр хүндэд халдсан үндэслэлгүй мэдээлэл гаргах, түгээхийг хориглоно. Бизнес эрхлэгчийн нийгмийн хариуцлагын хүрээнд үйл ажиллагаанд албадан оролцуулахыг хориглоно. Хуульд зааснаас бусад тохиолдолд зарим бизнес эрхлэгчид давуу эрх олгосон захиргааны хэм хэмжээний акт батлахыг хориглоно гэж маш тодорхой, маш чухал бодлогын асуудлууд тусгасан ийм хууль байгаа шүү.

Тийм болохоор энийгээ хэлэлцээд явъя, манай бас зарим гишүүдээс өргөн барьсан Эдийн засгийн эрх чөлөөний тухай хуультайгаа нэгтгэх эсэх асуудал дээр урьд нь ажлын хэсэг ахалж ажиллаж байсан гишүүд анхааралдаа аваарай гэдгийг хэлье. Гишүүд асуулт асууж, үг хэлж, хариулт авч дууссан. Одоо үг хэлж дууслаа. Дараагийн асуудалдаа оръё. Санал хураалтыг 17:00 цагаас.

Зочин танилцуулъя. УИХ-ын гишүүн Энхбаярын Батшугарын урилгаар нийслэлийн ерөнхий боловсролын 41 дүгээр сургуулийн 9а ангийн багш, сурагчид Их Хурлын үйл ажиллагаа, Төрийн ордонтой танилцаж байна. Төрийн ордонтой танилцаж байгаа сурагч хүүхэд, багачууддаа Их Хурлынхаа нийт гишүүдийн нэрийн өмнөөс эрүүл энх, аз жаргал, сайн сайхан бүхнийг хүсэн ерөөе. Зуныхаа амралтаар сайхан амарцгаагаарай хүүхдүүдээ. Бид амрах арай болоогүй. 100 хууль явж байгаа шүү энд.

Гурав.Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл /Улсын Их Хурлын гишүүн С.Одонтуяа нарын 37 гишүүн 2026.05.29-ний өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/

Дараагийн асуудалдаа оръё. Монгол Улсын ХЭҮК-ын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн хэлэлцэх эсэх асуудлаар хэлэлцүүлэг явуулна. Хууль санаачлагчийн илтгэлийг УИХ-ын гишүүн Салдангийн Одонтуяа танилцуулна. Таныг индэрт урьж байна. Таныг индэрт урьж байна.

С.Одонтуяа: УИХ-ын дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын нэгдэн орсон олон улсын хүний эрхийн гэрээ, конвенцын хэрэгжилтийг хангах, цэргийн байгууллага дахь хүний эрхийн хамгаалалтыг бэхжүүлэх зорилгоор Монгол Улсын ХЭҮК-ын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулан өргөн мэдүүлээд байна.

Хуулийн төслөөр Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.1.2 дахь хэсэгт нэмэлт оруулж, эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үндэсний ажиллагааны чиг үүргийн хүрээнд цэргийн албан хаагчдад зориулсан сургалт, соён гэгээрүүлэх үйл ажиллагааг тогтмол зохион байгуулах эрх зүйн үндсийг бүрдүүлэхээр тусгасан. Монгол Улсын ХЭҮК нь хүний эрхийг хамгаалах, сурталчлах чиг үүрэг хэрэгжүүлдэг боловч цэргийн байгууллагад чиглэсэн тусгайлсан сургалт, урьдчилан сэргийлэх арга хэмжээний эрх зүйн зохицуулалт өнөөдөр хангалтгүй байна. Үүний улмаас цэргийн алба хаагчдын хүний эрхийн мэдлэг, ойлголтыг тогтмол нэмэгдүүлэх, эрсдэлийг урьдчилан илрүүлэх, хүний эрхийн зөрчлөөс сэргийлэх ажил системтэй хэрэгжих боломж хязгаарлагдмал хэвээр байна. Сүүлийн жилүүдэд олон улсын байгууллагуудаас Монгол Улсад өгсөн зөвлөмжүүдэд цэргийн байгууллага дахь хүний эрхийн хамгаалалтыг бэхжүүлэх, эрүүдэн шүүх болон хүнлэг бус харьцаанаас урьдчилан сэргийлэх арга хэмжээг эрчимжүүлэхийг онцлон зөвлөсөн.

Тухайлбал НҮБ-ын Эрүүдэн шүүхийн эсрэг хорооноос Монгол Улсад өгсөн зөвлөмжид цэргийн алба хаагчдад холбогдох гомдлыг үр нөлөөтэй шалгах, урьдчилан сэргийлэх механизмын хяналтыг сайжруулах шаардлагыг дурдсан байдаг. Цэргийн байгууллага нь хаалттай орчинд үйл ажиллагаа явуулдаг онцлогтой. Ийм нөхцөлд дүрмийн бус харьцаа, сэтгэл зүйн дарамт, ялгаварлан гадуурхалт, хүчирхийлэл зэрэг хүний эрхийн зөрчлөөс урьдчилан сэргийлэх хамгийн үр дүнтэй арга замын нэг нь хүний эрхийн боловсрол, соёлыг тогтолцоотой төлөвшүүлэх явдал юм.

Хуулийн төсөл батлагдсанаар цэргийн албан хаагчдад зориулсан хүний эрхийн сургалт, соён гэгээрүүлэх үйл ажиллагааг тогтмол зохион байгуулах эрх зүйн үндэс бүрдэх бөгөөд алба хаагчдын хүний эрхийн талаарх мэдлэг, ойлголт,

хандлагыг дээшлүүлэх ач холбогдолтой юм. Үүний үр дүнд дүрмийн бус харьцаа, дарамт шахалт, хүчирхийлэл зэрэг хүний эрхийн зөрчлөөс урьдчилан сэргийлэх нөхцөл сайжирч, хүний эрхийг хүндэтгэсэн байгууллагын соёл төлөвшихөд эерэг нөлөө үзүүлнэ. Түүнчлэн захирагч, удирдах бүрэлдэхүүн хүний эрхэд суурилсан удирдлагын арга барилыг төлөвшүүлж, сахилга хариуцлагыг дарамт шахалт бус харилцан хүндэтгэл, ойлголцолд тулгуурлан хэрэгжүүлэх нөхцөл бүрдэх юм. Мөн хүний эрхийн зөрчлийг эрт илрүүлэх, мэдээлэх, шийдвэрлэх тогтолцоо бэхжиж, дотоод хяналтын үр нөлөө нэмэгдэнэ.

Улмаар цэргийн байгууллагад хүний эрхийг дээдэлсэн, сахилга хариуцлагатай, харилцан хүндэтгэлтэй орчин төлөвшиж, алба хаагчдын аюулгүй байдал, сэтгэл зүйн тогтвортой байдал, ажлын бүтээмж сайжрахын зэрэгцээ цэргийн албаны нэр хүнд, олон нийтийн итгэл нэмэгдэх ач холбогдолтой гэж үзэж байна. Олон улсын туршлагаас харахад НҮБ болон бусад улсын зэвсэгт хүчнүүд хүний эрх, олон улсын хүмүүнлэгийн эрх зүйн сургалтыг цэргийн бэлтгэлийн салшгүй хэсэг болгон хэрэгжүүлдэг бөгөөд энэ нь хүний эрхийн зөрчлийг бууруулах, командлалын хариуцлагыг бэхжүүлэхэд чухал ач холбогдолтой болох нь нотлогдсон байдаг. Иймд Монгол Улсын ХЭҮК-ын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг хэлэлцэн дэмжиж өгөхийг хүсье. Анхаарал тавьсанд баярлалаа.

Улсын Их Хурлын дэд дарга Б.Пүрэвдорж 14 цаг 31 минутаас хуралдааныг даргалав.

Б.Пүрэвдорж: Одонтуяа гишүүнд баярлалаа. Төслийн талаарх ХЗБХ-ны санал, дүгнэлтийг УИХ-ын гишүүн Гончигдоржийн Уянгахишиг танилцуулна. Индэрт урьж байна.

Г.Уянгахишиг: УИХ-ын дарга, эрхэм гишүүд ээ,

МУИХ-ын гишүүн С.Одонтуяа нарын 37 гишүүнээс 2026 оны 5 дугаар сарын 29-ний өдөр УИХ-д өргөн мэдүүлсэн Монгол Улсын ХЭҮК-ын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн хэлэлцэх эсэх асуудлыг ХЗБХ 2026 оны 6 дугаар сарын 10-ны өдрийн хуралдаанаараа хэлэлцлээ. Хууль санаачлагч эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үндэсний ажиллагаанаас цэргийн ангиудад эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар хүний нэр төрийг доромжлон харьцаж шийтгэхээс ангид байх эрхийг хангах, хамгаалах чиглэлээр сургалт, мэдээлэл, соён гэгээрүүлэх нөлөөллийн арга хэмжээг зохион байгуулж, тус салбарт хүний эрхийн зөрчлөөс ангид байх нөхцөлийг бүрдүүлэх, эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үндэсний механизмын чадавхыг бэхжүүлэх зорилгоор хуулийн төслийг боловсруулсан бөгөөд төслийг dparliament.mn цахим сайтад байршуулж, иргэд, олон нийтийн саналыг авч байгаа болно.

Байнгын хорооны хуралдаанаар хуулийн төслийг хэлэлцэх үед УИХ-ын гишүүн Н.Алтанхуяг цэргийн алба хаагчдад чиглэсэн сургалт, соён гэгээрүүлэх нөлөөллийн арга хэмжээ авч хэрэгжүүлснээр үр дүн гарах эсэх талаар асуулт асууж, хариулт авсан бөгөөд УИХ-ын гишүүн П.Сайнзориг ХЭҮК-ын Эрүүдэн шүүлтээс урьдчилан сэргийлэх механизмыг зөв ажиллуулах, УИХ-ын гишүүн Д.Батлут хуулийн төслийн зорилго БХЯ-ны үйл ажиллагааны чиглэлд бүрэн нийцэж байгаа бөгөөд энэ хүрээнд Батлан хамгаалахын сайдын дэргэдэх Хүний эрхийн зөвлөлийг байгуулсан, мөн Зэвсэгт хүчнийг эрсдэлээс чөлөөлөх талаар тодорхой алхмуудыг

хийж байгаа талаар, хүний эрхийн чиглэлээр сургагч багш бэлтгэн Зэвсэгт хүчний анги, БХЯ-ны харьяа байгууллагуудаар байнгын хуваарийн дагуу үйл ажиллагаа явуулж байгаа талаар, УИХ-ын гишүүн Д.Цогтбаатар БХЯ уг хуулийн төслийг батлагдахад хэрэгжүүлэх шатанд дэмжин ажиллах нь зүйтэй талаар тус тус үг хэлсэн болно.

УИХ-ын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.11 дэх хэсэгт заасны дагуу Монгол Улсын ХЭҮК-ын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслөөр санал хураалт явуулахад Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн олонх буюу 61.9 хувь нь үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжиж, чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх нь зүйтэй гэж үзсэн болно.

УИХ-ын эрхэм гишүүд ээ, Монгол Улсын ХЭҮК-ын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн хэлэлцэх эсэх хэлэлцүүлгийг явуулсан талаарх ХЗБХ-ны санал, дүгнэлтийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг та бүхнээс хүсье. Анхаарал тавьсанд баярлалаа.

Б.Пүрэвдорж: Уянгахишиг гишүүнд баярлалаа. Ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг танилцуулъя. Шагдарын Үнэнтөгс ХЭҮК-ын Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх хэлтсийн дарга, Эрдэнэцогтын Дарханцэцэг УИХ-ын гишүүний зөвлөх.

МУИХ-ын тухай хуулийн 21.24-т нэгдсэн хуралдаанд мэдээлэл хийж байгаа ЗГ-ын гишүүн, ажлын хэсгийн бүрэлдэхүүнд орсон холбогдох албан тушаалтан үнэн зөв, бүрэн гүйцэт мэдээлэл өгөх үүрэгтэй. 21.25-д нэгдсэн хуралдаанд мэдээлэл хийх, асуултад хариулах, тайлбар өгөх албан тушаалтан өөрийн танилцуулсан мэдээллийн үнэн зөвийг хариуцах бөгөөд мэдээллийг санаатайгаар нуун дарагдуулах, худал мэдээлэл өгөх, танилцуулах, УИХ-д худал мэдээлэл ирүүлэхийг хориглоно. 21.31-д чуулганы хуралдаанд хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр хүрэлцэн ирээгүй, тайлбар өгөхөөс татгалзсан, хуралдаанд оролцсон этгээд хуралдааны дэг зөрчсөн бол парламентыг үл хүндэтгэсэнд тооцож, тухайн этгээдэд Төрийн албаны тухай хууль болон холбогдох бусад хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ гэж заасныг ажлын хэсгийн бүрэлдэхүүнд сануулъя.

УИХ-ын гишүүд Байнгын хорооны санал, дүгнэлт, хууль санаачлагчийн илтгэл болон хуулийн төслийн үзэл баримтлалтай холбогдуулан намын бүлэг болон бүлэгт харьяалагдаагүй гишүүдээс урьдчилан ирүүлсэн нэрсийн дагуу асуулт асууна. Сүхбаатарын Эрдэнэболд гишүүн асуулт асууна.

С.Эрдэнэболд: Юуны өмнө энэ хүний эрхтэй холбоотой чухал асуудлаар чухал хуулийн төслийг санаачилсан Салдангийн Одонтуяа гишүүнд талархал илэрхийлье. 1 дүгээрт энэ хүний эрхийн асуудал жижиг гэлтгүй олон хуулийн салаа мөчрүүд дээр зөрчигдөөд байгаа юм. Тэгээд энийг ер нь бид том зургаар нь хараад, хаана ямар зөрчил, асуудлууд байна, хаана хийдэл, давхцал байна, хаана хүний эрхийн зөрчил үйлдэгдээд байна гэдэг дээр нэг бүрчлэн анализ, дүгнэлт хийж ажиллах ёстой.

Энэ 2025 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар би энэ Энхбаяр сайдыг хуулийн сайд хийж байхад нь лавлагаа авч байсан, Хүний эрхийн дэд хороон дээрээс. Ер нь энэ цэргийн ангиуд болон хууль сахиулах байгууллагуудад гарсан зөрчил, хүний эрхийн зөрчил, тэнд амь насаа алдсан хүмүүс ямар шалтгаан,

нөхцөлөөр алдсан юм, тэнд тодорхой хэмжээнд дарамт, зодуурт орсон хүмүүс ямар шалтгаанаар байсан юм бэ гэдэг дээр ингээд нэг бүрчлэн судалгаа хийлгүүлээд, сүүлийн 25 жилийн дүн мэдээ, тайланг авсан юм. Ингээд харж байхад хэд хэдэн ийм онцлог шалтгааны үүднээс, ялангуяа энэ цэргийн алба хааж байгаа хүмүүсийн дунд зөрчил гардаг юм байна. 1 дүгээрт нь тэр амиа хорлолтын индексийг нь харахаар хамтран амьдрагч, эсвэл эхнэр, эсвэл найз охинтойгоо муудалцсан гэсэн шалтгаанаар маш олон хүмүүс амиа хорлосон. Бусдын биед халдаж гэмтэл учруулсан энэ тохиолдлууд нь маш жижигхэн үл ойлголцол, соёл буруугаас. Тэгээд энд авагдаж байгаа мэдээллүүдийг ингээд үзэхээр, ялангуяа бусдын биед халдчихсан хүмүүс дээр ингээд шалгалт явуулаад үзэхээр хүний эрхийн суурь мэдлэг муутай нь харагдаж байгаа юм. Хэрвээ тэр хүмүүст тодорхой хэмжээнд сургалт явуулсан бол, нөлөөллийн ажил явуулсан бол, тийм зорилтот аяныг явуулсан бол энэ гэмт хэргүүд ядаж 50-иас дээш хувиар буурах байсан байна гэдэг нь эндээс харагдаж байгаа юм, энэ зүй тогтол нь. Тийм учраас энэ Одонтуяа гишүүний санаачилсан хууль яг цаг үеэ олсон, цаашлаад магадгүй, магадгүй юу байх вэ, бусдын амь бие, эрүүл мэндийг тодорхой аюулт үзэгдлээс урьдчилан сэргийлэх ийм зохицуулалт болж чадна гэж бодож байгаа.

Асуух гэж байгаа асуулт нь болохоор тэр ЗГ-аас гаргасан тэмдэглэл дээр байгаа. Хуулийн төсөлд эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх асуудал эрхэлсэн гишүүний сургалт зохион байгуулах чиг үүргийг хуульчлахдаа зөвхөн цэргийн албан хаагчаар хязгаарлахгүй, эрсдэлтэй бүлгүүдийг мөн хамруулах боломжийг бүрдүүлэх нь зүйтэй гэсэн байгаа. Гомдол хаана их гарч байна гэхээр шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын түвшинд хүний эрхийн гомдлууд, мөн цагдаагийн байгууллагын түвшинд хүний эрхийн гомдлууд зонхилж гарсаар ирсэн. Тэгэхээр энэ цаашдаа өргөн хүрээтэй байх байх л даа. Тэгэхээр яг энэ эрсдэлт бүлэг гэдэг нь хүний эрх зөрчигдөх магадлалтай тэр цэгүүдийг хэлж байгаа юм. Энийг жишээлбэл хуулийн төслийнхөө хүрээнд яаж найруулж оруулж байгаа вэ? Энд асууж байгаа шалтгаан нь зохицуулалтыг нэгэнт л энэ хууль өөрчилж, хуульд өөрчлөлт оруулж байгаа юм чинь хамрах хүрээг асар тодорхой, яв цав гаргачихвал олон асуудлыг бид урьдчилан шийдэх боломжтой юм байна гэж харагдаж байгаа юм. Энэ асуултад Салдангийн Одонтуяа гишүүнээс хариулт авъя.

Б.Пүрэвдорж: Хууль санаачлагч Салдангийн Одонтуяа гишүүн хариулна.

С.Одонтуяа: Эрдэнэболд гишүүний асуултад хариулъя. Тэгэхээр энэ эрсдэлт бүлэгт оруулж болохгүй юу гэсэн байгаа. Тэгэхээр ер нь энэ ХЭҮК-ын тухай хуулийн 33 дугаар зүйлд эрүүдэн шүүхээс урьдчилан сэргийлэх үндэсний ажиллагаа нь ямар газарт хийгдэх вэ гэхээр яг саяын таны хэлдэг энэ эрсдэлт бүлэгт ингээд бүр нэр заагаад хийчихсэн байгаа. Энд хүн өөрийн хүсэлтээр гарч явах боломжгүй бүх газарт гэж байгаа. Тэгэхээр бүх газарт гэдэгт юу юу орох вэ гэхээр яг хорих анги, цагдан хорих анги, Сэтгэцийн эрүүл мэндийн төв, асрамжийн газрууд, бусад оронд дүрвэгсдийн байр гээд хүн өөрийн хүсэлтээр гарч явах боломжгүй гэхээр эрх нь хязгаарлагдмал ийм хүмүүс гэсэн үг. Тэгэхээр эдгээр хүмүүс бүгд энэ хуульд орчихсон байгаа.

Миний нэмж байгаа зүйл юу вэ гэхээр энэ бүх газарт гэдэгт цэргийн байгууллагуудын албан хаагч ордоггүй байсан. Яагаад гэхээр шалтгаан нь би Төрийн болон албаны нууцын тухай хуультай холбоотой юм уу гэж бодсон. Цэргийн ангиуд, цэргийн ангийн бүрэлдэхүүн, бүх энэ байршил, нөөц нь нууцын зэрэглэлтэй байдаг учраас энэ ороогүй. Тийм учраас бид энэ дээр, энэ хүний эрхийн зөрчил

явагдаад байгаа учраас нэмээд цэргийн албан хаагчдад энэ сургалт, сурталчилгаа, соён гэгээрүүлэх ажлыг нь хийж өгье гэж байгаа юм. Хамгийн гол нь нэг хэрэг гараад бид бөөн сенсаци болоод л тэр ч буруутай, энэ ч буруутай гэхийн оронд урьдчилан сэргийлэх ажлыг нь яг олон улсын энэ зөвлөмжийнхөө дагуу хийе гэж байгаа юм. УИХ-д энэ эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үндэсний ажиллагаа гээд бүр энэ олон улсын конвенцынхоо дагуу энэ бүх сургалтууд, урьдчилан сэргийлэх ажил нь хийгддэг. Тэгэхээр яг энэний дагуу бусад орны туршлагыг хариуцаад хийе гэж байгаа юм.

Сүүлийн үед БХЯ, Зэвсэгт хүчинд олон төрлийн ингээд реформын ажлуудыг эхлүүлчихсэн байна л даа. Бид хэвлэлээс хараад л байж байна, Хүний эрхийн хяналтын зөвлөл, энэ цэргийн албыг эрсдэлээс чөлөөлье гээд ийм реформ, юмнууд хийж байна. Тэгэхдээ энэ ганцхан нэг яамны ажил биш, энэ бүгдээрээ УИХ, ЗГ, ард иргэд бүгд л энэ дээр ингэж ажиллах шаардлагатай байгаа юм. Тэгээд та бүхэн мэдэж байгаа байх, өмнө нь нэг хэсэг тэр "Тусгай салаа" кино гарахад залуучууд бүгд цэрэгт явъя гээд л маш гоё ийм эрмэлзэлтэй байсан, одоо цэрэгт явна гэхээр л хүмүүс бүгд ийм айдастай болчихсон. Тэгэхээр бид энэ олон нийтийн түгшүүртэй байдал, энэ харгис хэрцгий, балмад энэ бүх зүйлээс ангид байлгахын тулд энэ эрүүдэн шүүхээс урьдчилан сэргийлэх үндэсний ажиллагааг бүр энэ том утгаар нь ингээд хийе гээд тэгж байгаа учраас таны.../минут дуусав/

Б.Пүрэвдорж: Нийслэлийн ерөнхий боловсролын 69 дүгээр сургуулийн 1986 оны төгсөгчид УИХ-ын үйл ажиллагаа болон Төрийн ордонтой танилцаж байна. Та бүхэнд төгсөлтийн чинь 40 жилийн ойн баярын мэнд хүргэе. Сүхбаатарын Эрдэнэболд гишүүн тодруулъя.

С.Эрдэнэболд: Одонтуяа гишүүн ээ, сая 2026 оны 5 дугаар сарын 1-ний өдөр ХЗБХ-ноос оруулж ирээд чуулганаар нэг том тогтоол батлагдсан. "Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд илэрч байгаа системийн зөрчил, хүний эрхийн баталгааг хангах талаар авах зарим арга хэмжээний тухай" гээд ЗГ-т чиглэл өгсөн хэд хэдэн асуудлууд байгаа, энэ аягүй том дүгнэлт гарсан. Сүүлийн бараг жил гаруйн хугацаанд тодорхой хүний эрхийн зөрчил, тэр тусмаа эрүүдэн шүүхийн асуудал, тэгээд яаж хохирсон, тэр хохирлыг яаж нөхөн төлүүлэх юм, цаашид яаж ийм алдаа дутагдлыг гаргахгүй байх юм, энэ нь өөрөө яагаад системийн шинж чанартай юм бэ гээд манай Хүний эрхийн дэд хорооны дарга Баасанжаргал энэ дээр манлайлж ажиллаж байгаа. Тэгэхээр яг энэ хуультайгаа уялдуулаад, яг энэ тогтоолын хүрээнд гарах хуулиудын асуудал дээр уялдуулж ажиллаарай гэж хэлэх гэж байгаа шүү.

Б.Пүрэвдорж: Үг хэллээ. Мөнхчулууны Энхцэцэг гишүүн асуулт асууна, алга байна. Оюунсайханы Алтангэрэл гишүүн асуулт асууна.

О.Алтангэрэл: Энэ Монгол хүний эрх зөрчигдөх, Монгол Улсад хүний эрх зөрчигдөх явдал үндсэндээ хавтгайрлаа. Хүний эрхийг хамгаалах гол манаач нь болсон, хүний эрхийг хамгаалах тогтолцооны гол үндэс нь болсон ХЭҮК-ын ажил ер нь тааруухан байна. Нийгэмд гарч байгаа энэ зөрчил, болохгүй бүтэхгүй байгаа зүйлүүдийг иргэний нийгмийн байгууллагууд, сэтгүүлчид гаргаж ирж тавьж байна. Үндсэндээ өнгөрсөн жилүүдэд ХЭҮК-ын хийх ёстой байсан чиг үүргээ хэрэгжүүлээгүй, үйл ажиллагаандаа сэтгэл гаргаж хангаагүйн эс үйлдлийнх нь илрэл өнөөдөр илэрч байна. Тэгээд өнөөдөр асуудал болохоор нэг ийм биеэ өмгөөлөх, хаацайлах маягтай.

Сая болж өнгөрсөн явдалтай холбоотойгоор, тухайлбал хүний эрхийг хамгаалах ёстой ХЭҮК-ын өөрийнх нь бичгийн дагуу хэвлэл мэдээллийн редакцыг торгочхоод байхад гарч байгаа тайлбаруудыг нь харахад нэг ч хүн уучлал гуйхгүй байна. Өнгөрсөн жилүүдэд энэ нийгэмд болсон хүний эрхийг хамгаалах чиглэлээр хийж болох байсан ажлуудаа хэрэгжүүлээгүйн төлөө, олон зүйлүүдийн хажуугаар нүд аньж өнгөрснийхөө төлөө ХЭҮК уучлал гуйх хэрэгтэй. "Уучлаарай, бидний буруу боллоо" гээд. Тэр ХЭҮК-ын гишүүн Нарантуяа мэдэгдэл хийж байна лээ шүү дээ, "манай өргөдөл шалган шийдвэрлэх процесст алдаа гарсан байна" гээд. Үгүй ээ, тэгээд мэдэгдэж байгаа нь энэ шүү дээ. Хэдэн хүний өргөдлийг шийдвэрлэсэн юм, хэдэн хүний өргөдлөөр ахиц гарсан юм, яаж ажиллаж байгаа юм. Бид ингээд төрөөс байгуулчихсан хуультай, УИХ дэргэдээ авч явдаг, үйл ажиллагааных нь баталгааг хангачихсан хүний эрхийг хангах байгууллагатай гэж бодоод байгаад байдаг.

Харамсалтай нь энэ байгууллага чиг зорилгынхоо хүрээнд хүртэл ажиллаж чадахгүй байна. Энэ олон асуудлууд өнгөрсөн жилүүдэд хүний эрхийн зөрчил, ганцхан энэ цэргийн анги дээр байгаа амиа алдсан энэ олон залуучуудын асуудал биш, төрөл бүрийн асуудлуудаар хүний эрх чөлөө зөрчигдөж байгаа. Дорвитой арга хэмжээ авдаг, дуугардаг, шийдвэр гаргагчдад хүргэдэг, өөрсдөө манлайлдаг, үлгэрлэл дуурайлал үзүүлдэг, гал авдаг ийм комисстой бид ер нь болмоор байна. Ийм байгууллагын хэрэгцээ шаардлага бидэнд байна. Хууль зүйн үндэсний хүрээлэнгээс судалгаа хийгээд, ХЭҮК-ын үйл ажиллагаа, хуульд нь дүн шинжилгээ хийгээд, хуульд нь давхцал байна, хийдэл байна, зөрчил байна, зохицуулалтууд хоорондоо зөрчилтэй байна гээд ингээд дүгнэлт гарчихсан байдаг. Бид анхаардаггүй.

УИХ-ын дарга Бямбацогт дарга энэ асуудал дээр онцгой анхаарал хандуулмаар байна. УИХ-д шууд ажлаа хариуцаж тайлагнадаг байгууллагын чинь өнөөдрийн энэ нүүр царай, байдал нэг иймэрхүү байна. Ард иргэдээ өмгөөлөхгүй байна. Энэ түмэн олонд чинь нэг хууль ёсны дагуу эрхийг нь хамгаалдаг, өмгөөлдөг газар хэрэгтэй байна. Өнөөдрийн хуульд оруулах гэж байгаа нэмэлт, өөрчлөлтийг бүрэн дэмжиж байна. Одонтуяа гишүүн өнгөрсөн жилүүдэд хүний эрхийн чиглэлээр олон зүйл санаачилж байсан хүний хувьд зөв зүйтэй асуудал хөндсөн байна. Тэгэхдээ цаашид Комиссын хуулийг уг үндсээр нь өөрчлөх, бид энэ зохицуулалтуудыг боловсронгуй болгох, үр дүнтэй болгох энэ асуудал дээр анхаарах шаардлагатай байна гэж би хувьдаа үзэж байна. Тэгэхээр энэ нэмэлт, өөрчлөлтийг оруулах хуулийн төслөө боловсруулах явцдаа энэ тал дээр ер нь бүхэлд нь энэ хуулийг шинэчлэн найруулах, өөрчлөх, тогтолцоогоо шинэчлэх, Монгол хүний төлөө ажилладаг байгууллага болох тал дээр нь ямар нэг бодол санаа ер нь төрж байв уу? Цаашдаа ер нь бид юун дээр анхаарах ёстой вэ гэдэг дээр та энэ хууль санаачлагчийн хувьд Одонтуяа гишүүнээс байр суурийг.../минут дуусав/

Б.Пүрэвдорж: Зочин танилцуулъя. УИХ-ын гишүүн З.Мэндсайханы урилгаар нийслэлийн ерөнхий боловсролын 52 дугаар сургуулийн 7Г ангийн багш, сурагчид УИХ-ын үйл ажиллагаа, Төрийн ордонтой танилцаж байна. Та бүхэнд сурлагын өндөр амжилтыг хүсэн ерөөе. Сайхан хувцастай хүүхдүүд байна. Одонтуяа гишүүн хариулъя.

С.Одонтуяа: Хуулийн төслийг дэмжсэнд баярлалаа. Тэгээд энэ ХЭҮК УИХ-д тусдаа тайлан гаргаж байгаа, эрүүдэн шүүхээс урьдчилан сэргийлэх үндэсний

ажиллагаа гээд ингээд тусдаа тайлан гаргадаг юм. Бид гишүүд, зарим нь энийг ингээд яг нэг байгууллагын малгай доор уяад байдаг. Гэтэл энэ 2 нэг ёсондоо, энэ эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үндэсний ажиллагаа нь ийм бие даасан, хараат бус ийм тогтолцоо байх ёстой юм. Яагаад хараат бус байх ёстой юм бэ гэхээр, энэ олон улсын зөвлөмжид юу гэж зааж байгаа вэ гэхээр ер нь эрүүдэн шүүлт гэдэг дандаа ардаа захиалгатай, ардаа том даргын юугаар ингэж эрүүдэн шүүдэг. Тийм учраас энэ улс төрөөс асар хараат бус байх ёстой юм гэдэг. Тэгээд энэ 2 байгууллагын хооронд ингээд зөрчил гараад байдаг юм. Тэгээд би өнгөрсөн парламент байхад энэ зөрчлийг арилгах хуулийн төсөл санаачилсан, хүмүүс нь дургүй, "энэ чинь манай мэдлийг авах гээд байна, энэ ингээд байна" гээд ингээд энэ асуудал шийдэгдээгүй. Тэгэхээр энэ 2 байгууллагын асуудлыг, статус нь ямар байх ёстой юм, тэр хараат бус гэдгээ юу гэж ойлгох юм гэдгээ манай УИХ ер нь нэг мөр шийдэх ёстой юм байна лээ.

Энэ цэргийн үйл ажиллагаа дээр энэ эрүүдэн шүүхээс сэргийлэх үндэсний ажиллагаа одоогоор 8 хүнтэй байгаа, 8 хүнтэй байгууллага өнгөрсөн 4 жилийн хугацаанд нэлээдгүй ажил хийсэн байгаа. Би энэ тайланг нэг бүрчлэн ингээд үздэг. Жишээлэхэд, хорих ангиуд дээр юу хийсэн юм, СЭМҮТ дээр юу хийсэн юм гээд энэ өөрөө ийм амаргүй ажил. Тэгээд яг энэ олон улсынхаа зөвлөмжийн дагуу ингээд хийгдээд байгаа юм. Олон улсын зөвлөмжөөс бид нэг зүйлийг биелүүлэхгүй байгаа нь юу вэ гэхээр ерөөсөө л энэ цэргийн анги дахь хүчирхийллээ болиоч, тэнд эрүү шүүлт явагдаад байна гэдгийг олон улсын байгууллагын зөвлөмжид байнга дурдаж байгаа. Тэгээд 2024 онд УИХ-ын Хүний эрхийн дэд хороо хяналтын сонсгол хийсэн юм. Яг энэ цэргийн анги дээр явагдаад байгаа хүнлэг бус харьцаа, энэ эрүүдэн шүүлттэй холбоотой сонсгол хийхэд бүх хохирогчдын ар гэрийнхэн ирж ингээд ярьсан. Тэгээд энэнтэй холбоотой тогтоолууд гараад, ЗГ-т бидний тогтоол гараад ингээд хэрэгжээд явж байгаа юм.

Тэгэхээр энэ нэг ганц жижигхэн заалт орж байгаа мэт боловч ач холбогдол нь их том юм байгаа юм. Тэгэхээр энийг манай гишүүд зөв ойлгоосой гэж хүсэж байна. Зүгээр нэг сургалт гэх биш, энэ бүр урьдчилан сэргийлэх гээд л байгаа юм. Аливаа хэргийг нэг гарсан хойно нь биш, урьдчилан сэргийлж, ер нь хүний эрхийн ийм соён гэгээрүүлэх ийм соёлтой, арай өөр бид чинь нийгэмд амьдарч байна шүү дээ, ингэж энэ асуудлыг зохион байгуулъя л гэсэн ийм зорилготой хуулийн төсөл байгаа. Тэгээд өмнө нь энэ хуулиар хаалттай байсан юм, цэргийн ангиудад орох боломжгүй. Тэгэхээр энэ цэргийн ангиудад сургалт гэдгээр бид энэ.../минут дуусав/

Б.Пүрэвдорж: Ганбатын Очирбат гишүүн асуулт асууна.

Г.Очирбат: Гишүүддээ өдрийн мэнд хүргэе. Энэ хуулийн төсөл яг цагаа олж, зөв орж ирж байна гэж харж байгаа. Хүний эрхийн Үндэсний Комиссоос гаргасан тайланг бүгд л үздэг, хардаг. Тэгээд сүүлийн 10 жилийн хугацаанд бараг 44 орчим манай алба хаагчид амь насаа алдсан. Уг шалтгаан, учир нь юу вэ гэдэг дээр АН-ын бүлэг нэлээн авч хэлэлцсэн. АН-ын бүлэгт ч гэсэн иргэд, салбарын хүмүүс санал тавиад, бид 14 хоногийн өмнө энэ талаар сонсож, мэдээлэл авсан. Тэгээд энэ мэдээлэлтэй холбоотойгоор Монгол Улсын Ерөнхий сайд Ням-Осорын Учралд Батлан хамгаалахын салбар чинь ер нь ямар болчихоод байгаа юм бэ, бидний өгсөн шаардлагын дагуу мэдээлэл өгөөч гэснээс хойш 14 хоног хүлээсэн, нэг ч хариу өгөөгүй. Энийг иргэдээ дорд үзэж байна гэх үү, нэг бол АН-ын бүлэг иргэдийнхээ дуу хоолой болоод шаардлага хүргүүлэхээр шаардлагын хариуг нь өгөхгүй, дээр нь

гишгэчхэж болдог юм гэж харуулж байгаа юм уу. А4-цаасан дээр 10 үг холбоод хариу өгчихөд ер нь яагаад болдоггүй байсан юм бэ? Энэ дээр би гайхаж байгаа.

Хуулийн төслийг үзэл баримтлалынх нь хүрээнд дэмжиж байгаа. Урьд нь ч гэсэн ингэж оруулж ирээд манай цэргийн алба хаагчид болон ахлах дарга, цэрэг нар, офицеруудад энэ сургалтуудыг үе шаттай оруулах ёстой. Сургалтаар бид тархи оюунд нь юм хийж өгөхгүй бол очоод тэр бие махбод дээрэлхдэг, дарангуйлдаг юм явж л байгаа байхгүй юу. Тэгэхээр хуулийн төслийг дэмжиж байгаа. Тэгээд хуулийн төслийг санаачлагч Салдангийн Одонтуяа гишүүнээс ер нь энэ хуулийн төсөл цаашаа хэрэгжээд явбал хэр хэмжээний үр дүн гарах вэ, хэчнээн хэмжээний сургагч багш нар гарах вэ, сургагч багш нарын цаашаа ажиллах дүрэм, хөтөлбөр, журмыг нь хэрхэн яаж харж байгаа вэ гэсэн ийм асуултуудыг асуугаад тодруулъя.

Б.Пүрэвдорж: Хууль санаачлагч Салдангийн Одонтуяа.

С.Одонтуяа: Би хариулчихъя. Хуулийн төсөл батлагдсанаар бид ямар ч байсан энэ хүний эрхийн сургалт, соён гэгээрүүлэх үйл ажиллагааг тогтмол зохион байгуулах ийм эрх зүйн үндэс бүрдэж байна гэж харж байгаа. Тэгэхээр энэ яг олон улсынхаа гэрээ, конвенцын дагуу, тэр өгсөн зөвлөмжийн дагуу бид энэ сургалт, соён гэгээрүүлэх ажлыг хийнэ. Яг хэдэн хувиар буурах вэ гэдгийг би одоо яг хэлж мэдэхгүй байна. Нөгөөтээгүүр энэ тоо баримтыг ил хэлэх боломжгүй. Яагаад гэхээр өөрөө энэ цэргийн ангийн салбарын тоо, нөөц нь нууц байдаг учраас энэ дээр хууль батлагдахад бид тооцоо судалгааг нэлээд нарийвчилж гаргах ийм боломж бүрдэнэ.

Гол асуудал юу вэ гэхээр, энэ олон улсын туршлагаас бид нэлээд зүйлийг авч байгаа. НҮБ болон бусад улсын зэвсэгт хүчинд энэ хүний эрх, олон улсын хүмүүнлэгийн эрх зүйн сургалтыг цэргийн бэлтгэлийнхээ салшгүй хэсэг болгоод ингээд хийдэг юм билээ. Бүр практик дээр нь ингэж хийдэг. Тийм учраас бид энэ зөрчлийг бууруулах, командлалын хариуцлагыг бэхжүүлэхэд энэ сургалтууд чухал үр дүн үзүүлнэ гэж бодож байгаа. Яагаад гэхээр энэ үндэсний ажиллагаа хорих ангиуд дээр хийсэн, хүүхдийн асрамжийн газарт хийсэн сургалтууд маш үр дүнтэй болж байгаа. Хүмүүс хаана гомдлоо гаргах вэ, ер нь хүний эрхийн энэ удирдлага чинь хүний эрхийг зөрчөөд байна уу, зөрчихгүй байна уу гэдгээ ядаж мэддэг болдог. Ер нь эрүүдэн шүүнэ гэдэг чинь зөвхөн зодохыг хэлэхгүй юм байна. Эрүүдэн шүүнэ гэдэг чинь хүний нэр төрийг гутаан доромжлох, өвлийн хүйтэнд олон цагаар гадаа зогсоох ч юм уу, хоол ундгүй байлгах, энэ бүхэн чинь эрүүдэн шүүхийн хэлбэр юм, хүний эрхийн зөрчил юм гэдгээ хүмүүс ойлгоод эхлэхээр өөрсдөө энэ гомдлоо гаргадаг, өөрийнхөө эрхийн төлөө тэмцдэг ийм болж ирэх юм.

Тэгээд өчигдөр надтай хэдэн ТББ-ын залуучууд холбогдоод, бид энэ цэрэгт явж байгаа залуучуудад хүний эрхийн энэ сургалтыг хийе, тэгэх юм бол залуучууд очоод өөрсдийнхөө эрхийг мэддэг болно, өөрсдийнхөө биеэ хамгаалдаг чадвартай болно гээд тийм хөөрхөн санаачилгуудыг яриад явсан. Тийм учраас бид энэ асуудлыг зүгээр орхиж болохгүй. Мэдээж БХЯ, Хууль зүйн яам бүх л газартайгаа ингээд хамтраад, энэ хүний амь нас хохирохгүй, хүний эрхийн зөрчил гаргахгүй болтлоо л бид бүх талаар ажиллах ёстой юм. Тэгэхгүй бол эцэг эхчүүдэд байнга ийм нэг сэтгэлд нь сэвтэй, түгшүүртэй, тэгээд өөрөө энэ манай Батлан хамгаалахын салбар, цэргийн албаны нэр хүндийг ингээд унагаадаг. Тийм учраас бид энэ зүйл дээр онцгойлон анхаараад ажиллана гэж тооцож байгаа.

Б.Пүрэвдорж: Мөнхтөрийн Нарантуяа-Нара гишүүн асуулт асууна.

М.Нарантуяа-Нара: Өдрийн мэнд хүргэе. Тэгэхээр төр өөрөө иргэдийнхээ эрүүл мэндээрээ шалгарсан хөвгүүдийг өөрсдөө шалгаж байгаад, сорчлоод, татаж аваад явдаг. Энэ хүүхэд л манайд тэнцэх юм байна, манай албанд тэнцэх юм байна гээд аваад явдаг. Ингээд авч явсан хүүхдүүдээсээ эргээд ар гэрт нь цогцсыг нь буцаадаг, ийм эмгэнэлтэй, гашуун, бүр ийм гаж тогтолцоог халах цаг нь болсон. Энхийн тайван цагт эх орноо хамгаалахад бэлтгэгдээд ирье гээд явсан залуучууд эргэж ирэхгүй, дэндүү олон жил дэндүү олон залуус ар араасаа амь насаа алдлаа. Тэгэхээр нийгмийг цочирдуулсан энэ цэргийн ангиуд дахь хүний эрхийн зөрчлүүдэд цэг тавих цаг нь болсон.

Тийм учраас Салдангийн Одонтуяа гишүүн их зөв хуулийн төслийг өргөн барьсан байна. Үзэл баримтлалын хувьд дэмжиж байгаа. Гэхдээ нөгөө талд хэрэгжүүлэгч газар маань ямар нөхцөл байдалтай байгаа билээ гэдгийг бид харах ёстой. Энэ Хүний эрхийн Үндэсний Комиссын тухай хуульд оруулж байгаа нэмэлт, өөрчлөлт зөвхөн нэг цаас төдий биш, бүр энэ цэрэг эрсийн амь нас, эрүүл мэндийг хамгаалдаг амьд хууль байх ёстой гэж би хувьдаа үзэж байна. Тэгэхээр 3, 4 асуулт асууя.

Хүний эрхийн комиссоос яг одоо цэргийн ангиудтай холбоотой хүний эрхийн зөрчлийн асуудлаар өмнө нь гарч байсан зөвлөмжүүдийн хэрэгжилт өнөөдөр яг ямар түвшинд байгаа юм бэ? Өнөөдрийн түвшинд цэргийн албан хаагчид хүний эрхийн зөрчил, дарамт, хүчирхийллийн талаар айх айдасгүйгээр, ямар нэгэн хараа хяналтгүйгээр мэдээлэл, гомдол гаргах нөхцөл нь яг ямар байгаа юм бэ? ХЭҮК-т энэ хуулиар шинэ чиг үүрэг, ачаалал нэмэгдэх нь байна шүү дээ. Гэтэл Хүний эрхийн Үндэсний Комисс өөрөө цэргийн ангиудад гэнэтийн шалгалт хийх, эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх бодит чадамж, хүний нөөц байгаа юм уу? Энэ бүхнийг хэрэгжүүлнэ гээд байгаа Хүний эрхийн Үндэсний Комисс өөрөө өнөөдөр эрх дархтай хүмүүст нэг өөрөөр үйлчилдэг, иргэд, энгийн эгэл жирийн иргэдэд нэг өөрөөр үйлчилдэг ийм нөхцөл байдалтай байгаа үед энэ хуулийг бид мянга өөрчлөөд үнэхээрийн бодит үр дүн авчрах уу? Жишээлбэл яг энэ Хүний эрхийн Үндэсний Комиссынхон сэтгүүлчид гаргасан дүгнэлтээ яагаад өгөхгүй, тамгаа нуугаад явчихсан байгаа юм бэ? Нөгөө дарга нь гадаад явчихсан байна гэж байна, олдохгүй. Ингэж хүний эрхийг боомилдог хүмүүс өөрсдөө энэ хүний эрхийн хэрэгжилтийг хэрэгжүүлнэ гэхээр яах вэ гэхээр, ийм баахан номууд хэвлээд, бөөн зузаан зузаан тайлан бичээд, энийгээ зүгээр л data report, тайлан энэ нь өөрөө эргээд татвар төлөгчдийн мөнгийг үрэн таран хийдэг ийм юмны нэмэлт юм болчих вий дээ гэдгээс үнэхээр сэргийлэх хэрэгцээ шаардлага байна.

Тэгээд энэ хуулийн төслөөр Хүний эрхийн Үндэсний Комиссын соён гэгээрүүлэх, урьдчилан сэргийлэх чиг үүргийг өргөжүүлж байгаа ч бодит байдал дээр хүний эрхийн зөрчлийг бууруулах яг ямар үр дүн авчрах вэ? Цэргийн албан хаагчдад сургалт орно гэсэн байгаа юм. Тэгээд энэ сургалт чинь яг хэнд чиглэх юм бэ? Цэргийн албан хаагчдын цэргүүдэд юм уу, эсвэл тэд нарыг дэглэж дарамталдаг, тэднээс статус, байр суурийн хувьд өндөр дээд өнөөх офицер, ахлагч, дарга, удирдлагад нь юм уу? Дарга, удирдлагынх нь хандлагыг өөрчлөхгүйгээр цэргүүдэд мянга мянган удаа ч сургалт ороод нэмэргүй байхгүй юу. Тэгэхээр энэ зөвхөн нэг ийм сургалт, семинар гэдэг юмаар хүний эрх цогцолчихгүй. Энэ хяналт, хариуцлага, хэрэгжилтийн хариуцлагын тогтолцоо.../минут дуусав/

Б.Пүрэвдорж: Салдангийн Одонтуяа гишүүн хариулна.

С.Одонтуяа: Нарантуяа-Нара гишүүн дэмжиж байгаад баярлалаа. Би асуултад нь хариулъя. Энэ 2025 оны үйл ажиллагааны тайлан гарсан байгаа, эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үндэсний ажиллагаа гээд. Тэгээд яах вэ, зүгээр миний хувьд би ингээд нэг бүрчлэн үзэхэд эднийх одоогоор 8 хүнтэй ажиллаж байгаа. 8 хүнтэй байгууллага ажиллаад яг энэ олон улсынхаа, байгуулагдаад 4 жил болж байгаа. Тэгэхээр энэ өмнөх байсан нөхцөлөөс нэлээд их олон шат, алхам урагшилсан гэж би харж байна л даа. Бид гэрээ, конвенцын үүргүүдээ биелүүлээд, тайлангаа өгөөд ингээд явж байгаа.

Тайлан өгөх явцад НҮБ дээр ямар асуудал яригдсан бэ гэхээр Эрүүдэн шүүхийн эсрэг хорооноос Монгол Улсад зөвлөмж өгөхдөө, энэ цэргийн байгууллага дахь эрүү шүүлтээс та нар урьдчилан сэргийлэх шаардлагатай байна гэдэг энэ зөвлөмжийг өгсөн. Ингээд бид цэргийн ангиуд дээр энэ сургалтыг, урьдчилан сэргийлэх ажиллагааг хийвэл 27 оны төсөвт тодорхой хүмүүсээр нэмэх шаардлагатай гэж бид урьдчилан тооцоолж байгаа. Яагаад гэхээр энэ 8 хүн маань өнцөг булан бүрд хүрч ажиллахад жоохон боломж багатай. Тэгэхээр санаагаар болдог бол бүс болгон дээр энэ үндэсний ажиллагааг хариуцсан хүмүүс нь байгаад, тухайн бүсийнхээ ажлыг хариуцаад ингээд аль болохоор л энэ урьдчилан сэргийлэх ажлуудыг хийх юм.

Таны асуусан, энэ зөвхөн цэргийн албан хаагчид юм уу гэдэг дээр, цэргийн албан хаагчдаас гадна цэргийн мэргэжлийн удирдлага, захиргааны удирдлага гээд бүх удирдлагууд орох юм. Командлагч, захирагч, тэгээд л цэргийн ангиудын энэ бүх захирагч, удирдлагууд, эд нарт хамгийн гол нь энэ сургалтыг өгнө. Энэ урьдчилан сэргийлэх, энэ үндэсний үйл ажиллагаа явагдсанаар бид ямар үр дүн хүлээж байгаа вэ гэхээр, тэнд алба хааж байгаа хүмүүс, дарга нар ер нь хүний эрхийг зөрчвөл ямар хариуцлага үүрэх юм бэ гэдэг дээр 1 дүгээрт мэдлэг, мэдээлэлтэй болно. Яагаад гэвэл хэрвээ та энэ хүнийг эрүүдэн шүүх юм бол, энэ хүн гомдол гаргаад холбогдох байгууллагууд энэ дээр хэрэг үүсгэх юм бол Эрүүгийн хуулийн 21.12-т заасан эрүүдэн шүүсэн энэ асуудлаар та эрүүгийн хариуцлага хүлээнэ шүү гэдгийг бид тэр алба хааж байгаа хүмүүс болон дарга нар, удирдлагуудад хэлэх юм. Тэгээд энийг зөвхөн энэ үндэсний ажиллагаа хийнэ гэвэл учир дутагдалтай. Тэгэхээр БХЯ-тай энийг нэлээд хамтарч хийнэ гээд ярилцсан байгаа. БХЯ энэ Зэвсэгт хүчин дэх Хүний эрхийн хяналтын зөвлөлөө байгуулаад ажиллаж байна. Энэтэй хамтран ажиллана. Цэргийн албыг эрсдэлээс чөлөөлье гэдэг энэ бүх эрсдэлүүдээ тооцоод ингээд ажиллаж байгаа юм. Тэгэхээр энэ зөвхөн энэ 8 хүний ажил биш, зүгээр санаачилсан нэг хэдэн гишүүдийн.../минут дуусав/

Б.Пүрэвдорж: Мөнхтөрийн Нарантуяа-Нара гишүүн тодруулъя.

М.Нарантуяа-Нара: Тэгэхээр миний хувьд яг энэ хуулийг батлаад, хэрэгжилт дээр нь үнэхээр маш сайн хяналтаа тавихаас гадна, хамгийн гол нь заавал ХЭҮК гээд хүн, хүчний нөөц боломжгүй байгаа тэр газарт ингээд л уяатай байгаад байх биш, маш олон иргэний нийгмийн байгууллагууд хүний эрхийн чиглэлээр бүр дагнаад 10, 20 жил ажиллачихсан, мэдлэг туршлагатай, чин сэтгэлээсээ хүний төлөө явдаг ийм хүмүүс байгаа шүү дээ. Ийм хүмүүсийг оруулж хамтарч ажиллах талаар зөвхөн тэр нэг ХЭҮК-ийн 8 хүнийг хараад суугаад байх биш, ингээд хамтын нөгөө төрийн бус байгууллагуудыг ч гэсэн, иргэний нийгмүүдийг ч гэсэн оролцуулах байдлаар хийх нь зүйтэй. Тэгээд энд чинь ингээд явуулахаар чинь санхүүгийн

асуудал юу яах нь байна, тэгээд дахиад нөгөө нэг баахан л төсөв үрээд л, нэг дүнгүй, үр дүнгүй формаль ийм сургалт болоод өнгөрчих вий дээ гэдэг дээр үнэхээр бид, ялангуяа хууль санаачлагч маш олон.../минут дуусав/

Б.Пүрэвдорж: Одонтуяа гишүүн хариулъя.

С.Одонтуяа: Бид энэ үндэсний үйл ажиллагааг ер нь ямар хэмжээнд явуулах вэ гэдгээс хамаарна. Жишээлэхэд бид ер нь энэ салбар дахь хүний эрхийн зөрчлийг арилгах талаар нэлээд бүр дорвитойхон, ингээд яг энэ хууль батлагдсаны дараа тогтоол гаргаад дорвитойхон ажиллая гэвэл зардал мөнгө гаргаад явах хэрэгтэй. Жишээлэхэд бензин тосны зардал гээд ингээд л улс орон даяар энэ цэргийн ангиудад хүрч ажиллах ийм шаардлагатай болно. Таны хэлж байгаа тэр иргэний нийгмийн байгууллагууд, ТББ-тай хамтарч ажиллах хэрэгтэй гэдэг дээр санал нийлж байна. Тэд нөгөө иргэдийн хяналт гэдгийг маш сайн тавьдаг. Жишээлэхэд нэг хүн хохирогчоос гомдол гараад тэр гомдол нь дарагдах биш, тэр гомдол аль болохоор дарагдахгүй, үнэн зөв, шударга ингээд шийдээд, тэр буруутай этгээдүүд нь хариуцлагаа хүлээдэг ийм систем рүү явах ёстой. Тэгээд ер нь бид нэг шинэ шатанд гаргаад энэ.../минут дуусав/

Б.Пүрэвдорж: Нэмж Мөнхтөрийн Нарантуяа-Нара гишүүн тодруулъя.

М.Нарантуяа-Нара: Тэгээд нэгэнт энэ асуудлыг хэлэлцэж байгаа дээр, салбарын сайд нь сууж байгаа дээр асуулт асуумаар байна. Батлут сайдаа, сая өнгөрсөн хугацаанд, 2 долоо хоногийн өмнө нас барсан цэргийн албан хаагч, цэрэг залуугийн амь насанд хэн хариуцлага хүлээсэн бэ танай салбарт 1 дүгээрт?

2-рт ар гэр бүлд нь, ямар үр хүүхдээ алдсан тэр айлд юу гэдэг юм, нөхөн төлбөр ч гэдэг юм уу, ийм ямар арга хэмжээ авав? Зүгээр нэг уучлаарай гээд зогсчхов уу, эсвэл хэдэн төгрөг өгөөд аргалчхав уу, яав? Цаашлаад ингээд байгаад байх уу? Өнгөрсөн хугацаанд энэ асуудлаар ярьснаас хойш маш олон амь нас, эрүүл мэндээрээ хохирсон цэргүүдийн ар гэр бүл над руу холбогдоод байгаа. Тэгэхээр энэ дээр нэг хариулт авчихмаар байна.

Б.Пүрэвдорж: Батлут сайд хариулъя.

Д.Батлут: Нарантуяа-Нара гишүүний асуултад хариулъя. Батлан хамгаалах салбар, Зэвсэгт хүчинд иргэний хяналтын чиглэлийн үйл ажиллагаа, хяналтыг хэрэгжүүлж ажилладаг. Зэвсэгт хүчний анги салбар дээр болсон асуудал, тухайлбал, 339 дүгээр анги дээр 2 хугацаат цэргийн албан хаагч, байлдагчид харилцааны зөрчил гаргаснаас үүдэж нэг нь амь насаа алдсан ийм харамсалтай хэрэг гарсан. Одоогоор хууль хяналтын байгууллага шалгаж байна, эцсийн дүгнэлт гараагүй байгаа. Бид ар гэр дээр нь очиж уулзсан, хүн ёсны, хүн ёсоор хандаж асуудалд оролцсон байгаа гэдгийг хэлэх нь зүйтэй. Цаашлаад энэ гэм буруутай нөхцөлүүд нь тодорхой болоод ирсний дараа холбогдох арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлнэ. Мөн хууль, дүрмийн хүрээнд энэ ар гэрт нь тодорхой хэмжээний асуудлуудыг шийдвэрлэх боломжууд гарах байх гэж бодож байгаа. Ер нь үүнийг ярьсан дээр тодорхой.../минут дуусав/

Б.Пүрэвдорж: Батлут сайд нэмж тодруулъя.

Д.Батлут: Ер нь бид энэ хугацаат цэргийн албан хаагчидтай холбоотой асуудал дээр онцгой анхаарлаа хандуулах ёстой. Тэр ч утгаараа бид Хүний эрхийн Үндэсний Комисстой хамтарч 1100 гаруй албан хаагчдыг хамруулан сургалтуудыг зохион байгуулж, өнөөдрийн Хүний эрхийн Үндэсний Комиссоос батламж авсан 78 сургагч багшийг бэлтгэж гаргаад анги, салбаруудаар ажиллуулж байгаа. Сэтгэл зүйчдийн хөдөлгөөнт бүлгүүдийг байгуулж, анги, салбаруудаар ажиллуулж хэвшсэн гээд олон зүйлүүдийг бид өнгөрсөн хугацаанд хийсэн байна. Цаашлаад энэ цэргийн анги, салбарыг тодорхой эрсдэл гарахаас хамгаалах чиглэлээр 7 реформын шинж чанартай үйл ажиллагаануудыг авч хэрэгжүүлэхээр Ерөнхий сайдаас чиглэл болгосны дагуу бид үйл ажиллагаагаа явуулж байгаа. Түүнээс гадна бид хүүхдүүдийг хэрхэн хүмүүжүүлэх вэ гэдэг дээр онцгой анхаарах ёстой гэж харж байгаа.

Б.Пүрэвдорж: Дахиад нэмж хариулъя.

Д.Батлут: Энэ утгаараа бид Боловсролын яамтай хамтраад, би ажил авсан цагаасаа хойш судалгааны ажлууд хийгдсэн, ерөнхий боловсролын сургуулиудад хүн байхын тухай, цэрэг эх оронч хүмүүжил олгох тухайд, өөр өөрийгөө хамгаалах чадамжид суралцах тухайд, үүх түүх, соёлоос суралцах тухай заавал суралцдаг хичээлийг оруулдаг болгохоор бид зохион байгуулалтын арга хэмжээ аваад явж байна. Удахгүй Боловсролын яамтайгаа ярьж байгаад хичээлийн программд нь оруулах, дээрээс нь сурах бичгүүдэд тодорхой сэдвүүдийг оруулж өгөх ажлууд хийгдэх гээд ингээд хүлээгдээд явж байгаа зүйл байна. Энэ нь эргээд энэ хүүхдүүдийг зөв хүмүүжилтэй, зөв төлөвшилтэй, нийгмийн харилцаанд зөв ордог ийм нөхцөл байдалд сургах, цаашлаад цэргийн алба болоод бусад чиглэлд чадамжтай бие хүн болгож төлөвшүүлэх, мөн үндэсний сөрөн тэсвэрлэх чадамжийг шинэ түвшинд гаргахад ч гэсэн томоохон өөрчлөлтүүдийг бий болгоно гэж харж байгаа юм. Цэргийн амь нас үрэгдсэн нь харамсалтай хэрэг. Тэгэхдээ.../минут дуусав/

Б.Пүрэвдорж: 2024 оны 11 сард байх аа, Сайнзориг гишүүнээр ахлуулаад эрүү шүүлт тулгах, хүнлэг бус, хэрцгий хандахаас ангид байх хүний эрхийн хэрэгжилтийн талаар сонсгол явж байсан. Тэгээд манай Одонтуяа гишүүн энэ дээр нэлээн идэвхтэй оролцсон. Энэ Зэвсэгт хүчний жанжин штаб, БХЯ-наас ч гэсэн оролцож байсан. Тэгэхээр ингээд энэ мэдээж энэ сургалт, бүх зүйл явна, офицер, ахлагч нар илүү хариуцлагатай болох ийм шаардлага гарч ирж байна. Үүнийхээ хажуугаар яг тэр офицер, ахлагч нарын амралтын үеэр, шөнө оройн цагаар энэ асуудлаар тодорхой камерын хяналт юм уу, аль эсвэл онлайн байлгах, тэр хүмүүсийн хөдөлгөөн энэ тэр бүх зүйлийг хянах энэ асуудал дээр тодорхой хөрөнгө оруулалтыг гаргаж, энэ асуудлаар шийдэж байгаа ажил байгаа юу? Энэ талаараа, энэ чинь тухайн үеийн сонсголын дүгнэлтээр энэ асуудлыг шийдэх ёстой гэж үүрэг өгсөн шиг санагдаж байна, тэгээд энэ дээр нэг хариулт өгөөч? Батлан хамгаалахын сайд Батлут.

Д.Батлут: Камержуулалтын түвшинд бид улсын төсөв дээр батлагдсан төсвийнхөө хүрээнд анги салбаруудаа камержуулсан. Ангийн удирдлагууд ерөнхийдөө камерын хяналтаа хийгээд явж байгаа. Одоо харин бид энэ камерын хяналтыг ЗХЖШ дээр 24 цагийн хяналтад оруулах чиглэлээр ажиллаж байгаа. Цахим хөгжлийн яамтай хамтраад тодорхой хөрөнгө оруулалтын асуудлуудыг нь төлөвлөж гаргаж ирээд хийж, хэрэгжүүлье гэж бодож байгаа. Түүнээс гадна камерын хяналт байхгүй бие засдаг газар, усанд ордог газруудыг ч гэсэн чанга яригч

болон яаралтай тусламж үзүүлэх улаан кнопуудыг байршуулах, тэрийг авч хэрэгжүүлэх ажлуудыг хийж хэрэгжүүлэхээр болж байгаа юм.

Өнөөдөр манай Монгол Улсын Зэвсэгт хүчний нөхөн хангалт 58 хувьтай явж байгаа. Тэр дундаа хугацаат цэргийн албан хаагч нартай ажилладаг салаан захирагч, ротын захирагчид 30-хан хувийн хангалттай явж байгаа. 30-хан хувийн. Энэ нь бидний хувьд гамшиг гэсэн үг яг үнэндээ. Үүнийг шийдэхийн тулд бид төсөв хөрөнгөтэй холбоотой асуудал яригдана. Харин өнгөрсөн 5, 6 жилийн хугацаанд Монгол Улсын Зэвсэгт хүчинд бага ч гэсэн хөрөнгө оруулалт хийдэг болчихсон, ингээд тодорхой асуудлуудыг бид шийдээд явж байгаа нь үнэн. Гэхдээ тулгамдаж байгаа олон асуудлууд бий. Дор хаяж хүний нөөцийн нөхөн хангалттай холбоотой асуудлыг ч гэсэн авч үзэж шийдэхгүй бол хугацаат цэргийн албан хаагчтай нүүр тулж уулзаж, тэр хүүхдүүдийн аав, ээжийн оронд нь аав, ээж нь болж, 24 цагийн хугацаанд ингэж харж хамгаалж, хамтарч ажилладаг энэ хүмүүсийг бэлдэж гаргаж ажиллуулахгүй бол яг өнөөдөр хугацаат цэргийн албан хаагчтай ажиллах хүний нөөц хомсдолтой болчихсон. Энэ ч гэсэн тодорхой нөлөөллийг үзүүлж байгаа гэж харж байгаа. Тэгээд энэ нөхөн хангалтыг бүрэн дүүрэн хийж чадахгүй бол үнэхээр асуудал бий.

Энэ дээр ч гэсэн манай УИХ-ын гишүүд нөхцөл байдлыг зөв ойлгож, очиж үзэж, танилцаж, асуудлыг өргөн хүрээнд авч үзээсэй гэж харж байгаа. Энэ Зэвсэгт хүчинд хийх хөрөнгө оруулалтуудыг нэмэгдүүлээсэй гэж харж байгаа. Өнөөдөр геополитикийн нөхцөл байдал ямар байгааг та бүхэн бүгдээрээ мэдэж байгаа. Энэ Монгол Улсын аюулгүй байдлыг батлан хамгаалдаг энэ салбарыг чадавхжуулах, хүний нөөцийг бэхжүүлэх, техник, тоног төхөөрөмж, өнөө цагийн дэвшилтэт тоноглолоор тоноглуулах, хөрөнгө оруулалт хийх энэ тэр олон асуудлууд бий. Гэтэл өнөөдөр төсөв хөрөнгө ямар байгаа билээ гээд бүгдээрээ бодох ёстой асуудлууд зөндөө бий. Тийм учраас УИХ-ын гишүүд ч гэсэн энэ асуудал дээр онцгой анхаарч, ирэх он жилүүдэд энэ хөрөнгө оруулалтын хэмжээг нэмэгдүүлэх тал дээр ч гэсэн илүү санаачилгатай ажиллаж өгөөсэй гэж хүсэж байгаа. Энэ өөрөө аливаа эрсдэлүүдээс хамгаалах, эрсдэлгүй байх боломжид томоохон нөлөөлөл үзүүлэх ийм хөрөнгө оруулалт болно гэдгийг хэлэх нь зүйтэй байх. Баярлалаа.

Б.Пүрэвдорж: Зочин танилцуулъя. УИХ-ын гишүүн Д.Үүрийнтуяагийн урилгаар Орхон аймгийн Баян-Өндөр сумын Эрдэнэ багийн ахмадууд УИХ-ын үйл ажиллагаа болон Төрийн ордонтой танилцаж байна. Та бүхэнд эрүүл энх, сайн сайхан бүхнийг нийт гишүүдийн өмнөөс хүргэе. Гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа. Хуулийн төслийн талаар Байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг дэмжсэн, эсрэг байр суурьтай намын бүлгийг төлөөлж болон бүлэгт харьяалагддаггүй гишүүдээс урьдчилан ирүүлсэн нэрсийн дагуу гишүүд дэмжсэн, дэмжээгүй байр сууриас үг хэлнэ. Мөнхтөрийн Нарантуяа-Нара гишүүн, индрийн 2-р микрофон.

М.Нарантуяа-Нара: Баярлалаа. Тэгэхээр өнөөдрийн энэ нийгэмд үнэхээр хүний эрхийн зөрчилтэй, сэтгэл эмзэглүүлэм олон, олон асуудлууд гарч байгаа, тэр дундаа цэргийн армид, цэрэг, цэргийн албан хаагчдын дунд маш ийм ноцтой асуудал гарч байгаа үед чухал хуулийн төсөл орж ирж байгаад талархалтай байгаа, дэмжиж байгаа. Хамгийн гол нь бид яг энэ хууль, өдөр болгон л маш олон, олон хуулиуд баталж байна. Гэхдээ энэ хуулиуд эргээд хэрэгжилт дээрээ ямар байх вэ, хэрэгжилтээ хэрхэн хангах вэ, хангаж байгаа хэрэгжилтийг хэрхэн хянах вэ гэдэг дээр бид үнэхээр байнгын анхаарлаа хандуулж байх ёстой. Тэгэхээр хууль

санаачлагчийн хувьд хууль батлуулаад орхих биш, эргээд энэ хуулийн хэрэгжилт яг ямар байна вэ гэдэг дээр маш сайн анхаарч ажиллаасай гэж хүсэж байгаагаа илэрхийлье.

Тэгээд цэргийн албанд дүрмийн бус харилцаа үүсэж, хүний эрх зөрчигдөж байгаагийн гол шалтгаан ерөөсөө л тэнд хяналт шалгалт дутагдсан болон мөн тэнд суурь соёл, хүний эрхийн боловсрол, соёл дутагдаж байгааг онцолж үзэх ёстой. Тэгэхээр салбарын сайд нь энэ талаар сургалт, арга хэмжээг авахаар явж байгаад нэг бодлын талархалтай байна. Гэхдээ энэ салбарт үхсэний хохь, амьдын зол байж болохгүй. Цаашид нэг ч хүн амь нас эрсдэхгүй, эрүүл мэндээр доройтохгүй байх талаас үнэхээр зөвхөн Хүний эрхийн Үндэсний Комисс гэхгүй, бүх шатанд хяналт шалгалтыг байнга тогтмол хийж байх ёстой гэсэн ийм байр суурьтай байгаа.

Тэгээд хамгийн гол нь энэ сургалт, соён гэгээрүүлэх, нөлөөллийн арга хэмжээг зөвхөн цэргийн албан хаагчдад биш, тэр нөгөө дэглэм үүсгэдэг дарга нарт нь чиглүүлэхэд, бас тэр цэргийн ангийг удирдаж байгаа офицер, ахлагч болон бүх шатны сайдаас нь авхуулаад бүх шатны удирдлагад энэ мэдлэг, хандлагыг олгох нь зүйтэй гэж бодож байна. Тэгээд энэ нэмэлт, өөрчлөлт нь зөвхөн төсөв үрэх биш, хамгийн гол нь дорвитой, бодит үр дүнг хэмжихийн тулд одоо байгаа нөхцөл байдлыг хэмжиж, ямар хэмжээтэй байснаас энэ нэмэлт хууль хэрэгжсэнээс ямар үр дүнд хүрэх вэ гэдгийг хэмжихийн тулд одоо байгаа нөхцөл байдлыг тодорхой болгох ийм шаардлага байгаа шүү, тэрийг сайн анхаараарай гэж хэлмээр байна. Ингээд энэ хуулийг үзэл баримтлалын хувьд дэмжээд, цаашдаа хэлэлцүүлгийн явцад нэмэлт шинэ, шинэ санаануудыг нэмэрлээд явъя гэж бодож байна, баярлалаа.

Б.Пүрэвдорж: Яг энэ хуулийг хэлэлцэж байх явцад, Одонтуяа гишүүнээ, над руу ингээд мессеж ирж байна. "Зэвсэгт хүчнээс гадна Дотоодын цэргийн амь насны тухай асуумаар байна. 809 дүгээр ангиас 2025 оны 11 сарын 20-нд нас барсан цэргийн албан хаагчийн гомдлыг шийдвэрлэмээр байна" гэж, тэгээд би танд утасны дугаарыг нь өгчихнө, та энэ талаар санаа тавиарай. Хүрэлбаатарын Баасанжаргал гишүүн үг хэлнэ, индрийн 1 дүгээр микрофон.

Х.Баасанжаргал: Эрхэм сайдыг анхаарлаа хандуулаад суугаасай гэж хүсэж байна.

Б.Пүрэвдорж: Батлут сайд. Минутыг эхнээс нь өгье.

Х.Баасанжаргал: Баярлалаа. Яагаад би сайд бөгөөд хууль санаачлагч, ХЭҮК гээд энд байгаа бүх оролцогч талууд, энэ олон эрх ашиг нь хөндөгдсөн, эрх нь зөрчигдсөн, нас барсан цэргүүдийн өмнө бүгд хариуцлага хүлээх ёстой үүрэг хүлээгчид сууж байгаа учраас хэд хэдэн зүйлийг энэ индэр дээрээс хэлэх нь зөв байх гэж бодож байна. Өнгөрсөн хугацаанд ХЭҮК-оос нийтдээ 133 удаагийн хяналт шалгалтыг цэргийн ангиудад явуулжээ. Энэ бага тоо биш. Нэг удаа биш, 2 удаа биш, нийтдээ 133 удаагийн хяналт шалгалт явуулсан байна. Энэ хүрээндээ нийтдээ 30 гаруй удаа, 80 гаруй зүйл, заалт бүхий зөвлөмжийг БХЯ, холбогдох цэргийн удирдлагуудад хүргүүлж байжээ.

2-рт, нийтдээ 3 мянга гаруй цэргийн алба хаагчдад зориулсан сургалт, үйл ажиллагааг өнгөрсөн 3 жилийн хугацаанд зохион байгуулжээ, 47 ийм сургагч багш бэлтгэжээ. Гэхдээ надад юу олдсонгүй вэ гэвэл, энэ бүх зөвлөмж, хяналт шалгалтын үр дүнд хэнд ямар хариуцлага тооцсон бэ гэдэг мэдээлэл хаана ч байхгүй байна.

Хэн хариуцлага хүлээсэн юм, бүгд хохироод дуусаж байгаа юм уу, яриад дуусаж байгаа юм уу. Зүгээр л яриад дуусдаг ийм сэдэв байх ёсгүй гэж бодож байна. Тэгэхээр энэ хариуцлагын асуудлуудыг бид дараагийн чуулганаар ярих ёстой, өнгөрсөн хугацааны энэ бүх үйл явдалд хэн, ямар хариуцлага хүлээсэн юм, цэргийн анги, удирдлагууд ямар хариуцлага хүлээсэн юм гэдэг мэдээллийг ил тод, тодорхой болгох ёстой.

2-рт, бид хувь хүнд найдсан тогтолцоо биш, тогтолцоо өөрийгөө засдаг болох энэ системийн өөрчлөлтийг хийх хэрэгтэй гэж харж байна. Бид сайн хүнийг цэрэгт авах тухайд биш, хохирогчийг буруутгах тухайд биш, хүмүүжилтэй хүүхдүүд цэрэгт явах тухайд ерөөсөө бид ярих ёсгүй, тэр дундаа БХЯ хохирогчийг буруутгасан ийм өнгө аястай, ийм мэдэгдэл, ийм агуулга, ийм байр суурийг цаашид битгий илэрхийлээсэй гэж бодож байна. Энэ БХЯ-ны хийх ёстой ажил биш, энэ өөр бусад салбаруудын хийх ёстой асуудал. Харин БХЯ юу хийх вэ гэвэл, урьдчилан сэргийлэхийн тулд ямар механизм, ямар зүйлүүдийг хийх ёстой вэ гэдэгтээ илүү анхаарал хандуулах ёстой.

Гэхдээ бид зөвхөн мөнгө, санхүүгийн асуудлаар түрүү бариад дуусаж болохгүй. Хийж болох ёстой, боломжтой маш олон зөвлөмжүүдийг Монгол Улсад олон улсын байгууллагууд өгч иржээ. Түүний 1 дүгээрт ХЭҮК-оос удирдлагуудад, анги, ангийн удирдлагуудад огт мэдэгдэхгүйгээр гэнэтийн хяналт шалгалтыг тогтмол, байнга зохион байгуулаач гэдэг зөвлөмжийг удаа дараа хүргүүлжээ. Энэ тухай мэдээлэл, тайланг би хаанаас ч хайгаад олсонгүй. Яг хяналт шалгалтыг хийхдээ гэнэтийн хийдэг юм уу, хэлж хийдэг юм уу, төлөвлөгөөт юм уу гэдэг мэдээлэл хаана ч байхгүй байна. 2-рт цэргүүдтэй уулзах, гэхдээ огт удирдлагуудын оролцоогүйгээр цэргүүдтэй уулзаж мэдээллийг цуглуулах хэрэгтэй. 3-рт цэргүүд энэ талаарх мэдээлэл, гомдол, эрүү шүүлттэй холбоотой, эрх нь зөрчигдөж байгаа асуудлын талаар мэдээлэл хэлдэг нууц сувгуудыг бий болгох хэрэгтэй байна. Энд мөнгө ерөөсөө бараг шаардлагагүй. Яаж ХЭҮК-той холбогдох хүнтэй шууд холбогдох юм, анги, удирдлагуудын хяналтгүйгээр яаж энэ гомдлыг хэлдэг байх юм. Дээрээс нь ингэж мэдээлэл гаргасан цэргийг яаж хамгаалах ёстой юм бэ гэдэг дүрэм, журам бидэнд ерөөсөө байхгүй байгаад байна, үүнийг бий болгох хэрэгтэй гэж харж байна.

3-д сэтгэл зүйн дэмжлэг маш их хэрэгцээ шаардлагатай байна. Бид энэ сэтгэл зүйн үйлчилгээг зөвхөн мөнгөө төлөөд авдаг үйлчилгээ, эсвэл энийг эрүүл мэндийн үнэхээр хүндэрчихсэн хүний үйлчилгээ гэж бид бүгдээрээ харж болохгүй. Цэрэгт авахдаа эрүүл мэндийн үзлэг, шинжилгээ, бие махбодын үзлэг, шинжилгээ хийдэг шиг бүх цэргүүдийн сэтгэл зүйн эрүүл мэндийн үнэлгээг хийгээд, хамгийн эрсдэлтэй цэргүүддээ тусгайлсан хөтөлбөр, тусгайлсан сэтгэл зүйн зөвлөгөө явдаг энэ тогтолцоог бий болгох хэрэгтэй. Харьцангуй сэтгэл зүйчид БХЯ-нд ажилладаг юм байна гэж харсан, гэж ойлгож байгаа, сүүлийн үед авч байгаа арга хэмжээнээс нь харвал. Тэгвэл үүнийгээ эрсдэлтэй цэргүүд рүүгээ илүү шилжүүлэх ийм хэрэгцээ шаардлагатай байна. Гэхдээ эрсдэлтэй.../минут дуусав/

Б.Пүрэвдорж: Баярлалаа. Чинбатын Ундрэм гишүүн индрийн 1 дүгээр микрофоноос үг хэлнэ.

Ч.Ундрэм: Эрүүдэн шүүлтээс урьдчилан сэргийлэх зорилгоор, тэр дундаа цэргийн ангид урьдчилан сэргийлэх шаардлагатай байна гэж үзээд энэ хуулийг өргөн барьсан. Энэ зорилго, үзэл баримтлалыг би дэмжиж байгаа юм. Гагцхүү энэ

Монгол Улсын ХЭҮК-ын тухай хуулийн 33.1.2-т "цэргийн албан хаагчдад сургалт оруулна" гэж энэ агуулгыг нэмснээрээ бид бүрэн урьдчилан сэргийлж чадах уу, үгүй юү гэдэгт би нэлээн эргэлзээд байна л даа. Одоо тэртээ тэргүй байгаа заалтад нь "төрийн албан тушаалтан, иргэдэд сурталчлах" гээд орчихсон байгаа байхгүй юу. Тэгэхээр төрийн албан тушаалтан болон иргэд гэдэгт чинь энэ агуулгад чинь дарга нар нь албан тушаалтан, иргэд гэдэгт нь нөгөө цэргүүд маань орчхож байна гэж би үзээд байгаа юм. Хэрвээ нэгэнт цэргийн албан хаагчид сургалт зохион байгуулна гэж орж байгаа бол ерөнхийдөө энэ дээр нэмээд, энэ цэргүүд чинь ЕБС-д сурагч байж байгаад орж ирж байгаа шүү дээ. Тэгэхээр ЕБС-ийн хөтөлбөрт нь тэр хүний эрхтэй холбоотой, хууль, эрх зүйтэй холбоотой хичээлийн хөтөлбөрт нь давхар оруулна гээд яг энэ заалт дээрээ нэмээд оруулчихвал энэ хуулийн ач холбогдол өндөрсөх юм болов уу гэж бодож байгаа. Герман, Финланд улсад ЕБС-ийн хөтөлбөрт энэ асуудал ордог юм билээ.

Тэгээд эргээд Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын одоогийн төсвийг нь харлаа л даа. Бид энэ жил 14.9 тэрбум төгрөг л баталж өгсөн байна. Энэний 13.4 тэрбум нь урсгал зардал, цалин, НДШ-тэй л явчихдаг. Тэгэхээр үндсэндээ бүтэн жилийн турш 1.5 тэрбум төгрөгөөр энэ олон байгууллагын асуудлууд дээр хяналт шалгалт хийх, сургалт зохион байгуулах гээд ийм их ажлыг нугалдаг ийм байгууллага байгаа юм. Тэгэхээр бид "Ийм ажил чи хийх ёстой" гэж заачхаад, араас нь төсөв санхүү, бүтэц гээд энэ бүх хүчин чадлыг нь шийдэж өгөхгүй болохоор зүгээр л нэг ийм юм хий гээд нэг хүслээ хэлээд байгаа юм шиг болчихоод байна. Тэгэхээр энэ хуульдаа бараг ингээд төсөв нь тийм зүйлүүдийг хамрах ёстой ч гэдэг юм уу бүр ингэж оруулж өгвөл яасан юм бэ?

Энэ байгууллага нь өөрөө нэг шүдгүй арслан шиг л ер нь байдаг шүү дээ. Хяналт тавьдаг, сургалт зохион байгуулдаг, илрүүлдэг, шаардлага л хүргүүлдэг, ингээд л болчихдог. Тэгэнгүүт бид асуудал гарлаа, Хүний эрхийн Үндэсний Комисс руу л ерөөсөө бүгд уурладаг. Гэтэл энэ байгууллага чинь өөрөө хариуцлага тооцдог байгууллага биш. Хариуцлага тооцдог газар нь прокурор, хууль хяналтын байгууллагууд эргээд байж байдаг, тийм ээ. Гэтэл энэ байгууллагууд дээр чинь бас л эрүүдэн шүүхтэй холбоотой асуудлууд яригддаг. Тэгэхээр энийг бид илүү боловсронгуй болгож өгөх ёстой юм биш үү.

Үүнээс гадна миний нэмж хэлмээр байгаа зүйл нь, энэ НҮБ-ын Committee against Torture буюу Эрүүдэн шүүхийн эсрэг энэ зөвлөлөөс гаргасан, боловсруулж улс орнууд нэгдсэн конвенцын нэмэлт протоколыг үндэслэж та энэ хуулийн төслийг өргөн барьсан байна. Энэ нэмэлт протокол дээр эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар хүний нэр төрийг доромжлон харьцах, шийтгэх явдлаас урьдчилан сэргийлэх гэж байна. Тэгэхээр энэ ганцхан бие махбодын асуудлаас илүү өргөн хүрээнд яригдах ёстой. Өнөөдөр сошиал дээр хүмүүсийг янз бүрээр эрүүдэн шүүж байна шүү дээ, доромжилж байна. Өөрсдөө мэдэхгүй, хууль хяналтын байгууллага тогтоогоогүй байхад тэр хүнийг буруутан мэтээр бараг цаазын тавцанд аваачиж байна шүү дээ. Тэр хүний сэтгэл санааны хохирол өчнөөн асуудал. Тэгэхээр бид ганцхан бие махбодын хүрээ хэмжээнд биш, илүү өргөн хүрээнд өнөөдөр энэ асуудлыг ярихгүй бол өнөөдөр сошиал ертөнц хөгжчихсөн, хүний сэтгэл санаа, энэ амиа хорлолтын статистикийг ч гэсэн жил болгон бид хараад эмэгтэй хүний хувьд, эмэгтэй гишүүдийн хувьд сэтгэл шимшрээд ярьж суугаа шүү дээ. Тэгэхээр ийм өргөн хүрээнд.../минут дуусав/

Б.Пүрэвдорж: Баярлалаа. Санал хураалтыг нэгтгэж явуулна, түр хойшлуулъя.

15.32 цаг

Дөрөв.Улсын бүртгэлийн ерөнхий хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүд /Улсын Их Хурлын гишүүн П.Сайнзориг нарын 37 гишүүн 2026.05.29 -ний өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/

Дараагийн асуудалдаа оръё. Улсын бүртгэлийн ерөнхий хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүдийг хэлэлцэх эсэх хэлэлцүүлгийг явуулна. Хууль санаачлагчийн илтгэлийг УИХ-ын гишүүн Пүрэвжавын Сайнзориг танилцуулна. Индэрт урьж байна.

П.Сайнзориг: УИХ-ын дэд дарга, эрхэм гишүүд ээ,

УИХ-ын нэр бүхий 37 гишүүн хамтран Улсын бүртгэлийн ерөнхий хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг боловсрууллаа. Сүүлийн жилүүдэд орон сууцны захиалгын гэрээтэй холбоотой маргаан, залилангийн шинжтэй үйлдэл нэмэгдэж, иргэдийн хөрөнгө, цаг хугацаа, хууль ёсны ашиг сонирхолд ихээхэн хохирол учруулах боллоо. Төр, түүний байгууллагаас хууль ёсоор тусгайлан хамгаалбал зохих нууцад хамаарахаас бусад мэдээллийг иргэд, хуулийн этгээд хуульд заасан үндэслэл, журмын дагуу хүлээн авах нь хууль бус үйлдэл, санхүүгийн гэмт хэргийн хохирогч болж хохирохоос урьдчилан сэргийлэх чухал алхам гэж үзэж байна.

2018 оны 6 дугаар сарын 21-ний өдөр батлагдсан Улсын бүртгэлийн ерөнхий хуулийн 12 дугаар зүйлийн 12.1-д улсын бүртгэлийн мэдээллийн нэгдсэн сангийн мэдээлэл нээлттэй, хаалттай, хязгаартай буюу хуулиар тогтоосон шаардлага хангасан этгээдэд өгнө гэж заан хуульчилж, нэрийн сан, хаягийн сан, хуулийн этгээдийн нэр, хаяг, регистрийн дугаар, төрөл, хэлбэр, үйл ажиллагааны чиглэл зэрэг мэдээлэл нь нээлттэй байхаар тогтож, улсын бүртгэлийн байгууллагаас зарим иргэд мэдээллийг авч танилцах боломж нэгэнт тогтсон практик болон хэвшиж байна.

21 оны 12 дугаар сарын 17-ны өдөр батлагдсан Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуульд мөн нийтийн мэдээллийг нээлттэй, хязгаартай, хаалттай гэж ангилсан бөгөөд нийтийн мэдээллийг ашиглахад хуульд зааснаас бусад тохиолдолд иргэний мэдээлэл авах эрх, эрх чөлөөг үл хязгаарлах, төрийн байгууллагын үйл ажиллагаа олон нийтэд ил тод, нээлттэй байх, хүн, хуулийн этгээд хуулиар хязгаарлалт тогтоогоогүй аливаа мэдээллийг саадгүй олж авах нөхцөл боломжийг бүрдүүлэх замаар иргэд орон сууцны захиалгатай холбоотой харилцаанаас үүсэх хөрөнгө санхүү, цаг хугацаа, гэрээний харилцаанаас үүсэх эрсдэлийг бууруулах, сэргийлэх боломжтой гэж үзэж байна.

Барьж дуусаагүй барилгыг улсын бүртгэлд бүртгүүлж, өмчлөх эрхийн гэрчилгээ авсан иргэн, хуулийн этгээд нь тухайн барилгыг удаан хугацаатай, өндөр хэмжээний зээлийн авч, мөн барьцаанд тавьдаг. Үүний улмаас тухайн захиалгын гэрээ байгуулж хөрөнгө оруулсан иргэн, хуулийн этгээд өөрийн өмчлөлд бүртгүүлэх процесс удааширдаг, эрсдэлд ордог тохиолдлууд ч мөн газар авсан байна. Мөн

тухайн зээл авсан барилгын компани нь төлбөрөө төлөөгүйн улмаас мөн бусад асуудлаар хууль хяналтын байгууллагад шалгагдаж, нийтийн зориулалттай дуусаагүй барилгыг захиран зарцуулах эрхийг түдгэлзүүлэх тохиолдол багагүй гардаг. Иймд Иргэний хуулийн 145.2-т заасны дагуу эрхийн улсын бүртгэлд бүртгүүлсэн хэлцэл болон барьж дуусгаагүй барилга дээр үл хөдлөх эд хөрөнгийн эрхийг бүртгүүлэх тухай шаардлагыг хангах агуулга бүхий нийтийн зориулалттай орон сууцны захиалгын гэрээний хэсгээр барьцаанд тавихыг хязгаарлах нь давхардуулан хөрөнгө босгохоос сэргийлэх буюу зээл олгож буй банк, санхүүгийн байгууллага болон орон сууцны захиалгын гэрээ байгуулж хөрөнгө оруулсан этгээдийн эрх ашгийг хамгаалах ач холбогдолтой гэж үзэж байна.

Одоо үйлчилж буй хууль, эрх зүйн хүрээнд бүх дуусаагүй барилгыг улсын бүртгэлд бүртгэдэггүй, сайн дурын үндсэн дээр явж ирсэн учраас иргэдээс захиалгын гэрээг авахдаа улсын бүртгэлд бүртгүүлээгүй барилга дээр захиалга авдаг, тухайн барилга нь цаашид хэрхэн ямар эрхийн шаардлагууд хангагдах эсэх талаар мэдээлэл тодорхойгүй байна. Энэ хүрээнд иргэдээс давхардуулан захиалга авч, иргэд, хөрөнгө оруулагчдыг хууран мэхлэх тохиолдол ч олон байгааг хууль хяналтын байгууллага дурдаж байна. Тухайлбал, сүүлийн 3 жилд орон сууцны захиалга авч бусдыг залилах гэмт хэргийн төлөв байдлыг судалж, дүн шинжилгээ хийхэд 3613 иргэнд 204.9 тэрбум төгрөгийн хохирол учирсан байгаа бөгөөд Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаанд 300 гаруй хохирогчийн 15 орчим тэрбум төгрөгийн хохирол барагдуулах ажиллагаа явагдаж байна.

Мөн барьж дуусаагүй нийтийн зориулалттай орон сууцны барилгын ажлыг эхлэхэд тухайн барилга байгууламжид албан ёсны хаяг эсвэл урьдчилсан хаягийн зохицуулалтыг олгодоггүй бөгөөд уг урьдчилсан хаягийн зохицуулалтыг шинээр бий болгох шаардлагатай гэж үзэж байна. Одоо бүртгэлийн практикт барилгын компани өөрийн төслийн нэрээр нэрлэж, "А, Б блок" гэх зэргээр өөрсдийн үзэмжээр хаягийг олгож, үүн дээрээ захиалга авдаг бөгөөд сүүлд тухайн барилга нь ашиглалтад орсны дараа хаяг өөрчлөгдөж, гэрээний маргаан үүсэх, дээрээс нь эрх ашгаа хамгаалуулахад иргэдийн хувьд хүндрэлтэй нөхцөл байдлууд үүсэж байна. Мөн хаягийн зөрөөтэй байдал нь иргэд хохирлоо нэхэмжлэх, хууль хяналтын байгууллагаас мэдээлэл, лавлагаа авахад хүртэл хүндрэл, чирэгдэл үүсгэсээр байна.

Иймд ашиглалтад оруулахаар гэрчилгээ олгоогүй боловч барьж дуусаагүй барилгын эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлд бүртгүүлж өмчлөх, эзэмших, ашиглах эрх үүссэн эсэх, зөвшөөрөлд заагдсан нийтийн зориулалттай орон сууцны зориулалтаар барьж байгаа барилга байгууламж дээр үл хөдлөх эд хөрөнгийн эрхийг бүртгүүлэх тухай шаардлага хангах агуулга бүхий хэлцэл, урьдчилсан тэмдэглэгээ байгаа эсэх, Иргэний хуулийн 145.2-т заасны дагуу орон сууцны захиалгын гэрээ, хэлцэл тухайн барилгатай холбоотойгоор байгуулагдаж бүртгүүлсэн эсэх талаарх мэдээллийг нээлттэй байлгах аар хуулийн төсөлд тусгаж, Улсын бүртгэлийн ерөнхий хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг Монгол Улсын Үндсэн хууль болон олон улсын гэрээнд нэгдэж орсон олон улсын гэрээтэй нийцүүлэн боловсруулсан бөгөөд мөн хуулийн төсөлтэй уялдуулан Барилгын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Иргэний хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Үл хөдлөх эд хөрөнгийн барьцааны тухай хуульд нэмэлт оруулах тухай, Үл хөдлөх эд хөрөнгийн албан татварын тухай хуульд нэмэлт оруулах тухай, Хаягжуулалтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Эд хөрөнгийн эрхийн

улсын бүртгэлийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хууль баталсантай холбогдуулан авах арга хэмжээний тухай Монгол Улсын Их Хурлын тогтоолын төслийг боловсрууллаа.

УИХ-ын дэд дарга, эрхэм гишүүд ээ, хуулийн төсөл батлагдсанаар орон сууцны захиалгын гэрээгээр халхавчилж залилах гэмт хэрэг гарахаас урьдчилан сэргийлэх, давхардуулан иргэдээс захиалга авч иргэдийг хохироох эрсдэлийг бууруулж, иргэд тодорхой мэдээллийг мэдэх боломжоор хангагдах нь гэрээ байгуулахдаа эрсдэлээс урьдчилан сэргийлэх чухал алхам болно гэж үзэж байна. Иймд хуулийн төслийн үзэл баримтлал, хуулийн төслийг хэлэлцэхийг дэмжиж өгөхийг та бүхнээсээ хүсье.

Б.Пүрэвдорж: Сайнзориг гишүүнд баярлалаа. Зочин танилцуулъя. УИХ-ын гишүүн Б.Түвшингийн урилгаар Завхан аймгийн Тэс сумын ЕБС-ийн 1986 оны төгсөгчид УИХ-ын үйл ажиллагаа болон Төрийн ордонтой танилцаж байна. Та бүхэнд ажлын амжилт болон эрүүл энхийг хүсэн ерөөе. Төслүүдийн талаарх ХЗБХ-ны санал, дүгнэлтийг УИХ-ын гишүүн Даваахүүгийн Пүрэвдаваа танилцуулна. Индэрт урьж байна.

Д.Пүрэвдаваа: УИХ-ын дарга, эрхэм гишүүд ээ,

УИХ-ын гишүүн П.Сайнзориг нарын 37 гишүүнээс 2026 оны 5 дугаар сарын 29-ний өдөр УИХ-д өргөн мэдүүлсэн Улсын бүртгэлийн ерөнхий хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүдийн хэлэлцэх эсэх асуудлыг ХЗБХ 2026 оны 6 дугаар сарын 10-ны өдрийн хуралдаанаараа хэлэлцлээ.

Хууль санаачлагч ашиглалтад оруулах гэрчилгээ олгоогүй боловч барьж дуусаагүй барилгыг эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлд бүртгүүлж өмчлөх, эзэмших, ашиглах эрх үүссэн эсэх, зөвшөөрөлд заагдсан нийтийн зориулалттай орон сууцны зориулалтаар барьж байгаа барилга байгууламж дээр үл хөдлөх эд хөрөнгийн эрхийн бүртгэл бүртгүүлэх тухай шаардлагыг хангах агуулга бүхий хэлцэл, урьдчилсан тэмдэглэгээ байгаа эсэх, Иргэний хуулийн 145.2-т заасны дагуу орон сууцны захиалгын гэрээ, хэлцэл тухайн барилгатай холбоотойгоор байгуулагдаж бүртгүүлсэн эсэх талаарх мэдээлэл нээлттэй байхаар хуулийн төслийг боловсруулжээ.

Хуулийн төсөл батлагдсанаар улсын төсвөөс нэмэлт зардал шаардагдахгүй гэж хууль санаачлагч үзсэн бөгөөд хуулийн төслийг dparliament.mn цахим сайтад байршуулж, иргэд, олон нийтийн саналыг авч байгаа болно.

Байнгын хорооны хуралдаанаар хуулийн төслийг хэлэлцэх үед УИХ-ын гишүүн О.Номинчимэг улсын бүртгэлийн цахим санд оруулах мэдээллийн жагсаалт, холбогдуулан боловсруулсан Иргэний хуулийн төсөлд Улсын Дээд шүүхээс санал авсан эсэх, олон улсын туршлага, хуулийн этгээдийн эрх ашгийг хамгаалах зорилгоор урьдчилсан тэмдэглэгээг заавал хийх субъектийн талаар, УИХ-ын гишүүн С.Одонтуяа орон сууцны захиалгын залиланд холбогдсон компаниудыг хар жагсаалтад оруулах зохицуулалт байгаа эсэх, хувь хүний нууцад хамаарах мэдээлэл ил болох эрсдэл үүсэх талаар, УИХ-ын гишүүн Д.Пүрэвдаваа Англи, Австрали улсын туршлагыг судалсан эсэх, барилгын компанийн тулгасан гэрээний

нөхцөл, барилгын салбарын төлөөллийн санал, тоон мэдээллийн талаар асууж, хариулт авсан болно.

Түүнчлэн УИХ-ын гишүүн Л.Соронзонболд орон сууцны захиалгын гэрээний хүрээнд анхаарах асуудлын талаар, УИХ-ын гишүүн Н.Алтанхуяг хуулийн төслийг хугацаа алдалгүй шийдвэрлэх ёстой бөгөөд ЗГ-аас цогцоор нь авч үзэн холбогдох бусад хуулийн төслүүдийг боловсруулж УИХ-д өргөн мэдүүлэх, орон сууцны төслийн борлуулалт нь тухайн төслийн бүтээн байгуулалтын ажил тодорхой хувьд хүрсний дараа эхэлдэг байх нь зүйтэй талаар, УИХ-ын гишүүн Да.Цогтбаатар барилгын компаниудын хариуцлагын асуудлыг дээшлүүлэх, УИХ-ын гишүүн Б.Баярбаатар иргэдийг хохироохоос хамгаалах зорилгоор хуулийн төслийг яаралтай хэлэлцэн батлах нь зүйтэй талаар, УИХ-ын гишүүн Б.Тулга орон сууцны захиалгын талаар үүссэн нөхцөл байдлыг шуурхай шийдвэрлэх талаар ЗГ-т холбогдох чиглэлийг өгөх нь зүйтэй талаар, УИХ-ын гишүүн О.Номинчимэг эрсдэлийг зөв хуваарилж, дундын хяналтын асуудлыг холбогдох хуульд тусгах нь зүйтэй талаар, УИХ-ын гишүүн Д.Пүрэвдаваа холбогдох судалгаа, тоон мэдээллийг гаргаж танилцуулах, бүртгэлийн байгууллагын хариуцлагын асуудлыг тодорхой тусгах, төрийн байгууллагын хүнд суртлыг анхаарах талаар, УИХ-ын гишүүн Д.Цогтбаатар хуулийн төслийг хэлэлцэх явцад барилгын салбарын төлөөллийг оролцуулж хэлэлцүүлэх нь зүйтэй талаар тус тус үг хэлсэн болно.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.11 дэх хэсэгт заасны дагуу Улсын бүртгэлийн ерөнхий хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүдээр санал хураалт явуулахад Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн олонх нь буюу 54.2 хувь нь үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжиж, чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх нь зүйтэй гэж үзсэн болно.

УИХ-ын эрхэм гишүүд ээ, Улсын бүртгэлийн ерөнхий хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн Барилгын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Иргэний хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Үл хөдлөх эд хөрөнгийн барьцааны тухай хуульд нэмэлт оруулах тухай, Үл хөдлөх эд хөрөнгийн албан татварын тухай хуульд нэмэлт оруулах тухай, Хаягжуулалтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Хууль хэрэгжүүлэх арга хэмжээний тухай хууль, тогтоолын төслүүдийн хэлэлцэх эсэх хэлэлцүүлгийг явуулсан талаарх ХЗБХ-ны санал, дүгнэлтийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг та бүхнээс хүсье. Анхаарал тавьсанд баярлалаа.

Б.Пүрэвдорж: Пүрэвдаваа гишүүнд баярлалаа. Ажлын хэсгийг танилцуулъя. Оюунбаатарын Оюунзул ХЗДХЯ-ын Хууль зүйн бодлогын газрын Хувийн эрх зүйн хэлтсийн даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч, Баатарсүрэнгийн Батзориг ЦЕГ-ын Хуулийн хэлтсийн дарга, Дашцэрэнгийн Сайнжаргал ЦЕГ-ын Мөрдөн шалгах албаны Залилах гэмт хэрэгтэй тэмцэх газрын Мөрдөн шалгах хэлтсийн дарга, Эрхэмбаярын Отгонтунгалаг УБЕГ-ын Эд хөрөнгийн улсын бүртгэлийн газрын улсын ахлах бүртгэгч, Өлзийдаваагийн Өнөрлхам УБЕГ-ын Эд хөрөнгийн улсын бүртгэлийн газрын улсын ахлах бүртгэгч. Энэ уул нь яаж энэ зөвшөөрлөө хурдан шуурхай өгөх вэ гэдгийг мэддэг албан тушаалтнууд байвал зүгээр байсан даа, тийм ээ, яах вэ.

УИХ-ын гишүүд Байнгын хорооны санал, дүгнэлт, хууль санаачлагчийн илтгэл болон хуулийн төслийн үзэл баримтлалтай холбогдуулан намын бүлэг болон бүлэгт харьяалагдаагүй гишүүдээс урьдчилан ирүүлсэн нэрсийн дагуу асуулт асууна. Зочин танилцуулъя. Нийслэлийн ерөнхий боловсролын 52 дугаар сургуулийн 9^Е ангийн багш, сурагчид УИХ-ын үйл ажиллагаа, Төрийн ордонтой танилцаж байна. Та бүхэнд сурлага, хөдөлмөрийн өндөр амжилтыг хүсэн ерөөе. Сүхбаатарын Эрдэнэболд гишүүн асуулт асууна.

С.Эрдэнэболд: Сайнзориг гишүүний яг энэ санаачилсан хууль улсын бүртгэлтэй холбоотой, энэ хуулийн зохицуулалт маш чухал. 2 жилийн өмнө Ушаандарын Болдхүү гээд хуульч улсын бүртгэлийн даргын ажлыг хийж байсан Болдхүү яг энэ төрлийн хууль хэрэгтэй гэдэг санааг хэлж байсан. Тэгээд ашгүй Сайнзориг гишүүн яг энэ хуулийг ингээд хэлбэржүүлээд, санаачлаад ороод ирж байгаа. Эрнандо де Сото (Hernando de Soto) гэж томоохон эдийн засагчийн Монголд ирэхдээ хэлсэн нэг үг байдаг. Ер нь энэ өмчийн бүртгэл яв цав, тодорхой байж, тэр нь өөрөө шударгаар эдийн засгийн эргэлтэд ордог байж нийгмийн энэ өсөлтийг, эдийн засгийн боломжуудыг авчирна гэж 1 дүгээрт хэлсэн.

2 дугаарт, Нобелийн шагналт Амартья Сен /Amartya Sen/ гэж хүний 1998 онд Нобелийн шагнал авсан гол бүтээл дээр "Хөгжил гэдэг эрх чөлөө" гэж байгаа юм. Тэгээд энэ нэг бизнесийн эрх чөлөө, өмчлөх эрх чөлөө, эдийн засгийн харилцаа нь өөрөө ямар нэгэн гэмт халдлага, хулгай, луйвар, залилангаас ангид байх тухай ойлголт. Тэгэхээр энэ Сайнзориг нарын гишүүдийн санаачилж байгаа хуулийн гол концепци нь энэ өмчлөлийн асуудал асар тодорхой байх. Нэг байрны, баригдаж дуусаагүй байгаа байрны явцаар олон дахин барьцаалбар гаргаад иргэдийг хууран мэхэлдэг ийм асуудал гараад байгаа юм. Яагаад энэ хууль явж байгаа вэ гэхээр 1дүгээрт залилан мэхлэх, хууран мэхлэх, бусдыг хүнд байдалд оруулах хохирол учруулахаас энэ хууль гарснаараа урьдчилан сэргийлэх боломжтой.

Нөгөө талдаа яг энэ шударгаар бизнес эрхлээд явж байгаа, барилгын салбарт байгаа, яг баялаг бүтээгээд явж байгаа хүмүүсийг, ажлын байртай байлгаж байгаа хүмүүсийн эрх ашгийг хамгаалах. "Нэг үхрийн эвэр доргивол мянган үхрийн эвэр доргино" гэж хэлдэг. Тэгээд 1 асуудал дээр луйвар гарлаа гэхэд бүхэлд нь тэр асуудлыг харлуулах ийм асуудал гарчихдаг учраас энийг нэг цэгцэлж авъя гэсэн. Тэгэхээр ер нь УИХ-аар олон хуулиуд гарч байгаа. Ер нь хууль маш энгийн, хүмүүст ойлгомжтой байх ёстой гэсэн зарчим байдаг. 1823 онд Томас Жефферсоны /Thomas Jefferson/ бичсэнээр хууль маш энгийн логиктой, ойлгомжтойгоор нийгмийн харилцааг зохицуулж байх ёстой гэсэн байгаа юм.

Хуулийн төслийг санаачлагчаас асуух нь, яагаад энэ хууль зайлшгүй энэ нийгэмд хэрэгтэй байгаа тухай, түүнээс ямар, ямар зохицуулалт нь гарцаагүй хэрэгтэй байгаа тухай маш товчхоноор, жирийн иргэдэд ойлгомжтой байдлаар энэ төслийг товчхон танилцуулаач. Энэ хууль гарахгүй бол ямар алдагдсан боломж гэдэг шиг эрх зүйн зохицуулалт байсаар байгаад тэр нь эргээд иргэдийг хохироох нөхцөл байдал байгаад байгаа вэ гэдэг дээр тодруулга хэлж өгөөч гэж хүсье.

Б.Пүрэвдорж: Хууль санаачлагч Сайнзориг гишүүн хариулъя.

П.Сайнзориг: Эрдэнэболд гишүүнд баярлалаа. Концепцыг нь маш тодорхой та өөрөө бараг байр сууриараа хэлчихлээ дээ. Ер нь зүгээр энэ аливаа бүртгэлийн үнэн зөв байх гэдэг энэ төрийн байгууламж, Монгол Улсын бүх зүйлийг

төлөвлөхөөсөө эхлээд хэрэгжүүлэх энэ ажиллагаа дээр яг бодитой шийдлүүд гаргана л гэсэн үг. Бүртгэлээ бид бүх аливаа салбаруудаар хийж чадахгүй бол иргэдийнхээ өмчийг хамгаалж чадахгүй, эргээд төрөөс үзүүлж байгаа дэмжлэг, туслалцааг үзүүлж чадахгүй гэх мэт маш олон зүйлүүд байгаа. Тэгэхээр энэ зүйлүүдтэй би санал нэг байна.

Тэгээд гол агуулга нь мэдээж энэ өмч, өмчийн эрхийг эзэмшигч буюу шударга өмчлөгчийг бид ерөөсөө хамгаалъя л гэж байгаа юм. Энэ орон сууцны захиалгын асуудлын цаана иргэдийн нөгөө анхдагч хэрэгцээ, орон сууцтай больё гэсэн хүсэл тэмүүлэл байж байгаа юм. Тэгээд энийг нөгөө хүмүүс чинь зүгээр нэг өнөөдрийн цалингийн мөнгө биш байхгүй юу. Насаараа хуримтлуулсан мөнгө, аав, ээжийнх нь үлдээсэн хэдэн цаас, эсвэл өмнөх байр сав, хашаа байшингаа зараад байрны урьдчилгаанд өгчхөж байгаа, эсвэл нөхөр, эхнэр нь ч байдаг юм уу, аль нэг гэр бүлийн гишүүн нь гадаад улсад энэ хүнд хүчир хөдөлмөр хийгээд эх орон руугаа илгээж байгаа ийм мөнгөнүүдийг л өгч, ийм байрны захиалга өгөөд байртай болчихъё л гэсэн зүйл байгаад байгаа юм. Энэ хэрэгцээ шаардлага гэдэг юм уу, иргэдийн нэг талдаа мэдлэг, ухамсар багатай, нэг талдаа шууд гэрээг тулгаад санал болгочхож байгаа юм, "зурахгүй бол дараагийн хүн зурна" ч гэдэг юм уу. Энэ зүйлээс нь шалтгаалаад их боломжгүй, тааруухан гэрээнүүдийг жишээ нь иргэд хийчхээд байгаа юм. Энэнээс бид урьдчилан сэргийлье гэдэг байдлаар энэ орж ирж байгаа.

Өнөөдөр иргэд 3 байдлаар ерөнхийдөө хохироод байна орон сууцтай болох асуудал дээр. Анхнаасаа яг залилах гэж байгаа хүмүүсийн арга мэхэнд орчхож байна. Тэнд угаасаа газрын зөвшөөрөл ч байхгүй, хоосон бичиг баримт, макет үзүүлчхөж байгаа юм. Зарим хэсэг нь нөгөө барилгын компанидаа итгээд мөнгөө өгөөд явж байдаг, барилгын компани нь гадаад, дотоод гэдэг юм уу хүчин зүйлсээс болоод, зарим мөнгийг нь аваад өөр төсөл рүү оруулчихдаг ийм зүйлээсээ болоод ингээд хугацаандаа ордоггүй, ингээд саатаж байгаа зүйл байхад, зарим нь энэ гэр хорооллын орон сууцны төлөвлөлт болоод хуучин ашиглалтын шаардлага хангахгүй байшингуудын дахин төлөвлөлтийн явцад хохирч байгаа бүлэг этгээдүүд байгаа. Ерөнхийдөө ийм 3 хэсэгтэй байна.

Шинээр баригдаж байгаа энэ орон сууцууд дээр ингээд захиалгыг зарим орон сууцуудыг давхардуулан зарах практик нэлээн байна. Дунджаар 2-оос 3 хүнд зарчхаж байна, тэгээд дээд тал нь бүр 5 хүнд зарчихсан ч тохиолдлууд байна. Тэгэхээр иргэд энэ мэдээллийг буюу мэдээд ирэх юм бол гэрээ байгуулахдаа захиалгатай юм уу, банкны барьцаанд тавьсан байран дээр захиалга өгөхгүй байх ийм боломжуудыг эрэлхийлэх нь зөв л гэж энэ хуулийн төслийг оруулж ирж байгаа. Өөрөөр хэлбэл.../минут дуусав/

Б.Пүрэвдорж: Сүхбаатарын Эрдэнэболд гишүүн тодруулъя.

С.Эрдэнэболд: Дэлхийн ер нь томоохон санхүүгийн хямралууд яг энэ үл хөдлөх хөрөнгийн хөөстэй холбоотой гарсан байдаг. Манай улсад ямар түгээмэл зовлон байна вэ гэхээр олны танил гэх хүмүүс, нөлөөлөгчид гэх хүмүүс тухайн бизнес моделийг ойлгоогүйгээр ямар нэгэн төлбөр аваад, эсвэл өөрсдөө тэнд нь бартер маягаар байр сууц, хямдрал ч юм уу аваад ингээд нөгөө олон нийтэд хариуцлагагүй мэдэгдэл, мэдээлэл, сурталчилгаа хийдэг. Түүний үр дүнд тэр олны танил хүмүүсийн рекламд итгээд маш олон мянган хүмүүс байрны урьдчилсан захиалга өгчихдөг. Ингээд тэр нь амжилттай ч болсон түүхүүд байна, амжилтгүй ч болсон түүхүүд байна. Өнөөдөр хэдэн мянган хүн энэ хэргийн, залилангийн

хохирогч болчихсон. Тэгээд миний мэдэж байгаагаар хамгийн олон нь "Нарны хүү, сарны охин" гээд байж байгаа. Тэгээд энэ хууль батлагдсанаараа.../минут дуусав/

Б.Пүрэвдорж: Үг хэллээ. Эхлээд зочин танилцуулчихъя. УИХ-ын гишүүн Д.Үүрийнтуяагийн урилгаар Орхон аймгийн Баян-Өндөр сумын ахмадууд УИХ-ын үйл ажиллагаа, Төрийн ордонтой танилцаж байна. Та бүхэнд эрүүл энх, сайн сайхан бүхнийг хүсэн ерөөе. Одсүрэнгийн Номинчимэг гишүүн асуулт асууна.

О.Номинчимэг: Энэ орон сууцны захиалга хийгээд хэрэглэгчийн эрхийг хамгаалахгүй, эрсдэлээс иргэдээ хамгаалах хууль, эрх зүйн орчин байхгүйгээс болоод маш олон мянган иргэд олон тэрбум төгрөгөөр хохирсон хэрэг гарсан. Өргөдлийн байнгын хороон дээр өнгөрсөн 12 дугаар сараас хойш энэ дээр ажиллаад, тэгээд өдий 6 сарын дараа ингээд хууль орж ирж байна. Уг нь яамд энэ дээр манлайлал үзүүлж, хууль нь хурдан орж ирэх ёстой байсан. Тэгээд энэ дээр ингээд манай гишүүд ч гэсэн энэ асуудлыг, энэ нийгмийн асуудал болчихсон гэдгийг нь сайн ойлгоод, дэмжээд дуугарч явж байгаад маш их талархаж байна. Тэгээд энийг шийдчих гэсэн ийм шийдэл болсон хуулиуд орж ирж байна гэж харж байгаа.

Манай Өргөдлийн байнгын хороон дээр энэ хавар яг энэ асуудлаар 700 гаруй иргэдийн өргөдөл ирчхээд байна, нийтдээ 20 хэдэн төрлийн төсөлтэй холбоотой. Тэгээд бид яг юу нь ямар учир шалтгаанаас ийм байна гээд ингээд үзэхээр үнэхээр бидний хууль, эрх зүйн орчинд энэ санхүүгийн, тэр компанийн хямрал гарахад эсвэл залилах, хүмүүсээс мөнгө авчхаад тэрийгээ өөр тийш нь зарцуулах гэх мэт янз бүрийн аргаар ингээд энийг чинь хийж болно шүү дээ. Тэрнээс сэргийлсэн, энэ эрсдэлийг хуваарилсан ерөөсөө манай хууль, эрх зүйн орчин байхгүй байгаад байгаа юм. Тэгээд энийг ингээд бид яаралтай шийдлүүдийг нь олоод явах ёстой, энэ хуулийн хувьд би дэмжиж байгаа. Гэхдээ яах вэ, энэ хууль бүрэн шийдэл болж чадахгүй гэдгийг урьдчилаад хэлэх ёстой. Тийм учраас БХБЯ энэ Барилгын тухай хуулийн шинэчилсэн найруулгыг хурдан оруулж ирэх ёстой. Тэр дээр яг энэ гол, хамгийн гол зохицуулалт буюу энэ эрсдэлийг хамгийн сайн, уян хатнаар зохицуулж, хааж чадах шийдлүүдийг оруулж ирээсэй гэж бодож байгаа юм.

Тэр нь юу вэ гэхээр, ерөөсөө л энэ эрсдэлийн хуваарилалт буюу хэрэглэгч болсон иргэд орон сууц захиалж байгаа тохиолдолд энэ эрсдэлийг нь үнэлж дүгнэж, энэ эрсдэлээс нь урьдчилан сэргийлдэг энэ нэг дундын механизм байх ёстой. Барилгын компани, борлуулалт 2-ыг салгах ёстой, эсвэл тэр захиалга өгөөд өгч байгаа мөнгийг нь үнэхээр тэр барилгадаа орж байна уу гэдгийг хянах банк, санхүүгийн байгууллагын оролцоо байх ёстой. Ингэж байж энэ асуудал шийдэгдэхгүй бол мэдээж бүртгэлээр бид давхардуулж олгох асуудал, банкны барьцаанд өгчхөөд дахиад иргэнд өгөх энэ асуудал буурна. Гэхдээ нөгөө гол асуудал болох мөнгийг нь авчхаад эндээ зарахгүй байж байгаад барилгаа зогсоож, царцаагаад 7, 8 жил болгож хохироодог асуудал энэ хуулиар шийдэгдэхгүй байгаа. Тэгэхээр Барилгын яамыг энэ дээр анхаарч, Барилгын тухай хуулийнхаа төслийг оруулж ирээсэй гэж бодож байгаа юм.

Энэ дээр бид ХЗБХ дээр ярьсан, би ганц, хоёр асуудлуудыг дараа нь хэлэлцүүлгийн шатанд засах ёстой гэж харж байгаа. 1 дүгээрт, энэ Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн тухай хууль дээр "Ү" гэрчилгээнээс гадна "Д" гэрчилгээ гэж орж ирсэн байгаа. Тэгээд хэрвээ үнэхээр энэ "Д" гэдэг гэрчилгээг шинэ ийм дугаартайгаар оруулах гэж байгаа бол газар өмчлөх эрх дээр өгдөг "Г" гэрчилгээний дугаар, хөдлөх эд хөрөнгийн дугаар болох "Х" гээд энэ дугааруудыг ч гэсэн адилхан

оруулж ирэх ёстой. Одоо бол Даргынхаа журмаар явдаг ийм төрлийн гэрчилгээнүүд гардаг. Тэгэхээр ингээд хууль дээр зөвхөн "Д" гээд орчихоор нөгөө "Г", "Х" гэрчилгээнүүдийн асуудал юу болох вэ гэдэг асуудал байгаа учраас энэ дээр хуулийг нэг мөр болгож засах ёстой гэж харж байгаа.

2 дугаарт, үл хөдлөх эд хөрөнгийн татвартай холбоотой асуудал байгаа. Энэ дээр гэр хорооллын газрын дахин төлөвлөлт, төлөвлөн барилгажуулах хүрээнд баригдсан барилга байгууламж болон эрчим хүчний эх үүсвэр бүхий барилга байгууламжийн татварыг 5 жилд 100 хувиар хөнгөлнө гэсэн ийм асуудал орж ирж байгаа, тэгээд энэ хуулийн үзэл санаатай би холбоогүй гэж харж байгаа. Иргэдэд очиж байгаа ачааллыг хөнгөлөх асуудал биш. Энэ орон сууцны асуудал бол иргэд угаасаа 2 үл хөдлөх хөрөнгө дээр татвар төлдөггүй. Дахин төлөвлөлтийн хувьд энэ мэдээж орон сууцтай нь холбоотой л асуудал.../минут дуусав/

Б.Пүрэвдорж: 1 минут нэмж тодруулъя.

О.Номинчимэг: Тэгэхээр энэ хөнгөлөлт орж ирж байгаа энэ асуудал хасагдах ёстой гэсэн ийм байр суурьтай байгаа.

Мөн 3 дугаарт орж ирж байгаа энэ Иргэний хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн 182.5-д урьдчилсан бүртгэл хийлгээгүй барилга дээр захиалга авахыг, гэрээ хийхийг хориглосон байгаа. Тэгээд энэ 1 дүгээрт энэ гэрээний эрх зүйн асуудал энэ бүртгэл дээр орж ирж байгаа нь учир дутагдалтай, буруу байршилтай байгаа гэж бодож байгаа. 2 дугаарт энийг хориглоод үнэхээр яаж хэрэгжүүлэх юм бэ гэдэг хяналтын систем байхгүй, энэ угаасаа нотариатаар чинь захиалгын гэрээ хийгддэггүй. Энийг юу гэдэг юм, бүртгүүлээгүй байхдаа тэгвэл захиалга авчихлаа гэхэд энийг яаж тэгвэл хяналт хийх юм, хариуцлагажуулах юм гэдэг механизм өөрөө байхгүй байгаа учраас энийг бид цааш нь хэлэлцээд явахад яаж энийг зөв болгох вэ гэдэг дээр УИХ, ажлын хэсэг илүү сайн хараад явах байх гэсэн бодолтой байна. Мэдээж хаягжуулалт, тэр бүртгэлийн асуудлыг дэмжиж байгаа, ингэж байж нээлттэй мэдээллийн сан дээр байж иргэд.../минут дуусав/

Б.Пүрэвдорж: Хууль санаачлагч Пүрэвжавын Сайнзориг хариулна.

П.Сайнзориг: Эхний суурь асуудлуудтай ижил байгаа. Энэ дээр мэдээж үл хөдлөх хөрөнгийн зуучлал байх уу, банк орж ирэх үү, ер нь даатгалын тогтолцоо орж ирэх үү гээд маш олон суурь асуудлуудыг иж бүрээр нь ярих ёстой. Энэ удаад энэ асуудлыг хөндөөгүй. Ямар ч байсан иргэд, барилга барьж байгаа барилгын компанийн хоорондын энэ харилцаа өнөөдрийн Иргэний хууль, бусад хууль тогтоомжийн хувьд явах боломжтой, энэ хүрээн дээр нь энэ эрсдэлийг яаж бууруулах вэ гэдэг зүйлийг л харж байгаа. Барилгын компани, иргэд хоорондын асуудлаар тухайн төслийн мэдээлэл, мэдлэг маш зөрөөтэй, дээрээс нь барилгын компанийн яг өөр өөрсдийнхөө эрх ашгийг хамгаалж боловсруулсан тэр гэрээн дээр иргэд зураад л захиалгаа өгч байгаа. Тэгэхээр энэ бүх зүйлүүдээс хамгаалж чадах нэг зүйл нь зарим мэдээллүүдийг иргэдэд нээлттэй болгоё. Тухайн барилга барихад барилгын ажлыг эхлэх зөвшөөрөл өгөхөд урьдчилсан хаяг олгоно. Урьдчилсан хаяг гэдэг хаалганы хаягаасаа хүртэл байгаа. Энэ хаягийг олгоно гэдэг хот төлөвлөлтийн хувьд нийцэж байгаа юм байна, дээрээс нь техникийн бусад нөхцөл буюу халуун, дулаанаар хангагдах юм байна ч гэдэг юм уу, энэ нөхцөл байдлуудыг үнэлсний хүрээнд Нийслэлээс юм уу, аймгаас энэ урьдчилсан хаягийг олгож байгаа юм.

Тийм учраас энэ иргэдийн цаад нөгөө нэг "ашиглалтад орох болов уу, улсын комисс ажиллах болов уу" гэдэг эрсдэлийг 1 дүгээрт бууруулна. 2 дугаарт, Номинчимэг гишүүн яг л хэллээ, давхардуулан захиалга өгөөд, иргэдийн зарим мөнгийг зохисгүй хэмжээнд эргэлдүүлдэг ийм зүйлүүдээс бид урьдчилан сэргийлэх гэж байгаа юм. 2-оос 3 иргэнд зарчхаад, дахиад "Мөнгө нэмбэл, барилгын материал өссөн, ажиллах хүчний зардал өссөн, нэмээд өгвөл аль нэмж өгсөнд нь өгнө" гэсэн барилгын компаниудын хандлага байгаа. Дээрээс нь үлдэж байгаа, тэр хохирч байгаа 1, 2 хүнийг нь "Шүүхдээд ав" гэдэг. Шүүхдээд авна гэдэг 2-оос 3 жилийн ажил, 2-оос 3 жилийн энэ процессын хувьд өнөөдөр өгч байгаа 100 сая төгрөг, 3 жилийн дараа 100 сая төгрөгөө гар дээрээ авах 2-ын үнэ цэн, худалдан авах чадвар шал өөр болчихно. Тэгэхээр энэ бүх зүйлүүдээс ямар ч байсан иргэдийгээ тодорхой хэмжээний энэ бүртгэл дээр үүсэх мэдээллээс нэг давхар ядаж энэ барилга дээр захиалга авчаж уу, тэр хаалган дээр, дээрээс нь элдэв банк, санхүүгийн байгууллагын барьцаанд байна уу гэдгийг эрсдэлээ юу ч гэсэн дүгнэх, харчих л гэдэг энэ боломжийг 1 дүгээрт олгож байгаа юм.

Яах вэ, "Д" гэрчилгээний хувьд ингээд тодруулж өгч байгаа, дуусаагүй болон "Ү" гэдэг үл хөдлөх хөрөнгө буюу Улсын комисс ашиглалтад авсан гэсэн үг. Газрын хууль тогтоомжийг иж бүрнээр нь оруулна гэдгийг Хэрэг эрхлэх газрын дарга намар хэлээд байгаа, тэр дээрээ энэ асуудлаа ярьж болох байх. Татварын асуудал дээрээ яах вэ, зүгээр энэ орон сууцжуулалт буюу нийлүүлэлтийн талаасаа дахин төлөвлөлтийн арга хэмжээний хүрээнд иргэд орон сууцтай болоод, энийг нь үл хөдлөх хөрөнгөөр эхний 5 жилд нь чөлөөлчихье л гэж байгаа юм. Ингэвэл энэ дахин төлөвлөлтийг дэмжих энэ хандлага энэ тэр байх юм болов уу гэсэн энэ юу байгаа. Эрчим хүчний эх үүсвэр гэдэг энэ орон сууцжуулалтын нийлүүлэлтийг дэмжиж байгаа, өртгийг бууруулж байгаа тодорхой хэрэгсэл учраас энийг нь дэмжиж өгье гэдэг байдлаар би оруулсан юм. Иргэний хууль болон хариуцлагын асуудал байгаа, өнөөдрийн энэ.../минут дуусав/

Б.Пүрэвдорж: Хариултаа багтааж асуугаарай. Батын Батбаатар гишүүн алга байна, Даваахүүгийн Пүрэвдаваа гишүүн алга байна, Жуковын Алдаржавхлан гишүүн алга байна. Дуламын Бум-Очир гишүүн асуулт асууна.

Д.Бум-Очир: Энэ маш чухал хуулийн төсөл орж иржээ, шийдвэрлэхийг оролдсон байна. Нэг байрыг олон захиалагчид зарчихдаг, өөрөөр хэлбэл нэг зүйл байлаа гэхэд тэрийг 3 хүнд зарж байгаатай, 4 хүнд зарж байгаатай ялгаагүй, нэг ёсны залилан луйврын ийм зүйл болдог, иргэд маш ихээр хохирдог, манай нийгэмд маш түгээмэл байдаг энэ асуудлыг зохицуулах ийм оролдлого хийж орж ирсэн байна. Би нэг хэдэн зүйлийг тодруулмаар байна.

1 дүгээрт, тэр урьдчилсан хаягжилт гэдэг маань энэ асуудлыг бүрэн шийдэх үү? Урьдчилсан хаягжилт гэдэг маань жишээ нь УБЕГ дээр бүртгэлтэй байх юм уу, хаана бүртгэлтэй байх юм, тэр нь урьдчилсан гэдэг нэг утгаараа хэр албан ёсны байх юм бэ гэдгийг 1 дүгээрт тодруулмаар байна?

2 дугаарт, түрүүн Номинчимэг гишүүн хэлээд байна, би Номинчимэг гишүүнтэй үндсэндээ санал нэг байна. Яг энэ өнөөдрийн орж ирж байгаа энэ хуулийн төсөл маань ил тод болгож байгаа, мэдээллийг ил тод болгож байгаа, эцэслэн бүрэн дүүрэн шийдвэрлэж чадахгүй болов уу гэсэн нэг ийм эргэлзээ байгаад байна л даа. Энийг эцэслэн шийдвэрлэх нэг системийн шинэчлэл УБЕГ дээр хийгдчих болов уу гэж ойлгоод байна. Нөгөө блокчэйн шилжих тухай асуудал,

блокчэйд шилжчихвэл тэр нэг хаяг дээр давхар бүртгэл явуулах боломжгүй болох ёстой. Тэрийг өөрчлөх боломжгүй болох ёстой, аюулгүй байдал нь хангагдах ёстой. Миний авсан мэдээллээр блокчэйн системд энэ жилдээ багтааж шилжих гэж, блокчэйн системд УБЕГ энэ жилдээ багтааж шилжинэ гэсэн ийм мэдээллийг надад, би өмнө нь өөр хуулийн төсөл дээр ажиллаж байхад надад өгсөн. Тэгэхээр блокчэйн системд шилжсэнээр энэ урьдчилсан хаягжилтын асуудал, нэг хаягийг буюу нэг орон сууцыг олон иргэнд зарж борлуулж захиалга авах энэ байдлыг энэ системээр хязгаарлаж зохицуулах боломжтой юу, үүнтэй холбогдож орж ирэх үү гэдгийг тодруулмаар байна?

Тэгэхээр 2 зүйл байгаа, тэгээд 1 нь тэр урьдчилсан хаягжилт чинь яаж явагдах юм, үнэхээр албан ёсны байх юм уу? 2 дугаарт, 3 дугаарт би нэг зүйлийг асуучихъя. Түрүүн Сайнзориг гишүүн хариулж амжсангүй, тэр эрх зүйн хариуцлагын тухай асуудал гээд түрүүн яасангүй. тэрийгээ Номинчимэг гишүүний асууж байсан асуулт байгаа. Хариуцлагын тухай асуудлыг Сайнзориг гишүүн үргэлжлүүлээд хариулаад өгөөч гэсэн ийм 3 зүйл байна. Блокчэйнтэй холбоотой асуудал, тэр урьдчилсан хаягжилт гээд албан ёсны байх юм уу, яаж бүртгэгдэх юм, 3-д нь тэр хариуцлагын асуудал.

Б.Пүрэвдорж: Зочин танилцуулъя. УИХ-ын гишүүн Г.Тэмүүлэнгийн урилгаар нийслэлийн ерөнхий боловсролын "Элит" олон улсын дунд сургуулийн 10С ангийн сурагчид УИХ-ын үйл ажиллагаа болон Төрийн ордонтой танилцаж байна. Та бүхэнд сурлагын өндөр амжилтыг хүсэн ерөөе. Пүрэвжавын Сайнзориг гишүүн хариулъя.

П.Сайнзориг: Бум-Очир гишүүний асуултад хариулъя. Хариуцлагын асуудал байгаа, яг энийг дагаад яах вэ Эрүүгийн хуулийг хөндөөд, ялангуяа орон сууцны захиалгын гэрээгээр халхавчилж залилан мэхлэх гэмт хэргийг бүр хүндрүүлэх бүрэлдэхүүн болоод ял хариуцлагыг ихэсгээ гэсэн боловч энэ удаагийнхаар хэрэггүй гэдэг зүйлийг прокурорын байгууллага хандаад байсан. Ийм учраас орхисон. Зөрчлийн тухай хуулиар Барилгын тухай хууль тогтоомж зөрчих, улсын бүртгэлийн бүртгэлд бүртгүүлэх журам зөрчих, Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хууль тогтоомж зөрчих энэ юунуудаар 5 сая төгрөгөөр барилгын компанийг торгох хариуцлага байгаа, үйлдэл болгон дээр гэсэн үг шүү дээ зөрчил болгон дээр ийм зүйлүүд байна, Ямар ч байсан энэ хариуцлагын асуудал байгаа гэдэг зүйлийг би танд хэлье.

Хаягийн асуудал одоо бол зүгээр барилгыг Улсын комисс хүлээж авсны дараа хаяг олгогдож байгаа. Тийм учраас нөгөө хаяг олгогдохгүй учраас барилгын компаниуд захиалга авахдаа "А блок", "Б блок" гээд төслийнхөө талбай дээр өөрсдөө өгсөн хаяг дээрээ захиалгаа авдаг. Хаяг олгосны дараа маргаан гараад ирэхээр энэ дээрээсээ эхлээд, бичиг баримтын зөрөөнөөсөө эхлээд л иргэдэд хүндрэл учруулчхаж байгаа юм. Тэгэхээр урьдчилсан хаяг олгоно гэдэг нэг талдаа барилгын компаниа хамгаалах гээд байгаа байхгүй юу. Дараа нь Улсын комисс дээр "авна, авахгүй" гэдэг зүйл бас яригдахгүй гэсэн үг. Зарим зүйлүүдээ засаж сайжруулах юман дээр нь зөвлөгөө өгч болно шүү дээ. Тэгэхээр ямар ч байсан газрын эрхийн зөрчилгүй юм байна, хот төлөвлөлтийн хүрээнд суугдсан юм байна, төлөвлөлтөд орсон юм байна, дээрээс нь ус, дулаанаар хангагдах юм байна гэсний үндсэн дээр энэ урьдчилсан хаяг олгогдоно. Тэгээд тийм учраас иргэд миний захиалга өгч байгаа барилга маань техникийн нөхцөл ч юм уу, газрын эрхийн зөрчил

талаасаа гайгүй юм байна гэдэг ч юм уу, эрэлхэг эргэлзээгүй юм байна гэдэг дээр итгэл үнэмшил авна гэсэн үг.

Дээрээс нь хаяг бол барилгын хаягнаасаа гадна хаалганы хаяг давхар олгогдохоор байгаа, энэ дээр. Тийм учраас Чингэлтэй дүүргийн жишээ авч байгаа шүү, Чингэлтэй дүүргийн 3 дугаар хороо, 9 дүгээр байр гэхэд 9 дүгээр байр нь нэг орцтой, 20 айлын орон сууц байх юм, 10 тоотыг захиалъя гэхэд 10 тоот дээр урьд нь захиалга хийгдэж үү, 10 тоот дээр барьцаанд тавигдсан зүйл байна уу гэдгийг нь шалгаж үзэх эрхийн төлөв гарна. Түүнээс биш яг 10 тоотыг Сайнзориг захиалж уу, Бум-Очир захиалж уу гэдэг гарахгүй, зүгээр захиалгатай, захиалаагүй, ер нь банкны барьцаанд байна, байхгүй гэдэг зүйл л гарна.

Блокчэйн технологийн хувьд Улсын бүртгэлийн ерөнхий хуулиар зүгээр энэ оруулж ирж байгаа суурь мэдээллүүдийг өөрчлөгдөхгүй байдлаар буюу нэмэлт update хийгээд явах байдлаар ингээд орсон, суурь юугаа. Яг хууль дээр блокчэйн гэж зааж болохгүй. Энэ зүгээр л нэг брэнд. Тийм учраас энэ мэдээллийг үнэн зөв байдаг, хэн нэг этгээд дураараа өөрчилдөггүй, өөрчлөгдөж буюу нэмж өөрчилсөн, засварласан энэ тохиолдолд дандаа лог үүсэж байж, хамгаалагдаж байж мэдээллийн эзэнд хүрдэг энэ технологийг л цаашдаа бид "И-Монголиа" болон бусад энэ системийнхээ хүрээнд сайжруулаад явах ёстой, ер нь лог үүсээд лог хэвээрээ байгаа. Ингэж байж энэ дотоод хяналт шалгалтаараа.../минут дуусав/

Б.Пүрэвдорж: Бум-Очир гишүүн тодруулъя.

Д.Бум-Очир: Блокчэйн системийн хувьд би УБЕГ-аас өөрөөс нь хариулт авмаар байна. Надад байгаа, танай дарга нараас өмнө нь авсан мэдээллээр энэ жилдээ блокчэйн системд шилжчих юм байна гэдэг ийм ойлголт, мэдээлэл авсан. Энийг би яагаад яриад байна вэ гэхээр саяхан Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл ороод, энэ дээр давхардаж санал өгөх тухай асуудал гарах уу, ямар технологиор яаж хамгаалагдах вэ гэдэг энэ асуудал яригдаад блокчэйн системд шилжчихэд энэ асуудал хаагдах ёстой юм. Тэгээд би болоод бидэнд байгаа, гишүүдэд ирсэн мэдээллээр Улсын бүртгэлийн ерөнхий газраас блокчэйн системд шилжинэ гэдэг ийм мэдээлэл өгөөд байгаа байхгүй юу. Энийгээ албан ёсоор яг микрофон дээр, протоколд оруулаад өгөөч. Яагаад гэхээр блокчэйн системд шилжчихнэ гэж үзээд энэ хуулийн төслийг би оруулж ирээд байгаа хэрэг байхгүй юу. Тэгэхээр энийгээ тодруулах гэсэн юм, 1 дүгээрт.

2 дугаарт, яг саяын, өнөөдрийн энэ ярьж байгаа хуулийн асуудал дээр блокчэйн системийг хэрэглэх боломжгүй юм уу, давхардал үүсгэхгүй үүднээс энэ 2 дээр хариулт өгөөч?

Б.Пүрэвдорж: Индрийн 4 дүгээр микрофон, нэр, албан тушаалаа хэлээд хариулаарай. Нэг минут.

Э.Отгонтунгалаг: УБЕГ-ын Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн газрын улсын ахлах бүртгэгч Отгонтунгалаг. Гишүүний асуултад хариулъя. Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн системийн хувьд системийн шинэчлэлийн хөгжүүлэлтийн ажиллагаа яг одоогийн байдлаар явж байгаа. Блокчэйн технологийг нэвтрүүлж байгаа яг салбар нь цахим гэрчилгээний, үл хөдлөх хөрөнгийн цахим гэрчилгээний хувьд блокчэйнийг хөгжүүлж байгаа. Ер нь энэ хууль батлагдсанаар Хаягжуулалтын

тухай хууль, тэгээд нөгөө Хот байгуулалтын тухай хуулийн дагуу төрийн захиргааны байгууллагуудтай мэдээлэл нийлүүлэх системийг хөгжүүлэх шаардлага үүсэж байгаа юм.

Б.Пүрэвдорж: Ганбатын Хосбаяр гишүүн асуулт асууна.

Г.Хосбаяр: Энэ Улсын бүртгэлийн ерөнхий хуульд нэмэлт оруулах тухай энэ хуулийг хэлэлцэж байна. Тэгээд яах вэ, энэ дээр нөгөө барилгын салбарт гарсан залилан, энэ талаар ярьж байна л даа. Тэгэхээр өнөөдөр Монголд маш олон амжилттай ажиллаж байгаа барилгын компаниуд, барилгын төслүүд байгаа. Сая Өргөдлийн байнгын хорооны даргын ярианд гарч байна, нөгөө 22 төсөлтэй холбоотой гомдлууд байгаа гэж. Тэгэхээр маш олон төслүүд амжилттай хэрэгжиж, энэ Монголын барилгачид өнгөрсөн жил гэхэд 19600 айлын орон сууц барьж ашиглалтад оруулсан байгаа. Тэгээд маш олон амжилттай төслүүд дотор мэдээж ийм саар зүйлүүд байна, болохгүй зүйлүүд байна, залилан мэхлэгчид байна.

Тэгэхээр энэ хуулийн өөрчлөлттэй холбоотой мэдээлэл өгөхдөө барилгын салбарыг, энэ төслүүдийг тэр чигээр нь залилж мэхэлдэг юм шиг ийм мэдээлэл, ойлголтыг нийгэмд өгч болохгүй шүү гэж хэлмээр байна. Тэгээд мэдээж барилгын салбарт залилан хийсэн тодорхой хүмүүс, хэсэг бүлэг зохион байгуулалттай ийм зүйлүүд байгаа. Олон жилийн өмнөөс мөн энэ урлаг соёлын одууд, олны танил хүмүүс оролцоод л "Байр авбал Ланд 300 бэлэглэнэ" гэж хүртэл сурталчилгаа олон нийтийн хэвлэл мэдээллээр явж байсан. Өнөөдөр яг шударга бизнест ийм боломж байхгүй шүү дээ. Байр барьж өгчхөөд, дээр нь дахиад ланд, house барьж өгчхөөд, дээр нь дахиад "Ланд 300" бэлэглэж байдаг ийм санхүүгийн загвар, модель байхгүй, ийм зүйл анхнаасаа залилан, хууран мэхлэлт байдаг.

Тэгээд одоо энэ өөрчлөлтөөр яах вэ, энэ өөрчлөлтийг оруулснаар бүх юмыг хаачхаж байгаа хэлбэр биш л дээ. Тэгэхээр энэ өөрчлөлт ингээд улсын бүртгэл дээр одоо ч энэ дутуу барилгын гэрчилгээ дээр тэмдэглэгээ хийлгэж байгаа, байр захиалсан иргэд хүсвэл. Тэгэхээр зэрэг одоо энэ олон нийтэд ил тод болгож, энэ мэдээллийн санг ил тод болгосноор, энэ бүртгэлийг илүү боловсронгуй болгосноор ер нь энэ эдийн засаг, санхүүгийн ямар нэгэн үр дагавар гарах уу? Энэ дээр ер нь ажлын хэсэг, энэ бүртгэлийн байгууллага тооцоо, судалгаа хийсэн зүйл байна уу? Тэгэхгүй бол нөгөө талд нь энэ чинь барилгын маш олон амжилттай ажиллаж байгаа төслүүд, компаниуддаа хүндрэл үүсгэсэн, цаг хугацаа орсон, улсын бүртгэл дээр ч оочир дараалал үүсгэсэн ийм зүйл болчих вий гэж бодож байна.

Нөгөө талд нь бас нэг өөрчлөлт орж байгаа энэ хаяг олгох асуудал дээр, одоо яг бодит байдал дээр үнэн, Улсын комисс ажилласны дараа барилгын хаяг олгож байгаа, орон сууцжуулалтын хаягийг олгож байгаа. Тэгэхтэйгээ зэрэг өнөөдөр Улаанбаатар хотын хаягжилт чинь ингээд ойлгомжгүй болчихсон. 101, 102 гэж явж байснаа 150, 160 гэж байснаа дараа нь дахиад эргээд 103, 104, 105 дугаар байр гээд ингээд алаг цоог болчихсон, энд тэнд болчихсон. Тэгэхээр энийгээ ингэж цэгцэлж, эхнээс нь зураг төсөл батлахдаа энэ зүйлийг хийж явах нь зөв гэж харж байна.

Тэгээд ер нь цаашдаа яг ийм залилан мэхлэлт, энэ хууль бус юмнуудыг бүр хааж, эрсдэлийг бууруулъя гэвэл барилгын компани нь барилгаа л барьдаг, энэ борлуулалт, зуучлал, энэ зүйлийг тэр хөрөнгө менежментийн компаниуд буюу хөрөнгө зуучлалын компаниуд нь хийдэг болох тал руу энэ Барилгын тухай хуулийн

төсөл дээр өөрчлөлт оруулах ёстой. Ингэж байж энэ салбартай холбоотой энэ хууран мэхлэлт, залилан юм явна уу болохоос биш, өнөөдөр барилгын компани нь барилгаа ч барьж байна, борлуулалтаа ч хийж байна, зарим нь дараагийн ашиглалт буюу СӨХ-оо ч хариуцаад явж байна. Энэ дунд чинь энэ асуудлаас чинь болоод залилан гарч байгаа юм. Тэгэхээр энэ дунд нь зуучлалын компаниуд байгаа, хөрөнгө зуучийн компаниуд байгаа нөхцөлд энэ залилан мэхлэлт, энэ зүйлүүд гарахгүй гэж ингэж харж байгаа. Тийм учраас энэ хаягийн асуудал, энэ эдийн засаг, санхүүгийн үр дагавар гарах уу гэдэг 2 асуултад хариулт өгөөч гэж хүсэж байна.

Улсын Их Хурлын дарга С.Бямбацогт 16 цаг 19 минутаас хуралдааныг даргалав.

С.Бямбацогт: Хууль санаачлагч хариулъя Сайнзориг гишүүн.

П.Сайнзориг: Нэмээд манай бүртгэлийн байгууллагаас нэмэлт мэдээлэл өгөөрэй гэж хүсэж байна. Би Хосбаяр гишүүнтэй санал нэг байна. Энд шударгаар бизнес эрхэлж байгаа барилгын компаниудаа хамгаалах л зорилготой хууль юм байгаа юм. Яг нэг тогоонд байгаа учраас аль нь ялгагдахгүй байна. 2 дугаарт манай татварын бодлого байна, 10 хувийн татвар, 25 хувийн гээд 2 шатлалтай, дундын хувилбар байхгүй, тэгээд 6 тэрбумаас дээшээ давсан орлого болгон дээр нь 25 хувийн татвар байдаг учраас компаниуд жижгэрдэг. Яг захиалга өгөхдөө нөгөө охин компани гэдэг юм уу, эсвэл хараат компани, эсвэл нэгдмэл сонирхолтой этгээдүүд маш олон байдлуудаар захиалга, борлуулалтаа авдаг. Яг энэ схем ч гэсэн залилан мэхлэгчид ашиглачихдаг. Нэг оффист сууж байгаад л гэрээгээ зурахдаа шал өөр компанийн нэр дээр явангуутаа "Мөнгөө ийшээ шилжүүлчих" ч гэдэг юм уу ийм олон зүйлүүдээр яваад иргэдийг хохироодог. Тэгээд үнэнч шударгаар явж байгаа, Барилгын тухай хууль тогтоомжоо биелүүлээд, гэрээний үүргээ биелүүлээд энэ барилга барьж байгаа компаниудынхаа нэр хүндийг, бизнесийн эрх ашгийг хамгаалах зорилгоор энэ хууль орж ирж байгаа гэдгийг танд хэлье.

Ер нь өнгөрсөн хугацаанд 1992 оноос хойш Улаанбаатар хотын хүн ам 3 дахин, суурьшлын бүс 6 дахин тэлээд, энэ их суурьшлын бүс тэлж байгаа хүн ам өсөж байгаа дээр манай барилгачид энэ орон сууцжуулах бодлогыг маш сайн хийсэн, энд амжилт байгаа шүү. Өнөөдөр Улаанбаатар хотын тал хүн ам нь хэдийгээр орон сууцанд орж чадаагүй байгаа ч гэсэн, 92 оноос хойш ингээд явсан үзүүлэлтээрээ явах юм бол хүн ам 3 дахин өсчхөөд байгаа учраас энэний талыг нь орон сууцанд оруулчихсан байна гэдэг их том барилгачдын хийсэн энэ нийгэмд бүтээсэн амжилт юм байгаа юм. Энүүнтэй, алагтай, цоогтой ийм сөрөг үзэгдлүүд гарч байгааг л хэдүүлээ урьдчилан сэргийлж таслан зогсооё л гэдэг байдлаар энэ хууль орж ирж байгаа юм.

Зардлын хувьд хуулийн этгээд иргэд, ААНБ талаасаа гайгүй. Гол асуудал юу вэ гэхээр Барилгын яам, ХЗДХЯ, бүртгэл дээр үүсэх энэ мэдээллийн дэд бүтэц, программ хангамжийг сайжруулах ёстой. Энэ бүртгэлийн байгууллагын программ санхүүжилтээс ерөөсөө харамлаад байгаа. Тэгчхээд цахим шилжилт бүрэн шилжье гээд байдаг суурь мэдээлэл нь УБЕГ газрын харилцаан дээр л байгаа Монгол Улсын. Энэ мэдээллүүдийг боловсруулалтыг хийдэг, хамгаалдаг энийгээ зөв ашигладаг асуудал дээр ерөөсөө хөрөнгө мөнгө татаад, И Монголиа ч гэнэ үү нэг баахан юман дээр үрэн таран хийгээд л яваад байгаа. Энийгээ би шулуухан хэлмээр байгаа юм. Өгдөг газар нь өгч, энэ байгууллагуудын мэдээллийн аюулгүй байдал энэ бүх зүйлүүдийг сайжруулах ёстой шүү гэдэг зүйлийг 1 дүгээрт хэлмээр байна.

Хаягийн асуудал тантай санал нэг байна. Тэгэхдээ ямар ч байсан хаягжуулалтыг урьдчилсан хаяг гэдэг зүйлийг бий болгоод, барилгын ажил эхлэхэд иргэд маань яг тухайлан хаяг дээрээ захиалгаа өгдөг, энэ дээрээ үүсэх эрсдэлүүдээ харчихдаг энэ боломжийг л өгье. Ер нь хаягжуулалтын тэр хуулийн шинэчилсэн найруулгыг ЗГ дээр бараг сүүлийн 8 жил ярьж байгаа Барилгын яам л оруулж ирэх.../минут дуусав/

С.Бямбацогт: Улсын бүртгэлээс нэмж хариулья.

Ө.Өнөрлхам: УБЕГ-ын Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн газрын улсын ахлах бүртгэгч Өнөрлхам. Энэ саяын 2 асуудал дээр нэмэлт хариулж мэдээлэл өгнө. Хаягийн асуудал манай Монгол Улсын хэмжээнд хамгийн асуудалтай анхаармаар ийм асуудлуудын нэг байгаа. Энэ төсөл дээр түр хаяг гэж явж байгаа. Тэгэхдээ хуулийн төсөл дээр хаягийг урьдчилсан авахдаа тоот хүртэл тодорхой авна гэж оруулж ирсэн нь энэ хаягийн давхардал болох асуудлаас урьдчилан сэргийлж байгаа ийм ач холбогдолтой байгаа. Яг практик дээр яаж байна вэ гэхлээр хаягийг аваагүй хаяг нь тодорхойгүй байдгаас захиалгын гэрээ авахдаа яг хаяг тоотоор нь авалгүйгээр төддүгээр блок ийм байрны А блок гээд авдаг учраас нөгөө захиалгын гэрээ давхардаад байгаа асуудал гардаг гол асуудал энэ дээр байж байгаа. Тийм учраас энэ.../минут дуусав/

С.Бямбацогт: Гүйцээгээд хариулчихъя, хариултаа дуусгая.

Ө.Өнөрлхам: Хуулийн төсөл дээр энэ хаягийг ингэж тодруулж оруулж ирсэн нь эрсдэлийг бууруулах ач холбогдолтой гэж үзэж байгаа. Үр дагавар гэж ярьж байна. Энэ хуулийн төсөл хэрэгжиж эхлээд хамгийн гол нь энэ мэдээллийг нээлттэй болгох, мэдээллийн тэнцвэртэй байдлыг хангах гэж иргэдэд тодорхой мэдээллийг өгснөөр энэ давхар хийдэг, залилан хийдэг энэ асуудал багасна, сайн үр дагавар нь гарна гэсэн ийм хүлээлттэй байгаа.

С.Бямбацогт: Хосбаяр гишүүн тодруулж асууя.

Г.Хосбаяр: Бид сая 2 асуудлын өмнө л нөгөө Бизнесийн эрх чөлөөний тухай хуулийн төслийг хэлэлцсэн, тэгээд яг энэ дээр л дагаж 90 хуулийн өөрчлөлт орж ирж байгаа. Яг энэ дээр л энэ Барилгын тухай хууль дээр, удахгүй Барилгын тухай, Барилгын ерөнхий хууль шинэчилсэн найруулгаар орж ирнэ гэж байгаа. Тэгэхээр энэ БХБЯ-ныхан энэ яриаг сонсож байгаа байх, энэ барилгын компани, энэ хөрөнгө зуучлал, дараагийн энэ орон сууц, нийтийн аж ахуй буюу СӨХ гэж ярьдаг бидний нөгөө дараагийн ашиглалт, энэ юмнуудаа л маш сайн зааглаж, тодорхой болгож орж ирмээр байна л даа. Тэгэхгүй бол зарим хүмүүсийн ойлголтоор барилгын компаниуд бүгд л залилан хийдэг, зарим хүмүүс хэт хаширлаад захиалгын гэрээ хийхээ байчихсан, хийхийн тулд бараг л захирлынх нь удам судрыг судлахаас наахнуур юм болдог болсон зэрэг ийм асуудлууд байгаа. Тэгэхээр энэ хуулиар тодорхой болгож өгөөрэй гэж хүсье.

С.Бямбацогт: Үг хэллээ. Зочин танилцуулъя. УИХ-ын гишүүн Очирбатын Амгаланбаатарын урилгаар нийслэлийн ерөнхий боловсролын 19 дүгээр сургуулийн 12В ангийн багш, сурагчид УИХ-ын үйл ажиллагаа, Төрийн ордонтой танилцаж байна. Төрийн ордонтой танилцаж байгаа сурагч хүүхдүүддээ УИХ-ынхаа

нийт гишүүдийн нэрийн өмнөөс эрүүл энх, аз жаргал, сайн сайхан бүхнийг хүсэн ерөөе. Жуковын Алдаржавхлан гишүүн асуултаа асууя.

Ж.Алдаржавхлан: Би хууль санаачлагчаас 2 асуулт байна. Энэ хууль хэрэгтэй хууль. Аягүй олон байрны залилангууд ер нь гарсан гэдгийг бүгдээрээ ярьсан. Манай Хан-Уул дүүрэгт Нисэхийн цагаан хаалга гэдэг хотхонд 500 иргэнийг хохироогоод, давхардуулаад зарчихсан маш олон тохиолдол гараад, хэдэн арван, хэдэн жил бараг үргэлжилж байгаа ийм маргаанууд явж байгаа. Энийг таслахад их хэрэгтэй хууль гэж 1 дүгээрт ойлгож байна.

Гэхдээ 2 зүйлийг асууя гэж бодож байна. Ингээд баригдаж байгаа орон сууцны төслүүд дээр урьдчилсан захиалгыг тэмдэглээд нийтэд ил тод зарлана гэхээр, Сайнзориг гишүүнээ, ингээд гайгүй төслүүдийг бушуухан түрүүлж очиж гэрээ байгуулаад, олон зуугаар нь дарж гэрээ байгуулдаг энэ байрны ченжүүд сүүлийн үед их болсон гээд байгаа шүү дээ. Энэ "Хурд"-ын төслүүд дээр ялангуяа түрүүлээд хэдэн арваар нь аваад дарчихдаг ийм хүмүүсийн нэр ил тод болох уу? Манайхан хардаж ярьдаг, энэ гаднынхан ерөөсөө хамаг байрны үнэ аваад, энэ орон сууцны үнэ өсгөөд байна. Ерөөсөө гаднаас гадаадын иргэд аваад дууслаа гэж яригддаг энэ зүйлүүд ил тод болох уу 1-рт энэ асуултад хариулаач?

2-рт дуусаагүй барилгын гэрчилгээгээ авах нь битгий хэл, дуусчихсан барилгынхаа гэрчилгээг авч чадахгүй газрууд олон байна. Энэ тусгай хамгаалалттай газар, манай Хан-Уул дүүргийн замын урдуур, Богдхан уулын тусгай хамгаалалттай газарт байшин барьчихсан маш олон барилгууд байгаа. Тэнд авсан иргэд зарим нь гэрчилгээгээ ч авч чадахгүй нөхцөл байдал үүсдэг. Энэ хүмүүс дээр энэ хууль хэрэгжиж чадах уу? Тусгай хамгаалалттай газарт орон сууц хэдэн арваар нь бариад байгаа шүү дээ. Энэ хүмүүс дээр энэ хууль хэрэгжиж чадах юм уу, ийм 2 асуулт байна?

С.Бямбацогт: Хууль санаачлагч хариулъя, Сайнзориг гишүүн.

П.Сайнзориг: Бид Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хуультай. Тийм учраас энэ хуулийнхаа хүрээнд энэ мэдээлэл ил болох юм. Яг тухайлан Жуковын Алдаржавхлан, Пүрэвжавын Сайнзориг гэдэг нэр гарах боломжгүй. Тухайн магадгүй нэг орцтой байрны 10 тоот дээр гэхэд "захиалгатай", "банкны барьцаанд байгаа" буюу тэмдэглэгээ хийлгэгчихсэн гэдэг л төлөв гарч ирнэ, эрхийн төлөв. Түүнээс биш яг А гэдэг этгээд, Б гэдэг этгээд гэдэг нэр усаараа гарах боломжгүй. Гэрээ байгуулж байгаа хүн энийгээ, эрсдэлээ яана, А гэдэг этгээд нь лавлагаагаа аваад ч юм уу ингээд цаашдаа явах юм. Тэрнээс биш үнэнийг хэлэхэд хүний овог нэрээр нь бүх зүйлийг зарлах тийм боломжгүй гэдэг зүйлийг би танд хэлье.

Яах вэ, энэ гадаадын ийм байгууллагууд, төвлөрөл энэ тэр гээд надад яг тоон судалгаа алга. Зүгээр энийг хэлэлцүүлгийн явцад эдийн засгийн энэ агшилттай холбоотойгоор бартерын юмнууд яваад ААН, байгууллагууд бие биедээ байгаа бараа, материал солилцохдоо ингээд л солилцдог, энэ дээр нь гадна дотнын компаниуд орж ирээд л барилгууд төвлөрөөд байгаа ч юм шиг ийм зүйлүүд байгаа юм байна лээ. Энийг би хэлэлцүүлгийн явцад, зарим хүмүүс ч хэлээд байна. Ер нь ийм байдлаар байрууд зарим хүн дээр ингээд ихээр орж ирдэг ийм зүйлүүд байгаа энэ тэр гээд хэлэлцүүлгийн хувьд хуульчид болон зарим энэ үл хөдлөх хөрөнгийн зуучлалынхан хэлж байна лээ. Энэ дээр нэр ус ч гэдэг юм уу ийм зүйл байхгүй. Нэг өөрийн нэр дээр маш олон орон сууцтай гэж хардалтууд байдаг. Энэ бол УБЕГ

дээрээс авч үзэж байгаа мэдээллээр харьцангуй цөөхөн л иргэд байдаг юм байна лээ, энэ дээр 2 болон түүнээс дээш орон сууцтай иргэдийн мэдээллийг тоогоор нь боломжтой бол манай УБЕГ-ынхан нэг хэлээд өгөөч.

Тусгай хамгаалалттай газар нутаг /ТХГН/-ийн хууль удахгүй орж ирээд энэ асуудал дээр нэг гарц, гаргалгаа гаргах гээд манай Бат-Эрдэнэ, Бат-Өлзийн Бат-Эрдэнэ гишүүн ажиллаж байгаа юм билээ. Одоо бол түрүүчээсээ гэрчилгээ олгочихсон энэ байшингууд чинь дандаа аялал жуулчлалын орон сууц гээд хуулиа зөрчиж ингээд гэрчилгээ олгосон шүү дээ, хүчээр. Тэгээд зарим нь ингээд зогсчихсон, ийм л байдалтай байгаа. Тэгэхээр ТХГН-ийн асуудалд энэ хуулиар би бүрэн хариулт өгч чадахгүй. Газрын суурь эрхийн асуудал нь эхлээд зөв болж байж, дараа нь энэ дээр нь баригдаж байгаа байр сууц гэдэг юм уу, үл хөдлөх хөрөнгө гэдэг бүх л объёмоороо зөв болно. Тэгээд ямар ч байсан Бат-Эрдэнэ гишүүн маань энэ хаврын чуулгандаа энэ хуулиа өргөн барих юм билээ, намрын чуулганаар энэ хуулийг нэг зөв концепцоор нь, энэ тулж байгаа, үүссэн энэ асуудлуудаа нэг цэг тавиад, тэгээд нэг мухарлаад явах юм байна гэсэн ийм ойлголттой, мэдээлэл солилцоод явж байгаа.

С.Бямбацогт: Алдаржавхлан гишүүн тодруулъя.

Ж.Алдаржавхлан: Ер нь ойлголоо. Тэгэхдээ манай Бат-Эрдэнэ гишүүний санаачилж байгаа энэ тусгай хамгаалалттай газар, ялангуяа энэ Нисэх, Яармаг, Зайсанд баригдаж байгаа орон сууцууд улсын гэрчилгээ авч чадахгүй байгаа явдал дээр хуулийн гарц, гаргалгаа санаачлаад явж байгаа. Ер нь энэ замын урд, Яармагийн замын урд байгаа айлуудыг тусгай хамгаалалтаас гаргахгүй бол нөхцөл байдал нэлээн хүнд байгаа, энэ дээр би дэмжиж ажиллана гэдгээ илэрхийлье. Гол нь, Сайнзориг гишүүнээ, энэ нэг ийм сүүлийн үед ийм байрны тийм ченж маягийн хүмүүс их болчихоод байна л даа. Энэ дээр хэдүүлээ энэ өргөн барьсан хуулийн чинь хүрээнд тэмцэж болохгүй юу? Тэгээд бүр тэрнээс ч хамгаалаад, орон сууцны компаниуд чинь аягүй нарийн арга хэрэглэж байж, тэгэхгүй бол орж ирээд хэдэн арваар нь захиалчихдаг, тэгээд дамлан зардаг ийм хүмүүс маш олон болчихсон байна. Энэ дээр энэ хуулийн юун дээр чинь гаргалгаа энэ тэр байна уу, үгүй юу?

С.Бямбацогт: Хууль санаачлагч хариулъя, дараа нь Улсын бүртгэл хариулъя.

П.Сайнзориг: Яах вэ, ченжүүдийг бид буруутгаж болохгүй. Энэ яг Иргэний хуулийнхаа дагуу л, гэрээний чөлөөт байдлын дагуу л энэ хөрөнгүүдийг шударгаар олж авч байгаа байлгүй дээ. Янз бүрийн байдлаар бусад мөнгө эргэлдүүлээд зөв болгож байгаа бол энэ тусдаа асуудал. Энэний гол бодлогын асуудал нь орон сууцны нийлүүлэлтийг л сайжруулах асуудал байгаа юм. Тэгэхээр энэ нийлүүлэлт сайжирч байж өөрөө орон сууцны үнэ тогтвортой болно, дээрээс нь ченжүүд их хэмжээгээр төвлөрүүлж худалдаж авах байдал буурна шүү дээ. Миний байгаа мэдээллээр орон сууцанд оръё, ипотекийн зээлд хамрагдъя гээд жилд 50 мянган хүн хүсэлт гаргаж байхад дөнгөж 19 мянган орон сууц л жилд ашиглалтад орж байгаа байхгүй юу. Энэ эрэлт хэрэгцээ дээр чинь тоглолт явж байгаа, энэ дээр залилан мэхлэгчид тоглолт хийж байгаа ийм зүйлүүд байгаа. Тэгэхээр өнөөдөр сая мэдээ хараад сууж байна, УИХ-ын дарга Бямбацогт даргад ЗГ-аас Орон сууцжуулалтын тухай хууль өргөн барьж байгаа гэж ойлголоо. Энэ хуулиар нийлүүлэлтийг сайжруулах, нийлүүлэлтийн цаана эргээд газрын харилцаа болон дэд бүтцийг л шийдэж өгөх.../минут дуусав/

С.Бямбацогт: Ажлын хэсэг хариулъя, 4 дүгээр микрофон.

Э.Отгонтунгалаг: Улсын бүртгэлд 2026 оны 3 дугаар сарын 31-ний байдлаар нэг орон сууцтай 418276 иргэн, 2-оос 4 орон сууцтай 89207 иргэн, 5-аас дээш орон сууц өмчилдөг 1250 иргэн, анхны бүртгэлээс хойш өмчлөх эрхээ шилжүүлээгүй 215766 иргэн бүртгэлтэй байна.

С.Бямбацогт: Гишүүд асуулт асууж дууслаа. Би гишүүнийхээ хувьд нэг асуулт асуугаадахъя, Сайнзориг гишүүнээ. Энэ орон сууцны залилан газар авчихсан, нэг орон сууцыг олон иргэнд давхардуулан зардаг. Иргэд маань хуруу хумсаа хугалан байж гадаад, дотоодод ажиллаж, баахан банкнаас зээл авч нэг орон сууц захиалдаг. Захиалсан орон сууц нь ашиглалтад орохгүй 5, 10 жил болдог, үүнээсээ болж хохирдог. Мөн захиалсан орон сууцыг нь давхардуулаад 5, 10 хүнд зэрэгцүүлээд зарчихдаг, үүнээсээ болоод олон мянган иргэд гадуур түрээсийн байранд эсвэл гэр хороололд, эсвэл аав, ээжийнхээ хажууд амьдарч байгаа. Тэгээд энэ асуудлыг цэгцэлье. Орон сууцыг давхардуулан зарахаас сэргийлье, орон сууцыг зарах мэдээллийг, бүртгэлийг ил тод болгоё гэдэг агуулгаар орж ирж байгаа хууль учраас дэмжиж байгаа.

Хамгийн гол нь хууль хэрэгжих боломж байна уу, хэрэгжүүлэхийн тулд юу анхаарах ёстой вэ? Бид алга ташуулаад нэг хууль баталчихдаг, одоо бүх юм болчихлоо гээд бодно. Гэтэл бодит байдал дээр төрийн албан хаагчид, бүртгэлийн байгууллага энэ хуулийг хэрэгжүүлэх гээд эхлэхэд мэдээллийн технологи, программ хангамж, систем, техник, тоног төхөөрөмж, хүн хүч гээд энэ бололцоо нь байгаа юу, энийг яаж бий болгох юм бэ бид? Тэгэхгүй бол эцэст нь бид хууль батлаад өглөө, ЗГ, холбогдох байгууллага хэрэгжүүлэхгүй байна гээд дахиад нөгөө асуудлаа цэгцэлж чадахгүй, нөгөө иргэдийн хүсэн хүлээж байсан хүлээлт алга болдог. Эргээд "Та нарын баталсан хууль чинь амьдрал дээр хэрэгжихгүй байна" гэдэг ийм юм руу орчих вий. Тийм болохоор цаашдаа энэ орон сууцны залилангийн асуудалд цэг тавих, барилга, газар, бүртгэл, банк, санхүү гээд энэ бүх системүүдийг хооронд нь нэгтгэж уялдуулах, мэдээллээ солилцдог байх, шаардлагатай мэдээллүүд нь ил тод байх, энэ төрийн албан хаагчид ажлаа хийх бололцоо, боломжийг нь бүрдүүлэх энэ тал дээр бид яах ёстой вэ?

Мөн дээрээс нь нөгөө компаниуд захиалга авчхаад компанийнхаа нэрийг өөрчлөөд, улсын бүртгэлд бүртгүүлээд, дахиад компаниа зараад, дахиад өөр нэртэй болоод ингээд хэдэн давхар хохироогоод алга болдог. Тэгээд тэрийг нь шийдэх гээд шүүх дээр очоод хэдэн жил шийдэгддэггүй, шүүх нэг шийдвэр гаргадаг, шийдвэр гүйцэтгэл хэрэгжүүлэх гэж бас хэдэн жил болдог. Энэ хооронд нөгөө төгрөгийн ханш, тэгээд нөгөө иргэд чинь улам их хохирдог. Нэг иймэрхүү юмнуудыг баталсан хуулиа хэрэгжүүлэхтэй холбоотой бид яг юу, юу хийх ёстой, ЗГ юунд анхаарах ёстой, УИХ ямар, ямар хууль тогтоомжид өөрчлөлт оруулах ёстой вэ? Энийг давхар шийдээд, олон мянган иргэд олон жил хохирч байгаа энэ асуудлыг нэг мөр цэгцлэхгүй бол хуулийн нэг хэсгээр нь нэг хэсэг асуудал нь шийдэгдээд, цаад талд нь "хонх нь дуугарахаар дамар нь таг" гээд ийм юм руу орчих вий. Энэ дээр ямархуу хуулийг хэрэгжүүлэхтэй холбоотой бид яаж болох вэ, юу хийж болох вэ? Энэ дээр та нэг хууль санаачлагчийн хувьд үр дагаврыг, үр дүнг, хуулийн хэрэгжилтийг хангуулах талаар бодсон зүйл, төлөвлөсөн зүйлээ л хэлэхгүй юу.

П.Сайнзориг: УИХ-ын дарга Сандагийн Бямбацогтын асуултад хариулъя. Таныг ХЗДХ-ийн сайдаар ажиллаж байхад бид улсын бүртгэлийн багц хуулийг боловсруулаад, тэгээд УИХ-аар дараа нь өргөн барьж хэлэлцүүлээд, энэ хүрээнд дээрээ маш олон мэдээллүүдийг ил тод болгож байсан. Энэ мэдээллийн ил тод байдал гэдэг нийгэм заримдаа шийдлээ олж чадахгүй байгаа, бугшаад байгаа мэдээллийн зөрөөнөөс болоод гэрээ байгуулж байхдаа эрх тэгш байдлаа хангаж чадахгүй байгаа нөхцөл байдлуудыг засах нэг арга зам. Тухайн үедээ энэ олон мэдээллүүдийг ил болгохоор итгэж өгөхгүй л байсан. "Пүү паа, бид хэдийн өмч хөрөнгө чинь нууц байх ёстой" л гээд байсан. Хуулийн этгээдийн мэдээллүүд ил болсноороо гэрээний бие биедээ итгэх тэр итгэл, жишээ нь, дээшилсэн байхгүй юу. Яг энэ компанийн эцсийн өмчлөгч нь хэн юм, хэдэн хувьцаа эзэмшсэн юм, энэ компани ер нь ямар, ямар түүхтэй юм гээд. Манай тендерийн хулгай, ЖДҮ-лэлийг шуугиулсан зарим хууль бус зүйлүүд ч гэсэн энүүгээр илэрч байсан.

Энэ концепцыг би шууд энэ жилийн хувьд яагаад барьж орж ирэв гэхээр, 18 онд яг энэ мэдээллүүдийг ил болгох гэж байсан байхгүй юу. Тэгээд тухайн үеийн парламент УИХ маань итгэж өгөөгүй. "Энэ болохгүй, хүний өмч хөрөнгөтэй холбоотой мэдээллийг, эрхийн төлөвийг нь ч гэсэн гаргаж болохгүй" гэдэг л энэ хандлагаас болоод ингээд 6, 7 жил явчихсан ийм асуудал байгаа юм. Тэгээд энийгээ дагаад орон сууцны захиалгатай холбоотой, давхардуулан захиалга авах энэ байдал маш их хүндэрсэн учраас яг 18 онд ярьж байсан энэ концепцоо л би томъёолол болгоод зарим энэ эрхийн төлөвийн мэдээллийг л нээлттэй болгоё гэж байгаа юм. Чиг үүргийн хувьд манай Улсын бүртгэлийн ерөнхий байгууллага дээр нэмэгдсэн юм байхгүй, яг хийж байгаа. Дэд бүтцэд болон программ хангамжийн хувьд энэ байгууллагыг дэмжих зайлшгүй шаардлага байгаа.

Хуулийн төслүүдийг дагаад Хууль хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тогтоол байж байгаа. Тэгэхээр Монгол Улсын ЗГ нь барьж дуусаагүй нийтийн зориулалттай орон сууцны барилгын эрхийн бүртгэлд бүртгэгдсэн тохиолдолд уг барилгад орон сууцны захиалга бүхий хэлэлцээр, хөрөнгө оруулсан иргэн, хуулийн этгээдийн эрх ашгийг хамгаалах зорилгоор урьдчилсан тэмдэглэгээ заавал хийх зохицуулалтыг хэрэгжүүлэх хүрээнд тус байгууллагын программ хангамж, дэд бүтцийг сайжруулах ажлыг хийх ёстой байгаа. Энэ нөгөө суурь нь гарчихсан, одоо ч улсын бүртгэлийн маш олон мэдээллүүдийг ил тод, нээлттэй болгоод "И-Монголиа"-д байршуулж байгаа. Энэ хүрээндээ энэ программыг сайжруулаад, өргөтгөөд явах бүрэн боломжтой. Чиг үүргийн хувьд нэмэгдээгүй учраас энэ асуудал дээр ямар нэгэн ойлголтын зөрөө гарахгүй гэж ойлгож байгаа. Гол нь программ хангамж, тэр хатуу, зөөлөн дэд бүтцийг л бүрдүүлэхэд хөрөнгө мөнгө зайлшгүй хэрэгтэй. Тийм учраас энэ хугацаа тавьж, шилжилт хийх зохицуулалтыг нь энэ тогтоолын төслөөр өгч байгаа юм.

Дээрээс нь нөгөө барилга ашиглалтад орохгүй байгаа нэг асуудал маань мөнгийг нь аваад өөр бизнест оруулахаасаа гадна газрын эрхийн маргаан үүсдэг ч байдаг юм уу, эргээд халуун, дулаанаар хангагдах зөвшөөрөл нь авагдаагүй ч байдаг юм уу ийм зүйлүүдээс болдог. Энэ мэдээллүүдийг ил болгох Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулиар болгож байгаа. Тэгэхээр иргэд маань яг дараа нь ер нь Улсын комисс ажиллаад, ер нь ашиглалтад орох барилга мөн үү, биш үү гэдгийг нягталж шалгах энэ бүрэн бололцоог нь энэ хуулиар олгож байгаа юм. Тэгээд олон талын ач холбогдол байгаа. Энэ мэдээллийг ил тод, нээлттэй болгох энэ асуудлын суурь нь Монгол Улсын хэмжээнд тавигдчихсан. "И-Монголиа" болон холбогдох энэ хуулийн байгууллагууд төрийн байгууллагуудын мэдээллийн

тодорхой дэд бүтцүүд үүссэн байгаа учраас хэрэгжүүлэхэд цоо шинэ зүйл биш гэж би хэлмээр байгаа юм. Тэгээд тодорхой хэмжээний хөрөнгө мөнгө хэрэгтэй.

С.Бямбацогт: Бүртгэлийн байгууллагаас асуучихъя. Энэ бүртгэлийн байгууллага маш их ачаалалтай болох нь. Барилга, газрыг нь бүртгэнэ, барьж эхлэхэд нь бүртгэнэ, зарж борлуулж эхлэхэд нь бүртгэнэ, дуусахад нь бүртгэнэ, хоорондоо шилжүүлэхэд нь бүртгэнэ. Энэ хэмжээгээр бүртгэлээ бүрэн хийж чадах уу? Ингээд 20, 30 мянган барилга жилд ашиглалтад ордог. Одоогийн байдлаар 1000 орчим барилга л бүртгэл хийж чаддаг юм шиг байгаа юм. Цаашдаа нэг бүртгэлийн байгууллага дээр байшин барилгаа бүртгүүлэх гээд, иргэд нь худалдаж авах, захиалга өгсөн гээд бүртгүүлэх гээд эх захгүй оочир дараалал үүсдэг, бүртгэхгүй баахан хүнд суртал гардаг, цаашлаад тэр нь шан харамж болдог ийм эрсдэл үүсгэхгүй байх боломжууд юу байна вэ? Та хэд бүгдийг цахимаар, заавал хүний оролцоогүйгээр, заавал улсын бүртгэлийн газар дээр очиж бүртгүүл гэж оочир дараалал авч, хурдан бүртгүүлэхийн тулд шан харамж өгөхгүйгээр цахимаар, хүний оролцоогүй гэрээсээ, гар утаснаасаа, компьютер дээрээсээ бүртгэх ийм боломжийг бүрдүүлж чадах уу? Энэ дээр юу хийж байгаа вэ. 4 дүгээр микрофон.

Ө.Өнөрлхам: Ер нь төрийн байгууллагуудын орон тоо цомхотгогдсон байгаа, 9 хувиар цомхотгосон. Ер нь улсын бүртгэлийн байгууллага дээр цахим бүртгэлүүд хийгдэж эхэлсэн. Жишээлбэл, барьцааны гэрээг цахимаар бүртгэж байна. Нотариатаас өөрийнхөө гэрчилсэн материалыг улсын бүртгэлийн байгууллагаар цахимаар илгээгээд, улсын бүртгэлийн байгууллага цахимаар хүлээж авч бүртгэж байгаа ийм асуудлууд байж байна. Дээр нь "И-Монголиа"-гаас /E-Mongolia/ гарч байгаа топ 10 үйлчилгээний 3 нь улсын бүртгэлийн байгууллагын үйлчилгээ байснаас үзэхэд улсын бүртгэлийн байгууллага энэ төрийн үйлчилгээ болон цахим бүртгэл дээр төрийн байгууллагуудыг манлайлж ажиллаж байгаа гэдэг нь эндээс, энэ тоо баримтаас харагдах байх гэж бодож байна.

Ер нь хэдийгээр цахимаар бүртгэл хийж байгаа боловч цахим бүртгэл гэхээр хүмүүс албан хаагчийн хүний оролцоо байхгүй гэж боддог. Яг бодит байдал дээр тэр цахимаар ирсэн мэдээллүүдийг боловсруулах, хууль, эрх зүйгээ шинэчлэх, үйлчилгээг хүртээмжтэй ажиллуулах хүрээнд хүний нөөц байнга орж байдаг. Тийм учраас хэрвээ боломжтой бол улсын бүртгэлийн байгууллагад хүний нөөцийг нэмэгдүүлэх энэ тал дээр боломжтой бол анхаарч өгөөсэй гэж хүсэлт гаргаж байна.

С.Бямбацогт: Сайнзориг гишүүн хариулъя.

П.Сайнзориг: Бямбацогт дарга маш чухал асуулт асуугаад байгаа юм, "Үзэл баримтлал, концепци нь зөв байгаа, баталчихдаг, хэрэгжих үү" гээд. Тэгэхээр ер нь зүгээр мэдээж энэ бүртгэлийн байгууллагын үйл ажиллагааг бид маш сайжруулаад явж байгаа, одоо энэ цахимжилтын 2 дугаар үе шатыг л улсын бүртгэл дээр хиймээр байгаа юм. Өөрөөр хэлбэл энэ мэдээллийн боловсруулалтыг хийх энэ программ хангамжийн шинэчлэлийг сайн хийж өгөх асуудал байна. Одоо болохоор цаасан суурьтай байсан тэр зүйлүүдийг сканердаж оруулаад бид шилжчихсэн юм, өөрөө анхнаасаа тэр бүртгэл дээр боловсруулалтыг эхнээс нь хийдэг тэр программ хангамжийн шилжилт рүү л орох энэ ажил дээр улсын бүртгэлийн байгууллагыг дэмжиж, ойлгож, хөрөнгө мөнгийг нь ирэх жилийн төсөв дээр тавьчихвал энэ бодит байдлаараа төрийн үйлчилгээний 70 хувийг чинь улсын бүртгэлийн байгууллага үзүүлдэг байхгүй юу. Тэгэхээр энэ рүүгээ ингээд зөв шилжилт хийх гээд байгаа юм, Бямбацогт дарга чухал асуудлыг гаргалаа.

Дээрээс нь газрын хууль тогтоомжийг, барилгын хууль тогтоомжийг, хаягжилтын хууль тогтоомжийг ЗГ иж бүрээр нь оруулж ирэх шаардлагатай байгаа юм, энэ одоо.../минут дуусав/

С.Бямбацогт: Гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа. Саяын асуудлыг хэлэлцэж байх явцад нэлээн анхаараад явъя. Хууль, тогтоолын төслүүдийн талаар Байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг дэмжсэн, эсрэг байр суурьтай гишүүд үг хэлнэ үү? Одсүрэнгийн Номинчимэг гишүүн алга байна. Цэвэгдоржийн Туваан гишүүн, 2 дугаар индэр.

Ц.Туваан: Энэ дэмжиж байгаа хууль санаачлагч байгаа. Тэгэхдээ энд нэг хэдэн зүйлийг хэлэхээс өөр аргагүй байна. Бид энэ гэмт хэрэг, зөрчлөөс иргэдээ хамгаалах ийм үүрэгтэй төр л дөө. Тэгээд бид бол ер нь энэ орон сууцны хулгай, луйврын араас нь, өөрөөр хэлбэл "Ниргэсэн хойно нь хашхирав" гэдэг л болчихоод байгаа юм. Маш олон иргэн хохирсон. Одоогоор мэдэгдэж байгаагаар 3637 иргэн энэ өргөдөл, гомдлоо өгсөн шүү дээ, 118.5 тэрбум төгрөгийн хохирол одоогоор мэдэгдэж байгаа юм. Мэдэгдээгүй бас маш их итгэж найдаад хүлээгээд сууж байгаа хүмүүс байгаа. Зөвхөн нэг хүний хохироосон, залилсан 260 хохирогчтой, олон арван тэрбум төгрөгийн хохиролтой ийм хэрэг ч байгаад байгаа юм.

Тэгэхээр энэ хуулийн ач холбогдол нь бид эргэж үүнээс хойш энэ хуулийг батлан гаргаснаар, энэ урьдчилсан байдлаар улсын бүртгэлд бүртгээд, тэр сонирхож байгаа иргэн маань тэр улсын бүртгэлээс лавлагаа аваад, энэ байран дээр өөр давхардаж захиалсан захиалга байна уу, үгүй юү, энэ гарааш дээр өөр давхардсан захиалга байна уу гэдгээ үзэх ийм боломжийг нээж өгч байгаа хамгийн чухал зүйл байгаа юм. Тэгэхээр нөгөө иргэн маань өөрөө энэ дээр өмнө нь тохиолдоод байсан нэг байран дээр, нэг хаяг дээр олон иргэнийг залилаад байсан, энэ асуудал байхгүй болохыг нь хааж өгөх ийм ач холбогдолтой хууль байгаа юм.

Өмнө нь энэ барилгын компаниуд чинь нөгөө өөрсдөө нэр өгөөд, тэр байрны "А блок", "Б блок" гээд өөрсдөө компаниараа нэр өгчхөөд, тэгээд түүн дээрээ үндэслээд А блокийн тэдэн өрөө гэж захиалга аваад, ингээд энэ захиалга дээрээ олон давхардал үүсгээд байсан. Энэ олон давхардал үүсгэж байгаад яг дараагаар нь байшин баригдаж дууслаа гэж бодоход, энэ дээр албан ёсны хаяг авах гэхээр Нийслэлийн Хот байгуулалт болон Хотын стандартын хяналтын газраас олгосон ийм албан ёсны хаягаар бүртгэгдэхээр нөгөө анхны захиалга авсан хаяг чинь өөрчлөгдөөд явчихна. Тэгэхээр иргэдийг ингээд төөрөлдүүлсэн, нөгөө компани болохоор давхардуулж иргэдийг хохироосон ийм асуудал гараад байгаа учраас энэ хуулийн ач холбогдол нь эндээ оршиж байгаа юм аа.

Дээрээс нь энэ дээр би бас нэг зүйлийг хэлмээр байна. Сая УИХ-ын гишүүн Сүхбаатарын Эрдэнэболд, Далайн Батбаяр нартай ингээд орон нутагт ажиллаж байхад Дархан-Уул аймаг дээр эрүүл мэндийн салбарын Эрүүл мэндийн газрын Үйлдвэрчний эвлэлийнхний баталгаа гаргасан, сурталчилсан, ямар нэгэн байдлаар, ямар байдлаар юм бэ мэдэхгүй, аман байдлаар юм уу ингээд "Энд байрны захиалга хийгдэж байна, энэ байранд захиалгаа өгөөрэй" гэдэг ийм зүйлээс болоод эрүүл мэндийн салбарын 70 гаруй иргэн нөгөө байранд урьдчилсан байдлаар мөнгөө төлөөд ингээд залилуулчихсан ийм кэйс гарч ирж байгаа юм. Тэгэхээр энэ компани маш хариуцлагагүй байна, маш гомдмоор байна. Энэ төрийн албан хаагч, дээрээс нь хуруу хумсаа хуйхлан байж цалингаасаа илүүчлэн барин, эрүүл мэндийн

салбарынхан ингээд жижүүрт гаран барин нэг хэдэн цаас цуглуулаад, өр зээл тавиад 1 компани дээр ингээд баахан мөнгөө төлчихсөн, нөгөө компани нь ингээд хулхидаад алга болчихсон ийм кэйс хүртэл байна.

Тэгэхээр бид ганцхан энэ ирээдүйдээ энэ хуулийг шинэчлэн баталснаар ирээдүйд үүсэх хохирлыг багасгахаас гадна, энэ ташрамд манай энэ хууль, шүүхийн байгууллагууд, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагууд энэ хохирчихсон иргэдийн асуудлыг, энэ олон зуун тэрбум төгрөгийн асуудлыг яаралтай анхаарч шийдэхгүй бол энд хамгийн боломж муутай, төсвийн байгууллагын цалин авдаг, хуруу хумсаа хуйхлан байж хэдэн цаас цуглуулсан хүмүүс маш их хохироод байна шүү гэдгийг энэ ташрамд хэлье. Баярлалаа.

С.Бямбацогт: Салдангийн Одонтуяа гишүүн үгээ хэлнэ.

С.Одонтуяа: Хуулийн төслийг үзэл баримтлалын хувьд дэмжиж байгаа. Ер нь манай улсад барилгын салбар нэлээд эрчимтэй хөгжиж байгаа, энэний хажуугаар зайлшгүй зохицуулах ийм шаардлагууд гарч байна. Та бүхэн мэдэж байгаа байх, нэг банкны хохирогчдын хэрэг, Хадгаламж зээлийн хоршооны хэрэг гээд нэг айхтар том, олон зуун хохирогчтой хэргүүд гарч байсан, яг тэрэн шиг асуудал хүндэрчихсэн байгаа, орон сууц худалдан авахаар мөнгө төгрөгөө өгөөд, гэрээгээ хийгээд залилуулчихсан хүмүүс. Тийм учраас бид энийг зайлшгүй шийдвэрлэх шаардлагатай байгаа юм.

Өргөдлийн байнгын хороон дээр энэ орон сууц авах гээд залилуулсан иргэдтэй нэлээд уулзсан, бид асуудлыг нь сайн сонссон. Ялангуяа манай Баянгол дүүрэг дээр маш олон иргэд залилуулаад, суулт зарлаад ингээд байж байгаа юм. Зарим хүн нь бүр 10 жил байрандаа орохгүй явж байна гээд бод доо та нар, 10 жил шүү дээ. Би бүр тэр хүнтэй уулзаад бүр цочиж байгаа. Тэгэхээр энэ арай л дэндүү ийм асуудлууд байна. Дээрээс нь энэ давхар зардаг асуудлыг сая гишүүн болгон хэлж байгаа. Тэгэхээр энэ давхар зарахаас ямар ч байсан энэ хууль нэлээн сэргийлэх юм байна гэж харж байна. Нэг ААН-тэй ингээд иргэд гэрээ хийдэг, тэгэнгүүт тэр ААН 2 туслан гүйцэтгэгчтэй ингээд давхар гэрээ хийчхэж байгаа юм. Тэгээд иргэдийг очихоор "тэр туслан гүйцэтгэгчтэй уулз" гэдэг, туслан гүйцэтгэгчид нь давхар, давхар ингээд орон сууцаа зарчхаж байгаа юм. Тэгэхээр энэ асуудлыг бид зохицуулж өгөхгүй бол хохирогчдын тоо улам ингээд нэмэгдээд байх магадлалтай байна.

Зарим газар энэ ямар ч дэд бүтцээ шийдээгүй хэр нь ингээд баахан захиалга авчихдаг, тэгээд сүүлд нь иргэдэд юу гэж хэлдэг вэ гэхээр "Үгүй ээ, манай дэд бүтцийг Нийслэл шийдэхгүй байгаа юм чинь бид яаж байраа өгөх юм бэ" гээд ингээд өөдөөс нь суудаг. Тэгэхээр энэ асуудлыг бид цэгцлэх хэрэгтэй, мөнгийг ингээд авчхаад өөр зүйл рүү оруулчихдаг, энийг Байнгын хороон дээр маш олон гишүүд ярьсан, яг энэ барилгынх нь төсөл рүү л ордог болгох энэ арга замыг бид нэг зохицуулаад үзэх хэрэгтэй, мөнгийг аваад ингээд өөрсдөө эргэлдүүлчхэж байгаа юм, барилгын компаниуд. Тэгэхээр энэ зүйл дээр маш их гомдлууд ирж байна.

Бас нэг томоохон гомдол юун дээр ирж байна гэхээр, энэ бүртгэл дээр хийж болбол хийгээд өгөөрэй гээд Сайнзориг гишүүнд захисан байгаа. Энэ юу вэ гэхээр, эхлээд маш гоё зураг үзүүлдэг, "тоглоомын талбай нь ийм том, ногоон байгууламж нь ийм том" гээд "энд 10 байшин байна, хороолол, хотхонд" гэххээд яг захиалга аваад, ирээд нөгөө байшингууд нь боссоны дараагаар дахиад нэмээд баахан

байшин барьчихдаг. Тэгэхээр яг энэ эхний зургаар нь хийдэг, энэнээс зөрвөл хариуцлага тооцдог ийм зүйл болох хэрэгтэй байх.

Залилж залилчхаад энэ барилгын компаниуд нэрээ сольчихдог, тэгэхээр энэ дээр ямар юм орох ёстой юм, Барилгын тухай хуульд оруулах ёстой юм уу, тэгээд би ингэж бодож байна. Энэ Сайнзориг нарын гишүүдийн хуулийг бид чамбайруулж баталчхаад, тэрэнд орж чадаагүй, өргөн баригдаагүй зүйлүүдийг бусад хуулиудаар заавал зохицуулж өгөхгүй бол энэ нэлээд хохирол дагуулах янзтай ийм байгаа. Тэгээд иргэд маш их хохирч байна. Ялангуяа тэр захиалга өгсөн гэр бүлийн гишүүнээ буруутгадаг, гэр бүл салдаг, зарим нь машиндаа тэдэн сар амьдарлаа гээд иймэрхүү зүйлүүд, маш их гомдол ирж байгаа, над дээр Баянгол дүүргийн энэ "Хөх сувд" хорооллын гомдол ерөөсөө тасрахгүй ирж байгаа.

Мэдээж би бүх барилгын компанийг хамруулаагүй, энд мэдээж ингээд үүргээ сайн биелүүлж байгаа компаниуд байна. Нөгөө талаас мөнгөний ханш унах ч юм уу, ковидтой.../минут дуусав/

С.Бямбацогт: Пүрэвсүрэнгийн Наранбаяр гишүүн үг хэлнэ.

П.Наранбаяр: Баярлалаа. Тэгэхээр энэ иргэдийг хамгаалах, орон байраар иргэдийг залилах, луйвардах ийм хэргийг энд УИХ дээр ярьж, энийг хамгаалах талаар ийм хуулийн төсөл санаачилж байгааг бүрэн дэмжиж байгаа. Ер нь мэдээллээс хол байгаа иргэн өөрөө луйвардуулах, залилуулах ийм том хэргийн золиос болдог учраас хуулийн төсөлд байгаа энэ заалтуудыг дэмжиж байгаа. Гэхдээ энэ бүрэн бус байна, бүрэн бус байна.

Түүний зэрэгцээ энэ дээр бид цааш нь ингээд хараад явахгүй бол болохгүй асуудлууд байгаад байгааг ярихаас өөр аргагүй. Түрүүн ярьж байна, 3667 хүн, 118 тэрбум төгрөгийн ийм хохирол, тэгээд шийдэгдэхгүй хохирол амсчхаад ингээд яваад байгаа гээд. Зөвхөн шүүх дээр гэхэд 300 гаруй хохирогчийн 15 орчим тэрбум төгрөгийн барагдуулах ажиллагаа явж байна гэж Шүүхийн шийдвэр гүйцэтгэх дээр. Тэгэхээр ийм нөхцөл байдалд бид 1 дүгээрт, 2 талаас нь асуудлыг харах ёстой гэж ингэж бодож байна. Энэ нь юу гэсэн үг вэ гэхээр эхнийх нь энэ барилгын сайн ийм хариуцлагатай компани байгаагийн зэрэгцээ барилгын ийм муу түүхтэй, дээр нь нэмээд ийм луйвар хийдэг ийм компаниуд байгаад байгаа нь үнэн байна. Манай Баянзүрх дүүрэг дээр гэхэд дахин төлөвлөлт дээр 14 дүгээр хороонд аймаар юм болсон шүү дээ, 10 гаран жил тэр газраа өгчхөөд байшингаа одоо хүртэл сургийг нь ч хараагүй, барааг нь ч хараагүй хүмүүс байж байна, нөгөө ертөнцөд одчихсон хүмүүс ч байна.

2 дугаарт, энэ дээр Баянзүрх дүүргийн 38 дугаар хороо, "Баганат" хорооллын тэнд баригдаж байгаа энэ барилгууд нийт бараг 600 өрхийг ингээд хохироочхоод ингээд явж байна. Энэ дээр харж байхад тухайн "Баганат өргөө" гэдэг компани нь газраа туслан гүйцэтгэгчдээ өгөөд, нөгөө туслан гүйцэтгэгч нь "Мөнгөнсар" гэлүү ийм компани нь тэгээд хулхидаад алга болчихсон, ингээд хүмүүс хохироод явж байгаа ийм нөхцөл байдалтай байгаа учраас дэмжиж байгаа юм. Бас нэг тохиолдлыг ярья, энэ төр нь иргэдээ хохироогоод муугаар ярих юм бол хуураад, хулхидаад байгаа явдал. Жишээлбэл, Баянзүрх дүүргийн 43 дугаар хороон дээр байгаа асуудал, "Цаст констракшн"-ы гэдэг нэртэй ийм 43 дугаар хороон дээр, 83 дугаар байрны урд талд ийм балгас байсан, суурь байсан. Тэрийг барилга болгохгүй арваад жил болсны дараа ингээд газраа зараад явсан юм шиг байгаа юм. Тэрний

дараа авсан компани нь 16 давхар барилга барих зөвшөөрөл авчихсан байгаа байхгүй юу. Төр нь өгчихсөн, тэрний дараа иргэд нь эсэргүүцэхээр эргэж очоод, НЗД байсан Нямбаатар өөрөө очиж тэр дээр цуцална гэдгээ мэдэгдэж байгаа юм. Дараа нь Пүрэвдагва дарга очиж сая цуцална гэдгээ мэдэгдэж байгаа юм.

Миний хувьд иргэдийнхээ санал бодлыг, хүсэлтүүдийг тэдэнд уламжилж өгч байгаа ийм л ажлыг хийж байгаа шүү дээ. Ингээд 2 дараалаад цуцлаад хаячихаар юу болж байна гэхээр, тэр ААН нь өөрөө хохироод байгаа юм. Тэгвэл эхнээс нь төр яах гэж тэр А буюу барилга барих зөвшөөрлийг өгөөд байгаа юм бэ? Өнөөдөр тэгээд очоод нягтаршил ихтэй ийм газруудад барилга барихгүй гээд ингээд ярьдаг, НИТХ-аар ч гэсэн ийм тогтоол гарч байсан, би маш сайн санаж байна. Бүх байрлалууд дээр нь харж байгаад энэ Сүхбаатар төлөөлөгч бид ярилцаад ингээд оруулж ирээд, тэгээд тэр дээр энэ батлагдаж байсныг санаж байна. Гэтэл энийгээ өөрсдөө уландаа гишгээд, тэгээд А зөвшөөрлөө өгчихдөг. Тэрний дараа ингээд хэн нь хохирч байна гэхээр иргэн нь хохирч байна, дээр нь нэмээд ААН өөрсдөө барилга барих зөвшөөрөл бүхий ийм компаниуд хохироод байгаа гэдгийг бид харах ёстой.

Ийм учраас хот төлөвлөлт маш ойлгомжтой, хот төлөвлөлтийн бүх нарийн байршил, юмнууд ямар ч иргэнд харагддаг болох ёстой. "Энэ байршил дээр би байшин авч болох юм уу, үгүй юм уу" гэдэг нь харагддаг байх ёстой, кадастр нь маш нарийн харагддаг байх ёстой. Тэгэхээрээ хуулийн хамрах хүрээг энэ рүү оруулж өгвөл маш сайн, орсон байгаа юм. Тэгэхээр энэ эхний.../минут дуусав/

С.Бямбацогт: Наранбаяр гишүүнд баярлалаа. Гишүүд үг хэлж дууслаа. Санал хураалтыг хойшлуулаад, нэгтгээд явуулна.

16.55 цаг

Тав.Ашигт малтмалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Засгийн газар 2026.05.26-ны өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/

Дараагийн асуудалдаа оръё. Ашигт малтмалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг хэлэлцэх эсэх хэлэлцүүлгийг явуулна. Хууль санаачлагчийн илтгэлийг Монгол Улсын ЗГ-ын гишүүн, Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайд Гонгорын Дамдинням танилцуулна. Индэрт урьж байна.

Г.Дамдинням: УИХ-ын дарга, МУИХ-ын эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Үндсэн хуулийн 6 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт "стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордыг ашиглахдаа байгалийн баялаг ард түмний мэдэлд байх зарчимд нийцүүлэн, түүний үр өгөөжийн дийлэнх нь ард түмэнд ногдож байх эрх зүйн үндсийг хуулиар тогтооно" гэж заасан. Монгол Улсын Их Хурлаас 2020 оны 1 дүгээр сарын 9-ний өдрийн 02 дугаар тогтоолын хавсралтаар баталсан Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтөд хууль тогтоомжийг нийцүүлэх хуваарийн 1.1-д Ашигт малтмалын тухай болон холбогдох бусад хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулж, УИХ-д өргөн мэдүүлэхийг ЗГ-т даалгасан байдаг. Мөн ХЗДХЯ-тай хамтран геологи, уул уурхайн салбарын харилцааг зохицуулж буй 10 голлох хуульд дүн шинжилгээ хийхэд 2006 онд батлагдсан Ашигт малтмалын тухай хуулийн шинэчилсэн

найруулгад нийт 153 өөрчлөлт, 111 удаагийн нэмэлт, хүчингүй болсон 29 зүйл заалт байгаа бөгөөд нийт 267 давхардал, 150 зөрчил, 150 хийдэл тогтоогдсон болно.

Ашигт малтмалын тухай хууль нь геологи, уул уурхайн салбарын харилцааг зохицуулдаг, оролцогч талуудын эрх ашгийг тэгш хангах салбарын гол хууль бөгөөд бусад хуультай нийцүүлэн давхардал, хийдэл, зөрчлийг арилгах шаардлага хэдийн үүсээд байна. Өнөөгийн байдлаар Монгол Улсын эдийн засаг уул уурхайгаас ихээхэн хамааралтай бөгөөд нөхөн сэргээгдэхгүй байгалийн баялгийг ашиглах бодлого нь уул уурхайн салбарын шууд болон дам нөлөөг дагасан эдийн засгаас бусад салбарыг дэмжих замаар улсын нийгэм, эдийн засгийн хөгжлийг хөгжүүлэх, иргэдийн амьдралын чанарыг дээшлүүлэх шаардлагатайг хөгжлийн бодлогын баримт бичгүүдэд тодорхой заасан байдаг.

Иймд Ашигт малтмалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулах үүрэг бүхий ажлын хэсгийг байгуулж, хуулийн төсөлд зарчмын шинж чанартай дараах асуудлуудыг тусгасан болно.

1 дүгээрт, хайгуулын ажлыг эрчимжүүлж, эрдэс баялгийн нөөцийг өсгөх зорилго тавилаа. Геологи, уул уурхайн салбар нь төрийн урт хугацааны тогтвортой, оновчтой, хариуцлагатай бодлого, шийдвэртэй байхаас хамааран хөрөнгө оруулалт, хариуцлагатай уул уурхайг дэмжсэнээр иргэдийн итгэлийг нэмэгдүүлэх, байгаль орчныг нөхөн сэргээх, тусгай зөвшөөрлийг зохистой түвшинд эдийн засгийн эргэлтэд оруулах эерэг үр дүнг бий болгох нь чухал алхам юм. Өнгөрсөн 30 жилийн хугацаанд 16880 гаруй тусгай зөвшөөрөл олгогдсоноос өнөөгийн байдлаар нийт газар нутгийн 4.6 хувийг хамарсан 2830 ашигт малтмалын хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрөл хүчин төгөлдөр байна. Үүнээс нийт газар нутгийн 3.4 хувийг хамарсан 1074 хайгуулын тусгай зөвшөөрөл, 1.2 хувийг хамарсан 1766 ашиглалтын тусгай зөвшөөрөл хүчин төгөлдөр байгаа буюу хайгуулын тусгай зөвшөөрөл ашиглалтын тусгай зөвшөөрлөөс 1.6 дахин бага байна.

Өнгөрсөн хугацаанд ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрлийг өргөдлөөр болон сонгон шалгаруулалтаар олгох зохицуулалттай байсан хэдий ч Ашигт малтмалын тухай хууль 2006 онд батлагдсанаас хойш 20 жилийн хугацаанд тусгай зөвшөөрөл олголтыг 2010-оос 2013 онд 3 жилийн хугацаагаар, 2019 оны эцсээс 1 жилийн хугацаагаар, нийт 4 жил зогсоосон бөгөөд 2018 оноос өргөдлөөр олгохыг бүрэн зогсоож, зөвхөн сонгон шалгаруулалтаар олгож байна. Хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтаар геологийн судалгаа, эрлийн ажлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу хориглосон, хязгаарласан болон сонгон шалгаруулалтаар тусгай зөвшөөрөл олгохоос бусад газарт буюу нийт нутаг дэвсгэрийн 16 хувьд гэрээгээр гүйцэтгүүлснээр улсын төсөвт ирэх ачааллыг бууруулах, геологийн суурь судалгааны ажлыг эрчимжүүлж, ашигт малтмалын нөөцийг өсгөн уул уурхайн салбарын тогтвортой үйл ажиллагааг дэмжиж, улмаар газрын төлөв байдал, гидрогеологи, геоэкологи, геотехник болон ХАА, аялал жуулчлал, улсын бүтээн байгуулалтад шаардлагатай суурь мэдээллийг бүрдүүлэх чухал ач холбогдолтой юм. Иймд эдийн засгийн өсөлтийг хангах урт хугацааны бодлогын зорилтод нийцүүлэн эрлийн хайгуул руу шилжих боломжийг нээж, хайгуулын тусгай зөвшөөрлийг олон төрлөөр олгох зохицуулалтыг тусгалаа.

Түүнчлэн хайгуулын тусгай зөвшөөрлийн хугацааг 2 дахин бууруулж, улмаар тусгай зөвшөөрлийн төлбөрийг жилүүдийн шатлалаар нь дунджаар 13 дахин нэмэгдүүллээ. Энэхүү зохицуулалт нь хайгуулын ажлыг мэргэжлийн түвшинд

эрчимжүүлэн, үр дүнг богино хугацаанд гаргах, хайгуулын тусгай зөвшөөрлийг удаан хугацаанд үр дүнгүй хадгалах, лицензийн наймаа хийх, бусдын боломжийг хаах асуудлыг эцэслэн шийдвэрлэх юм.

2 дугаарт, байгаль орчны нөхөн сэргээлт, уурхайн хаалтын зохицуулалтыг тодорхой болгох хариуцлагын тогтолцоог шинэ түвшинд гаргана. Уул уурхайн салбарт хувийн хэвшлийн оролцоо нээлттэй болсон сүүлийн 30 жилийн хугацаанд нөхөн сэргээлт, хаалтын эрх зүйн зохицуулалт хангалтгүй, тунхгийн шинжтэй, ёс төдий хэв шинжийг агуулсан зохицуулалттайгаас эзэнгүй орхигдсон, эвдэрсэн газрын хэмжээ 42 мянган га талбайд хүрч, улмаар нөлөөлөлд өртсөн орон нутгийн иргэд, байгаль орчноо хамгаалах иргэний нийгмийн байгууллагууд уул уурхайг эсэргүүцсэн үйлдлүүд гарсаар байна. Хариуцлагатай уул уурхайг төлөвшүүлэх зорилтын хүрээнд уурхай болон баяжуулах үйлдвэрийн хаалтын эрх зүйн зохицуулалтыг тусгаж, уг харилцааг боловсронгуй болгоно.

Ашиглалтын болон баяжуулалтын тусгай зөвшөөрөл олгоход хаалтын урьдчилсан төлөвлөгөөг техник эдийн засгийн үндэслэл /ТЭЗҮ/-д тулгуурлан боловсруулсан байхыг шаардах бөгөөд олборлолт, баяжуулалтын үйл ажиллагааны туршид хаалтын төлөвлөлтийг бодит нөхцөл байдалд нийцүүлэн тодорхой давтамжтайгаар тодотгож байхаар зохицуулна. Төсөл хэрэгжүүлэгч нь байгаль орчны нөхөн сэргээлтийг тасралтгүй хийж хэрэгжүүлэх бөгөөд уурхайг хаахаас өмнөх хугацааны 2/3 хугацааны өмнө шаардлагатай хөрөнгийг 100 хувь байршуулж, улмаар нөхөн сэргээлт, хаалтаа бүрэн хийсний дараа хөрөнгөө суллуулах хариуцлагыг тусгалаа.

3 дугаарт, чухал ашигт малтмалын талаарх анхны эрх зүйн орчныг бий болгож, бодлогоо тодорхой болгоно. Цэвэр эрчим хүчний үйлдвэрлэлийн хэрэгцээ нэмэгдэхийн хэрээр чухал ашигт малтмал критикал минералын ханган нийлүүлэлтийн эрсдэлтэй тулгарч байгааг улс орнууд анхааралдаа авч, бодлого стратегиа шинэчлэх, хэрэгжилтийн арга хэрэгслүүдээр хөгжүүлэх, үндэсний үйлдвэрлэл, ханган нийлүүлэлтийн аюулгүй байдлыг баталгаажуулах арга хэмжээг эрчимтэй хэрэгжүүлж байна. Үүний улмаас чухал ашигт малтмалын эцсийн хэрэглэгч улс орнууд төдийгүй түүний ханган нийлүүлэлтийн гинжин хэлхээнд оролцогч олборлогч, боловсруулагч улс орнууд ч чухал ашигт малтмалын бодлого, стратегиа тодорхойлсоор байна. Одоогоор дэлхийн улс орнууд дунджаар 30-аас 35 элемент болон эрдсийг чухал ашигт малтмалын жагсаалтад хамруулсан бөгөөд Монгол Улс эдгээрийн 1/3 нь эдийн засгийн эргэлтэд орсон, 1/3 нь нөөц нь тогтоогдсон болон үлдсэн хэсэг нь илрэлийн түвшин тогтоогдсон байдалтай байна. Иймд манай улс чухал ашигт малтмалын бодлогоо тодорхойлж, олон улсад танилцуулснаар энэ төрлийн ашигт малтмалын судалгааг гүнзгийрүүлэх, шинээр орд газруудыг нээх, эдийн засгийн эргэлтэд оруулах, хөрөнгө оруулалт татах, технологийн дэвшлийг нутагшуулах, бэлдэц бүтээгдэхүүн үйлдвэрлэх, дотоодын дэд бүтэц, хүний нөөцийн чадавхыг бэхжүүлэх боломж нээгдэнэ гэж үзлээ.

4 дүгээрт, орон нутгийн хөгжлийн санг арвижуулах, иргэдийн амьдрах орчин, нөхцөлийг дээшлүүлэх чиглэлд өөрчлөлт орно. Уул уурхайн үйлдвэрлэл явагдаж байгаа тухайн орон нутгийн иргэд уул уурхайн үйлдвэрлэлийн нөлөөлөлд хамгийн түрүүнд, хамгийн ихээр өртөж байдаг. Гэсэн хэдий ч өнөөдөр манай улсад хэрэгжиж буй орлогын тэгш хуваарилалтын зарчмаар уул уурхайгаас хүртэх өгөөжийг бусад орон нутагтай тэнцүү хэмжээгээр хүртэж байна. Энэхүү хуулийн төслөөр бид орлогын шударга хуваарилалтын зарчмыг санал болгож байна. Төсвийн тухай

хуулийн 59 дүгээр зүйлд заасан орон нутгийн хөгжлийн санд ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр /АМНАТ/-ийн орлогын 10 хувийг төвлөрүүлдэг байсныг 15 хувь болгож, 406 тэрбум төгрөгийн орлого ордог байсныг 200 тэрбумаар нэмэгдүүлэхээр тусгалаа.

Түүнчлэн орон нутгийн хөгжлийн санд хөрөнгө хуваарилах итгэлцүүрт АМНАТ-ийн орлогын хэмжээг шинээр нэмж тусгалаа. Энэхүү зохицуулалтын үр дүнд иргэдийн эсэргүүцэл буурах, уул уурхайн үйл ажиллагаа идэвхтэй явагдаж буй сум, орон нутагт илүү хөрөнгө оруулалт хийгдэх, байгалийн баялгийн үр өгөөж иргэдэд шууд очих боломж бүрдэнэ гэж үзлээ.

5 дугаарт, дотоодын үйлдвэрүүдийн эрх зүйн орчныг тодорхой болгож, нэмүү өртөг шингэсэн үйлдвэрлэлийг бий болгоно. Одоогийн хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа Ашигт малтмалын тухай хуулиар ашигт малтмалаа олборлох, баяжуулах үйл ажиллагааг дан ганц ашиглалтын тусгай зөвшөөрлийн үндсэн дээр эрхлэхээр зохицуулсан байдаг. Өөрөөр хэлбэл ашигт малтмалын ашиглалтын тусгай зөвшөөрөлгүй хуулийн этгээд баяжуулалтын үйл ажиллагаа эрхлэх хуулийн зохицуулалт орхигдсон байна. Манай улсад өнөөдрийн байдлаар 150 баяжуулах үйлдвэр ажиллаж байгаагаас 64 нь буюу 43 хувь нь өөрийн ордгүй, тусгай зөвшөөрөл эзэмшдэггүй ААН-үүд байна. Эдгээр ААН-үүдэд чиглэсэн нэгдсэн бодлого хэрэгжүүлэх, хуулиас гадуур баяжуулалтын үйл ажиллагаа явуулснаас үүдэн гарах хууль, эдийн засгийн эрсдэлээс хамгаалах, төрийн нийтийн өмч болох ашигт малтмалыг үнэгүйдүүлэхээс сэргийлж, АМНАТ-ийг бүрэн төвлөрүүлэх зэрэг асуудлыг нэг мөр шийдвэрлэх шаардлага үүсээд байгаа юм.

Иймд тусгай зөвшөөрөлгүйгээр ашигт малтмал баяжуулах үйл ажиллагаа эрхэлж байгаа харилцааг эрх зүйн зохицуулалттай болгох, ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигчийн баяжуулалтын үйл ажиллагааг гэрээгээр гүйцэтгэх, үүссэн үүсмэл орд ашиглах хуулийн этгээд баяжуулалтын тусгай зөвшөөрлийн үндсэн дээр үйл ажиллагаа эрхлэхээр хуулийн төсөлд тусгалаа. Ингэснээр ашигт малтмалын ашиглалтын тусгай зөвшөөрөлгүй хэдий ч ашигт малтмалыг баяжуулах, боловсруулах замаар нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүний үйлдвэрлэл нэмэгдэж, улс, орон нутгийн төсөвт төвлөрүүлэх татвар, хураамжийг урьдчилан тооцоолох, ашигт малтмалын нөөцөд хяналт тавих боломж бүрдэх юм.

6 дугаарт, зэсийн АМНАТ-ийг олон улсын жишигт нийцүүлэн хөрөнгө оруулалт татаж, баялгийн сангаа арвижуулах зорилтыг тавьсан болно. Зэсийн салбарт томоохонд тооцогдож буй улс орнуудын тухайд дунджаар 8-аас 10 хувийн ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийг ногдуулж байна. Ашигт малтмалын тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.5 дахь хэсэгт заасан зэсийн ашигт малтмалын боловсруулалтын түвшнээс хамаарч үндсэн хувь дээр нэмж ногдуулах АМНАТ-ийн хувь хэмжээг хэт өндрөөр тогтоож өгсөн нь Монгол Улсад шинээр зэсийн орд ашиглалтад оруулах нөхцөлийг бууруулж байна гэж үзэж байна. Иймд зэсийн ашигт малтмалын боловсруулалтын түвшнээс хамаарч үндсэн хувь дээр нэмж ногдуулах АМНАТ-ийн хувь хэмжээг олон улсын жишигт нийцүүлэн тусгасан бөгөөд төсвийн орлогыг бууруулахгүй байх зорилгоор Эрдэнэт уулын баяжуулах "Эрдэнэт үйлдвэр" төрийн өмчит үйлдвэрийн газрын төсөвт төвлөрүүлж байгаа АМНАТ-ийг хэвээр үлдээхээр зохицуулсан болно.

Хуулийн төсөл батлагдсанаар одоо үйлдвэрлэж буй 2.1 сая тонн зэсийн баяжмалын үйлдвэрлэл хуульд нэмэлт, өөрчлөлт орсноор 3.3 сая тонн хүртэл буюу

47 хувиар, АМНАТ-ийн ногдуулалтыг 2.2 их наяд төгрөг хүртэл буюу 37 хүртэл хувиар нэмэгдүүлэх боломж бүрдэнэ гэж үзэж байна. Мөн 2028 оноос 2032 оны хооронд хайгуулын ажил гүйцэтгэж, нөөцийг нь тогтоосон 20 төсөл хэрэгжих боломж бүрдэж, нийт 5.7 их наяд төгрөгийн хөрөнгө оруулалт хийгдэж, улс, орон нутгийн төсөвт 13.5 их наяд төгрөгийн татвар, хураамж.../минут дуусав/

С.Бямбацогт: Микрофоныг сунгая.

Г.Дамдинням: Үүнээс АМНАТ-өөр 4.1 их наяд төгрөг төвлөрүүлж, шинээр нийт 60 мянга орчим ажлын байр бий болохоор байна. Гэвч зэсийн АМНАТ-ийн хувь хэмжээг бууруулах асуудлаар УИХ-ын гишүүдийн гаргасан байр суурийг хүндэтгэн үзэж, зарим стратегийн ордын хөрөнгө оруулалтын гэрээний хэлцэл дуустал зэсийн АМНАТ-ийн зохицуулалтыг өөрчлөхгүй байх зарчмын байр суурьтай байгаагаа илэрхийлье.

Тус хуулийн төслийг Хууль тогтоомжийн тухай хуулийн дагуу салбарын оролцогч талууд болох иргэд, ААН, төрийн болон ТББ, олон улсын байгууллагуудад танилцуулан хэлэлцүүлсэн бөгөөд 21 аймгийн иргэд, нутгийн болон орон нутгийн байгууллагуудаар хэлэлцүүлж, нийт 1448 санал авч, саналыг нэгтгэн боловсрууллаа.

УИХ-ын дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Үндсэн хуульд нийцүүлэн боловсруулсан Ашигт малтмалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг хүсье. Анхаарал хандуулсанд баярлалаа.

С.Бямбацогт: Дамдинням сайдад баярлалаа. Төслүүдийн талаарх Эдийн засгийн байнгын хорооны санал, дүгнэлтийг УИХ-ын гишүүн Шинэбаярын Бямбасүрэн танилцуулна.

Ш.Бямбасүрэн: УИХ-ын дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын ЗГ-аас 2026 оны 5 дугаар сарын 26-ны өдөр УИХ-д өргөн мэдүүлсэн Ашигт малтмалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг Эдийн засгийн байнгын хороо 2026 оны 6 дугаар сарын 9-ний өдрийн хуралдаанаараа үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэх эсэх хэлэлцүүлгийг явууллаа.

Хуулийн төсөл санаачлагч нь газрын хэвлийн баялгийн үр өгөөжийг Үндэсний баялгийн санд төвлөрүүлэх, уул уурхайн салбарт бизнес эрхлэгчдийн үйл ажиллагаа явуулах эрх зүйн орчныг бүрдүүлэх, хайгуулын үйл ажиллагааг эрчимжүүлэн газрын хэвлийн баялгийн нөөцийг тогтоох, тус салбарт хөрөнгө оруулагчдыг нэмэгдүүлж, нийгэм, эдийн засгийн хөгжилд эерэг нөлөөлөл үзүүлэх, мөн тусгай зөвшөөрлийн төлбөрийг нэмэгдүүлэх, зарим төрлийн АМНАТ ногдуулах хувийг оновчтой тогтоох, баяжуулах үйлдвэрийг тусгай зөвшөөрлийн үндсэн дээр үйл ажиллагаа явуулж, хариуцлагатай уул уурхайн тогтолцоог бэхжүүлэх зорилгоор хуулийн төслийг боловсруулсан байна.

Байнгын хорооны хуралдаанаар хуулийн төслийг хэлэлцэх үед УИХ-ын гишүүн Үүрийнтуяа өндөр агуулгатай хүдэр баяжуулах процесс дамжаагүй атлаа

баяжмал ангиллаар экспортлогдож, үүний улмаас хүдэрт ногдох татварыг бүрэн авч чадахгүй байгаа асуудлыг энэ хуулийн төсөлд хэрхэн зохицуулж, цаашид ямар хяналтын механизм, стандартын өөрчлөлтөөр шийдвэрлэхээр төлөвлөж байгаа, АМНАТ-тэй холбоотойгоор дагалдах элемент, хаягдал болон эдийн засгийн үр өгөөжгүй хэсэгт хүртэл АМНАТ тооцож байгаа өнөөгийн тогтолцоог өөрчлөх, олон улсын жишигт нийцүүлэх зохицуулалтыг хуулийн төсөлд хэрхэн тусгасан талаар, Эрдэнэт үйлдвэрт АМНАТ-ийн одоогийн зохицуулалтыг хэвээр үлдээж байгаа шалтгаан, борлуулалтын орлогын өндөр хувийг татвар, ногдол ашигт төвлөрүүлж байгаа нөхцөлд тус үйлдвэрийн хөрөнгө оруулалт, аюулгүй ажиллагаа, урт хугацааны тогтвортой үйл ажиллагааг хэрхэн хангах талаар ямар бодлого баримталж байгааг, хэрэв тус төлбөрийн зохицуулалтыг өөрчлөхөд төсөвт их хэмжээний нөлөөлөл үзүүлэхээр байгаа тул Эрдэнэт үйлдвэрт үзүүлж буй татварын ачааллыг үе шаттайгаар өөрчлөх боломжийг судалсан эсэх,

УИХ-ын гишүүн Батнайрамдал Ашигт малтмалын тухай хуульд шинэчлэл хийх шаардлагатай гэдэгтэй санал нэгдэж байгаа талаар дурдаад, Онтрэ компанийн хэлэлцээр үргэлжилж буй энэ үед бусад АМНАТ-ийг хөндөхгүй, зөвхөн зэсийн АМНАТ-ийг өөрчлөх нь Монгол Улсын эрх ашиг, хэлэлцээний байр суурьт сөргөөр нөлөөлөх эрсдэлтэй бөгөөд Онтрэ компанитай хийх хэлэлцээр дуусах хүртэл зэсийн АМНАТ-ийг хөндөхгүй байх зарчмын байр суурийн талаар,

УИХ-ын гишүүн Г.Уянга Оюу Толгойн бүлэг ордтой холбоотой нэмэлт хөрөнгө оруулалтын гэрээ байгуулах хугацаанд зэсийн АМНАТ-ийн 10 хувийн таазтай холбоотой шинэ зохицуулалт Оюу Толгойн бүлэг ордод хамаарах эсэх, үүнийг дагаж мөрдөх журмын тухай хууль эсхүл УИХ-ын тогтоолоор зохицуулах эсэх гарц нь ямар байх, Оюу Толгойн хэлэлцээртэй холбоотой зэсийн АМНАТ-ийн асуудлыг хүлээлтэд оруулах нь цаашид хэрэгжих бусад зэсийн төслүүдэд сөргөөр нөлөөлөх эрсдэл үүсэх эсэх, ашигт малтмалын салбарын орон нутаг дахь хяналт, хэрэгжилтийг бэхжүүлэх зорилгоор аймаг, бүсийн түвшинд бүтэц, төлөвлөлттэй ажиллах тогтолцоог энэ хуулийн төсөлд яагаад тусгаагүй, цаашид хэрхэн шийдвэрлэх, маркшейдер мэргэжилд тусгай зөвшөөрлийг шинээр бий болгох үндэслэл, шаардлага, чухал, ашигт малтмалын төрөл, чиглэл тус бүрээр бодлого, зохицуулалтын замын зураг боловсруулж хэрэгжүүлэх үүргийг ЗГ-т олгож байгаа нөхцөлд энэ чиглэлээр хайгуул, олборлолт явуулж буй ААН-үүдийг хэрхэн дэмжих, чухал ашигт малтмалын зохицуулалт нь цаашдаа стратегийн ашигт малтмалын ордын адил хэт хатуу зохицуулалт руу шилжих эрсдэл үүсэх эсэх,

УИХ-ын гишүүн Очирбат УИХ-ын гишүүдээс өргөн барьсан Газрын тосны тухай хуулийн төсөл зэрэг бусад хуулийн төслүүдтэй уялдуулж салбарын шинэчлэлийг нэгтгэсэн цогц байдлаар боловсруулах боломж байсан эсэх, хуулийн нэмэлт, өөрчлөлт нь зэсийн АМНАТ болон хувийн хэвшлээр хайгуул хийлгэх асуудлыг хөндсөн нь тус салбарын бодлоготой нийцэж байгаа эсэх, сүүлийн 5 жилд улсын төсвийн хөрөнгөөр хийгдсэн хайгуулын ажлын үр дүн, өмнө нь ЗГ-ын шийдвэрээр дүйцүүлэн олгосон талбайтай холбоотой асуудлаас үүдэн хөрөнгө оруулагч ААН-үүдэд үүссэн хохирол, маргааны асуудлыг хэрхэн шийдвэрлэх, хөрөнгө оруулагч ААН-үүдийн эрх ашиг, итгэлийн асуудлыг шийдвэрлэхгүйгээр дахин хувийн хэвшлээр хайгуул хийлгэж, дараа нь тусгай зөвшөөрөл олгох асуудлын талаар,

УИХ-ын гишүүн Ш.Бямбасүрэн хуулийн төслийн 3Г чухал ашигт малтмалын жагсаалт батална гэсэн зохицуулалтын үндэслэл, шаардлага, үүнтэй холбоотойгоор татвар тогтворжуулалтын гэрээ болон хөрөнгө оруулалтын орчинд үүсэх асуудлыг хэрхэн зохицуулах, мөн эдийн засгийн ач холбогдолгүй дагалдах эрдэс, металлд АМНАТ ногдуулахгүй байж болохоор тусгасан нь Оюу Толгой гэх мэт томоохон ордуудад хамаарах эсэх, бичил уурхайг дэмжих эсвэл хязгаарлах эсэхийг хуулийн төсөлд ямар байдлаар тусгасан талаар,

УИХ-ын гишүүн Золжаргал Оюу Толгойн олборлолт, ашиглалт, ажиллагааны өнөөгийн нөхцөлтэй уялдуулан ногдол ашиг авах хугацааг наашлуулах, дамжуулан зээлийн зохицуулалтыг өөрчлөх, менежментийн оролцоог нэмэгдүүлэх асуудлаар 3Г хэлэлцээрийг хэрхэн үргэлжлүүлэхээр төлөвлөж байгаа, зэсийн АМНАТ-ийн өөрчлөлт нь тус хэлэлцээрт нөлөөлөх эсэх, стратегийн ач холбогдол бүхий ордод хөрөнгө оруулагч нь 34 хувиас дээш эзэмших боломжгүй байхаар тусгасан нь гадаадын хөрөнгө оруулалтыг хязгаарлах эсэх, баяжуулах үйлдвэр байгуулах үйл ажиллагааг тусгай зөвшөөрлөөр зохицуулах нь үйлдвэрлэлийг дэмжиж байгаа эсэх, маркшейдер мэргэжилд тусгай зөвшөөрөл шинээр бий болгож буй үндэслэл, шаардлагын талаар,

УИХ-ын гишүүн Жаргалан Оюу Толгойн асуудлаар УИХ-ын 2025 оны 120 дугаар тогтоолын үүрэг чиглэлийн хэрэгжилт ямар түвшинд явж байгаа, ялангуяа "Рио Тинто" компанитай хийж буй хэлэлцээрийн хүрээнд менежментийн төлбөр, зээлийн хүү зэрэг асуудлаар ямар ахиц гарсан талаар, зэсийн АМНАТ-тэй холбогдуулан төлбөртэй холбоотой зохицуулалт нь Онтрэ компанитай хийх хэлэлцээрт хэрхэн нөлөөлөх, чухал ашигт малтмалын жагсаалтыг 3Г баталдаг зохицуулалтын талаар, баяжуулах үйлдвэрийн тусгай зөвшөөрлийг 5 жилийн хугацаатай олгох, сунгахаар тусгаж буй зохицуулалт нь хөрөнгө оруулалтын тогтвортой байдлыг хангах боломжтой эсэх,

УИХ-ын гишүүн Цэнгүүн Ашигт малтмалын тухай хуульд стратегийн ач холбогдол бүхий ордын тусгай зөвшөөрөл эзэмшигч этгээдийн 34 хувиас дээш эзэмшилтэй холбоотой шаардлагыг биелүүлээгүй тохиолдолд бүрэн эрхт төлөөлөгч томилох зохицуулалт хэвээр хадгалагдаж байгаа нь Үндсэн хуулийн үзэл баримтлал болон хөрөнгө оруулалтын орчинтой нийцэж байгаа эсэх, стратегийн ордод 34 хувиас дээш эзэмшилтэй хөрөнгө оруулагчид бүрэн эрхт төлөөлөгч томилох зохицуулалттай улс орнуудын талаар, тус зохицуулалт нь хөрөнгө оруулагчдыг татахад сөрөг нөлөө үзүүлэх эсэх талаар,

УИХ-ын гишүүн Сайнзориг Ашигт малтмалын тухай хуулийн нэмэлт, өөрчлөлтийн орон нутгийн хөгжил, орон нутгийн эдийн засагт ямар бодитой үр нөлөө үзүүлэх, тусгай зөвшөөрөл эзэмшээд үйл ажиллагаа эрхлээгүй тохиолдолд лицензийн төлбөрийг нэмэгдүүлэх, хугацааны шаардлагыг чангатгах замаар лицензийн төвлөрлийг бууруулах зохицуулалт төсөлд туссан эсэх, Оюу Толгой төслийн хүрээнд 34 хувийн эзэмшлийг тусгай АМНАТ-өөр орлуулах хувилбарыг 3Г бодлогоор авч үзэж байгаа эсэх, Онтрэ компанийн талбайд олборлолт, ашиглалтын үйл ажиллагаа эхэлсэн эсэх, хэлэлцээр эцэслээгүй байхад ашиглалтын үйл ажиллагаа явуулсан нь гэрээг хүчингүй болгох үндэслэл болох эсэх талаар,

УИХ-ын гишүүн Батболд Ашигт малтмалын тухай хуулийн шинэчлэлийг эрчимжүүлж, уул уурхайн салбарт шинэ тоглогч оруулах, хайгуулын ажлыг нэмэгдүүлэх, боловсруулалтын түвшнийг ахиулах чиглэлээр ямар бодит

зохицуулалтууд тусгасан, Онтрэ компанитай хийх гэрээг хэзээ эцэслэхээр төлөвлөж байгаа, тус төслийн хүрээнд 20 хувийн АМНАТ-ийг төлбөрийн нөхцөлөөр хөрөнгө оруулалтын гэрээ байгуулах бодит боломж байгаа эсэх, уг хуулийн төслийн зэсийн АМНАТ-ийн зохицуулалтыг мөрдөх хугацааг хойшлуулахгүйгээр төсөл дууссан хугацаагаар нь хэрэгжүүлэх боломжтой эсэх талаар асуулт асууж, хариулт авлаа.

Хуулийн төслийн үзэл баримтлалтай холбогдуулан хуралд оролцсон гишүүд дэмжсэн, дэмжээгүй байр сууриа илэрхийлж, санал хэлэх үед УИХ-ын гишүүн Үүрийнтуяа хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжиж буйгаа илэрхийлээд, Эрдэнэт үйлдвэрийг бусдаас ялгаатай зохицуулж байгаа нь хууль Үндсэн хуулийн эрх тэгш зарчимд нийцээгүй, мөн АМНАТ, баяжуулах үйлдвэр, хяналтын тогтолцоо зэрэг олон асуудлыг илүү нарийвчлан тусгах шаардлагатай талаар, УИХ-ын гишүүн Очирбат хуулийн төслийн суурь судалгаа, тооцоо хангалтгүй, зөвхөн тодорхой ашиг сонирхолд чиглэсэн байдлаар боловсруулсан, уул уурхайн салбарын өргөн хүрээний асуудлыг шийдвэрлэж чадахгүй, хөрөнгө оруулагчдын өмнөх асуудлыг шийдээгүй, шинэ хөрөнгө оруулалт татах асуудал нь тодорхой бус байгаа учраас төслийг дэмжихгүй талаар, УИХ-ын гишүүн Жаргалан ЗГ-аас өргөн барьж буй томоохон хуулийн төслүүд ихэвчлэн дутуу боловсруулагдсан, тодорхой шийдэлгүй, нийгмийн хүлээлтэд хүрээгүй, Оюу Толгойн хэлэлцээрийн үр дүн, УИХ-ын 120 дугаар тогтоолын хэрэгжилт хангалтгүй байгаа тул төслийг дэмжихгүй талаар,

УИХ-ын гишүүн Сайнзориг хуулийн төслийг хэлэлцэхийг дэмжиж байгаа бөгөөд цаг алдалгүй мэргэжлийн түвшинд нягт нямбай ажиллах шаардлагатай, мөн ажлын хэсгийг ашиг сонирхлын зөрчилгүй бүрдүүлж, Эрдэнэт үйлдвэрийн болон бусад хөрөнгө оруулагчдыг ижил тэгш нөхцөл бүрдүүлэх талаар, УИХ-ын гишүүн Шижиэр Эрдэнэт үйлдвэр болон бусад ААН-үүдэд ялгаатай АМНАТ ногдуулж буй нь төрөөс ялгавартай хандаж буй хэлбэр гэж шүүмжилж, хөрөнгө оруулагчид болон орон нутгийн иргэдийн хоорондын зөрчлийг төр зохицуулж чадахгүй байгаа, уул уурхайн төслийн хэвийн хэрэгжих эрх зүйн орчныг бүрдүүлэх шаардлагатай талаар, УИХ-ын гишүүн Батнайрамдал Онтрэ компанитай хийх хэлцэл болон Оюу Толгойтой холбоотой асуудлыг цаг алдалгүй шийдвэрлэх, Оюу Толгойн хэлэлцээр, ногдол ашиг болон УИХ-ын 2025 оны 120 дугаар тогтоолын хэрэгжилтийг урагшлуулах, УИХ-ын гишүүн Заяабал инфляц өндөр, эдийн засаг удааширсан үед уул уурхайгаа түшиглэн эдийн засгаа идэвхжүүлэх шаардлагатай тул төслийг дэмжиж байгаа бөгөөд ялангуяа геологийн суурь судалгаанд хувийн хэвшлийг оролцуулах, уурхайн хаалт, нөхөн сэргээлтийн тусгай сан байгуулах, нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүний үйлдвэрлэл, ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийг бууруулах зүйтэй талаар.../минут дуусав/

С.Бямбацогт: Индрийн микрофон, цаг сунгая.

Ш.Бямбасүрэн: Байнгын хорооны хуралдаанаар Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.11 дэх хэсэгт заасныг баримтлан Ашигт малтмалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төсөл тус бүрийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжих эсэх санал хураалт явуулахад хуралдаанд оролцсон гишүүдийн олонх хуулийн төслийг хэлэлцэхийг дэмжсэн болно.

УИХ-ын эрхэм гишүүд ээ,

Ашигт малтмалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн Ашигт малтмалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай, Газрын хэвлийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Гол, мөрний урсац бүрэлдэх эх, усны сан бүхий газрын хамгаалалтын бүс, ойн сан бүхий газарт ашигт малтмал хайх, ашиглахыг хориглох тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Зөвшөөрлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Зөрчлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Уул уурхайн бүтээгдэхүүний биржийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Цөмийн энергийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуульд нэмэлт оруулах тухай, Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүдийг хэлэлцэх эсэх хэлэлцүүлгийг явуулсан талаарх Эдийн засгийн байнгын хорооны санал, дүгнэлтийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг та бүхнээс хүсье. Анхаарал хандуулсанд баярлалаа.

С.Бямбацогт: Бямбасүрэн гишүүнд баярлалаа. Гишүүд ээ, 17 цагаас санал хураалттай гээд зарлачихсан. Өнөөдөр маш олон саналууд, Бизнесийн эрх чөлөөний тухай хууль дээр 100 санал хураалт явна. Бусад хуулиудын төслүүд дээр санал хураалтууд байгаа. Тэгээд нэгэнтээ зарласан цагтаа санал хураалтаа явуулчихаад хэлэлцэх асуудлаа үргэлжлүүлэх үү? Өнөөдөр хэлэлцэх асуудал дөнгөж талдаа орж байгаа, цаг сунгаж хуралдахаас өөр аргагүй болох байх. Яагаад гэвэл чуулган одоо жоохон шахаж ажиллахгүй бол чуулганы төгсгөл рүү нэлээн асуудлууд шахагдана.

Гишүүдийг танхимдаа урьж байна. 17 цагаас санал хураалт зарласан байгаа, санал хураалтдаа хүрэлцэн ирцгээнэ үү. Бүлгүүдийн ажлын алба, бүлгийн дарга, дэд дарга нар, гишүүдийн зөвлөх, туслахууд гишүүдээ чуулганы танхим руу явуулаарай. Ирц бүртгэлийн санал хураалт явуулах уу? Гишүүд санал хураалтдаа бэлтгэе. Гишүүд санал хураалтдаа бэлтгэж, гишүүд суудлаа эзэлцгээе. Сая сүүлд орж ирсэн гишүүд хурууны хээ уншуулсан уу, хурууны хээгээ уншуулаад санал хураалтдаа бэлдчих, ирц бүртгэлийн санал хураалт явуулна. Батсуурь гишүүний хурууны хээ.

Ирц бүртгэлийн санал хураалт. 108 гишүүнээс 71 гишүүн танхимд хүрэлцэн ирсэн байна. Энэ байхгүй 37, татгалзаж байгаа гишүүд яг одоо танхимд байхгүй, ажлаа хийхгүй байгаа гишүүд шүү. Гишүүдийн зөвлөх, туслахууд гишүүддээ хэлээрэй. Тэгвэл саналаа өг. Саналаа өгөхгүй танхимдаа байж болохгүй шүү дээ. Бизнесийн эрх чөлөөний тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжих эсэх асуудлаар санал хураалт явуулна. Гишүүд санал хураалтад бэлтгэе. Зарим гишүүд бэлтгэж амжаагүй байх шиг байна шүү.

Түрүүн нэр гарсан гишүүдийн нэрсийг энд гаргаад тавьчихаж болохгүй юу? Ирц бүртгэлийн санал хураалтад оролцохгүй, чуулганы танхимд байхгүй гишүүдийг. Энд байна нэр. Алтанхуяг гишүүн, Амарбаясгалан гишүүн, Баатархүү гишүүн, Бат-Амгалан сайд, Батбаатар гишүүн, Батболд гишүүн, Батжаргал гишүүн, Батлут гишүүн, Болормаа нарын гишүүд, 2 Болормаа, Булгантуяа гишүүн, Ганбаатар гишүүн, Ганбаатар гишүүн, Ганбат гишүүн, Гантөмөр гишүүн, Доржханд сайд, Жавхлан гишүүн, Жаргалсайхан гишүүн, Мандхай гишүүн, Мөнхбаатар гишүүн,

Мөнхсайхан гишүүн, Мөнхтулга гишүүн, Мөнхтуяа гишүүн, Мэндсайхан сайд, Номин гишүүн, Отгонбаяр гишүүн, Очирбат гишүүн, Ундраа гишүүн, Учрал Ерөнхий сайд, Цогтбаатар, Дамдины Цогтбаатар гишүүн үү, байна, байна. Даваагийн Цогтбаатар гишүүн, Цогтгэрэл гишүүн, Чинбүрэн гишүүн, Чойжилсүрэн гишүүн, Шижир гишүүн, Энх-Амгалан сайд нарын сая нэр дурдсан гишүүд чуулганы хуралдааны танхимд хүрэлцэн ирнэ үү, ажлаа хийнэ үү. Гишүүдийн зөвлөх, туслахууд гишүүдээ ажилд нь ирүүлнэ үү чуулганы танхим руу. Баатархүү гишүүн байна, Дамдины Цогтбаатар гишүүн байна.

Санал хураалт явуулъя. Бизнесийн эрх чөлөөний тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалтад 108 оролцсоноос 68 гишүүн буюу 63 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

Хамт өргөн мэдүүлсэн 99 хуулийн төсөл байгаа.

Авто замын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалтад 108 оролцсоноос 70 гишүүн буюу 64,8 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ. Ерөнхий сайдад баярлалаа. Гүйгээд хүрээд ирлээ шүү.

Автотээврийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалтад 108 оролцсоноос 72 гишүүн буюу 66 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

4.Агаарын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя 108-аас 70 гишүүн буюу 64 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

5.Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя. 108 гишүүнээс 73 гишүүн буюу 67 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

6.Ажиллах хүчний шилжилт хөдөлгөөний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя. 108 гишүүнээс 68 буюу 63 хувийн саналаар санал дэмжигдлээ.

7.Амьтны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя. 8, санал хураалтад 108-аас 70 гишүүн буюу 64 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ. Шинэ дэгийн хуулиар энэ олон найруулгын саналуудыг бол бөөнд нь хураана. Агуулгын хуулиуд байвал тус тусад нь хураахаар өөрчилж байгаа.

8.Арбитрын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал

хураалт явуулъя. 108-аас 70 гишүүн буюу 64,8 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

9.Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя. 108-аас 71 буюу 65 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

10.Аудитын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя. 108-аас 70 гишүүн буюу 64 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

11.Ашигт малтмалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалтад 108 гишүүнээс 29 гишүүн буюу 26,9 хувийн саналаар энэ санал дэмжигдсэнгүй. 12. Саяын хэд билээ, саяын санал хураалт дэмжигдсэнгүй. Санал хураалтад оролцсон гишүүдийн олонх хуулийн төслийг үзэл баримтлалын хэлэлцэхийг дэмжээгүй тул хуулийн төслийг хууль санаачлагчид буцаах тогтоол батлагдсан тооцлоо.

12.Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя. 108-аас 74 гишүүн буюу 68 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ. 14.

13.Байгаль орчныг хамгаалах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя. 108-аас 74 гишүүн буюу 68 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

14.Байгалийн ургамлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя. 108-аас 73 гишүүн буюу 67 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

15.Банкны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя. 108-аас 72 буюу 66 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

16.Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя. 108-аас 70 буюу 64 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

17.Барилгын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя. 108-аас 73 буюу 67 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

18.Боловсролын ерөнхий хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын

томьёоллоор санал хураалт явуулъя. 108-аас 72 буюу 66 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

19.Гаалийн тариф, гаалийн татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя. 108-аас 70 буюу 64 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

20.Гаалийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя. 108-аас 69 буюу 63 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

21.Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя. 108-аас 67 буюу 62 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

22.Газрын тосны бүтээгдэхүүний тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя. 108-аас 69 буюу 63 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

23.Газрын тосны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя. 24. 108-аас 69 буюу 63 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

24.Газрын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя. 108-аас 70 буюу 64 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

25.Газрын хэвлийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя. 108-аас 66 буюу 61,1 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

26.Гамшгаас хамгаалах тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт. 108-аас 68 буюу 63 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

27.Генетик нөөцийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя. 108-аас 68 буюу 63 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

28.Геоземи, зураг зүйн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя. 108-аас 71 буюу 65 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

29.Гэрийн тэжээвэр амьтны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя. 108-аас 69 буюу 63 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

30.Гэрээт харуул хамгаалалтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя. 108-аас 61 буюу 56 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

31.Даатгалын мэргэжлийн оролцогчийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя. 108-аас 70 буюу 64 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

32.Даатгалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя. 108-аас 70 буюу 64 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

33.Дипломат албаны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя. 108-аас 71 буюу 65 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

34.Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя. 108-аас 68 буюу 63 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

35.Зар сурталчилгааны тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя. 108-аас 69 буюу 63 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

36.Засгийн газрын тусгай сангийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя. 108-аас 66 буюу 61 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

37.Зөвшөөрлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя. 108-аас 71 буюу 65 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

38.Зөрчлийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя. 108-аас 72 буюу 66 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

39.Зээлийн мэдээллийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын

томьёоллоор санал хураалт явуулъя. 108-аас 73 буюу 67 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

40.Кадастрын зураглал ба газрын кадастрын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя. 108-аас 73 буюу 67 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

41.Мал, амьтны эм, тэжээлийн нэмэлтийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя. 108-аас 69 буюу 63 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

42.Малын генетик нөөцийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя. 108-аас 68 буюу 63 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

43.Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын эргэлтэд хяналт тавих тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя. 108-аас 71 буюу 65 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

44.Монгол Улсын хилийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт. 108-аас 65 буюу 60 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

45.Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя. 108-аас 68 буюу 63 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

46.Нийгмийн даатгалын ерөнхий хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя. 108-аас 66 буюу 61 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

47.Нийгмийн халамжийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя. 108-аас 65 буюу 60 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

48.Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя. 108-аас 68 буюу 63 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

49.Ойн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя. 108-аас 72 буюу 66 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

50.Оюуны өмчийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя. 108-аас 73 буюу 67 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

51.Өргөн нэвтрүүлгийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя. 108-аас 68 буюу 63 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

52.Радио долгионы тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя. 108-аас 70 буюу 64 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

53.Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя. 108-аас 72 буюу 66 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

54.Согтууруулах ундааны эргэлтэд хяналт тавих, архидан согтуурахтай тэмцэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя. 108-аас 71 буюу 65 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

55.Стандартчилал, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээний итгэмжлэлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя. 108-аас 74 буюу 68 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

56.Тамхины хяналтын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя. 108-аас 71 буюу 65 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

57.Таримал ургамлын үр, сортын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя. 108-аас 73 буюу 67 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

58.Татварын мэргэшсэн зөвлөх үйлчилгээний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя. 108-аас 74 буюу 68 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

59.Төлбөр тооцоог үндэсний мөнгөн тэмдэгтээр гүйцэтгэх тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя. 108-аас 72 буюу 66 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

60.Төмөр замын тээврийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя. 108-аас 68 буюу 63 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

61.Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя. 108-аас 73 буюу 67 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

62.Төрийн хяналт шалгалтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя. 108-аас 74 буюу 68 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

63.Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя. 108-аас 74 буюу 68 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

64.Түгээмэл тархацтай ашигт малтмалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя. 108-аас 67 буюу 62 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

65.Тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийн эргэлтэд хяналт тавих тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя. 108-аас 69 буюу 63 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

66.Улсын бүртгэлийн ерөнхий хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя. 108-аас 73 буюу 67 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

67.Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя. 108-аас 71 буюу 65 хувиар энэ санал дэмжигдлээ.

68.Ургамлын эрүүл мэнд, ургамал хамгааллын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя. 108-аас 75 буюу 69 хувиар энэ санал дэмжигдлээ.

69.Усан замын тээврийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя. 100 хулиар зөвшөөрөл өгдөг байсан байна шүү дээ. 108-аас 74 буюу 68 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

70.Усны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалтад 108 гишүүн оролцсоноос 76 гишүүн буюу 70 хувиар энэ санал дэмжигдлээ.

71.Уул уурхайн бүтээгдэхүүний биржийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя. 108-аас 69 буюу 63,9 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

72.Үйлдвэрлэл, технологийн паркийн эрх зүйн байдлын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя. 108-аас 75 буюу 69,4 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

73.Үнэт цаасны зах зээлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя. 108-аас 73 буюу 67 хувиар энэ санал дэмжигдлээ.

74.Хадгаламж, зээлийн хоршооны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя. 108-аас 73 буюу 67 хувиар энэ санал дэмжигдлээ.

75.Харилцаа холбооны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя. 108-аас 70 буюу 64 хувиар энэ санал дэмжигдлээ.

76.Химийн хорт болон аюултай бодисын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя. 108-аас 76 буюу 70 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

77.Ховордсон амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай эд зүйлийн гадаад худалдааг зохицуулах тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя. 108-аас 69 буюу 63,9 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

78.Хог хаягдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя. 108-аас 70 гишүүн буюу 64 хувиар энэ санал дэмжигдлээ.

79.Хот байгуулалтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя. Та хэдийг л чилээхгүй гээд л явж байна шүү. 108-аас 74 буюу 68 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

80.Хот, суурин ус хангамж, ариутгах татуургын ашиглалтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя. 108-аас 72 буюу 66 хувиар энэ санал дэмжигдлээ.

81.Хөдөө аж ахуйн гаралтай бараа, түүхий эдийн биржийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя. 108-аас 74 буюу 68 хувиар энэ санал дэмжигдлээ.

82.Хөрөнгийн үнэлгээний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя. 108-аас 72 буюу 66 хувиар энэ санал дэмжигдлээ.

83.Хөрөнгө оруулалтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя. 108-аас 74 буюу 68 хувиар санал дэмжигдлээ.

84.Хөрөнгө оруулалтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя. 108-аас 76 буюу 70 хувиар санал дэмжигдлээ.

85.Хөрөнгө оруулалтын сангийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя. 108-аас 75 буюу 69 хувийн саналаар санал дэмжигдлээ.

86.Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя. 108-аас 71 буюу 65 хувиар санал дэмжигдлээ.

87.Хувийн хамгаалалтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя. 108-аас 67 буюу 62 хувиар санал дэмжигдлээ.

88.Хувиргасан амьд организмын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя. 108-аас 73 буюу 67 хувиар энэ санал дэмжигдлээ.

89.Хувь хүний орлогын албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя. 108-аас 71 буюу 65 хувиар энэ санал дэмжигдлээ.

90.Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье

гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя. 108-аас 72 буюу 66 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

91.Хүүхэд харах үйлчилгээний тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалтад 108 гишүүн оролцсоноос 36 буюу 33 хувийн саналаар энэ санал дэмжигдсэнгүй. Гишүүдийн олонх дэмжээгүй тул хуулийн төслийг үзэл баримтлалыг хүрээнд дэмжээгүй тул хууль санаачлагчид нь буцаалаа.

92.Цөмийн энергийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя. 108-аас 73 буюу 67 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

93.Чөлөөт бүсийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя. 108-аас 72 буюу 66 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

94.Шилэн дансны тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя. 108-аас 73 буюу 67 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

95.Шуудангийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя. 108-аас 75 буюу 69 хувиар энэ санал дэмжигдлээ.

96.Шүүх шинжилгээний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя. Уншсан. 108-аас 77 буюу 71 хувиар энэ санал дэмжигдлээ.

97.Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя. 108-аас 79 буюу 73 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

98.Эмнэлгийн тусламж, үйлчилгээний тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя. 108-аас 76 буюу 70 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

99.Эрүүл мэндийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя. 108-аас 72 буюу 66,7 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

100.Эрчим хүчний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын

томъёоллоор санал хураалт явуулъя. 108-аас 76 буюу 70,4 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

Бизнесийн эрх чөлөөний тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг санал хураалтад оролцсон гишүүдийн олонх дэмжсэн тул төслүүдийг анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Эдийн засгийн байнгын хороонд шилжүүллээ.

18.05 цаг

Одоо 2 хуулийн төслийн санал хураалт байгаа. 30 дугаар хуудас уу. 18 цаг болсон байна. Өнөөдрийн хэлэлцэх асуудлаа дуустал хуралдааны, чуулганы хуралдааны цагийг сунгаж байна. 2 санал хураалт байгаа шүү гишүүдээ. Түр хүлээж байгаарай. Гишүүд.

Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжих эсэх асуудлаар санал хураалт явуулна. Гишүүд санал хураалтдаа бэлтгэе. Санал хураалтдаа бэлтгэцгээе. Санал хураалт явуулна.

Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалтад 108 гишүүн оролцсоноос 72 буюу 83 гишүүн буюу 76 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын тухай, Эрдэнэболд гишүүнийг дэмжсэнээр авъя. 84 гишүүн дэмжлээ.

Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг санал хураалтад оролцсон гишүүдийн олонх дэмжсэн тул анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Хууль зүйн байнгын хороонд шилжүүллээ.

18.07 цаг

Дараагийн санал хураалт. Улсын бүртгэлийн ерөнхий хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүдийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжих эсэх асуудлаар санал хураалт явуулна. Гишүүд санал хураалтдаа бэлтгэе. Санал хураалт явуулна.

Улсын бүртгэлийн ерөнхий хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалтад 108 гишүүн оролцсоноос 84 гишүүн буюу 77 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

Хамт өргөн мэдүүлсэн 7 хуулийн төсөл байгаа.

2.Барилгын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя. 108-аас 81 гишүүн буюу 75 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

3.Иргэний хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя. 108-аас 79 гишүүн буюу 73 хувиар энэ санал дэмжигдлээ.

4.Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя. 108-аас 78 гишүүн буюу 72 хувиар энэ санал дэмжигдлээ.

5.Үл хөдлөх эд хөрөнгийн барьцааны тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя. 108-аас 81 буюу 75 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

6.Үл хөдлөх эд хөрөнгийн албан татварын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя. 108-аас 76 буюу 70 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

7.Хаягжуулалтын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя. 108-аас 79 гишүүн буюу 73 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

8.Эд хөрөнгийн эрхийн бүртгэлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя. 108-аас 81 гишүүн буюу 75 хувиар энэ санал дэмжигдлээ.

9.“Хууль хэрэгжүүлэх арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя. 108-аас 80 гишүүн буюу 74 хувиар энэ санал дэмжигдлээ.

Улсын бүртгэлийн ерөнхий хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүдийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг санал хураалтад оролцсон гишүүдийн олонх дэмжсэн тул төслүүдийг анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Хууль зүйн байнгын хороонд шилжүүллээ. Орон сууцны залилан. Энэ орон сууцны залилантай холбоотой хууль байгаа.

18.11 цаг

Дараагийн асуудалдаа оръё. Ашигт малтмалын тухай хуулийн нэмэлт, өөрчлөлтийг хэлэлцэж эхэлсэн байгаа. Ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг та бүхэнд танилцуулъя.

Гонгорын Дамдинням Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайд, Буриадын Дашпүрэв Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамны Төрийн нарийн бичгийн дарга, Пүрэвжавын Баянбаатар Ашигт малтмал, газрын тосны газар /АМГТГ/-ын дарга,

Гүнчинсүрэнгийн Намчинсүрэн Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамны Уул уурхайн бодлогын газрын дарга, Намсрайн Мөнхбилэг Үндэсний геологийн албаны дарга, Хүрэлбаатарын Санчигдорж Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамны Геологийн бодлогын газрын дарга, Сэр-Одын Ган-Очир АМГТГ-ын Хайгуул, ашиглалтын газрын дарга, Мөнхсайханы Энхтулга АМГТГ-ын Кадастрын хэлтсийн дарга.

Ажлын хэсгийн бүрэлдэхүүнд, ЗГ-ын гишүүн, ажлын хэсгийн гишүүдэд УИХ-ын үйл ажиллагаанд, УИХ-д хүндэтгэлтэй хандахыг хүснэ. УИХ-ын гишүүдийн асуултад үнэн зөв, бодитой хариулт өгнө. Худлаа мэдээлэл өгөх, асуултад хариулахаас цааргалах, түдгэлзэх болохгүй. Хэрвээ саяын хэлсэн асуудлаар зөрчил гаргавал холбогдох хариуцлага тооцдог болохыг хууль сануулж анхааруулъя.

УИХ-ын гишүүд Байнгын хорооны санал, дүгнэлт, хууль санаачлагчийн илтгэл болон хуулийн төслүүдийн үзэл баримтлалтай холбогдуулан гишүүдээс урьдчилан ирүүлсэн нэрсийн дагуу асуулт асууна. Энэ асуудлууд болон бусад асуудлыг хуралдаан дуустал, өнөөдрийн хэлэлцэх асуудал дуустал хуралдана.

Санал хураалтуудыг маргааш өглөө 10 цагаас нэгдсэн байдлаар явуулна. Наранцэцэгийн Алтаншагай гишүүн асуултаа асууна уу.

Н.Алтаншагай: Хуулийн төсөлтэй холбоотой дараах асуултууд байна. Монгол Улс бараг уул уурхайн орон гээд хэлчихэд хилсдэхгүй байна. Энэ улсын төсвийн бүрдүүлэлтийн дийлэнх хувь нь уул уурхайгаас хэт хамааралтай байгаа. 2008 онд 4 мянга гаруй байсан хайгуулын тусгай зөвшөөрөл 2024 онд 840 хүртлээ буурсан. Энэ гадаадын хөрөнгө оруулалт буурч, үүнтэй холбоотойгоор гадаадын хөрөнгө оруулалт 3 дахин буурсан гэсэн ийм нэг тоон үзүүлэлт, статистик мэдээлэл байна. Хайгуулын тусгай зөвшөөрөл олгох нь манай улсын ашигт малтмалын нөөцийг нэмэгдүүлэх, гадаад, дотоодын хөрөнгө оруулалтыг татах ийм өндөр ач холбогдолтой. Гэтэл бид олгосон хайгуулын зөвшөөрөл, ашиглалтын зөвшөөрлөө төр маань нэгэнт олгочхоод хамгаалж чадахгүй байна. Үүнтэй холбоотойгоор ААН-үүд үйл ажиллагаа явуулахад маш хүндрэлтэй байгаа. Энэ дээр, энэ хууль дээр яаж тусгасан бэ, яаж хамгаалах вэ, 1 дүгээр асуудал?

2 дугаарт, энэ бичил уурхай эрхлэгчид, нөхөрлөл, хоршоодоос ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр авах гэж заалт орсон байна гэж ойлгож байгаа. 1990 оноос 2000 он хүртэл бидний нэршсэнээр нинжанууд, 2000 оноос 2010 он хүртэл нөхөрлөл хэлбэрээр явсан, 2010-аас 2020 он хүртэл бичил уул уурхай эрхлэгчид гээд ингээд сүүлийн 30 жилд 3 үе шатыг дамжаад ирсэн ийм нэг бүтэц, процесс байгаа байхгүй юу. Тэгэхээр сүүлийн үед бичил уул уурхай эрхлэгчид, энэ нөхөрлөлүүд маань хэт их техникжсэн, тэгээд энэ нөхөн сэргээлт хийгддэггүй, татвар төлдөггүй ийм хариуцлагагүй уул уурхай явснаас энэ иргэдийн итгэл алдарч, маш хүнд нөхцөл байдал үүссэн.

Ялангуяа Төв аймаг, Сэлэнгэ, Булган, Архангай аймгийн нутаг дэвсгэрүүд дээр 2000 оноос 2015 он хүртэл ерөнхийдөө энэ бичил, гар аргаар алт олборлогчид ер нь дураараа дургилаа шүү дээ. Сүүлд энэ нөхөн сэргээлттэй холбоотой Төв аймгийн Заамар сумын нутаг дэвсгэрт хүүхдийн амь эрсэдсэн харамсалтай үйл явдал болсон. Тэгэхээр энэ дээр яг гол, гол бодлогын зохицуулалт, эргээд энэ нөхөн сэргээлт хийх, хамгаалах, мөн энэ хөрөнгө оруулагч нараа тал бүрээс нь дэмжих

гээд энэ бодлогын зохицуулалтуудыг яг нарийн тусгаж өгч чадсан уу, энэ хүлээлт орсон уу? Хариулт аваад дараа нь нэмэлт асуулт асууя Их Хурлын даргаа.

С.Бямбацогт: Дамдинням сайд хариулъя.

Г.Дамдинням: Алтаншагай гишүүний асуултад хариулъя. Үнэн, их чухал асуудлуудыг, энэ улс орныхоо эдийн засагт нөлөөтэй энэ асуудлуудад үнэхээр яг голыг нь олж асуулт асууж байна. Монгол Улс өнгөрсөн 30-ад жилийн хугацаанд тусгай зөвшөөрлөөр 16880 гаруй тусгай зөвшөөрөл олгосноос өнөөгийн байдлаар нийт газар нутгийн 4.6 хувийг хамарсан 2830 ашигт малтмалын хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрөл байна. Нэг гажиг бий болчихоод байгаа юм. Юу вэ гэхээр хайгуулын тусгай зөвшөөрөл маань ашиглалтын тусгай зөвшөөрлөөсөө 1.6 дахин цөөхөн болчихоод байгаа юм. Ийм уул уурхайн суурьтай эдийн засагтай орон байхгүй. Дэлхийн дунджаар ер нь хайгуулын тусгай зөвшөөрөл ашиглалтын тусгай зөвшөөрлөөсөө хамгийн багадаа 5 дахин их байж, ирээдүйн эдийн засгаа хангаж, тэтгэж явах эх үүсвэрүүдээ бэлэн болгож байдаг. Хайгуулын тусгай зөвшөөрөл болгон, ашиглалтын тусгай зөвшөөрөл болгон уурхай болдоггүй. Монгол Улсын дундаж статистик мянган хайгуулын тусгай зөвшөөрлөөс нэг уурхай гардаг ийм статистик байгаа. Тэгэхээр энийг нээж байж бид явах ёстой.

Хамгаалах тухай асуудал байгаа. Хууль ёсны дагуу үйл ажиллагаа явуулж байгаа ААН-үүдийг очоод зогсоочихдог, тэгээд хөрөнгөө гаргаад, эрсдэлээ хийгээд явж байгаа энэ хүмүүсийг хамгаалах механизм байдаггүй, 100 мянган төгрөгөөр торгоод явуулдаг ийм л байсан. Тэгэхээр энэ хуулиар энэ хамгаалалтын зохицуулалтыг оруулж ирж байгаа. Өөрөөр хэлбэл, хууль ёсоор үйл ажиллагаа явуулж байгаа ААН-үүдийн үйл ажиллагаанд саад учруулбал Зөрчлийн тухай хуулиар шийтгэдэг болох ийм зохицуулалтыг оруулж ирсэн. Хүний эрхийн Үндэсний Комисс, Монгол Улсын Дээд шүүх, УЕП-оос дүгнэлт авч энэ хуулийн зохицуулалтад оруулж өгсөн байгаа.

2-р асуудал, бичил уурхай. Бичил уурхай манай энэ салбарын нэр хүндийг маш их унагааж байгаа. Үнэн, бүртгэлтэй, бүртгэлгүй нөхөрлөлүүд байна. Тэгэхээр бид энийг 1 дүгээрт бүртгэдэг болгож байгаа Алтаншагай гишүүн, 2 дугаарт АМНАТ төлөгч этгээд болгож байгаа. Хуучин ерөөсөө АМНАТ төлдөггүй, бүртгэл хийдэггүй, тэгээд ерөөсөө засаг замбараагүй энэ салбарын нэр хүндийг унагаасан ийм байсан, энийг хариуцлагатай болгож байгаа. 3-д нь нөхөн сэргээлттэй холбоотой асуудал. Нөхөн сэргээлттэй холбоотой асуудал харьцангуй муу явсан. Шинэ хуулиар бид тухайн уул уурхайн орд газрын ашиглалтын нийт хугацааны 2/3 нь өнгөрч байхад нөхөн сэргээлтийн баталгааны хөрөнгийн 100 хувь Байгаль орчны яамны дансанд хуримтлуулж байхаар оруулсан. ААН өөрөө нөхөн сэргээгээд мөнгөө буцаагаад авч болно, эсвэл мэргэжлийн ААН энэ мөнгөөр нь нөхөн сэргээлт хийж болдог ийм зохицуулалтыг хийж байгаа.

Улсын Их Хурлын дэд дарга Б.Пүрэвдорж 18 цаг 19 минутаас хуралдааныг даргалав.

Б.Пүрэвдорж: Гишүүн тодруулъя.

Н.Алтаншагай: Баярлалаа. Энэ орон нутгийн өөрөө удирдах байгууллагууд энэ нөхөрлөлүүдэд зөвшөөрөл өгөөд байгаа шүү дээ. Саяхан энэ хэвлэлийн мэдээгээр гараад 2, 3 Засаг дарга ял авлаа гээд, энэ зохицуулалтаар яг ямар

зохицуулалт энэ дээр орсон бэ? Энийг ер нь хаах ёстой шүү. Тухайн шатны сумын удирдлагууд, ИНХ гээд энэ нөхдүүд чинь лоббинд автдаг. Жинхэнэ нөгөө нэг авлигын, нэг бичил авлигын тэр схем чинь тэр дээр байх магадлалтай, нөхөрлөлүүдэд өгдөг, тэр иргэдийн бүлэгт гээд өгдөг, тэгээд ухуулдаг. Нөгөөдүүл нь тэгээд л ухчаад л, сүйтгэчихээд л тэр алтыг нь аваад л алга болчихдог. Түрүүний таны хэлдгээр тэр нөгөө татварууд, олон төрлийн татвар ямар ч төлөлт байхгүй, нөхөн сэргээлт байхгүй, энэ дээр энэ хаалтын зохицуулалтууд яаж орсон бэ?

Б.Пүрэвдорж: Дамдинням сайд хариулъя.

Г.Дамдинням: Одоо бол тийм, Алтаншагай гишүүн яг голыг нь олж байна. Яг л ийм зовлонтой асуудал байгаад байгаа. Одоо бүртгэлтэй болон бүртгэлгүй нөхөрлөлүүд гэдэг нэг юм гарчихсан, тэгээд энэ орон нутгийнхан маань өгчихдөг, манай энэ ашигт малтмалын бодлого хариуцдаг энэ агентлагт бүртгэл байдаггүй, тэгээд ер нь юу нь мэдэгддэггүй, суман дээрээ л бужигнуулаад байдаг. Ашигт малтмалын хулгай, зэлгий тэндээс олох, ашигласны нөөц татвар ер нь орж байгаа юм байдаггүй. Тэгэхээр энэ удаад бид хуулийн төслөөр заавал бүртгүүлдэг байх, тусгай зөвшөөрөлтэй байдаг ийм нөхцөл рүү оруулж байгаа юм.

Б.Пүрэвдорж: Сайнхүүгийн Ганбаатар гишүүн асуулт асууна.

С.Ганбаатар: Би Ашигт малтмалын тухай хуулийг асууя. Ашигт малтмалын тухай хууль яригдаж байхад гадаа иргэд жагсаж, цуглаад үзэл бодлоо илэрхийлж байгаа. Ерөнхий сайд Учрал, УИХ-ын дарга Бямбацогт хэзээ энэ ард иргэдтэй уулзах вэ? Өнөөдөр үү, хэзээ вэ, 1 дүгээр асуулт. Ардын намын удирдлагууд өнөөдөр сонгууль болохоор "Жорлонг нь ухах өгье" гээд л гуйгаад л гүйлддэг, одоо нүдний булай болохгүй энэ 50-хан метрийн цаана байгаа ард иргэдтэй уулзаж, зөвшилцөж, ойлгож, ярилцах ёстой. Та нар Монголын ард түмнийг үзэл бодлоо илэрхийлж байгаад үл ойшоосноос болж хүчирхийлэл рүү турхирч байгаа гэдгээ ойлгоорой. Би хуулийн дагуу асууж байна. Хууль тогтоомжийн тухай хуулийн тухайд заавал зөвшилцөж, ярилцаж, ард түмэнтэй, төлөөлөлтэй уулзсан байх ёстой, 1 дүгээр асуулт?

2 дугаар асуулт, Эрдэс баялгийн яамны сайдаас 2 асуулт байгаа. Эхлээд би Эдийн засгийн яамны сайд Ж.Энхбаяр, Сангийн сайд Мэндсайхан нараас асуулт асууя. Эдийн засгийн үр өгөөж, баялгийн төлбөрийн талаар, татварын талаар асуулт асууя. Та нар 5 хувийн баялгийн АМНАТ-ийг 1.7 хувь болгоё гэж орж ирж байна. Үгүй ээ, мөн гайхамшигтай юм. Хэдэн төгрөгийг Монголын ард түмнээс хулгайлж байгааг мэдэж байна уу, 600 орчим тэрбум төгрөг. Энэ мөнгөөр Улаанбаатар метротой болно, боловсрол, эрүүл мэндийн салбарын ажилчдынхаа цалинг нь нэмж чадна, тэтгэврээ нэмнэ. Энэ боломжийг яагаад "Рио Тинто"-д бэлэглэж байгаа юм бэ? Миний асуулт энэ эдийн засгийн дүн шинжилгээний асуулт учраас Эдийн засгийн яам, Сангийн яаман дээр ямар шинжээч, экспертүүдээс зөвлөгөө авсан бэ? Энийгээ ил тод хэлээч, сайдууд энэ талаар юу ч мэдэхгүй байна.

2-р асуулт, Чили өнөөдөр 5-аас 14 хувийн рояалти хөдөлгөж байгаа, зарим тал дээр тохируулсан татварын орлого гэдэг нь 8-аас 26 хувь, дээд тал нь 46.5 хувийн татвар төлж байгаа. Үгүй ээ, Чили ингээд өнөөдөр зэс өсөж байхад рояалтигаа болон татваруудаа нэмж байхад манайх зөрүүлээд бууна гэж юу гэсэн үг вэ?

Миний дараагийн асуулт, дэлхий дээр зэсийн үнэ манай Монголд чинь 4200-аас 4800 доллар байсан шүү, анх дөнгөж эхэлж байхад 10 гаруй жилийн өмнө. Одоо 13800 доллар болчихоод байхад тонн нь, буулгаад ард түмнээ аварсан ямар орон байгаа вэ? Та нэг жишээ хэлээд өгөөч. Канад өсгөж байна, Казахстан өсгөж байна, Чили өсгөж байна. Монголын сайд нарыг би тэнэг гэж мэднэ л дээ, тэгсэн чинь харин бүр шал тэнэг юм байна, энийг хэлэх үг алга. Ард түмнээсээ ингэж боломжийг нь хулгай хийж байна гэдэг, та нар ядаж мөнгө өгдөггүй юм гэхэд өгөх гэж байгаа, тэртээ тэргүй та нартай та наргүй өсөж байгаа зэсийн үнээс авах ёстой юмыг нь битгий буулгаач. Эдийн засгийн яам, Сангийн яаман дээр энэ эдийн засгийн үр өгөөжийн тооцоо хийж байх ёстой, асууж байна?

3 дахь асуулт. Өнөөдөр яагаад Эрдэнэт ГОК 21.6 хувийг төлж болоод байхад хувийн компаниас 5 хувийг авахаасаа татганаад 1.7 хувь авах гээд байгаа юм бэ? Энэ ноцтой асуулт шүү. Үндэсний Эрдэнэтийн үйлдвэрийг 21.6 гэж дээрэлхчхээд, яагаад хувийн компаниас 1.7 хувь авах гээд байгаа юм, ичиж үхмээр л гэж хэлмээр байгаа юм, үхэхгүй л дээ та нар.

2-р асуулт, энэ Ашигт малтмалын тухай хуулийн талаар Дамдинням сайдаас асуучихъя. Ашигт малтмалын тухай хуулийн 64 дүгээр зүйлд тусгай зөвшөөрөл эзэмшигч нь хуульд заасан эрхээ хэрэгжүүлэхийн тулд учруулсан хохирлыг.../минут дуусав/

Б.Пүрэвдорж: Дамдинням сайд хариулъя. Уучлаарай, Дамдинням сайд хариулахаас өмнө Сангийн сайд, Эдийн засгийн сайд нар энэ танхимд орж ирэхийг шаардаж байна, нэмэлтээр хариулъя.

Г.Дамдинням: Ганбаатар гишүүний асуултад би хариулчихъя, миний авч орж ирж байгаа хууль учраас. Энэ АМНАТ зэс дээр яригдаж байсан, энд Ганбаатар гишүүнээ, 1.7 гэсэн хувь байхгүй. 2 дугаарт, АМНАТ-ийг зэс дээр одоо байгаа яг хэвээр нь явъя гэдэг ийм байр суурьтай байгаагаа танилцуулга дээр дурдаж уншсан.

Гэхдээ нэг зүйлийг хэлье. Юу вэ гэхээр Монгол Улс зэсийн хүлээгдэж байгаа 20 төсөлтэй байна. Энэ 20 төслийг хөдөлгөх гэхээр 21.6 хувийн АМНАТ-тэй, манайх борлуулалт дээр суурилсан АМНАТ-тэй, Чили бол ашиг дээр суурилсан АМНАТ-тэй таны харьцуулж байгаа. 46 хувийн өгөөжийг авна гэдэг чинь яг бүгдийг нь нийлүүлээд авч байгаа хэлбэр, манай улсын тухайд дахиад Цагаансуварга, Хармагтай тэргүүтэй 20 ордоо яаралтай хөдөлгөөд, энэ Рио Тинто гэж ганц хөрөнгө оруулалтаас хамааралтай байдлаасаа гарах л бодлого дэвшүүлэх гээд оролдож байгаа юм. Бид дахиад нэг Эрдэнэт үйлдвэртэй, дахиад нэг Оюу Толгойтой болчихвол ганцхан таны олон жил үзэж тарж байгаа энэ төслөөс, хөрөнгө оруулалтаас хамааралтай байдлаа бууруулах гэж л оролдоод байгаа юм. Яг үнэнийг хэлэхэд энэ зэсийн АМНАТ-ийг буулгана гэдэг нь нөгөө талдаа уулын баяжуулах Эрдэнэт үйлдвэрээ ашигтай ажиллуулаад, ногдол ашгаа илүү авах, дээрээс нь ААНОАТ-аа илүү авах ийм бодлого байгаа давхар цаана нь.

2 дугаарт хамгийн чухал нь шинэ өөр төслүүдээ хөдөлгөж аваад ганцхан төслийн базаанд ороод байгаад байгаагаа болимоор байгаа байхгүй юу. Оюу Толгой дээр бид тавхан хувийн АМНАТ-тэй байхгүй юу. Тэгээд Рио Тинтотой хэлэлцээрт ороод зогсоочхож чаддаггүй, сайжруулж ч чаддаггүй, "гар" гээд хэлчхэж чаддаггүй. "Гарах юм бол гар" гэвэл 1.6 их наяд төгрөгийн төсвийн орлого тасрах

гээд байдаг, "гаргахгүй" гэхээр ганцаараа байгаа хүн биднийг "гаргаж чадахгүй шүү дээ" гэсэн байртай байгаад байдаг. Тэгэхээр 2, 3 том төсөлтэй болж байж нэгийг нь "Та гарч болно" гэж хэлж чаддаг бярттай болох ийм л бодлого юм уг нь. Олон улсын дунджид аваачиж өрсөлдье л гээд байгаа юм бид. Ийм хэмжээнд хийхгүй бол 21.6 хувь дэлхийн хамгийн өндрүүдийн нэг. Тэгэхдээ энэ хуулийн хүрээнд бид энэ зэсийн АМНАТ-ийг энэ Онтрэ хэлэлцээр дуусан дуустал хөдөлгөхгүй байя гэсэн ийм байр суурьтай байгаа.

Б.Пүрэвдорж: Сангийн сайдаас асуугаад байгаа, ямар эксперт яагаад ингэж зөвлөсөн юм, яагаад бусад орнууд ингээд буулгаад байхад, өсгөөд байхад манайх буулгаад байгаа юм бэ, үндэслэл юу вэ гэж асуусан. Буулгасан ямар орон байгаа юм бэ?

З.Мэндсайхан: Ганбаатар гишүүний асуултад хариулъя. Дамдинням сайд сая маш тодорхой хариуллаа. Энэ татварын өөрчлөлтөөр ирэх оны төсөвт ямар ч нөлөө байхгүй. Бид зэсийн хоёрхон үйлдвэртэй, та илүү маш сайн мэдэж байгаа. Таны маш их байнга ярих болгондоо дурддаг Оюу Толгой чинь хөрөнгө оруулалтын гэрээгээрээ АМНАТ-өө төлөөд явж байгаа, энийг та сайн мэдэж байгаа. Эрдэнэт үйлдвэр бол тусгайлсан тогтоолоор явж байгаа, энэ хууль дотор орж ирээгүй. Ганцхан Эрдэнэт үйлдвэр маань дэлхийд байхгүй татвар төлж байгаа. Бид дахиад өөр шинэ төслүүдтэй болъё, шинэ зэсийн үйлдвэрүүдтэй болъё. Энэнээсээ авах АМНАТ-өө тэр хөрөнгө оруулагч нараа татахын тулд энд татварын бодлого орж ирж байгаа. Түүнээс биш одоо байгаа 2 дээр чинь юу ч өөрчлөгдөөгүй. Тийм учраас шинээр орж ирэх, шинээр эхлэх төслүүд дээр чинь энэ бодлого хэрэгжээд явна. Энэ хууль батлагдах юм бол.

Б.Пүрэвдорж: Сайнхүүгийн Ганбаатар гишүүн нэмж тодруулъя.

С.Ганбаатар: Энэ чинь юу ч асуудлаа мэдэхгүй улсууд байна шүү дээ. Өнөөдөр татварын таатай нөхцөл бүрдэх л юм бол Оюу Толгой, Рио Тинто энийг чинь ашиглана гээд гэрээндээ заачихсан байгаа шүү дээ. Тэгээд энийг чинь "Таатай нөхцөл бүрдүүлэх" гээд та нар яриад байна шүү дээ. Дээр нь нэмээд миний асуулт их ойлгомжтой. Өөр ямар оронд та нар шиг ийм шидэт арга хэрэглэсэн юм бэ, хаана нэг газар байгаа юу? Та дэлхий дээр анх удаа ийм юм санаачилж байгаа юм уу, тэгээд ямар экспертүүд байгаа юм бэ? Та нар энэ талаар юу ч мэдэхгүй байна, та нарын шинжээч дүгнэлт гаргасан юм уу?

Тэгээд Учрал, Бямбацогт 2 энэ ард иргэнтэй уулзах юм уу, үгүй юу? Энэ гадаа бидний сонгосон сонгогчид, 50-хан метрийн цаана энэ Ашигт малтмалын тухай хуулиар чинь ярилцъя, ойлголцъя, хүлээж авч уулзаач, зөвлөлдье гэж байна шүү дээ, энэ чинь хуулийн дагуу явж байгаа шүү дээ. Хууль тогтоомжийн тухай хууль дээр аливаа хууль гарахаасаа өмнө заавал ард иргэдийн санаа бодлыг авсан байх ёстой, "Яръя" гээд байхад ярихгүй байна. Миний 3 асуултад хариулт авъя.

Б.Пүрэвдорж: Дамдинням сайд хариулъя.

Г.Дамдинням: Би манай улс геологийн нөөцийн хувьд Ганбаатар гишүүнээ зэсийн том тоглогч болох боломжтой. Ганцхан нүүрс дээр суурилсан эдийн засагтай байгаад байгаа, зэс гэдэг хөдөлгүүртэй болохын тулд харин би танд нөгөө талаас нь хэлбэл ер нь илүү дээр юм байна гээд бодлоо. Юу вэ гэхээр, 21.6 хувийн борлуулалтын орлого дээр тавьдаг АМНАТ-тэй улс дэлхийд байхгүй, бид дэлхийн

жишиг рүү нь л авчрах гээд байгаа юм. Ингэж байж, ингэхгүй бол энэ хөрөнгө оруулалтууд чинь тойрч давхиад, бид Рио Тинто гэдэг ганцхан хөрөнгө оруулагчийн атгад байгаад байна, энэнээсээ салъя гэж байгаа юм. Чили үндсэндээ одоо би хэллээ шүү дээ, борлуулалт дээр нь 1 хувь, ашиг дээр нь 26 хувь тавьж байгаа байхгүй юу, арай өөр бүтэцтэй. Дунджаар энэ чинь бид 9 орчим хувийн АМНАТ-тэй байгаа байхгүй юу дэлхийн зэсийн тоглогчид, энийг бид 15 дээр авчрах гээд байгаа юм ядаж.

Б.Пүрэвдорж: Тодруулах уу? Ганбаатар гишүүн дахиж тодруулъя.

С.Ганбаатар: Би уг нь 3, 4 ч асуулт бэлдсэн, бусдыгаа асууя даа, саяын асуултад хариулт авсангүй. Тэгээд хэлэлцүүлгийн явцад би нэлээн тодруулж асууна. 64¹ дээр "тусгай зөвшөөрөл эзэмшигч нь эрхээ хэрэгжүүлэхэд нь тусална" гэсэн ийм заасан байна. Тэгээд үндсэндээ "ард иргэдийн зохион байгуулалттай эсэргүүцлийн ажиллагаа газар авч байгаа учраас энэ орлогыг тасалдуулах магадлалтай, энийг болиулна" гэж зааж байна. Үгүй ээ, энэ чинь "зохион байгуулалтгүй эсэргүүцэл" гэж юу байна, энэ чинь би насаараа л зохион байгууллаа. Өнөөдөр ард иргэд амьжиргаагаа хамгаалж, хууль бусаар авлига өгөөд орж ирж байгаа тэр байгаль орчныг бохирдуулах гээд, ард иргэдийн тэр бэлчээрийг талхлах гээд байгаа тэр улсуудтай хэлэлцээрт орох, ойлголцуулах, зөвшилцүүлэх механизм энэ хууль дотор алга. Зүгээр л хүчирхийлэлд уриалсан айхтар юм гараад ирж. Төр ер нь үндсэндээ өөрийгөө өмгөөлөх чадваргүй, хүчгүй, сул доройд нь үйлчлэх гэж төр.../минут дуусав/

Б.Пүрэвдорж: Дамдинням сайд хариулъя.

Г.Дамдинням: Энэ дээр бас ард иргэдийн зүй ёсны, хууль ёсны эсэргүүцэл, шаардлагыг төр хүлээж авалгүй яах вэ. Лиценз олгоод, эрх олгоод, стандарт нормын дагуу үйл ажиллагаа явуулж байгаа ААН-үүдийг санаатай болон санамсаргүй байдлаар очиж зогсоогоод, эдийн засгийн алдагдалд оруулж байгаа тохиолдолд торгууль ногдуулдаг ийм л зохицуулалт оруулж байгаа юм нэг. Энэ юунаас болж байгааг нь бас засаж байгаа юм. Юу вэ гэхээр, орон нутаг, тухайн уул уурхайн төсөл байгаа орон нутагт АМНАТ-ийн хуваарилалт очдоггүй байхгүй юу сумд нь, бүр хасдаг, "Та тэр уурхайтайгаа учраа ол" гээд. Одоо бид орон нутагт очдог АМНАТ-ийн хэмжээг 10 байсныг 15 хувь болгож, орон нутагт очдог байсан хувь 4 байсныг 6 хувь болгож, бүр сумд нь хуваарилдаг зохицуулалтыг хийж байгаа юм, Ганбаатар гишүүнээ. Ингэснээр энэ "Ард иргэдэд уул уурхайгаас юу ч бидэнд ордоггүй" гэдэг шүүмжлэл арилах юм. Ингээд ард иргэдээ төслүүдтэйгээ хамтарч ажиллах зохицуулалтыг.../минут дуусав/

Б.Пүрэвдорж: Шижир гишүүн алга байна. Энэ гишүүдэд нэг зүйлийг хэлэхэд энэ Их Хурлын гишүүдэд олон экспертүүд яг энэ Ашигт малтмалын тухай хуулиар, мэргэжилтнүүд олон улсын жишиг, энэ бүх зүйлийг ард иргэд болон экспертүүд зөвлөгөө өгч байгаа. Тэгээд энэ Их Хурлын гишүүд энд сууж байгаад энэ хүмүүсийн үгийг сонсож, дараа дараагийнхаа энэ хуулийг хэлэлцүүлэх явцад хэрэглэнэ гэдэг маш их чухал байгаа юм. Тийм учраас гишүүд их шуугилдахгүйгээр энэ танхимдаа орж ирж, энэ гишүүдийнхээ, нэгнийхээ үгийг сайн сонсох хэрэгтэй гэж хэлмээр байна. Ингээд Болдын Уянга гишүүн үг хэлнэ, асуулт асууна.

Б.Уянга: Ажлын хэсгийнхэнд энэ өдрийн мэнд хүргэе, эрхэм гишүүддээ энэ өдрийн мэнд хүргэе. Ашигт малтмалын тухай хуулийн нэмэлт, өөрчлөлтийн энэ

төслөөс асуух олон асуулт байна. Гэхдээ дараах зүйлийг онцлоод асууя. Тэгэхээр энэ Ашигт малтмалын тухай хуулийг дагуулаад Төсвийн тухай хуульд, түрүүн Дамдинням сайдын хэлсэн хариултаас үргэлжлүүлээд асуувал, АМНАТ-өөс бүрдэх төлбөрийн 10 хувь нь Орон нутгийн хөгжлийн санд хуваарилагддаг байсныг 15 хувь болгож орж ирж байна. Гэхдээ аймаг, нийслэлд энэ 15 хувь нь цаашлаад ингээд хуваагдах байдлаар хэвээрээ буюу яг энэ Төсвийн тухай хуулийнхаа 59.7-г хөндөж орж ирж байна л даа. Миний асуух гээд байгаа зүйл нь, та хэд маань яг орон нутагт ингээд яваад очихоор улс төржилт их хүнд байгаа газруудад аймаг нь өөр нам, сум нь өөр нам байгаа тохиолдолд төдийлөн Орон нутгийн хөгжлийн сан нь сумдаа яг байх ёстой хэмжээгээрээ очихгүй байгаа дүр зураг ажиглагддаг. Тэгэхээр нэгмөсөн ингэж Төсвийн тухай хуулийг оруулж ирэхдээ сум, дүүрэгт нь гээд шууд хуваарилах байдлаар оруулж ирэхгүй байсан уу, эхний асуулт энэ дээр?

Хоёрдугаарх нь, орон нутгийн оролцоотой холбоотой хэсгээс асуулт асууя. Орон нутгийн оролцоо гээд бүтэн зүйл оруулж ирж байгаа. Тэгэхээр орон нутгийн оролцоотой холбоотой энэ зүйлтэй холбоотой Нээлттэй нийгэм форум /ННФ/-ынхан ирж уулзлаа, ННФ-ыг яамныхан сайн мэдэж байгаа. Иргэний нийгмийн байгууллагатай холбоотой өмнө нь энэ хуулийн ажлын хэсгүүд дээр ч гэсэн орж ажилладаг байсан, хэр их саналыг нь тусгав? Надад хэлж байгаагаар энэ орон нутгийн оролцоо гэсэн хэсэг дээр нэмж суулгах зүйлүүд байсан юм. Олборлох салбарын ил тод байдалтай холбоотой зарим мэдээллийн ил тод байдлыг нь суулгаж өгөх байсан биш үү гэсэн байдлаар саналууд хэлсэн. Тэгэхээр ННФ-ынхантай, ер нь иргэний нийгмийн байгууллагынхантай хэр их уулзаж саналыг тусгасан талаар мэдээллийг авъя? Тэгээд цааш цаашдаа ажлын хэсэг Их Хурал дээр байгуулагдахад нь иргэний нийгмийн байгууллагынхаа төлөөллийг бүгдээрээ оруулах нь зүйтэй байна.

3 дугаар асуулт нь болохоороо, 4 дүгээр зүйл хуулийн төслийн 4 дүгээр зүйл дээр байгаль орчны менежментийн төлөвлөгөө гэснийг байгаль орчныг хамгаалах гэдэг байдлаар орж ирж байх шиг харагдаад байх юм. Тэгсэн мөртөө яг энэ зүйлийн толгой 40 дүгээр зүйл нь болохоороо "байгаль орчны менежмент" гэдэг үгээрээ хэвээрээ. Тэгэхээр энэ байгаль орчныг хамгаалах төлөвлөгөө гэдэг ямар зориулалттай, ямар судалгааны үндсэн дээр хуульд нэмэлт, өөрчлөлтөөр оруулж ирэхээр төсөлд тусгагдав? Ийм 3 асуултад хариулт авъя.

Б.Пүрэвдорж: Дамдинням сайд хариулъя.

Г.Дамдинням: АМНАТ-ийг орон нутагт шударга, зохистой хуваарилахгүй бол улсын хэмжээнд ийм болчхоод байгаа юм. Улсын хэмжээнд ашигт малтмалын үйл ажиллагааг дэмждэг аймгууд нь бага мөнгө авна. Сангийн яам нь хуваарилахдаа юу гэж хуваарилдаг вэ гэхээр тэр уурхайтай аймгуудад нь бага хуваагаад, уурхайгүйчүүдэд нь илүү хуваачихдаг. Ингээд аймаг дээр нь АМНАТ-ийн хуваарилалт очихоор уул уурхайг дэмжээд, хамтраад ажиллах гээд оролдоод байгаа сумдаа бага хуваарилаад, уул уурхайг эсэргүүцээд байгаад нь их тавьчихаад байгаа юм. Энэ чинь нөгөө шударга байдал нь алдагдчихаад байгаа байхгүй юу. Тэгэхээр бид 1 дүгээрт АМНАТ-ийн төлбөрийн 10 хувийг Орон нутгийн хөгжлийн санд өгдөг байсан бол 2 дугаарт энийг 15 хувь болгоод, 6 хувь нь сумд очихоор, аймагт очихоор болгож байгаа. 4 хувь нь очдог байсан бол 6 хувь болж очиж байгаа.

2 дугаарт, хүн ам, газар нутаг, ашигт малтмалын тусгай зөвшөөрлийн тоо, АМНАТ төлж байгаа хэлбэрээр нь буюу 4 ийм индикатораар, бид өөрөөр хэлбэл үзүүлэлтээр гэсэн үг, энэ АМНАТ-ийг орон нутагт хуваарилдаг болно гэсэн үг. Өөрөөр хэлбэл, хариуцлагатай уул уурхайтай хамтарч ажиллаж чадаж байгаа орон нутгуудад илүү АМНАТ очно. Орон нутагт уул уурхайг дэмжээд байхад сургуульгүй, цэцэрлэггүй, эмнэлэггүй, багшгүй, тоггүй, цахилгаангүй байвал ард иргэд уурлах нь зөв. Эндээс орж ирж байгаа орлогоосоо өөрсдийнхөө энэ асуудлыг шийддэг боломжийг нь олгоё гэж байгаа юм. Тийм учраас энэ уул уурхайг эсэргүүцэж байгаа, хамтарч ажиллаж чадахгүй байгаа энэ асуудлыг шийднэ гэж харж байгаа юм нэг. Сумдад нь өгнө гэдэг энэ зохицуулалтыг манай төлөвлөгөөнд оруулсан байсан, төсөлд Сангийн яам маань аймаг гэдгээр нь явж байгаа, ер нь сум гэдэг хуваарилалтыг хийе гэж ажлын хэсэг дээрээ хийгээд явчих боломжтой байгаа.

Иргэний нийгмийн байгууллагуудтай бид хамтарч хэлэлцүүлгүүд хийсэн, төрийн бус байгууллагуудтай 36 удаагийн хэлэлцүүлгүүдийг хийж байсан. Ил тод байдалтай холбоотой нэлээн олон заалтуудыг тавьсан. Тусгай зөвшөөрөл эзэмшигчдийн мэдээлэл, тусгай зөвшөөрөл олгох боломжтой талбайн хэмжээ, тоо бүгдийг нь нийтэд ил болгох зохицуулалтыг энэ хуульдаа бид оруулж өгсөн байгаа.

Б.Пүрэвдорж: Уянга гишүүн тодруулъя.

Б.Уянга: Байгаль хамгаалах төлөвлөгөөтэй холбоотой хариултаа авъя. Тэрнээс гадна ингээд зэс дээр АМНАТ-ийг хөндсөнтэй холбоотой нэлээн асуудлууд яригдсан. Гэхдээ цаанатай уул нь олон өөр ашигт малтмал дээр асуудлууд байдаг. Төмөр дээр байна, жонш дээр байна. Нөгөө жишиг үнэ гэдэг нэг төвөгтэй асуудал гаргаж ирээд, тухайн компанийн олоогүй байгаа орлогоос нь "Та нар ийм орлого олох байсан юм" гээд гадаадад гарч байгаа зардлыг нь нэмсэн байдлаар татвар аваад байдаг. Тэгэхээр энэ жишиг үнийг та хэд маань хэрхэн орж ирж чадав уу? Төмрөө, нэгмөсөн оруулж ирж байгаа дээрээ төмрийг, жоншийг оруулаад ирэх ёстой байсан юм биш үү? Энэ 2 асуултдаа хариулт авъя.

Б.Пүрэвдорж: Дамдинням хариулъя.

Г.Дамдинням: Энэ АМНАТ-ийн ногдуулалт үнэн, шударга биш байгаад байгаа юм, 100 төгрөгийн бүтээгдэхүүн дээр 120 төгрөг гэж үнэлээд АМНАТ аваад байгаа юм. Тэгэхээр бид энэ дотоодын өөрийн биржээ нэр хүндтэй болгож, өөрийнхөө биржийн борлуулалтын үнээр жишиг авч АМНАТ авдаг байх зохицуулалтыг уг нь бид хуулийн төсөлдөө тусгаж оруулж ирсэн. Тэгээд Сангийн яаман дээр маань дэмжигдсэнгүй. Ажлын хэсгийн хүрээнд энэ асуудлыг шийдээд оруулж ирэх боломжтой гэж харж байгаа. Тэгэхгүй бол энэ чинь хэдэн ААН-үүдийг хэтэрхий шулаад байгаа байхгүй юу. Тэгэхээр энийг дотоодын биржээр шийдээд явах боломжтой. Бид 55 дугаар гэж тогтоолоор энийг шийдээд үзсэн, дотоодын энэ биржийн үйл ажиллагаа, идэвхжил орж байж орлого өсөж байсан ийм үзүүлэлт гарч байсан. Тэр байгаль орчинтой холбоотой асуудлыг манай Уул уурхайн бодлогын газрын дарга Намчинсүрэн хариулна.

Б.Пүрэвдорж: Индрийн 4 дүгээр микрофон.

Г.Намчинсүрэн: Уянга гишүүний асуултад хариулъя. Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамны Уул уурхайн бодлогын газрын дарга Намчинсүрэн. Энэ Ашигт малтмалын тухай хуулийн 40.1 дэх хэсэг дээр өөрчлөлт оруулж байгаа маань зүгээр

энэ нэршил нийцүүлж байгаа л асуудал, гишүүнээ. Өөрөөр хэлбэл, хуучин "байгаль орчны менежментийн төлөвлөгөө" гэдэг байсныг "байгаль орчныг хамгаалах төлөвлөгөө" гэдэг нэршилтэй нийцүүлж байгаа л асуудал юм байгаа юм.

Б.Пүрэвдорж: Отгоншарын Батнайрамдал гишүүн алга байна, Даваахүүгийн Пүрэвдаваа гишүүн алга байна. Чинбатын Ундрам гишүүн алга байна. Пүрэвжавын Ганзориг гишүүн асуулт асууя.

П.Ганзориг: Ашигт малтмалын тухай хуулийн нэмэлт, өөрчлөлттэй холбоотой ЗГ-аас, ялангуяа холбогдох сайд, Сангийн сайд, Эдийн засаг, хөгжлийн сайд нараас тодорхой асуултууд байна. Яах вэ, томоор нь харах юм бол уул уурхайн салбарынхаа дунд, урт хугацааны тогтвортой өсөлтийг хангах гээд, хайгуулынхаа үйл ажиллагааг эрчимжүүлэх гээд, олон улсын жишгийн дагуу ашиглалтаасаа 3, 4 дахин хайгуулын үйл ажиллагааг явуулах гээд, мөн томоохон төслүүдээ гадаад, дотоодын хөрөнгө оруулалтаар нэмэгдүүлэх, татварын орчин бүрдүүлэх талаас нь ойлгож байгаа. Гэхдээ бид нөгөө "Ниргэсэн хойно нь хашхирав" гэгч болохгүйн тулд зайлшгүй анхаарах хэд хэдэн асуудал байгааг саяын 3 сайдаас асууя тусгайлж, тус бүр.

Нэгдүгээрт, сүүлийн жилүүдэд дэлхийн зах зээл дээр зэсийн үнэ тогтвортой өсөж байгааг бид бүгд мэдэж байгаа. Өнөөдрийн байдлаар нэг тонн зэсийн үнэ 13700 доллар орчим байж байгаа. Тэгэхээр энэ өсөлт түр зуурын өсөлт биш. Энэ цахилгаан машины хэрэглээ, сэргээгдэх эрчим хүч, нарны панель, батареи хураагуур, хиймэл оюун ухаан, дата төв, сервер гээд олон зүйлийн томоохон эрэлтүүдээс, өөрөөр хэлбэл бүтцийн шинжтэй, урт хугацааны томоохон зэсийн эрэлтийн шилжилттэй холбоотой эрэлт явагдаж байгаа. Үүгээрээ ойрын жилүүдэд зэсийн үнэ тогтвортой байна гэдэг нь эндээс тодорхой харагдаж байгаа юм. Ийм үед ЗГ-аас өргөн барьсан төсөлд энэ зэсийн АМНАТ-ийг үнээс хамаараад 11-ээс 15 хувь байгааг 1-ээс 5 хувь болгож огцом бууруулахаар тооцоолж оруулж ирсэн. Энэ огцом бууруулснаараа яг ямар, ямар төслүүд, хэзээ эхлэх гээд байгаа юм бэ? Ийм тооцоо байгаа юм бэ? Хэдий хэмжээний татварын орлогыг хөнгөлөөд, зөрүүлээд хэдий хэмжээний төсвийн орлого, экспортын орлого нэмэгдүүлэх тооцоолол байгаа вэ, шинээр хэдий хэмжээний ажлын байр бий болохоор тооцсон юм бэ гэдэг асуудал нэгдүгээрт тодорхой яг Эдийн засаг, хөгжлийн сайд, Сангийн сайд, Аж үйлдвэрийн сайд, уул уурхайн сайд цугт нь хариулмаар байна?

2-т, зэсийн үнийн түвшнийг нь АМНАТ-өөр тооцохдоо 5 мянгаас 9 мянган долларт үе шаттайгаар мянга мянган доллароор ингээд тодорхой хэмжээнд бууруулахаар ингээд интервал гаргасан. Гэтэл сүүлийн 2 жил гаруйг харах юм бол зэсийн үнэ нэг тонн нь тогтмол 9 мянган доллароос дээшээ байгаа, ойрын жилүүдэд ч энэнээсээ өндөр байна. Гэтэл энэ АМНАТ-ийн интервал чинь хэрэг байгаа юм уу? Ямар тооцооллоор энэ 9 мянган доллар дээд тал нь хүртэл энэ АМНАТ-ийг тогтоосон юм бэ, 9 мянган доллароос ойрын 5 жилд ч юм уу, доошоо орно гэсэн та нарт судалгаа байгаа юу? Хэдий хэмжээгээр энэ нь бодогдохоор байгаа вэ гэдэг 2 тодорхой асуултад хариулт авъя, баярлалаа.

Б.Пүрэвдорж: Эхний ээлжид Дамдинням сайд хариулъя. Эдийн засаг, хөгжлийн сайд, Сангийн сайд нар хариултад бэлтгээрэй.

Г.Дамдинням: Зэсийн АМНАТ гэдэг яах вэ нэг зүйлийг хэдүүлээ ойлгох ёстой байх. Аливаа уул уурхайн төслөөс ерөнхийдөө 3 эх үүсвэрээс төсөвт орлого орж

ирж байгаа, ганц АМНАТ-аас орж ирдэггүй. АМНАТ өндөр байвал ААН-ийн орлогын албан татвар буурдаг, ногдол ашиг буурдаг. АМНАТ бага байвал ААНОАТ өснө, ногдол ашиг өснө. Манай уулын баяжуулах Эрдэнэт үйлдвэр яг тэгж явж байгаа. Ер нь ирээдүйд 2028 оноос ашиглалтад орох 7, нийт 2032 он болтол 20 зэсийн төсөл хүлээгдэж байна. Геологийн нөөц нь 5.2 сая тонны нөөцтэй 20 төсөл, нийт ажиллах хүчний тоо нь 7 мянган шууд ажлын байр, шууд бус ажлын байр нь 60 мянган хүн ажлын байраар хангагдах ийм нөхцөлтэй төслүүд хүлээгдэж байгаа. Эндээс зөвхөн нийт хөрөнгө оруулалт нь гэхэд 5.7 тэрбум долларын хөрөнгө оруулалт урьдчилсан тооцооллын ТЭЗҮ-ээрээ байгаа.

Нийт зөвхөн АМНАТ-өөр гэхэд 4.1 их наяд төгрөгийн орлого олно эндээс. Бусад татварын эх үүсвэрүүдээр аваад үзвэл 13 их наяд төгрөгийн орлого оруулахаар ийм тооцоололтой хүлээгдээд байгаа юм. Энэ том төслүүдээс, эднээсээ ядаж 2, 3 томыг нь ашиглалтад оруулчихвал бид нэг хөрөнгө оруулагчаас хамааралтай энэ байдлаасаа гарчих гээд байгаа юм. Бидний хувьд олон хөдөлгүүртэй болмоор байгаа. Дэлхийн зах зээл дээр нүүрсний зах зээл 850 тэрбум, бид нүүрсний зах зээл дээр том тоглогч, БНХАУ-ын коксжих нүүрсний 50 хувийг нийлүүлж байгаа. 2 дахь том зах зээл зэс 450 тэрбум долларын зах зээл байдаг. Энд бид тоглогч болоход олон тоглогчийг өргөж гаргаж ирж, төсөв маань, улс маань эдийн засгийн хувьд тогтвортой өсөх энэ боломжийг хангах ёстой.

Канад, Австрали гээд энэ улсууд бүгдээрээ яг ийм бодлого баримталдаг. Тэгэхээр хөрөнгө оруулалт татахад өндөр АМНАТ тавина гэдэг нь өөрөө орд ашиглалтыг бууруулчихдаг ийм нөхцөлтэй юм. 10 граммыг 1 тонноос авах байсан, ашигтай байсан бол 20 граммыг авч байж ашигтай болоод ордынхоо насжилтыг унагаачихдаг яг ийм уул уурхайн талаасаа ийм л юм байдаг. Тийм учраас бид 100 жил ашиглах Эрдэнэт үйлдвэрээ 80 жил болгочихгүйн тулд энэ бодлогыг хийж байгаа. Эдийн засгийн болон уул уурхайн 2 ийм утгатай л бодлого л доо. Тэгэхдээ дахин тодотгож хэлье, зэсийн АМНАТ-д өөрчлөлт орохгүй одоо.

Б.Пүрэвдорж: Ганзориг гишүүн тодруулъя.

П.Ганзориг: Энэ Монгол Улсын эдийн засгийн цаашдын өсөлттэй холбоотой, төсвийн орлоготой холбоотой асуудал болохоор би Сангийн сайд, Эдийн засаг, хөгжлийн сайд 2-оос асуух гээд байгаа юм. Энэ чинь бүгдийг нь тооцсон байх ёстой шүүдээ. Тэднээс яаж хариултаа авах вэ 1-д?

2 дахь асуудал нь ер нь энэ интервал байгаад байгаа 5 мянган доллароос 9 мянган доллар гээд, сүүлийн 2 жил гаруйн хугацаанд нэг тонн зэсийн үнэ дэлхийн зах зээл дээр 9 мянган доллароос дээшээ байгаа. Одоогоор 13700 доллар байгаа. Цаашдаа ойрын 5, 10 жилд ямар байна гэсэн төсөөлөл байгаа юм бэ? 9 мянган доллароос өндөр байх юм бол энэ интервал ямар хэрэг байгаад байгаа юм. Ямар ч ашиглахгүй интервал болох гээд байна шүү дээ. Тэгэхээр энэ интервалын тооцоолоо хэрхэн, яаж хийсэн юм бэ гэдэг дээр нэг тодорхой хариултууд өгөөч. Тэгээд түрүүчийн эхний асуулт дээр энэ зэсийн АМНАТ-тэй холбоотой асуудлаа яах вэ, олонхын бүлэг татъя гэдэг зарчмын санал гаргачихсан юм шиг байна лээ. Тэгэхдээ ер нь яаж тооцоолж орж ирсэн юм, хэдий хэмжээний.../минут дуусав/

Б.Пүрэвдорж: Дамдинням сайд хариулъя.

Г.Дамдинням: Зэсийн АМНАТ-ийг бид тооцоолохдоо ойрын 4 жилдээ, одоо бид 1.8 их наяд төгрөгийг АМНАТ-аас олж байгаа юм зэсээс, энэний тал нь Эрдэнэт үйлдвэр, тал нь Оюу Толгойгоос орж ирж байгаа юм, 900 нь. Тэгэхээр бид ойрын 4 жилдээ 2.2 их наяд болгох тооцоололтой шинэ төслүүдээ хөдөлгөснөөр явна гэж, өөрөөр хэлбэл шинэ төслүүдээ хөдөлгөх боломж олгож байж энийг явуулах гэж байгаа юм гэж тооцсон. Ирээдүйн тооцоолол зэс шинэ ажлын хэсгийнхээ хүрээнд 10 мянга байвал яах юм, 11 мянга байвал яах юм гээд нэмээд явах боломжтой. Тэгэхдээ дундажлаад олон улсын агентлагууд мэдээлж байгаагаар 10 дээр дундажлаж болж байна гэсэн ийм мэдээлэл байгаа.

Б.Пүрэвдорж: Тодруулчихсан шүү дээ, тийм үү? Ганзориг гишүүн тодруулъя.

П.Ганзориг: 10 мянга дээр байна гээд байгаа бол тэр интервал хэрэг байгаа юм уу л гэж би асуугаад байгаа юм, тэнд нь хариулчихъя хэрэгтэй бол хэрэгтэй гээд, хэрэггүй бол хэрэггүй гээд.

2-т, хэдий хэмжээний татварын, АМНАТ-ийн татварын хөнгөлөлт үзүүлээд байгаа юм бэ? Хэрвээ энийгээ оруулаад явна гэсэн тохиолдолд тэгж тооцоолсон юм бэ гэдэг дээр тодорхой хариулт өгөөч?

3-д, яг ямар тодорхой төслүүд байгаа юм бэ гэж би түрүүн асуусан шүү дээ. Нэрийг нь тухайлбал гэж байгаад 5 төсөл нэрлээдхээч, яг энэ төслүүд ингээд эхлэх гээд байгаа юм зэсийн. Тэгээд зэсийн баяжмалын экспорт ингэж нэмэгдэх гээд байгаа юм, дотооддоо бид нэмүү өртөг шингээж ийм зэсийн үйлдвэрлэл, цэвэршүүлэлт хийх гээд байгаа юм гээд. Энэ дээрээ нэг тодорхой хариултууд өгчихвөл. Энэ чинь яг энэ Их Хурал дээр хэлэлцэж байгаагийн хувьд энэ чухал асуудал, тэгээд шийдвэр гаргахад чухал нөлөөтэй шүү дээ. Яг бодитой энэ төслүүд нь байгаа юм уу, үгүй юм уу, эхэлнэ гээд хэлчихсэн, эхлэхэд бэлэн болчихсон яг ямар төслүүд байгаад байгаа юм бэ?

Б.Пүрэвдорж: Дамдинням сайд хариулъя.

Г.Дамдинням: 1 дүгээрт интервал дээр нэмж болно, Ганзориг гишүүн, 9 мянга хүртэл байгааг 10 мянга болгоод нэмээд тавьчихаж болно. Тэр ажлын хэсгийн хүрээнд асуудал байхгүй 1-д.

2-рт бид ямар ч АМНАТ-ийн хөнгөлөлт хэнд ч үзүүлэхгүй, хэнд ч мөнгө өгөх гээгүй. Яагаад вэ гэвэл уулын баяжуулах Эрдэнэт үйлдвэр 21.6 хувиараа байна, бидний Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамны санал 4 жил энүүгээр нь барьж байгаад бусадтай ижилхэн буулгая гэж байгаа төсвийн орлогоо бодож. Оюу Толгой төсөл гэж хоёрхон төсөлтэй манайх, Оюу Толгой төсөл 5 хувиар байгаа. Энд нөлөөлөл орохгүй, юу ч байхгүй, Оюу Толгойд ямар ч давуу тал байхгүй. Эрдэнэт үйлдвэр дээр буулгавал Эрдэнэтийн ногдол ашиг өснө, татвар өснө.

Цаашаа явах гээд байгаа төслүүд гэвэл энэ. Монголын алт компанийн Эрдэнэс Цагаансуварга байна, Оюут улаан байна, Моли металл байна гээд энэ ордууд 2028 онд ашиглалтад ороход бэлэн болчихож байгаа юм, бүтээн байгуулалт нь хийгдэж байгаа юм.

Б.Пүрэвдорж: Хоёрхныг хэллээ шүү дээ, 5 гэсэн шүү дээ. Дамдинням сайд.

Г.Дамдинням: 20 төсөл байна, 2028 он гэхэд үйл ажиллагаагаа эхлүүлэх боломжтой 5-ыг уншиж өгье. Монголын алт /МАК/ компанийн төсөл байна, 1.6 сая тонн нөөцтэй, геологийн нөөц, Эрдэнэс Цагаансуварга төсөл 1.6 сая тонн нөөцтэй, Оюут улаан 512 мянга, Моли металл 317 мянга, Нью Саймент Ресорсес 336 мянга гэсэн ийм нөөцтэй 5 төсөл хөдлөхөд бэлэн болчихсон байна, болно гэсэн үг, явна гэсэн үг.

Б.Пүрэвдорж: Мөнхчулууны Энхцэцэг гишүүн асуулт асууна.

М.Энхцэцэг: Та бүхэнд энэ өдрийн мэнд хүргэе. Ингээд Ашигт малтмалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулж байгааг зарчмын хувьд дэмжиж байгаа. Тэгэхээр уул уурхайгаас хамааралтай эдийн засагтай Монгол Улсын хувьд энэ өөрчлөлтийг оруулснаар хөрөнгө оруулалтыг татаж, эдийн засгаа өсгөж чадна гэдэгт итгэж байгаа.

Гэхдээ 2 асуулт байгаад байна л даа. 1 дүгээр асуулт болохоор, ер нь хүн болгон л энийг асууя гэж асуугаад л байх шиг байна л даа. Эрдэнэт үйлдвэрийн хувьд АМНАТ-ийн хувь нь 21.6 хувьтай, гэтэл Оюу Толгой 5 хувьтай, тэгэхээр яагаад ийм хол зөрөөтэй хувьтай байдаг юм бэ, ямар үндэслэл байгаа юм бэ? Эрдэнэт үйлдвэрийн хувьд үнэхээр бид бараг улсын өмчийн үйлдвэр гэдгээрээ хувь нь ийм өндөр байгаад, хамаг өрмийг нь ингээд улс орон хумьж авчхаад, тэгээд энэ үйлдвэр чинь технологийн шинэчлэл хийж чаддаггүй, энэ үйлдвэр оршин тогтнож байгаа орон нутаг, Эрдэнэт хот хөгжиж чаддаггүй гээд ингээд олон асуудлууд байна. Дээрээс нь улсын үйлдвэр болохоор ингээд 21.6 хувийг өгөөд байгаа мөртөө амьдраад дампуурчихгүй, болоод бүтээд байдаг, хувийн хөрөнгө оруулалт болохоор л АМНАТ-ийн хувь нь өндөр болохоор л бараг дампуурчих гээд л болохоо байлаа, бүтээхээ байлаа, "тогтвортой байдлын гэрээ хийе" гээд ингээд байдаг нь нэг жоохон эргэлзээтэй санагдаж байна л даа.

Тэгээд сая Дамдинням сайдын амнаас маш олон удаа "шударга", өөрөөр хэлбэл "шударга байдал", "энэ хувь шардрга байх ёстой" гээд их л олон яриад байх шиг байна л даа. Тэгэхээр энэ дээр нь үнэхээр шардрга байдал чинь харагдаж байна уу? Тэгээд цаашдаа бид ингээд нөгөө уурхайн яг нэр заагаад л хуульдаа өөрчлөлт оруулаад байх юм уу? Ингээд Эрдэнэт үйлдвэрийг ганцааранг нь заагаад үлдээж байгаа бол цаана нь тэгээд л Эрдэнэт үйлдвэрийн хажууд байгаа тэр Ачит Ихт гэдэг юм уу, ингээд олон уурхайнууд гарч ирнэ. Тэр болгоныг нь ингээд нэрийг нь заагаад л, хувийг нь ондоо ондоогоор оруулж ирээд байх юм уу? Энэ чинь нэг ийм тэгш, уян юу ёстой юм биш үү гэж харж байгаа юм. Энэ дээр нэг хариулт өгөөч.

2 дугаар асуудал болохоор, яг энэ хуулийнхаа хүрээнд давс олборлолтын асуудлыг нээж өгөх боломж байхгүй юу? Урт нэртэй хууль батлагдсанаараа ямар асуудал бий болсон бэ гэхээр, ерөөсөө Монгол Улсад давс олборлолтыг бүрэн хорьчихсон юм байна. Гэтэл давс гэдэг бидний өдөр тутмын хамгийн наад захын хэрэглээ, бидний эрүүл мэндэд асар их хэмжээгээр нөлөө үзүүлж байдаг ийм асуудал. Гэтэл бид яаж байна гэхээр, нөгөө байнгын дахин сэргээгдэж байдаг давс Монгол Улсад байгаад байдаг, гэтэл тэрийгээ ашиглаж чадахгүй учраас яаж байна гэхээр химийн аргаар гаргаж авсан импортын давс хэрэглэж байна. Жилдээ бараг 20 гаруй сая долларыг импортын давсыг худалдаж авахад зарцуулж байна гэж байна. Тэгээд нөгөө давс олборлолтыг бүрэн хорьчихсон учраас хулгайн аргаар олборлож байна, асуудал үүсэж байна. Тэгэхээр энэ хуулийнхаа хүрээнд тэр Урт нэртэй хуулиар хориглосон, ерөөсөө нуур хамгаалах гэдэг нэрийн доор л тэр

байгалийн нөөцтэй ургаад л, тэрийг олборлоод, буцаад ургаад байдаг тэр давсаа бид олборлох боломжгүй, байгалийн ийм цэвэр давс хэрэглэх боломжийг бүрэн хаачихсан, ард иргэдийнхээ нөгөө эрүүл мэндийг маш ноцтой байдалд оруулчихсан ийм шийдвэр байгаад байгаа юм байна. Тэгэхээр энэ өөрчлөлтийнхөө хүрээнд энийг нээж өгөх боломж байна уу? Зөвхөн давс олборлодог уул уурхайнуудыг хамаарахгүй гэдэг байдлаар тэр Урт нэртэй хуульдаа өөрчлөлт оруулах ийм боломж байгаа юу гэдэг ийм 2 асуултыг асууя.

Б.Пүрэвдорж: Дамдинням сайд хариулъя.

Г.Дамдинням: Энхцэцэг гишүүний асуултад хариулъя. 2 дахь асуултаас нь эхэлж хариулъя. Тийм, Урт нэртэй хууль маань гарахдаа хэтэрхий хорио хязгаар тогтоочихсон ийм маягаар гарсан юм билээ. Энэ удаагийн Ашигт малтмалын тухай хуулийг дагаж орж ирж байгаа 11 хуулийн нэг дотор Урт нэртэй хуулийн өөрчлөлт орно. Тэр нь давсыг чөлөөлж байгаа, үнэн. Давсыг ерөөсөө бүтэн олборлохыг хорьчихсон байдаг юм билээ. Тэгэхээр энийгээ шийдэж байгаа юм.

Эрдэнэт үйлдвэр, уулын баяжуулах Эрдэнэт үйлдвэр, Оюу Толгой 2 яагаад өөр байгаа юм бэ. Уулын баяжуулах Эрдэнэт үйлдвэр 50 жилийн өмнө байгуулагдаад, хөрөнгө оруулалтаа нөхөөд, одоо ингээд өгөөжөө өгөөд явж байгаа. Ингээд бид гаднын хөрөнгө оруулагчтай хамтарч эзэмшдэг байх үедээ дотооддоо арай илүү авч үлдэх гэж энэ 21.6 хувийн АМНАТ-ийг тавьсан юм билээ. Тэгээд одоо 100 хувь дотоодын төрийн өмч болоод явчихсан чинь энэ 21.6 хувь нь уурхайн насжилтдаа нөлөөлөөд хүндрээд байгаа юм. Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамны зүгээс, салбарын зүгээс, сайдын хувьд уулын баяжуулах Эрдэнэт үйлдвэрийгээ энэ төсвийн орлого тасалчихгүй байх үүднээс 4 жил яг 21.6-гаар нь явуулаад, тэгээд бусадтай нь ижилхэн болгоё. Тэгэхгүй бол энэ чинь хоёрхон зэсийн төсөлтэй байгаад байгаагийн сул тал нь энэ болчхоод байгаа байхгүй юу. Тэгээд 2009 онд байгуулагдсан Оюу Толгойн хөрөнгө оруулалтын гэрээ гэж, Хөрөнгө оруулалтын хуулиар хийгдсэн гэрээгээр зэсийн АМНАТ-ийг Оюу Толгой төсөл дээр 5 хувиар тогтворжуулчихсан, ийм байгаа.

Тэгэхээр хэрвээ шинэ хуулийн зохицуулалтаар, бидний санал болгож байгаа хувилбараар АМНАТ өөрчлөгдвөл Эрдэнэт үйлдвэр маань, би 2029 онд гарах өөрчлөлтийг нь хэлье, 582.3 тэрбум төгрөгийг одоо мөрдөж байгаа 21.6 хувиар цэвэр ашиг олох байсан бол шинэ хуулиар ингээд өөрчлөөд, АМНАТ-ийг нь жоохон буулгаад өгчихвөл 949.1 тэрбум төгрөгийн цэвэр ашигтай ажиллана. Энэ Монголын төрд орно, олон нийтэд ирнэ. Яагаад гэвэл зардлыг нь буулгачхаж байгаа болохоор цэвэр ашиг нь өсөөд явчхаж байгаа юм. Дээр нь ААНОАТ нь 251.4 тэрбум байх байсан бол 373.7 тэрбум болох юм. Төрд ногдох ногдол ашиг 246.3 тэрбум байх байсан бол 414.9 тэрбум болох юм. Өөрөөр хэлбэл АМНАТ-ийг нь, уулын баяжуулах Эрдэнэт үйлдвэрийн АМНАТ-ийг буулгангуут цэвэр ашиг нь, ААНОАТ нь, дээрээс нь төрд ногдох ногдол ашиг нь өсчхөж байгаа байхгүй юу. Буцаагаад нөхөөд авч байна гэсэн үг. Би түрүүн хэлсэн, бид 3 хэлбэрээр төсөвт орлого оруулж байгаа, алийг нь их, бага байлгахаас шалтгаалж бодлого явдаг. Тэгэхээр бид бусад зэсийн төслүүдээ хөдөлгөж чадвал уг нь энэ байдал эерэг болох гээд байгаа юм л даа. Тэгээд одоо бид энэ удаад зэсийн АМНАТ-д хүрэхгүй, хүрэхгүй байя гэдэг ийм зарчмын шийдэлтэй байгаа.

Б.Пүрэвдорж: Мөнхтөрийн Нарантуяа-Нара гишүүн асуулт асууна.

М.Нарантуяа-Нара: Оройн мэнд хүргэе. Энэ хуулийн төсөлд үнэхээр маш нухацтай хандах ёстой. Ялангуяа энэ хуулийн төсөл дотор шургуулж орж ирсэн зарим нэгэн хуулийн төслүүд үнэхээр Монгол Улсын эрх ашгийн эсрэг ийм зүйл, заалтууд байсан. Манай Монгол Улсын стратегийн хамгийн гол бүтээгдэхүүн болох зэсийн үнэ яг одоо дэлхийн зах зээлд овоо үнэ өсөөд, ингээд ийм сайхан байж байгаа энэ үед яг энэ АМНАТ-ийг нь бууруулж орж ирье гэсэн энэ байдал ер нь хуулийн хулгайн завдал гэж би харж байгаа Дамдинням сайдаа. Жишээлбэл яг одоо Онтрэ-гийн гэрээ, хэлэлцээр явагдаж байна шүү дээ. Үүнтэй зэрэгцээд гадаа Монголын ард түмний нэгээхэн хэсэг жагсаж байна. Энэ хүмүүс Монголын ард түмэн мөн үү, эсвэл зүгээр гэрээт, төлбөртэй жагсагчид уу? Та энэ дээр өөрийн байр сууриа хэлээрэй. Тэгээд энэ хүмүүс, жагсагчдын та юу хүсээд байгаа юм, ямар шаардлага тавиад байгаа юм, юуг ойлгохгүй байгаа юм бэ, ямар эрсдэл, ямар айдастай байгаа юм бэ гэдэг талаар та сонссон уу?

Та бол яг ижилхэн сайд болохоосоо өмнө олон нийт, иргэд, олон нийтийн саналаар УИХ-ын гишүүн болж, түүнийхээ улмаар Уул уурхайн сайд болоод ажиллаад явж байгаа хүн шүү дээ. Тэгэхээр хамгийн түрүүнд бид иргэдийнхээ энэ ойлгохгүй байгаа зүйлийг, шаардлага тавиад байгаа зүйлийг бид сонсож, хүлээж авч байж, дараа дараагийн сайн хууль, тэдний төлөө сайн сайхныг бүтээх юм. Тэгээд энэ хүмүүсийг, жишээлбэл Онтрэ-гийн гэрээ, хэлэлцээрийн юм явагдаж байна, тэгээд энэ жишээлбэл, Оюу Толгой дээр, би Оюу Толгойг ингээд бүр 100 хувь эсэргүүцдэг хүн биш. Ялангуяа ковидын үед Оюу Толгой төслийн ачаар Монголчууд нэг өлбөрч үхэлгүйхэн шиг давсан гэж би хувьдаа итгэлтэй байдаг. Гэхдээ Монголын ард түмэн үнэхээр өөрсдийнхөө хүртэх ёстой тэр баялгийн хэмжээгээр ч юм уу, эсвэл багахан хувийг нь ч гэсэн хүртэж чадахгүй байгаа учраас дургүйцээд, эсэргүүцээд, гомдоллоод байгаа байхгүй юу. Энийг үнэхээр маш сайн хүлээж авах ёстой.

Зүгээр энэ 1072 хувьцаа 60, 70 мянган төгрөг өгснөөр Монголын ард түмний амьдрал сайжирч байгаа юу гэвэл тэрэн шиг үлгэр байхгүй шүү дээ. Тэгээд энэ байгалийн асар их баялагтай мөртөө ингээд баялаг бүтээж байгаа бүс нутгийн энэ амьдрал ерөөсөө сайжрахгүй, эсрэгээрээ бүр тоосжилт, усны хомсдол, бэлчээрийн доройтол, байгаль орчны эрсдэлийг хамгийн түрүүнд тухайн бүс нутгийн хүмүүс, иргэд хүртэж байна. Үгүй ээ, тэр битгий хэл тэр уул уурхай явагдаж байгаа, энэ хариуцлагагүй уул уурхай явагдаж байгаа газарт үр хүүхэд нь хүртэл үхэж үрэгдэж байна шүү дээ. Тэгээд энэ уул уурхайн лицензийг хэн олгодог юм бэ, би олгохгүй шүү дээ, иргэд өөрөө өөрсдөдөө олгохгүй шүү дээ, төр засгаар дамжиж л олгогдож байгаа энэ лиценз биз дээ. Тэгээд энэний араас хариуцлага, хяналтыг тавьж явдаггүй, олгохыгоо олгоод нэг юу гэдэг юм, ямар нэгэн эрх ашиг, авлига, хээл хахуулийн шинж чанартай юмнууд олгоод нүдээ аниад хаячихдаг. Нөгөө хэд нь тэнд нь дураараа дургиад, ухсан нүхээ ч бөглөдөггүй ийм байдлаас ч юм болоод дахиад хэчнээн хүүхэд үрэгдэхийг бид мэдэгдэхгүй байна.

Тэгээд энэ хуулийн төсөлд АМНАТ-өөс орон нутгийн хөгжлийн санд төвлөрөх орлогыг нэмэгдүүлэхээр тусгасан байна л даа, энэ харьцангуй зөв юм. Ялангуяа орон нутагт өөрсдийнхөө санхүүгийн хувьд дэмжих, баялгийн шударга хуваарилалтыг бий болгоход ингээд зохицуулалт орж байгаа нь зөв. Гэхдээ орлогын хувийг нэмэгдүүлснээр орон нутгийн бие даасан байдал яг хэдэн хувиар өсөхөөр тооцоолсон байгаа юм бэ, орон нутагт орлого нь бодитоор нэмэгдэх юм уу.../минут дуусав/

Б.Пүрэвдорж: Дамдинням сайд хариулъя.

Г.Дамдинням: Нарантуяа-Нара гишүүний асуултад хариулъя. Чухал асуудлууд байна. Тэгээд яах вэ, бид энэ нөгөө нэг ярьж байгаа асуудлуудаа нийтэд нэг ойлгомжтой тайлбарлаж, тэгээд уул уурхай гэхээр мангас биш байдлаар л харуулмаар байгаад байгаа юм. Тэгэхгүй бол ингээд буруу ойлгоод байгаа юм. Яах вэ, уул уурхайн төслүүдээс 3 хэлбэрээр улс, аймгийн төсөвт хамгийн том мөнгө орж ирж байгаа, АМНАТ, ногдол ашиг, татварын орлого. АМНАТ өндөр байвал татварын орлого бага байна, ногдол ашиг бага байна. АМНАТ бага байвал татварын орлого өндөр байна, ногдол ашиг өндөр байна. Тэгэхээр энэний тэгш балансыг л олох ёстой юм. Түүнээс биш бусдад давуу тал олгох гээд байгаа ерөөсөө ч зүйл байхгүй.

Ялангуяа стратегийн орд газрууд Онтрэ дээр Монгол Улсын Үндсэн хуулийн 6 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт “51 хувиас дийлэнх нь” гээд заачихсан, тэр хувиас дээш өгөөжийг заавал авах ёстой, тусгайлсан хэлэлцээрээр хийдэг. Энэ тусгайлсан хэлэлцээрээр бид ярих ёстой. Монголын ард түмэн санал, санаачилгаа гаргаж, бид арчилсан улсад амьдарч байгаа, жагсаж цуглаж, тэгээд би ч залуу байхдаа жагсаж явлаа л даа, Нарантуяа-Нара гишүүнээ. Тэгэхээр ер нь сонсох ёстой, ярилцах ёстой, бүх оролцогч талууд цуг суух ёстой. Тэгэхээр бичиг цаасаар, бодитойгоор яг ингээд асуудлууд яривал үр дүнтэй байх ёстой юм билээ. Тэгээд ямар ч нөхцөлд ирсэн саналуудыг сонсож хариу өгдөг.

Дараачийн асуудал, энэ баялаг бүтээж байгаа яг хөөрхий тэр уул уурхайн нөлөөллийн бүсэд амьдарч байгаа ард иргэд өрөвдмөөр үнэн шүү. Тэр аягүй хэцүү байдаг. Тэгэхээр бид энэ АМНАТ-ийг 10 хувь байсныг 15 хувь болгоод, нэмэлт 5 хувийг нь яг тэр сумд руу нь олгоё гэдэг ийм л зохицуулалт оруулж ирж байгаа юм. Өөрийнхөө өвөг дээдсийн хэдэн мянган жил нутагласан газар орныг ухуулаад, уул уурхайтай хамтарч ажилласныхаа үр дүнд харсан чинь сумын сургууль нь нураад уначихсан, гэрэл байхгүй, сумын багш нь, нэг англи хэлний багшид нэмэлт цалин өгөх гэхээр сумд нь төсөв байхгүй ийм байвал ард иргэд эсэргүүцэх нь зөв байхгүй юу. Би энэ ард иргэдийн энэ шударга эсэргүүцлийг ойлгодог. Тийм учраас энэ сумдад нь зориуд нэмэлт олгоё гэдэг зохицуулалтыг оруулж ирж байгаа юм.

Нөхөн сэргээлттэй холбоотой асуудал, нөхөн сэргээлттэй холбоотой асуудал дээр Нарантуяа-Нара гишүүнээ, нэг зөв зүйлийг ойлгуулахгүй бол болохгүй байгаа юм. Юу вэ гэхээр, байгаль орчны нөхөн сэргээлтийг байгаль орчны сумын байцаагч, сумын дарга, аймгийн дарга нар хариуцдаг хуультай. Аж үйлдвэр, эрдэс баялгийн яам орон нутагт хяналт тавьдаг долоохон хүнтэй, долоохон хүнтэй шүү дээ улсын хэмжээнд, өөр явж амждаггүй бид. Тийм учраас хуулиар нь тэр нөхөн сэргээлт, байгаль орчныг хамгаалах, хүн, малын аюулгүй байдлыг хамгаалах үүргийг тэр байгаль орчныхонд хийлгэдэг юм. Тэгээд энэ дээр нэлээн чангаруулж оруулж байгаа юм. Тэгэхгүй бол энэ ингээд хуурамч гарын үсэг зураад, хуурамчаар хүлээж авснаас саяын тэр эмгэнэлтэй юм болж байгаа.../минут дуусав/

Б.Пүрэвдорж: Нарантуяа-Нара гишүүн нэмж тодруулъя.

М.Нарантуяа-Нара: Тийм, 1 дүгээрт, энд маш ноцтой юм ярьж байна шүү дээ, хуурамч тэр сая юу гэххэв, хуурамч, тийм. Хуурамчаар, төрийн өмнөөс хуурамчаар ийм юм хийгээд явж байж болдог юм уу? Энэ хүмүүст ямар хариуцлага тооцох вэ?

2 дугаарт, энэ аймаг, сум, орон нутгийн чинь Засаг дарга нарыг хэн томилж байгаа юм бэ? Ард иргэд дундаасаа сонгоод томилж байгаа биш шүү дээ. Эрх баригч нам өөрсдийнхөө сувгаар, өөрсдийнхөө хүмүүсийг л томилж байгаа шүү дээ. Тэгэхээр энэ өөрөө шат шатандаа та нар хяналт, удирдлагаа тавьж чадахгүй байгаа учраас, энэ та бүгдийн өөрсдийн чинь томилсон хүмүүс тэнд хариуцлага, хяналтыг цогцлоож чадахгүйн улмаас, өөрөөр хэлбэл энэ төр засгийн бүх шатны хариуцлагагүй байдлаас болоод л ийм нүхнүүдэд хүн, мал гэмтэж, амь эрсдэж байна гэдгийг үнэхээр хүлээн зөвшөөрч байгаад баяртай байна. Гэхдээ нөгөө талаар ингээд төр ингээд салбараа.../минут дуусав/

Б.Пүрэвдорж: Нэмж дахиад 1 минут тодруулъя.

М.Нарантуяа-Нара: Ер нь ингээд л хар даа, энэ хайгуулын салбараа хүнд суртал, хууль, эрх зүйн тогтворгүй байдлаараа боомилж байгаа нь төр өөрөө шүү дээ. Тэгчхээд хөрөнгө оруулагчид сонирхохгүй байна гэдэг шалтгаанаар одоо тэгээд цахим сонгон шалгаруулалтын зарчмаас ухарч байгаа юм байна шүү дээ, үгүй юү? Хамгийн гол нь ингээд юмыг хувийн хэвшлийнхэнтэй гэрээ, лиценз байгуулах, лиценз олгох ийм далд системийг бий болгочих вий дээ гэж хардаад байгаа байхгүй юу энэ дунд.

Б.Пүрэвдорж: Дамдинням сайд хариулъя.

Г.Дамдинням: Тэгэхээр одоогийн мөрдөж байгаа хууль нь ийм байгаад байгаа юм. Сумын Засаг даргыг сумын сонгуулиар сонгогдсон иргэдийн Төлөөлөгчид томилдог, тэр сонгогдсон сумын Засаг дарга нь сумын байгаль орчны байцаагчийг томилдог, тэр намууд нь янз янзаар л сонгогдож байгаа байх. Тэгэхээр тэр нөхдүүд, жишээ нь гэхэд энэ Заамарт болсон үйл явдал дээр Байгаль орчны сайд явсан шалгалтаар. Байгаль орчны менежментийн төлөвлөгөө гэдэг төлөвлөгөө байдаг юм. Тэр төлөвлөгөөг хэрэгжүүлснээ тухайн компани тэр сумын байцаагч дээр очиж батлуулаад, шалгуулаад, тэр нүхэн дээр цемент цутгаад, труба зоогоод, таних тэмдэг тавиад явах ёстой. Гэтэл тэгээгүй байхад нь байгаль орчны менежментийн төлөвлөгөөг нь батлаад өгчхөж байгаа байхгүй юу. Энэ хүн Авлигатай тэмцэх газар /АТГ/ руу явж байгаа, эрүүгийн гэмт хэрэг үүсгэгдээд явж байгаа, ийм хариуцлага хүлээнэ, хууль нь байж байгаа. Цахим сонгон шалгаруулалтаас бид ухраагүй, ил тод, бүр нээлттэй болгож байгаа. Олон нийтэд ил байлгах бүр хуулийн зохицуулалт хийчихсэн байгаа.

Б.Пүрэвдорж: Сүхбаатарын Эрдэнэболд гишүүн асуулт асууна.

С.Эрдэнэболд: Уул уурхай, олборлох салбар Монголын эдийн засгийг нуруун дээрээ авч явж байгаа. Төсвийн орлогын 31.6 хувь, экспортын орлогын 92 хувь, ДНБ-ий 28.2 хувийг бүрдүүлж байна. НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөрийн /UNDP/ захиалгаар хийсэн "Монголын уул уурхайн салбарын авлигын эрсдэлийн үнэлгээ" гэсэн ийм судалгаа гаргасан. Энэ дээр хайгуул, лиценз, олборлолт, хаалтын бүх үе шатанд нийтдээ 15 төрлийн томоохон авлигын эрсдэл байгааг тодорхойлсон байгаа. Ингээд тодорхой жишээ, 2023 онд АТГ нүүрсний эрхтэй холбоотой 72 эрүүгийн хэргийг нээн шалгасан, эндээс 11 нь шүүхэд шилжээд, 43 хувь нь хэрэг бүртгэх, мөрдөн шалгах шатандаа явж байгаа. Нүүрсний хэрэгтэй холбоотой 155 иргэн, албан тушаалтан, 3 хуулийн этгээдийг яллагдагчаар шалгасан талаар АТГ мэдээлсэн. Прокурорын газрын мэдээллээр 124 төрлийн мөрдөн шалгах ажиллагаа явуулж байгаа, 156 хүн, 3 хуулийн этгээдийг яллагдагчаар татсан байна. Нүүрсний

хэрэг дээр одоогоор 88 хүнд эрүүгийн хариуцлага хүлээлгэсэн гэж прокурорын байгууллагын албан ёсны мэдээ байна.

Ингээд харахаар манай улсын мөнгө олж байгаа салбар нь энэ салбар. Нөгөө талдаа авлига, хээл хахуульд хамгийн их идэгдсэн байгаа салбар нь энэ салбар юм. Тэгэхээр яг энэ шинэ хуулийн зохицуулалт гараад ирэхээр түрүүний тэр UNDP-ийн судалгаагаар 15 төрлийн томоохон авлигын эх сурвалжууд энэ хуулийн орчил хөдөлгөөн дотор явагдаад байгаа юм. Энэ шинэ хууль батлагдсанаар ямар ахиц, давуу талууд гарах юм бэ? Нөгөө Транспэрэнси Интернэшнл байгууллагаас гаргаж байгаа Авлигын төсөөллийн судалгаа, индексийн судалгаагаар төрийн өмчит газрууд, тэр дундаа төрийн өмчит уул уурхайн авлигад идэгдсэн байдал чинь бүр толгой цохиж байгаа шүү дээ. Тэгэхээр энэ яаж байна гэхээр хүний нүднээс далд авлига үржих сүүдэртэй байгаад байгаа учраас, тэнд хуулийн зохицуулалт нь хомсдоод байгаа учраас, тэнд албан тушаалтан авлига, хээл хахууль авч, өгдөг тэр потенциал нь байгаад байгаа учраас л энэ асуудлууд үүсээд байгаа юм. Тэгэхээр энэ яг хууль гарснаар энэ тодорхой яг яаж буурах вэ гэсэн маш тодорхой асуулт?

2 дугаарт манай улсын улс төрийн орчил хөдөлгөөн, сонгуулийн үр дүнд энэ уул уурхай тойрсон авлига, популизм маш их жин дардаг. Сонгуулийн өмнө хувийн уурхай, ААН-үүдийг хаачихдаг, заримыг нь очоод дээрэмдээд авчихдаг, БЭТ томилдог. Сонгуулийн дараагаар тэр нь ямар ч ул мөргүй зүйл байсан юм шиг ААН, иргэдийг хохироодог, түүнийгээ цагдаагийн байгууллага ашиглаад улс төрд нөлөө бүхий хүмүүсийг намнах зорилгоор ашигладаг. Тэгээд энэ бүх зүйл яг энэ хуультай ямар харилцан хамаарлаар буурах юм бэ?

Дараагийн асуулт, энэ хуулийн төсөл батлагдсаны дараагаар нийгэмд ямар эерэг нөлөөлөл үзүүлэх вэ гэсэн нийтдээ 6 өгүүлбэр байна л даа. "Ингэснээр салбарын талаарх олон нийтийн ойлголт, итгэл нэмэгдэж, эсэргүүцэл багасна" гэсэн байгаа. Энэ томьёолол өөрөө зөв биш гэж харагдаж байгаа. Иргэд ойлголт, мэдээлэл багатай учраас, иргэд хардах эрхтэй учраас, хэвлэл мэдээлэл энэ дээр судлах, эрэн сурвалжлах боломжтой учраас л яваад байгаа. Тэгээд шууд иргэдийгээ ингээд эсэргүүцэл, жагсаал цуглааныг эсэргүүцэл гэж харж боломгүй байна. Тэгэхээр энэ ойлголт, нэр томьёог энэ концепц дотор өөрчлөх зайлшгүй шаардлага байна. Эдгээр асуултуудад хариулт авъя.

Б.Пүрэвдорж: Дамдинням сайд хариулна.

Г.Дамдинням: 1 дүгээрт, Эрдэнэболд гишүүнээ, яах вэ энэ уул уурхайн салбар гээд нэрлэчихээрээ л хөөрхий ингээд юу яадаг юм даа, яг ний нуугүй хэлэхэд уул уурхайн салбар өөрөө олдог салбар байхгүй юу хөөрхий. Яг тэр мөнгийг нь зарцуулж байгаа салбарт л асуудал байгаа шүү дээ. Дэлхий даяар ерөөсөө уул уурхайтай бүх орнуудад ийм л үг байдаг. Уул уурхайтай холбоотой бүхий л гомдол, маргаанууд эцсийн дүндээ явсаар байгаад уул уурхайтай холбоогүй, харин түүний олж ирсэн орлогыг хуваахтай холбоотой асуудал дээр байдаг гэж. Ийм л байгаа 1-д.

2 дугаарт, би ажил аваад нэг жил болж байна уу даа, манай ил тод байдлын үзүүлэлт их сайжирсан байгаа. Зүгээр энэ хуулийн хүрээнд бид, манай дээр гол асуудал энэ тусгай зөвшөөрөл олголт дээр л яригдаад байдаг юм. Тэгэхээр Нийтийн мэдээллийн ил тод байдлыг хангах хуулийн хүрээнд бид хайгуул, ашиглалт, баяжуулалтын тусгай зөвшөөрөл эзэмшигчийн үйл ажиллагааны мэдээлэл олон

нийтэд ил тод, нээлттэй байх бөгөөд тусгай зөвшөөрөл эзэмшигч үйл ажиллагааны талаар тогтмол мэдээлж, тайлагнаж байх үүргийг бүр нэмж оруулж өгч байгаа юм. Үгүй бол тусгай зөвшөөрөлтэй нь ярьдаг болно. Ингэхгүй бол манайд, жишээ нь би танд хэлье, манай салбар дээр төрийн өмчит компани /ТӨК/-иуд байна. Бодлогынхоо хувьд хамаардаг ч, үйл ажиллагаа нь ерөөсөө хамаардаггүй. Тэгэхээр авлига, хулгайтай холбоотой асуудлуудад эрүүгийн гэмт хэргийн бүх санкц, бүх зохицуулалтууд нь байж байгаа шүү дээ. Тэгэхээр тэр хууль хяналтынхаа байгууллагуудаар шалгагдаад ингээд л явах л ёстой.

Салбарын сайдын хувьд ганц л зүйл шаардаж байгаа нь ил тод л бай. Энэ хуулийн дараа бид, Их Хурлын гишүүдийн дунд яригдаад яваад байгаа бид юу яаж байгаа юм, Олборлох салбарын ил тод байдлын тухай хуулийг оруулж ирэх гэж байгаа юм. Олборлох салбарын ил тод байдлын тухай хууль бол олсноо тайлагнана гэдэг ийм олон улсын зарчимтай, тэр хуулийнхаа хүрээнд л бид бүгдийг нь нэг нээлттэй болгоод тавьчихъя гээд зориод байгаа юм.

Б.Пүрэвдорж: Сүхбаатарын Эрдэнэболд гишүүн нэмж тодруулъя.

С.Эрдэнэболд: Дамдинням сайдаа, яах вэ би ойлгож байна. Тэгэхдээ яг энэ би яг эш татаж тодорхой хэлээд байгаа нь нөгөө олж ирсэн мөнгийг зарцуулахдаа авлига гэж хэлээд байна шүү дээ та бол. Миний хэлээд байгаа үндэслэл болохоор НҮБ-ын энэ "Монголын уул уурхайн салбарын авлигын эрсдэлийн үнэлгээ" гэдэг дээр би яах вэ, ингээд нэг бүрчлэн яривал нурших гээд байгаа учраас 15 төрлийн авлигын эрсдэл байна гээд байгаа шүү дээ. Хайгуул, лиценз, олборлолт, хаалтын бүх үе шатанд гэж байгаа байхгүй юу. Тэрнээс биш тэндээс олсон мөнгөний зарцуулалт гэдэг зүйлийг ойлгож байгаа. Гэхдээ яг энэ НҮБ-ын чинь дүгнэлт дээр энэ байгаад байгаа шүү. Тэр утгаараа энэ хууль хэлэлцэгдээд явахад байж болох тэр нүх сүвнүүд, авлига авч, өгөх цоорхой, хуулийн хийдэл гаргах зүйлүүдийг нь л бөглөж, урьдчилан тооцож авах зайлшгүй шаардлага байна.

2 дугаарт, энэ хууль хэрэгжсэнээр нийгэм, эдийн засагт ямар үр дүн өгөх төсөөт аргын загварчлал буюу симуляцийг хэлэлцүүлгийн явцад заавал хэлээрэй, хийгээрэй гэж хэлмээр байна.

Б.Пүрэвдорж: Үг хэллээ. Далайн Батбаяр гишүүн асуулт асууна.

Д.Батбаяр: Тэгэхээр энэ хууль уг нь шаардлагатай байсан хууль л даа. Тэгээд бид байж, байж сая л дөнгөж орж ирж байна. Уг нь олон асуудлуудыг шийдэхээр байгаад байгаа, нөхөн сэргээлт, байгаль орчин, орон нутагт ирж байгаа өгөөж, тэгээд энэ чухал ашигт малтмал гэдгийг томъёолоод, мөн биржийн худалдааны асуудлыг шийднэ гээд олон асуудлуудыг уг нь шийдэх боломжтой ийм хууль байгаад байгаа учраас дэмжээд байгаа юм.

Тэгэхдээ энэ дээр асуудал дагуулсан зүйлүүд байна. Жишээлбэл, түрүүн Уянга гишүүний асууж байсан жишиг үнэтэй холбоотой асуудал энд хөндөгдөөгүй учраас Байнгын хороон дээр, ажлын хэсэг дээр ахиад л шийдэгдэхээргүй ингээд гацахаар шинжтэй юм билээ. 2 дугаарт нь боловсруулах үйлдвэр, 3 дугаарт нь АМНАТ гэдэг асуудлууд байна. Энэ 3 асуудлыг энэ хуулийн төсөл хэрвээ цаашаагаа явах юм бол шийдэх шаардлагатай байна гэж харж байна. Үдээс өмнөх хурал дээр бид Бизнесийн эрх чөлөөний тухай хууль ярьсан, энэ дээр олон улсууд хариуцсан сайд нь бүгдээрээ ярьсан. "Олон, олон тусгай зөвшөөрлүүдийг хүчингүй болгоно,

бизнесийн байгууллагуудыг дэмжинэ, эдийн засгаа чөлөөлнө" гээд аягүй сайхан зүйлүүд ярьсан боловч яг дагалдуулаад нөгөө гар талаар нь нөгөө сайд нь дагуулаад аваад ороод ирж байгаа энэ хууль дээр нь тусгай зөвшөөрөл ахиад ороод ирж байна. Боловсруулах үйлдвэрүүдийг барихад тусгай зөвшөөрөл шаардана гэдэг байдлаар ахиад ингээд ороод ирж байгаа нь яг энэ Засгийн газрын бодлого маань өөрөө яг ямархуу байна вэ, нэг байж чадаж байна уу, хоёр байж чадаж байна уу?

Тэгээд 2 асуулт байгаад байгаа. Сангийн яам юм уу, Эдийн засаг, хөгжлийн яамнаас дарга, төлөөлөл байгаа болов уу, байхгүй байна тийм ээ? Тэгэхээр Сангийн яамнаас л асуучихмаар байгаад байгаа байхгүй юу. Тэгээд өдийг хүртэл барьж ирсэн энэ бодлого маань өнөөдөр үр дүнгээ өгөөгүй. Давхар АМНАТ-ийн асуудал, ажлын байрыг үйлдвэр шинээр барьж байж нэмэгдүүлнэ, нэмүү өртгийг үйлдвэр барьж байж нэмэгдүүлнэ. Энэ бодлогыг бид маш олон жилийн хугацаанд ярьж байна, одоо ч ярьсаар байна. Энэ хуулийн үзэл баримтлал дээр дурдсан байгаад байна. Гэтэл олборлолт хийж байхад ч АМНАТ төлдөг, боловсруулаад, баяжуулаад гаргаад ирсэн ч гэсэн АМНАТ-ийг нь төлдөг, давхар төлдөг энэ байдлыг өөрчлөх тал дээр юу ч хийгдээгүй, энэ хууль дээр тусгагдаагүй байна. Тэгэхээр Эдийн засаг, хөгжлийн яам юм уу, Сангийн яам энэ дээр ямар байр суурьтай байгаа юм бэ? Өдийг хүртэл явж ирсэн энэ бодлого маань үр дүнгээ өгсөн юм уу? Бидний зориод байгаа өнөө нэмүү өртгөө бий болгох, ажлын байраа бий болгох дээр ямар нэгэн байдлаар энэ нэмэр болох уу, 1 дүгээр асуулт нь ийм байгаад байна.

2 дугаар асуулт нь Дамдинням сайдтай холбоотойгоор. Маш олон бүлэг ордуудыг жижиглээд, жижиг, жижиг лиценз болгоод өгчихсөн. Дангаараа боловсруулах, баяжуулах үйлдвэр барих боломж байхгүй. Бүлэг ордын дунд нь нэг үйлдвэр бариад байснаар эдийн засгийн хувьд ач холбогдолтой болно шүү дээ. Гэтэл энэ нь тусгай зөвшөөрөлтэй болоод, тэр тусгай зөвшөөрлийг 5 жилийн хугацаатай болгочхож байна. Хөрөнгө оруулалтаа хөөцөлдөж эхлэхээс өмнө тусгай зөвшөөрлөө хөөцөлдөх хэрэгтэй болох нь байна. Бичиг цаасаа боловсруулах хэрэгтэй болох нь байна. Тэгэхээр энэ дараагийн шатны боловсруулалтыг хийхэд энэ таны оруулж ирж байгаа энэ хуулийн үзэл санаа маань яг жинхэнэ нийцэж байна уу, тусгай зөвшөөрөл ямар үр нөлөөтэй давуу тал бий болгох юм бэ гэдэг ийм 2 асуулт байна?

Б.Пүрэвдорж: Дамдинням сайд хариулъя.

Г.Дамдинням: Далайн Батбаяр гишүүн салбар мэддэг хүний хувьд яг л асууж байна. Яах вэ, баяжуулах болон боловсруулах үйлдвэрийн тусгай зөвшөөрөл өнөөдөр ямар ч боловсруулах үйлдвэрийн салбар ямар ч зохицуулалтгүй байгаа. Хамгийн тод жишээг нь хэлье, баялгийн хулгай яваад байгаа юм энд жишээ нь. Зэс Эрдэнийн Хувь гээд уулын баяжуулах Эрдэнэт үйлдвэрийн дэргэд баригдчихсан байгаа, Ачит Ихт тэгээд цаана нь Эрдмин гээд үйлдвэрүүд. Зөвхөн би тэр Зэс Эрдэнийн Хувь гэдэг ААН-ийг хэлье. Тусгай зөвшөөрөл байхгүй, яаманд хүлээлгэж өгөөгүй, ТЭЗҮ байхгүй, Эрдэнэт үйлдвэрийн овоолгыг үнэгүй ашигладаг. Энэ Дорноговь руу гараад ингээд явангуут нөгөө жонш гээд явж өгнө. Юу нь мэдэгдэхгүй, гарал үүсэл нь тодорхойгүй баяжуулсан бүтээгдэхүүнүүд хилээр гаргана. Гарал үүсэл тодорхойгүй болохоор тэнд хулгай явагдана, зохицуулалт байхгүй.

Зөвшөөрлийн тухай хуулиар энэ байгалийн баялаг дээр заавал зөвшөөрөл авах ёстой заалттай. Бид чөлөөлөх, хөнгөлөх юмаа бол чөлөөлөх, хөнгөлөх ёстой.

Тэгэхдээ байгалийн баялаг дээр хэт задгай тавих нь юу юм бол доо л гэж бодож байна. Зохицуулалтгүй юм зөндөө байна. Дээрээс нь бид дэмжих гэхээр бас бодлого байхгүй, яаж дэмжих юм бэ. Нэгдсэн зохион байгуулалт байхгүй. Улсын хэмжээнд одоо байна шүү дээ, улсын хэмжээнд өөрийн орд газартай ААН-үүд болоод байгаа юм, ТЭЗҮ-ийнхээ хүрээнд манай яаманд тайлан тооцоогоо өгөөд, гарал үүсэл нь тодорхой, хэмжээ хязгаар нь тодорхой, оруулж ирж байгаа химийн бодис нь эзэнтэй, хүн амьтан алчихгүй болчхож байна. 47 үйлдвэр өөрийн орд газаргүй, баяжуулах үйлдвэртэй байгаа, эд нарыг яах вэ. Хаанаас, ямар бүтээгдэхүүн аваад, яаж баяжуулаад, яаж гаргаж байгаа нь ямар ч бүртгэл байхгүй, удирдлага, зохион байгуулалт байхгүй. Хэлж байна шүү дээ. Зэс Эрдэнийн Хувь бол сонгодог жишээ нь байна. Тэгэхээр хууль байхгүй учраас бид энийг хянаж чаддаггүй, тусгай зөвшөөрөл өгч чаддаггүй, буруу үйл ажиллагаа явуулах юм бол торгож чаддаггүй, хааж чаддаггүй ийм нөхцөлтэй байгаа. Тэгээд энийг зохицуулах ёстой болчхоод байна.

2 дугаар асуудал давхар АМНАТ, давхар АМНАТ дээр тантай санал нэг байна. Монгол Улсын аж үйлдвэр, уул уурхайн салбарын бодлого бол одоо "ухаад, ачаад шууд гадагшаа гаргаж зар" гэдэг бодлоготой. Бид аж үйлдвэржих ёстой, боловсруулах ёстой. Манай яамны боловсруулсан төсөл "давхар АМНАТ-ийг больё, боловсруулахыг дэмждэг байя, ажлын байр нэмэгдүүлж, нэмүү өртөг шингэж байгаа бол татварын орлогоороо тэр авах гээд байгаа юмаа авдаг больё" гэдэг ийм бодлоготой орж ирсэн. Ажлын хэсгийн хүрээнд энэ асуудлыг яриад оруулж өгөх боломжтой. Яах вэ, Сангийн яамнаас маань энийг зөвшөөрөөгүй, үнэнээ хэлье.

Б.Пүрэвдорж: Би 2 асуулт байна. Яг энэ 2028 онд тийм олон зэсийн орд ашиглалтад орох юм уу даа, энэ Цагаансуварга л байж магадгүй гэж манай Монгол Улсын гавьяат эдийн засагч, геологич, энэ салбарын эдийн засагч Балжинням гуай надаас асууж байлаа л даа. Тэгэхээр яг энэ, яг тэр саяын 5 орд чинь яг хэдий хэдийд ашиглалтад орох юм бэ, түүнийг 1-рт хэлчих?

2-рт, энэ олон хүмүүс энэ Оюу толгойтой холбоотой жагсаал цуглаан болж байгаа, энэний нэг гол асуудал зээлийн хүүгийн асуудал байж байгаа. ЗГ энэ 6 дугаар сарын 31-нээр хэлэлцээр дуусна. Тэгэхээр би энэ өнгөрсөн 11 дүгээр сард болсон Оюу толгойн түр хорооны хурал дээр SOFR буюу энэ дэлхийн банк, санхүүгийн хоногийн зээлийн хүү, дундаж хүү, тэр нь 3.5 хувь байгаа юм, байсан юм тухайн үед. Энэ дээр "нэмэх нь 3" буюу өөрөөр хэлбэл Оюу толгойн гаднаас авч байгаа зээл 6.5 хувиас хэтрэхгүй байх ийм зарчмын зөрүүтэй саналыг гаргасан. Би энэ Их Хурлын, АН-ын Их Хурлын гишүүдээсээ бүгдээс нь асуугаад, энэ саналыг гаргая ингээд дэмжээд, тэгээд миний зарчмын зөрүүтэй саналаар гарсан. Гэвч энийг Түр хороон дээр Шижир гишүүн, Жаргалан гишүүн нар дэмжээд, бусад нь унагаасан.

Тэгэхээр энэ нэг талаараа яагаад 6.5 байгаад байгаа юм бэ гэхээр, Рио Тинто өөрөө ЗА зэрэглэлтэй компани, 4.5 хувиар бонд босгодог байхгүй юу даа. Тэр дээр нь 2 хувь нэмээд, ингээд 6.5 байж болох юм гэдэг ийм 2 үндсэн агуулгаар энэ саналыг гаргасан. Тэгэхээр одоо энийг та ер нь АН-ын гишүүдийн санал яг ийм байгаа юм байна шүү гэдэг тэр протокол дээр, Түр хорооны протокол дээр ч байгаа, зарчмын зөрүүтэй санал ч байгаа. Тэгээд энэ дээр ингээд харж байгаад та тэр хэлэлцээртээ ашиглаарай гэж би танд хэлье. Тэгээд энэ талаар хариултаа авъя.

Г.Дамдинням: Пүрэвдорж даргын асуултад хариулъя. Бид энэ ордуудын тооцооллыг манай АМГТГ-аас ирүүлсэн байгаа, ТЭЗҮ дээр тооцоолж гаргаж байгаа,

ААН-үүдтэйгээ холбоотой ажиллаж байгаа. Зэсийн төсөл эзэмшигчидтэй бид уулзалт зохион байгуулж, "Хэрвээ АМНАТ буурвал яах вэ" гэдэг дээр бизнес төлөвлөгөөнүүдийнх нь талаар хүртэл ярилцсан. Ингээд бид хуваарь гаргасан юм, ААН-үүдтэйгээ их ойрхон ажиллаж бид энэ асуудлуудыг ярьдаг юм.

2 дугаар асуудал юу байгаа юм бэ гэхээр, энэ зээлийн хүү, Оюу толгой төслийн зээлийн хүү гэдэг өндөр байгаа нь үнэн. Энэ өндөр байгаа зээлийн хүүтэй холбоотой хэлэлцээрийг Мэндсайхан сайд хийж байна, Мэндсайхан сайдын хийж байгаа энэ ажил үр дүнд хүрэх байх гэсэн ийм л хүлээлттэй байгаа юм. Ойрын үед бид Рио Тинтотой дахиад суух ёстой Мэндсайхан сайдын ажлын хэсэг.

Нэг зүйлийг та бас жоохон, би тодруулж хэлье, 6 дугаар сарын 31-нд хэлэлцээрийн хугацаа дуусахгүй. 7 жилийн түгжээ хийснийг миний ахалсан ажлын хэсэг хуралдаж байгаад өнгөрсөн оны сүүлээр 7 жилийн түгжээ гэж байхгүй болсон, одоо дуусан дуустлаа хэлэлцээр хийнэ. Ташрамд би мэдээлэл өгчихье. Буруу, зөрүү ойлголт яваад байдаг юм билээ. Менежментийн үйлчилгээний төлбөрийг буруулах тухай хэлэлцээрийг би ахалсан, энэ ажлынхаа хүрээнд менежментийн төлбөрийг 2 дахин бууруулсан. Менежментийн төлбөр дээр 6 хувь гэж байдаг, энэнээс доош өөр тоо байхгүй. Энийг 3.95 болгосон байж "2 дахин буулгалаа" гэдэг ийм шүүмж явсан. Энд 3 төрлийн төлбөр авдаг байсан юм, 1 дүгээрт менежментийн үйлчилгээний төлбөр 6 хувь, 2 дугаарт төслийн санхүүжилтийн хүү, шимтгэлийн дахиад 6 хувь авдаг байсан давхар, нэмээд давхардуулсан Рио Тинтогийн менежментийн үйлчилгээний төлбөр гээд жил болгон 27.2 сая доллар авдаг, нийтдээ ингээд харвал 9 орчим хувийн хүүтэй явдаг байсан бид. Энийг бид 3.95 болгож, олон улсын "Анкора" /Ancora/ гэж байгууллагаас өгсөн зөвлөх үйлчилгээний, менежментийн төлбөр, зөвлөх үйлчилгээний компанийн өгсөн зөвлөмжийн дагуу "3-аас, 4-өөс 4.5-ын хооронд болговол зөв байна" гэж үзэж байсан түвшинд аваачиж чадсан, тэрнээс доош нь оруулж чадсан ийм үр дүн гаргасан.

Б.Пүрэвдорж: Хэрвээ энэ SOFR дээр нэмэх нь 3 хувь болох юм бол өдөрт төлж байгаа 4.7 тэрбум төгрөгийн зээлийн хүү чинь 2.2-оор багасаж, 2.5 болох байсан шүү гэдгийг хэлье. Гишүүд асуулт асууж, үг хэлж дууслаа. Хуулийн төслүүдийн талаар Байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг дэмжсэн, эсрэг байр суурьтай намын бүлгийг төлөөлж болон бүлэгт харьяалагддаггүй гишүүдээс урьдчилан ирүүлсэн нэрсийн дагуу гишүүд дэмжсэн, дэмжээгүй байр сууриа илэрхийлж үг хэлнэ. Гомбын Ганбаатар гишүүн алга байна, Одсүрэнгийн Номинчимэг гишүүн алга байна, Мөнхтөрийн Нарантуяа-Нара гишүүн алга байна. Байна уу? Дашцэрэнгийн Энхтүвшин гишүүн үг хэлье, дараа нь хэлээрэй Нарантуяа-Нара гишүүнээ.

Д.Энхтүвшин: Энэ хуулийн төслийг дэмжиж байгаа. Тэгээд Монгол Улсын эдийн засаг хөгжихийн тулд хамгийн чухал хэрэгтэй юм бол гадаадын хөрөнгө оруулалт байгаа. Тэгээд гадаадын хөрөнгө оруулалтын хувьд хамгийн сонирхол татаж байгаа салбар бол уул уурхайн салбар. Тэгээд уул уурхайн салбарын хуулиа өөрчлөх гээд оруулж ирээд, энийг хэлэлцэхгүй буцаавал, үзэл баримтлал нь нийцэхгүй байна гээд буцаавал энэ гадаад орчинд, хөрөнгө оруулагчдын орчинд маш буруу сигнал болно. Энд мэдээж сайжруулах зүйлүүд байна, хүлээлтэд хүрээгүй зүйлүүд байна. Тэгэхдээ энэ хуулийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэх нь зүйтэй гэж бодож байгаа.

Тэгээд эндээс би нэг зүйлийг онцолж, орж ирсэн зөв заалтуудын нэгийг нь онцолж хэлмээр байгаа юм. Энэ Төсвийн тухай хууль дээр Орон нутгийн хөгжлийн нэгдсэн санд АМНАТ-ийн орлогын 10 хувийг төвлөрүүлдэг байсныг 15 хувь болгож нэмэгдүүлж байгаа юм. Тэгэхээр энэ нь өөрөөр хэлбэл уул уурхайн төслүүд явахад хүндрэл учирдаг орон нутгийн энэ дэмжлэгийг илүү орон нутгийг эдийн засгийн хувьд чадавхжуулах, тэгээд энэ уул уурхайн төслүүдээсээ оршин суугчид нь үр шимийг нь хүртдэг байх энэ бололцоо, боломжуудыг хангах утгаараа энэ их зөв чиглэл рүү явж байгаа заалт гэж харагдаж байгаа юм.

Тэгэхдээ нөгөө талдаа аудитын тайлан гарахад энэ Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сан болон Орон нутгийн хөгжлийн сангуудтай холбоотой зарцуулалт дээр хөгжлийн биш зүгээр урсгал зардлууд ч юм уу, баяр наадам тэмдэглэсэн иймэрхүү зардлууд их санхүүжүүлж байсан. Тэгэхээр энэ аудитын өмнө гарсан дүгнэлтүүд дээр үндэслээд энэ сангуудын ашиглалтыг сайжруулах дээр ЗГ-аас орон нутагтай холбоотой ийм арга хэмжээнүүд авах хэрэгтэй харагдаж байна. Тэгэхээр бусад зүйлүүд бол мэдээж өмнө нь сая асуулт, хариултын үеэр яригдсан. Тэгээд сайжруулах зүйлүүд байгаа харагдаж байгаа. Тэгээд энэ хуулийн төслийг хэлэлцээд явах нь зүйтэй гэж бодож байна. Баярлалаа.

Улсын Их Хурлын дарга С.Бямбацогт 19 цаг 32 минутаас хуралдааныг даргалав.

С.Бямбацогт: Энхтүвшин гишүүн үг хэллээ. Очирбатын Амгаланбаатар гишүүн үгээ хэлнэ.

О.Амгаланбаатар: Ашигт малтмал, газрын тосны газрын дарга Баянбаатарт, сайдад бол бас нэг албан бичиг хүргүүлсэн байгаа. Тэгээд албан бичгийнхээ хариуг хурдан өгөөч гэж шаардах гэж байна. Энэ ямар албан бичиг гэхээр хайгуулын тусгай зөвшөөрлийг цуцлуулах тухай албан бичгийг аль хавар өгсөн. Говь-Алтай аймгийн Бигэр сумын нутаг дэвсгэрт хайгуулын үйл ажиллагаа явуулж буй Домогт хээр хувьцаат компанийн хайгуулын тусгай зөвшөөрөл нь Усны тухай хууль мөн Бигэр сумын ИТХ-ын 2015 оны 4 дүгээр сарын 30-ны өдрийн 04 дүгээр тогтоолоор орон нутгийн тусгай хамгаалалтад авсан. Энэ Бичигт хад Молор толгой нэртэй газартай. Мөн сумын ИТХ-ын 2015 оны 05 дугаар тогтоолоор орон нутгийн тусгай хамгаалалтад авсан Улаан зарын хойд Дэнжийн Баян айраг нэртэй газартай давхцалтай байгаа. Ийм учраас энэ хайгуулын лицензийг цуцлуулах ийм албан бичиг өгсөн. Мөн энэ компани нь Монгол Улсын хууль тогтоомжийг удаа дараа зөрчин үйл ажиллагаа явуулаагүй атал явуулсан мэтээр материал бүрдүүлсэн ийм зөрчлүүд байгаа юм. Тэгэхээр энэ асуудлыг та яаралтайгаар энэ АМГТГ-т үүрэг чиглэл өгч, энийг хурдан шийдмээр байна. Хувийг АТГ-т өгсөн байгааг хэлье 1-д.

2 дахь дээр энэ хуулийг хэлэлцээд, хэлэлцэхдээ нэлээн олон зүйлийг анхаарах хэрэгтэй байна. Мөн энийг хэлэлцэхээс өөр замгүй. Үнэхээр энэ яаралтайгаар хэлэлцээд, дээр нь олон өөрчлөлтүүд хийх хэрэгтэй байна. Тэр дундаа анхаарах зүйлүүд дээр 2 зүйл нэмж хэлье. Ямарваа нэг хайгуулын зөвшөөрөл ингээд олгогдохдог, хамгийн хүнд ачааг үүрдэг хүмүүс сумын Засаг дарга нар, аймгийн Засаг дарга нар байдаг. Өглөө босоод иртэл чинь танай бэлчээр дээр хайгуулын лиценз олгогдохсон гээд нөгөө сумын малчид маань, иргэд маань сумын Засаг дарга дээрээ харайгаад ирдэг. Сумын Засаг дарга нь мэдээгүй байж байдаг, аймгийн Засаг дарга нь мэдээгүй байж байдаг. Ингээд өмнөх энэ одоогийн байгаа хуульд сумын иргэдийн Хурал, аймгийн иргэдийн Хурлын саналыг авч гэсэн

ийм заалт байж байдаг. Саналыг сумын иргэдийн Хурал, аймгийн иргэдийн Хурал ямар санал өгөхөөс үл хамааран лиценз олгогдчихдог. Ингээд иргэд сумын дарга, аймгийн дарга, яам гээд ингээд нэг гурвалжин дөрвөлжин хэрүүл болсоор байгаад ингээд дуусдаг. Тэгэхээр сумын иргэдийн Хурал юм уу, эсвэл сумын иргэдийн саналыг үндэслэж гэдэг заалтыг оруулах хэрэгтэй байх. Энэ дээр та анхаарч өгөөрэй.

Хэрвээ ажлын хэсэг гаргаад, энэ дээр ийм өөрчлөлтүүд оруулаад явах юм бол орон нутгийн иргэд, сум, аймгийн удирдлагууд, ингээд энэ хайгуулын лиценз олгож байгаа төв байгууллага, энэ хэд маань нэг ойлголттой, дахиад дээр нь тэр хайгуулын лиценз олгосон, авсан компаниудтай ямар нэгэн зөрчил үүсэхгүй ингээд явчих юм. Түүнээс биш зөвхөн саналыг нь авсан сумын иргэдийн Хурал татгалзсан санал өгсөн, гэтэл ингээд олгочхож байгаа учраас тэр лицензийг сумын Засаг дарга юм уу, аймгийн Засаг дарга олгосон юм шиг ингэж иргэдэд ойлгогдоод, ийм маш их зөрчил, тэрнээс болоод энэ уул уурхай чинь урагшаа явахгүй байгаа юм. Тэгэхээр энэ дээр танай яамны зүгээс орон нутгийн иргэдтэй, сум, аймгийн тэр удирдлагуудтай нягт хамтарч ажиллаж, иргэддээ зөв ойлголт өгүүлэх тал дээр, мөн саналыг нь үндэслэж, лиценз олгодог энэ зарчим руу орохгүй бол болохгүй гэдгийг хэлье. Тэгээд хэлэлцүүлгийн шатанд ажлын хэсэгт орж ажиллана гэдгийг хэлье.

С.Бямбацогт: Баярлалаа. Мөнхтөрийн Нарантуяа-Нара гишүүн үгээ хэлье.

М.Нарантуяа-Нара: Юуны өмнө Ашигт малтмалын тухай хууль Монголын ард түмний баялгийн шударга хуваарилалт, эдийн засгийн тусгаар тогтнолын баталгаа байх ёстой. Манай улсын эдийн засаг ашигт малтмалаасаа шууд хамааралтай байдаг. Тийм учраас энэ хуулийн нэмэлт, өөрчлөлт бүрд манай УИХ-ын гишүүд маш хяналттай, хариуцлагатай, нухацтай ажиллах ёстой гэж би хувьдаа бодож байна.

Ашигт малтмалын тухай хуульд 2006 оноос хойш өнөөдрийг хүртэл нийт 16 удаагийн нэмэлт, өөрчлөлтөөр 11 бүлэг, 59 зүйл, хэсэг, заалтад нэмэлт, өөрчлөлт орсон байдаг. Тэгээд нэг хуульд ийм олон удаагийн нэмэлт, өөрчлөлт оруулсан байна гэдэг нь нэг талаар нийгмийн хэрэгцээ шаардлага, эрх зүйн зохицуулалтыг сайжруулах гэсэн оролдлого мөн боловч, нөгөө талаас манай уул уурхайн салбарын эрх зүйн орчин ямар тогтворгүй, ойлгомжгүй, маргаан дагуулж байдаг болон улс төрийн нөлөө ихтэй байгаагийн тод жишээ гэж хувьдаа харж байна. Тэгээд хууль тогтоомж тогтвортой байж, эдийн засаг алсдаа тогтвортой хөгжинө. Тийм учраас ЗГ-ын энэ өргөн мэдүүлсэн энэ хуулийн зүйл, заалт бүр дээр УИХ-ын гишүүд маш хянамгай байгаасай гэж дахин хүсэж байна.

Тэгээд ялангуяа яг одоо Оюу толгойн гэрээ, Далд уурхайн бүтээн байгуулалтын санхүүжилтийн төлөвлөгөө буюу Онтрэ хэлэлцээр яг явагдаж байгаа энэ үед олон улсын тавцанд Монголын талын ашиг сонирхлыг хамгаалах яриа хэлэлцээр өрнөж байгаа энэ үед ард иргэдийнхээ санал, санаачилга, хүсэл шаардлага, санал гомдлыг энэ гэрээнд тусгаж өгөх, мөн түүнчлэн иргэдийн хүртэх, Монгол Улсын хүртэх өгөөжийг байр суурин дээр илүү их манлайлалтай ажиллаасай гэж хүсэж байна. Тэгээд Монгол Улсын эрх ашгийг, үндэсний эрх ашиг, төсвийн орлогод сөрөг нөлөөлөх юм уу эсвэл хөрөнгө оруулагчдыг татах зайлшгүй шаардлага байв уу гэдэгт хууль санаачлагчаас маш тодорхой, үндэслэлтэйгээр тайлбаруудыг ард иргэддээ ч гэсэн ойлгуулах шаардлагатай.

Та түрүүн хэлж байсан, "Иргэд энийг ингээд нөгөө уул уурхай гэхээр мангас гэж бодоод байна" гэж байгаа юм. Хүн мэдэхгүй зүйлээсээ л айдаг, мэддэг зүйлдээ итгэлтэй байдаг. Мэдэхгүй байгаа зүйлийг нь та нар тод өнгөөр нь, харж байгаа юм бол тэнд ямар өнгө байгаа юм гэдгийг нь ойлгуулж, үзүүлж, харуулж, ойлголцлыг бий болгох нь чухал. Ингэснийхээ дараагаар тэр хүмүүс ойлгоод, тэр хүмүүсийн шаардлагаас хүлээж авах боломжтой нь юу юм, тусах нь юу юм, тусах боломжгүй байгаа нь ямар учраас тусгах боломжгүй юм бэ гэдгээ эргээд үндэслэл дээр, судалгаан дээр үндэслээд тайлбарлаад өгчих юм бол энэ иргэд чинь тэнэг биш. Энэ иргэд аль болох л Үндсэн хуулиар заасан бидэнд олгогдсон байгаа байгалийн баялгаа тэгш хүртээмжтэй эдэлье гэсэн л хүмүүс байгаа шүү дээ. Тийм учраас яг энэ тал дээр маш сайн ажиллаарай гэж хэлмээр байна. Тэгээд гишүүд энэ хуулийг хэлэлцүүлэхийг дэмжих юм шиг байна. Гэхдээ дэмжиж болно, хэлэлцүүлгийн явцад маш олон талаас нь маш сайн харах ийм хэрэгцээ шаардлага байна шүү гэдгийг онцолмоор байна. Баярлалаа.

С.Бямбацогт: Баярлалаа. Би энэ Ашигт малтмалын тухай хуультай холбоотой гишүүний хувьд хэдэн үг хэлчихье. Ашигт малтмалын тухай хуулийн өөрчлөлт хийж, энэ ашигт малтмалын салбарт явуулах төр бодлогынхоо алдааг засах, сайжруулах энэ хуулийн төслийг дэмжиж байгаа. Гэхдээ үүнээс илүү тулгамдсан асуудал, ард иргэдийн өмнө тулгамдсан асуудалд анхаарлаа хандуулмаар байна. Энэ сүүлийн өдрүүдэд Ховд аймгийн нутагт хэрэгжих гэж байгаа "Халзан бүргэдтэй" төсөлтэй холбоотойгоор нутгийн иргэдээс, малчдаас маш олон санал гомдол ирж байгаа. Нөхцөл байдал улам тийм хурцадмал түвшинд хүрч байна. Нутаг усаа хамгаалан тэмцэж байгаа иргэд болон тэр компани, төсөл хэрэгжүүлэгч компанийн хооронд үл ойлголцол нэлээд удсан, ужгирсан, даамжирсан, газар авсан, одоо бол улам хурцадмал болж байна. Улам бие биеэ гэмтээх тийм эрсдэлтэй нөхцөл байдал руу орж байна. Ийм ноцтой байдал үүсэж байхад манай Уул уурхайн яамныхан, холбогдох байгууллага, албан тушаалтнууд мэдэж байгаа юу, анхаарч байгаа юу? Аймгийн удирдлагууд нь тэр хооронд төслийн компани, иргэд хоорондоо учраа олчих байх гээд хараад, хөндлөнгөөс ажиглаад суугаад байх юм уу, энд онцгой анхаарал тавимаар байна.

Монгол Улсын Үндсэн хуульд "Иргэд эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрхтэй", дээрээс нь "Газрын хэвлийн баялгийг ашигласнаар байгаль орчинд үзүүлэх нөлөөллийн талаар мэдэх эрхтэй" гээд заачихсан, маш тодорхой заачихсан байж байгаа. Тэгэхээр төрөлх нутаг ус, бэлчээрээ хамгаалж, сэтгэл зовниж байгаа малчдын, иргэдийн тэмцлийг, эсэргүүцлийг буруутгахгүй. Халзан бүргэдтэй энэ төсөл ард иргэдийн амьдралд, мал амьтанд, хүн амьтанд ээлтэй юу, байгаль орчинд ээлтэй юу, эсвэл хортой юу гэдгийг бид шинжлэх ухааны үндэслэлтэйгээр, мэргэжлийн байгууллага, холбогдох газрууд нь нэг тайлбарлаж, иргэдийг мэдэх эрхээр хангамаар байна. Иргэд нь мэдэхгүй, ерөөсөө "Маш хортой" гэж боддог. Төсөл хэрэгжүүлэгч компани "Энэ хоргүй, асуудалгүй" гэж ярьдаг. Ингээд үл ойлголцол үүсдэг, үүнээсээ болоод зөвшилцөж, ойлголцож чаддаггүй.

Тийм болохоор иргэдтэйгээ зөвшилцөж, ойлголцох, иргэдийн мэдэх эрх, эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрхийг нь хангах, тэр төсөл хэрэгжсэнээрээ байгаль орчинд, хүн амьтанд, эрүүл мэндэд хортой, хохиролтой юу, үгүй юу гэдэг нь мэдэх эрх нь хангагдаж байж энэ төсөл хэрэгжмээр байгаа юм. Хэрэгжих ёстой бол. Хэрвээ тийм биш бол энэ төслөө зогсоох ёстой. Ингээд үл ойлголцол бий болгоод, дүлий дүмбэ оргиод, тэнд иргэд хоорондоо үндсэндээ бие биеийнхээ эрүүл мэнд, амь насанд аюул занал учруулах хэмжээнд хүрч байна. Энийг нэг анхааралдаа авмаар

байна. Энэ дээр газар дээр нь яаралтай Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамнаас ажлын хэсэг томилж, газар дээр нь ажиллуулж, энийг нэг тодорхой шийдэлд гарга.

Урьд нь УИХ тодорхой сонсгол хийсэн, үүний үр дүн юу болов, орон нутгийн удирдлагууд юу хийж байна, тэр төслийн нэгжийн компаниуд нь юу хийж байгаа юм, яагаад ийм асуудал үүсээд байгаа юм бэ. "Хүн хэлээрээ, мал хөлөөрөө" гэж ярьдаг шүү дээ. Ярилцаад, ойлголцоод "хэрэгжих ёстой бол хэрэгжих ёстой, хэрэгжих ёсгүй бол хэрэгжих ёсгүй" гээд нэг талд нь гаргаж болно шүү дээ, шийдэж болохгүй асуудал байхгүй. Тийм болохоор мэргэжлийн яам энэ тал дээр анхаарах ёстой шүү. Тэгэхгүй бол иргэд нь нутаг усаа хамгаалаад нэг талдаа тэмцдэг, мэдэх эрх нь хангагдаагүй учраас, нөгөө талд нь иргэдийн бухимдал дээр дөрөөлөөд ашиг хонжоо хайсан шантаажчин нөхдүүд нь эх оронч царайлаад, дүр эсгээд улам иргэдийн бухимдлыг дэвэргэдэг, төр засаг нь, холбогдох газрууд нь энэ хажуугаас нь хараад суудаг байж таармааргүй байна. Ийм ганцхан Халзан бүргэдтэй ч биш, Петрочайна, өөр олон, олон уул уурхайн төслүүд дээр иймэрхүү асуудал үүсэж байгаа. Энийгээ энэ Ашигт малтмалын тухай хуультайгаа хамт хэрхэн, яаж шийдэх юм бэ. Иймэрхүү асуудлыг цаашид гаргуулахгүй байх талаар ямархуу арга хэмжээ авах юм бэ. Энэ тал дээр манай Аж үйлдвэр, эрдэс баялгийн яам, Дамдинням сайд онцгой анхааралдаа авч ажилламаар байна шүү. Энэ ойрын үед хүмүүс явуулаад ажиллуулаадхаарай.

Гишүүд үг хэлж дууслаа. Хуулийн төслийн санал хураалтыг маргааш өглөө 10 цагаас явуулна, баасан гарагийн.

19.46 цаг

Зургаа.Газрын тосны тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Улсын Их Хурлын гишүүн Л.Соронзонболд нарын 13 гишүүн 2026.05.21-ний өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/

Дараагийн асуудалдаа оръё. Газрын тосны тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг хэлэлцэх эсэх хэлэлцүүлгийг явуулна. Хууль санаачлагчийн илтгэлийг УИХ-ын гишүүн Лхагвасүрэнгийн Соронзонболд танилцуулна. Таныг индэрт урьж байна.

Л.Соронзонболд: УИХ-ын дарга, эрхэм гишүүд ээ,

Газрын тосны тухай хуулийг 1991 онд анх баталж, 2014 онд шинэчлэн найруулсан. Уг хуулийн 30 дугаар зүйлийн 30.1 дэх хэсэгт "гэрээлэгч газрын тосны хайгуулын болон ашиглалтын үед тусгай зөвшөөрлийн төлбөрийг жил бүр төлнө", 30.6 дахь хэсэгт "тусгай зөвшөөрлийн төлбөрийн 10 хувийг тухайн тусгай зөвшөөрлийн талбайг харьяалах сум, дүүргийн төсөвт, 20 хувийг аймаг, нийслэлийн төсөвт, 70 хувийг улсын төсөвт тус тус хуваарилна", 31 дүгээр зүйлийн 31.3 дахь хэсэгт "нөөц ашигласны төлбөрийн 30 хувийг орон нутгийн хөгжлийн нэгдсэн санд, 70 хувийг улсын төсөвт тус тус төвлөрүүлнэ" хэмээн зохицуулсан.

Мөн Монгол Улсын ЗГ-аас Үндэсний баялгийн сангийн тухай хуулийн төслийг боловсруулан өргөн мэдүүлснийг УИХ хэлэлцэн 2024 оны 4 дүгээр сарын 19-ний өдөр баталсан. Газрын хэвлийн баялгийн үр өгөөжийг төвлөрүүлэх, үр ашигтай хөрөнгө оруулалт хийх, одоо ба ирээдүй үеийн иргэн бүрд тэгш, шударга

хуваарилах, хуримтлуулах төрөлжсөн сангаас бүрдэх тогтолцоог Үндэсний баялгийн сан гэж тодорхойлсон байх бөгөөд төрөлжсөн сангуудад хатуу ашигт малтмал, цацраг идэвхт ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр, уул уурхайн олборлолт, ашигт малтмалын боловсруулах салбарын хуулийн этгээдийн төрийн эзэмшилд ногдох ногдол ашгийг хуваарилахтай холбоотой харилцааг зохицуулахаар уг хуульд тусгажээ.

Харин газрын хэвлийн баялаг болох газрын тос, байгалийн хийн нөөц ашигласны төлбөрийг улсын төсөв, Үндэсний баялгийн сангийн төрөлжсөн сан, орон нутгийн хөгжлийн нэгдсэн сан болон ашиглалтын тусгай зөвшөөрлийн талбайг харьяалах бүс, аймаг, сумын төсөвт хэрхэн хуваарилах, мөн газрын тос, байгалийн хий олборлох, боловсруулах салбарын төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээд дэх төрийн эзэмшлийн ногдол ашгийг Баялгийн санд төвлөрүүлэхтэй холбоотой харилцааг тусгаагүй орхигдуулсан байна.

Түүнчлэн байгалийн баялгийг олборлох, ашиглах үйл явц нь экологийн тэнцвэрт байдал төдийгүй тухайн бүс нутагт амьдарч буй иргэдийн эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрхэд тодорхой хэмжээний сөрөг нөлөө үзүүлдэг тул манай улс Үндсэн хуулийн 16 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт "эрүүл, аюулгүй орчинд амьдрах, орчны бохирдол, байгалийн тэнцэл алдагдахаас хамгаалуулах эрхтэй" хэмээн тусгаж, энэхүү иргэдийн эрхийг баталгаажуулж өгсөн. Мөн олон улсын байгууллагын судалгааны дүгнэлт, зөвлөмжүүд ч уул уурхайн олборлолтын бүс нутагт амьдарч буй иргэдийн эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрхийг хамгаалах, бэхжүүлэхэд хөрөнгө хуваарилах ёстойг харуулдаг.

Тухайлбал, НҮБ-ын Хүүхдийн сангаас /UNICEF/ санаачлан 2017 оны 4 дүгээр сард "Уул уурхайгаас үүдсэн шилжилт хөдөлгөөн хүүхдэд үзүүлэх нөлөөлөл" сэдвээр судалгаа хийж, зөвлөмж гаргасан байна. Тус зөвлөмжид уул уурхайн үйл ажиллагаа нь алслагдсан хөдөө орон нутаг дахь хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, зам тээвэр, ус ба цахилгаан зэрэг дэд бүтцийг хөгжүүлэх, уул уурхайн ашиг орлого, татварын орлогыг дахин хуваарилах замаар улсын төсвийн хуваарилалт болон хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх, уул уурхайн компаниуд нийгмийн хариуцлагын төслүүд хэрэгжүүлэх зэрэг олон зэрэг үр нөлөөг орон нутагт авчрах боломжтой. Гэвч уул уурхайн үйл ажиллагаа нь нүүлгэн шилжүүлэлт, соёлын өөрчлөлтүүд, замын хөдөлгөөний ачаалал, тоосжилт, дуу чимээний бохирдол үүсэх зэргээр иргэдийн аж амьдрал, эрүүл мэнд, аюулгүй орчинд амьдрах эрхэд нь сөргөөр нөлөөлдөг. Түүнчлэн тухайн орон нутгийн хүн амын өсөлтөөс үүдэн нийгмийн дэд бүтэц болон нийгмийн үйлчилгээнд нэмэлт ачаалал үүсэх зэрэг сөрөг үр дагавар үүсгэх боломжтой талаар дурдсан байдаг.

Дээрх зөвлөмжид уул уурхайн салбар нь байгаль орчныг бохирдуулах, тухайн бүс нутгийн иргэдийн эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрхийг хөндөх, уламжлалт нүүдлийн аж ахуйн суурь болох бэлчээрийн газаргүй болох, мал амьтны оршин байх нөхцөлийг дордуулах зэрэг асуудал үүсгэдэг тул анхаарах шаардлагатайг харуулж байгаа юм. Мөн Монгол Улсын Үндсэн хуулийн 19 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт "Төрөөс хүний эрх, эрх чөлөөг хангахуйц эдийн засаг, нийгэм, хууль зүйн болон бусад баталгааг бүрдүүлэх, хүний эрх, эрх чөлөөг зөрчихтэй тэмцэх, хөндөгдсөн эрхийг сэргээн эдлүүлэх үүргийг иргэнийхээ өмнө хариуцна" гэж заасан байдаг. Түүнчлэн иргэний болон улс төрийн эрх буюу шүүхийн албадлагаар сэргээх боломжтой хүний үндсэн эрхийг негатив эрх, харин төрийн зүгээс тухайн эрхийг

эдлэх эрх зүйн орчныг бүрдүүлэх замаар хэрэгжилтийг нь хангах эрхэд эдийн засаг, нийгэм, соёлын эрхийг хамааруулдаг.

Монгол Улсын Үндсэн хуулийн 6 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт "эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрхийг баталгаажуулна" хэмээн тусгасан нь энэхүү эрх нь өөрөө хэрэгжих шинжгүй эрх бөгөөд одоо ба ирээдүйн үеийн иргэн бүрд эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрхийг баталгаажуулахын тулд төрөөс эрх зүйн орчныг бий болгоно. Учир нь олон улсад байгалийн баялгийн олборлолт явагдаж буй бүс нутгийн иргэд байгаль орчин, нийгэмд үзүүлж буй сөрөг нөлөөллийг хамгийн бага байлгах, тэдний амьжиргааг нь дэмжих, байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээхтэй холбогдсон асуудлыг илүү анхаарах хандлагатай бөгөөд тус бүс нутагт чиглэсэн арга хэмжээг тусгайлан авч хэрэгжүүлдэг.

Тодруулбал, байгалийн баялгийн нөөцийг ашигласны үндсэн дээр бий болох орлого, түүний үр өгөөжийг одоо ба ирээдүй үеийн иргэн бүрд олгохоос гадна уул уурхайн үйл ажиллагаанаас төвлөрүүлсэн орлогын тодорхой хувийг олборлолтын сөрөг нөлөөлөлд өртөж буй тухайн бүс нутагт нь хуваарилах байдлаар шударга ёсны зарчмыг хангах хэрэгцээ шаардлага бий болоод байна. Монгол Улсын ЗГ-ын 2024-өөс 2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн бүсчилсэн хөгжлийн бодлогод "Бүс нутагт амьдрахад таатай нөхцөлийг бий болгох, хот, хөдөөгийн тэнцвэрийг хангах бүсчилсэн хөгжлийн бодлогыг хэрэгжүүлж, иргэдэд таатай, эрүүл, аюулгүй, байгаль орчинд ээлтэй дэд бүтэц бүхий хотуудыг хөгжүүлнэ" гэж заасан байдаг. Бүсчилсэн хөгжлийн бодлогыг хэрэгжүүлэхэд газрын хэвлийн баялгийн үр өгөөжийг тухайн бүс, орон нутагт хуваарилах байдлаар бүс, орон нутгийн хөгжлийн тэнцвэртэй байдлыг хангах, бүс нутгийн чанартай болон бүсийн хэлэлцээрээр тохиролцон тэргүүлэх ач холбогдол бүхий хөгжлийн төсөл, арга хэмжээг санхүүжүүлэх байдлаар тухайн бүс, орон нутгийн эдийн засгийн чадавхыг дээшлүүлж, цаашлаад бие даан хөгжих боломжийг бүрдүүлж, үйл ажиллагааг тогтворжуулах, энэ чиглэлээр эрх зүйн орчныг бүрдүүлэх шаардлагатай байна.

Дээрх хууль зүйн болон практик хэрэгцээ шаардлагыг үндэслэн газрын хэвлийн баялаг болох газрын тос, байгалийн хийн нөөц ашигласны төлбөрийг улсын төсөв, Үндэсний баялгийн сангийн төрөлжсөн сангууд, Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сан, газрын тосны ашиглалтын нөлөөлөлд өртөж буй тухайн бүс, аймаг, сумдын төсөвт хуваарилах, мөн газрын тос, байгалийн хий олборлох, боловсруулах салбарын төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээд дэх төрийн эзэмшлийн хувьд ногдох ногдол ашгийг Үндэсний баялгийн санд төвлөрүүлэх энэ төрлийн харилцааг зохицуулахаар Газрын тосны тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон дагалдах бусад хуулийн төслийг санаачлан боловсрууллаа.

УИХ-ын эрхэм гишүүд ээ, энэхүү хуулийн төслийг хэлэлцэх эсэхийг дэмжиж өгөхийг та бүхнээс хүсье. Анхаарал тавьсанд баярлалаа.

С.Бямбацогт: Соронзонболд гишүүнд баярлалаа. Төслүүдийн талаарх Эдийн засгийн байнгын хорооны санал, дүгнэлтийг УИХ-ын гишүүн Чинбаатарын Анар танилцуулна.

Ч.Анар: УИХ-ын дарга, эрхэм гишүүд ээ,

УИХ-ын гишүүн Соронзонболд, Бадамсүрэн, Бямбасүрэн, Ганбаатар, Ганхүлэг, Дэлгэрсайхан, Идэрбат, Мөнхбаясгалан, Мөнхбат, Наранбаатар, Отгонбаяр, Сэддорж, Эрдэнэбүрэн нараас 2026 оны 5 дугаар сарын 21-ний өдөр УИХ-д өргөн мэдүүлсэн Газрын тосны тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэх эсэх асуудлыг Эдийн засгийн байнгын хороо 2026 оны 6 дугаар сарын 9-ний өдрийн хуралдаанаараа хэлэлцлээ.

Хууль санаачлагч нь байгалийн баялгийн үр өгөөжийг одоо болон ирээдүй үеийн иргэн бүрд тэгш, шударга хүртээх Үндсэн хууль болон Үндэсний баялгийн сангийн хуваарилалт, зарцуулалтын зарчмыг хангах төрийн бодлогыг хэрэгжүүлэх, ялангуяа олборлох, ашиглах үйл ажиллагааны сөрөг нөлөөлөлд өртөж байгаа бүс нутаг, иргэдийн эрүүл мэнд, аюулгүй орчинд амьдрах нөхцөлийг бүрдүүлэх, бүсчилсэн хөгжлийн удирдлага, зохицуулалтыг сайжруулах, орон нутгийн хөгжлийн тэнцвэртэй байдал, хөгжлийг дэмжих санхүүгийн эх үүсвэрийг нэмэгдүүлэх зэрэг ач холбогдлыг харгалзан үзэж, Газрын тосны тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулж, уг хуулийн төслийг дагалдуулан Төсвийн тухай хууль, Үндэсний баялгийн сангийн тухай хууль, Татварын ерөнхий хууль, Бүсчилсэн хөгжлийн удирдлага, зохицуулалтын тухай хуулиудад нэмэлт, өөрчлөлт оруулах хуулийн төслүүдийг боловсруулан өргөн мэдүүлжээ.

Хуулийн төсөлд газрын тос, байгалийн хийн нөөц ашигласны төлбөрийн 25 хувийг улсын төсөвт, 35 хувийг Үндэсний баялгийн санд, 10 хувийг Орон нутгийн хөгжлийн нэгдсэн санд, 10 хувийг тусгай зөвшөөрлийн талбай байрлах Бүсийн хөгжлийн санд, 10 хувийг тухайн тусгай зөвшөөрлийн талбай байрлах аймаг, нийслэлийн төсөвт, 10 хувийг тусгай зөвшөөрлийн талбай байрлах сум, дүүргийн төсөвт тус тус хуваарилахаар тусгасан байна. Хуулийн төслийг D-Parliament цахим сайтад байршуулж, иргэд, олон нийтийн саналыг авч байна.

Эдийн засгийн байнгын хорооны хуралдаанаар хуулийн төслүүдийг хэлэлцэх үед УИХ-ын гишүүн Батнайрамдал Бүсийн хөгжлийн сан шинээр байгуулах хэрэгцээ, шаардлагын талаар, газрын тос, байгалийн хий, алт, зэс зэрэг газрын хэвлийн баялаг бүрд өөр, өөр хуваарилалтын тогтолцоо бий болгож байгаа нь Баялгийн сангийн нэгдсэн бодлоготой нийцэж байгаа эсэх талаар, төсвийн орлогыг олон санд хуваарилах нь улсын орлогод хэрхэн нөлөөлөх талаар, Үндсэн хуулийн 6 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт заасан газрын хэвлийн баялгийн үр өгөөжийг иргэн бүр тэгш, шударга хүртээх зарчимтай нийцэж байгаа эсэх талаар, мөн Газрын тосны тухай хуульд заасан нөөц ашигласны төлбөр нь АМНАТ-тэй мөн чанартай ижил төлбөр тул нэгдсэн ойлголт, бодлогоор зохицуулах ёстой талаар, УИХ-ын гишүүн Б.Уянга Бүсийн хөгжлийн сан байгуулах гол үндэслэл нь газрын тосны орлого Үндэсний баялгийн санд төвлөрдөггүйтэй холбоотой гэж үзэж байвал Үндэсний баялгийн санд төвлөрүүлэх зохицуулалтыг хийж, нэгдсэн байдлаар тухайн сангаас хуваарилах хувилбар байж болох эсэх талаар, мөн хуулийн төсөлд ЗГ-аас ямар санал өгсөн талаар,

УИХ-ын гишүүн А.Ундраа шатдаг занар, занарын хий, занарын тос зэрэг бусад ашигт малтмал болон ашигт малтмалын олборлолтын явцад үүсдэг зарим төрлийн дагалдах ашигт малтмал, тухайлбал нүүрсний давхаргын метан хий гэх мэт дагалдах бүтээгдэхүүний эрх зүйн зохицуулалтыг хуулийн төсөлд хэрхэн тусгасан талаар, Бүсийн хөгжлийн сан байгуулах санааг дэмжиж байгаа ч өнгөрсөн хугацаанд байгуулагдсан олон төрлийн сангуудын удирдлага, хөрөнгө зарцуулалт,

хугацаанд байгуулагдсан, тайлагнал нь ил тод бус, хариуцлагын тогтолцоо нь тодорхойгүй явж ирснийг шүүмжлээд, энэ хуулийн төсөлд хэрхэн анхаарч байгаа талаар, УИХ-ын гишүүн Х.Булгантуяа газрын тосны орлогын хуваарилалтын асуудлыг дангаар нь бус газрын тосны салбарын хөгжлийн бодлого, хайгуул, олборлолтыг нэмэгдүүлэх эрх зүйн шинэчлэлтэй хамтран авч үзэх ёстой талаар, Бүсийн хөгжлийн сан байгуулах санааг дэмжиж байгаа ч баялгийн нөөц баялагтай аймгууд болон шууд өгөөж хүртэх боломжгүй нөөц баялаггүй боловч уул уурхайн ашиглалтын дэд бүтцийн ачаалал, сөрөг нөлөөлөлд өртдөг аймгуудын хөгжлийг хэрхэн тэнцвэртэй байлгах талаар, хуваарилалтын тогтолцоог сайтар боловсруулах талаар,

Их Хурлын гишүүн Б.Жаргалан энэхүү хуулийн төсөл нь зөвхөн газрын тосны орлогыг хуваарилах тухай асуудал биш, харин төсөв, татвар, Үндэсний баялгийн сангийн тогтолцоонд нөлөөлөх суурь шинжтэй өөрчлөлт учраас шинээр байгуулагдсан Бүсийн хөгжлийн сангийн бүтэц тодорхойгүй байгааг шүүмжлээд, сангийн хөрөнгийг хэн удирдах, шийдвэрийг хэн гаргаж, удирдлагын бүтэц ямар байх, засаглал, хяналт, хариуцлагын тогтолцоо хэрхэн ажиллах талаар, УИХ-ын гишүүн Ч.Анар газрын тос боловсруулах үйлдвэр ашиглалтад орох хугацаа ойртож байгаа ч үйлдвэрийг хангах хэмжээний газрын тосны баталгаатай эх үүсвэр байгаа эсэхэд эргэлзэж байгаагаа илэрхийлээд, Бүсийн хөгжлийн сан байгуулах санааг дэмжиж байгаа ч хөрөнгийг юунд зарцуулахыг журмаар биш, хуулиар нарийвчлан тогтоох, байгаль орчны нөхөн сэргээлт, экологийн хамгаалалт, орон нутгийн иргэдийн амьжиргааг дээшлүүлэх төсөл, хөтөлбөрүүдийн зориулалтыг хуульд тодорхой тусгах шаардлагатай талаар тус тус асуулт асууж, хариулт авлаа.

Мөн Байнгын хорооны хуралдаанаар хуулийн төслийг хэлэлцэх үед УИХ-ын гишүүн Г.Очирбат ЗГ-ын байр суурийн зөрөөтэй байдлыг шүүмжилж, байгалийн баялгийн өгөөжийг уул уурхайн үйл ажиллагааны сөрөг нөлөөлөлд өртөж байгаа бүс нутаг, иргэдэд түлхүү хүртээх зарчмыг дэмжиж байгаа талаар, УИХ-ын гишүүн Ш.Бямбасүрэн сөрөг нөлөөлөлд өртөж байгаа орон нутаг, иргэдийн үр өгөөжийг бодитой байдлаар хүртээх нь тухайн орон нутгийн иргэдийн дэмжлэг нэмэгдэх, газрын тосны хайгуул, олборлолт болон боловсруулах үйлдвэрлэлийн түүхий эдийн бааз бэхжих ач холбогдолтой талаар, УИХ-ын гишүүн Г.Уянгахишиг хуулийн төслийг хэлэлцэхийг дэмжиж байгаа ч хэлэлцүүлгийн явцад Бүсийн хөгжлийн сан, Үндэсний баялгийн сангийн зохицуулалт болон орлогын хуваарилалтын механизмыг нарийвчлан хэлэлцэх шаардлагатай талаар, УИХ-ын гишүүн Батнайрамдал орон нутагт байгалийн баялгийн өгөөжөө хүртэх боломжийг нэмэгдүүлэх шаардлагатай ч үүнийг зөвхөн Газрын тосны тухай хуульд өөрчлөлт оруулах хүрээнд бус Үндсэн хууль, Үндэсний баялгийн сан, төсвийн нэгдсэн бодлого, орон нутгийн хөгжлийн сангийн тогтолцоотой уялдуулж, судалгаанд тулгуурласан цогц байдлаар шийдвэрлэх ёстой талаар,

УИХ-ын гишүүн Д.Үүрийнтуяа хуулийн төслийг хэлэлцэхийг дэмжиж байгаагаа илэрхийлээд, энэ асуудлыг Бүсчилсэн хөгжлийн бодлого, Үндсэн хуулийн 6 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн нийтийн өмчийн зарчим болон Ашигт малтмалын тухай хуулийн шинэчлэлтэй уялдуулан цогцоор нь шийдэх ёстой талаар, УИХ-ын гишүүн Б.Мөнхсоёл газрын тосны орлогын хуваарилалтын асуудлыг дангаар нь шийдвэрлэх бус, Ашигт малтмалын тухай хуулийн шинэчлэлтэй уялдуулан авч үзэх шаардлагатай талаар, мөн шинэ сан нэмж байгуулахаасаа илүүтэйгээр одоо байгаа сангуудын тогтолцоо, хуваарилалтын механизмыг сайжруулж, үр ашигтай байдалд онцгойлон анхаарах талаар тус тус санал хэлсэн болно.

Байнгын хорооны хуралдаанаар Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.11 дэх хэсэгт заасныг үндэслэн хуулийн төсөл тус бүрийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжих эсэх талаар санал хураалт явуулахад Газрын тосны тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг 62.5 хувь, Төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг 66.7 хувь, Бүсчилсэн хөгжлийн удирдлага, зохицуулалтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг 54.2 хувь, Татварын ерөнхий хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг 66.7 хувь, Үндэсний баялгийн сангийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг 66.7 хувийн саналаар хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжиж, хуулийн төслүүдийг УИХ-ын чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх нь зүйтэй гэж үзлээ.

УИХ-ын эрхэм гишүүд ээ, Газрын тосны тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн Төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Бүсчилсэн хөгжлийн удирдлага, зохицуулалтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Татварын ерөнхий хуульд өөрчлөлт оруулах тухай, Үндэсний баялгийн сангийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүдийн хэлэлцэх эсэх талаарх Эдийн засгийн байнгын хорооны санал, дүгнэлтийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг та бүхнээс хүсье. Анхаарал тавьсанд баярлалаа.

С.Бямбацогт: Баярлалаа. Ажлын хэсгийг танилцуулъя. Чулууны Хишигдалай Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамны Газрын тосны бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга, Батхишигийн Мөнх-Эрдэнэ, Эдийн засаг, хөгжлийн яамны Макро эдийн засгийн бодлогын газрын дарга, Батжаргалын Төгөлдөр Эдийн засаг, хөгжлийн яамны Хөрөнгө оруулалтын бодлогын газрын дарга, Ванчиг-Арслангийн Содномдаржаа Сангийн яамны Төсвийн бодлого, төлөвлөлтийн газрын Төсвийн нэгтгэлийн хэлтсийн дарга. Ажлын хэсгийн бүрэлдэхүүн та бүхэн УИХ-д хүндэтгэлтэй хандах, УИХ-ын гишүүдийн асуултад үнэн зөв, бодитой, гүйцэд мэдээлэл өгч хариулах ёстой. Худлаа мэдээлэл өгөх, УИХ-ын үйл ажиллагаанд хүндэтгэлгүй хандах, хариулахаас татгалзах юм бол холбогдох хуулийн дагуу хариуцлага хүлээдэг болохыг сануулъя.

Хуулийн төслийн үзэл баримтлал болон Байнгын хорооны санал, дүгнэлт, хууль санаачлагчийн илтгэлтэй холбогдуулж асуух асуулттай гишүүд нэрсээ өгнө үү? Урьдчилан ирүүлсэн нэрсийн дагуу Гомбын Ганбаатар гишүүн алга байна, Батын Батбаатар гишүүн алга байна. Дашцэрэнгийн Энхтүвшин гишүүн асуултаа асууя.

Д.Энхтүвшин: Хуулийн төслийг дэмжиж байгаа. Тэгэхдээ 1 тодруулах ЗГ-ын хуралдааны тэмдэглэл дээр Бүсийн хөгжлийн сантай холбоотой асуудал хөндсөн байгаа. Дагаж байгаа хууль төсвийн тухай хуулийн нэмэлт, өөрчлөлт дээр гол заалт нь Бүсийн хөгжлийн сантай холбоотой. Тэгэхээр орон нутгийн хөгжлийн нэгдсэн сан гээд Төсвийн тухай хуулийн 4.1.28 дээр энэ сангийн тодорхойлолтыг бүс нутгийн тэнцвэртэй байдлыг хангах гээд заачихсан байгаа юм. Тэгэхээр ийн бүс нутгийн тэнцвэртэй байдлыг хангах зориулалттай сан байхад давхар бүсийн хөгжлийн сан гэж байгуулах шаардлага байгаа юу? Энийг хууль санаачлагчид ямаршуу байдлаар шийдье гэж бодож байгаа вэ, ЗГ-ын хуралдааны тэмдэглэлийн талаар энэ хуулийн

төсөл дээр дахиж өөрчлөлт оруулаагүй орж ирсэн юм шиг байна. Тэгээд энэ дээр тайлбар хэлээч гэдэг нэг л асуулт байна?

С.Бямбацогт: Хэн хариулах вэ? Хууль санаачлагч Соронзонболд гишүүн хариулъя.

Л.Соронзонболд: Тэгэхээр таны хэлж байгаа үнэн л дээ, орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангийн зорилго нь орон нутгийн хөгжил бүсийн хөгжлийг тэгш байлгахад зорилготой байдаг. Гэсэн хэдий ч яг өнөөдрийн байдлаар яг орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангийн зарцуулалт, гүйцэтгэл маань өөрөө бүс тус бүрийн тэргүүлэх чиглэл рүү чиглэсэн асуудлууд руу чиглэсэн зарцуулалт харьцангуй бага байгаад байгаа юм. Тийм учраас бүс тус бүрд нь бүсийн хөгжлийн сан байгуулаад, тэндээсээ тодорхой хэмжээний зарцуулалтыг хийж байвал илүү үр дүнтэй юм болов уу гэсэн энэ бодлогын үүднээс хуулийг санаачлахад энэ саналыг оруулсан. Хэрвээ УИХ-ын гишүүд маань энэхүү хуулийн төслийг маань хэлэлцэх эсэхийг дэмжвэл энэ дээр хэлэлцэх эсэхэд бэлтгэх хэлэлцүүлэгт бэлтгэх ажлын хэсэг дээр тодорхой хэмжээний өөрчлөлтүүдийг оруулаад явах боломж байгаа гэж бодож байгаа.

Гэхдээ та бүхэн мэдэж байгаа, жишээлбэл зүүн бүс гэхэд түүхэн аялал жуулчлал болон эрчимжсэн МАА-г, эрчимжсэн ХАА-г тэргүүлэх чиглэлээ болгосон бүс байна гэсэн мөртөө яг тэр чиглэл рүү чиглэсэн ийм бүсийн тэргүүлэх зэргийн зарцуулалт, хөрөнгө оруулалт хийж байгаа байдал хангалтгүй байгаад байгаа юм. Тийм учраас энэ бүсчилсэн хөгжлийн сан бүсийн нэгдсэн бүсийн хөгжлийн сантай болоод тэндээсээ тодорхой хэмжээний бүсийн хөгжлийн дэд бүтцийн хөрөнгө оруулалт янз бүрийн зүйлүүдээ хийдэг байх нь зүйтэй юм болов уу гэж бодож байгаа юм.

Энэ Бүсийн хөгжлийн сан дээр бас нэг анхаарч байгаа зүйл нь өнөөдөр Дорнод аймаг гэхэд жишээлбэл газрын тосны нөөц ашигласны төлбөр авч байгаа, эндээс олж байгаа, хуримтлуулсан юунаасаа бүсийн хөгжлийн санд 10 хувийг нь хуваарилаад тэндээсээ Хэнтий, Сүхбаатар аймаг руугаа 3 аймгийн дундаа тохироод бүсийн хэлэлцээрээр тохирсон тэргүүлэх чиглэлийн салбар луугаа хөрөнгө оруулалт хийх ийм боломжууд нь бий болно гэж харсан учраас ийм саналыг гаргасан. Тэгээд мэдээж Эдийн засгийн байнгын хорооны хурлаар гишүүд энэ тал дээр орон нутгийн хөгжлийн нэгдсэн сан дээрээ илүү түлхүү тулгуурлаад явбал яасан юм бэ гэсэн саналууд гаргасан. Тэгэхээр энэ нээлттэй. Энийг хэрвээ хэлэлцэх эсэх нь дэмжигдээд явах юм бол хэлэлцүүлгийн шатад тодорхой хэмжээнд өөрчлөх боломж байгаа гэж харж байгаа.

С.Бямбацогт: Баярлалаа. Сайнхүүгийн Ганбаатар гишүүн асуултаа асууя.

С.Ганбаатар: Энэхүү хууль орж ирлээ. Газрын тосны үйлдвэртэй болохыг дэмждэг, мөрөөддөг хүний хувиар асуулт асууя. Хуулийн үзэл баримтлал дээр Монгол Улсын Үндсэн хуулийн 6 дугаар зүйлийн 2 дээр газрын хэвлийн баялаг ард түмний мэдэл, нийтийн өмч байна гээд заасан байгаа. Үүнтэй холбогдуулаад энэ үзэл баримтлал дээр газрын тос, байгалийн хийн нөөц ашигласны талаарх зүйл, заалттай холбогдуулж асуулт асууя. Өнөөдөр Газрын тосны тухай хуульд өөрчлөлт оруулах энэ тухай орж ирж байгаа. Өнөөдөр газрын тосны үйлдвэртэй холбогдуулж, 2018 оны 1 дүгээр сарын тогтоолоор Энэтхэгийн 1 тэрбум долларын зээлээр газрын тос боловсруулах үйлдвэр баригдана, 760 сая доллароор хөрөнгөөр үйлдвэр

барина, 240 сая доллароор нь дамжуулах хоолой барина гэж заасан. Энэ ТЭЗҮ-г үзсэн үү? Хэдэн сарын, хэдэн оны ТЭЗҮ байгаа вэ? Энэ ТЭЗҮ-тэй байх ёстой.

Дараа нь 1 тэрбум доллар 1.2 тэрбум доллар болж өөрчлөгдсөн. Дараа нь 1.7 тэрбум доллар болж өөрчлөгдсөн. 200 сая доллар, 460 сая доллар ингээд нэмэгдэж байхад ТЭЗҮ-д өөрчлөлт орсон уу, хэдэн сарын хэдэн огноогоор, хэд, хэзээ өөрчлөгдсөн бэ та нар үзсэн үү? Миний 2 дугаар асуулт.

3 дугаар асуулт энийг Монголын ард түмэн төлнө шүү дээ, дараа нь хүүтэй төлнө шүү дээ. Хүүтэй төлнө Монголын ард түмэн, ашигт үйлийн коэффициент энэ өөрөө өөрийгөө хэзээ нөхөх вэ, хэдэн жилийн дараа нөхөх вэ? Миний тооцоогоор 60.6 жилийн дараа нөхнө. Үндсэндээ хэзээ ч энэний ашиг шимийг одоо амьдарч байгаа Монголчууд харахгүй байх. Миний энэ асууж байгаа зүйлүүд дээр тоо баримттай хэзээний тоо, хэзээний ТЭЗҮ, хэзээний дүгнэлтүүд байгаа вэ гэдгийг он, сар, өдөртэй огноотой нь хэлж өгнө үү?

3 дугаар асуулт, энэ тосны үйлдвэр дээр ТЭЗҮ-гийн талаар асуучихлаа, усны талаар усаар хэзээ ч дутагдахгүй, усаар хангалттай байна, энэ үйлдвэр мөрөөдөл биш, хүмүүсийн мөрөөдөл дээр тоглож байгаа юм биш, та санаа зовохгүй байж болно гэдгээ усны дүн шинжилгээ, экспертүүдийн дүгнэлт нь хэзээ гарсан бэ? Хэн, хэн гэдэг эрдэмтдийн дүгнэлт байгаа вэ?

Дараагийн асуулт түүхий эдийн гэрээ байгуулсан уу та нар? Яг энэ хуулийн энэ нэмэлт, өөрчлөлттэй оруулж ирж байгааг асууж байна шүү. Дорнодын тэр Тамсагаас түүхий эд таслахгүй гэдэг гэрээ байгуулагдсан уу? Хэдэн сарын хэдэнд, ямар тоотой, ямар огноотойгоор байгуулагдсан бэ? Би 4 маш тодорхой асуулт асууж байна. Ийм юманд хариулахгүй бол та нар над шиг энэ дотор сууж байгаа 126 шиг Монголчуудын мөрөөдлийг хуурч байна гэсэн үг. 2018 онд үйлдвэр баригдана, 2 жилийн дотор баригдана гэсэн, одоо 2018 он болчихсон, яагаад 10 жил хойшлогдов, миний 5 дахь энэ асуултад хариулна үү.

6-д нь эртээд асуусан, надад ямар ч тоймтой хариулт өгөөгүй. Яг энэ газрын тосны үйлдвэрийг хариуцаж байгаа ЗГ-аас төлөөлж байгаа, энэ УУЯ-ыг төлөөлж байгаа Алтанцэцэг захирал 480 сая доллар, 480 сая доллар орж ирсэн юм шиг байна лээ, хаашаа орсон нь мэдэхгүй гэдгийг 4 дүгээр сарын 1-нд энэ ордон дотор коридорт олон мэдээллийн хэрэгслээр ярьсан, энэ 480 сая доллар байхгүй, орж ирээгүй гэж байгаа юм. Эсхүл тэр хүн худлаа хэлсэн юм уу, та нар эсхүл худлаа хэлж байна уу? Энэ чинь Монголын ард түмнийг төлөөлж байгаа хүн энийг асуух ёстой шүү дээ. Та нар хариултаа саяын 6 асуултад тоо баримттай, үндэслэлтэй, тооттой хариулах ёстой нэр устай, би хариултаа авъя.

С.Бямбацогт: Ажлын хэсэг хариулъя. Индрийн 4 дүгээр микрофон.

Ч.Хишигдалай: Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамны Газрын тосны бодлогын газрын дарга Хишигдалай. ТЭЗҮ-ийг 2019 оны 1 дүгээр сарын 30-ны өдрийн STR 18-05-01 дугаартай дүгнэлтээр анхны ТЭЗҮ-ийг хүлээж авсан. Уг ТЭЗҮ-ээр 1 тэрбум 236 сая долларын хөрөнгө оруулалтаар үйлдвэрийг барина. Дараагийн ТЭЗҮ-ийн тодотголыг 2023 оны 10 дугаар сарын 6-ны өдөр ГСХ/23001 дугаартай дүгнэлтээр хүлээж авсан. Уг ТЭЗҮ дээр 462 сая ам.доллар нэмэгдэж, тэрбум 698 сая ам.доллараар тус үйлдвэрийг ашиглалтад хүлээж авна гэсэн тодотгол хийгдсэн. Гол үндэслэл нь цар тахлын улмаас бараа бүтээгдэхүүний үнэ, тээвэр, логистикийн

үнэ нэмэгдсэн. Мөн боловсруулах үйлдвэр дээр тодорхой хэмжээний техник, технологийг Монгол Улсын цаг агаар, байгаль орчны юунд тохируулж шинэчлэх шаардлагатай гэдэг үндэслэлээр ингээд хийгдсэн байгаа.

Үйлдвэр 2019 оноос анх баригдаж эхэлсэн, 21, 22, 23 онд цар тахлын улмаас үйл ажиллагаа зогссон. Үүнтэй холбоотой үйлдвэрийн ажил тодорхой хэмжээгээр сунжирч байгаа. Үүнтэй адилхан төсөл хөтөлбөрүүд дэд бүтэц хөгжсөн газар 4-өөс 5 жил босдог. Дэд бүтэц хөгжөөгүй улс орнуудад 8-аас 9 жилийн хугацаанд босдог практикийг бид судалж үзсэн. Дорнод аймагт газрын тосны олборлолтын үйл ажиллагаа явуулж байгаа Петро Чайна Дачин Тамсаг компанитай бид Бүтээгдэхүүн хуваах гэрээтэй, бүтээгдэхүүн хуваах гэрээний салшгүй хэсэг протоколоор Монгол Улсад газрын тос боловсруулах үйлдвэр баригдсан тохиолдолд нэн тэргүүн ээлжид газрын тосыг Монгол Улсын газрын тос боловсруулах үйлдвэрт нийлүүлнэ гэсэн гэрээний нэг салшгүй протоколтой. Энийг 2011 онд, би буруу санаагүй бол хийсэн. 2014 онд батлагдсан Газрын тосны тухай хууль дээр мөн нэн тэргүүнд Монгол Улсын газрын тос боловсруулах үйлдвэрт нийлүүлнэ гэдгийг хуульчилсан байгаа.

Дараагийн асуулт. Тэр 468 сая доллар орж ирсэн, хаашаа орсон нь мэдэхгүй байна гэдэг асуудал буруу ойлголт төрүүлсэн юм шиг байна. Ер нь энэ төсөл өөрөө Энэтхэгийн Эксим банкнаас санхүүжилт нь гардаг, гүйцэтгэлээр нь тухайн ЕРС 1, 2, 3, 4 дээр ажиллаж байгаа ААН-үүд рүү шилжээд явдаг. Үүнд Монгол Улсын ямар нэгэн банк, санхүүгийн байгууллага руу орж ирэх Монгол Улсаас.../минут дуусав/

С.Бямбацогт: Гүйцээж хариулъя, 4 дүгээр микрофон.

Ч.Хишигдалай: Энэ зээлийн зарцуулалтын дагуу Энэтхэгийн Эксим банкнаас төслийн гүйцэтгэгч рүү санхүүжилт шилждэг байгаа. Монгол Улсын ямар нэгэн банк, санхүүгийн байгууллага руу орж ирэх, дамжих, хуваарилах тийм боломж байхгүй. Хариулж дууслаа.

Усны хувьд Дорноговь аймгийн Бор хөөврийн талаас тус үйлдвэрийг хангахуйц хэмжээний усны нөөц тогтоогдоод уг үйлдвэрийг хангахаар төслийн ТЭЗҮ-д орчихсон явж байгаа. Бор хөөврийн тал гэдэг газраас.

С.Бямбацогт: Баярлалаа. Болдын Уянга гишүүн асуултаа асууя. Тодруулах уу? Сайнхүүгийн Ганбаатар гишүүн тодруулъя.

С.Ганбаатар: Энэ үйлдвэрийн ашигт үйлийн коэффициентын талаар би асуусан, 60 жилийн дараа өөрийгөө нөхнө гэсэн үг байгаа, тэрийг тодруулж асуусан.

2 дугаар зүйл гэвэл өнөөдөр Дачин Тамсагаас тэр Дорнодоос нефтиэ 100 хувь хангана гэдэг тоо баримтыг та худлаа хэлж байна. Гэрээн дээр нэг тийм үг байгаа л гэж хэлээд байна, үндсэндээ тэрийг баталгаажуулж байж өнөөдөр ярих ёстой.

3 дугаар зүйл гэвэл өнөөдөр та нар бод доо, 1 тэрбумаар барина гэсэн үйлдвэр 760 гэж байгаа шүү, 760 сая доллароор барина, хоолой нь 240 сая доллар гэж байгаа, 1.7 болчихсон, 70 хувиар ихэссэн, 700 сая доллароор өссөн. Энэ чинь гурил, будаа биш шүү дээ, энэ чинь. Land Cruiser өнөөдөр одоо 10 жилийн дотор хэд өсөв, өсөөгүй шүү дээ, яг гурил, будааны наймаачин шиг л юм ярих юм. ТЭЗҮ-ийн дүгнэлтүүдийг нь харъя гэвэл бүгдийг нь нууц гээд хадгалчихдаг.

С.Бямбацогт: Үг хэллээ. Болдын Уянга гишүүн алга байна. Отгоншарын Батнайрамдал гишүүн алга байна. Сүхбаатарын Эрдэнэбат гишүүн асуулт асууя.

С.Эрдэнэбат: Хуулийг үзэл баримтлалын хувьд дэмжиж байгаа. Ер нь одоо тухайн газар орон нутгийг ашиглаж байгаа Петро Чайнагийн хувьд газрын тосны хувьд аваад үзэхэд 40 хувийг нь Монгол Улсын ЗГ бүтээгдэхүүн хуваах гэрээгээр шууд ЗГ луу төвлөрүүлээд авчихдаг, эргүүлээд хуваарилахдаа орон нутагт нь энэнээс багагүй юм нь ногдож байгаа. Би тэгэхээр 16 жилийн өмнөх зүйлийг эргээд ярья. Тухайн үед Ерөнхий сайд Баяр Ерөнхий сайд байсан санаж байна. Би тухайн үед үйлдвэрчний эвлэлд Петро Чайнагийн ажилчдын эрх ашгийг нь хамгаалж, цалингаа нэмүүлэх гэдэг маргаан дээр нь очиж байхад бүгдээрээ контейнерт амьдарч байсан. Халуун зунд контейнерт амьдарна гээд бодоорой доо, өвөл ч гэсэн. Тэгээд орон сууц барина гэдэг шаардлагыг тухайн үеийн Ерөнхий сайд тавьж байсан. Тэгэхэд Хятадын тал юу гэж хэлсэн юм бэ гэхээр Монгол Улс өөрөө ногдол ашиг 40 хувийн байдлаар бүтээгдэхүүн хуваах гэрээ авч байгаагийн хувьд тодорхой хөрөнгө оруулалтаа хийгээд, бид тодорхой тэр хэмжээнд нь хөрөнгө оруулж ажилчдын орон сууц барина гэж. Одоо яг манай Тамсагт байж байгаа ажилчид яг орон сууцад байна уу, контейнерт амьдарч байна уу, энийг тодруулж асууя.

2 дугаарт, тухайн үед 150 долларын цалин авч байсан юм, 3 хоног ажил хаялт хийгээд энэ чинь бараг 2 улсын ЗГ-ын хоорондох асуудал болоод тухайн үед манай Ганбаатар гишүүн хамт явсан, санаж байна бид, Даваасүрэн гишүүн, Болорчулуун гишүүн бид хэд чинь бөөн юм болж байж тэнд нэг цалинг нь 300 доллар болгож байсан. Одоо яг хэдэн доллароор авч байгаа вэ? Тэгэхээр тэнд халуунд нь халж, хүйтэнд нь хөрж байгаа ажилчдад ихэнх нь Дорнодын иргэд байдаг. Тэр хүмүүст тодорхой хэмжээний орон нутагт нь хуваарилах юунуудаас ядаж орон сууц бариад өгчих. Ойрхон, энэ чинь 200 гаран километр байгаа шүү дээ Дорнодын төвөөс Матад гээд урагшаа. Тэгэхээр энэ орон нутагт нь хуваарилсан мөнгөөр тухайн хүнд нь зориулсан гэдэг байдлаар тавихгүй бол дахиад орон нутагт нь хуваарилахаар тэрийг нь аваачаад нэг байшин, барилга янз бүрийн бусад юунууд руу тараагаад тавьчих вий. Нөгөө Матад сумд яг яаж ногдол ашиг ногдохоор энэ хуулийн төсөл дээр тавьсан уу, үгүй юу гэдгийг хэлмээр байна.

Дээрээс нь энэ орон нутгийн ажиллах хүчийг нийлүүлэх гэрээ гээд хэдэн хүмүүс мянган доллар цаад компаниас нь авангуутаа 500-г нь өгөөд, 500-г нь дундуур нь цавчдаг ийм юм байсан юм тухайн үед очиход. Тал дээр нэг хэдэн хүмүүсийг хөөрхий нэг гэр дотор хийгээд тавьчихсан. Тэгэхээр одоо яг тэр ажиллах хүч нийлүүлэх асуудал яг юу болж байгаа вэ? Тэгэхээр энэ орон нутагт ногдох хэрвээ орлого орж ирэх юм бол тэнд ажиллаж байгаа Дорнодын иргэд, сумдын иргэд, тэнд ажиллаж байгаа хүмүүст нь юу ногдох юм бэ? Би бол хэрвээ тухайн үед эрчим хүчинд холбогдоогүй тийм байгаа үед нь яах вэ гэхээр тэр сэргээгдэх эко орон сууцууд бариад орон нутагт ногдох юугаар нь, тэгээд тэнд ажиллаж байгаа газрын тосны үйлдвэр илүү л томрох байлгүй. Тэнд ядаж нөгөө тохилог орон сууцад амьдардаг болмоор байна.

Манай Оюу Толгой ч гэсэн ялгаа байхгүй шүү дээ яг үнэндээ контейнер угсраад л тавьчихсан, тэнд нь л нэг хэдэн ажилчид 15 жил л амьдарч байна. Тэгэхээр энд хэзээ нэгэн цагт газрын нөөц дуусна, баялаг дуусна, тэнд хот үлдэх хэрэгтэй, Эрдэнэт шиг. Тэгэхээр яг ийм бодлогоор л бид цааш цаашдаа энэ хуулиуддаа өөрчилж авахгүй бол газрын баялаг нь дуусдаг, тэнд хоосон нүх үлддэг,

хоосон хүн ч байхгүй нэг тийм л юм үлддэг, ийм үлдэх вий дээ л гэдэг үүднээс би энэ санааг хэлье, асууя гэдэг үүднээс энэ хуулиа хэлэлцэх эсэхийг нь дэмжээд, нэмээд ийм саналуудыг оруулах боломж байна уу? Өөрөөр хэлбэл, орон нутагт ногдох тэр юунд нь тэр тухайн орон нутаг болон ажиллах хүмүүст нь ногдол ашиг, би ажилчдад хувьцаа олго гэж яриад байгаа юм. Өөрийнхөө хүч хөдөлмөр гэрээсээ тухайн үед 60 хоног гэрээсээ хол байдаг байлаа шүү дээ, Дорнодын ажилчид. Үндсэндээ тэнд гэр бүл гэдэг зүйл тун хэцүү болдог. Тийм учраас тухайн орон нутагт баялаг үйлдэх ёстой, энэ талд нь тухайн орон нутагт ажиллаж, амьдарч байгаа хүмүүсийг ядаж уурхайнхаа хажууд орон сууцтай, тохилог гэр бүлтэйгээ амьдрах энэ боломж, бололцоог бүрдүүлэх тал дээр дийлэнх нь зарцуулагдах ёстой гэдэг үүднээс энийг тодруулж асууж байна.

С.Бямбацогт: Соронзонболд гишүүн хариулъя хууль санаачлагч.

Л.Соронзонболд: Эрдэнэбат гишүүн маш зөв асуудал хөндөж байна. 30 гаруй жил манайд газрын тос олборлоод, өнгөрсөн, Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамнаас авсан мэдээллээр ерөнхийдөө 3 их наяд төгрөгийн төсөвт орлого оруулсан юм байна лээ. Энэ нь бүтээгдэхүүн хуваах гэрээний хүрээнд болон тусгай зөвшөөрлийн төлбөр, газрын тосны нөөц ашигласны төлбөр гэсэн нийт дүнгээр 3 их наяд төгрөгийн төсөвт өнгөрсөн 30 гаруй жилийн хугацаанд оруулсан байна. Тийм учраас яг сумд ордог төлбөр нь юу байдаг вэ гэхээр тусгай зөвшөөрлийн төлбөрийн 10 хувийг тухайн сумд оруулдаг, тусгай зөвшөөрлийн төлбөрийн 20 хувийг аймгийн төсөвт, үлдсэн 70 хувийг нь улсын төсөвт оруулдаг ийм хувилбараар явж байгаа.

Харин газрын тосны нөөц ашигласны төлбөр тэр чигээрээ улсын төсөвт ордог, эндээс улсын төсвөөс 30 хувийг нь орон нутгийн хөгжлийн нэгдсэн санд хуваарилж байгаа юм. Орон нутгийн хөгжлийн нэгдсэн санд. Тэндээсээ 30 хувийг нь газрын тосны нөөц ашиглуулж байгаа энэ нөлөөлөлд өртөж байгаа аймгуудын хэрвээ оруулж байгаа хувь нэмэр нь 1 хувиас дээш байвал тэнцүү хуваарилдаг. Ингээд манай Дорнод аймаг болон Дорноговь аймаг жил бүр нэг ойролцоогоор 2.3-аас 2.4 тэрбум төгрөгийг газрын тосны нөөц ашигласны төлбөрөөс хүлээж авдаг. Дорнод аймаг маань өөрөө 14 сумтай, Матад сум маань нэг сум, Матад сумдаа тодорхой хэмжээний мөнгө хуваарилдаг иймэрхүү байдалтай байгаа. Тэгэхээр яг тухайн нөлөөлөлд өртөж байгаа сумдын хувьд орж байгаа хөрөнгө оруулалтын хэмжээ харьцангуй бага байгаа юм. Тийм ч учраас нутгийн иргэд энэ өгөөж нь яг иргэдэд очиж байгаа өгөөж бага байна гэдгээрээ нэлээн эсэргүүцдэг.

Дээрээс нь бид чинь ингээд газрын тосны үйлдвэр байгуулаад ашиглалтад оруулах гээд байдаг, хайгуул хийх гээд байдаг, сумдын иргэд эсэргүүцээд байдаг. Яагаад гэхээр өмнөх сумдад нь очиж байгаа өгөөж, үр өгөөж нь бага байгаа ийм асуудал байгаа учраас энэ хуулийг зүүн бүсийн гишүүд говийн бүсийн гишүүдтэй хамтарч санаачлаад өргөн барьсан гэдгийг танд дуулгаж хэлмээр байна.

Тэгээд энэ хөдөлмөр зуучийн үйлчилгээ тэр компаниар дамжиж байгаа. Тэгэхдээ яг одоо тодорхой үнэ, ажиллагсдын цалин дээр ямар байдалтай вэ гэдгийг үнэхээр хэлж мэдэхгүй байна. Энэ дээр та судалж байгаад, эргээд хариу хэлье гэж бодож байна. Бусад асуудал дээр нь ажлын хэсгээс нэмээд хариулчих уу. Ер нь контейнерт ажиллагсад байгаа хэвээрээ байгаа. Тэнд ямар нэгэн шинээр орон сууц барьсан зүйл байхгүй байгаа гэж харж байгаа.

С.Бямбацогт: Цэвэгдоржийн Туваан гишүүн. 4 номер ажлын хэсэг хариулъя.

Ч.Хишигдалай: Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамны Газрын тосны бодлогын газрын дарга Хишигдалай. Яг өнөөдөр кемпийн ажилчид тохижуулсан контейнерт ажиллаж байгаа. Энэ салбарын онцлог. Яагаад вэ гэвэл тухайн орд ашиглалт дуусаад тухайн орд дээр байгаа барилга, байгууламжуудыг бүгдийг нь буулгаад, нөхөн сэргээгээд, байгалийн унаган төрхөд нь оруулж өгөөд явах ёстой байдаг. Ажилчдын нийгмийн асуудлыг шийдэхийн тулд компанийн хүрээнд спорт заал, хоолны газар, ресторан барих гэх мэтчилэн хөрөнгө оруулалтуудыг хийгээд явдаг. Гэхдээ эргээд нөгөө үл хөдлөх хөрөнгийн татвар эд нар гээд асуудлууд гараад ирдэг. Магадгүй сумын хэмжээнд орон сууцжуулах гэх мэтчилэн хөрөнгө оруулаад явах боломжууд байгаа. Тэгэхдээ салбарын онцлогийг та харгалзаж үзээсэй гэж бодож байна. Энэ хуулийн төслөөр тухайн сумын төсөвт нийтдээ 10 хувь нь очих ёстой, энэ нь ойролцоо.../минут дуусав/

С.Бямбацогт: Хариултаа дуусгая.

Ч.Хишигдалай: 2025 оны нөөц ашигласны төлбөрөөс харвал жилдээ 3.6 тэрбум төгрөг сум дээр очихоор харагдаж байна.

С.Бямбацогт: Эрдэнэбат гишүүн тодруулъя.

С.Эрдэнэбат: Салбарын онцлог гээд тэнд хүн амьдрах байшин барьж болохгүй гэсэн юм ярьж болохгүй. Одоо тэнд очиж ажиллах гэж байгаа өнөөдөр мэргэжил эзэмшиж байгаа залуу би эндээс мянган километр туулж очоод тэнд ажил хийнэ гэдэг байдлаар, гэр бүл нь Улаанбаатар хотод байдаг байдлаар цаашаа явж болохгүй. Эрдэнэт хот гэхэд хот босгоод болчихсон байна шүү дээ бүхэл бүтэн 100 гаран мянган хүнтэй. Тэгэхээр салбарын онцлог гээд байдаг, Оюу Толгойг ч гэсэн одоо тэгэх юм уу, салбарын онцлог учраас Ханбогд сумд магадгүй 100 жилийн дараа хот байхгүй, бүгдийг нь булаад ингээд явна гэдэг ийм үзэл баримтлалаар ярьж болохгүй гэдгийг би хэлмээр байна. Тийм учраас тэнд ажиллаж, амьдарч байгаа хүмүүс тэнд тохилог байртай байх ёстой. Тохижуулсан контейнер гэдэг чинь яг л би төсөөлж байна, аравхан метр квадрат байрны дотор нэг ийм сэнс тавьчихсан хуурай нөхцөлд, өвөл хуурай тенгэйд тэгээд тийм л байгаа байхгүй юу. Тийм учраас энийг бүр эрс, хэрвээ ашиглалт юу оруулах юм бол дэмжих.../минут дуусав/

С.Бямбацогт: Үг хэлчихлээ. Цэвэгдоржийн Туваан гишүүн асуултаа асууя.

Ц.Туваан: Эндээс энэ бүсийн хөгжлийн сан гээд нэг сан үүсэх нь. Энэ хуульд байхгүй ийм сантай болох юм байна гэж харагдаж байна. Тэгээд энэ орон нутгийн хөгжлийн сангаас ямар ялгаатай юм бэ? Энэ орон нутгийн хөгжлийн сангаараа явж болохгүй заавал ингэж хуульчлах шалтгаан юундаа байгаа юм бэ гэдгийг асуучихъя? Яагаад ингэж асууж байна гэхээр Бүсийн хөгжлийн сан гаргана гээд нэг прецедент тогтоохоор бусад бүсүүд бүгдээрээ Бүсийн хөгжлийн сантай болъё, ийм, ийм юмнуудаа эндээ авъя гээд эхлэх байх л даа, би тийм үр дүнг харж байна. Тэгэхээр энэ дээрээ нэг хариулт өгөөч?

Олборлолтын талаар нэг мэдээлэл өгчхөөч. Өнгөрсөн 2025 оны олборлолтын дүнг 2 компани л байгаа, тэр 2-ын дүнг тус тусад нь болон нэгтгээд хэлээд өгчхөөч? Бид өмнө нь энэ 2012, 2013 оны үед чинь 1.1 сая тонн жилдээ олборлож байсан ийм түүх байгаа. Тэгээд энэ газрын тосны салбар өдөрт 1 сая долларын мөнгийг улсын төсөвт төвлөрүүлж байсан ийм түүх байгаа. Тэгэхээр бид юу хэлэх гээд байна гэхээр

энэ олборлолтоо нэмэгдүүлж байж энд авах мөнгө чинь нэмэгдэнэ шүү дээ. Тэгэхээр бид энэ хөрөнгө оруулалт, дээрээс нь үйл ажиллагаа явуулж байгаа компани энэ тэртэйгээ ойлголцож, шинэ талбай ашиглах гэдэг байдлаар энэ олборлолтоо нэмэхгүй бол нөгөө 1.5 сая тонныг хэрэглэх газрын тос боловсруулах үйлдвэр маань нэг жил гаруйн дараа хаалга тогшоод л байж байна ашиглалтад орох гээд. Энэ талаар ер нь ямар арга хэмжээ авч байна гэдэг нэг асуудал байна.

Бид чинь жилдээ 2 тэрбум доллароо ОХУ руу бэлнээр нь явуулаад газрын тосны бүтээгдэхүүн авч байгаа, тэрийгээ гуйн барин янз бүрийн асуудал, нөхцөлүүдийн дундуур авч байгаа. Тэгэхээр өөрсдийн газрын тосны хэрэглээнийхээ 55 хувийг хангах энэ үйлдвэрээ бариад, жил хагасын дараа ашиглалтад орох гэж байна. Энэний гэдэс, ходоод руу хийх, ам руу нь хийх газрын тосон дээр ер нь ямар бодлого бодож цаашаа явж байна, энэ чинь ер нь өнөө маргаашгүй болж байгаа шүү. Энэ нэлээн тийм сэтгэл түгшээсэн ийм зүйл болж байгаа юм. Дээр нь ашиглалтын баталгаат нөөцийг хэмжээг нь хэлээд өгөөч. Хүмүүс энийг их асуугаад байдаг юм.

Тэгээд дээрээс нь хайгуулын асуудал дээр нэг хариулт авчихъя. Хайгуул дээр одоо яг хайгуул явагдаж байгаа хэдэн талбай байна, үр дүн байна уу, хайгуул хийгдэж байна уу гэдэг нэг ийм зүйлийг ажлын хэсгээс нэмээд асуучихъя. Тэгээд энэ дээр нэг юм нь болохоор яг энэ хуулийн өмнө Ашигт малтмалын тухай хууль орж ирж байгаа юм. Ашигт малтмалын тухай хууль дээр чинь ерөөсөө гол амин сүнс концепц нь энэ АМНАТ-ийн хэчнээн хувийг өмнөх хуулиасаа нэмүү байдлаар орон нутагт үлдээх вэ гэдэг л ийм концепц. Тэгэхээр Дорнод аймгийн иргэдэд энэ газрын тосоо ашиглуулж байгаа энэ аймагт нь АМНАТ-ийн өндөр хувь өгөхийг нь дэмжиж байгаа. Энэ алтаа, газрын тосоо өгч байгаа газарт нь ахиу орлого өгөхгүй бол тэр хүмүүст чинь ямар сэтгэл ханамж байх вэ, тийм ээ, тийм утгаараа энэ зөв. Тэгээд саяын асуултууддаа хариулт авъя.

С.Бямбацогт: Ажлын хэсэг хариулъя. 4 дүгээр микрофон.

Ч.Хишигдалай: Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамны Газрын тосны бодлогын газрын дарга. Дорнод аймгийн Тосон уул, Тамсаг 21 талбай дээр олборлолтын үйл ажиллагаа явуулж байгаа Петро Чайна Дачин Тамсаг компанийн орд ашиглах төлөвлөгөөнд үндэслэж, газрын тос боловсруулах үйлдвэрийг бид барьж эхлүүлсэн. Петро Чайна Дачин Тамсаг компани гол олборлолтынхоо үед 1.2 сая тонныг олборлож, 1.1 сая тонн газрын тосыг экспортолж байсан. Нөөцийн хувьд 335 сая тонн геологийн нөөцтэй, ашиглалтын баталгаат нөөц анх 43.5 сая тонн эрдэс баялгийн санд бүртгүүлж байсан бол өнөөдөр 12 сая тонныг олборлоод экспортолчихсон байна.

Сүүлийн үед олборлолт тодорхой хэмжээгээр буурсан. Өнгөрсөн 2025 онд Монгол Улсын хэмжээнд нийтдээ 518 сая тонн газрын тос импортолж, экспортолсон байна. Үндсэн гол шалтгаан 1991 оны Газрын тосны тухай хуулиар байгуулагдсан Бүтээгдэхүүн хуваах гэрээнүүд өнөөдөр үйлчилж, хүчин төгөлдөр үйлчилж байгаа хууль тогтоомжтой нийцэхгүй. Нийгмийн даатгал, хүн амын орлогын албан татвар, нөөц ашигласны төлбөр гэх мэтчилэн тухайн үед бүтээгдэхүүн хуваах гэрээн дээр Монгол Улсын ЗГ-т ногдох хувь хэмжээнд орсон байгаа гэдэг байдлаар гэрээлэгдсэн байдаг. Гэрээний дагуу уг татварууд Монгол Улсын ЗГ-т ногдох хувь хэмжээнд байгаа гэж тооцогдох ёстой байдаг. Гэтэл хууль тогтоомжийн өөрчлөлттэй холбоотой маш их хэмжээний татварт тавигдсан актууд мөнгө тавигдсан, нөөц

ашигласны төлбөр гээд тавигдсан нэлээдгүй асуудлууд боссон учраас уг асуудлыг шийдвэрлэсний дараа бид тухайн ордууд дээр хөрөнгө оруулалт хийж, тосны олборлолтын хэмжээг нэмэгдүүлнэ. Мөн нэмэлтээр хайгуулын талбай ашиглаж нөөцийг, хайгуулын талбай дээр бүтээгдэхүүн хуваах гэрээ байгуулж нөөцийг нэмэгдүүлэх боломжтой гэдэг байдлаар Хятадын талаас мэдэгдээд ажиллаж байна. Сүүлийн 4 жилийн хугацаанд тухайн талбай дээр хөрөнгө оруулалт огт байхгүй болсон, үйл ажиллагаагаа тогтмол явуулах төдий хэмжээний хөрөнгө оруулалт л хийгддэг. Жилд нэг 20-оос 40 сая долларын хөрөнгө оруулалт хийгээд явж байгаа. Бодит байдал дээр газрын тосны ордыг ашиглах, хөгжүүлэх нь тогтмол асар их хэмжээний хөрөнгө оруулалтууд, нэмэлт өрөмдлөгийн ажлууд шаардлагатай байдаг. Өмнө нь 100-аас 200 сая долларын хөрөнгө оруулалтууд жил болгон хийгдээд явж байсан.

Хайгуулын хувьд Монгол Улсын хэмжээнд газрын тосны бүтээгдэхүүн авах гэрээтэй хайгуулын 11 талбай байна. Нүүрсний давхаргын бүтээгдэхүүн хуваах гэрээтэй хайгуулын 7 талбай байна. Хамгийн сүүлд газрын тосны хайгуулын Галба 11 талбай дээр Өлгий ордын газрын тосны баялгийн үнэлгээ, нөөцийн тооцооны тайланг Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлөөр хэлэлцүүлсэн. Ашиглалтын баталгаат.../минут дуусав/

С.Бямбацогт: Туваан гишүүн тодруулъя.

Ц.Туваан: Бүсийн хөгжлийн санг гүйцээгээд хариулаад өгөөрэй, юугаараа ялгаатай вэ гээд. Тэгээд энэ дээр тэр маргаан дээрээ энэ чинь гаргалгаатай шүү дээ. Одоо тэр маргаанаа шийдээд, учир начраа олоод, хөрөнгө оруулалтаа нэмэгдүүлээд энэ газрын тос олборлолтоо нэмэгдүүлж байж, би хэлээд байна шүү дээ. Нөгөө 1.7 сая долларын хөрөнгө оруулалт чинь тэгээд газрын тосгүй, 1.7 тэрбум доллароор хийгдэж байгаа нөгөө газрын тос боловсруулах үйлдвэр маань хүнээр бол идэх юмгүй, хоолгүй, ходоод руу нь хийх зүйлгүй ингээд зогсчих вий гэдэг асуудал одоо хаалга тогшоод эхэлчихсэн шүү. Одоо энэ маргаан дээрээ ямар нэгэн гаргалгаа байна уу, бодсон, санасан юм байна уу? Энэ чинь гарцтай эд байхгүй юу. Тэгэхээр энийг яг ойрын хугацаанд төлөвлөсөн зүйл юу байна гэдэг ийм 2 асуулт дээр хариулт авъя?

С.Бямбацогт: 4 дүгээр микрофон, ажлын хэсэг хариулъя.

Ч.Хишигдалай: Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамны Газрын тосны бодлогын газар Хишигдалай. Петро Чайна Дачин Тамсаг болон Доншин Монгол газрын тос компаниудтай үүссэн Бүтээгдэхүүн хуваах гэрээтэй холбоотой маргааныг шийдвэрлэх ажлын хэсэг Ерөнхий сайдын захирамжаар 98 дугаар ажлын хэсэг гарсан байгаа. Уг ажлын хэсгийг Эдийн засаг, хөгжлийн сайд Ж.Энхбаяр ахалж байгаа. Ажлын хэсгийн хүрээнд асуудлыг ярилцаад, УИХ-ын тогтоол, хуулийн төсөл боловсруулаад ажиллаж байна. Ирэх долоо хоногт ЗГ-ын хуралдаанаар хэлэлцүүлэх, яаралтай горимоор өргөн барихаар төлөвлөөд ажиллаж байгаа. Тэгэхээр энэ асуудлыг бид ойрын хугацаанд шийдвэрлэж, газрын тосны салбарын хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх, олборлолтыг нэмэгдүүлэх чиглэлээр нэн яаралтай арга хэмжээ авах нь зайлшгүй нэн яаралтай шийдэх асуудлын нэг болсон байгаа.

С.Бямбацогт: Соронзонболд гишүүн нэмж хариулъя.

Л.Соронзонболд: Туваан гишүүн өөрөө яг Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайдаар ажиллаж байсан учраас нөхцөл байдлыг маш сайн ойлгож байгаа, таны тавьж байгаа асуултууд их зөв асуултууд байна. Тэгэхээр бид чинь бүгдээрээ бүсээс сонгогдсон. Зарим аймагт уул уурхайн ашигт малтмалын нөөц байна, газрын тосны нөөц байна, зарим аймагт байхгүй байна. Ашигт малтмалын нөөц ихтэй, газрын тосны нөөц ихтэй аймгууд нь илүү их орлого тодорхой хэмжээнд хуваарилагддаг. Гэтэл тийм бага нөөцтэй аймгуудад нь хуваарилагдаж байгаа орон нутгийн хөгжлийн сангийн дүн бага байгаа. Хэдийгээр орон нутгийн хөгжлийн нэгдсэн сан маань бүсчилсэн хөгжлийг хангахыг чиглэсэн зориулалттай боловч яг тэр чиглэлээр зарцуулж байгаа гүйцэтгэл ерөөсөө байхгүй байгаад байгаа юм 1 дүгээрт.

2 дугаарт болохоор 2023 оны 3Г-ын тогтоолоор баталсан энэ орон нутгийн нэгдсэн хөгжлийн сан болон орон нутгийн хөгжлийн сангаас олгох шилжүүлгийн аргачлал гээд байгаа. Энэ дээр яг бүс рүү хуваарилж байгаа чиглэл ерөөсөө байхгүй. Зөвхөн тухайн.../минут дуусав/

С.Бямбацогт: Гүйцээгээд хариулчихъя. Соронзонболд гишүүн.

Л.Соронзонболд: Тэгэхээр энэ аргачлалыг харахаар ерөнхийдөө орон нутгийн хөгжлийн индекс гээд, тэгээд тухайн аймгийн хүн ам, газар нутгийн хэмжээ, дээрээс нь уул уурхайн нөлөөлөлд орж байгаа ашиглагдаж байгаа талбайн хэмжээ гэсэн ийм үзүүлэлтүүдийг тооцож байгаад ерөнхийдөө орон нутгийн хөгжлийн санг хуваарилж байгаа.

Харин АМНАТ, газрын тосны нөөц ашигласны төлбөр чинь тухайн нөлөөлөлд өртөж байгаа аймгуудад л илүү орон нутгийн хөгжлийн сангаас хуваарилагдаж байгаа нэг ийм дүр зурагтай байгаад байгаа учраас энэ бүсийн хөгжлийн сангийн саналыг оруулж ирсэн юм. Гэхдээ үнэхээр гишүүд хэлэлцэх эсэхийг дэмжээд, энэ Ашигт малтмалын тухай хууль бас давхар хэлэлцэгдэж байгаа. Ерөнхий санаа нь адилхан учраас энийг бүсийн хөгжлийн санг заавал тусад нь байгуулахгүйгээр орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангийн тэр аргачлал дотор тодорхой хэмжээний өөрчлөлт оруулах байдлаар шийдвэрлэх боломж байна л гэж харж байгаа. Нээлттэй байгаа гэж.

С.Бямбацогт: Даваахүүгийн Пүрэвдаваа гишүүн алга байна. Гишүүд хуулийн төслийн үзэл баримтлалтай холбогдуулж асуух асуулт асууж дууслаа. АН-ын бүлэг Тэмүүжин гишүүнд үг өгье.

Х.Тэмүүжин: АН-ын бүлэг хэлэлцэж байгаа асуудлаас 16 цагийн завсарлага авч байна.

С.Бямбацогт: Энэ асуудлаас уу?

Х.Тэмүүжин: Энэ асуудлаас.

С.Бямбацогт: 16 цагийн завсарлага өглөө.

Дараагийн асуудалдаа оръё. Алдаржавхлан гишүүн байна уу? Чөлөө авсан, хүндэтгэн үзэх шалтгаантай энэ асуудлыг хойшлууллаа. Хууль санаачлагч эзгүй тул дараагийн хуралдаан хүртэл хойшлууллаа. Дараагийн асуудал.

Долоо.Монгол Улсын Их Хурлын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл /Улсын Их Хурлын гишүүн М.Энхцэцэг нарын 70 гишүүн 2026.05.27-ны өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/

Монгол УИХ-ын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл хэлэлцэх хэлэлцүүлэг явуулна. Хууль санаачлагчийн илтгэлийг УИХ-ын гишүүн Мөнхчулууны Энхцэцэг танилцуулна. Таныг индэрт урьж байна. Тэмүүжин гишүүн АН-ын бүлэг.

Х.Тэмүүжин: Монгол УИХ-ын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг энэ хэлэлцэж байгаа асуудал дээрээс АН 1 цагийн завсарлага авч байна.

С.Бямбацогт: 1 цагийн завсарлага авлаа, энийг хойшлууллаа.

Найм.Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл /Үндсэн хуулийн цэцийн 2026 оны 04 дүгээр дүгнэлтийг хүлээн зөвшөөрсөнтэй холбогдуулан боловсруулсан, анхны хэлэлцүүлэг/

Дараагийн асуудалд оръё. Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг явуулна. АН-ын бүлэг Тэмүүжин гишүүн.

Х.Тэмүүжин: УИХ-ын энэ хэлэлцэж байгаа асуудал дээр мөн адил АН-ын бүлэг 1 цагийн завсарлага авч байна.

С.Бямбацогт: 1 цагийн завсарлага өглөө. Дараагийн асуудалдаа оръё.

Ес.Хүнсний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Улсын Их Хурлын гишүүн М.Мандхай нарын 10 гишүүн 2025.06.19-ний өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/

Хүнсний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн анхны хэлэлцүүлгийг явуулна. Төслүүдийн анхны хэлэлцүүлэг явуулсан талаарх БОХХАА-н байнгын хорооны санал, дүгнэлтийг УИХ-ын гишүүн Тогтмолын Мөнхсайхан танилцуулна. АН-ын бүлэг Тэмүүжин гишүүн.

Х.Тэмүүжин: УИХ-ын хэлэлцэж байгаа 10 дахь асуудал болох Хүнсний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл дээр АН-ын бүлэг 1 цагийн завсарлага авч байна.

С.Бямбацогт: 1 цагийн завсарлага өглөө. 1 цагийн завсарлага шүү, тэгээд цагийн дараа хуралдана шүү, гишүүдээ. Өнөөдөр хэлэлцэх асуудлаа дуусгана. Дараагийн асуудалд оръё.

Арав.Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Улсын Их Хурлын гишүүн О.Амгаланбаатар нарын 17 гишүүн 2026.05.29-ний өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх, үргэлжилнэ/

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг хэлэлцэх эсэх хэлэлцүүлэг үргэлжлүүлнэ. Хэлэлцэж байгаа асуудалтай холбогдуулан УИХ дахь МАН-ын бүлэг 5 өдрийн завсарлага авсан. Бүлгийн дарга үг хэлэх эсэхийг асуух бүлгийн удирдлагууд байхгүй байна. Хууль санаачлагчийн илтгэлийг УИХ-ын гишүүн Очирбатын Амгаланбаатар танилцуулна. Индэрт урьж байна.

О.Амгаланбаатар: Эрхэм УИХ-ын дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Үндсэн хуулийн 58 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт аймаг, нийслэл, сум, дүүрэг хуулиар тусгайлан олгогдсон чиг үүрэг, өөрийн удирдлага бүхий засаг захиргаа, нутаг дэвсгэр, эдийн засаг, нийгмийн цогцолбор мөн гэсэн заалт байгаа. 59 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн удирдлага нь нутгийн өөрөө удирдах ёсыг төрийн удирдлагатай хослуулах үндсэн дээр хэрэгжинэ. 61 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт Засаг дарга тухайн хурлын шийдвэрийг хэрэгжүүлэхийн хамт Засаг төрийн төлөөлөгчийн хувьд харьяа нутаг дэвсгэртээ хууль тогтоомж, ЗГ, харьяалах дээд шатныхаа байгууллагын шийдвэрийн гүйцэтгэлийг хангах ажлыг ЗГ, дээд шатны Засаг даргын өмнө хариуцна. 62 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт нутгийн өөрөө удирдах байгууллага тухайн аймаг, нийслэл, сум, дүүрэг, баг, хорооны нутаг дэвсгэрийн хэмжээний эдийн засаг, нийгмийн амьдралын асуудлыг бие дааж шийдвэрлэхийн хамт улс, дээд шатны нэгжийн чанартай асуудлыг шийдвэрлэхэд хүн амыг зохион байгуулж оролцуулна гэсэн байдаг. 62 дугаар зүйлийн 3 дахь хэсэгт УИХ, ЗГ-аас шаардлагатай хэмээн үзсэн тохиолдолд өөрийн бүрэн эрхэд хамаарах зарим асуудлыг шийдвэрлүүлэхээр аймаг, нийслэлийн Хурал, Засаг даргад шилжүүлж болно гэж тус тус заасан.

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн шинэчилсэн найруулга 2020 онд хийгдсэн бөгөөд уг шинэчилсэн найруулгаар засаг захиргааны нэгж, нутгийн удирдлагын чиг үүргийг тодорхойлж, улмаар чиг үүргийг давхардалгүй, хийдэлгүй тодорхойлсны дээр нутгийн удирдлагын чиг үүргээс гадна төрийн зарим чиг үүргийг төлөөлүүлэн гүйцэтгүүлэхээр мөн хуульд тодорхой зааж өгсөн байдаг. Иймд орон нутаг дахь хуульд заасан чиг үүргээ хэрэгжүүлэх, улмаар Засаг дарга тухайн хурлын шийдвэрийг хэрэгжүүлэхийн хамт Засаг төрийн төлөөлөгчийн хувьд харьяа нутаг дэвсгэртээ хууль тогтоомж, ЗГ, харьяалах дээд шатныхаа байгууллагын шийдвэрийн гүйцэтгэлийг хангах ажлыг ЗГ, дээд шатны Засаг даргын өмнө хариуцах хүрээнд өөрийн эрхлэх асуудлын хүрээний агентлагуудыг удирдлагаар хангах, тэдний ажлын хариуцлагыг ч гэсэн мөн өөрөө давхар хариуцуулахаар хуульчлагдсан.

Иймээс харьяа нутаг дэвсгэртээ төрийн чиг үүргийг төлөөлүүлэн хэрэгжүүлэх хүрээнд Засаг дарга нь засаг төрийн төлөөлөгчийн хувьд өөрийн эрхлэх асуудлын хүрээний агентлагийн удирдлагыг томилж, чөлөөлөх, хариуцлага тооцох, ажлын төлөвлөлт, түүний гүйцэтгэлд хяналт тавих, чадварлаг төрийн албан хаагчийг

сонгон шалгаруулах, урьж ажиллуулах зэргээр удирдлага, зохион байгуулалтын эрхийг нь мөн шилжүүлж өгөх шаардлага үүсэж байгаа болно. Төрийн зарим чиг үүргийг төлөөлүүлэн гүйцэтгүүлэх чиг үүргийн хүрээнд төрийн захиргааны төв болон төрийн захиргааны байгууллагын бодлого хэрэгжүүлэх төрийн үйлчилгээ, аж ахуйн талаарх чиг үүргийг орон нутагт хэрэгжүүлдэг агентлагуудын удирдлагын томилгоог орон нутаг, Засаг даргад шилжүүлэх боломжтой гэж үзэж байна.

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 27 дугаар зүйлд нэгжийн удирдлагаар төлөөлүүлэн гүйцэтгүүлэх төрийн чиг үүрэгтэй холбоотой харилцааг тусгайлан зохицуулахаар тусгаж, 27 дугаар зүйлийн 27.5-д засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн удирдлагаар дараах төрийн чиг үүргийг төлөөлөн гүйцэтгүүлнэ гэж холбогдох чиг үүргүүдийг жагсааж өгсөн байдаг. Үүнд, Монгол Улсын ЗГ-ын 2025 оны 1 дүгээр сарын 29-ний өдрийн аймгийн ЗДТГ-ын бүтэц, орон тооны хязгаарыг шинэчлэн тогтоох тухай 37 дугаар тогтоолоор аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний 26 газар, хэлтсийг тогтоож өгснөөс өнөөдрийн байдлаар 8 газар, хэлтсийн удирдлагыг аймгийн Засаг дарга томилж, чөлөөлөх эрхтэй байгаа нь 1 дүгээрт, Үндсэн хуульд заасан орон нутаг нь эдийн засаг, нийгмийн цогцолбор мөн байх асуудал, 2 дугаарт, Засаг дарга нь харьяа нутаг дэвсгэртээ хууль тогтоомж, ЗГ, харьяалах дээд шатныхаа байгууллагын шийдвэрийн гүйцэтгэлийг хангах ажлыг ЗГ, дээд шатны Засаг даргын өмнө хариуцна гэсэн Үндсэн хуулийн зарчим хангагдахгүй нөхцөлд байна.

Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний агентлагуудын удирдлагыг томилж, чөлөөлөх асуудлыг тухайн салбарын хуулиудад төрийн захиргааны төв байгууллагаас томилуулахаар тусгасан нь Засаг дарга хууль тогтоомж, дээд шатны байгууллагын шийдвэрийг харьяа нутаг дэвсгэртээ хэрэгжүүлж, Үндсэн хуулиар олгогдсон чиг үүргийн хүрээнд шийдвэрийн гүйцэтгэлийг хангаж ажиллах нөхцөл бүрэн олгогдохгүй байна гэж үзэж байна. Иймээс Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуульд Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний зарим агентлагийн удирдлагыг Засаг дарга томилж, чөлөөлдөг байх зохицуулалтыг тусгах, мөн орон нутагт хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах төрийн чиг үүргийг хэрэгжүүлж буй Боловсролын газар, Хүүхэд, гэр бүл, хөгжил, хамгааллын газар, Мал эмнэлгийн газар, Хөдөлмөр, халамж, үйлчилгээний газар, Соёл, урлаг, аялал жуулчлал, залуучуудын газар, Цахим хөгжлийн хэлтэс, Биеийн тамир, спортын газар гэсэн аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний 7 газар, хэлтсийн удирдлагуудыг томилох, чөлөөлөх эрхийг Засаг даргад олгох асуудлыг салбарын хуулиудад зааж өгөх зохицуулалтыг энэхүү хуулийн нэмэлт, өөрчлөлтийн төсөлтэй хамт өргөн мэдүүлэх хуулийн төслүүдэд тус тус тусгалаа.

Аймаг, НИТХ-ын дарга, Засаг даргаар ажиллаж байсан УИХ-ын гишүүд санаачлан хуулийн төслийн үзэл баримтлалыг УИХ дахь намын бүлэг, бүлгийн гишүүдэд танилцуулж, улмаар УИХ-ын гишүүд хамтран ажиллаж олон нийт, орон нутгийн засаг захиргааны нэгжийн удирдлагуудын хүрээнд хэд хэдэн удаагийн хэлэлцүүлэг, уулзалт зохион байгуулж ажиллалаа. Иймд Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжиж өгнө үү. Анхаарал хандуулсанд баярлалаа.

С.Бямбацогт: Амгаланбаатар гишүүнд баярлалаа. Төслүүдийн талаарх ТББХ-ны санал, дүгнэлтийг УИХ-ын гишүүн Жудагийн Баярмаа танилцуулна.

Ж.Баярмаа: УИХ-ын дарга, эрхэм гишүүд ээ,

УИХ-ын гишүүн О.Амгаланбаатар нарын 17 гишүүн 2026 оны 5 дугаар сарын 29-ний өдөр УИХ-д өргөн мэдүүлсэн Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн хэлэлцэх эсэх хэлэлцүүлгийг ТББХ 2026 оны 6 дугаар сарын 2-ны өдрийн хуралдаанаараа явууллаа.

Хууль санаачлагч орон нутаг хуульд заасан чиг үүргээ хэрэгжүүлэх, улмаар Засаг дарга тухайн хурлын шийдвэрийг хэрэгжүүлэхийн хамт засаг төрийн төлөөлөгчийн хувьд харьяа нутаг дэвсгэртээ хууль тогтоомж, ЗГ, харьяалах дээд шатныхаа байгууллагын шийдвэр гүйцэтгэлийг хангах ажлыг ЗГ, дээд шатны Засаг даргын өмнө хариуцах хүрээнд өөрийн эрхлэх асуудлын хүрээний агентлагуудыг удирдлагаар хангах, тэдний ажлын хариуцлагыг ч мөн өөрөө давхар хариуцахаар хуульчлагдсан учир харьяа нутаг дэвсгэртээ төрийн чиг үүргийг төлөөлөн хэрэгжүүлэх хүрээнд Засаг дарга нь өөрийн эрхлэх асуудлын хүрээний агентлагийн удирдлагыг томилж, чөлөөлөх, хариуцлага тооцох, ажлын төлөвлөлт, түүний гүйцэтгэлд хяналт тавих, чадварлаг төрийн албан хаагчийг сонгон шалгаруулах, урьж ажиллуулах зэргээр удирдлага, зохион байгуулалтын эрхийг нь мөн шилжүүлж өгөх шаардлагатай гэж үзэж, хуулийн төслийг боловсруулсан байна.

Хуулийн төсөлд иргэдийн оролцоог хангах, санал авах зорилгоор УИХ-ын d.parliament.mn цахим сайтад байршуулсан болно.

Байнгын хорооны хуралдаанаар хуулийн төслийг хэлэлцэх үед УИХ-ын гишүүн Ц.Туваан төрийн захиргааны төв байгууллагаас томилдог болж өөрчлөгдсөн албан тушаалуудын талаар, УИХ-ын гишүүн Баярбаатар хуулийн төсөлд ЗГ-аас санал авсан эсэх талаар, УИХ-ын гишүүн Ариунзаяа хуулийн төслийн талаарх ЗГ-ын байр суурийн талаар болон 2025 оны 11 дүгээр сарын 27-ны өдөр өргөн мэдүүлсэн Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлд 17 байгууллага тусгагдсан байсныг энэ хуулийн төсөлд 7 болгосон шалтгааны талаар асуулт асууж хариулт авсан болно.

Байнгын хорооны хуралдаанаар хуулийн төслийг хэлэлцэх үед УИХ-ын гишүүн Зулпхар орон нутгийн томилгоо хэт өргөн байх нь оновчтой бус, хууль сахиулах зэрэг зарим байгууллагын томилгоог орон нутаг хийх нь зохисгүй талаар болон хуулийн төсөлд тусгагдсан зарим байгууллагын хувьд ажлын хэсэг дээр нарийвчлан ярилцах шаардлагатай талаар, УИХ-ын гишүүн Гантөмөр сүүлийн арваад жил томилгоог төвлөрүүлж ирсэн нь орон нутгийн бие даасан байдлыг алдагдуулж байгаа талаар, Үндсэн хуульд тусгай бүлэг болж тусгагдсан засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын асуудлыг улс төржихгүй шийдэх нь зүйтэй, Цагдаагийн байгууллагын томилгоог уг хуулийн төсөлд тусгах шаардлагатай талаар үг хэлсэн болно.

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн олонх үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжсэн болно.

УИХ-ын эрхэм гишүүд ээ, Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн Боловсролын ерөнхий хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл, Хүүхэд хамгааллын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл, Мал, амьтны эрүүл мэндийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл, Нийгмийн халамжийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл, Соёлын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл, Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл, Биеийн тамир, спортын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн хэлэлцэх эсэх хэлэлцүүлгийг явуулсан талаар ТББХ-ны санал, дүгнэлтийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг та бүхнээс хүсье.

С.Бямбацогт: Баярмаа гишүүнд баярлалаа. УИХ-ын гишүүд Байнгын хорооны санал, дүгнэлт, хууль санаачлагчийн илтгэл болон хуулийн төслийн үзэл баримтлалтай холбогдуулан урьдчилан ирүүлсэн нэрсийн дагуу асуулт асууна. Батын Батбаатар гишүүн алга байна. Сайнхүүгийн Ганбаатар гишүүн алга байна. Сархадын Зулпхар гишүүн алга байна. Одонгийн Цогтгэрэл гишүүн алга байна. Болдын Уянга гишүүн алга байна. Бадарчийн Хэрлэн гишүүн алга байна. Хассуурийн Хэрлэн гишүүн алга байна. Даваахүүгийн Пүрэвдаваа гишүүн алга байна. Дашцэрэнгийн Энхтүвшин гишүүн асуултаа асууя.

Д.Энхтүвшин: Нутгийн өөрөө удирдах ёс, орон нутгийн удирдлага энэ харилцааг сайжруулах зайлшгүй шаардлага байгаа. Чадавхжуулах эдийн засгийн хувьд ч гэсэн, хүн хүчний хувьд ч гэсэн ийм шаардлага байгаа, энэ Үндсэн хуулийн үзэл баримтлалыг амилуулах, өнгөрсөн жилүүдэд төвөөс удирддаг, төвөөс чиглэл хүлээдэг иймэрхүү хандлага байгаад байгаа. Энэ дээр яах вэ орж ирсэн хуулийн төсөл дээр томилно гэдэг чинь өөрөө чөлөөлөх дур зорго гэх юм уу, эрхийг хамтатгадаг. Тэгэхээр энэ 7 томилох эрхийн 4 нь болохоор томилох, хуульд заасны дагуу чөлөөлнө гэж байгаа юм, 3 нь болохоор зүгээр шууд томилж, чөлөөлнө. Тэгэхээр бага улс төржүүлэхийн тулд яг ямар нэгэн хуулийн зүйл, заалтгүйгээр шууд чөлөөлнө гэдэг энэ 3 заалт, ялангуяа энэ зүйл, заалтууд нийгмийн халамжийн үйлчилгээний байгууллагын даргыг томилох, цахим хөгжил, харилцаа холбооны орон нутаг дахь газар, хэлтийн дарга, биеийн тамир, спортын байгууллагын дарга гэх мэтчилэн эд нарыг болохоор ямар нэгэн хуульд заасан ч юм уу гэж юм байхгүй, зүгээр л шууд томилж, чөлөөлнө гээд заачихсан юм байна.

Тэгэхээр энийг хууль санаачлагч бусадтай нь адилхан хуульд заасны дагуу гэсэн байдлаар өөрчлөн найруулбал илүү бодитой гэх юм уу даа, шууд дур зоргоороо хүн чөлөөлдөг, улс төрийн томилгоо болохгүй байх бас ийм эрсдэлийг хаах зүйл, заалт болох юм уу гэж бодож байна. Тэгээд энэ талаар хууль санаачлагчаас асууя. Чөлөөлөх тэр зүгээр хууль ёсны дагуу биш, зүгээр чөлөөлнө гэсэн 3 заалтыг бусад 4 заалттай нь адилхан хуульд заасны дагуу чөлөөлөх гэдэг байдлаар өөрчлөн найруулбал хэлэлцүүлгийн явцад энэ талаар хууль санаачлагчаас асуулт байна?

С.Бямбацогт: Очирбатын Амгаланбаатар гишүүн, хууль санаачлагч хариулъя.

О.Амгаланбаатар: Асуултыг хариулъя. Саяын Энхтүвшин гишүүний саналыг хэлэлцүүлгийн явцад яг хуульд нийцүүлээд засах боломжтой, тэгээд засаад явъя.

С.Бямбацогт: Товчхон, тодорхой хариулчихлаа. Сархадын Зулпхар гишүүн асуултаа асууя.

С.Зулпхар: УИХ-ын дарга, эрхэм гишүүдийн оройн амгаланг айлтгая. Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай асуудал өөрөө их тийм байнга тодорхой эрсдэлтэй тулгарч байдаг нэг ийм харилцаа байгаа юм. Гэхдээ энэ өөрөө мэдээж хэрэг эрх мэдлийг зохих түвшинд орон нутгийн эрх бүхий байгууллагуудад, орон нутгийн захиргааны байгууллагад шилжүүлэх энэ асуудал, энэ туршлага өөрөө байнга яригдаж байгаа, зохих түвшинд бид туршсан, заримдаа сорилтууд гарсан. Цаашдаа ч гэсэн шилжүүлэх ёстой.

Захиргааны эрх мэдлийг шилжүүлэх ажлууд хийгддэг, санхүүгийн эрх мэдлийг шилжүүлэх ажил хийгддэг. Томилгооны эрх мэдлүүд ч гэсэн шилжих тохиолдол байдаг. Гэхдээ энэ өөрөө заримдаа тогтолцооны хувьд эрсдэл дагуулдаг. Бид нарийн бодож байж, хэлэлцэж байж зөв шийдвэр гаргахгүй бол гэсэн үг шүү дээ. Энэ талаас нь би 1 дүгээр асуулт асууж байгаа юм. Ер нь яг бид саяын тодорхой төрийн байгууллагуудыг сонгочихсон байна шүү дээ. Энэ сонгохдоо нутгийн өөрөө удирдах байгууллага биш, нутгийн захиргааны байгууллагын гол жишээ нь эрх мэдэл хэрэгжүүлэх субъект болсон Засаг даргын хувьд хамаарах чиг үүрэгтэй нь уялдсан байна уу гэдэг талаар шинжилгээ хийгдсэн байна уу гэсэн 1 дүгээр асуулт гарчхаж байгаа юм, энэ нэг дэх нь?

2 дахь нь, та бүхэн мэдэж байгаа байх, зарим байгууллагуудын тухайд боловсролын бодлого нэгдмэл байдаг. Орон нутагт өгч үзсэн, буцаагаад авсан, авсан шалтгаан нь ер нь боловсрол өөрөө хүний хөгжлийн суурь учраас үүнийгээ бид нэгдмэл удирдлагаар хангая, орон нутаг зохих түвшинд оролцоод явъя гэсэн ийм шийдвэр гарч байсан. Энэ асуудлыг харгалзсан уу гэдэг нэг ийм 2 дахь асуудал байна?

Халамжтай холбоотой зүйл дээр ахиж асуумаар байгаа юм. Халамж өөрөө сан юм. Нийгмийн даатгалын сан гэдэг шиг нэгдмэл удирдлагатай байж, хяналттай байж гарч болох янз янзын эрсдэлийг даван туулдаг юм л даа. Тэгэхээр энэ асуудлыг та бүхэн харгалзаж үзсэн үү, судалсан уу гэдэг нэг ийм асуулт байна?

4 дэх асуудал энэ хүүхэд хамгааллын байгууллагын даргыг Засаг дарга томилъё гээд. Яг одоо байгаа тогтолцоогоор чинь хүүхдийн эрх хамгааллын асуудал Ерөнхий сайдын бүр үндэсний хэмжээнд удирддаг тухайлсан зохион байгуулалт байж байгаа шүү дээ. Хүүхэд хамгааллын асуудал хүүхдийн эрх бол онцгой эрх учраас Ерөнхий сайд өөрөө хариуцдаг. Тэрнээс гадна орон нутагт яах вэ, орон нутгийн Засаг дарга орон нутаг дахь хүүхдийн эрхийн тодорхой бүтэц бүхий зөвлөлийг даргалдаг ийм хэлбэр байгаа юм. Тэгэхээр энийг та бүхэн судалж үзсэн үү? Энийг нэлээн ярьж байж нэгдсэн удирдлагатай болгоод удаагүй байгаа ийм нөхцөл байгаа, энийг танаас тодруулж байна?

С.Бямбацогт: Батсуурь гишүүн, хууль санаачлагч хариулъя.

Ж.Батсуурь: Бүгдэд нь оройн мэнд хүргэе. Тэгэхээр Монгол Улс 1992 онд ардчилсан Үндсэн хуулиа баталснаас батлаад, тэгээд төрөө сонгодог сонгуулийн ардчилал бий болоод 9 удаагийн сонгууль явсан. Үндсэн хуулийн дараа орох Бага Үндсэн хууль ч гэж ярьдаг, Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж,

түүний удирдлагын тухай хууль гэж энэ том хууль таны хэлдгээр бүх нэгжийг хамарсан ийм хууль байгаа юм. Тэгээд энэ хууль анх байгуулагдахдаа батлагдсанаас хойш үүргээ маш онцгой биелүүлж, дунд ба анхан шатны төрийн үйл ажиллагаа чанартай явах, тэрийг хэрэгжүүлэх Үндсэн хуульд зааснаар засаг захиргаа, нутаг дэвсгэр, эдийн засаг, нийгмийн цогцолбор мөн гэсэн энэ агуулгаараа явж байсан юм.

Гэтэл он удаан жилд сайд нар дагасан хуулиудаар нэг нэгээр нь татаж авсаар байж байгаад орон нутагт байж байгаа 30 орчим агентлагийг үндсэнд нь бараг бүгдийг татаад ингээд төвлөрүүлэн удирдчихсан. Та яг одоо хэлж байна. Гэтэл яамны сайд хүн яам бол бодлого л гаргах ёстой. Таны хэлж байгаагаар боловсролын бодлогыг гаргах ёстой, хүүхдийн бодлогыг Ерөнхий сайдаар ахлуулсан гаргах ёстой, нийгмийн халамжийн бодлогоо гаргах ёстой. Гэтэл яг анхан шатанд тэр халамжаас гаргах, хүүхдийн асуудал бол ерөөсөө Засаг даргын, дунд шатны, аймгийн Засаг даргын, сумын Засаг даргын эрхлэх хүрээний үндсэн ажил байдаг юм. Гэтэл өнөөдөр бид бүхэн сайд нараа бараг олж, гишүүд нь олж уулзаж чадахгүй байх шахам байхад тухайн боловсролын асуудлыг, тэнд болж байгаа асуудлуудыг сайд шийднэ гэдэг дэндүү холдчихсон байгаа юм. Жишээ нь, боловсрол ярингуут боловсролын чанарын асуудал ярьдаг, чанар гэнгүүт багшийн асуудал ярьдаг.

Тэгвэл тухайн багшийг аймагт аваачих, сумд аваачихад тухайн Засаг дарга би танд 3 өрөө байр өгье, эсхүл ийм, ийм үйл ажиллагаа үзүүлэе, та манай математикийн асуудлыг, та манай англи хэлний асуудлыг ийм хэмжээнд хүргээч гэсэн энэ асуудал дунд шатанд Засаг дарга дээр л яригддаг. Би өөрөө олон жил Засаг дарга хийж байсан хүн. Гэтэл сайдаа олж, сайд тэр олон аймгуудын дунд шатны Засаг даргын өмнөөс тэр багш нарыг байршуулах, нийгмийн асуудлуудыг нь шийдэх, тэр хүүхдийн асуудлуудыг, тэр халамжийн асуудлуудыг сайд шийдэх боломж байхгүй. ЗГ, ЗГ-ын гишүүн, тухайн сайд бол бодлого л гаргаж ирнэ. Ямар халамж өгөх юм, ямар халамж нь зөв байгаа юм, ямар халамж нь буруу байгаа юм, хүүхдийн асуудал дээр тухайн ЗГ ямар бодлого хэрэгжүүлэх гэж байгаа юм, боловсролын асуудал дээр ямар тогтолцоо хэрэгжүүлэх гэж байгаа юм, 6 настай хүүхдээ яах гэж байгаа юм, 7 настай хүүхдээ яах гэж байгаа юм, бодлогыг л гаргах ёстой болохоос өөр аж ахуйн асуудал руу ороод, аймгийн дунд.../минут дуусав/

С.Бямбацогт: Батсуурь гишүүн нэмж, гүйцээж хариулъя.

Ж.Батсуурь: Ингээд тэр томилгоонд ороод ингээд явчихдаг. Ингээд тухайн сургуулийг энэ маань л сайн удирдаж чадах юм даа гээд нутгийн хүмүүс мэдэж байхад огт өөр хүн дээрээс томилгоогоор хүрээд ирдэг. Энэ нь доошоо томилгоонууд хийгээд, ингээд ард иргэдээсээ бодлого нь холдчих энэ нөхцөл байдал үүсээд байгаа юм. Тэгэхээр энийг одоо нэг засаж авахгүй бол үндсэндээ цэрэг, цагдаа, тагнуул гэдэг юм уу, татвар гэдэг юм уу энэ асуудлуудыг ойлгож байна. Бусад асуудлууд хэвтээ удирдлагатай байж, энэ төвлөрөл чинь саарах, энэ Улаанбаатарт болоод байгаа асуудал чинь нутгийн өөрөө удирдах ёсны чадавх сайжирснаар, тэнд байгаа Засаг даргын Үндсэн хуулиар олгогдсон эрхийг нь олгосноороо л энэ хуулийн өөрчлөлт ашиг тусаа өгнө гэж ингэж илэрхийлж байгаа юм.

С.Бямбацогт: Амгаланбаатар гишүүн нэмж хариулъя, хууль санаачлагч.

О.Амгаланбаатар: Зулпхар гишүүн энэ хуулийг Байнгын хороон дээр хэлэлцэхэд хэд хэдэн судалгааг үзээрэй гэсэн. Тэгээд Удирдлагын академийн нутгийн захиргааны байгууллагын бүтэц, зохион байгуулалтын шинжилгээг өмнө нь бид судалгаандаа тайланг нь нэг бүрчлэн үзсэн. Мөн Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн хэрэгцээ, шаардлагын урьдчилсан тандан судалгаа гээд 3, 4 байгууллагын Судлаач бодлогын төв, Өмгөөллийн OSD Partners гэх зэргээр ийм 3, 4 байгууллагын судалгааны тайланг бид авч үзсэн. Тэгээд энэ дээрээс цагдаагийн байгууллагын хэрэг бүртгэлт гэх зэргээр 10 гаруй байгууллагыг орон нутаг руу эрх мэдлийг, томилгооны болон захиргааны эрх мэдлийг шилжүүлэх нь боломжтой гэсэн ийм тайлан байна лээ, энэ тайлангууд дээр. Таны.../минут дуусав/

С.Бямбацогт: Нэмэлт минут.

О.Амгаланбаатар: Ийм хурдан гэж үү? Боловсролын байгууллагын хувьд үнэхээр орон нутгийн хувьд бүх томилгоо нь босоо болчихсон байгаа одоогоор сургууль, цэцэрлэг гээд. Гэтэл орон нутагтаа хүүхдийн байгууллагын, хүүхдийн хариуцсан дарга нь аймгийн Засаг дарга байж байдаг. Иргэдийнхээ өмнө, төрийн өмнө, Ерөнхий сайдын өмнө гэж энэ хүүхэд хамгаалал, гэр бүл, мөн энэ боловсролын тал дээр үүрэг хүлээгээд гарын үсэг, гэрээ зурчихсан байж байдаг. Аймаг, орон нутаг, удирдлагын хувьд ингээд нэгдмэл байж чадахаа больчихсон. Улаанбаатар хотын утаа, түгжрэлийг арилгая, энэ төвлөрлийг саармагжуулъя гэдэг ийм зүйлийг аман дээрээ ярьдаг боловч ачир дээрээ төвлөрүүлж татсанаас болоод энэ бүх асуудлууд орон нутагт үнэхээр хэцүүдчихсэн. Хэний хүүхдийн сурлага сайн байна, муу байна, яаж анхаарах вэ гэдгийг хамгийн сайн мэддэг нь сум, аймгийн удирдлагууд, яг нэгж дээр гардан ажиллаж байгаа хүмүүс. Тэгээд яамнаас гарсан бодлогыг, төрөөс гарсан бодлогыг орон нутагт гардан хэрэгжүүлдэг хүмүүст нь энэ томилгооны эрх мэдлийг нь өгөх нь зөв гэж үзэж байгаа.

С.Бямбацогт: Зулпхар гишүүн тодруулж асууя.

С.Зулпхар: Баярлалаа. Бид яах вэ, хэлэлцээд л, мэтгэлцээд л тодорхой юмнуудаа яриад л явах ёстой, судалгаануудаа ярьж байгаа нь их сайн. Судалгаанууд үзэж байгаад талархалтай байна. Би нэг асуулт асуусан, яг нөгөө Засаг даргын өөрийнх нь чиг үүрэгтэй уялдсан байдлаар тэр томилгооны эрх мэдлийг юм уу, захиргааны эрх мэдлийг шилжүүлдэг юм шүү дээ. Тэр талаас нь одоо энэ сонгож авсан 7 байгууллага чинь тохирсон уу гэдэг энэ чиглэлээр та бүхэн ямар зүйл судалсан юм бэ гэдэг ийм асуудал байна.

2 дахь зүйл, энэ халамж яг сан шүү дээ. Халамж сан учраас нийгмийн даатгалын сантай адилхан сангийн удирдлага нь нэгдмэл байдаг нь энэний эрсдэлийг л бууруулах чухал зүйл юм, 72 тогтсон үйлчилгээтэй. Энд ямар нэгэн байдлаар хөндлөнгийн нөлөөлөл орох юм бол эцсийн дүндээ янз янзын нөхцөл байдлууд үүсэж байсан, тэрийг даван туулах гэсэн л практик нөхцөл байдал л даа. Тэгэхээр энэ дээр та бүхэн ямаршуу судалгаа хийсэн юм бэ? Боловсрол дан ганц анги танхимын асуудал биш, энэ хөтөлбөр байгаа юм. Тэгэхээр боловсролын хөтөлбөр нэгдмэл удирдлагатай байх үүднээс оруулсан юм.../минут дуусав/

С.Бямбацогт: Цэвэгдоржийн Туваан гишүүн. Тэмүүжин гишүүн, АН-ын бүлгийн түр яачихъя. АН-ын бүлэг.

Х.Тэмүүжин: Үндэсний хиймэл дагуул хөөргөх төслийн талаар авах зарим арга хэмжээний тухай тогтоолын төслийг энэний дараа хэлэлцэх байх. Тэрний дараа манай бүлгээс цагийн завсарлага авсан сэдвүүдтэй холбоотой бүлгийн завсарлага дууссан гээд мэдэгдэж байгаа.

С.Бямбацогт: Газрын тос, нэгмөсөн өнөөдөр хэлэлцэх асуудлаа дуусчихвал хойш нь тавиад байхгүй, 16 цаг гэхихсэн. Цэвэгдоржийн Туваан гишүүн.

Ц.Туваан: Энэ хуулийн төслийг дэмжиж байгаа. Яагаад вэ гэхээр энэ аймаг, сумд чинь бүгд л босоо болчихсон доо, бараг л энэ томилгоонууд. Бүр ард иргэд хүртэл ярьдаг байсан шүү дээ, Засаг дарга, засаатай мал 2 л дийлдэг юм гэж. Тэгсэн Засаг даргад одоо шийддэг асуудал гэж байхгүй болсон. Тухайн орон нутгийнхаа хил хязгаар дотор Монгол Улсад хэрэгжиж байгаа энэ бүх л 900-аад хууль, дүрэм бүгдийг нь ингээд хариуцдаг, тэгээд хариуцаад ингээд хийх тэртээ тэргүй хийх байтал нөгөө нэг цэргүүд нь тэнд үйл ажиллагаа явуулж байгаа цэргүүд нь Засаг дарга нарынхаа үгэнд орохоо больсон. Яагаад гэхээр тэд чинь томилохгүй байгаа, хүн томилдог дарга дээрээ ёсолдог. Тэгэхээр иймэрхүү байдлаас болоод энэ орон нутагт төрийн бодлого, яамдын бодлого, ЗГ-ын бодлого, УИХ-ын бодлогууд яг одоо хэрэгжихгүй байгаад байгаа юм. Хэрэгжих гэхээсээ илүү хэн намайг томилсон бэ, тэрэндээ үйлчилнэ гэдэг шиг ийм зүйлүүд яваад байгаа.

Маш олон агентлагуудыг бүгдийг нь босоо тогтолцоотой, босоо томилгоотой болгосноос үүдэж, Засаг даргын эрх мэдэл аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг дарга нарын тэр хууль хэрэгжүүлэх ажилд нь саад болж байгаа юм. Зарим хүн дээр ярьж байгаа Засаг дарга нар жишээлбэл, аймаг, дүүргийн Засаг дарга Ерөнхий сайд, ЗГ-ын сайд нартай жил болгон гэрээ байгуулдаг. Тэр гэрээнийхээ үеэр яамдын бодлогыг ойлгоод, хэрэгжүүлэх асуудал дээрээ чиглэлээ аваад, гэрээгээ байгуулаад явчихдаг. Аймгуудын Засаг дарга нар бүх сумдтайгаа бас гэрээ байгуулдаг. Бүгдийг нь цуглуулж байгаад энэ жил ийм бодлого хэрэгжинэ шүү, ингэнэ гээд. Тэгэхээр энэ дээр тэр ярих, заавал босоо болголгүйгээр энэ дээрээ асуудлаа яриад, гэрээ байгуулаад шийдээд явчхаж болох ийм зүйл байгаа юм. Тэгэхээр энэ хуулийг хэрэгжүүлээд аймаг, сумдын Засаг дарга нарыг шүдгүй арслан шиг биш, хууль хэрэгжүүлэх хэмжээнд томилгоотой албан тушаалтнуудтай, цэргүүдтэй болгох асуудал энэ дээр яригдаж байгаа учраас их чухал байгаа юм.

Энэ дээр 2 асуулт байна. Батсуурь гишүүн хууль санаачлагч, энэ нэмж томилох гэж байгаа байгууллагуудын нэрийг, хэдэн байгууллага байгаа юм гэдгийг хэлээд өгөөч? 2 дугаарт, аймаг, сумдын Засаг дарга нар дээр яг томилж байгаа нөгөө цөөхөн юм байгаа шүү дээ, 3, 4 л юм байгаа байх, тэд нарыг ийм томилгоонууд нь үлдээд, бусад нь байхгүй болсон гэдэг дээр тодорхой зүйл хэлээд өгөөч гэсэн асуулт байна?

С.Бямбацогт: Батсуурь гишүүн хариулах уу, хэн хариулах вэ? Амгаланбаатар гишүүн хариулъя, хууль санаачлагч. Батсуурь гишүүн хариулъя.

Ж.Батсуурь: Ер нь орон нутагт чинь яам, тамгын газрын харьяа салбар нэгж гээд 30 орчим агентлаг байдаг шүү дээ. Одоо орон нутагт 6 агентлаг л үлдээд байгаа юм, эрүүл мэнд, ХАА гэх мэт. Тэгээд бид энэ БТСГ, Боловсролын газар, Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын газар, Мал эмнэлгийн газар, Соёл, урлаг, аялал жуулчлал, залуучуудын газар, Хөдөлмөр, халамж, үйлчилгээний газар, Цахим хөгжлийн газар гэсэн энэ 7 газруудыг л нэмж өгөх нь зүйтэй гэж ярилцсан юм.

Жишээ нь, Мал эмнэлгийн газар гэж. Өнөөдөр хөдөөд шүлхий гардаг, мялзан гардаг, маш яаралтай зүйлүүд гардаг. Энэ босоо тогтолцоотой байх ямар ч шаардлага байхгүй. Үнэхээр Мал эмнэлгийн газар нь өөрөө бодлогоо энэ жил ямар вакцин хийх юм, хаанаас авах юм, яах юм, ийх юм, ер нь ХАА-н бодлого нь ямар байх юм гэдгээ л гаргаад өгнө үү гэхээс тэрийг аймаг, орон нутаг, анхан шатанд л хийх ёстой аж ахуйн ажлуудыг сайд нар дээшээ татаж аваад байгааг нь л хэлээд байгаа юм. Гэр бүлийн асуудал, ер нь хүн чинь дэргэдээ байгаа өрх гэрээ бий болгох, баг, бригадаа өсгөх, сум орноо ингээд аймаг гээд явдаг. Гэтэл би танай өрхийг мэднэ, танай гэр бүлийг мэднэ гээд сайдын хэмжээнд татаад авчихаар энэ бодлого анхан шатанд хэрэгжихгүй. Аливаа зүйл чинь орон нутаг чинь өөр говь, хангай гэж байна, хүйтэн, сэрүүн гэж байна, цагийн бүсчлэл байна. Энэ бүх зүйлийг анхан шатанд тохируулгаа хийх бүх боломж нь орон нутагтаа л байж байгаа юм.

Жишээлбэл, нийтийн биеийн тамирын газар эндээс гэнэт орон даяар зэрэг хөтөлбөр, төлөвлөгөө батлаад л очдог, дээд шатныхаа даргын өмнө хүлээхээс өөр арга байдаггүй. Тэгтэл тэнд бороотой байвал яах юм, цастай байвал яах юм, шавар шавхайтай байвал яах юм, ган зудтай байвал яах юм. Тэгвэл ийм хэмжээний ажлуудыг бид хийх ёстой юм гэдгийг нь л ерөнхий бодлогыг нь гаргаад өгчих юм бол энийг яг анхан шатандаа, дунд шатандаа хийх асуудлууд байж байгаа. Хөдөлмөр, халамж, үйлчилгээний асуудал байгаа. Хэн хөдөлмөр хийдэг вэ, хэн халамж авах ёстой вэ гэдгийг анхан шат, багийн даргаас авхуулаад сумын даргаас авхуулаад аймаг л мэднэ үү гэхээс зэрэг энд байгаа сайд бол тухайн орон нутгийн хэн халамж авч байгаа, авах ёстой вэ, хэн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаар дэмжлэг авах ёстой вэ гэдгийг огтоосоо мэдэхгүй.

Тийм учраас Хөдөлмөр, халамж, үйлчилгээний газар гэдэг юм уу, халамж хариуцсан яам нь Монгол Улсын хэмжээнд ер нь хөдөлмөрийн ийм бодлого явуулах гэж байгаа юм, халамжийн ийм бодлого явуулах гэж байгаа юм, үйлчилгээний ийм бодлого явуулах гэж байгаа юм гэдгээр л чиглэлийг нь өгөх л ийм асуудал яам дээр яригдах ёстой болохоос өөр аж ахуйн шинжтэй асуудлуудыг бүгдийг яам татаж авч байгаа болохоор энэ нь өөрөө төвлөрлийг улам нэмэгдүүлж байна. Төвлөрөл нэмэгдвэл өнөөдөр Улаанбаатарын.../минут дуусав/

С.Бямбацогт: Гишүүд асуулт асууж дууслаа. Одоо үг хэлэх гишүүд урьдчилан ирүүлсэн нэрсийн дагуу дэмжсэн, дэмжээгүй үгээ хэлнэ үү. Ганбаатар гишүүн алга байна. Бадарчийн Хэрлэн гишүүн. Сархадын Зулпхар гишүүн үгээ хэлье, 1 дүгээр индэр.

С.Зулпхар: Та бүхэнд оройн мэнд дэвшүүлье. Энэ хуулийг мэдээж санаачилж болно. Ийм хууль байж болно. Би Байнгын хороон дээр ч гэсэн ийм байр суурь илэрхийлсэн. Учир юу гэхээр яах вэ, бид тодорхой эрх мэдлийг, захиргааны, санхүүгийн, томилгооны эрх мэдлийг орон нутаг руу нь шилжүүлэх энэ асуудлыг үндсэндээ сүүлийн 30 гаран жил ярьж байгаа юм. Зохиох түвшинд хийсэн, зарим тохиолдолд сорилт гарсан, зарим зүйл дээр бид сорилтоосоо уялдсан, үүдсэн алдаанууд ч гэсэн гарсан. Тэгэхээр ийм хууль хэлэлцэж болно гэдгийг нэн түрүүнд хэлж байна.

Гэхдээ энэ асуудал өөрөө нарийн, ээдрээтэй зүйл. Тогтолцооны хувьд хэрвээ буруу шийдвэр гарах юм бол эрсдэл дагуулдаг нь үнэн. Тэр дагуулсан байдал нь манай тодорхой салбар дээр гарсан өнөөдрийн зарим үр дагаврууд гэдгийг хүлээн

зөвшөөрөх ёстой. Манай боловсролын энэ тогтолцоо ер нь асуудалтай байгаа шүү дээ. Тэгээд бид энийг зүгээр Засаг даргад даатгаад үлдээчих юм бол, боловсролын хөгжлийг өөрөө хариуцаарай, өөрөө мэдээрэй гэдэг энэ байж болохгүй зүйл гэдгийг бүгдээрээ мэдэж байгаа. Тэгэхээр боловсролын бодлого нэг байдаг шигээ зохицуулалт нь нэг байдаг ийм практикийг бид оновчтой юм байна гэж үзээд, энэ ахиад зохицуулалт хийсэн юм байгаа юм. Гэхдээ мэдээж хэрэг орон нутагт энэ үйл ажиллагаанд Засаг дарга дэмжиж оролцдог чиглэл бий, энийг бид заавал ярих ёстой.

Нөгөөтээгүүр, би энэ дээр зарим зүйлийг нь ярьж байна шүү дээ, халамжтай холбоотой асуудал дээр та бүхэн эргэж хараач гэж байгаа юм. Халамж өнөөдрийн байдлаар 7 байгууллагын 13 мэдээлэл дээр суурилсан байдлаар 72 үйлчилгээг нэгдмэл зохион байгуулалтаар өгдөг ийм үйлчилгээ болчихсон байгаа. Жишээ нь, Туваан гишүүн энийг сайн мэдэж байгаа, энэ чиглэлээр өөрөө ажиллаж байсан. Гэхдээ Засаг дарга нар маань сайн мэдэж байгаа. Тэгэхээр энэ халамжийн үйлчилгээ дотор бид Засаг даргын томилгоотой уялдсан байдлаар ямар нэгэн орон нутгийн нөлөөлөл орж эхлэх юм бол өнөөдрийг хүртэл бидний явж ирсэн тэр халамжийн хавтгайрсан, эсхүл халамж замбараагүй олгодог гэдэг ийм зөрчлүүд гардаг, гарсаар ирсэн. Энэ зөрчлийг бид өнгөрсөн хугацаанд шийдэх гэж оролдсон. Зарим асуудлыг нь саяын цахим болон мэдээллийг бүрэн байдлаар ашигладгаар шийдсэн, одоо харьцангуй гайгүй. Гэлээ гэх нь энийг нэгдмэл байх нь практик талаасаа зөв юм байна гэдгийг ОУБ-ын бидэнд өгсөн зөвлөмж ингэсэн учраас би энийг зориуд та бүхэнд дуулгаж байгаа юм. Та бүхэн энэ хуулийг хэлэлцэх явцад анхаараач гэж байгаа юм. Боловсрол, халамж 2 ийм үндэслэлтэй юм.

Хүүхдийн асуудал дээр үндэслэл бол саяын миний хэлсэнчлэн хүүхдийн эрх бидний хувьд онцгой эрх, үүнтэй уялдсан байдлаар Ерөнхий сайд өөрийнхөө дэргэд үндэсний зөвлөлийг ахалдаг. Орон нутагт, аймагт тодорхой аймгийн зөвлөлийг ахлуулаад энэ хүүхэд хамгааллын хөгжлийн асуудлыг хариуцуулдаг юм. Тэгэхээр энэ нэгдмэл байж, нэгдмэл удирдлагаар, гэхдээ орон нутгаа дэмжсэн байдлаар байна гэж. Одоогийн байгаа тогтолцоогоор санхүүгийн эрх мэдлүүд нь орон нутаг руу нь шууд хуваарилагдаад оччихсон байгаа юм байгууллагуудаа дагаад. Захиргааны зохион байгуулалт угаасаа мерит зарчимдаа суурилсан төрийн захиргааны албан хаагчдын энэ зохион байгуулалтаар явж байгаа. Тэгэхээр яг саяын 3 байгууллагын тухайд заавал даргыг нь Засаг дарга томилох нь тийм ач холбогдолтой зүйл биш.

Харин эсрэгээрээ дээрээс нь томилоод саяын удирдлагаа хэрэгжүүлбэл орон нутаг дахь үйлчилгээнүүд нь боловсролын, халамжийн, хүүхэд хамгааллын үйлчилгээ гэсэн үг шүү дээ. Энэ бол үр дүнтэй хүрэх, тэрнээс гадна уялдах боломж бол гарч байна. Би бусад тэр 4 байгууллагын тухайд та бүхний хэлсэн үндэслэлтэй санал нэг байна. Тэгэхээр энийг та бүхэн ажлын хэсэг гарах үедээ харгалзаач гэж байгаа юм. Хууль санаачлагчид энэ дээр тодорхой байр суурьтай байгаарай гэдгийг хэлж байна, баярлалаа.

С.Бямбацогт: Баярлалаа. Бадарчийн Хэрлэн гишүүн үг хэлнэ. Индрийн 1 дүгээр микрофон.

Б.Хэрлэн: Оройн мэнд хүргэе. Тэгэхээр Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуульд Амгаланбаатар нарын 17 гишүүн өөрчлөлт оруулах саналыг гаргасан байгаа. Тэгэхээр аймаг, нийслэл, дүүргийн

Засаг даргын бүрэн эрхийг зарим агентлагийн удирдлагыг томилох, чөлөөлөх эрх олгож, бүрэн эрхийг нь нэмэгдүүлэх ийм төслийг оруулж ирж байгаа. Өнөөдөр хуулиараа аймаг, дүүрэг, НЗД нийтдээ 26 үндсэн чиг үүргийг хэрэгжүүлж байгаа, агентлагуудыг хамаарч байдаг. Энэний долоогийнх нь удирдлагыг томилох, чөлөөлөх хуулиар олгогдсон ийм эрхийг эдэлж байгаа юм. Түүн дээрээ нэмээд 7 агентлагийн удирдлагыг томилох, чөлөөлөх эрхийг Засаг захиргааны нэгжийн тухай хуульд өөрчлөлт оруулах замаар, холбогдох хуулиудад өөрчлөлтийг оруулах замаар энэ эрхийг нэмэгдүүлэе гэж байна.

Тэгэхээр энэ эрэлхийллийг би өнөөдөр манайхны ярьдгаар босоо, хэвтээ тогтолцооны улмаас үүсээд байгаа зөрчлийг, шийдлийг хайж байгаа нэг хайгуул гэж би харж байгаа юм. Асуудлыг шийдэхийн төлөө явж байгааг нь би дэмжиж байгаа. Гэхдээ менежментийн шинжлэх ухаанаар энэ матрицын бүтэцтэй ийм тохиолдолд гардаг ийм зөрчил, маргааны асуудал байдаг. Миний бодож байгаагаар хэрвээ бид яг энэ байдлаар шийдвэл бид төрийн алба, төрийн захиргааны хүрээнд хийгдэж байгаа өөрчлөлтийн шинэчлэлийн 2 том зарчмын өөрчлөлтөөсөө бид ухарсан болно. 2008 онд Төрийн албаны тухай хуульд өөрчлөлт оруулж, төрийн албыг улс төрийн нөлөөллөөс ангид байлгах энэ зарчмыг нэвтрүүлсэн. Яагаад гэвэл сонгууль, сонгуулийн дараагаар төрийн албан хаагчид маш ихээр халагддаг, солигддог. Тэгэхээр энийг зохицуулахын тулд төрийн албыг улс төрөөс ангид байлгана гэж шийдвэрлэсэн байдаг.

Хэрвээ бид энийг хэрэгжүүлээд явах юм бол магадгүй сонгуулийн дараагаар хууль бус үндэслэл, хууль бус томилгоонууд, үндэслэлгүй ажил, албан тушаалаас нь халах зэрэг ийм асуудлуудыг магадгүй нэмэгдүүлж болзошгүй. Өөрөөр хэлбэл, төрийн албаа илүү улс төрийн нөлөөлөл рүү оруулах ийм талтай болно. Яагаад гэвэл Засаг дарга өөрөө улс төрийн албан тушаалтан. Намын гишүүдийг багаа бүрдүүлэх гэдэг санаагаар төрийн албанд оруулах, ингэснээрээ нөгөө бид чинь төрийн албаа мерит зарчмыг хэрэгжүүлээд тогтвортой, мэргэшсэн болгоё гэж бидний зорьж яваа энэ алхмаас бидэнд ухрахад хүргэж болзошгүй байгаа. Тэгэхээр энийг бид бодох ёстой.

2 дахь ямар төрийн захиргааны шинэчлэлээс шинэчлэлд маань өнөөдрийн энэ эрэл хайгуул тодорхой хэмжээний хүндрэлийг үүсгэж болох юм бэ гэхээр 2011 оноос эхлээд Монгол Улс үр дүнд чиглэсэн төрийн албыг бэхжүүлэхийн төлөө ажиллаж байгаа. Тэгэхээр төсөв хуваарилах, төсвийн зардлыг хуваарилах, боловсон хүчний шийдвэрийг гаргах, ялангуяа удирдах албан тушаалтныг томилох энэ шийдвэр төсвийн ерөнхийлөн захирагч буюу салбарын сайдуудад энэ эрх олгогдож байгаа. Хэрвээ өнөөдрийнх шиг ингээд ахиад 7, нийтдээ 14 агентлагийн удирдлагыг Засаг дарга нар томилдог болоод явчихвал өөрийг нь томилдог, чөлөөлдөг Засаг даргынхаа үгийг сонсох уу, төсөв хөрөнгийнх нь асуудлыг шийдээд төлөвлөгөө, зорилгыг нь тодорхойлоод байгаа салбарын сайдын үүрэг даалгаврыг сонсох уу гээд тэр хүний хувьд хоёрдмол байдал байсаар байх болно. Өөрөөр хэлбэл, өнөөдрийн дэвшүүлж байгаа энэ шийдэл менежментийн матрицын бүтцийн улмаас гарч ирдэг зөрчлийг шийдвэрлэх хамгийн оновчтой арга зам гэж би харахгүй байгаа. Арга замыг, энэ асуудлыг шийдэхийн төлөө явж байгааг би бүрэн дэмжиж байна. Энэ яах аргагүй шийдлээ хүлээсэн асуудал мөн. Гэхдээ үүн дээр бид илүү жаахан бодож, тунгааж яаж тогтвортой, мэргэшсэн төрийн албаа бэхжүүлэх вэ, яаж төрийн албыг үр дүнтэй.../минут дуусав/

С.Бямбацогт: Баярлалаа. Гишүүд үг хэлж дууслаа. Санал хураалтыг Баасан гарагийн нэгдсэн чуулганы хуралдаанаар явуулна.

21.20 цаг

Арван нэг. “Үндэсний хиймэл дагуул хөөргөх төслийн талаар авах зарим арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл

Дараагийн асуудалдаа оръё. Үндэсний хиймэл дагуул хөөргөх төслийн талаар авах зарим арга хэмжээний тухай УИХ-ын тогтоолын төслийг хэлэлцэнэ. Төслийн талаарх Эдийн засгийн байнгын хорооны санал, дүгнэлтийг УИХ-ын гишүүн Соронзонболд танилцуулъя.

Л.Соронзонболд: УИХ-ын дарга, эрхэм гишүүд ээ,

Эдийн засгийн байнгын хороо 2026 оны 6 дугаар сарын 3-ны өдрийн хуралдаанаараа Үндэсний хиймэл дагуул хөөргөх төслийн хүрээнд Монгол Улсад үр өгөөжтэй ашиглах боломжтой олон талт хэрэгцээ, шаардлагад нийцсэн хиймэл дагуулын асуудлаар Инновац, цахим бодлогын хөгжлийн дэд хорооны санал, дүгнэлт болон тус дэд хорооноос боловсруулсан УИХ-ын тогтоолын төслийг хэлэлцлээ.

Инновац, цахим бодлогын хөгжлийн дэд хорооны 2026 оны 1 дүгээр тогтоолоор байгуулагдсан Үндэсний хиймэл дагуул хөөргөх төслийн хүрээнд Монгол Улсад үр өгөөжтэй ашиглах боломжтой олон талт хэрэгцээ, шаардлагад нийцсэн хиймэл дагуулын талаар судлан, санал, дүгнэлт гаргах үүрэг бүхий ажлын хэсгийн зүгээс Thales Alenia Space компани, түүний толгой компани болох Thales Group болон олон улсын хиймэл дагуулын шийдэл нийлүүлэгч 5 байгууллагатай биечлэн уулзалт, хэлэлцүүлэг хийж, хиймэл дагуулын хүчин чадал, давтамжийн боломж, хөөргөх хугацаа, хөөргөлт, түүний үнэ, даатгал, газрын станц, модуляц, санхүүжилтийн нөхцөл зэрэг үзүүлэлтийг харьцуулан авч үзээд санал, дүгнэлт бэлтгэн дэд хороонд танилцуулсан талаар Байнгын хорооны хуралдаанд УИХ-ын гишүүн, дэд хорооны дарга Анар танилцуулсан бөгөөд дэд хорооны санал, дүгнэлтэд дараах асуудлыг тусгасан байна.

1 дүгээрт, ТЭЗҮ хуучирсан, өндөр өртөг, хязгаарлагдмал хүчин чадал, санхүүжилтийн бүрэн эцэслэгдээгүй нөхцөл, нэмэлт зардлын эрсдэл зэргээс шалтгаалан Үндэсний хиймэл дагуулын төслийн одоогийн хувилбарыг дахин нягтлах, ТЭЗҮ-ийг шинэчлэх, шинэчилсэн ТЭЗҮ нь хилийн бүсийн холбоо, гамшгийн үеийн нөөц, холболт, төрийн болон хувийн хэвшлийн хэрэглээ, газрын станц, олон улсын гарцын нөөц холболт, ирээдүйн хүчин чадлын өсөлт, санхүүжилтийн олон хувилбарыг хамарсан байх.

2 дугаарт, төслийн нийт өртгийг зөвхөн хиймэл дагуулын үндсэн үнээр бус хөөргөлт, даатгал, газрын станц, gateway, хэрэглэгчийн терминал, сургалт, үйл ажиллагаа, засвар үйлчилгээ, санхүүжилтийн хүүгийн зардал, сансрын ашигтай байршил зэрэг нийт эзэмшлийн өртгөөр тооцож, олон улсын боломжит хувилбаруудтай нэг ижил шалгуураар харьцуулах.

3 дугаарт, Монгол Улсад хамгийн үр ашигтай хувилбарыг тодорхойлохын тулд олон улсын зах зээл дэх бодит боломжит хувилбаруудыг ТЭЗҮ, санхүүжилт,

хэрэгжүүлэх хугацаа, нийт өртөг, хүчин чадал гэсэн нэгдсэн шалгуураар дахин харьцуулан үнэлэх нь зүйтэй гэж үзжээ.

Байнгын хорооны хурал дээр дэд хорооны санал, дүгнэлт болон тогтоолын төслийг хэлэлцэх үед УИХ-ын гишүүн Уянга тогтоолын төслийн 1.1-д тусгагдсан төслийн ТЭЗҮ-ийг дахин шинээр боловсруулах хэрэгцээ, шаардлага болон шаардагдах төсвийн талаар асуулт асууж, хариулт авсан бөгөөд тогтоолын төсөлтэй холбогдуулан УИХ-ын гишүүдээс санал гараагүй болно.

Монгол УИХ-ын тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.2 дахь хэсэг, Монгол УИХ-ын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 45 дугаар зүйлийн 45.2-т заасныг үндэслэн дэд хорооноос боловсруулсан Үндэсний хиймэл дагуул хөөргөх төслийн талаар авах зарим арга хэмжээний тухай УИХ-ын тогтоолын төслийг нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэхийг дэмжих эсэх асуудлаар Байнгын хорооны хуралдаанаар санал хураалт явуулахад хуралдаанд оролцсон гишүүдийн олонх буюу 75 хувь нь дэмжлээ.

УИХ-ын дарга, эрхэм гишүүд ээ, Инновац, цахим бодлогын хөгжлийн дэд хорооны санал, дүгнэлт болон Үндэсний хиймэл дагуул хөөргөх төслийн талаар авах зарим арга хэмжээний тухай УИХ-ын тогтоолын төслийг хэлэлцсэн талаарх Эдийн засгийн байнгын хорооны санал, дүгнэлт, тогтоолын төслийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг та бүхнээс хүсье. Анхаарал тавьсанд баярлалаа.

С.Бямбацогт: Баярлалаа. Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан асуулт асууж, үг хэлэх гишүүд нэрсээ өгнө үү. Пүрэвдорж гишүүнээр тасаллаа. Пүрэвдорж гишүүн үгээ хэлье.

Б.Пүрэвдорж: Энэ Байнгын хорооны танилцуулга дээр тодорхой компаниудын нэр гарч байна, уулзалт, яриа хэлцэл явсан юм байна. Ер нь би Франц, Монголын парламентын найрамдлын бүлгийн даргын хувьд энэ асуудлаар үг хэлж байгаа. Тэгэхээр мэдээж энэ хиймэл дагуулын асуудал манай Монгол Улсад маш том, их ач холбогдолтой гэдгийг 1 дүгээрт хэлье. Энэ хиймэл дагуул хөөрснөөр бид бүхэн Монгол Улсын аль ч өнцөг булан бүрээс ямарваа асуудалгүй гар утсаараа болон бусад хэрэгслээр холбогдох ийм боломжийг бий болгож байгаа юм.

Тэгэхээр энэ тогтоол дээр тодорхой хэмжээний саналуудыг хэлье. Ер нь start-up компаниуд хиймэл дагуул хөөргөлөө гэхэд 5 хиймэл дагуул бүрийн 3 нь fail-дэх магадлал маш их өндөр байгаа. Дээрээс нь бага оврын хиймэл дагуулууд ер нь мэдээллийг өгөх өгөгдөхүүн болон бусад гүйцэтгэл нь бага байх ийм магадлал өндөртэй. Жишээ нь, 150 мянган малчин хүмүүс, малчин өрх, хүмүүс Старлинкийн хиймэл дагуулд холбогдлоо гэхэд 2 жил төлдөг төлбөр нь нэг томоохон, жишээ нь, Чингис хиймэл дагуулыг санхүүжүүлэх ийм боломжтой байгаа. Тийм учраас энэ тогтоолын дагуу ЗГ тодорхой арга хэмжээ авахдаа аль болох дараагийн зардал нь өндөр гарахгүй, хөрөнгө оруулалтыг илүү оновчтой, өгөгдөл өндөртэй ийм хиймэл дагуулыг сонгож, тэгээд үүнийхээ үр дүнд хямд, бага үнэтэй ийм үйлчилгээг үзүүлэх хиймэл дагуулыг сонгоорой.

Яагаад гэвэл Их Хурлын хэлэлцэх явцад тогтоолын төсөл дээр хэлсэн үг тодорхой хэмжээгээр ЗГ үйл ажиллагаа явуулахад ийм давуу тал болж үлддэг. Тийм учраас энэ дээр сануулж хэлэх үүднээс энэ саналыг хэлж байна. Асуулт алга байна, баярлалаа.

С.Бямбацогт: Тайлбар хэлэх юм уу, тэгье. Золжаргал гишүүн.

Ж.Золжаргал: Харилцаа холбоо гэдэг тусгаар тогтносон улсын үндэстний нэг чухал салбар, тэгэхээр өөрийн хиймэл дагуул гэдэг их чухал зүйл маргаангүй.

2 дугаарт нь, ямар боломжит эх үүсвэрүүд байж болох вэ. Франц улсын тэр яригдаж ирсэн төсөл техникийн, улс орных нь техникийн чадамж ч тэр, хамтрагч олон, урт хугацааны хамтын ажиллагааг хөгжүүлсэн улс гүрэн гэдэг утгаар ч тэр маргаангүй. Гэхдээ энд нэг асуудал байгаа нь энэ төсөл анхнаасаа их чухал, хамтрагч улсуудтай хэрэгжүүлнэ гээд тийм романтик улс төрийн чухал шийдвэр гэдэг өнгө аясаар нэлээн олон жил явж ирсэн байна. Энэ хооронд чухал зорилго тавьчихаад тэр дунд нь техникийн болоод санхүүгийн нөхцөлүүд дээр ажиллах ажил нэлээн орхигдсон юм байна лээ. Ажлын хэсгийн бүрэлдэхүүнд орж ажилласны хувьд ер нь тиймэрхүү зүйл дүгнэсэн. Тэгэхээр 1 дүгээрт, тэр үнэ арилжааны шинжтэй төсөл буюу энэ нэг тийм айхтар хөнгөлөлттэй зүйл байгаагүй.

2 дугаарт, зээлийн санхүүжилтийн нөхцөл ялгаагүй тал нь арилжааны, тал нь ЗГ-ын хөнгөлөлттэй зээл, магадгүй 100 хувь зээл болж болзошгүй. Гэхдээ эцсийн байдлаар ингээд л ярьж хэлэлцэж байсан ийм зүйл байна. Тэгээд 10 гаруй жилийн хугацаа өнгөрчихсөн, тэр хооронд чинь техник урагшаа явчихсан, нөхцөл өөр болсон байна, хүчин чадал бага байна, үнэ өндөр байна. Тийм учраас эргэж харж, олон хувилбарууд дундаас орхигдуулсан ажлаа гүйцээж хийх нь, харьцуулах ажлаа хийх нь зөв юм байна гэж ажлын хэсгийн ерөнхий дүгнэлт гарсан, тэнд нь санал нийлээд, тогтоолын төслийг дэмжиж байгаа.

С.Бямбацогт: Анар гишүүн.

Ч.Анар: Оройн мэнд. Энэ ажлын хэсгийн ахлагчийн зүгээс тайлбар тавья. Пүрэвдорж гишүүний хэлсэнтэй санал нэг байгаа. Энэ хиймэл дагуул, Үндэсний хиймэл дагуул Монгол Улсад зайлшгүй хэрэгтэй, түүнтэй хэн ч маргахгүй байгаа юм. Хамгийн гол нь бидний ярьсан юм бол энэ одоо та бүхэнд харуулъя. 2011 онд хийсэн ТЭЗҮ байгаа байх, 2013 онд хийсэн ТЭЗҮ байгаа юм. Тэгээд 2013 онд хийсэн ТЭЗҮ энэ Японы Padeco гэж зөвлөх үйлчилгээний компаниар хийсэн, маш сайн хийсэн ТЭЗҮ. Тэгэхдээ 3 өөр чиглэлийн хиймэл дагуулын ТЭЗҮ хийгээд, Их Хурал дээр орж танилцуулахдаа гурвууланг нь нэгтгэж танилцуулангуутаа нэг хиймэл дагуулын гэрээ ороод ирчихсэн, тэр дээрээс л үл ойлголцол үүссэн. Энэ хооронд бид ажлын хэсэг Франц улсад очиж Thales Alenia-тай ажилласан, бусад хиймэл дагуулын компаниудтай ч ажилласан. Энэ.../минут дуусав/

С.Бямбацогт: Гүйцээгээд хариулъя.

Ч.Анар: Тэгэхээр энэ хиймэл дагуул бидэнд хэрэгтэй. Одоо орчин үед чинь энгийнээр хэлбэл 2013 онд ухаалаг утсанд тавигдах шаардлагаар 2026 онд утас авах гэж оролдсон л асуудал болчихоод байгаа юм. Тэгэхээр энийгээ бид ЗГ шинэчлээд дахиад Францын, Европын Холбооны маш том хиймэл дагуулуудыг авах бололцоо байгаа. Тэр бүрэн эрхийн ЗГ-т байгаа. 1.2 их наядоор авах хиймэл дагуулыг бид үндсэндээ ажлын хэсэг 600 тэрбум, цаашилбал 400 тэрбумаар ч авах бололцоотой юм байна л гэж дүгнэсэн байгаа товчхондоо. Тэгээд илүү дор хаяж 10 дахин өндөр чадалтай хиймэл дагуулыг 2-оос 3 дахин бага өртгөөр Монгол Улс

хөнгөлөлттэй зээлээр авах бололцоотой юм байна гэж үзсэн учраас ЗГ хэлцлээ дахин хийхийг хүсэж, чиглэл өгсөн тогтоол оруулсан байгаа юм. Баярлалаа.

С.Бямбацогт: Баярлалаа. Дүгэрийн Рэгдэл гишүүн үг хэлье.

Д.Рэгдэл: Үндэсний хиймэл дагуул гэдэг ер нь ямар хэрэгтэй юм гэдгийг бүгд л мэдэж байгаа. Энд үнэхээр л гарцаагүй чухал эд. Энэ геостационар /Geostationary Orbit/ орбитод байршдаг энэ хиймэл дагуулын асуудал чинь социализмын үед яригдаж, нэлээн явж байгаад тэгээд сүүлдээ чимээгүй болж болж, одоо дахиад л 2010-аад оноос эхэлж яригдаад энэ түвшинд очсон байна. Ажлын хэсэг сайн ажилласан юм шиг байна. Ер нь олон компанитай харилцаж, мэдээ, материалаа цуглуулж, тэгээд ер нь ТЭЗҮ-ийг үндсээр нь шинэчлэх ёстой гэж би бодоод байгаа юм. Бүр үндсээр нь шинэчлээд, аль нэг улс руу чиглэсэн бодлого энд хэрэггүй. Монголд хамгийн ашигтай хувилбараа бодоод, тэгээд ерөнхийдөө үнэний талд ажлын хэсэг өөрийн гэсэн дүгнэлттэй болсон юм байна гэж ойлголоо. Ер нь Франц, Хятад, АНУ гээд энэ чиглэлдээ тэргүүлдэг компаниуд байгаа, тэгээд анхаармаар юмнууд байгаа юм.

Тэр стационар орбитод байдаг үндэсний хиймэл дагуул маань ажиллахад хэдэн жилийн баталгаа өгөх вэ нөгөө цаад тал чинь, аль болохоор олон жилийн баталгаатай байвал зүгээр байгаа юм. Тэгээд үүрэн телефоны сувгийг нь ажиллуулдаг, телевизийн нэвтрүүлгийг нь дамжуулдаг, тэгээд зайнаас тандан судлалын зорилтуудыг хэрэгжүүлэхэд ашиглагддаг гээд аль болохоор олон талын, олон шугамаар ашиглаж болох энэ хувилбарыг нь сонгоод, мэдээж хэрэг хямд үнэ, хөнгөлөлттэй зээл гээд янз янзын юмыг нь бодох боловч аль болохоор олон чиглэлээр ашиглаж болох тэр талыг нь бодож явбал манайд ирээдүйд хэрэгтэй. Тэгээд Их Хурлын тогтоол гараад, ЗГ-т чиглэл өгөх юм бол одоо нэгэнт ТЭЗҮ хийгдчихсэн юм чинь тэр ТЭЗҮ дээрээ суурилж, тэрнээсээ жишээ аваад харьцангуй богино хугацаанд цоо шинэ ТЭЗҮ гаргаж ирж, хэлэлцүүлэх болов уу гэж бодож байна. Тэгээд энийг ер нь бид цаашдаа дэмжээд явах нь зүйтэй, ийм чухал тогтоолын төсөл гарах гэж байна гэж бодож байна.

С.Бямбацогт: Баярлалаа. Үг хэллээ. Гишүүд асуулт асууж, хариулт авч, үг хэлж дууслаа. Санал хураалтыг Баасан гарагийн нэгдсэн чуулганы хуралдаанаар явуулна.

21.34 цаг

Монгол Улсын Их Хурлын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн хэлэлцэх эсэх хэлэлцүүлэг үргэлжлэв.

Дараагийн асуудалдаа оръё. Одоо чинь Хүнсний тухай хууль билүү? Их Хурлын хууль, 49. Дараагийн асуудалд оръё. Монгол УИХ-ын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл хэлэлцэх эсэх хэлэлцүүлэг явуулна. Хууль санаачлагчийн илтгэлийг УИХ-ын гишүүн Мөнхчулууны Энхцэцэг танилцуулна. АН-ын бүлгийн завсарлагын хугацаа дууссан, завсарлага сунгаагүй. Танилцуулъя, индэрт дээрээс.

М.Энхцэцэг: Та бүхэнд оройн мэнд хүргэе. Эдийн засгийн байнгын хорооны доор Эрчим хүчний хөгжлийн дэд хороог байгуулах ийм хуулийн төсөл санаачилсан байгаа. Тэгээд Эрчим хүчний хөгжлийн дэд хороог байгуулах нь зүйтэй юм гэж

дэмжиж, 76 гишүүн дэмжиж гарын үсэг зурсан байгаа. Бид 2024 онд УИХ-ын тухай хуульд өөрчлөлт оруулахдаа хэт том бүтэцтэй, олон асуудлыг хариуцсан нүсэр том ийм Байнгын хороонуудыг байгуулсан. Тэгэхээр энэнээс болоод ямар асуудал үүсэж байна вэ гэхээр ер нь асуудлуудаа яг хэлэлцэж чаддаггүй, дээрээс нь мэргэжлийн Байнгын хороо гэсэн утга нь алдагдсан, мөн тэргүүлэх салбарууд хаягдсан ийм байдалтай байгаад байгаа.

Тухайлбал, Эдийн засгийн байнгын хорооны хувьд Монголбанк, арилжааны банк, Санхүүгийн зохицуулах хороо, мөн Үндэсний статистикийн газар гээд маш олон эдийн засаг, банктay холбоотой асуудлуудаас гадна маш том салбаруудын асуудлыг хариуцдаг, тухайлбал, агаарын тээвэр, төмөр зам, түлш, эрчим хүч гээд. Тэгэхээр үүнээс болоод олон салбарууд, тэргүүлэх салбарууд хаягдаж байна, мэргэжлийн гэсэн шинж чанар нь алдагдаж байна гэж ингэж үзэж байгаа.

Тэгээд энэ дотроо эрчим хүчний салбар маань, та бүхэн мэдэж байгаа, өнөөдөр улс орны тэргүүлэх салбар бол эрчим хүчний салбар. Бид бүхний ганц толгойны өвчин бол эрчим хүчний салбар болчихоод байгаа. Энэ салбарын өмнө тулгамдсан олон асуудлууд байгаад байгаа. Гэтэл энэ олон асуудлуудыг мэргэжлийн Байнгын хорооны зүгээс мэргэжлийн гишүүд нэлээн төвлөрч ажиллаж, энэ салбарын асуудлуудыг шийдэхэд хувь нэмэр оруулж, оролцоогоо хангаж ажиллах нь зүйтэй юм. Тийм учраас Эдийн засгийн байнгын хорооны доор Эрчим хүчний хөгжлийн дэд хороог байгуулах ийм хуулийг өргөн барьж байгаа. Тэгээд олон гишүүд энэ нь зөв, зүйтэй асуудал байна гэж ингэж дэмжиж ажилласан байгаа.

Мөн 2024 онд байгуулагдсан УИХ маань олон мэргэжлийн салбарын гишүүд орж ирсэн. УИХ дээр эрчим хүчний салбар луу үйл ажиллагаагаа чиглүүлдэг нэлээд олон гишүүд Эдийн засгийн байнгын хороон дээр ажиллаж байгаа. Тэгэхээр эдгээр гишүүд 4-өөс 5 гишүүн энэ Эдийн засгийн байнгын дэд хороонд орж, тодорхой хэмжээний чиглэлүүдээр сонсгол хийх, санал, дүгнэлт гаргах, шаардлагатай бол УИХ-ын тогтоолын төсөл боловсруулах, мөн УИХ-ын хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллах зэргээр эрчим хүчний салбарын тулгамдсан асуудлуудыг шийдэхэд УИХ-ын гишүүдийн хувь нэмрийг оруулах, оролцоог хангах чиглэл рүү үр дүнтэй ажиллаж чадна. Тэгээд Байнгын хорооны мэргэжлийн гэдэг энэ утга учрыг хангаж ажиллаж чадна гэж ингэж үзсэн байгаа. Тийм учраас гишүүд маань энэ хуулийг маань дэмжиж өгч, хамтарч ажиллаарай гэж хүсье.

С.Бямбацогт: Хууль санаачлагч Энхцэцэг гишүүнд баярлалаа. Төслийн талаарх ТББХ-ны санал, дүгнэлтийг УИХ-ын гишүүн Доржзовдын Энхтуяа танилцуулна. Таныг индэрт урьж байна.

Д.Энхтуяа: УИХ-ын дарга, эрхэм гишүүд ээ,

УИХ-ын гишүүн Энхцэцэг нарын 71 гишүүнээс 2026 оны 5 дугаар сарын 27-ны өдөр УИХ-д өргөн мэдүүлсэн Монгол УИХ-ын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн хэлэлцэх эсэх хэлэлцүүлгийг ТББХ 2026 оны 6 дугаар сарын 10-ны өдрийн хуралдаанаараа явууллаа.

Хууль санаачлагч эрчим хүчний салбарын хөгжлийн бодлого, хууль тогтоомжийн хэрэгжилт, хөрөнгө оруулалт, томоохон төсөл, хөтөлбөрийн явц, эрчим хүчний аюулгүй байдал, сэргээгдэх эрчим хүчний хөгжил, эрчим хүчний хараат байдлыг бууруулах асуудлыг тогтмол хэлэлцэх, парламентын хяналтыг

хэрэгжүүлэх зорилгоор УИХ-ын бүтцэд Эрчим хүчний хөгжлийн дэд хороо байгуулах нь зүйтэй гэж үзэн хуулийн төслийг боловсруулсан байна.

Хуулийн төсөлд иргэдийн оролцоог хангах, санал авах зорилгоор УИХ-ын d.parliament.mn цахим системд байршуулсан болно.

Байнгын хорооны хуралдаанаар хуулийн төслийг хэлэлцэх үед УИХ-ын гишүүн Батбаатар төслийг дэмжиж байгаагаа илэрхийлээд, хуулийн төслийн 27.3.7-д Эрчим хүчний хөгжлийн гэж дэд хорооны нэршлийг тусгасан боловч хэрэгжүүлэх чиг үүрэг, эрхлэх асуудлыг нарийн тусгаагүй байгаа талаар, эрчим хүчний асуудлын талаарх тайланг ЗГ, ЭХЯ, Эрчим хүчний зохицуулах хороо болон ТӨК-иуд улирал тутам хэлэлцэх талаар хууль санаачлагч ямар байр суурьтай байгаа, импорт, оргил ачааллын үеийн нөөц хүчин чадал, шинэ эх үүсвэр, сүлжээний алдагдал, салбарын санхүүгийн алдагдал гэсэн 5 үндсэн асуудлыг хуульд хэрхэн тусгах тухай, Эрчим хүчний хөгжлийн дэд хороо нь дээрх асуудлын хүрээнд ЗГ-ын тайланг сонсож, хэрэгжилтэд бодит хариуцлага тооцдог механизмтай болох чиглэлээр хуульд хэрхэн тусгах, дэд хороо зөвхөн сонсгол хийдэг биш, томоохон төслүүдийн явцыг ил тод хянадаг, парламентын хяналтыг хэрэгжүүлдэг байх, тарифын шинэчлэлт, хөрөнгө оруулалт, ТӨК-ийн өр төлбөр, алдагдлын асуудлыг хэлэлцэж, хариуцлага тооцдог байх, УИХ-ын гишүүн Ундрам УИХ-ын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг хэлэлцүүлэгт бэлтгэх үүрэг бүхий ажлын хэсгээр уг хуулийн төслийг хэлэлцэн шийдвэрлэх боломжтой эсэх, тусдаа хэлэлцүүлэх шаардлагагүй талаар асуулт асууж, хариулт авсан болно.

Монгол УИХ-ын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд дэмжих нь зүйтэй гэсэн томьёоллоор санал хураалт явуулахад Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн олонх нь дэмжсэн болно.

УИХ-ын эрхэм гишүүд ээ, Монгол УИХ-ын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн хэлэлцэх эсэх талаарх ТББХ-ны санал, дүгнэлтийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг та бүхнээс хүсье. Анхаарал хандуулсанд баярлалаа.

С.Бямбацогт: Энхтуяа гишүүнд баярлалаа. УИХ-ын гишүүд Байнгын хорооны санал, дүгнэлт, хууль санаачлагчийн илтгэл болон хуулийн төслийн үзэл баримтлалтай холбогдуулж урьдчилан ирүүлсэн нэрсийн дагуу үг хэлнэ, асуулт асууна. Лхагвасүрэнгийн Соронзонболд гишүүн асуултаа асуух уу, нэрээ татлаа. Асуулт асуух гишүүд дууслаа. Гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа. Төслийн талаар Байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг дэмжсэн, эсрэг байр суурьтай гишүүд урьдчилан ирүүлсэн нэрсийн дагуу үг хэлнэ. Алга байна, гишүүд үг хэлж дууслаа. Санал хураалтыг Баасан гарагийн чуулганы нэгдсэн хуралдаанаар явуулна.

21.43 цаг

Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлэг үргэлжлэв.

Дараагийн асуудалдаа орёе. Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлэг явуулна. Төслийн

анхны хэлэлцүүлэг явуулсан талаарх ТББХ-ны санал, дүгнэлтийг УИХ-ын гишүүн Лхагвын Мөнхбаатар танилцуулна. Таныг индэрт урьж байна.

Л.Мөнхбаатар: УИХ-ын дарга, эрхэм гишүүд ээ,

УИХ ҮХЦ-ийн 2026 оны 04 дүгээр дүгнэлтийг 2026 оны 5 дугаар сарын 28-ны өдрийн нэгдсэн хуралдаанаараа дүгнэлтийг хэлэлцэж, уг дүгнэлтийг хүлээн зөвшөөрөх нь зүйтэй гэж үзэн Монгол УИХ-ын 23 дугаар тогтоолыг баталсан.

Тус дүгнэлтийг хүлээн зөвшөөрсөнтэй холбогдуулан Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулж, хэлэлцүүлэгт бэлтгэх үүрэг бүхий Ажлын хэсгийг УИХ-ын гишүүн Л.Мөнхбаатар ахалж, гишүүдэд УИХ-ын гишүүн О.Алтангэрэл, Ч.Ундрэм нарын бүрэлдэхүүнтэй байгуулсан. Ажлын хэсгээс боловсруулсан Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг ТББХ 2026 оны 6 дугаар сарын 10-ны өдөр Монгол УИХ-ын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39 дүгээр зүйлийг баримтлан хэлэлцлээ.

Хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг явуулах үед зарчмын зөрүүтэй санал гараагүй тул анхны хэлэлцүүлгээс эцэслэн батлах үе шат руу шилжүүлэх горимын саналыг УИХ-ын гишүүн Л.Мөнхбаатар гаргасныг Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн олонх нь дэмжсэн болно.

УИХ-ын эрхэм гишүүд ээ, Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлэг явуулсан талаарх ТББХ-ны санал, дүгнэлтийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг та бүхнээс хүсье.

21.45 цаг

С.Бямбацогт: Мөнхбаатар гишүүнд баярлалаа. УИХ-ын гишүүд Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан намын бүлэг болон бүлэгт харьяалагдаагүй гишүүд урьдчилан ирүүлсэн нэрсийн дагуу асуулт асууна. Сүхбаатарын Эрдэнэболд гишүүн алга байна, Одсүрэнгийн Номинчимэг гишүүн алга байна, Хишигдэмбэрэлийн Тэмүүжин гишүүн алга байна. Алга байна гишүүд. Асуулт асууж, хариулт авч дууслаа. Санал хураалтыг хойшлууллаа. Баасан гарагийн чуулганы нэгдсэн хуралдаанаар санал хураалт явуулна.

21.45 цаг

Хүнсний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн анхны хэлэлцүүлэг үргэлжлэв.

Дараагийн асуудалдаа оръё. Хүнсний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн анхны хэлэлцүүлгийг явуулна. Төслүүдийн анхны хэлэлцүүлэг явуулсан талаарх БОХХАА-н байнгын хорооны санал, дүгнэлтийг УИХ-ын гишүүн Тогтмолын Мөнхсайхан танилцуулна. Таныг индэрт урьж байна.

Т.Мөнхсайхан: УИХ-ын дарга, эрхэм гишүүд ээ,

УИХ-ын гишүүн М.Мандхай нарын 10 гишүүнээс 2025 оны 6 дугаар сарын 19-ний өдөр УИХ-д өргөн мэдүүлсэн Хүнсний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслийн хэлэлцэх эсэх асуудлыг 2025 оны 10 дугаар сарын 2-ны өдрийн чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцэж, анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр БОХХАА-н байнгын хороонд шилжүүлсэн.

Хүнсний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслийг Байнгын хорооны болон чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх бэлтгэл хангах үүрэг бүхий ажлын хэсгийг Байнгын хорооны 2025 оны 23 дугаар тогтоолоор байгуулсан бөгөөд ажлын хэсгийн ахлагчаар УИХ-ын гишүүн Т.Мөнхсайхан, бүрэлдэхүүнд УИХ-ын гишүүн П.Батчимэг, Г.Ганбаатар, Н.Наранбаатар, А.Ундраа, Б.Уянга нар ажиллалаа.

БОХХАА-н байнгын хороо 2026 оны 6 дугаар сарын 10-ны өдрийн хуралдаанаараа хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг Монгол УИХ-ын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39 дүгээр зүйлд заасны дагуу явуулж, хуулийн төслийг зүйл тус бүрээр хэлэлцлээ. Хуулийн төслийг Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцэх үед УИХ-ын гишүүдээс асуулт, санал гараагүй болно. Ажлын хэсгээс хоол үйлдвэрлэл, үйлчилгээ гэх нэр томьёог стандартын шаардлага хангасан байр, түүхий эд, технологи болон мэргэжлийн хүний нөөцөд тулгуурлан хоол үйлдвэрлэх, үйлчлэх үйл ажиллагаа байхаар өөрчлөн найруулах, аюулгүй байдал гэх нэр томьёог баталгаат байдал болгон хуулийн нэрийг өөрчлөх нэр томьёог сууриар нь солих асуудал нь одоогийн нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн хүрээнд өөрчлөх нь зөвхөн нэр томьёоны механик өөрчлөлт биш, харин бодлогын томоохон шинэчлэлд тооцогдох тул нэмэлт, өөрчлөлтийн хүрээнд шийдвэрлэх боломжгүй бөгөөд үүнийг нэг мөр солих нь салбарын бодлогыг бүхэлд нь шинэчлэн тодорхойлох хэмжээний зарчмын өөрчлөлт учраас аюулгүй байдал гэсэн нэр томьёог хэвээр нь үлдээх, төсөлд хүнсний аюулгүй байдал гэсэн нэр томьёог хасаж, тусад нь зүйл болгон томьёолсон байсныг Хууль тогтоомжийн тухай хуульд нэр томьёо нь нэг утга агуулгаар нийт хуулийн хэмжээнд хэрэглэгдэх бол түүний тодорхойлолтыг уг хуулийн нийтлэг үндэслэл гэсэн бүлэгт оруулан заана, мөн хуулийн төсөлд тодорхойлолт өгсөн хэд хэдэн нэр томьёо байгаа бол тэдгээрийг хуулийн нэр томьёоны тодорхойлолт гэсэн гарчигтай зүйлд нэгтгэнэ гэж заасны дагуу уг нэр томьёог холбогдох зүйлд хэвээр үлдээх.

Төрөөс баримтлах бодлогын хүрээнд цэцэрлэг, сургуулийн хүүхдийн хоол үйлдвэрлэлд дотоодын гарал үүсэлтэй түүхий эд ашиглан стандарт, техникийн зохицуулалтын шаардлага хангасан үйлдвэрт бэлтгэсэн хагас боловсруулсан болон бэлэн бүтээгдэхүүн нийлүүлсэн ААН, хоршоог дэмжих, салбар хоорондын үйл ажиллагааг уялдуулах зорилгоор мэдээллийн нэгдсэн санг үүсгэж, эрхлэн хөтлөх. Уг сан нь хүнсний чиглэлийн үйл ажиллагаа эрхлэгчдийн бүртгэл, гол нэрийн хүнсний нөөцийн мэдээлэл, хяналт, шалгалтын тайлан, импорт, экспортын зөвшөөрөл, гүйцэтгэлийн мэдээлэл зэрэг 8 төрлийн мэдээллээс бүрдэх бөгөөд бусад төрийн байгууллагын системтэй цахимаар холбогдож, мэдээллийг бүрдүүлэх зэрэг саналуудыг Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжсэн болно. Байнгын хорооны хуралдаанаар зарчмын зөрүүтэй саналын томьёоллыг нэг бүрчлэн хэлэлцэн, олонхын санал авснаар нь бүлэглэн анхны хэлэлцүүлэг явуулсан талаарх Байнгын хорооны санал, дүгнэлтийн хамт та бүхэнд хүргүүлсэн болно.

УИХ-ын эрхэм гишүүд ээ, Хүнсний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг явуулсан талаарх БОХХАА-н байнгын хорооны санал, дүгнэлт, зарчмын зөрүүтэй саналын томъёоллыг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг та бүхнээс хүсье. Анхаарал хандуулсанд баярлалаа.

С.Бямбацогт: Мөнхсайхан гишүүнд баярлалаа. Ажлын хэсгийг танилцуулъя. Даваасүрэнгийн Довчинсүрэн Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам /ХХААХҮЯ/-ны Хүнсний үйлдвэрийн бодлогын хэрэгжилт зохицуулах газрын дарга, Чадраабалын Раднаабазар ХХААХҮЯ-ны Хуулийн хэлтсийн дарга, Отгонзулын Онон ХХААХҮЯ-ны Бодлого, төлөвлөлтийн газрын салбарын нэгдсэн бодлого, төлөвлөлт хариуцсан ахлах шинжээч, Хурцаагийн Цэрэнханд ХХААХҮЯ-ны Бодлого, төлөвлөлтийн газрын салбарын бодлого, төлөвлөлт хариуцсан ахлах мэргэжилтэн, М.Пүрэвжав Хүнсний эрдэм шинжилгээ, судалгааны хүрээлэнгийн захирал, Ядамын Хишигт хуульч, судлаач. УИХ-д хүндэтгэлтэй хандахыг та бүхнээс хүсье, бодитой, үнэн зөв мэдээлэл өгөх үүрэгтэй шүү гэдгийг сануулъя.

УИХ-ын гишүүд Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан урьдчилан ирүүлсэн нэрсийн дагуу асуулт асууна. Дашцэрэнгийн Энхтүвшин гишүүн.

Д.Энхтүвшин: Хүнсний баталгаат байдлыг сайжруулах, иргэдийг чанартай, шим тэжээллэг хүнсээр хангах энэ төслийн зорилгыг дэмжиж байгаа. Тэгэхдээ энэ хууль дотор дэмжих боломжгүй заалт байгаад байгаа юм. Төслийн өгсөн мэдээллээр 200 орчим ААН нэг өдөр бүгдээрээ Зөрчлийн хуулиар өр төлбөрт орох иймэрхүү нөхцөл байдал үүсгэж байна. Төслийн 3 дугаар зүйлийн Хүнсний тухай хуулийн 10.1.4 дэх заалт, 17.1 дэх хэсгийг өөрчлөн найруулж хүнсний чиглэлийн үйл ажиллагаа эрхэлдэг эрхлэгч бүр зохистой дадал нэвтрүүлснээ итгэмжилсэн байгууллагаар заавал баталгаажуулах ийм үүрэг хүлээлгэж, энэ үүрэг нь өнөөдөр сайн дурын шинжтэй байгаа. Тэгэхээр хууль санаачлагчийн өргөн мэдүүлсэн баримт бичгээс харахаар 200 мянган ААН үйл ажиллагаа явуулж байна. Тэгээд энэ зохистой дадал баталгаажуулдаг итгэмжилсэн байгууллага улсын хэмжээнд 1, 2-хон байгаа гэж байгаа юм. Тэгээд өнөөдрийг хүртэл энэ зохистой дадал нэвтрүүлснээ баталгаажуулсан нэг ч ААН байхгүй, гараагүй. Дараагийн шатны ISO 22000 ч юм уу энэ 12 жилийн хугацаанд 33 ААН баталгаажуулсан. Тэгэхээр энэ хоёрхон байгууллага жилдээ 500 байгууллагад баталгаажилт хийдэг. Тэгэхээр энэ хэдэн 100 мянган ААН-ийн чинь юунд хэдэн 100 жил ингээд шаардагдахаар байгаа байхгүй юу. Тэгэхээр энэ нөгөө хүчин чадлуудаа бий болгоогүй, сайжруулаагүй, бэлдээгүй байж шууд ингээд яг энэ хуулийн өөрчлөлт ороод ирэхээр биелэгдэх боломжгүй ийм үүргүүдийг бий болгоод байна.

Тэгээд энэ дээр байгаа тоонууд нь хоорондоо зөрчилдөөд байна л даа дагалдаж байгаа тэр өгсөн мэдээллүүд нь, ААН-үүдэд дарамт болохгүй гэж байгаа юм. Тэгсэн мөртөө энэ баталгаажуулалтын байгууллагын тоо нь хязгаарлагдмал, заавал стандарт дутмаг, нутагшуулахад хүндрэлтэй гээд хүндрэлүүд, дарамтууд байна. Зардал гарахгүй гэсэн мөртөө ААН-үүд дээр тодорхой зардал гарна гэсэн 2 зөрчилдсөн юмнууд ард талын нэмэлт мэдээллүүд дээр байна лээ. Тэгэхээр энэ нөгөө талаас энэ баталгаажуулалт маань зөвшөөрлийн шинжтэй байгаад байгаа юм. Яг л одоо ингээд нэр нь зөвшөөрөл биш ч гэсэн яг энэ нөхцөлтэй урьдчилсан нөхцөлтэй, үйл ажиллагаа эрхлэх урьдчилсан нөхцөл, хугацаатай гэрчилгээтэй, түдгэлзүүлэх, хүчингүй болгох механизм гээд ингээд бүгдээрээ ийм зөвшөөрлийн далд зөвшөөрлийн шинжтэй. Тэгээд дээр нь зөвшөөрөл маань харьцангуй хуулийн

хүрээлэлд ороод хуульчилдаг бол тэр зүйлүүд энэ дээр байхгүй. Зөвшөөрөлд үйлчилдэг шийдвэрлэх хугацаа, хураамжийн төлбөр, ямар хураамжтай байхыг мэдэхгүй, гомдол гаргах хамгаалалт тийм юм байхгүй. Тэгэхээр ийм монопол эрхтэй байгууллагуудад бүх ААН-үүдийг өнгөрсөн хугацаанд хийгээгүй, сайн дурын шинжтэй байсан энэ зохицуулалт руу бүгдийг нь шахаад, энийг зөрчвөл Зөрчлийн хуулиар хариуцлага хүлээлгэхээр иймэрхүү зүйл, заалт орж ирж байна.

Энэ өнөөдөр бидний ярилцсан бизнесийн эрх чөлөө гэдэг зарчимтай зөрчилдөж байна. ААН-үүдэд илүү хүндрэл бий болохоор. Үнэхээр ийм энэ хэрэв оруулъя гэвэл үе шаттайгаар хугацааны хувьд ч гэсэн ядаж энэ баталгаажуулалтынхаа хүчин чадал, энэ итгэмжлэгдсэн байгууллагуудынхаа хүчин чадлуудыг нэмээд, хэрэгжих хугацааг нь жоохон уужуу тавиад, эрсдэл дээрээ үндэслээд, зарим нэг эрсдэлтэй байгууллагуудыг заавал ч юм уу гэж явахгүй бол шууд бүх ААН-үүдийг ийм баталгаажуулалт, ийм зөвшөөрлийн шинжтэй зүйл оруулж ирэхийг өөрчлөхгүй бол наад хууль чинь асуудалтай, чөлөөлье гэдэг зарчимтай, Монгол Улсад хуулиар хориглосноос бусад үйл ажиллагааг чөлөөтэй эрхлэх эрх зүйн Зөвшөөрлийн тухай хуулийн агуулга маань тийм байгаа. Тэгэхээр энд зөвшөөрөл биш ч гэсэн зөвшөөрлийн шинжтэй ийм зүйлийг бүх ААН-үүдийг үүрэгжүүлэх гэж байна. Тэгээд бүгдийг нь Зөрчлийн хуулиар энэ үүргээ биелүүлээгүй бол хариуцлага тооцохоор иймэрхүү зүйл орж.../минут дуусав/

С.Бямбацогт: Мөнхсайхан гишүүн хариулъя ажлын хэсэг. Уг нь ажлын хэсэг, анхны хэлэлцүүлэгт ажлын хэрэг хариулах ёстой. Санаачлагч хариулъя, Мандхай гишүүн хариулъя.

М.Мандхай: Энхтүвшин гишүүн чухал асуудал хөндөж байна, зөв. Гэхдээ би энэ зохистой дадал гэж юу вэ гэдгийг нэг ойлголт ард түмэнд өгөхгүй бол болохгүй байх. Ер нь хүнсний үйлдвэр ч бай, ресторан, цайны газар, агуулах, хүнсний чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа түгээлт гээд энэ хүнсний сүлжээнд үйлдвэрлэл, үйл ажиллагаа явуулж байгаа нэмэлт байгууллагууд хамгийн энгийн энэ бол өөрөө өндөр түвшний сертификат биш, зүгээр л хамгийн энгийн, өдөр тутамдаа эрүүл ахуй, ариун цэвэр, тэр хадгалалт, тээвэрлэлтийн сахилга хариуцлагыг нь хангах ийм зарчмын зориулалттай юм 1 дүгээрт.

2 дугаарт, энэ одоо байгаа Хүнсний тухай хууль дээр үндсэндээ одоогийн Хүнсний хуулийн 7.1 дүгээр зүйл дээр заавал баталгаажуулалтыг үүрэг болгосон байгаа. 2012 оноос хойш эхлээд. Өнөөдөр 50 гаруй хүнсний ногоо тариалагчид баталгаажуулалт хийлгэсэн байдаг. Тэгээд харамсалтай нь, өнөөдөр манайд бидний амаар орж байгаа хүнс, зохисгүй хоол хэрэглээ, хүнсний баталгаат байдал өөрөө хяналт сул, алдагдсантай холбоотойгоор халдварт бус өвчлөл нэмэгдэж байгаа. Мөн Халдвар судлалын үндэсний төвөөс хавдар үүсгэж байгаа 35 хувь нь өөрөө зохисгүй хоол хэрэглээ байгаа гэсэн. Тэгэхээр энэ 12 оноос хойш хэрэгжиж байгаа, үүрэгжүүлсэн байгаа баталгаажуулалт хийгддэг энэ зохистой дадал өөрөө хэрэгжихгүй яваад байгаа юм. Тэгэхээр энэ энгийн гараа угаах, хэрвээ та хоол хүнс үйлдвэрлэдэг бол битгий махан дээр, махныхаа гампанзыг хүнсний ногоо, бусад төрлийн хүнстэйгээ битгий холиоч гэсэн энгийн ийм дадлыг нэвтрүүлэх шаардлага, хэрэгцээ байгаад байгаа юм.

Тэрнээс биш, ISO стандарттай, учиргүй лабораториор хэмжиж байгаа тийм шаардлага биш. Тэгэхээр энгийн энэ зохистой дадлыг нэвтрүүлдэг байгаач гэсэн ийм л зохицуулалтыг хуульд оруулж өгч байгаа юм. Ер нь ингээд харах юм бол ЕБС-

ийн хоол үйлдвэрлэлийн тухай хууль дээр ч гэсэн зохистой дадлыг нэвтрүүлэх, энийг бүр зохион байгуулах, хяналт тавих үүргийг тусгачихсан байдаг юм. Эм, эмийн түүхий эд, биологийн идэвхт энэ хууль, ахуйн үйлчилгээний салбарыг хөгжүүлэх гээд энэ олон хууль, эрх зүйн орчинд зохистой дадлыг нэвтрүүлэхээр нарийн зохицуулалт. Тэгэхээр энэ нь өөрөө хуульдаа зохицуулалт нь орчихсон, гагцхүү бид хэрэгжүүлдэг, энийг хэвшүүлдэг энэ дадлыг бий болгох шаардлагыг л энэ хуульд зохицуулж, оруулж өгч байгаа юм.

С.Бямбацогт: Тодруулъя, Энхтүвшин гишүүн.

Д.Энхтүвшин: Тэгэхээр гол нь бэлэн биш байгаад байгаа байхгүй юу. Өнгөрсөн хугацаанд энэ үр дүн гараагүй. Тэгээд одоо ингээд Зөрчлийн хуулиар хариуцлага хүлээлгэхээр ААН-үүдийг бүгдийг нь шахахаар бид энэ итгэмжилсэн байгууллагууд чинь хүчин чадал чинь хүрэхгүй байгаа болохоор одоо эд дээр чинь бүгдээрээ дараалаад, үнэ ханш нь ямар байх юм, ямар нэгэн хэрвээ маргаан үүсвэл яах юм гэдэг нарийн юм юу ч байхгүй. Тэгэхээр ийм юм руу ингээд энэ олон ААН-үүдийг бүгдийг нь ингээд шахах нь, яг энэ хэрэгжүүлэх талаасаа эсэргүүцэлтэй тулж магадгүй. Хэрвээ энийг энэ хүчин чадлуудаа сайжруулаад, энэ ойлголтуудаа сайжруулаад ингээд явбал зорилгыг нь дэмжиж байгаа, гол нь яг энийг хэрэгжүүлэх бололцоо, боломж маань хүчээр ингэж шийдэх нь зохисгүй л харагдаад байна.

С.Бямбацогт: Хариулъя, Мандхай гишүүн.

М.Мандхай: Тэгэхээр одоо угаасаа хууль дээр байгаа зохицуулалт байхгүй юу. Тэгээд энэ угаасаа зохистой дадлыг үүрэгжүүлээд нэвтрүүлнэ гээд хууль дээр тусгачихсан байгаад байгаа юм. Тэгэхээр бид одоо байгаа эрх зүйн орчныг дордуулж ерөөсөө болохгүй. Зөвшөөрлийн тухай хууль дээр яаж байгаа вэ гэхээр угаасаа жилдээ 2 удаа одоо Бизнесийн эрх чөлөөний тухай хууль ч гэсэн зөвшөөрлийг ерөнхийдөө бизнес эрхлэгчдэд зөөлрүүлж өгч байгаа боловч нөгөө талдаа хяналтын механизм хэвээрээ байгаа. Жилдээ 2 удаа хяналт тавина. Тэгэхээр ээлжит үзлэг, хяналтынхаа үеэр энгийн зохистой дадал хуульд заасан энэ зохицуулалтыг хэрэгжүүлж байна уу, үгүй юү гэдэг дээр л хяналт тавина. Тэгэхээр зохистой дадал гэдэг харин түрүүн хэлсэн энгийн гараа угаах асуудал, энгийн байх ёстой зааварчилгаа, түрүүн хэлсэн 2 гампанзын хооронд махны гампанзыг хүнсний бусад төрлийнхөө хүнстэй хольдоггүй байх гэдэг энэ энгийн эрүүл ахуйн шаардлага хангасан дадлыг хүнсний үйлдвэр.../минут дуусав/

С.Бямбацогт: Тодруулъя Энхтүвшин гишүүн.

Д.Энхтүвшин: Гол нь нэвтрүүлэх юу дадлыг ойлгоод байгаа юм. Гол нь нөгөө баталгаажуулна гээд байгаа байхгүй юу. Эрхтэй байгууллагуудаар, тэр эрхтэй, тэр баталгаажуулах байгууллага чинь улсын хэмжээнд хангалттай биш байна шүү дээ. Тэгэхээр энэ шууд ингэж, тэгэхээр энэ бэлэн болчихоод энэ хуулийг, жишээлбэл энэ баталгаажуулах байгууллагууддаа хангалттай ч юм уу юмнууд нь тодорхой болгочхоод хэрэгжүүлэхгүй бол энэ дээр нэг ийм монопол байгууллагууд руу бүх ААН-үүдийг, хоол, хүнсний байгууллагуудыг аваачаад хийж байгаа юм шиг л, тэнд нь ямар ч завхрал гарахыг хэлж мэдэхгүй л иймэрхүү байдал руу л шахаад байна.

С.Бямбацогт: Хариулъя Мандхай гишүүн.

М.Мандхай: Энэ Хүнсний тухай хууль маань 14 жилийн дараа нэмэлт, өөрчлөлт орж байгаа. Үүнтэй холбоотой энэ хууль ерөөсөө яг ингээд нэвтрүүлнэ гээд орхичихсонтой холбоотойгоор ямар асуудал үүссэн вэ гэхээр бид бизнесийн эрх ашгийг дэмжилгүй яах вэ, зөв. Гэхдээ нөгөө талдаа бид хүний эрүүл мэндийн асуудал яригдаж байгаа гэдгийг 1 дүгээрт бид маш сайн анхаарч ойлгох ёстой, энэ дээр өндөр ач холбогдол өгөх ёстой. Тэгэхээр энэ хоол хүнснээс шалтгаалсан өвчлөл өөрөө 70 гаруй хувийг эзэлж байгаа учраас бид энэ энгийн зохистой дадал өөрөө хэрэгждэг байх ёстой, аливаа үйл ажиллагаа явуулж байгаа байгууллагууд ингэе. Тэрнээс бид бүгдээрээ ISO стандарт гэдэг юм уу, ХАССП стандартыг нэвтрүүлсэн бай, сертификатжуулсан бай гэсэн юм байхгүй. Тэгээд хяналтын асуудлыг одоо угаасаа Стандарт, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээний тухай хуулиараа маргаан хэрвээ гарвал зохицуулагдаад тэр хуулиараа л бусад.../минут дуусав/

С.Бямбацогт: Мөнхсайхан гишүүн нэмж хариулъя.

Т.Мөнхсайхан: Энэ ийм учиртай юм. Одоогийн хууль дээр зохистой дадлыг олон улсын итгэмжлэгдсэн байгууллагаар магадлуулж болно гээд, магадлуулахгүй ч байж болох ийм заалт байгаа. Тэгэхээр өнгөрсөн хугацаанд энэ заалтаар 2012 оноос хойш явж иржээ. Гэтэл энэ хугацаанд нэг ч байгууллага зохистой дадлаар магадлалаа хийлгэхгүй яваад байна гэдэг чинь өөрөө эргээд энгийн жижигхэн юм шиг мөртөө хүнсний хэрэглээн дээр хүн ардын эрүүл мэндэд маш их сөрөг нөлөөлөл авчирч байгаа байхгүй юу. Тэгэхээр энэ хууль дээр бид заавал энийгээ магадлуулна гэдэг заалтыг нь оруулж өгөөд, энэ магадлалыг нь хийдэг байгууллагууд нь үүний дагуу нэмж байгуулагдаад, энэ хүнс үйлдвэрлэгч, бүтээгч, энэ үйлдвэрлэгчид маань эргээд энэ магадлалдаа заавал ордог болсноороо маш их том эерэг үр дагаврыг авчрах гээд байгаа юм. Тийм учраас бид заавал энүүгээр магадлуулсан нь зөв гэдэг заалтыг нь оруулж өгч байж бид.../минут дуусав/

С.Бямбацогт: Гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа. Зарчмын зөрүүтэй 21 санал байгаа, санал хураалтыг маргааш явуулъя.

22.03 цаг

Ингээд өнөөдрийн чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцэх асуудлуудаа хэлэлцэж дууслаа. 22 цаг 03 минут хүртэл хуралдсан байна. Чуулганы хуралдаандаа идэвхтэй оролцсон Их Хурлын гишүүддээ, Тамгын газрын ажилтнууддаа баярлалаа. Мөн ажлын хэсгийн гишүүд та бүхэнд баярлалаа.

Өнөөдрийн нэгдсэн чуулганы хуралдаан өндөрлөснийг мэдэгдье.

ДУУНЫ БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ
ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ БУУЛГАЖ,
ХЯНАСАН: ШИНЖЭЭЧ

Д.УЯНГА